

# ӨДӨР ӨДРӨӨР

ХЭРЭГЖҮҮЛЭХ СУРГАМЖУУД

Зохиогч: Виллиям Макдоналд

veryday Publications Inc.  
310 Killaly Street West  
Port Colborne ON L3K 6A6  
Canada

Зохиогчийн эрх © 1982

Виллиям Макдоналд

ISBN 0-88873-067-5



Алдаа ба айдсаа  
Өвдөлт ба эндлээ  
Доройтол ба нулимсаа  
Зовлон ба зовнилоо  
Нэг л өдөр үүрье  
Яг одоо тэвчье

Нэг л өдөр, яг одоо!  
Тэвчээр хатуужил гаргая  
Сорилтыг даван туулья  
Буруутанд зөвлөн хандъя  
Хэцүү бүхэн ард үлдэнэ  
Харанхуй шөнө өнгөрөн одно  
Амар амгалан заавал ирнэ

Нэг л өдөр, яг одоо! Гэвч...  
Нэг өдөр удаан өнгөрөх юм  
Зориг минь мохох юм  
Сэтгэл минь цөхрөх юм  
Өршөөлт Христ ээ, ойр байгаач  
Өнөөдөр надад зориг, тэвчээр, хүч хайрлаач!

Түүнээс тодорхой сайхан хариу  
Аядуу зөвлнөөр ирлээ:  
“Би чамтай хамт байна

Зовлон дунд чамд тусална  
Би чамайг мартахгүй  
Эндэж алдаж гээхгүй  
Урмыг чинь хугалахгүй  
Би чамайг хаяхгүй  
Хэзээ ч орхиж явахгүй.”

Өчигдрийн ачааг үүр гэж  
Эзэн биднийг дуудаагүй шүү!  
Тодорхой бус маргашид  
Өнөөдөр шанал гэж хэлээгүй шүү!  
Өчигдөрт юунд гутарна гэж?  
Маргашид яагаад зовно гэж?  
Эзэн Бурханы минь нигүүлсэл  
Зөвхөн өнөөдөр хангалттай

Нэг л өдөр, яг одоо!  
Өнөөдөр бол Эзэний өдөр  
Цаг минутыг нь Тэр тоолсон  
Хором мөч нь урсан одож байна  
Түүний нигүүлсэл хангалттай  
Ганцаараа би алхаагүй  
Тэр надад энэ өдөр хүчийг өгнө

Энни Жонсон Флинт

## 1 сарын 1

*"Энэ сар нь та нарт саруудын эхлэл болно. Энэ нь та нарт жилийн тэргүүн сар байх болно."* (Гэт 12:2)

Шинэ оны эхэнд гаргадаг шийдвэр сайн зүйл гэдэг нь яриангүй. Гэвч ихэнх нь тогтворгүй учир дуустал хэрэгжих нь ховор. Шинэ оны эхний залбирлууд бусад үеийнхээс хүчтэй байдаг. Уг залбирлууд Бурханы сэнтий өөд хүрч, хариултын жолоог эргүүлдэг. Тиймээс, шинэ оны босгон дээр ирсэн бид дараах үгсээр чин сэтгэлээсээ залбирах хэрэгтэй:

Эзэн Есүс ээ, би өнөөдөр өөрийгөө Танд дахин шинээр өргөө. Ирж буй шинэ ондоо би өөрийн амьдралыг Таны алдрын төлөө ашигламаар байна. "Эзээн, амьдралыг минь жолоодооч. Амьдрал минь бүрэн Танд зориулагдах болтугай."

Намайг Та нүглээс сахин хамгаалж, нэрийг тань гутаах бүхнээс хол байлгаж өгөөч хэмээн би залбирч байна.

Намайг Ариун Сүнсний сургамжийг хайхардаг байлгаж өгөөч. Би Таны төлөө л урагшилмаар байна. Намайг үр бүтээлгүй бүү байлгаач.

"Тэр өсөж, харин би буурах ёстой" (Иох 3:30) гэдэг үг энэ жилийн минь уриа болог. Алдар нь зөвхөн Таных байг. Өөрийгөө алдаршуулахаас намайг хамгаалаач.

Аливаа шийдвэрийг залбиралтайгаар гаргахыг зааж өгөөч. Өөрийн ойлголтод түшиглэхээс би айж байна. "ЭЗЭН минь, замаа хүн өөрөө хардаггүйг би мэднэ. Алхмаа хүн өөрөө чиглүүлдэггүйг ч бас мэднэ." (Иер 10:23)

Энэ ертөнцийн хувьд би үхсэн хүн болог. Хайртай хүмүүс, найз нөхдийн минь магтаал сайшаал, доромжлол

үгүйсгэлийн алинд ч би үхсэн хүн больё. Гагцхүү Таны зүрхийг баярлуулах зүйлсийг үйлдэх хоёргүй сэтгэлийг надад өгөөч.

Бусдыг шүүмжлэх, хов жив ярихаас намайг хамгаалаач. Харин бусдыг барьж босгодог зөв сайн үгсийг ярихад минь туслаач.

Аврал хэрэгтэй сүнснүүд уруу намайг дагуулаач. Тан шиг би нүгэлтнүүдийн анд найз больё. Мөхөж буй хүмүүсийг энэрэн өрөвдөх нулимс надад хайрлаач. "Аврагчийн адил тэднийг хараад нүд минь нулимсаар дүүрэх болтугай. Төөрсөн хоньдыг өрөвдөн хараад Түүний хайраар тэднийг энэрэн хайрлая."

Эзэн Есүс ээ, христэч амьдралд минь юу ч тохиолдсон, цэвдэг хүйтэн болохоос, гомдол хорсол тээхээс, хүн чанараа алдахаас намайг хамгаалаач.

Мөнгө санхүүгийн хэрэг явдалд удирдан замчлаач. Таны надад хариуцуулсан бүхнийг сайн нярвын ёсоор захиран зарцуулахад туслаач.

Бие махбод маань Ариун Сүнсний орших сүм гэдгийг хором мөч бүхэнд сануулж өгөөч. Энэ чухал үнэн нь биеэ хэрхэн авч явах чиг баримжаа минь болох болтугай.

Эзэн Есүс ээ, энэ жил Та эргэж ирээч. Би Тантай нүүр тулан учирч, Таны хөлд сөгдөн мөргөхийг хүсэж байна. Ирэх онд энэхүү ерөөлт найдвар зүрхэнд минь цоо шинэхнээрээ байж, ертөнцийн юмсаас харааг минь салгаж, эргэн ирэхийг тань харуулдан хүлээх сэтгэлийг өгөх болтугай. " Амен. Ирээрэй, Эзэн Есүс ээ!" (Илч 22:20)

## 1 сарын 2

*"Даруугаар бие биенээ өөрөөсөө дээр гэж үз."* (Флп 2:36)

Бусдыг өөрөөсөө дээр гэж үзэх нь хүний төрөлх чанар биш юм. Нүгэлд унасан хүмүүний мөн чанар өөрийгөө дорд оруулахын эсрэг байдаг. Хүний талаас энэ нь ямар ч боломжгүй. Бид өөрсдийнхөө хүчээр ийм өөр ертөнцийн гэмээр амьдралаар амьдарч үл чадна. Гэвч энэ нь Бурханы хувьд боломжтой. Бидний дотор орших Ариун Сүнс бидэнд хүчийг өгснөөр бид өөрсдийгөө даруу болгож, бусдыг өөрөөсөө дээрд үзэн хүндэтгэж чадна.

Гидеон бол үүний тод жишээ. Тэрээр гурван зуун цэрэгтэйгээ мидианчуудыг хиар цохисныхоо дараа Ефраимын эрчүүдийг дуудаж эцсийн цохилтыг хамтдаа хийсэн. Тэд зугтах замыг нь хааж Мидианы хоёр ноёныг барьж авсан. Гэтэл Ефраимын эрчүүд гомдоллож, биднийг эртхэн дуудахгүй яасан юм бэ гэдэг. Гидеон хариуд нь "Абиезрийн усан үзмийн ургацаас Ефраимын жимсний хаягдал нь дээр бус уу?" (Шүү 8:2) гэж хэлсэн. Нэг ёсондоо, Ефраимын эрчүүдийн хийсэн эцсийн цохилтыг Гидеон өөрийнх нь удирдсан ажиллагаанаас илүү чухал гэж хэлсэн байгаа юм. Өөрийгөө бусдын доор оруулсан энэ хандлага ефраимчуудыг тайтгаруулжээ.

Иоаб мөн Раббаг эзлэн авахдаа Давидыг дуудуулж эзлэн авсан алдар гавьяаг Давидад өгөхдөө ийм даруу занг харуулсан (2См 12:26-28). Давид ялалтын гавьяаг хүртэхэд Иоаб сэтгэл хангалуун байлаа. Иоаб ийм хандлагатай байхдаа илүү нэр төртэй явсан билээ.

Элч Паул филиппойчуудыг өөрөөсөө илүүд үзсэн. Тэр тэдний хийж байгаа зүйлийг Бурханд тун чухал тахил гэж

хэлсэн. Харин өөрийгөө тэдний тахил ба итгэлийн үйлчлэл дээр ундаан өргөл болон асгагдсан төдий хэмээсэн (Флп 2:17).

Саяхны нэгэн жишээг дурдвал, Христийн нэгэн хайртай зарц, нэр хүндтэй номлогчидтой хамт тайзан дээр гарахаар зогсож байлаа. Түүнийг хаалгаар орж ирэхэд аянгын нүргээн мэт алга ташилт угтан авав. Тэр даруй өнөөх хүн хойш ухарч араас нь явж байсан хүмүүст алга ташилтын хүндлэлийг өгсөн.

Өөрийгөө бусдын доор оруулахын хамгийн дээд жишээ бол Эзэн Есүс билээ. Тэрээр биднийг өргөмжлөхийн тулд Өөрийгөө даруу болгосон. Биднийг баян болгохын тулд Өөрийгөө ядууруулсан. Биднийг амьтай байлгахын тулд Өөрийгөө үхүүлсэн.

"Өөр хоорондоо Христ Есүст байсан тийм бодолтой бай." (Флп 2:5)

## 1 сарын 3

*"Гаднах төрхөөр нь бүү шүү, харин шударга шүүлтээр шүү."* (Иох 7:24)

Нүгэлд унасан хүн төрөлхтний хамгийн том сул талуудын нэг бол гадаад төрхөөр шүүх хандлага юм. Бид хүнийг харагдах үзэмжээр дүгнэдэг. Хуучин машины сайн мууг их биеэр нь тодорхойлдог. Номыг бас хавтсаар нь үнэлдэг. Гадаад өнгөнд хууртаж, сэтгэл гонсойх зүйл олонтоо тохиолдсоор байвч "Гялтганадаг бүхэн алт биш шүү" гэдгийг ухаарч өгдөггүй.

Доктор Жеймс Добсоны *"Нуугд эсвэл хай"* номд бичсэнчлэн манай соёл хүний гадаад гоо сайхныг хамгийн өндөр үнэлдэг байна. Бидний ийм хандлагыг тэр "хүмүүний үнэтэй алтан зоос" гэж нэрлэсэн. Томчууд энгийн хүүхдээс илүү хөөрхөн хүүхдэд дуртай. Багш нар анхаарал татахуйц хүүхдэд сайн дүн тавих хандлагатай байдаг. Зүс царай сайнтай хүүхдүүд бусдаасаа бага шийтгэл авдаг. Эгэл төрхтэй хүүхдүүд буруу үйлдэлдээ илүү их буруутгуулдаг.

Самуел өндөр нуруутай, царайлаг Елиабыг хаанаар сонгох байсан (1Сам 16:7). Гэтэл Эзэн түүний бодлыг залруулж, "Түүний гаднах байдлыг болон нурууных нь өндрийг бүү хар. Би түүнийг нь үл хэрэгсэв. Учир нь Бурхан мөхөс нэгэнтэй адил хүний гаднах төрхийг хардаггүй. ЭЗЭН зүрхийг нь хардаг" гэж хэлсэн.

Түүхэн дэх буруу дүгнэлтийн хамгийн тод жишээ нь Эзэн Есүсийг энэ дэлхийд ирэх үед болсон юм. Гадаад төрхөөрөө Түүнд хүний анхаарал татах зүйл байсангүй. "Бидний харахаар хэлбэр дүрс, цог жавхлан Түүнд



байсангүй." (Иса 53:2). Хорвоод мэндэлсэн хамгийн үзэсгэлэнт Хүнээс тэд ямар ч гоо үзэсгэлэнг олж хараагүй байна

Харин Тэр Өөрөө гаднах төрхөөр шүүх урхинд унаж байсангүй. Учир нь Түүнийг ирэхээс өмнө, "Тэр нүдэндээ үзэгдсэнээр шүүхгүй, чихэндээ сонсогдсоноор шийдэхгүй" гэж зөгнөсөн байдаг (Иса 11:3). Тэрбээр царайг биш зан чанарыг, хавтсыг биш доторх агуулгыг, биеийг биш сэтгэлийг чухалчилдаг.

## 1 сарын 4

*"Хүч чадлаар ч бус, эрх мэдлээр ч бус, харин Миний Сүнсээр."* (Зех 4:6)

Эзэний ажил нь хүний мэдлэг чадвар, хүч чадлаар бус, харин Ариун Сүнсээр явагддаг гэсэн чухал үнэнийг энэ эшлэл агуулдаг.

Иерихог эзлэн авсан үйл явдлаас үүнийг харж болно. Хана хэрмийг Израилийн арми нураагаагүй юм. Тахилчид бүрээг долоон удаа үлээхэд хотыг израильчуудын гарт өгсөн Нэгэн бол Эзэн мөн.

Хэрэв Гидеон том армийг түшсэн бол мидианчуудыг ялан дийлэхгүй байх байсан. Учир нь түүний арми гурван зуун хүн болтлоо цөөрсөн. Тэд дотроо бамбар бүхий шавар ваарыг зэвсгээ болгосон. Ийм нөхцөлд тэдэнд ялалтыг өгсөн Нэгэн нь Эзэнээс өөр хэн байх билээ?

Елиа тахилын ширээнд гал асааж болзошгүй хүмүүний бүх боломжийг үгүй хийхийн тулд зориуд дөрвөн хөнөг ус асгасан. Гал бууж ирэхэд үүнийг Бурхан хийсэн гэхээс өөр арга үлдээгүй.

Шавь нар хүмүүний мэдлэгээр бүхэл шөнөжин загасчилсан боловч юу ч бариагүй. Эзэн энэ боломжийг ашиглаад үйлчлэлийн жинхэнэ үр дүн Эзэн рүү харахаас ирдэг гэдгийг харуулсан.

Христэч үйлчлэлийн хамгийн том хэрэгцээ нь мөнгө гэж бид боддог. Гэвч үнэндээ тийм биш. Өмнө нь ч тийм байгаагүй. Ирээдүйд ч тийм байхгүй. Хадсон Тэйлор энэ тал дээр үнэн хэлсэн: "Бид бага мөнгөтэй гэж айх хэрэггүй. Харин Бурханд зориулагдаагүй их мөнгөнөөс айх хэрэгтэй."

Бид стратеги тактик, өргөн цар хүрээтэй сурталчилгаа, хөтөлбөр программаар хүмүүсийн сэтгэлийг татаж, ухаалаг яриагаар Бурханы ажлыг хийх гэж үздэг. Цаашлаад далайцтай хөтөлбөрүүд, хүчирхэг зохион байгуулалтыг чухалчилж, ийм аргаар амжилтад хүрнэ хэмээн дэмий сэтгэдэг.

Гэвч Бурханы ажил ийм аргуудын алинаар ч урагшлахгүй. Хүч чадлаар ч бус, эрх мэдлээр ч бус, харин Эзэний Сүнсээр урагшилна.

Өнөөдөр христэч гэгдэх олон ажил Ариун Сүнсний оролцоогүй явж байна. Гэтэл жинхэнэ Христэч үйлчлэл нь махан биеийн зэвсгээр бус, сүнслэг зэвсгээр, тодруулбал залбирал, итгэл, Бурханы Үгээр хийгддэг.

## 1 сарын 5

"... чамтай байгаа хүмүүс хэтэрхий олон байна." (Шүү 7:2)

Хүн бүрийн дотор тооны араас хөөцөлдсөн зальт хүсэл, амжилтыг статистикаар дүгнэх хандлага оршдог. Тиймдээ ч жижиг бүлгүүдэд зэмлэнгүй, олон хүнтэй чуулганд хүндэтгэлтэй ханддаг. Энэ тал дээр бидний хандлага ямар байх ёстой вэ?

Олон тооны хүн Ариун Сүнсний ажлын үр жимс мөн бол түүнийг буруушааж болохгүй. Пентекостын өдөр 3000 орчим хүн Бурханы хаанчлалд орсон нь үүний нэг жишээ.

Бурхан алдаршиж, хүмүүст ерөөл ирж байвал бид олон тоонд баярлах ёстой. Олон хүн Бурхан уруу магтаалаар зүрх сэтгэл, дуу хоолойгоо өргөж, авралын мэдээг дэлхийд хүргэхийг хүсэх нь бидний хувьд зөв хандлага мөн.

Гэвч нөгөө талд их тоо нь бардамналд хүргэж байвал муу. "Би өөрийн гараар өөрийгөө аварсан" (Шүү 7:2) гэж израильчуудаар хэлүүлэхгүйн тулд Бурхан Гидеоны армийг цөөлжээ. Э.Стэнли Жонс нэгэнтээ өнөө цагийн байдлыг дүгнэж, "тооны араас явдаг хандлага байнга л бардамнал авчирдаг" гэж хэлсэн.

Их тоо нь Эзэнд бус хүний хүч чадалд найдах хандлага уруу хөтөлж байвал муу. Магадгүй Давидын тооллого цаанаа ийм сэдэлтэй байсан учраас Эзэний дургүйцлийг төрүүлсэн байж болох (2См 24:2-4). Давид хааны сэдэл цэвэр биш болохыг Иоаб гадарласан болохоор эсэргүүцсэн. Гэвч Давид хаан түүний үгийг сонсоогүй.

Олон хүнтэй болохын тулд жишиг хэмжүүрээ доошлуулж, Библийн зарчмуудыг зөрчиж, сайнмэдээний хүчийг сулруулж, бурханлаг сахилга батыг огоорч байвал

их тоо сайн биш. Бидний сэтгэл Эзэн дээр бус, их тоон дээр төвлөрвөл уруу таталт үргэлж гарч ирнэ.

Дотно нөхөрлөл гээгдэж байвал их тоо сайн биш. Дэндүү олон хүн дунд хүмүүс хаягдаж, тэдний байгаа үгүйг хэн ч анзаарахгүй, баяр гунигийг нь хэн ч хуваалцахгүй бол нэгэн бие гэдэг ойлголт тэр чигтээ орхигдоно.

Христийн бие доторх сүнслэг бэлгүүдийг ашиглахад саад учруулж байвал их тоо муу. Есүс арван хоёрхон хүнийг элчээр сонгосныг бодож үзэх л асуудал. Дэндүү их хүнийг удирдан зохион байгуулах амаргүй.

Бурхан ерөнхийдөө чин үнэнч үлдэгсдийн гэрчлэлээр дамжин ажилладаг. Тэр олон байна гээд баярладаггүй. Цөөн байна гээд гутардаггүй. Бид их тоонд бардаж болохгүй. Бас хойрго залхуу, хайхрамжгүйгээс минь үүдэлтэй цөөн тоонд ч ханаж болохгүй.

## 1 сарын 6

*"Учир нь миний дотор буюу махбодод минь ямар ч сайн зүйл байдаггүйг би мэддэг." (Ром 7:18)*

Залуу итгэгчид энэ үнэнийг христэч амьдралынхаа эхэн үед ойлговол хойш хойшдоо олон зовлонгоос өөрийгөө гэтэлгэж чадна. Бидний хуучин хүнд САЙН ЗҮЙЛ ЮУ Ч ҮГҮЙ гэж Библи номлодог. Махбодод сайн юм нэгээхэн ч үгүй. Энэ нь Христэд итгэлээ ч ямхын төдий сайжирдаггүй. Насан туршдаа христэч байлаа гээд аажимдаа дээрдэхгүй. Үнэндээ Бурхан махбодыг сайжруулья гэж хичээдэггүй. Бурхан махбодыг загалмай дээр үхэлд хүртэл нь ялласан бөгөөд махбодыг үхсэнд тооцоосой гэж биднээс хүсдэг.

Хэрэв надад ийм итгэл үнэмшил байвал өөрийнхөө дотроос сайныг хайдаг утгагүй ажлыг хийхгүй. Бурхан нэгэнт байхгүй гээд хэлчихсэн байхад би юунд хайна гэж?

Ийм итгэл үнэмшил нь намайг урам хугарахаас хамгаална. Өөрийнхөө дотроос сайныг эс оллоо гээд би сэтгэлээр унахгүй. Байхгүйг нь би анхнаасаа мэдэж байсан болохоор тэр.

Ийм итгэл үнэмшил нь намайг өөртөө төвлөрөхөөс хамгаална. Миний өөрийн дотор ялалт байхгүй гэсэн үзлээр би гараагаа эхэлнэ. Үнэндээ өөртөө төвлөрөх нь намайг ялагдалд хүргэдэг.

Мөн ийм итгэл үнэмшил байгаа цагт би сэтгэлзүйн зөвлөгөө авах гэж явахгүй. Учир нь энэ төрлийн зөвлөгөө нь хариултыг хүний өөрийн дотроос хайдаг бөгөөд асуудлыг шийдэх бус улам хүндрүүлдэг.

Цаашлаад, ийм итгэл үнэмшил нь Эзэн Есүс дээр бүх хараагаа тавихыг сургадаг. Роберт Мюри Макчэйн "Эзэн Есүст төвлөрөх нь өөртөө төвлөрдгөөс арав дахин их байх ёстой" гэж бичжээ. Энэ бол маш сайн тэнцвэр. Өөр нэгэн хүн бас, хуучин хүн маань хэчнээн ариуслаа ч ялгуусан Христийг хэзээ ч гүйцэхгүй гэж хэлжээ. Энэ тухай магтаалын дуу ч бий: "Хуучин хүнээсээ зугтаж, Аврагчдаа хоргодох хэчнээн сайхан бэ!"

Харамсалтай нь орчин үеийн олон номлогч, шинэ үеийн христэч номууд хүмүүсийг өөрсөд рүүгээ харахыг уриалж, хүний темперамент, өөрийн тухай төсөөлөл мэдрэмжийг онцолж, биеэ тэвчих тухай л яриад байна. Энэ нь тэнцвэрийг алдагдуулж итгэлийн амьдралыг сүйрсэн онгоц болгох аюултай.

"Би өөрийнхөө тухай бодохын аргагүй муу хүн билээ. Надад хэрэгтэй зүйл болбоос өөрийгөө мартаж, Бурхан уруу хамаг хараагаа талбих юм. Тэр л ганцаараа бүх бодлыг минь эзэмдэх зохистой Нэгэн мөн."

## 1 сарын 7

*"Бид үзэгдэх зүйлсээр бус, харин итгэлээр алхдаг."* (2Ко 5:7)

Яагаад хүмүүс залбирлын цуглаанд биш бейсболын тэмцээнд илүү дуртай байдгийг та бодож үзсэн үү? Үүнийг та хаа сайгүй харж болно.

Өөрөөр асууя. Яагаад хүмүүс чуулганы пастор болохыг биш АНУ-ын ерөнхийлөгч болохыг илүүд үздэг вэ? Эцэг эхчүүд хүүхдүүддээ, "Хоолоо сайн ид, чи нэг л өдөр пастор болно" гэж хэлдэггүй шүү дээ. Харин "Аяга тавгаа угаа, чи ерөнхийлөгч болох хүн" гэж хэлдэг.

Яагаад хүмүүс илгээлтийн эзэн болохыг биш бизнесийн амжилт хөөхийг илүүд үздэг вэ? Христчид ихэнхдээ хүүхдээ илгээлтийн эзэн болоход сэтгэлээр унаж, ямар нэг компанид том албан тушаалтай болоход баярладаг.

Яагаад телевизийн шоу нь Библи судлалаас илүү сонирхол татна вэ? Зурагтын өмнө уягдсан цагаа, хагас хугас Библи шагайсан цагтайгаа харьцуулаад нэг үзээрэй.

Яагаад хүмүүс Есүсийг хайрлахдаа хийдэггүй зүйлээ мөнгөний төлөө хийхэд бэлэн байдаг юм бэ? Ямар нэг компанийн ажлын төлөө эцэж цуцалгүй ажилладаг олон хүн Аврагч Эзэний дуудлагад яагаад хойрго хандана вэ?

Яагаад хүмүүс чуулганаас илүү улс төрийг чухалчилдаг вэ? Улс төрийн хэрэг явдал хэзээд анхаарлын төвд байхад чуулганы амьдралыг хэн ч үл тооно.

Энэ бүх асуултын хариу тун энгийн. Бид итгэлээр биш, харснаараа алхаж байгаад бүх учир бий. Бидний хараа булингартжээ. Бид бодит байдлыг харахаа больж, мөнхийн



бус, зуурдын юмсыг эрхэмлэж, сүнслэг бус, материаллаг зүйлсийг анхаарч, Бурханы шүүлтээс илүү хүний шүүлтээс эмээдэг болжээ.

Хэрэв бид итгэлээр алхваас бүгд өөрчлөгдөнө. Бидэнд сүнслэг хараа өгөгдөнө. Бурханы харж байгааг бид олж харна. Залбирахдаа орчлон ертөнцийн Эзэний өмнө сууж байна хэмээн үзнэ. Чуулганы пастор нь Бурханы нүдэнд улсын удирдагчаас чухал ажил гэдгийг ойлгоно. Бид Спержонтой нэгэн санаагаар, Бурхан хүнийг илгээлтийн эзэн болгохоор дуудсан бол тэр хүн хаан болох гэж зүтгэх нь эмгэнэл билээ гэж хэлнэ. Телевизийн нэвтрүүлгүүдийг бид бодит бусын ертөнц, Библийг харин дүүрэн амьдралын түлхүүр гэж харна. Цаашлаад Есүсийн төлөө цагаа зарцуулж, Есүсийн төлөө амьдарч эхэлнэ. Бурханы хувьд болоод Бурханы хүмүүсийн хувьд нутгийн чуулган нь дэлхийн хамгийн агуу эзэнт гүрнээс чухал гэдгийг бид ухаарна.

Итгэлээр амьдарвал бүх зүйл өөрчлөгддөг.

## 1 сарын 8

*"ЭзЭНий ажлыг хайнга хийгч нь хараагдах болтугай."*  
(Иер 48:10)

Эзэний ажил туйлын чухал. Тиймээс түүнд хүндлэлтэй, нухацтай, хариуцлагатай хандах зайлшгүй шаардлагатай. Түүнд хайнга ханддаг хүний дээр хараал оршдог ажгуу. Бурхан бидний охь шим, шилдэг сорыг хүсдэг төдийгүй тийм чанарыг авах зохистой Нэгэн учраас хааш яаш, дутуу дулимаг, хойрго залхуу, хариуцлагагүй байдлыг тэвчиж чаддаггүй юм. Эзэний ажилд хариуцлагагүй хандсанаас болоод ямар их асуудал үүсдэгийг бид гайхах зүйлгүй.

Нэгэн жишээ дурдъя. 1968 онд Чехословакийн Праг хотод залуухан христэч хүн, Ян Палах нэртэй өөр нэгэн чех залууд сайнмэдээг хуваалцжээ. Ян Палах, Христийн тухай чин сэтгэлээсээ сонирхож байх шиг санагдсан учраас итгэгч залуу түүнд Шинэ гэрээ явуулна гэж амлав. Тэрээр сайхан санаа гаргасан ч гэлээ хэрэгжүүлэхдээ хойрго ханджээ. Шинэ гэрээ олж авах гэж яаралгүй хэдэн долоо хоногийг өнгөрөөснөөс болоод амласан хугацаанаасаа хоцров.

Гэтэл 1969 оны 01 сарын 16-ны өдөр Ян Палах, Гэгээн Вацлавын Талбайд бие дээрээ бензин асгаж өөрийгөө шатаасан байна. Ян Палах өөрт нь өгнө гэж амласан Шинэ гэрээг үзэлгүйгээр энэ хорвоог орхижээ.

Сайн санал санаачилга байлаа гээд хангалтгүй. Тамын гудамжнуудад сайн санал санаачилгын хавтангаар зассан зам байдаг гэсэн үг хүртэл бий шүү. Гол нь хэрэгжүүлэх л хэрэгтэй. Сайн санал санаачилгыг үйлдэл болгох шаардлагатай. Үүнийг хийх цөөн хэдэн арга бий. Үүнд:

Нэгт, Эзэн таныг Өөрийнхөө төлөө ямар нэг зүйл хийлгэх гэж удирвал бүү цааргал. Тэр бол Эзэн. Тиймээс үг дуугүй дагах нь бидний үүрэг мөн.

Хоёрт, ажлыг хэзээ ч бүү хойш тавь. Хугацаанаасаа хоцорсон ажил хүний амины үнэтэй ч байж болно. Хоцролоос болж тусламж ба ивээл хүрэх ёстой хүндээ эс хүрч, бид өөрсдөө буруутгал харуусалд унадаг.

Гуравт, ажлыг хичээнгүй хий. "Гар чинь юуг хийхээр тэмүүлнэ, түүнийг бүхий л чадлаараа хийгтүн." (Ном 9:10). Хийх ёстой л юм бол чанартай хий.

Эцэст нь, бүхнийг Бурханы алдрын төлөө хий. "Тиймээс та нар идсэн ч, уусан ч, юу ч хийсэн Бурханы алдрын төлөө бүхнийг хий." (1Ко 10:31)

Эми Кармаиклийн үгийг сонс доо: "Надад Бурханд өгсөн тангараг бий. Гарынхаа сүүдрээр дүрс хийж тоглох юм уу ертөнцийн цэцэгсийг түүн зугаацах зав надад байхгүй. Ажлаа дуусгаад тайлангаа тавихад бэлэн болох хүртлээ би зүгээр суух эрхгүй." Энэ сэтгэл бидэнд бүгдэд маань байх ёстой.

## 1 сарын 9

"...юуны өмнө өөрсдийнхнийгөө [гэр бүлээ] хүндэл..." (1Тм 5:4)

"Гэрийнхэндээ чөтгөр, бусдад тэнгэрэлч" гэх үгийг та сонсож байсан биз ээ. Гаднын хүмүүст болохоор элэгсэг сайхан ханддаг мөртлөө гэр бүлдээ хахир хатуу авирладаг хүнийг хэлж байгаа юм.

Ийм хандлага бүх насны, аль ч ажил мэргэжлийн хүнээс харагдаж болно. Залуучууд үүнээс сэрэмжлэх хэрэгтэй. Найз нөхдөдөө телевизийн хөтлөгч шиг, эцэг эхдээ заналт дайсан мэт хандах явдал түгээмэл. Эрчүүд ажлынхандаа эелдэг дөлгөөн ханддаг мөртлөө гэртээ ирээд эхнэр хүүхдэдээ арслан барс болох явдал ч олон. Номлогчид индрийн ард хамаг сайхан зангаа гаргах атлаа орон гэртээ аймшигт мангас болж хувирах нь бий.

Нүгэлт хүмүүн бид ойр дотнынхондоо буюу өвчтэй зовлонтой үед минь хамгийн түрүүнд биднийг гэх хайртай хүмүүстээ байдаг муухай араншингаа үзүүлдэг. Элла Уиллер Уилкокс ийм араншныг ингэж шүлэглэжээ:

*Өрнө зүгээр аялж явахдаа би  
Үнэхээр чухал үнэнийг ухаарлаа  
Хамгийн хайртай хүмүүсээ бид  
Хайр найргүй гомдоодог ажээ  
Харь элгийн хүмүүст болохоор  
Хачин сайхан ханддаг мөртлөө  
Амин хайртай хүмүүстээ харин  
Адгийн муугаар авирладаг ажээ*

Өөр нэгэн зохиолч үүнтэй ижил санааг бас бичсэн: "Гаднын хүнтэй элэгсэг мэндэлж, зочин гийчинтэй найрсаг ханддаг бид хамгийн хайртай хүмүүстээ адайр муухай аашилж чаддаг."

"Чуулганы сайн итгэгч, залбирлын цуглааны идэвхтэн, христэч үйлчлэлийн хүн байх амархан. Харин өдөр тутмын амьдралд христитгэлээр амьдрах гэдэг огт өөр хэрэг юм аа. 'Юуны түрүүнд гэр бүлээ хүндлэх' нь христитгэлийн амин чухал хэсэг боловч нэн ховор үзэгдэл ажээ. Бусдын өмнө ариун шударга байх авч гэр орондоо увайгүй этгээд болдог итгэгчдийг олох өнөө цагт тийм ч хэцүү биш. Залбирлын цуглаандаа хүчтэй залбирч, сүм чуулганаа сургаал номлолоороо босгодог ч, эхнэр хүүхдээ үг хэлэх эрхгүй болтол нь бөмбөгнүүлдэг нэгэн аавыг би мэднэ." (Х. В. Смит)

"Амьтад өвдөлтийнхөө өс хонзонг өөрт нь ойр байгаа амьтнаас авдаг" гэж Самуел Жонсон хэлсэн байдаг. Хүмүүн бид ийм араатан араншингаа сэрэмжилж явах нь зүйтэй.

Гаднын хүмүүсийн өмнө ямар байх чинь бус, гэрийнхэндээ яаж ханддаг чинь таны христэч амьдралын үнэн төрх юм шүү.

## 1 сарын 10

*"...өмнөө тавигдсан уралдаанд тэвчээртэйгээр гүйцгээе."*  
(Евр 12:1)

Олон хүн христэч амьдралыг диваажин байх юм шиг төсөөлдөг. Дандаа л уулын оргилоор явна гэж санадаг. Тэд христэч ном сэтгүүл уншиж, хүмүүсийн мундаг мундаг гэрчлэлүүдийг сонсоод амьдрал ийм л байх ёстой гэж дүгнэсэн нь тэр. Тэдний мөрөөдлийн ертөнцөд ямар ч асуудал, санаа зовнил, сорилт бэрхшээл, саад тотгор гэж үгүй. Хүнд хүчир ажил, өдөр тутмын амьдрал, нэг хэвээр үргэлжлэх өдөр хоногууд гэж байхгүй. Яг л диваажин. Харамсалтай нь бодит байдал бодсоноос нь өөр болонгуут тэд сэтгэлээр унаж, гутарч, урам хугардаг.

Бодит үнэн тэдний төсөөлснөөс огт өөр. Христэч амьдралын ихэнх мөч Г. Кэмбэл Морганы хэлснээс нэг их зөрдөггүй: "Христэч амьдрал бол жижиг зүйлсийг тасралтгүй хийх тэвчээрийн зам билээ. Би ингэж л олж харсан. Хүнд хүчир ажил, олон цагийн сахилга баттай хичээл, үр дүн нь үл харагдах үйлчлэлүүд бол христэч амьдралын салшгүй хэсэг. 'Үнэхээр би үр дүнтэй юм хийж байна уу?' гэж бодох үе бишгүй гардаг. Яг тэр мөчид Эзэн урам зоригийг өгч, залбиралд маань гайхамшигт хариуг илгээж, тодорхой удирдамж өгдөг. Тийнхүү би цаашаагаа илүү хол явах тэнхээтэй болдог."

Христэч амьдрал бол богино зайн гүйлт биш, харин хол замын уралдаан юм. Замаа дуустал гүйж, бариандаа ороход тэвчээр хэрэгтэй. Гараанаас эрч хүчтэй гарах нь чухал ч гэлээ, бариандаа жавхлантайгаар орж ирэхийн тулд замаа дуусгах тэвчээр бүр илүү чухал юм.

Енох бол тэсвэр тэвчээрийн тод жишээ. Тэрээр Бурхантай хамт алхсан. Бодоод үз дээ. Тэр 300 жил Бурхантай хамт алхсан (Эх 5:22). Гэхдээ энэ урт хугацаанд нэг ч сэтгэлээр уналгүй, тасралтгүй баяр хөөртэй явсан гэж бодох нь үнэнд үл нийцнэ. Тэр яг л биднийхтэй адил ертөнцөд амьдарч байсан болохоор сорилт бэрхшээл, саад тотгор, хавчлага дарамтыг ялгаагүй амссан байж таарна. Гэхдээ тэглээ гээд сайныг үйлдэж явахаас няцаагүй юм. Енох эцсийг нь үзтэлээ тэвчжээ.

Шантармаар санагдсан үедээ Еврей 10:36-г санаарай: "Та нар Бурханы хүслийг биелүүлээд амлагдсаныг хүлээж авахын тулд та нарт тэвчээр хэрэгтэй."

*Ялгуусан амьдрал гэдэг нь  
Огцом ганц ялалт биш ээ  
Бурханы хүслийг үйлдсээр явдаг  
Олон өдрийн нийлбэр мөн*

## 1 сарын 11

*"...Тэгвэл хоёр юм уу гурван гэрчийн амаар хэрэг нь бүрэн нотлогдох болно." (Мт 18:16)*

Библийг харвал, зөв дүгнэлтийг хийхийн тулд заавал хоёр юм уу гурван хүний үгийг сонсох ёстой. Бид энэ зарчмыг дагасан бол үй түмэн асуудлаас аврагдах байлаа.

Бидний төрөлх зан нэг хүний мэдүүлгээр хамаг хэрэг явдлыг дүгнэх гэдэг сул талтай. Тэр хүний үг үнэний ортой санагдаж, түүнийг л өмгөөлж хамгаалах хэрэгтэй мэт бодогддог. Тэгээд дараа нь тэр хүн зөвхөн нэг өнцгийг барьж ярьсныг мэдэж авдаг. Нөгөө өнцгийг сонсох үед анхны мэдүүлэг тодорхой хэмжээний гуйвуулгатай эсвэл нэмэлт хачиртай байсныг ухаардаг. Тийм болохоор "Хөрш нь ирж, шалгахаас нааш хэрэг явдлаа түрүүлж хэлсэн хүний л зөв байдаг" (Сур 18:17) гэж Библи хэлжээ. Хэрэг явдлыг бүх өнцгөөс лавлаж тодруулаагүй байж дүгнэлт гаргах үед бидний шийдвэр энэ ертөнцийн шүүх тогтолцооны шийдвэрээс дорддог бөгөөд Сургаалт үгс 18:13-т хэлсэн үгийн биелэл болдог: "Сонсохоосоо өмнө хариу хэлэх нь мулгуу агаад ичгүүртэй."

Зиба, Мефибошетийг хаан ширээнд санаархаж байна гэж Давидад дуулгахад Давид шалгаж нягтлалгүйгээр ховын үгэнд итгэж, Мефибошетийн хөрөнгийг Зибад өгсөн (2См 16:1-4). Хожим нь Мефибошетод боломж гарч хаанд үнэн учрыг айлтгасан. Тэр үед л, хангалттай нотлох баримтгүйгээр шийдвэр гаргасан гэдгээ Давид ойлгосон.

Эзэн Есүс энэ зарчмыг баримталдаг байлаа. Тэр ганцаараа Өөрийнхөө тухай гэрчлээд хангалтгүй гэж хэлж байсан (Иох 5:31). Тиймээс дөрвөн гэрчээр Өөрийгөө



гэрчлүүлсэн. Тэрхүү дөрвөн гэрч болбоос баптисч Иохан (Иох 5:32-35), Өөрийнх нь ажил үйлс (Иох 5:36), Бурхан Эцэг (Иох 5:37,38), Бичвэрүүд (Иох 5:39,40).

Хоёр юм уу гурван хүний гэрчлэлийг сонсохгүйгээр хэрэг явдлыг шүүдгээс болж зүрх сэтгэлүүд эмтэрч, хүмүүсийн нэр төр сэвтэж, чуулганууд хуваагдаж, нөхөрлөлүүд бөхдөг. Бид Бурханы үгийг дагаваас түм буман шударга бус явдлаас зайлж, олон хүнийг хохироохгүй байж чадахсан.

## 1 сарын 12

*"Үнэхээр хүлээж авсан юм бол аваагүй юм шиг чи юунд сайрхана вэ?" (1Кор 4:7)*

Энэ бол сайшаалтай асуулт юм. Учир нь энэ асуулт бидэнд хэмжээг маань мэдүүлж байна. Бидэнд байгаа бүхнийг бид хүлээн авчээ. Бие махбод болоод оюуны чадамж төрөх үед маань өгөгддөг. Гадаад байдал маань ямар харагдах, тархи маань хэр сайн ажиллахыг бид өөрсдөө тогтоогоогүй болохоор үүнд сайрхах зүйл бидэнд үгүй. Энэ бүхэн төрөх үед маань өгөгдсөн.

Мэдлэг маань ч бас боловсролын үр дүн. Өөр хүмүүс оюун санаанд маань мэдлэг мэдээллийг оруулан өгчээ. Хэрэв бид анхнаасаа бүхнийг мэддэг байсан гэвэл, хорин жилийн өмнө уншсан номд тэр мэдлэг байхыг олж үзсэн төдий гэж хэлэхсэн. Тийм гэвэл, "Миний шилдэг санаануудыг эртний хүмүүс хулгайлчихсан байсан" гэж хэлдэг Эморсоны үгийг үнэн гэж зөвшөөрөхөөс яалтай.

Авьяас чадварыг юу гэх вэ гэж үү? Зарим авьяас чадвар гэр бүлийн хүмүүжилтэй шууд холбоотой байдаг. Тэдгээр нь давтлага сургуулилтын ачаар хөгждөг. Гол нь миний хэлэх гээд байгаа санаа гэвэл, тэр бүхэн биднээс өөрсдөөс минь гараагүй юм. Тэр бүхэн бидэнд өгөгддөг.

Пилат өөрийн эрх мэдэлд бардахад Эзэн Есүс түүнд "Танд дээрээс өгөгдөөгүй л бол Надаас дээгүүр ямар ч эрх мэдэл танд баймааргүйсэн" (Иох 19:11) гэж сануулсан.

Өөрөөр хэлбэл, хүмүүний уушгилж буй амьсгал бүхэн Бурханы бэлэг мөн. Тийм болохоор Паул 1Коринт 4:7 дээр "Чи байгаагаа хүлээж аваагүй гэж үү? Үнэхээр хүлээж

авсан юм бол аваагүй юм шиг чи юунд сайрхана вэ?" гэж асуужээ.

Энэ шалтгааны улмаас Хэррит Бичер Стөв "Том ахын байшин" номыг бичсэн гавьяаг өөртөө авахаас татгалзсан. Тэр ингэж бичсэн байдаг: "Том ахын байшин номыг би бичсэн гэж үү? Үгүй дээ. Зохиолыг би удирдаж чадахгүй шүү дээ. Зохиол өөрөө өөрийгөө бичсэн юм. Эзэн үүнийг бичсэн юм. Би бол Түүний мутрын багаж зэмсэг төдий. Бүх үйл явдал тархинд минь ар араасаа хөврөн орж ирж, яг үзэгдэл үзэж байгаа мэт нүдэнд харагдаж байсан. Харин би түүнийг нь цаасан дээр үгээр буулгасан юм. Зөвхөн Түүнд л магтаал байх учиртай!"

Бидэнд байгаа бүхнийг бид хүлээн авсан гэдэг ухаарал нь ихэрхэл бардамнал, өөрийгөө өргөмжлөх явдлаас биднийг хамгаалж, сайн үйл, сайн чанар бүрийнхээ төлөө Бурханд алдрыг өргөх сэтгэлийг төрүүлнэ.

"Мэргэн хүн мэргэн ухаанаараа, хүч чадалтай хүн хүч чадлаараа, баян хүн нь эд баялгаараа бүү сайрхаг. Харин сайрхагч нэгэн нь Намайг ЭЗЭН гэж мэдэж ойлгодгоороо гагцхүү сайрхаг. Хайр энэрэл, шударга ёс, зөв шударгыг дэлхий дээр хэрэгжүүлдэг Би ЭЗЭН. Учир нь Би үүнийг таалдаг гэж ЭЗЭН тунхаглаж байна." (Иер 9:23,24)

## 1 сарын 13

*“Намайг хүчирхэгжүүлэгч Түүгээр би бүгдийг хийж чадна.” (Флп 4:13)*

Энэ мэт эшлэлүүдийг буруу ойлгох тун амархан. Үүнийг уншингуутаа бид хийж чадахгүй зуу зуун зүйлсийг бодож эхэлдэг. Ер бусын хүч чадал шаарддаг ид шидийг би яаж хийж чадах юм бэ гэж өөрөөсөө асуудаг. Аль эсвэл бид, цар хүрээнээс минь хэтийдсэн оюуны өндөр хөгжлийг төсөөлдөг. Тийм болохоор дээрх үг нь биднийг урамшуулан босгохоос илүү ял зэм болох нь олон.

Гэтэл үнэндээ энэхүү эшлэл, Эзэн биднээр хийлгэхийг хүссэн бүх зүйлдээ хүч чадлыг өгч, бид түүнийг нь хийж чадна гэсэн утгатай. Түүний хүслийн хүрээнд боломжгүй юм нэг ч үгүй гэсэн үг.

Петр энэ нууцыг мэдэж байлаа. Өөрөөрөө бол усан дээр алхаж чадахгүйгээ Петр мэдэж байсан. Гэхдээ бас, Эзэн тушаавал алхаж чадна гэдгийг ч мэдэж байсан. Есүс Петрийг “нааш ир” гэж дуудсан даруйд Петр завинаасаа гараад усан дээгүүр алхаж эхэлсэн.

Жирийн үед уул миний тушаалыг дагаж далайд хаягдахгүй. Харин тэр уул Бурханы хүслийг биелүүлэхэд минь саад болж байвал “Эндээс тэр далай руу нүү” гэхэд үгийг минь дагана.

Нэг ёсондоо Бурханы хүсэл гэдэг Бурханы зөвшөөрөл болой. Тэгэхээр Бурхан сорилтыг давах хүчийг өгнө. Уруу татлага, муу зуршлыг ялан дийлэх хүчийг ч өгнө. Түүний таалалд нийцдэг зүйлсийг үйлдэж, цэвэр сэдэл, ариун бодол сэтгэлтэй явах хүчийг ч өгнө.

Хэрэв би бие, сэтгэл, сүнсний хувьд сүйрэлд хүрэх зүйлсийг үйлдэх гэж байвал, Түүний хүслийг огоорч, өөрийн хүслийг эрмэлзэж байвал Тэр надад хүчийг өгөхгүй. Бурханы ажил биш ажлуудыг Бурханы төлөө үйлддэг хүмүүс бий. Ийм ажлуудыг хийхэд Бурхан хүч чадлаа өгнө гэж амлаагүй.

Тиймээс, Бурханы хүсэл төлөвлөгөөний дотор үйлдэж байгаа эсэхээ мэдэх нь нэн чухал ажгуу. Хэрэв Түүний хүслийн дагуу явж байгаагаа баттай мэдвэл Тэр бидэнд хүчийг өгч, бид юуг ч хийж чадна гэдэгтээ итгэл төгс байж болно.

## 1 сарын 14

“Бүх юм та нарынх.” (1Ко 3:21-23)

Коринтын чуулганы ариун амьдралгүй ариун хүмүүс чуулганы доторх хүмүүн удирдагчдын талаар маргажээ. Зарим нь Паулыг мундаг гэгцгээв. Зарим нь Аполыг дэмжицгээв. Харин зарим нь Кефийг удирдагч гэж үзэв. Гэтэл бүх хүн тэднийх атал ганц хүнийг сонгох нь инээдтэй хэрэг гэж Паул хэлж байна. “Апол минийх” гэхийн оронд “Паул, Апол, Кеф бүгдээрээ минийх” гэх учиртай ажээ.

Энэ бол бидэнд зориулагдсан өнөөдрийн үг. Бид ер нь Лутер, Весли, Бүүт, Дарби, Билли Грэйм гэх мэт мундаг хүмүүсээс хэн нэгнийг нь дагах хандлагатай. Гэтэл энэ хүмүүс чинь бүгдээрээ биднийх шүү дээ! Тэд өөр өөрсдийн хэмжээнд бидэнд гэрлийг тусгасан бөгөөд бид ч тэдний тусгасан гэрэлд баярлах нь зөв. Тэрнээс биш, ганц хүнийг нь онцгойлж дагах ёсгүй.

Бидний юмс дан ганц Эзэний зарц нараар хязгаарлагдахгүй. Ертөнц бас биднийх ажээ. Бид Бурханы өв залгамжлагчид ба Христтэй хамт өв залгамжлах юм. Нэг л өдөр бид Эзэн Есүстэй хамт ертөнцийг захирахаар эргэн ирнэ. Одоогоор үл итгэгчид энэ ертөнцийг өөрсдийн мэт сэтгэн юмсыг хийж байна. Гэвч ертөнц тэднийх биш ээ. Бид ертөнцийг эзэмших хүртэл тэд түр хугацаанд ертөнцийг анхаарч халамжлан, захиран зарцуулж байгаа юм.

Амь ч бас биднийх. Энэ нь зүгээр л, бидэнд хүмүүний амь байдаг гэсэн үг биш. Тэр амь хүн бүрд бий. Харин энд яриад байгаа амь бол Христийн амь буюу мөнхийн элбэг

дэлбэг амь юм. Биднийх хий хоосон, сүнсний мөхөлд хүрэх амь биш ээ. Харин утга учиртай, зорилготой, шагналд хүрэх амь билээ.

Үхэл ч бас биднийх. Одоо бид хамаг амьдралынхаа турш үхлээс айж явах боолчлолоос чөлөөлөгджээ. Эдүгээ үхэл бол сүнсийг минь тэнгэрт аваачих Бурханы элч билээ. Тиймээс үхэх нь ололт юм аа. Энэ бүгд дээр нэмж хэлэхэд, бид Христийнх, Христ Бурханых. Үүнийг бодохоор Гая Кингийн егөөтэй үг санаанд буудагсан: “Бид чинь ямар их аз завшааныг хүртсэн гуйлгачид юм бэ!”

## 1 сарын 15

*“Ах дүү нар аа, та нар эрх чөлөө өөд дуудагдсан юм. Гэхдээ та нар эрх чөлөөгөө махбодын төлөөх таатай боломж болгож бүү ашигла. Харин бие биедээ хайраар үйлчил.” (Гал 5:13)*

Бурханы хүүхдэд эрх чөлөө хэмээх юугаар ч үнэлэмгүй хөрөнгө бий. Хүүгийн чөлөөлсөн нь үнэхээрийн эрх чөлөөт хүн мөн. Гэхдээ тэр нь далим бус, хариуцлагатай эрх чөлөө билээ.

Хүүхдүүд ер нь гэр орны захиргаадалтаас холдох сонирхолтой. Залуучууд хичээл ном хийх сахилга батыг тээршээдэг. Томчууд гэрлэлтийн тангаргаас чөлөөлөгдөхийг хүсдэг. Зарим хүн тогтмол ажлаар өөрийгөө хайрцаглахыг эсэргүүцдэг. Тэгвэл энэ бүхэн бидний дуудагдсан эрх чөлөө биш юм.

Одод тойрог замаасаа гарч сансар огторгуйгаар тэнэдэггүй. Галт тэрэг замаасаа гарч хөдөө талаар давхидаггүй. Онгоц тогтоосон замаас хазайдаггүй. Нисгэгч дүрэм журмыг хэр баримтлахаас онгоцны аюулгүй байдал хамаарна.

“Хууль дүрэмгүй бол эрх чөлөөтэй байдаг ямар ч газар үгүй. Эрх чөлөө байгаа газар заавал тодорхой хэм хэмжээ байдгийг та хаа сайгүй олж харна. Хөгжимчин уянгалаг сайхан аяз тоглоё гэвэл хөг аялгууны хуулийг дагахаас аргагүй. Барилгачин татах хүчний хуулийг огоорвол байшин барих биш, баахан тоосго овоолж хаяхаас хэтрэхгүй. Эрүүл ахуйн дүрэм журмыг зөрчөөд жаргалтай байдаг эрх чөлөөт хүнийг та харсан уу? Энэ бүх жишээн дээр хууль дүрмийг зөрчвөл өөрийгөө хохирооно. Харин



хууль дүрмийг дагах нь жинхэнэ эрх чөлөө юм” гэж Жовет бичсэн байдаг.

Итгэгч хүн хуулиас чөлөөлөгдсөн нь үнэн (Ром 7:3). Гэвч хуульгүй болсон гэсэн үг биш. Одоо тэрээр Христэд захируулж, хайрын хүлээсэнд уягдаж, Шинэ гэрээнд бичигдсэн олон тушаалыг дагах үүрэгтэй.

Итгэгч хүн эдүгээ, нүгэл хэмээх эзнээсээ чөлөөлөгдсөн (Ром 6:7,18,22). Гэвч тэглээ гээд эзэнгүй болсон юм биш. Одоо тэрээр Бурхан ба зөвт байдлын боол болсон.

Итгэгч хүн бүх хүнээс чөлөөтэй. Зорилго нь болбоос бүгдийн боол болж, илүү олныг аврах (1Ко 9:19).

Итгэгч хүний эрх чөлөө нь бузар мууг үйлдэх далим биш (1Пт 2:16). Махан биеийг өөхшүүлэх завшаан биш (Гал 5:13). Итгэгч хүн эрх чөлөөгөөр түрээ барьж бусдыг бүдрүүлж болохгүй (1Ко 8:9). Эрх чөлөө нэрээр Эзэн Есүсийн нэрийг гутаах эрхгүй (Ром 2:23,24). Итгэгч хүнд энэ ертөнцийг хайрлах эрх чөлөө байхгүй (1Ио 2:15-17). Мөн өөрийнхөө дотор орших Ариун Сүнснийг гомдоох эрх чөлөө байхгүй (1Ко 6:19).

Хүн гэгч өөрийнхөө зоргоор явснаар амар амгалан, бүрэн дүүрэн байдлыг олдоггүй. Харин Христийн буулгыг авч, Түүнээс суралцсанаар олно. “Түүнд үйлчлэх нь жинхэнэ эрх чөлөө болой.”

## 1 сарын 16

*“ЭЗЭНий үг Ионад хоёр дахь удаагаа ирэв.” (Ион 3:1)*

Найдвар ба амлалтаар гэрэлтсэн үг энд гарч байна. Хүн алдлаа гээд Бурхан түүнийг хэрэгсэхээ болино гэсэн үг биш ажээ.

Библи Давидын алдаа бурууг байгаа чигээр нь бичсэн. Түүний түүхийг уншихад тоос шороон дунд сууж, ичгүүр гутамшигтаа дарагдсан хүнийг олж хардаг. Гэвч Давид Эзэний өмнө хэрхэн хугарахыг, чин сэтгэлээсээ хэрхэн гэмшихийг мэддэг байжээ. Бурхан алдаагаар нь Давидад цэг тавиагүй. Бурхан Давидыг уучилж, сэргээгээд үр жимстэй амьдралыг хайрласан.

Иона Бурханы дуудлагаас нүүр буруулж яваад эцэст нь аварга загасны ходоодонд орсон. Далайн гүнд тэр дуулгавартай дагахыг сурчээ. Бурхан Ионаг хоёр дахь удаагаа дуудахад Иона, Ниневе хот уруу явж, шүүлт ирж буйг тунхагласан. Тэгэхэд Ниневе хот тэр аяараа Бурханы өмнө гэмшсэн.

Иохан Марк, Паул, Барнаб хоёртой гараагаа сайхан эхэлсэн. Гэвч тэр замаасаа ухарч гэртээ харьсан. Гэхдээ Бурхан түүнийг орхиогүй. Марк эргээд тулааны талбарт ирж, Паулын итгэлийг дахин олж аваад Төгс Зарцын тухай сайнмэдээг бичсэн.

Петр үхсэн ч сэхсэн ч хамт гэж амлан амлан Эзэнээсээ урвасан. Ийм болсон нэгнийг хүмүүс, хугархай далавчтай шувуу дахин хэзээ ч өмнөх шигээ өндөрт нисэж чадахгүй гэх биз ээ. Гэвч Бурхан түүнийг тийм хөөрхийлөлтэй төгсгөөгүй юм. Петр урьд өмнөхөөсөө ч өндөрт ниссэн. Тэрээр Пентекостын өдөр 3000 хүнд Бурханы хаанчлалын

хаалгыг нээж өгчээ. Петр эцэж цуцахыг үл мэдэн ажиллаж, хяхан хавчигчдын гараас байнгын зовлон амссан. Түүгээр ч зогсохгүй, өөрийнх нь нэрээр нэрлэгдсэн хоёр захидлыг бичиж, итгэлийнхээ төлөө амиа алдагсдын титмийг зүүх эрхийг олж авсан.

Үйлчлэлийн тухайд Бурхан бол хоёр дахь боломжийг өгдөг Бурхан мөн. Хүн алдсан ч Бурхан түүгээр нь цэг тавьдаггүй. Хүний дотор эмтэрсэн, гэмшсэн сэтгэл байх л юм бол Бурхан Өөрөө доош бууж ирээд алдаж эндсэн цэргийнхээ толгойг өргөдөг.

Гэхдээ үүнийг далимдуулж нүгэл хийх юм уу алдах эрх бидэнд байхгүй. Ингэж болохгүйн хамгийн том баталгаа бол Эзэний өмнө алдаж буруудахад төрдөг харуусал мөн.

Түүнээс гадна, Бурхан үхлийн дараа гэмшээгүй нүгэлтэнд хоёр дахь боломжийг олгоно гэсэн үг ерөөсөө ч биш. Үхлээр бүх боломж дуусдаг. “Мод өмнө ба хойд зүгт унаваас унасан тэр газартаа үлдэж хоцормуй.” (Ном 11:3) Нүгэл дотроо нас барсан хүний ял ийм.

## 1 сарын 17

*“Хүмүүст бус харин Эзэнд хэмээн сайн хүслээр үйлчил.”*  
(Еф 6:7)

Боолуудад хандсан Паулын заавар (Еф 6:5-8) Есүс Христийн зарц гэгдэгч бүхэнд утга учиртай үг.

Юуны түрүүнд, хэчнээн жижиг байсан ч, хүндэтгэлтэй хийсэн ажил бүхэн Бурханд алдрыг авчирч чаддагийг энэ үг харуулж байна. Паулаас заавар авсан тэр боолууд хог шүүрдэх, хоол хийх, аяга таваг угаах, мал маллах, тариа тарих зэрэг хар бор ажил хийдэг байсан. Ийм ажлыг ч гэсэн “Христэд ханддаг шигээ” (Еф 6:5) хий гэж элч Паул хэлжээ. Ингэснээрээ “Христийн боолууд ёсоор Бурханы хүслийг зүрх сэтгэлээсээ үйлдэж” (Еф 6:6), “Эзэнд” (Еф 6:7) үйлчлэх бөгөөд “сайн зүйл хийвэл Эзэнээс түүнийгээ буцааж авна.” (Еф 6:8)

Бид ер нь алив ажлыг нэг бол дэлхийнх, нөгөө бол Эзэнийх гэж ялгаж үзэх гээд байдаг. Өдөр тутмынхаа ажлыг дэлхийнх гээд, номлох, гэрчлэх, Библи заахыгаа Эзэний ариун ажил гэж үздэг. Гэтэл дээрх эшлэлийг харвал христэч бидний ажилд тийм ялгамж байхгүй ажээ. Үүнийг ойлгодог бол, номлогчийн эхнэр, “Гал тогоонд минь Бурханы үйлчлэл өдөрт гурвантаа явагддаг” гэсэн сэтгэлээр ажлаа хийж чадна.

Энэ зарчмыг мэддэг хүн нь

Энгийн ажлыг ч тэнгэрлэгт тооцно

Хог шүүрдэхийг ч Эзэнд зориулна

Хамаг ажлаа шилдгээрээ хийнэ

Жорж Хэрбэрт

Энэ эшлэлээс сурах хоёр дахь сургамж гэвэл, хүн нийгмийн давхаргын хамгийн доод зиндаанд байсан ч христитгэлийн хамгийн агуу ивээл ерөөл ба шагналыг хүртэж чаддаг байна. Тэр хүн ажлын хувцсаа заавал албаны костюмаар солих шаардлагагүй. Гагцхүү ажлаа чанарын өндөр түвшинд гүйцэтгэвэл Христэд алдрыг авчирч, шагналаа бүрэн авна. “Боол эсвэл чөлөөт байх нь ялгаагүй алив хүн сайн зүйл хийвэл тэрээр Эзэнээс түүнийгээ буцааж авна гэдгээ мэд.” (Еф 6:8)

Энэхүү итгэл үнэмшлээр бүгдээрээ Жорж Хэрбэртийн шүлгээр залбирья:

*Миний Бурхан, Хаантан минь  
Бүх зүйлээс Таныг олж харья  
Ямар ч ажил хийсэн бай  
Бүх зүйлийг Таны төлөө хийе.*

## 1 сарын 18

*“Миний хаанчлал бол энэ ертөнцийнх биш ээ. Хаанчлал минь энэ ертөнцийнх байсан бол...зарц нар минь тэмцэх байсан.” (Иох 18:36)*

Христийн хаанчлал энэ ертөнцийнх биш. Энэ нь дэлхийн улс төрөөс хол байхын маань хангалттай шалтгаан. Хэрэв би улс төртэй зууралдвал энэ ертөнцийн асуудлыг улс төрөөр засаж болно гэж итгэдэг хүн юм. Харамсалтай нь энэ итгэл үнэмшил христэч хүнд зохихгүй. Учир нь “бүх ертөнц нь ёрын нэгэн дор байдгийг [би] мэднэ.” (1Ио 5:19)

Улс төр нийгмийн асуудлуудыг засаж чадахгүй. Улс төр нь бугласан идээн дээр шархны лент наах төдий эмчилгээ хийдэг боловч халдварын голомттой нь ажилладаггүй. Өвчтэй нийгмийн маань гол асуудал нь нүгэл гэдгийг бид мэднэ. Нүглийг хөндөж гаргаж ирэхгүйгээр эмчилгээ хийх ямар ч боломжгүй.

Тэгэхээр, нүгэл бол нэн тэргүүнд шийдэх ёстой асуудал аж. Ингээд бодохоор улс төртэй зууралдаж явсан нь дээр үү эсвэл тэр цагаа сайнмэдээг тунхаглахад зарцуулсан нь дээр үү? Есүс “Үхэгсдийг үхэгсдээр нь оршуулуул. Харин чи явж Бурханы хаанчлалыг газар бүр тунхагла” (Лк 9:60) гэж хэлэхдээ энэ асуултад хариулсан. Бидний нэн тэргүүний ажил бол Христийг мэдүүлэх явдал. Яагаад гэвэл, Христ л энэ ертөнцийн асуудлуудын шийдэл юм.

“Бидний байлдааны зэвсэг нь махбодынх бус, харин ялагдашгүйг ч ялж чадах Бурханы хүчит зэвсгүүд юм.” (2Ко 10:4) Энэ үнэн бол улс орны болон дэлхий дахины

түүхийг улс төрөөр биш, залбирал, мацаг, Бурханы үгээр өөрчилж болохыг та ойлгож байгаа гэж найдна.

Олны танил нэгэн эрхэм дараах сануулгыг өгч байна: “Улс төрийн мөн чанар нь ялзрал. Чуулган улс төрд оролцоод өөрийн үүргийг умартаж болохгүй. Чуулган улс төрийн нэг хүчин байх учиргүй бөгөөд улс төрд орвол ариун байдлаа гарцаагүй гээгээ.”

Энэ үед Бурхан үндэстэн бүрээс Өөрийн нэрийн төлөө хүмүүсийг дуудаж байна (Үйл 15:14). Бурхан хүмүүсийг ялзарсан дэлхийдээ санаа амар суухыг биш, дуудлагад нь хариу үзүүлж, аврагдаасай гэж хүсэж байна. Харин бид энэхүү яруу алдарт ажилд Бурхантай хамт ажиллахын төлөө өөрсдийгөө зориулах ёстой.

“Тэгтэл тэд Түүнд ‘Бид Бурханы ажлыг гүйцэтгэхийн тулд юу хийх вэ?’ гэсэнд Есүс тэдэнд ‘Та нар Түүний илгээсэн Нэгэнд итгэх нь Бурханы ажил мөн’ гэж хариулав.” (Иох 6:28,29) Тэгэхээр хүмүүсийг улс төрийн үйл ажил уруу бус, итгэл рүү авчрах нь бидний үүрэгт ажил мөн.

## 1 сарын 19

*“Бид нүглээ улайвал итгэмжит, зөвт Тэрээр нүглийг маань уучилж, бүхий л зүй бусаас биднийг цэвэрлэнэ.”*  
(1Ио 1:9)

Энэ эшлэлд өгсөн баталгаа үгүй бол христэд амьдралаар амьдрах боломжгүй. Нигүүлсэл дотор өсөх тусам нүгэлтэн гэдгээ бид улам бүр олж хардаг. Ингээд нүглээсээ ангижрах нигүүлсэл өөрийн эрхгүй хэрэг болдог. Эс бөгөөс үргэлжийн буруутгал, ялагдалд явсаар дуусах байв.

Итгэгч хүнд ийм нигүүлсэл нүглээ улайснаар ирдэг гэж Иохан хэлж байна. Үл итгэгч нь Эзэн Есүст итгэснээр шийтгэгдэх ялаасаа уучлагддаг. Энэ бол Шүүгчийн зүгээс ирж буй уучлал. Итгэгч хүн харин нүглээ улайх замаар нүглийн бохирдлоо угаалгадаг. Энэ бол Эцэгээс ирж буй уучлал.

Нүгэл нь Бурханы хүүхдийн амьдрал дахь харилцааг эвддэг. Нүглээ улайж, түүнээсээ гэдрэг эргэхээс нааш тэр харилцаа хэвийн байдалдаа орохгүй. Хэрэв бид гэмшвэл хэлсэндээ хүрдэг Бурхан биднийг уучилна. Учир нь, уучилна гэж Тэр амласан. Бурхан загалмай дээрх Христийн ажлаар дамжуулан, нүгэлтнийг уучлах шударга үндэслэлийг бий болгосон тул Түүний уучлал зөвт билээ.

Хэрэв бид нүглээ гэмшвэл бүрэн цэвэршүүлэгдэж, бүрэн угаагдаж, эргээд гэр бүлийн аз жаргалтай харилцаанд орсноо бат мэдэж чадна хэмээн энэ эшлэл хэлж байна. Амьдралд маань нүгэл байгааг мөс чанар маань хэлсэн даруйд Бурханы өмнө очиж нүглээ нэрээр нь хэлж, түүнээс бүрэн нүүр буруулах ёстой. Үүнийг хийсэн



бол уг нүгэл Бурханы нүднээс зайлуулагдсан нь баттай үнэн.

Яаж баттай мэдэх вэ гэж үү? Уучлагдсанаа яаж мэдрэх вэ гэж үү? Энэ бол мэдрэмжийн асуудал ерөөсөө биш. Бурхан үгэндээ хэлсэн болохоор л уучлагдсанаа баттай мэдэж чадна. Мэдрэмж найдвартай эд биш. Харин Бурханы үг хөдөлшгүй хад мөн.

Магадгүй зарим нь, “Бурхан намайг уучилсныг мэдэж байгаа ч би өөрөө өөрийгөө уучилж чадахгүй байна” гэж хэлж мэднэ. Энэ нь ихэд сүсэгтэй хүний үг шиг санагдах байх. Харамсалтай нь Бурханыг үл хүндлэх хандлагаас өөр юу ч биш. Бурхан намайг уучилсан юм бол, тэр уучлалыг итгэлээр хүлээн аваад баяр хөөртэй байж, цэвэрлэгдсэн сав мэт Өөрт нь үйлчлээсэй гэж Бурхан хүсэж байгаа нь дамжиггүй.

## 1 сарын 20

*“Би цаашид тэдний нүглийг, тэдний ёс бус явдлыг эс санана.”* (Евр 10:17)

Бурхан Христийн цусаар далдлагдсан нүглүүдийг мартаж чаддаг нь Библид байгаа нэгэн гайхалтай сургаал мөн. Энэ сургаал сэтгэлийг дүүргэдэг.

“Өрнө нь дорноос хол байдаг адил гэмт үйлдлийг маань биднээс Тэрээр тийн холдуулсан.” (Дуу 103:12) Үнэхээр гайхалтай! “Гэм нүгэл бүрийг минь Та нурууныхаа араар хаясан.” (Иса 38:17) Бид Хезекиатай нэг адил ийм үгсийг хэлж чадах боломжтой нь юутай сайхан! “Би гэмт үйлдлийг чинь өтгөн үүл мэт, нүглийг чинь үүл мэт арчин хаяв.” Эзэний үгс сэтгэлийг үнэхээр бишрүүлж байна. “Учир нь Би тэдний хилэнцийг уучилж, нүглийг нь дахин эс санана.” Юутай агуу уучлал вэ!

Нүглээ улайх үед Бурхан биднийг уучлаад зогсохгүй нүглийг маань оргүй мартдаг ажээ. Тэр бидний нүглийг мартахуйн далайд булшилж орхидог гэсэн үг үнэнийг дэгсдүүлсэн хэрэг огт биш шүү! Нүгэлтэйгээ тэмцэлдээд дийлдсэн нэгэн итгэгчийн туршлагаар жишээ өгүүлье. Тэрээр сул дорой үедээ уруу татлагад бууж өгсөн бөгөөд тэр даруй Эзэний өмнө очин гэмшиж “Эзээн, би дахиад л хийчихлээ” гэж гэнэ. Харин Эзэн түүнээс “Чи юуг дахиад хийсэн юм бэ?” гэж асуух шиг бодол орж ирсэн байна. Хоёр дахь гэмшил дээр Бурхан түүний өмнөх нүглийг нэгэнт мартсан байсныг энд хэлэх гээд байгаа юм.

Бүхнийг мэдэгч Бурхан мартаж чаддаг гэхээр юутай баярламаар! Нэг талаас бодвол, Тэр бүхнийг мэднэ. Бурхан оддыг тоолж, бүгдийг нь нэрлэдэг. Бурхан эргэж

хөрвөөсөн бүх мөчийг тоогоор нь мэддэг. Бурхан нулимсны минь дусал бүрийг тоолдог. Үхсэн болжмор бүрийг анзаардаг. Үс минь хэдэн ширхэгтэйг ч мэднэ. Тэгсэн мөртлөө, нүглээ улайж, гэмшиж, түүнээсээ гэдрэг эргэвэл нүглийг мартдаг. “Бүхнийг мэдэгч Бурхан яаж мартдагийг би мэдэхгүй. Тэр мартдаг гэдгийг л мэднэ” гэж Давид Симэндс хэлсэн байдаг.

Эцэст нь хэлэхэд, Бурхан нүглийг уучилж, мартахуйн тэнгис рүүгээ чулуудан тэндээ булшилдаг нь сайхан. Гэхдээ Бурхан, тэнгисийн эрэг дээр “загасчилж болохгүй” гэсэн тэмдэг тавьдаг шүү! Бурхан нэгэнт мартсан бол далайг дахин шүүрдэж, өөрийн ч бай, өрөөлийн ч бай алив нүглийг загасчлах нь хориотой. Энэ тал дээр бид ой муутай, мартамхай байх хэрэгтэй.

## 1 сарын 21

*“ЭЗЭНий Сүнс Саулаас салсан бөгөөд ЭЗЭНээс ирсэн муу сүнс түүнийг айлган сүрдүүлэв.” (1См 16:14)*

Ёрын муу үйлийг Бурханд хамаатуулсан утгатай эшлэлүүд Библид байдаг. Жишээлбэл, Абимелех Израильд гурван жил хаанчилж байхад “Бурхан, Абимелех болон Шехемийн иргэдийн хооронд муу сүнсийг илгээсэн” (Шүү 9:23) гэж бичигджээ. Ахабын өдрүүдэд Микаиа, “ЭЗЭН энэ бүх эш үзүүлэгчдийн аманд хуурдаг сүнсийг хийсэн” (1Ха 22:23) гэж хорон муу хаанд мэдэгдсэн. Иов өөрийн хохирлыг Эзэний ажил хэмээн үзэж, “Сайныг Бурханаас хүлээн авсан бид, мууг хүлээн авах ёсгүй юу?” (Иов 2:10) гэж хэлсэн. Эзэн Өөрийнхөө тухай Исаиа 45:7 дээр “Би...амар тайвныг гүйцэтгэн, гай гамшгийг ч бүтээдэг” гэж тунхагласан.

Гэхдээ Бурхан ёр мууг бий болгодог ч үгүй, түүнийг зүгээр орхидог ч үгүй, учир нь Тэр ариун гэдгийг та бид мэднэ. Гэм нүгэл, өвчин, зовлон ба үхэл Эзэнээс ирдэггүй ээ. Тэр бол гэрэл, Түүний дотор харанхуй огт үгүй (1Ио 1:5) гэдэг. Бурхан Өөрийнхөө төгс ёс суртахууны эсрэг зүйл хийдэг гэж бодох ч хэрэггүй.

Нөгөө талд, өвчин зовлон, гамшиг сүйрэл, гай түйтгэрийн зохиогч нь Сатан гэж Библийн бусад хэсэгт хэлдэг. Иовын гарз хохирол, гашуун зовлон диаволоос гаралтай. Арван найман жил өвчинд шаналсан эмэгтэйд Сатан хүлээтэй байлгасан гэж Есүс хэлсэн (Лк 13:16). Паул өөрийнхөө бие дэх өргөсийг “Сатаны зарлага элч” (2Ко 12:7) гэж нэрлэсэн. Хүн төрөлхтний зовлон бүхний ард Сатан байдаг.

Тэгвэл Бурханыг бузар муугийн бүтээгч гэж харуулж байгаа эшлэлүүдийг хэрхэн ойлгох вэ? Тайлбар нь тун энгийн: Библид Бурхан, Өөрийнхөө зөвшөөрсөн зүйлсийг Өөрөө хийсэн мэт өгүүлдэг тохиолдол нэлээд бий. Бурханы Өөрийн хүсэл болон зөвшөөрсөн хүслийн ялгаа энд харагдаж байгаа юм. Заримдаа Бурхан Өөрийнхөө хүмүүсийг Өөрийнхөө хүсээгүй замаар явахыг зөвшөөрдөг. Үүний жишээ бол Израиль цөлөөр тэнүүчилсэн явдал. Хэрэв израильчууд зөвшөөрсөн бол Бурхан тэднийг товч замаар дагуулаад амлагдсан нутагт оруулахыг хүссэн. Гэвч израильчууд дуулгаваргүй байсан учраас Бурхан тэднийг дөчин жил цөлд тэнүүчлэхийг зөвшөөрчээ.

Бурхан чөтгөрийн болон хүний бузар мууг зөвшөөрдөг ч гэлээ, эцсийн хувь тавилан Бурханы гарт бий. Эцсийн эцэст Бурханы яруу алдар мандаж, Бурханыг хайрлагчид ерөөгдөх болно.

## 1 сарын 22

*“Золгүй явдлыг тэрээр Иаковын дотроос үзээгүй. Зовлонг бас Израилийн дотроос хараагүй.” (Тоо 23:21)*

Бүхнийг хардаг Бурхан Өөрийн ард түмэн Израилийн дотроос нүгэл олж хараагүй гэж хөлсний эш үзүүлэгч Балаам үнэн хэлсэн. Энэ үг Израилийн хувьд үнэн байсан юм бол өнөөдөр Христэд итгэгч бидний хувьд ч үнэн билээ. Бурхан итгэгчдийг харахад мөнх үхлийн ял шийтгэл хүртэх нэг ч болов нүгэл тэдний дотор байдаггүй. Учир нь итгэгч хүн “Христийн дотор” байдаг. Өөрөөр хэлбэл, итгэгч хүн Христийн төгс байдал ба үнэ цэнийн дотор оршин, Бурханы өмнө зогсдог. Бурхан хайрт Хүүгээ хэрхэн хүлээн авдаг тэр жишиг хэмжүүр дотор итгэгч хүн зогсдог учраас, Бурхан итгэгчдийг Христийн адил хүлээн авдаг. Итгэгч хүний Бурханы өмнөх байр суурь сайжрах шаардлагагүй, мөн хэзээ ч цуцлагдахгүй. Бурхан Христийн дотор байгаа хүнээс хэчнээн хайгаад ч ял зэм олж чаддаггүй.

Үүнийг дүрслэх жишээ нэгэн англи залууд тохиолджээ. Тэр залуу амралтаараа Ролс Ройс машинаа унаад франц уруу аялав. Гэтэл машинын нь арын тэнхлэг эвдэрхий байж. Тухайн орон нутгийн засварын газарт Ролс Ройсын арын тэнхлэгийг солих сэлбэг байгаагүй тул залуу Англи уруу холбоо барив. Машин үйлдвэрлэгч компани арын тэнхлэгээс гадна тэнхлэгийг зохис ёсоор угсарч чадах хоёр засварчин явуулжээ. Ингээд машин нь асуудалгүй болсон залуу аяллаа дуусгаад Англидаа иржээ. Англид ирээд төлбөрийн нэхэмжлэх ирэхийг хүлээж байлаа. Хэдэн сар өнгөрсөн ч нэхэмжлэх ирсэнгүй. Тэгэхээр нь залуу

машины компани руу бичиг явуулж, хамаг учир байдлаа тайлбарлаад төлбөрийн нэхэмжлэх хүсэв. Удалгүй компаниас хариу ирсэн нь ийм үгтэй байлаа: “Бид бүртгэлээ нэгд нэггүй шалгалаа. Гэвч манай Ролс Ройс машинуудаас арын тэнхлэг эвдэрч байсан тохиолдол ганц ч алга.”

Бурхан ч бас Өөрийн бүртгэлийг нэгд нэгэнгүй шалгахад итгэгч хүнээс ямар ч нүгэл олдоогүй учраас түүнийг тамд хаях ял оноодоггүй байна. Итгэгч хүн Бурханы хайрт Хүүгийн дотор хүлээн авагдсан. Итгэгч хүн Христийн дотор төгс болсон бөгөөд Бурханы зөвт байдлаар хувцасласан. Тиймээс Бурханы өмнө зогсохдоо төгс байдаг. Ийм болсон бид дараах дууг ялгууснаар, итгэл төгс дуулж чадна:

*Эхлээд та нар Аврагчийг минь хар*

*Нэг ч болов өө сэвтэйг нь батал*

*Ганц ч болов нүгэлтэйг нь нотол*

*Тэгж чадвал намайг бузарт тооц*

## 1 сарын 23

*“Чи өөртөө агуу зүйлсийг хайж байна уу? Бүү хай.”* (Иер 45:5)

Агуу болох, нэрээ сэтгүүл дээр тавих, алдраа радиогоор сонсох гэсэн зальт уруу татлага христэч үйлчлэлд ч байдаг. Гэхдээ энэ бол маш том занга. Энэ нь Христийн алдар сууг хулгайлдаг. Мөн биднээс амар тайвныг, баяр хөөрийг хулгайлдаг. Ийм занганд унасан хүн диаволын суманд амархан өртөнө.

Энэ хүсэл Христийн алдар сууг хулгайлдаг. Ч.Х.Макинтош энэ тухайд дараах тайлбарыг бичсэн: “Хүн өөрийгөө эсвэл ажлаа чухалд тавих үед аюул гэтэж байдаг. Эзэн Есүсийг гол анхаарлаас авч хаяад хэн нэг хүнийг эсвэл ажил үйлийг анхаарч эхлэхэд Сатан зорилгодоо хүрлээ гэсэн үг. Аливаа үйлчлэл анхандаа даруугаар эхэлж болох ч, үйлчлэгч хүн сонор сэрэмж алдвал яваандаа уг үйлчлэл хүмүүсийн анхаарлын төвд орж болзошгүй. Тийнхүү үйлчлэгч нь диаволын урхинд унадаг. Сатаны үндсэн зорилго бол Эзэн Есүсийг гутаах, хүндлэлийг нь булаах явдал. Христэч үйлчлэлийг ийм байдалд хүргэж чадвал Сатан агуу ялалтад хүрсэн хэрэг юм.” Дэннигийн хэлснийг ч мөн бодууштай: “Ямар ч хүн нэг зэрэг өөрийгөө болон Христийг өргөмжлөх боломжгүй.”

Агуу болох хүсэл нь явцын дунд биднийг өөрсдийг маань хулгайлдаг. “Агуу болох гэж хичээхээ болих хүртлээ би жинхэнэ амар амгалан, баяр хөөрийг мэддэггүй байлаа” гэж нэгэн хүн хэлсэн байдаг.

Агуу болох хүсэл нь биднийг Сатаны дайралтад ямар ч хамгаалалтгүй болгодог. Мундаг хүмүүсийн уналт



Христийг буруутгах хамгийн сайхан завшааныг бусдад өгнө.

Баптисч Иохан өөрийг нь агуу болгох гэсэн бүх боломжоос татгалзсан. Иохан, “Тэр өсөж, харин би буурах ёстой” гэсэн уриатай байлаа.

Бид ч мөн адил, Эзэн биднийг дээшээ суу гэх хүртэл хамгийн доор суухыг сонгох ёстой. “Эзээн, та намайг зөвхөн Христийн хайр ба үнэлэмжийг олсон, хэнд ч үл анзаарагдам өчүүхэн жижиг нэгэн байлгаж өгөөч” хэмээн залбирах нь бидэнд нийцнэ.

*Назар хот жижиг газар байлаа*

*Галил ч мөн ялгаагүй*

## 1 сарын 24

“Юунд ч санаа бүү зов.” (Флп 4:6)

Хүнд санаа зовох олон асуудал бий. Хорт хавдар, зүрхний шигдээс гээд янз бүрийн өвчин тусах магадлал, эрүүл мэндэд хортой хоол хүнс, ослоор амь насаа алдах эрсдэл, коммунистуудын сүрдүүлэг, цөмийн дайн, ханш уналт, тодорхойгүй ирээдүй, ийм хэцүү ертөнцөд өсөж буй хүүхдүүд. Энэ мэт олон асуудлыг бодохоор санаа зовохгүй байхын аргагүй.

Гэтэл Бурханы үг бидэнд “Юунд ч бүү санаа зов” гэж хэлдэг. Бурхан биднийг санаа зовнилоос ангид амьдраасай гэж хүсдэг. Шалтгаан нь ч үндэслэлтэй.

Санаа зоволт ямар ч хэрэгцээгүй зүйл. Эзэн биднийг байнга харж хандаж байгаа. Тэр бидний амьдралыг атгадаг. Бурхан зөвшөөрөөгүй цагт бидэнд юу ч тохиолдохгүй. Бид сохор аз, хувь тавилан, санаандгүй явдлын хохирогч болохгүй. Бидний амьдралд Бурханы төлөвлөгөө, дэс дараа, чиглүүлэг бий.

Санаа зоволт утга учиргүй хоосон зүйл. Санаа зовлоо гээд асуудал шийдэгдэхгүй. “Санаа зоволт нь маргаашийн зовлонг хугаслахгүй мөртөө өнөөдрийн хүч чадлыг үгүй хийдэг” гэж нэгэн хүн хэлжээ.

Санаа зоволт нь хор хөнөөлтэй. Олон өвчний шалтгаан нь зовнил, түгшүүр, айдас гэж эмч нар хүртэл хэлдэг. Санаа зоволтоос үүдэлтэй өвчнүүдэд шархлаа, үрэвсэл өндөр үзүүлэлттэй байдаг.

Санаа зоволт нь нүгэл. Санаа зовж буй хүн Бурханы мэргэн ухаанд, Бурханы хайранд, Бурханы хүч чадалд эргэлзэгч мөн. Цаашлаад, Бурхан юу хийж байгаагаа

мэддэггүй, Бурхан анхаардаггүй гэж үзэж байгаагаас ялгаагүй. Бурхан нөхцөл байдлыг ялан дийлэх чадалгүй учраас би санаа зовж байна гэж хэлж байгаагаас өөрцгүй.

Бид санаа зовдгоороо сайрхдаг. Нөхөр нь эхнэрээ хэрэгтэй хэрэггүй юманд санаа зовдгийг нь буруутгахад эхнэр нь, “Би санаа зовохгүй бол энд гараас гарах юм нэг ч алга” гэж хариулдаг. Санаа зоволтыг нүгэл хэмээн хүлээн зөвшөөрч, түүнээс гэдрэг эргэхээс нааш бид санаа зоволтыг гэтэлж чадахгүй. Түүнийг гэтэлбээс итгэлтэйгээр дараах шүлгийг хэлж чадна:

*Маргаашийг би яаж чадах билээ?*

*Аврагч минь л түүнд санаа тавиг*

*Зовлон гуниг ирнэ гэвэл*

*Тэр л надад тусалж чадна*

*Маргаашийг би яаж чадах билээ?*

*Ачааг нь өнөөдөр үүрэхийн хэрэг юун*

*Ивээл ерөөлийг нь зээлж авч чадахгүй хойно*

*Санаагаа зовоож шаналахын хэрэг юун*

## 1 сарын 25

“Бурхан бол хайр.” (1Ио 4:8)

Христийн ирэлт хайрыг илэрхийлсэн шинэ үгийг (*аганэ*) грек хэлнээ нэвтрүүлжээ. Грек хэлэнд анд нөхрийн хайр (*филиа*) хийгээд дурлалт хайрыг (*эрас*) илэрхийлсэн үг байсан боловч Бурханы хайрыг илэрхийлэх үг байгаагүй юм. Бурхан тэр хайрыг цорын ганц Хүүгээ өгөхдөө харуулж, тийм хайраар бие биеэ хайрлахыг Өөрийн хүмүүст уриалдаг.

Энэ нь өөр ертөнцийн гэмээр, дэлхийн хаана ч байхгүй хайр билээ. Бурханы хайранд эхлэл гэж үгүй, бас төгсгөл байхгүй. Бурханы хайрыг ямар нэг хэмжигдэхүүнээр хэмжих боломжгүй. Энэ хайр цэвэр ариун бөгөөд шунал тачаалын хэлтэрхий өчүүхэн ч агуулдаггүй. Энэ хайр ашиг бодохгүйгээр өөрийгөө золиосолж чаддаг. Хайрын мөн чанар бол өгөх. Учир нь “Бурхан ертөнцийг үнэхээр хайрласандаа цорын ганц Хүүгээ өгсөн” (Иох 3:16), “Христ та нарыг хайрласан бөгөөд Өөрийгөө бидний төлөө...өргөсөн” (Еф 5:2) гэж бичигджээ. Хайр нь үргэлж бусдын сайн сайхныг эрэлхийлдэг. Хайр нь муухай хүнийг ч, сайхан хүнийг ч хайрладаг. Өстөн дайснаа ч, анд нөхрөө ч хайрладаг. Хайрлуулагч нь үнэ цэнтэй, гавьяатай болохоор биш, хайрлагч нь сайн болохоор хайр гарч ирдэг. Хайр нь хувиа үл хичээгч бөгөөд хэзээ ч хариу нэхдэггүй, өөрийн ашгийн төлөө бусдыг завшдаггүй. Хайр нь бурууг дурсдаггүй, харин тэр бүх муу муухайн өмнүүр хөшиг татаж халхалж өгдөг. Хайр нь хараалыг ерөөлөөр, мууг сайнаар хариулж, өөрийг нь алах хүмүүсийн төлөө ч

залбирдаг. Хайр үргэлж бусдыг бодож, өөрөөсөө илүү бусдын сайн сайхныг хүсдэг.

Гэхдээ хайранд хатуу чанар бий. Бурхан хайрладаг хүнээ сахилгажуулдаг. Хайр нүглийг хүлцдэггүй. Яагаад гэвэл, нүгэл хор хөнөөлтэй. Тиймээс хайр нь хайрлаж байгаа хүнээ хор хөнөөлөөс хамгаалахыг хүсдэг.

Бурханы хайрын хамгийн агуу илрэл болбоос, Голгота хэмээх газар загалмай дээр цорын ганц хайрт Хүүгээ үхүүлэхээр өгсөн явдал билээ.

*Хамаг тааллыг тань хүртэж  
Хамгийн үнэт эрдэнэ тань болсон  
Хайрт Хүү Христийнхээ үхлээр харуулсан  
Хайрыг тань хэн хэмжиж чадах вэ, Бурхан минь!*  
(Аллабен)

## 1 сарын 26

*“Хайртууд минь, Бурхан биднийг ийнхүү хайрласан бол бид ч бие биеэ хайрлах учиртай.” (1Ио 4:11)*

Хянаж болдоггүй, урьдчилан таамаглах аргагүй сэтгэл хөдлөлтэй хайрыг андуурч болохгүй. Хайрлахыг бидэнд тушаасан. Хэрэв хайр гэдэг нь хэзээ ч хаашаа ч эргэж мэдэх сэтгэл хөдлөл байсан бол уг тушаалыг биелүүлэх боломжгүй. Хайр нь сэтгэл хөдлөлийг агуулдаг боловч сэтгэлийн хөдлөл гэхээсээ хүслийн асуудал юм.

Хайрыг бид өдөр тутмын амьдралаас салгаж, мөрөөдлийн ертөнцийн зүйл мэт ойлгож болохгүй. Харин ч, хайр гэдэг өдөр тутмын бүхий л асуудалтай зууралдаж байдаг.

Өөрөөр хэлбэл, хайр нь бодит үйлдлүүдээр илэрдэг. Жишээлбэл, ширээн дээр тавагтай гадил жимснүүд тавихад нэг нь хар толботой байлаа. Хайр тэрийг нь авна. Хайр хэрэглэсэн зүйлээ угааж цэвэрлэдэг. Хайр 00-ын цаас дууссан байхад шинийг авчирч тавиад дараагийнхаа хүмүүст хүндрэл учрахаас сэргийлнэ. Хайр, хэрэглээгүй бол тогоо унтраадаг. Хайр газарт унасан эд зүйлийг гишгэж гарахын оронд дээш нь авч тавьдаг. Хайр нь бусдын машиныг түр хэрэглэсэн бол бензинийг нь хийж өгдөг. Хайр хүмүүсийг хүлээлгэдэггүй. Хайр нь өөрөөсөө түрүүлж бусдад үйлчилдэг. Хайр нь цуглааныг үймүүлэхгүйн тулд уйлж буй хүүхдийг аваад гардаг. Хайр нь сонсгол муутайд чанга ярьж өгдөг. Хайр нь бусдад хуваалцах юмтай байхын тулд шургуу ажилладаг.

*Хайрын хувцасны эмжээр нь  
Хамаг муухайд хурч байдаг  
Хар хирээс айдаггүй тэр  
Хаа сайгүй ажиллаж байдаг  
Хайр, ууланд сууж биеэ оторлохгүй  
Хайр, тосгонд очиж шургуу ажиллана  
Учир нь түүний санаа сэтгэл  
Унтарсан амьдралыг асаатлаа амрахгүй*

## 1 сарын 27

“Цагийг авар.” (Еф 5:16 АБ2004)

Энэ ертөнцийн хүмүүс хамаг цагаа ажиллахад зориулж байхад христитгэгчид юу ч хийлгүй дэмий суудаг. Цагийг үр бүтээлгүй өнгөрөөх нь нүгэл юм.

Бүх үеийн хүмүүс хичээнгүй ажиллахын чухлыг ярьсаар иржээ. Аврагч Эзэн маань ч гэсэн, “Намайг Илгээгчийн үйлсийг Би өдөр байхад хийх ёстой. Хэн ч ажиллаж чадахгүй шөнө ирж байна” (Иох 9:4) гэж хэлжээ.

Кэмпис хотын Томас, “Хэзээ ч битгий зүгээр суу. Байнга ном уншиж, бичиж, залбирч, тунгаан бодож бай. Үргэлж бусдын сайн сайхны төлөө ямар нэг ажил хий” гэж бичсэн байдаг.

Бурханы үгийг тайлбарлагчийн хувьд хэрхэн амжилтад хүрсэн талаар нь Г. Кэмбэл Морганаас асуухад “Ажиллах, ажиллах, шургуу ажиллах” гэж хариулж байсан.

Эзэн Есүс энэ дэлхийд мужаан хийдэг байсныг мартаж болохгүй. Амьдралынх нь ихэнх хугацаа мужааны цехэд өнгөрсөн билээ.

Паул майхан оёдог байсан. Энэ ажил нь үйлчлэлийнх нь чухал хэсэг байлаа.

Нүгэл орж ирсний уршгаар бид ажиллах ёстой болсон гэдэг үзэл үндсээрээ буруу. Нүгэл орж ирэхээс өмнө Бурхан Адамыг цэцэрлэгт авчирч, цэцэрлэгийг арчлан сахих ажил даалгасныг санаарай (Эх 2:15). Нүглийн хараалд хөлслөө дуслуулан ажиллах нь багтдаг (Эх 3:19). Мөнхийн улсад очсон ч бид ажил хийнэ. Учир нь, “зарц нар нь Түүнд үйлчилнэ” (Илч 22:3) гэж бичигджээ.



Ажил бол ерөөл юм. Ажил хийж байж бүтээлч сэтгэлгээ минь тэлдэг. Ажил хийж байж бие сэтгэл маань саруулшдаг. Ажил хийгээд завгүй байх үед нүглээс бид хол байдаг. Учир нь “Сатан зүгээр суугчийн гараар хийлгэх муу муухайг хялбархан олдог юм” (Исаак Уаттс). “Сатан зүгээр суугаа хүнийг уруу татах уруу татлагад ордог” гэж Томас Уатсон хэлсэн. Чин шударга, хичээл зүтгэлтэй, итгэмжтэйгээр ажиллах нь христэч гэрчлэлийн маань амин чухал хэсэг мөн. Ажил хөдөлмөрийн маань үр шим биднийг өнгөрсөн хойно ч үлдэж хоцорч болно. Яг үүнийг нэг хүн ингэж хэлсэн: “Бие нь булшинд хэвтэж байхад ч гэсэн үр шимээ өгч байдаг тийм ажлыг хийх нь хүн бүрийн үүрэг мөн.” Виллиям Жэймс бас энэ талаар, “Үхсэний минь дараа ч гэсэн үлдэж хоцордог зүйлд цаг хугацаагаа зориулж болдог нь амьдралын сайхан чанар юм” гэж хэлжээ.

## 1 сарын 28

“Түүнд итгэгч нь үл тэвдэнэ.” (Иса 28:16)

Дуунаас хурдан онгоцоор аялдаг, өндөр хурдаар харилцаа холбоо үүсгэдэг энэ эрин үед, мөн хурдыг чухалчилдаг ийм соёл иргэншил дунд бид амьдарч байна. Харамсалтай нь үүнээсээ болоод Бурхан яарлыг Библид сайн талаас бараг дурсаагүй гэдгийг олж харахгүй болжээ. Бараг гэж хэлсний учир нь, эцэг нь тэнэмэл хүүгээ эргэж ирэхэд өөдөөс нь хар хурдаараа гүйсэн гэх нэг тохиолдол байгаа юм. Тэгэхээр Бурхан уучлахад яардаг байна. Харин ердийн үед ерөөсөө яарч адгадаггүй.

Давид “хааны тушаал яаралтай” (1См 21:8) гэж хэлэхдээ хүнийг хуурч байсан тул түүний үгийг барьж, өөрсдийн яаруу тэвдүү байдлыг хаацайлах хэрэггүй. Библийг харвал Эзэнд итгэгч хүн яарч тэвдэх шаардлагагүй аж. Ажил маань хэчнээн яаралтай байсан ч, махан биеийн үйлсээр адгаж хийснээс илүү Сүнс дотор чимээгүй алхвал үр бүтээл гардаг.

Зарим залуус хүнтэй гэрлэх гэж яардаг. Хурдан шуурхай хөдлөхгүй бол хайртай охин нь өөр хүнийх болчихно гэж адгасандаа тэр юм. Үнэнийг хэлье. Хэрэв тэр охин үнэхээр чиний заяаны хань мөн бол, Бурхан түүнийг чамд өгсөн бол өөр хэн ч түүнийг авч чадахгүй. Харин тэр охин Бурханы сонголт биш бол, “Хурдан гэрлээд удаан харамсах” гэж ямар утгатай үг болохыг их л зовлонтой замаар ойлгож авах болно.

Зарим хүн бүтэн цагийн үйлчлэлд орох гэж яардаг. Ертөнц мөхөл рүүгээ явж байхад надад хүлээж суух цаг алга гэж тэд маргадаг. Тэгвэл Эзэн Есүсийг бод. Тэрээр

Бурханы цагийг иртэл Назар хотод олон жилийг яаралгүй хүлээсэн.

Зарим хүн адгасан байдлаар бусдад сайнмэдээ тараадаг. Ингэхдээ, ургац боловсрохоос өмнө үр жимс түүж байна гэж хэлцгээдэг. Даан ч, Ариун Сүнс тухайн хүний дотор ажиллах, тэр хүн нүглээ олж харах цагийг хүлээдэггүй. Ийм яарч адгасан байдлаар ажиллах үед авралд үл хүрэх хуурамч итгэсэн гэх хүмүүс төрөх аюултай бөгөөд эцэст нь хүний амь амьдрал сүйрнэ. “Тэсвэр хатуужил нь төгс үр дүнтэй байг” (Иак 1:4 АБ2004) гэснийг бүгдээрээ баримталцгаая.

Өөрөө өөрийгөө томилсон үйлчлэлдээ утга учиргүй яарч тэвдсэнээр бус, Ариун Сүнсээр удирдуулан ажиллаж, Эзэнийг тэвчээртэй хүлээснээр амьдралд маань жинхэнэ үр дүн гарна.

## 1 сарын 29

*“Тийм ээ Аав минь, учир нь Таны өмнө энэ нь тааллыг олсон билээ.” (Мт 11:26)*

Хэзээ ч сонгож авахгүй, салж хагацахын түүс болдог ч, хэзээ ч өөрчилж чадахгүй зүйлс хүн бүрийн амьдралд байдаг. Жишээлбэл, хөгжлийн бэрхшээлтэй төрөх, хүнд өвчин тусах, сэтгэлийн хүнд дарамтад орох...

Маш олон хүн, ийм байсан бол гэж мөрөөдсөөр ялагдсан амьдралаар амьдарч байна. Хэрэв би өндөр байсан бол. Арай царайлаг байсан бол. Өөр айлд эсвэл өөр улсад төрсөн бол. Өөр хүйстэй төрсөн бол. Тамирчин болохоор биетэй байсан бол. Эрүүл саруул байсан бол.

Энэ хүмүүсийн сурах ёстой зүйл гэвэл, өөрчилж чадахгүйгээ хүлээн зөвшөөрснөөр амар амгалан ирдэг юм. Бид ямар байгаа нь Бурханы нигүүлсэл билээ. Бурхан, хязгааргүй хайр ба дуусашгүй мэргэн ухаанаар бидний амьдралыг төлөвлөсөн. Бурханы хардаг шиг хардагсан бол Түүний хийснийг буруутгаж чадахгүй. Бид өөрсдөө тийн хийх байсан. Тиймээс бид “Аав минь, учир нь Таны өмнө энэ нь тааллыг олсон билээ” гэж хэлэх тэнхээтэй байх ёстой.

Гэхдээ тэгээд болчихгүй. Өөрчлөх аргагүй зүйлсийг даруугаар хүлээж авахаас илүү хандлага бий. Энэ бүхэн хайрын Бурханы зөвшөөрлөөр болсон юм бол тэдгээрийг бид магтаал ба баяр хөөрөөр хүлээн авах хэрэгтэй. Паул биед нь өгөгдсөн өргөсийг зайлуулж өгөөч гэж Бурханаас гурвантаа залбирсан. Эзэн уг өргөсийг гэвчих нигүүлслийг өгнө гэж амлахад “Христийн хүч надад орших тул би ихэд

баяртайгаар мөхөсдөлөөрөө илүү сайрхана” (2Ко 12:9)  
хэмээн Паул мэдэгдсэн.

Амьдралд буй зовлонг нөхцөл байдалд баярлаж талархаад түүгээр Бурханыг алдаршуулж байвал сүнслэг төлөвшилд хүрсний шинж юм. Фэнни Кросби энэ ухаарлыг аль залуудаа олж авчээ. Сохор найрагч маань наймхан насандаа дараах шүлгийг бичиж байв:

*Харж чадахгүй ч гэлээ*

*Ямар ивээгдсэн хүүхэд вэ би!*

*Хараагүй болсон ч гэлээ*

*Сэтгэл амгалан байдаг би!*

*Өөр хүмүүсийн мэдэрч чадахгүй*

*Олон ивээл надад бий*

*Өрөөлийн зовлонг үзэж мэдрэхгүй*

*Онцгой ерөөл сохор надад бий*

## 1 сарын 30

“Үнэгүй авснаа үнэгүй өг.” (Мт 10:8)

Дэлхийн шилдэг хийлчдийн нэг Фриц Крайслер ингэж хэлжээ: “Хөгжим намайг төрөхөд дотор минь байсан. Уншиж сурахаасаа ч өмнө хөгжмийн нотуудыг би зөнгөөрөө мэддэг байлаа. Энэ бол Бурханы хишиг. Би үүнийг шинээр сураагүй. Тиймээс би хөгжмийн төлөө талархлаа илэрхийлэх эрхгүй...Хөгжим бол худалдаж борлуулахын аргүй ариун дагшин зүйл. Өнөө үед хөгжмийн алдартнууд хэтэрхий өндөр үнэ нэхдэг нь нийгмийн эсрэг хийж буй гэмт хэрэг мөн.”

Христийн ажилчин бүхэн энэ үгийг зүрхэндээ авах ёстой. Христэч үйлчлэл нь авах биш өгөх үйлчлэл билээ. “Надад ямар ашигтай вэ?” гэдэг асуулт бидэнд нийцэхгүй. Түүний оронд “Би явал сайнмэдээг олон хүнд хүргэж чадах вэ?” гэж асуух нь зөв. Христийн үйлчлэлд бид бусдаас төлбөр авах биш, бусдад зориулж өгөх үүрэгтэй.

“Ажилчид хөлсөө авах нь зохистой,” (Лк 10:7) “сайнмэдээг тунхаглагчид сайнмэдээгээр амь зуухыг Эзэн тогтоосон” (1Ко 9:14) гэж үнэн. Гэхдээ энэ нь өөрт өгөгдсөн бэлгийг мөнгөөр үнэлдэг явдлыг зөвтгөхгүй. Зохиосон магтан дууг нь ашигласны төлөө төлбөр авдгийг зөвтгөхгүй. Номлол хийх юм уу магтаалд дуулсны төлөө дэндүү их мөнгө авдгийг зөвтгөхгүй.

Илбэчин Симон бусдад Ариун Сүнснийг өгдөг хүч чадлыг мөнгөөр худалдаж авахыг санаархсан (Үйл 8:19). Ийм хүч чадалтай болчихвол мөнгө олж болохыг тэр олж харсан нь дамжиггүй. Эдүгээ сүсэг бишрэлийн давуу талыг олз ашгийн хэрэгсэл болгох үйлдлийг англи хэлэнд түүний

нэрээр нэрлэх (simony) болжээ. Өнөөдөр шашин шүтлэгийн ертөнцөд simony газар авчихсан гээд хэлбэл үнэнээс хол зөрөхгүй.

Мөнгийг христэч нэртэй ажлуудаас аваад хаячихвал олон үйлчлэл тэр даруй зогсох болно. Гэсэн ч эцсийн хүчээ шавхах хүртэл ажлаа үргэлжлүүлэх Эзэний итгэмжит зарц нар ч гэсэн бий.

Бид үнэнгүйгээр авснаа үнэгүй өгөх ёстой. Хэдий чинээ өгнө, төдий чинээ ивээл ерөөлийг хүртэж, илүү агуу шагналтай болно. “Тэгэхдээ шахагдсан, чигжсэн мөн бялхсан сайн хэмжээгээр өвөр дээр чинь асгарах болно.” (Лк 6:38)

## 1 сарын 31

*“Бүү шүү, тэгвэл шүүгдэхгүй.” (Мт 7:1)*

Библийг сайн мэдэхгүй хүмүүс энэ эшлэлийг сайн мэддэг бөгөөд их этгээд янзаар ашигладаг. Бузар муу үйлдлийг нь шүүмжилсэн ч гэсэн “Бүү шүү, тэгвэл шүүгдэхгүй” гэж өөдөөс нь хариулдаг. Өөрөөр хэлбэл, энэ эшлэлийг ашиглаад гэмт үйлдлээ хаацайлж суудаг.

Гэвч Библийн сургаал ёсоор, шүүж болохгүй талбар ба шүүх ёстой талбар гэж байдаг.

Шүүж болохгүй зүйлсийг дурдья: Бид хүмүүсийн сэдлийг шүүж болохгүй. Яагаад гэхээр бид бүхнийг мэдэгч биш бөгөөд тухайн хүн яагаад тийм үйлдэл гаргасныг нь мэдэхгүй. Мөн бусад итгэгчийн үйлчлэлийг шүүж болохгүй. Тэр Эзэнийхээ өмнө унадаг бас босдог. Цаашилбал, ёс суртахууны хувьд сааралд тооцогдох зүйлсийг буруу гэж үздэг хүмүүсийг шүүж болохгүй. Хүмүүсийн мөс чанарыг сэвтүүлэх нь өөрөө буруу юм. Түүнээс гадна, хүмүүсийг гадаад үзэмжээр нь шүүж болохгүй. Бурхан гадаад үзэмжийг биш, зүрх сэтгэлийг хардаг. Эцэст нь, бид юмыг шүүмжлэлт нүдээр хардаг байж болохгүй. Бусдын өөг байнга олж хардаг хүн христитгэлийг бусдад сайнаар таниулах нь ховор.

Тэгвэл нөгөө талд заавал шүүх ёстой талбарууд бий. Нэгт, аливаа сургаал номлол нь Библитэй таарч байна уу гэж шүүх ёстой. Хоёрт, хүмүүсийг жинхэнэ итгэгч мөн үү биш үү гэж шүүн үзэх ёстой. Тэгж байж, үл итгэгчидтэй нэг буулгад орохгүй. Гуравт, итгэгчдийн хоорондох маргааныг чуулган дотор шүүж, тэднийг төрийн шүүхийн өмнө очуулахаас хамгаална. Нутгийн чуулган дотроо



байгаа ноцтой нүглийг шүүж, буруутай итгэгч үл гэмших аваас түүнийг нөхөрлөл дотроосоо гаргах ёстой. Чуулганы итгэгчид ахлагч, үйлчлэгч болох гэж буй хүнийг шалгуурт тэнцэх эсэхийг шүүх ёстой.

Бурхан биднийг юуг ч шүүн тунгааж үздэггүй, ёс суртахууны болон сүнслэг хэм хэмжээг үл ойшоосон хүмүүс байгаасай гэж хүсдэггүй. Гагцхүү шүүх ёсгүйг эс шүүж, шүүх ёстойг шүүдэг байгаасай гэж хүсдэг.

## 2 сарын 1

“...Христийн алдрын тухай сайнмэдээ...” (2Ко 4:4)

Сайнмэдээ бол Христийн алдрын тухай гэдгийг хэзээ ч мартаж учиргүй. Сайнмэдээ нь цовдлогдон үхээд, булшлагдсан Нэгэний тухай гэдэг нь үнэн боловч одоо Тэр загалмай дээр бас булшинд байхаа нэгэнт больжээ. Тэр үхлээс амилж, тэнгэр өөд одож, цог жавхланд орж, Бурханы баруунтаа заларч байна.

Түүнийг одоо даруу дорд Нэгэн, Назарын мужаан, зовлонт Зарц, Галилын харь хүн гэж танилцуулах ёсгүй. Аль эсвэл, орчин үеийн шашны төлөөлөл дүр болсон буянт үйлстэн мэт толилуулах ёсгүй.

Бид амь ба алдрын Эзэнийг тунхаглах ёстой. Тэр бол Бурханы өргөмжилсөн Нэгэн, бүх нэрээс дээд нэрийг хүртэгч. Түүний нэрд өвдөг бүхэн сөхөрч, Бурхан Эцэгийн алдрын төлөө Есүс Христ бол Эзэн гэж хэл бүхэн хүлээн зөвшөөрнө. Тэрээр алдар хүндлэлийн титэм өмссөн Жонон ба Аврагч.

Бид номлодог сургаалаараа олон тохиолдолд Түүнийг гутаадаг. Хүнийг авьяас чадвараар нь өргөмжилж, ийм хүнээр үйлчлүүлж буй Бурхан азтай гэх сэтгэгдлийг хүмүүст төрүүлдэг. Өөрт нь итгэснээр Эзэнд тусыг үйлдэж байгаа юм шиг загнадаг. Энэ бол элч нарын тунхаглаж байсан сайнмэдээ биш ээ. Тэдний сургаалын агуулгыг дүгнэн хэлбэл: “Та Эзэн Есүс Христийн үхэлд буруутай. Та Түүнийг барьж аваад, бузар гараараа модонд өлгөсөн. Гэвч Бурхан Түүнийг үхлээс амилуулж, тэнгэрт баруун гарынхаа хүндэт суудалд өргөмжлөн алдаршуулсан. Өнөөдөр Тэр тэнд цог жавхлант биеэ өмсөн сууж байна.

Хадаас зоолгосон гар нь орчлон ертөнцийг захирах эрх мэдлийн таяг атгаж байна. Тэрээр дэлхийг шударга ёсоор шүүхийн тулд эргэн ирнэ. Тиймээс ГЭМШИЖ, Түүн рүү эргэж, Түүнд ИТГЭ. Энэ нь танд өлзийтэй. Өөр хэний ч дотор аврал үгүй. Учир нь бид аврагдаж болох өөр нэр тэнгэрийн доор хүмүүнд эс өгөгдөв.”

Цог жавхлант Нэгэнийг олж харатун! Тэргүүндээ алдрын титэмтэй Нэгэнийг тунхаглагтун! Тэгвээс Пентекостын өдрийнх шиг, хүмүүс “Ах дүү нар аа, бид одоо яах вэ?” (Үйл 2:37) гэж дуу алдацгаах болно.

## 2 сарын 2

*“Учир нь ‘Харанхуйгаас гэрэл гэрэлтэг’ гэж айлдсан Бурхан бол Христийн царайн дахь Бурханы алдрын мэдлэгийн гэрлийг өгөхөөр бидний зүрхэнд гэрэлтсэн Нэгэн юм.” (2Ко 4:6)*

“Бурхан бол...гэрлийг өгөхөөр бидний зүрхэнд гэрэлтсэн Нэгэн.” Юу гэсэн үг вэ гэвэл, бид Бурханы ерөөлийн эцсийн цэг бус, харин дамжуулах суваг нь юм. “Бидний зүрхэнд гэрэлтсэн” гэдэг нь бидний аврагдсаныг хэлж байна. Бурхан анх орчлон ертөнцийг бүтээхдээ гэрэл гийг хэмээн тушаасан шиг, биднийг шинэ бүтээл болгохдоо зүрхэнд минь гэрэлтжээ.

Гэхдээ Өөрийнх нь ерөөлийг дотроо хадгалаад дуусаасай гэж Тэр үүнийг хийгээгүй. Харин Христийн царайн дахь Бурханы алдрын мэдлэг биднээр дамжин бусдад хүрээсэй гэж хүссэндээ хийсэн.

Паул яг ийм санаа агуулж, “Хүүгээ миний дотор илчилснээр Түүнийг би харийнхны дунд тунхагладаг юм” (Гал 1:16) гэж хэлсэн. Бурхан Хүүгээ бидний дотор илчилсэн. Харин бид Түүнийг бусдад илчлэх ёстой. Олон жилийн өмнө энэ үнэнийг ухаарсан мөчдөө би Библийнхээ урд талын хоосон хуудас дээр дараах үгийг бичиж билээ:

Хүмүүс Есүс Христийг харъя гэвэл  
Магад чамаас Түүнийг олж харна  
Макдоналд аа, тэд юу олж харах бол?

“Номлол бол маш хариуцлагатай, бишрэл хүндлэлээр хийх учиртай, ер бусын ажил. Номлох үед Нэгэн хүн, хүнээр дамжин хүмүүст хүрдэг. Дамжин очдог тэр Хүн бол мөнх

Есүс юм” гэж Иэнь Мэкфэрсоны хэлсэн үг үнэн юм. Тэрээр үүнийг тайлбарлахдаа ашигласан жишээг доор сийрүүлье: “V Жорж хаан радиогоор үг хэлж байж. Түүний үг Америк даяар цацагдсан байна. Гэтэл Нью Йоркийн станцын гол кабельд гэмтэл гарч, ажилчид нь яах учраа олохгүй сандралджээ. Яг энэ үед залуу засварчин Хэролд Вивиень гэмтэлтэй кабелин хоёр үзүүрээс чанга гэгч нь атгаж авав. Кабелиар хааны яриаг дамжуулж байсан гүйдэл гүйж байлаа. Хоёр зуун тавин вольтын цахилгаан цэнэг түүний биеийг цохиж, хөлийн улнаас толгой хүртэл нь сарвагануулж, түүнд маш хүнд гэмтэл учруулсан боловч залуу засварчин кабелаас гараа авсангүй. Хааны үгийг хүмүүс сонсож дуусах хүртэл тэр залуу кабелиас тас зуурсан байлаа.”

*Ивээлт Эзэн минь ээ, бид бол суваг  
Та Өөрийн аугаа хүч чадлаараа  
Өдөр тутам, цаг мөч бүхэнд  
Биднээр дамжин ажиллаж чадна*

## 2 сарын 3

*“Алтан бойпор барьсан өөр нэгэн тэнгэрэлч ирж, тахилын ширээний дэргэд зогсов. Түүнд их хэмжээний утлага өгөгджээ. Ингэснээр тэр тэнгэрэлч түүнийг сэнтийн өмнө байх тахилын алтан ширээн дээр бүх ариун хүмүүсийн залбиралтай хамт өргөх ажээ.” (Илч 8:3)*

Энэхүү эшлэлд дурдагдсан тэнгэрэлч бол Эзэн Есүс юм. Түүний энэ үйлчлэл бидний хувьд тайтгарал ба урам зоригоор дүүрэн байна.

Тэр юу хийж байна вэ? Бүх ариун хүний залбирлыг авч, дээр нь үнэт утлагыг нэмээд Эцэг Бурханд өргөж байна.

Бидний залбирал ба магтаал төгс бус гэдгийг бид сайн мэднэ. Бид яаж залбирахаа мэддэггүй. Хийдэг бүх зүйл маань нүгэл, хуурамч сэдэл, хувиа хичээсэн зангаар бохирдсон байдаг.

*Өвдөг сөгдөн залбирахдаа ариун цагийг гаргасан гэж санадаг бид*

*Өнгө аялгуут дуун магтаалаа таалалд тань нийцсэн гэж боддог бид*

*Бүхний зүрхийг Нягтлагч Та, энэ бүхний маань дээр уучлалаа асгаач*

Тэгвэл бидний мөргөл ба залбирал Эцэг Бурханд хүрэхийн өмнө эхлээд Эзэн Есүсээр дамждаг байна. Эзэн Есүс төгс бусын хамаг ул мөрийг арилгаад Эцэг Бурханд өө сэвгүй мөргөл ба залбирлыг авч очдог. Зөвхөн үүгээр дуусахгүй. Эзэн Есүс ариун хүмүүсийн залбирал дээр утлага нэмдэг. Энэхүү утлага нь Эзэн Есүсийн хэн бэ гэдэг

мөн чанар ба хийсэн ажлын төгс төгөлдрийн анхилуун үнэр юм. Уг утлага залбирлыг маань үр дүнд хүргэдэг.

Ямар их урамшуулал вэ! Залбирал маань олон алдаа дутагдалтайг бид хэнээр ч хэлүүлэхгүй сайн мэднэ. Бид үгээ зөв хэлдэггүй. Өөрсдийгөө зөв илэрхийлдэггүй. Онол сургаалын алдаатай үгс унагадаг. Гэвч энэ бүхэн залбирлаас хойш суух шалтгаан биш ажээ. Бидэнд Агуу Тэргүүн Тахилч бий. Тэрээр Эцэгт өргөсөн үг бүхний маань алдааг хянан засварлаад, бүх залбирлыг маань ариусгадаг.

Мэри Боулигийн шүлэг энэ үнэнийг яруу найргаар сайхан илэрхийлжээ:

*Мөнх сэнтийний тань өмнө*

*Мөн чиг их утлага суунаглажээ*

*Мөхөс доройн дууг сонсохоор*

*Мөнхийн Эзэн доош бөхийжээ*

*Залбирал ба магтаалд минь*

*Христийн сайхан үнэр шингээжээ*

*Утлагын бойпор дээшээ очиход*

*Бурхан түүнийг таалан соёрхжээ*

## 2 сарын 4

*“Хэрвээ би ‘Би ингэж ярина’ гэсэн бол, харагтун, би Таны хүүхдүүдийн үе удмаас урвах байсан.” (Дуу 73:15)*

Дуулалыг бичигч Асаф хэцүү амьдралыг туулж байлаа. Түүний нүд, хорон муу хүмүүс дэлхий дээр хөгжин дэвжиж буйг харжээ. Гэтэл өөрийнх нь амьдрал хар дарсан зүүд шиг зовлон шаналал дунд байв. Тэрээр Бурханы шударга ёс, Бурханы хайр, Бурханы мэргэн ухаанд эргэлзэж эхэлжээ. Эзэн ёс бусыг шагнаж, шударгыг шийтгэдэг юм шиг түүнд санагджээ.

Гэхдээ Асаф нэр төртэй шийдвэр гаргасан. Тэрээр Бурхны хүүхдүүдийг бүдрүүлэхгүйн тулд эргэлзээгээ бусдад хэлэхгүй байхаар шийдсэн.

Бидэнд ч бас эргэлзэх, асуулт асуумаар санагдах үе ирдэг. Ялангуяа тэсвэр тэвчээр маань барагдаж, бүх зүйл биднийг дараад авах шиг санагдахад Бурханы тусламжид эргэлзэж эхэлдэг. Ийм үед яах ёстой вэ?

Мэдээж хэрэг, төлөвшсөн хүнд эргэлзээгээ ярьж, зөвлөгөө авч болно. Заримдаа бид хонгилын үзүүрт тусч буй гэрлийг харах тэнхэлгүй болдог. Харин хөндлөнгийн хүмүүс тэр гэрлийг олж хараад тэр зүгт биднийг чиглүүлж чаддаг.

Бусдаар бол, “гэрэлд бидэнд илчилсэн зүйлд харанхуй болмогц эргэлзэж болохгүй.” Нөхцөл байдал хэчнээн хэцүүдсэн ч Бурханы үгийг нөхцөл байдлаар тайлбарлаж болохгүй. Үүний оронд нөхцөл байдлыг Библиэр тайлбарла. Юу ч болж байсан, Бурханы зорилго заавал биелнэ гэдэгт итгэж, Түүний амлалтуудыг санаж бай.



Гэхдээ хамгийн чухал нь, өөрсдийн эргэлзээг хайхрамжгүй байдлаар хаа сайгүй ярьж явах ёсгүй. Христийн доторх бяцхан хүүхдүүдийг бүдрүүлэгч золгүй еэ! Учир нь, “Надад итгэгч энэ балчруудаас нэгийг нь хэн бүдрүүлнэ, тэр нь хүзүүндээ тээрмийн чулуу зүүгээд, тэнгисийн гүнд живсэн нь дээр” гэж бичигджээ (Мт. 18: 6).

Бидэнд буй баталгаа тоо томшгүй олон. Харин эргэлзэх шалтгаан маань цөөхөн. Тэр баталгаануудыг бусдад хуваалцаж байя. Гёте, “Танд итгэл байгаа бол түүнийгээ надад өгөөч. Эргэлзээгээ харин өөртөө хадгал. Учир нь надад өөрийн гэсэн эргэлзээ хангалттай байгаа” гэж хэлсэн.

## 2 сарын 5

*“Та бүхнийг үйлдэж чаддаг, зорьсонд тань боломжгүй нь үгүй гэдгийг би мэднэ.” (Иов 42:2)*

Бурханы зорилго заавал биелдэг. Хүн бузар мууг үйлдэж болох ч Бурханд Өөрийн арга зам бий. Хүнд хэлэх үг олон ч, Бурхан эцсийн үгийг хэлнэ. “ЭЗЭНийг сөрөн чадах мэргэн ухаан, бодрол ухаан, зөвлөгөө ч гэж ер үгүй” (Сур 21:30) хэмээн Соломон сануулсан. Иеремиа бас, “ЭЗЭНий зорилгууд байсаар байна” (Иер 51:29) хэмээн гэрчилсэн.

Ах нар нь Иосефыг мидианчуудад худалдаад түүнээс салж амрахыг хүссэн. Гэвч тэдний хийсэн ажил Бурханы хүслийг гүйцэлдүүлжээ. Мидианчууд Иосефыг Египет рүү үнэгүй хүргэж өгч, Иосеф тэнд ерөнхий сайд болон өндийж, өөрийнхнийгөө аварчээ.

Төрөлхийн сохор хүн хараатай болоод Аврагч Эзэнд найдахад иудейчүүд түүнийг синагогоос хөөсөн. Үүгээрээ иудейчүүд ялалт байгуулсан гэж үү? Үгүй ээ. Есүс угаасаа түүнийг синагогоос гаргах л байсан. Учир нь Сайн Хоньчин “өөрийн хоньдыг нэрээр нь дуудаж, тэднийг дагуулж гаргана.” (Иох 10:3) Тиймээс иудейчүүдийн үйлдэл Есүсийн ажлыг хөнгөвчилсөн төдий юм.

Хүмүүсийн хорон муу нь оргилдоо хүрч, тэд Эзэн Есүсийг барьж аваад загалмайд хадан амийг нь хороосон. Гэвч Эзэн Есүс “тогтоосон шийдвэр ба урьдаас Бурханы мэдсэний дагуу тушаагдсан” гэж Петр сануулсан. Бурхан хүмүүний хамгийн том гэмт хэргийг ч давж, Христийг Эзэн ба Аврагч болгохоор үхлээс амилуулсан.

Доналд Грэй Барнхаузын ярьсан түүхийг энд сийрүүлье: “Нэгэн баян газрын эзэн байж гэнэ. Тэрээр эзэмшил газартаа үзэсгэлэнт сайхан мододтой ажээ. Гэвч түүний өстөн дайсан түүнийг хохирооё гэж санан нэг модыг нь огтлохоор шийдэв. Шөнө болоход дайсан этгээд хамгийн үзэсгэлэнтэй модыг сүх хөрөөгөөр огтолж эхлэв. Үүр цайхад хоёр морьтон ирж яваа харагдлаа. Нэг нь газрын эзэн байв. Өнөөх хүн цавчигдсан модыг торгоож байсан шаантгийг сугалж аваад эзнийх нь нүдэн дээр модыг унагаах гэтэл модны нэг мөчирт тээглээд модонд дарагдан хүнд гэмтэл авч нас баржээ. Үхэхийнхээ өмнө тэр хүн ‘Би чиний энэ сайхан модыг тайрч унагасан юм’ гэж гэнэ. Тэгтэл газрын эзэн түүнийг өрөвдөнгүй хараад ‘Надтай яваа энэ хүн бол архитектурч байгаа юм. Бид байшин барья гэж төлөвлөөд нэг мод тайрч унаган байшин барих газраа өргөсгөө гэж хэлэлцсэн юм. Чи харин миний өмнөөс шөнөжингөө ажиллаж шүү дээ’ гэсэн гэдэг.”

## 2 сарын 6

*“Өөрсдийгөө хуурдаг зүгээр нэг сонсогчид биш, үгийг хэрэгжүүлэгчид бай.” (Иак 1:22)*

Уулзалт, хурал, цуглаан, зөвлөгөөнд суусныгаа Бурханы ажлыг хийж байна гэж бодож өөрсдийгөө хуурч мэхэлдэг шүү! Бид номлол сонсож, хийх ёстой зүйлсийнхээ талаар юу мэддэгээ ярилцдаг. Харамсалтай нь үүнийгээ бид Бурханы хүслийг биелүүлж байна гэж үздэгт гол төөрөгдөл оршдог. Их сонсож, их ярих тусмаа бид үүрэг хариуцлагаа нэмэгдүүлдэг бөгөөд өөрсдийгөө хуурч байгаа юм. Үнэн чанартаа бид махан биеийн дагуу явж байж, өөрсдийгөө сүнслэг гэж бодон өөрсдийгөө мэхэлдэг. Зогсонги байдалд орчихсон байж, сүнсээр өсөж байгаа гэж бодон өөрсдийгөө мэхэлдэг. Мунхаг болчихсон байж, мэргэн гэж бодон өөрсдийгөө мэхэлдэг.

Есүс юу гэж хэлснийг бодоод үзээрэй. Ухаантай хүн Түүний үгийг сонсоод хэрэгжүүлдэг. Тэнэг хүн Түүний үгийг сонсдог боловч хэрэгжүүлдэггүй.

Номлол сонсоод “Ямар гайхалтай сургаал вэ!” гэж хэлээд өнгөрөх нь хангалтгүй. Харин сонссон зүйлийнхээ талаар ямар нэг үйлдэл хийх хэрэгтэй. Үүгээр тэр хүний ухаарлыг шалгаж болно. Сайн номлол нь оюун санааг тэлж, зүрх сэтгэлийг бүлээцүүлж, урам зоригийг өдөөгөөд зогсохгүй, биднийг үйлдэл хийхэд хүргэдэг.

Нэгэн номлогч номлолынхоо дунд чуулганд ирсэн хүмүүсээс эхэнд дуулсан магтан дууны нэрийг асуув. Мэдэх хүн байсангүй. Уншсан эшлэлээ асуув. Мэдэх хүн байсангүй. Ямар зарлал хэлснийг асуув. Санах хүн байсангүй. Тэр хүмүүс цуглаан хийж тоглож байжээ.

Цуглаанд очихоосоо өмнө өөрөөсөө дараах асуултыг асуу. Би яагаад цуглаанд очих гэж байна вэ? Бурхан надад үгээ хэлээсэй гэж би хүсэж байна уу? Бурхан үгээ хэлбэл би Түүнийг дуулгавартай дагах уу?

Мөхсөн тэнгис нь гадагшаа цутгалангүй учраас Мөхсөн тэнгис нэртэй болсон. Бид ч гэсэн, хэрэгжүүлэхгүй зөвхөн мэдээлэл хүлээн авсаар байвал зогсонги байдалд орно. Аврагч Эзэн маань биднээс асууж байна: “Та нар Намайг ‘Эзэн, Эзэн’ гэж дууддаг хэр нь юунд хэлснийг минь үйлддэггүй юм бэ?” (Лк 6:46)

## 2 сарын 7

*“Би Христтэй хамт цовдлогдсон.”* (Гал 2:19)

Эзэн Есүс загалмай дээр үхэхдээ намайг орлохоос гадна намайг төлөөлж үхсэн юм. Тэр миний төлөө төдийгүй миний өмнөөс амиа өргөсөн. Түүнийг үхэхэд би ч бас хамт үхжээ. Адамын үр удам болохын хувьд надад байсан бүхэн, миний нүгэлт хуучин хүн загалмайд цовдлогдсон. Мах биед төрсөн хүний минь түүх Бурханы хувьд дуусгавар болжээ.

Ингээд дуусаагүй. Аврагчийг оршуулах үед би ч бас оршуулагдсан. Түүнийг булшлах үед би Христтэй нэг байсан. Нэг ёсондоо, Бурханы нүднээс хуучин “Би” үүрд далд оржээ.

Дараа нь Эзэн Есүс үхэгсдээс амилахад би ч бас амилав. Гэхдээ бүх юм өөрчлөгдсөн байна. Оршуулагдсан хуучин хүн эргээд амилсан юм биш. Харин шинэ хүн төрсөн юм. Одоо Христ миний дотор амьдардаг. Би шинэ амийн дотор алхахаар Христтэй хамт амилжээ.

Ингэж Бурханы нүднээ миний **байр суурь** өөрчлөгдсөн юм. Одоо энэхүү байр сууриа **бодит амьдралд** хэрэгжүүлээсэй гэж Бурхан хүсдэг. Өөрийгөө үхээд, оршуулагдаад дараа нь үхлээс амилсанд тооцоосой гэж Бурхан надаас хүсдэг. Яаж үүнийг хийх вэ гэж үү?

Уруу татлагад үхсэн хүний цогцос ямар хариу үзүүлэхийг бодоод үз. Үхсэн хүн ямар ч хариу үзүүлэхгүй. Уруу татлагад тэгж л ханд. Уруу татлага ирвэл эрс шийдмэгээр “Би нүглийн хувьд үхсэн. Чи миний эзэн байхаа больсон. Чиний хувьд би үхсэн хүн” гэж хэл.

Ялзарсан мөн чанартай, нүгэлт хуучин хүнээ Есүсийн булшинд оршуулагдсан гэж өдөр бүр бодож яв. Нэг ёсондоо хуучин хүндээ төвлөрөхөө байна гэсэн үг. Түүнээс сайныг хайхаа больж, өөдгүй мууг нь хараад урам хугарахгүй болно гэсэн үг.

Эцэст нь хэлэхэд, цаг мөч бүрд, Христтэй хамт амилсан шинэ хүний ёсоор амьдар. Шинэ хүсэл, шинэ сэдэл, шинэ зорилго, шинэ эрх чөлөө, шинэ хүч чадлаар амьдар.

Жорж Мюллер өөрийгөө хэрхэн Христтэй нэг болсноо дараах байдлаар илэрхийлсэн:

Нэг өдөр би нас барсан юм. Жорж Мюллерийн санаа сэтгэл, хүсэл зорилго, үзэл бодол тэр үед дуусжээ. Энэ ертөнцийн хувьд ч би нас барсан. Тэр мөчөөс энэ ертөнцийн цэнлүүр надад хамаагүй болсон. Ах дүү, найз нөхдийн маань магтаал сайшаал, буруутгал ч надад хүртээлгүй болсон. Гагцхүү Бурханы сайшаалыг олж авах нь одоо миний зорилго билээ.

## 2 сарын 8

*“Надтай хамт байдаггүй нь Миний эсрэг байна. Надтай хамт хураалцдаггүй нь тараагч нэгэн мөн.”* (Мт 12:30)

Эзэн Есүс энэ үсгийг фарисайчуудын тухайд хэлсэн. Тэд Ариун Сүнсний хүчээр хийсэн Эзэн Есүсийн гайхамшгуудыг чөтгөрүүдийн хаан Беелзебулийн хүч гэж хэлэн уучлагдашгүй нүгэл үйлджээ. Иймээс тэд Түүнийг Израилийн Мессиа, ертөнцийн Аврагч хэмээн хүлээж авахгүй нь тодорхой болов. Тэд Христийн төлөө зогсоогүй учраас Христийн эсрэг этгээдүүд гэдэг нь ойлгомжтой. Тэд Түүний талд ажиллаагүй болохоор Түүний эсрэг ажилласан нь илэрхий.

Христ гэж хэн бэ, Тэр ямар ажил хийсэн бэ гэдэг асуудалд төвийг сахих боломжгүй юм. Энэ тал дээр гуравдагч бодол гэж байдаггүй. Хүн нэг бол Христийн төлөө зогсдог. Эс бол Христийг эсэргүүцдэг. Хэнийх нь талд орохоо мэдэхгүй хүмүүс ч ялгаагүй Христийн эсрэг талд зогсож байдаг.

Христийн тухай үнэн дээр буулт хийж болдоггүй. Библийн дагуух христитгэлд хар ч биш, цагаан ч биш талбарууд гэж бий. Нэг ёсондоо хүмүүс тухайн асуудалд өөр өөр бодолтой байж болно гэсэн үг. Харин Христийн тал дээр тийм байх боломжгүй. А.В.Тозерын хэлсэнчлэн, “Зарим зүйлд буулт хийж болно.” Харин буулт хийж болохгүй үзэл баримтлал гэж бий. Тэр нь Эзэн Есүсийн тухай үзэл баримтлал билээ. Эзэн Есүс бол зуун хувь Бурхан бөгөөд Тэр онгон эмэгтэйгээс төрсөн, ямар ч гэм нүгэлгүй, Тэр нүгэлтнүүдийн төлөө тэднийг орлож нас барсан, Тэр үхлээс биеэрээ амилсан, тэгээд тэнгэр өөд



одож Бурханы баруунтаа заларч байгаа, Тэр хожим эргэн ирнэ гэдэг үзлийг бид бат баримтлах хэрэгтэй. Христитгэлийн энэ тулгуур сургаалуудыг сааралтуулагч нь хагас дутуу Аврагчийн зураглалыг бий болгох бөгөөд тэр нь Аврагч байх боломжгүй юм.

Энэ тухай бичсэн нэгэн шүлгийг сонсоно уу:

*Христийг хэн гэж үздэг чинь*

*Хэн болохыг чинь харуулаад өгнө*

*Есүсийг юу гэж хардаг чинь*

*Үнэн төрхийг чинь илчлээд өгнө*

*Түүнийг зөвөөр таниагүй бол*

*Таны зөв байх ямар ч боломжгүй*

*Есүсийг юу гэж хардгаар чинь*

*Христийг хэн гэж боддоогоор чинь*

*Бурхан танд хариу барина*

*Уучлах уу, уурлах уу гэдгээ шийднэ*

## 2 сарын 9

*“Хэн та нарыг үл эсэргүүцнэ, тэр та нарын талд.”* (Лк 9:49,50)

Өнгөцхөн харвал энэ эшлэл өчигдрийн эшлэлтэй зөрчилдөж байгаа мэт харагдана. Гэвч тийм биш. Өчигдрийн эшлэлд Аврагч маань “Надтай хамт байдаггүй нь Миний эсрэг байна” гэсэн нь үл итгэгч фарисайчуудад хандсан үг. Харин энд арай өөр асуудал яригдаж байна. Шавь нар, Есүсийн нэрээр чөтгөрүүдийг зайлуулж буй нэгэн хүний үйлдлийг хоригложээ. Тэр хүн өөрсөдтэй нь холбоогүй гэдгээс өөр дорвитой шалтгаан тэдэнд байсангүй. Тэгэхэд Есүс шавь нартаа “Түүнийг бүү хоригло. Хэн та нарыг үл эсэргүүцнэ, тэр та нарын талд” гэж хэлсэн.

Авралын асуудлыг яривал, Христийн төлөө биш хүмүүс Христийн эсрэг байдаг. Харин үйлчлэлийг яривал, Христийн эсрэг биш хүмүүс Христийн төлөө байдаг.

Эзэнд үйлчилдэг өөр бусад хүнийг эсэргүүцэх нь бидний дуудлага биш. Дэлхий ертөнц асар өргөн уудам учраас нэг нэгнийхээ хөлөн дээр гишгэхгүйгээр үйлчлэх талбар хүн бүрд бий. “Түүнийг бүү хоригло” гэсэн Аврагчийнхаа үгийг зүрхэндээ авцгаая.

Нөгөө талд Эзэн Есүс, Иохан болон бусад шавь нарыг тухайн хүнтэй очиж нийл гэж хэлээгүйг анзаараарай. Хүн бүрийн арга зам өөр. Нэг нь нөгөөгийнхөө арга замыг хүлээн зөвшөөрөхгүй байж болно. Хүн бүрийн номлолын онцлох үнэн өөр. Хүн бүрийн хүлээн авсан гэрэл өөр. Зарим нь их, зарим нь бага. Зарим хүн бусдаасаа илүү эрх чөлөөтэй байхад зарим хүний мөс чанар юм юмыг

болохгүй гэж үздэг. Бид бүх итгэгчийг нэгэн хэвэнд цутгах гэж оролдох нь илүү ажил юм. Элч Паулын хэлсэн шиг, сайнмэдээ хаа сайгүй тунхаглагдвал бид баярлаж байх ёстой: “Зарим нь үнэндээ атаархал, өрсөлдөөнөөс болж Христийг тунхагладаг байхад зарим нь бас сайн санаанаас тунхагладаг билээ. Сайнмэдээг хамгаалуулахаар намайг томилсныг тэд мэдээд Христийг хайраар тунхагладаг. Нөгөө нь чин сэтгэлээсээ бус өрсөлдөх хүслийн үүднээс Христийг тунхагладаг. Ингэхдээ тэд хүлээстэй намайг шаналгана гэж бодож байна. Тэгээд юу гэж! Хуурамч ч бай, үнэнээс ч бай аливаа замаар Христ тунхаглагдаж байна. Үүнд л би баярладаг. Мөн баярлах ч болно.” (Флп 1:15-18)

Сэм Шүмэкерийн асуултыг бодууштай: “Эдүгээ гэрэл нь харанхуйн эсрэг их тэмцэл өрнүүлж буй энэ цаг дор, биднээс ялгаатай аргаар ажиллаж байгаа гэлгүй өөрсдийн талынхныг дэмжин ажиллаж, анти-Христийн шуурганы өөдөөс христчид хамтдаа сөрөн зогсохын чухлыг бид хэзээ ойлгож ухаарах хүмүүс вэ?”

## 2 сарын 10

“Сүнсээр яв...гээж би та нарт хэлнэ.” (Гал 5:16)

Сүнсээр явах гэж яг яахыг хэлдэг юм бэ? Үнэндээ энэ нь зарим хүний боддог шиг тийм ярвигтай, амьдралаас хол тасархай зүйл биш ээ. Сүнсээр алхдаг хүний нэг өдөр хэрхэн өнгөрдгийг би доор өгүүлье.

Эхлээд залбирлаар тухайн өдрөө эхлүүлнэ. Амьдралд чинь ямар нэг нүгэл байвал түүнийг улайж гэмшинэ. Ингэснээр та Бурханд ашиглагдах боломжтой цэвэр сав болно. Дараа нь мөргөл ба магтаалыг Бурханд өргөх хэрэгтэй. Ингэснээр сэтгэл чинь зөв хөгтэй болно. Тэгээд амьдралаа Бурханы удирдлагад даатгана. Ингэснээр Эзэн танаар дамжин ажиллах боломжтой болно. Ийнхүү та Эзэнд өөрийгөө дахин өргөж, хэрэгтэй хэрэггүй төлөвлөгөөг орхин, амьдралынхаа жолоог Эзэнд өгөх юм.

Дараа нь Бурханы үгээр хооллох цагийг гаргах хэрэгтэй. Үүгээр таны амьдралд зориулсан Бурханы ерөнхий хүслийг олж мэднэ. Мөн одоогийн чинь нөхцөл байдалд Бурхан юу хүсэж байгааг ч олж мэдэх боломжтой.

Чимээгүй цагаа хийж дуусчхаад өдөр тутмынхаа ажил руу орно. Энэ нь ихэвчлэн нэг хэвийн, байнга давтагддаг ажлууд байдаг. Хүмүүс яг үүн дээр их буруу бодолтой явдаг. Тэдний бодлоор Сүнсээр алхах гэдэг нь хар бор ажлаас хол хөндий зүйл ажээ. Гэтэл үнэндээ, өдөр тутмын ажлаа итгэмжтэйгээр, хичээл зүтгэлээр гүйцэтгэх нь Сүнсээр алхахын гол жор юм.

Өдрийн турш ямар хандлагатай байх вэ гэвэл, алив нүгэл орж ирсэн даруйд шууд улайн гэмшиж, түүнээс гэдрэг эргэж, Эзэний ивээл ерөөлийг санах бүрийдээ

Түүнийг магтаж, сайныг үйлдэх боломж гарах бүрд Эзэнд дуулгавартай байж, бузар мууг үйлдэх сорилт гарч ирмэгц түүнийг хаяж одох.

Мөн тухайн өдөр тохиолдож байгаа үйл явдал бүхнийг Эзэний хүсэл гэж харах хэрэгтэй. Хүмүүс хөндлөнгөөс орж ирвэл түүнийг үйлчлэлийн боломж болгож, урам хугарах зүйлсийг Эзэний алдрын төлөө ашиглаж, утасны дуудлага, захидал, гийчин зочдыг Бурханы төлөвлөгөөний нэг хэсэг гэж үзэх.

Хэролд Вайлдишийн номоос эш татъя:

“Христийн гүйцэтгэсэн ажилд нүглийн бүх ачаагаа орхиж, түүнд түшиглэн амралтыг олдог шигээ дотор чинь ажиллаж буй Ариун Сүнсэнд амьдрал ба үйлчлэлийнхээ бүх ачааг даатгаж, Түүнийг түшиж амралтыг олоорой.”

“Өглөө бүр өөрийнхөө арга замаас ухарч, Ариун Сүнсээр удирдуулаарай. Таныг болон таны өдрийг удирдан чиглүүлэх ажлыг Түүнд даатгаад, магтаал ба амар тайван дотор алхаарай. Өдрийн турш Ариун Сүнсийг түшиж, Түүнд захирагдаж, явдал үйлээ чиглүүлэхдээ, Ариун Сүнс таны дотор бас танаар дамжуулан хүслээ үйлдэх чиглүүлэг, ухаарал, мэдлэг, сургамжийг өгнө гэж итгээрэй. Мэдрэмж ба сэтгэл хөдлөлийг бус Ариун Сүнсний ажлыг бодит гэж тооцоорой. Гагцхүү Ариун Сүнсэнд итгэж, Ариун Сүнсэнд дуулгавартай байж, амьдралаа өөрөө зохицуулах гэж гүйдэг хүнд ачаагаа Түүнд даатган, Түүгээр амьдралаа удирдуулж байж, Сүнсний үр жимс Түүний хүссэн хэмжээгээр танаас ургах бөгөөд энэ нь Бурханыг алдаршуулна.”

## 2 сарын 11

“...сэтгэл хийгээд сүнсийг...салтал...” (Евр 4:12)

Библи хүнийг гурван хэсгээс бүрдсэн бодгаль хэмээн ярихдаа сүнс, сэтгэл, бие гэсэн дарааллыг баримталдаг. Хүн энэ гурвыг хамт хэрэглэхдээ бие, сэтгэл, сүнс гэсэн дараалалтай болгодог. Нүгэл нь Бурханы дэс дарааг тонгоруулжээ. Хүн биеийг нэгт, сэтгэлийг хоёрт, сүнсийг адагт тавьдаг байна.

Хүнийг бүрдүүлэгч хоёр материаллаг бус хэсэг нь сүнс ба сэтгэл. Сүнс нь хүнийг Бурхантай нөхөрлөлтэй болгодог. Сэтгэл нь сэтгэлийн хөдөлгөөн ба хүсэлд хамаарна. Хэдий бид сүнс, сэтгэл хоёрын нарийн зааг ялгааг гаргаж чадахгүй ч гэлээ, юу нь сүнснийх, юу нь сэтгэлийнх гэдэг ялгааг олж харж чадна. Олж харах ч хэрэгтэй.

Тэгвэл юу нь сүнслэг зүйлс вэ? Христийг өргөмжилдөг номлол бол сүнслэг зүйл. Ариун Сүнсний тусламжтайгаар, Есүс Христээр дамжин Бурханд өргөдөг залбирал бол сүнслэг зүйл. Эзэний гэсэн хайраар өдөөгдөж, Ариун Сүнсний хүчээр хийгдэж буй үйлчлэл бол сүнслэг зүйл. Сүнсээр ба үнэнээр хийгддэг мөргөл бол сүнслэг зүйл.

Тэгвэл юу нь сэтгэлийн зүйлс вэ? Хүнийг, хүний чадварыг, яриаг анхаарлын төвд авчирч буй номлол бол сэтгэлд хамаатай зүйл. Бусдад сэтгэгдэл төрүүлэх зорилготой, үнэн сэтгэлийн бус механик залбирал бол сэтгэлд хамаатай зүйл. Өөрийгөө томилсон, мөнгөний төлөө хийдэг, махан биеийн аргаар явагддаг үйлчлэл бол сэтгэлд хамаарна. Үл үзэгдэх сүнслэг бодит байдлыг бус,

үзэгдэх орчин, материаллаг юманд түшиглэсэн мөргөл бол сэтгэлд хамаарна.

Сүмийн байшин, чимэглэсэн цонхнууд, ариун өмсгөл, цол гуншин, лаанууд, утлага гэх мэт зүйлс Бурханы чуулганд ямар хэрэгтэй юм бэ? Бүр ойртуулж асууя. Чуулган Мадисоны өргөн чөлөөнд сурталчилгаа байрлуулах ямар хэрэгтэй юм бэ? Мөнгө босгох аян, чуулганд олон хүн хамруулахаар зохиох янз бүрийн арга хэмжээ, хүний амбиц шингэсэн компани мэт сүмүүд, шоу концерт шиг магтаалын цуглаан Бурханы чуулганд ямар хэрэгтэй юм бэ?

Христэч сэтгүүлүүд дээр зар сурталчилгаа байдгийг харахад л, бид ямар их сэтгэлд хөтлөгдөн явдаг болсныг бэлхнээ гэрчилнэ.

Паул үйлчлэлүүдийн чанарыг “алт, мөнгө, эрдэнийн чулуу, мод, өвс, сүрэлтэй” (1Ко 3:12) зүйрлэсэн. Сүнслэг үйлчлэл бүхэн Бурханы шүүлтийн галд үлдэж хоцорно. Харин сэтгэлийг дагасан үйлчлэлүүд галд шатаагдаж үл үлдэнэ.

## 2 сарын 12

“...энэ уулан дээр ч биш, Иерусалимд ч биш...” (Иох 4:21)

Самаричуудын мөргөлийн төв бол Геризим уул. Харин иудейчүүдийн хувьд, Иерусалим нь Бурханы сонгосон хот буюу Бурхан Өөрийн нэрийг тавихаар дэлхийгээс сонгож авсан газар нь. Тэгвэл Есүс шинэ үе ирж байгааг самари эмэгтэйд хэлж өгсөн: “Үнэн мөргөгчид нь сүнсээрээ, үнэнээр Эцэгт минь мөргөх цаг ирж байгаа бөгөөд одоо ирчхээд байна. Эцэг Өөрт нь ийнхүү мөргөгчдийг эрж байна.” (Иох 4:23)

Эдүгээ мөргөлийн тусгай газар гэж энэ дэлхийд байхаа больсон. Бидний эрин үед Эзэн Есүс бол мөргөлийн ариун газрыг орлодог. Бурханы хүмүүс Эзэн Есүс Христийг тойрон чуулдаг. Үүгээр Иаковын үгс биеллээ олсон: “Бүх хүн түүнийг дуулгавартай дагах болно.” (Эх 49:10)

Бид Түүн рүү цугладаг. Бидний чуулган бол чимэглэлт цонхтой, бадралт хөгжимтэй ариун байшин биш. Бид хэн нэгэн чадварлаг удирдагчийг дагадаггүй. Бидний тэргүүн бол Эзэн Есүс.

Хаана цуглах нь одоо чухал биш. Сүм дуганд ч цуглаж болно. Айлын гэрт ч цуглаж болно. Гадаа талбайд ч цуглаж болно. Агуйд ч цуглаж болно. Жинхэнэ мөргөлд бид тэнгэрийн ариун газарт итгэлээр ордог. Тэнд Эцэг Бурхан заларч байгаа. Бас Эзэн Есүс заларч байгаа. Тэнгэрэлч нар ч чуулж байгаа. Хуучин гэрээний ариун хүмүүс бас тэнд бий. Чуулганы үеийн нас барсан ариун хүмүүс бас тэнд бий. Бид ийм сүрдэм чуулал дунд Ариун Сүнсний хүчээр, Эзэн Есүсээр дамжуулан Бурханд мөргөж, зүрх сэтгэлээ өргөх аз завшааныг хүртсэн билээ. Бие минь энэ дэлхий



дээр байсан ч гэсэн, сүнсээрээ бид дайн тулаантай, амар амгалангүй ертөнцөөс алсын алсад байдаг Бурханы оршихуйд очиж чаддаг.

Энэ нь “Хоёр буюу гурвуулаа Миний нэрээр хаана цуглана, тэнд Би тэдний дунд байна” (Мт 18:23) гэсэн Аврагч Эзэний үгтэй зөрчилдөж байна уу? Үгүй. Энэ үг ч гэсэн үнэн. Бурханы хүмүүс Эзэн Есүсийн нэрээр цуглах үед Эзэн Есүс онцгой замаар тэдний дунд оршин байдаг. Тэр бидний залбирал ба магтаалыг авч Эцэгт аваачдаг. Эзэн Есүс бидний дунд байдаг нь юутай их ерөөлтэй хэрэг бэ!

## 2 сарын 13

*“Нэг нэгэндээ хайртай байхаас өөрөөр хэнд ч, ямар ч өргүй бай.” (Ром 13:8)*

Энэ эшлэлийг бариад ямар ч өртэй байж болохгүй гэж хатуу баримтлал гаргах хэрэггүй юм. Орчин үед утас, тог, цахилгаан, усны төлбөр зэрэг өрнөөс ангид амьдрах боломжгүй. Зарим тохиолдолд сар бүр түрээсийн мөнгө төлж байснаас зээлээр байр худалдаж аваад өөрийн гэсэн үл хөдлөх хөрөнгөтэй болох нь. Өнөө үед зээлийн гэрээ хийхгүйгээр бизнес эрхлэхэд амаргүй.

Гэхдээ нөгөө талд, энэ эшлэл зарим төрлийн өрийг хориглож байгаа юм. Тухайлбал эргэн төлөх боломжгүй байж өр тавихыг хориглож байна. Үнэ өртөг нь унаж байгаа бүтээгдэхүүнийг худалдаж авахаар зээл тавихыг хориглож байна. Өр зээлээ хойшлуулахыг хориглож байна. Нэн шаардлагагүй зүйлсийн төлөө өр тавихыг хориглож байна. Хэт үрэлгэн зангаас болж, хэрэгцээнээс давсан эд зүйл худалдаж авч өрөнд орохыг хориглож байна. Эзний мөнгийг өрийн хүү төлөхөд үрэн таран хийхийг хориглож байна.

Энэ эшлэл биднийг нэхэл хатуутай зээлдэгчдээс, үрэлгэн байдлаас үүдэлтэй гэр бүлийн асуудлаас, өрөнд орж шоронд суухаас хамгаалах зорилготой. Энэ бүгд христэч хүний гэрчлэлийг үгүй хийдэг билээ.

Ер нь бол бид энгийн даруугаар өөрсдийн хэр хэмжээнд тааруулан амьдарч, санхүүгийн хариуцлагатай байж, өртөн нь зээлдүүлэгчийнхээ зарц болдгийг (Сур 22:7) байнга санаж явах ёстой.

Христэч бидний зайлшгүй ганц өр бол бие биеэ хайрлах. Бид үл итгэгчдийг хайрлан, тэдэнд сайнмэдээг хуваалцах үүрэгтэй (Ром 1:14). Бид ах дүүгээ хайрлан тэдний төлөө амиа зориулах үүрэгтэй (1Ио 3:16). Энэ төрлийн өр биднийг хуулийн өмнө хэзээ ч асуудалд унагадаггүй. Харин Паулын хэлсэнчлэн хуулийг биелүүлдэг.

## 2 сарын 14

*“Одоо Эзэн, тэдний заналхийллийг хараач. Таны үгийг ярих зоригийг боолууддаа соёрхооч.” (Үйл 4:29)*

Анхны итгэгчдэд хавчлага ирэхэд тэд нөхцөл байдал өөрчлөгдөхийг хүлээгээгүй. Харин тухайн нөхцөл байдал дотроо Бурханыг алдаршуулсан.

Харин бид тэдний үлгэр жишээг дагахдаа хойрго. Бид нөхцөл байдал сайжрах хүртэл үйлдэл хийдэггүй. Замд тээглэсэн чулууг саад бэрхшээл гэж харахаас биш, дээш өгсөх нэг гишгүүр гэж хардаггүй. Нөхцөл байдал минь таагүй болохоор би юм хийхгүй байна гэж өөрсдийгөө хаацайлдаг.

Зарим оюутнууд сургуулиа төгссөний дараа христэч үйлчлэлд орно гэцгээдэг. Тэгсэн мөртөө хайр дурлал, гэрлэлтийн асуудалд хамаг анхаарлаа хандуулж чаддаг. Ингээд сургуулиа төгссөний дараа ажилд ороод ажлын ачаалал, гэр бүлийн асуудалдаа түүртэхээрээ тэтгэвэрт гарахаа хүлээхээр шийддэг. Тэтгэвэрт гарчихвал зав чөлөөтэй болж бүх амьдралаа Эзэнд зориулна гэцгээдэг. Харамсалтай нь тэтгэврийн насанд ирэхээр хамаг эрч хүч, хараа зорилгоо гэсэн байдаг тул тав тухтай амьдралыг эрмэлзэж эхэлдэг.

Аль эсвэл бидэнтэй муухай харьцдаг хүмүүсээс болоод урагш ахихаа больчихно. Тэр хүмүүс нь чуулганы удирдлагын хүмүүс ч байж болох юм. Хэдий тэр хүмүүс итгэмжтэй, шургуу ажиллаж байсан ч бидэнд саадтай санагдана. Тэгэхээр нь бид яадаг вэ? Бид юу ч хийхээ больж, тэдний үхэхийг хүлээхээр шийддэг. Харамсалтай нь энэ арга хэрэгжихгүй. Яагаад гэвэл, бидэнд төвөг

учруулагч хүмүүс ихэнхдээ урт насалдаг. Тэдний оршуулгыг хүлээвэл үр бүтээл хэзээ ч гарахгүй.

Иосеф итгэлээр алхахын тулд шоронгоос гарахаа хүлээгээгүй. Тэрээр шоронд ч гэсэн Бурханд үйлчилж байсан. Даниел, Вавилоны цөллөгийн үеэр эрх мэдэлд хүрсэн. Хэрэв тэр цөллөг дуусахыг хүлээсэн бол дэндүү оройтох байлаа. Паул шоронд байх хугацаандаа Ефес, Филиппой, Колоссай, Филемон гэсэн захидлуудаа бичсэн. Тэрээр нөхцөл байдал сайжрахыг хүлээгээгүй.

Үнэн гэвэл, энэ амьдралд хэзээ ч төгс нөхцөл байдал бий болохгүй. Христэч бидэнд нөхцөл байдал сайжирна гэж Бурхан амлаагүй юм шүү. Тиймээс үйлчлэлд ч бай, авралд ч бай, хамгийн зөв цаг бол одоо юм.

Лютерийн хэлсэнчлэн “Нөхцөл байдал сайхан болохыг хүлээдэг хүн хэзээ ч тэр цагийг үздэггүй.” Соломон бас бидэнд сануулж байна: “Салхины аясыг харагч тариалж үл чадна, үүл харуулдагч нэгэн хурааж үл чадна.” (Ном 11:4)

## 2 сарын 15

*“Талхаа усны гадаргуу дээр хая! Учир нь олон хоногийн хойно чи түүнийгээ буцааж олно шүү дээ.”* (Ном 11:1)

Талх гэж шилжсэн утгаараа талхыг гаргаж авдаг үр тариаг хэлсэн бололтой. Египетэд усанги газар үр суулгадаг байж. Ус татрахаар тариа нь гарч ирдэг ажээ. Гэхдээ энэ үйл явц нэг өдрийн дотор болчихгүй. Ургац “олон хоногийн хойно” гарч ирдэг.

Өнөөдөр бид “яарч адгасан” нийгэмд амьдарч байна. Тиймдээ ч үр дүнг хурдан харахыг хүсдэг. Бидэнд хурдан хийгддэг олон зүйл бий. Тухалбал, түргэн хоол, шуурхай зээл, тэр даруй суваг ухраах тохиргоо гэх мэт.

Гэвч христэч амьдрал ба үйлчлэлд энэ зарчим тохирохгүй. Бидний сайн үйлийн шагнал тэр даруй ирдэггүй. Залбирал маань тэр даруй хариугаа авдаггүй. Үйлчлэлийн маань үр дүн ч бас тэр дороо харагддаггүй.

Библи сүнслэг үйлчлэлийг дүрслэхдээ тариалалтын үйл явцыг олонтоо ашигласан. “Харагтун, тариачин үр суулгахаар гарчээ.” (Мт 13:3) “Би тарьсан, Апол усалсан. Харин Бурхан ургуулсан.” (1Ко 3:6) “Газар эхлээд өөрөөсөө үрийг соёолуулж дараа нь түрүүг, тэгээд боловсорсон тариаг бий болгодог.” (Мк 4:28) Үр тариа нь урт хугацаанд аажмаар боловсордог.

Тиймээс сайн үйлсийнхээ шагналыг тэр даруй авахыг хүсэх нь бодит байдалд үл нийцнэ. Залбирлын хариуг шууд авах гэж зүтгэх нь төлөвшөөгүйн шинж. Сайнмэдээ сонссон хүнийг шууд шийдвэр гарга гэж шахах нь мэргэн бус. Ердийн туршлагаар бол удаан хугацааны турш тухайн хүнийхээ төлөө залбирч, түүнд зориулалт гаргаж,

үйлчилснээр үр дүн гардаг. Тэгэхээр Эзэнд зориулсан хөдөлмөр чинь хэзээ ч талаар өнгөрөхгүй гэдэгт итгэж болно. Үр дүн гарвал бардамнаж сайрхаарай гэсэн үг бас биш шүү. Харин үргэлжлүүлэн хичээ гэсэн урамшуулал юм. Бүрэн үр дүнг тэнгэрт очих хүртэл мэдэх боломжгүй. Тийм ээ, тэнд л хөдөлмөрийнхөө үр шимийг үзэх нь хамгийн сайхан, хамгийн аюулгүй билээ.

## 2 сарын 16

*“Инээж байвч зүрх хөндүүрлэж болох.” (Сур 14:13)*

Амьдралд төгс юм гэж үгүй. Инээд бүхэн уй гашуутай. Алмаз бүхэн өө сэвтэй. Хүн бүр зан чанарын доголдолтой. Амьдралын бүхий л талбарт дутуу юм бий.

Төгс төгөлдрийг хүсэмжлэгч байх нь сайн. Учир нь Бурхан бидний дотор төгс төгөлдрийг хүсэх эрмэлзэл оруулжээ. Гэхдээ юманд бодитой ханддаг байх нь ч сайн. Учир нь энэ дэлхийгээс туйлын төгс зүйл хэзээ ч олдохгүй.

Залуу хүмүүс ер нь өөрсдийн гэр бүлийг л хэрүүл маргаантай гэж боддог. Өөрсдийн эцэг эхийг л зан чанарын доголдолтой гэж хардаг.

Чуулганахаа итгэгчдэд урам хугарах шиг амархан юм үгүй. Бусад чуулганд их л гоё байгаа мэт санагдах нь олон.

Төгс найзыг насаараа хайгаад ч олохгүй. Бид өөрсдөө төгс байж чаддаггүй ч бусдаас яагаад ч юм төгс байдлыг хүсэх юм.

Хүн бүрд өөрийн гэсэн алдаа дутагдал байдгийг хүлээн зөвшөөрцгөөе. Заримынх нь илүү тод харагддаг. Ялангуяа олны өмнө байдаг хүний алдаа бүр ч ил байдаг. Тэгэхээр хүмүүсийн алдаа дутагдалд сэтгэл дундуур байхын оронд бусдынхаа сайн чанарыг олж харцгаая. Хүн бүрд сайн чанар бий. Бүх сайн чанарыг агуулсан ганц л хүн байдаг нь Эзэн Есүс билээ.

Эзэн зориуд биднийг төгс төгөлдрийг хүсэмжлэх дуусашгүй хүсэлтэй болгосон юм болов уу гэж заримдаа надад бодогддог юм. Тэгснээр бид ямар ч өө сэвгүй Түүн рүү хамаг хараагаа талбих болно. Учир нь Түүнд бүх гоо



үзэсгэлэн оршдог. Түүнийг харж явахад бид хэзээ ч урам хугарахгүй.

## 2 сарын 17

*“Намайг зовоход Та намайг тэлсэн билээ.”* (Дуу 4:1 Дарбигийн орчуулга)

“Давлагаа үгүй тэнгист далайчин төрдөггүй” гэж үнэн үг. Зовлон биднийг тэвчээрт сургадаг. Дарамт шахалт биднийг сунгаж тэлдэг.

Бэрхшээл хүнийг хөгжүүлж боловсруулдгийг үл итгэгчид ч мэддэг байна. Чарльз Кэттеринг нэгэн удаа, “Асуудал бол ахиц дэвшлийн үнэ юм. Надад асуудлаас өөр юу ч битгий дуулга. Сайн мэдээ намайг дорой болгодог” гэж хэлжээ.

Христитгэгчдийн дунд ч гэсэн зовлон бэрхшээлээс агуу гэрчлэлүүд төрөн гардаг.

“Зовлон өнгөрөн одно. Зовлонг давсан нь мөнхөд үлдэнэ” гэж үг бий.

Энэ үгийг баталсан утгатай мөртүүдийг сонсоно уу:

*Гэрлийн хөвгүүдийн дундах тэр олон дуучид нь  
Шилдэг дуугаа харанхуйн дунд сурсан гэнэ билээ  
Эцэгийн гэрийг дүүргэдэг эгшиг яруу дуунууд нь  
Харанхуй өрөөнд анх зохиогдсон гэнэ билээ*

Зовлон бэрхшээлийн ашиг тусыг Спержон өөрийнхөөрөө ийн илэрхийлсэн:

“Тав тухтай, амар хялбар, аз жаргалтай үедээ хүртсэн ивээл минь бүхлээрээ сохор зоосны үнэгүй байх вий. Харин уй гашуу, зовлон шаналал, өвдөлтөөсөө авсан сайн сайхан минь тооцож барамгүй үнэ цэнтэй. Зовлон бэрхшээлд би өртэй хүн. Шаналал бол миний гэрт хамгийн нийцтэй тавилга мөн.”

Ийм байхад бид юундаа гайхаж балмагдана гэж? Еврей номын нэр нь тодорхойгүй зохиогч бидэнд юу гэж хэлснийг санаарай: “Бүх сахилгажуулал нь тухайн үедээ баяр хөөр бус, харин уй гашуу мэт санагдавч дараа нь энэ нь түүгээр дасгалжсанд нь зөвт байдлын амар амгалан бүхий үр жимсийг гаргаж өгдөг.” (Евр 12:11)

## 2 сарын 18

*“Газар дэлхийн Шүүгч Та шударга шийдвэр эс гаргана гэж үү?” (Эх 18:25)*

Амьдралд ойлгохын аргагүй олон нууц байдаг ч, бүх дэлхийн Шүүгч нь төгс зөвт, туйлын шударга Бурхан гэдгийг бодон санаа амар байж болно.

Хариуцлага хүлээх насанд хүрэхээсээ өмнө нас барсан хүүхдүүд яах бол гэж хүмүүс асуудаг. Олон хүнд “тэнгэрийн хаанчлал нь эдний адил хүмүүсийнх юм” гэсэн үг хангалттай байдаг. Тэр хүүхдүүд Есүсийн цусаар дамжин аюулгүй байгаа. Гэвч энэ үгэнд санаа амрахгүй хүмүүс байвал Эхлэл 18:25-ыг бодох хэрэгтэй. Бурхан зөвхөн зөвийг үйлдэнэ гэдэгт итгэж болно.

Зарим хүн Бурханы сонголт ба урьдаас тогтоох явдлыг гайхдаг. Бурхан заримыг нь аврахаар, заримыг нь тамд унагахаар сонгодог гэж үү? Калвинист, Арминистууд үүнд өөрсдийн байр суурийг хэлэх л байх. Харин бид, Бурханд шударга бус чанар байхгүй гэдэгт л бат итгэлтэй байна.

Яагаад гэмт муу хүмүүс хөгжин дэвшиж байхад зөвт хүмүүс зовлонг амсдаг юм бэ? Сайнмэдээг хэзээ ч сонсоогүй хүмүүсийг ямар хувь тавилан хүлээж байгаа вэ? Бурхан яагаад нүгэл орж ирэхийг зөвшөөрсөн юм бэ? Энэ мэт олон асуултыг асуун хүн толгойгоо гашилгаж суудаг. Байгалийн гамшиг, ядуурал, өлсгөлөн, өвчин зовлонгийн өмнө заримдаа хэлэх ч үг олддоггүй. Тэгэхэд эргэлзээ бувтнаж, “Бурхан бүхнийг хянадаг юм бол яагаад энэ бүхнийг зогсоохгүй байгаа юм бэ?” гэдэг.

Итгэл үүнд ингэж хариулдаг: “Эцсийн хуудас бичигдэж дуустал тэвчээртэй хүлээ. Бурхан ганц ч алдаа

гаргаагүй гэдэгт итгэ. Бүх зүйл тодорхой болоход, бүх дэлхийн Шүүгч зөв зүйл хийжээ гэдгийг бид харах болно.”

*Бурханы үзэг дэндүү томоор бичдэг*

*Бидний нүд өчүүхэн жижгээр хардаг*

*Энэ богинохон хараагаар бид чинь*

*Эцэж туйлдсан найдвар хийгээд үхэл амьдралын*

*Эцэс төгсгөлгүй дайн ба утга учиргүй тэмцлүүдийн*

*Эх захгүй зовлон бүхний учрыг ойлгох гэж зүдчих юм*

*Энэ биедээ ахадсан эргэлзээт асуултад бүдчих юм*

*Хэрэв бидэнд илүү том хараа байдагсан бол*

*Бурханы зөв гэдгийг эрхгүй олж харахсан*

(Жон Оксенэм)

## 2 сарын 19

*“Мунхаглал өөрийг нь сүйрэлд хүргэх атал мөнөөхийн зүрх ЭЗЭНий эсрэг хилэгнэх.” (Сур 19:3)*

Сэтгэлзүйн тал дээр Библитэй эн зэрэгцэх ном үгүй. Хүний зан байдлын талаар өөр ямар ч номоос олохгүй үнэн мэдээллийг Библи өгч чадна. Жишээ нь, дээрх эшлэл, өөрийнхөө амьдралыг сүйрүүлчхээд өөрийгөө буруутгахын оронд Эзэнд буруугаа тохдог хүнийг дүрсэлжээ.

Амьдрал дээр ийм жишээ хэчнээн олон гээч. Өөрсдийгөө христэч гэх зарим нь садар самуун явдалд орооцолдоод ичгүүр, гутамшиг, санхүүгийн асуудалд унангуутаа гэмшихийн оронд Христийг буруутгаж, итгэлийг үгүйсгэж, идэвхтэй сүсэг бишрэлгүй хүн болдог тохиолдол бий.

Бид л сайн анзаардаггүй болохоос, итгэлийг хаях явдлын гол шалтгаан нь ёс суртахууны доройтол ажээ. А. Ж. Полк, Библийн талаар есөн жорын эргэлзээ, үгүйсгэл гаргаж ирсэн нэгэн залуутай уулзсан тухайгаа хуучилсан юм. Полк тэр залуугаас “Чи ямар нүглийг хүлээн зөвшөөрдөг вэ?” гэж асуутал өнөөх залуугийн ярианы өнгө өөрчлөгдөөд, өчнөөн олон нүгэл, ёс бусын муухай явдлуудыг ярьсан байна.

Хийсэн нүгэл нь мөс чанарыг нь зулгаах үед хүн Эзэний эсрэг уур унтууцлаа гаргадаг. Энэ бол шударга бус явдал. “Бурханы хориглосныг үйлдчихээд уршгийг нь Бурханд үүрүүлэх гэдэг чинь туйлын ёсгүй үйлдэл мөн” гэж В. Ф. Адини хэлсэн байдаг.

“Муу муухайг үйлдэгч бүр үйлс нь илэрчих вий гэсэндээ гэрлийг үзэн ядаж, гэрэлд гарч ирдэггүй” (Иох 3:20) гэж хэчнээн үнэн үг вэ! “Хүсэл тачаалаа дагадаг” элэглэн тохуурагсад үнэнийг “санаатайгаар үл ойшоодог” гэж элч Петр сануулсан. Полкийн бодол ийм байна: “Эндээс нэг зүйл тодорхой харагдана. Бурханы үнэнийг хүлээн авах хүсэлгүй гэдэг нь тухайн хүний ёс суртахуун ямар их доройтолтой байгаагийн шинж юм. Хүн ер нь нүглээсээ салах дургүй бөгөөд махан бие зөнгөөрөө Бурханыг үзэн яддаг. Магадгүй гэрэл үнэнийг илчилдэг болохоор, Библи нүглийг нь хориглодог учраас тэдний зэвүү хүрдэг байх. Тэгэхээр толгойд биш, зүрхэнд гол асуудал оршиж байна.”

## 2 сарын 20

*“Би ажил хэргийнхээ тухай ярихаас нааш хоол идэхгүй.”*  
(Эх 24:33)

Абрахамын зарц ирсэн зорилгоо яаралтай биелүүлэхийг хүссэн. Түүний энэ хандлага бидэнд ч байх ёстой. Гэхдээ энэ нь хаа сайгүй тэвдэн гүйхийн нэр биш. Аль эсвэл, хамаг ажлаа амжуулах гээд бачуурч явна гэсэн үг ч биш. Гол нь өмнөө байгаа үүрэг даалгавраа эн тэргүүнд тавин ажиллахыг хэлж байгаа юм.

Роберт Фростын шүлэгт гардаг хандлагыг өөрсдөдөө шингээцгээе:

*Энэ ой сайхан юм*

*Гүн бөгөөд харанхуй юм*

*Гэлээ ч надад сахих амлалт бий*

*Нойрсохын өмнө хороох зам бий*

Эми Кармайкл бичсэн үгэндээ ийм хандлагыг тусгасан: "Надад Бурханд өгсөн тангараг бий. Гарынхаа сүүдрээр дүрс хийж тоглох юм уу ертөнцийн цэцэгсийг түүн зугаацах зав надад байхгүй. Ажлаа дуусгаад тайлангаа тавихад бэлэн болох хүртлээ би зүгээр суух эрхгүй."

Эми Кармайкл өөр нэг газарт бас ингэж бичжээ:

*Арван хоёрхон цаг байдаг шүү дээ, сайн Хоньчин минь*

*Ажилдаа шамдах сэтгэлийг бүү бөхөөгөөч*

*Аврагдах сүнснүүдийг Тантай хамт би эрэн хайя*

Чарльз Симеон суралцаж байхдаа Хэнри Мартини зургийг байнга авч явдаг байлаа. Хаа явсан газар нь Мартин түүн рүү хараад “Хичээнгүй бай, хичээнгүй бай. Бүү хойш суу. Бүү хойш суу” гэж хэлж байгаа юм шиг санагддаг байж. Тэгэхэд нь Симеон “Тийм ээ, би хичээх



болно. Хичээх болно. Би хойш суухгүй. Учир нь хүмүүс мөхөж байна. Есүс алдарших ёстой” гэж хэлдэг байлаа.

Элч Паул яаран шамдахын талаар юу хэлснийг сонсогтун: “...хийдэг ганц юм маань ардхаа мартаж, урдах өөдөө тэмүүлж, Христ Есүс дотор Бурханы дээш чиглэсэн дуудлагын шагналын төлөө бариа өөд урагшилдаг.” (Флп 3:13,14)

Аврагч Эзэн маань ялгаагүй зорьсон зорилгодоо хүрэхийн төлөө яарч байгаагүй гэж үү? Тэрээр “Хүртэх ёстой нэгэн баптисм Надад байна. Үүнийг гүйцэлдгэл Би ямар их зовно вэ!” (Лк 12:50) гэж хэлсэн.

Христэч хүнд тухлан амарч суух эрх байхгүй.

## 2 сарын 21

*“Би ард түмнийхээ дунд амьдардаг.” (2Ха 4:13)*

Шунемийн нэгэн чинээлэг эмэгтэй, үе үе гэрийнх нь хажуугаар өнгөрдөг Елишад зочломтгой зан гаргажээ. Сүүлд нь тэр эмэгтэй нөхөртөө хэлээд гэрийнхээ зайг сунгаж Елишад тусгай өрөө гаргаж өгсөн. Елиша энэхүү сайхан сэтгэлийн хариуд ямар нэг зүйл хийж өгөхийг хүсээд тэр эмэгтэйн талаар хаанд эсвэл цэргийн жанжинд айлтгая гэж санал тавьсан. Тэгэхэд нь эмэгтэй, “Би ард түмнийхээ дунд амьдардаг” гэж хариулсан. Өөрөөр хэлбэл, түүний үг нь, “Би амьдралдаа сэтгэл хангалуун бөгөөд цуг амьдарч байгаа жирийн хүмүүстээ хайртай. Дээд зиндааныхны дунд орох сонирхол надад байхгүй. Алдартай хүмүүсийн нэг больё гэж санаархдаггүй” гэсэн утгатай юм.

Үнэхээр ухаантай эмэгтэй байжээ. Алдар нэртэй, хөрөнгө мөнгөтэй хүмүүстэй нийлэхгүй бол сэтгэл нь дүүрдэггүй хүмүүс нэг зүйлийг мэдвэл зохино. Энэ хорвоогийн хамгийн сайхан хүмүүс олонд нэг их танигдаагүй байдаг юм шүү!

Евангелийн ертөнцөд нэр нөлөө бүхий хүмүүстэй холбоо харилцаатай байх боломж надад нэлээд гардаг байлаа. Гэвч энэ нь ихэнхдээ урам хугалмаар дурсамж үлдээжээ. Харин тэднийг христэч хэвлэлүүд үргэлж магтан хөөргөж байдгийг харахаар бүр ч гутармаар санагддагсан. Хэрэв сонгож болдог бол, энэ ертөнцөд алдар нэргүй ч, тэнгэрт алдартай, даруу, бурханлаг, итгэмжит хүмүүсийг би сонгоно.

А.В.Тозер миний сэтгэлийг ойлгосон мэт дараах үгийг бичсэн байдаг: “Би ариун хүмүүс байдагт итгэдэг. Хошин шогийн юм шиг итгэгчидтэй таарч байлаа. Рекламандаа сайн христчинтэй ч уулзаж явлаа. Өөрийнхөө байгуулсныг хүмүүст мэдүүлэх гэж сүмийнхээ урд талд нэрээ бичсэн хүнийг ч харж байлаа. Христитгэгч гэгчхээд христэц шинжгүй олон хүнийг би мэднэ. Сонин сонин юм ярьдаг олон хүн Америк, Канад даяар байдаг. Гэвч зүрх минь ариун хүмүүсийг хайдаг. Би гагцхүү Эзэн Есүс Христийг хайрладаг хүмүүстэй уулзмаар байна. Үнэндээ, хүмүүн бидний цээжинд Бурхан Эзэний маань гоо үзэсгэлэн орших учиртай. Үнэн сүсэгт ганц л ариун хүн байхад шашны хэнээтэн, өөрийгөө дөвийлгөгч, хошин шог шиг этгээдүүдийг таван зуу дахин нийлүүлснээс илүү.”

Чарьлз Симеон үүнтэй адил үг хэлж байв: “Анх эхэлснээсээ хойш өнөөдрийг хүртэл би энэ хорвоогийн хамгийн сайхан хүмүүстэй учирч байсан юм. Тэд Эзэн Есүсийг хайрласандаа надад хамаг сайхан сэтгэлээ зориулж байлаа.”

“Би ард түмнийхээ дунд амьдардаг.” Ийм сайхан сүнслэг утга анхилсан үгийнх нь төлөө шунем эмэгтэйд талархлаа илэрхийлэх нь зүйтэй!

## 2 сарын 22

“...ариун хүмүүсийг үйлчлэлийн ажилд бэлтгэж...” (Еф 4:12)

Ямар нүд нээсэн үг вэ! Ефес 4-р бүлгийн бэлгүүд ариун хүмүүсийг үйлчлэлийн ажилд бэлтгэх зорилготой. Ариун хүмүүс ажлаа хийх чадвартай болмогц, уг бэлгүүд цааш явдаг.

Христэч үйлчлэлийн амжилт нь ажлаа хамгийн хурдан хугацаанд гүйцэтгээд дараагийн талбар уруу явж чадаж байгаа эсэхээр тодорхойлогдоно.

Паул ингэж ажилладаг байлаа. Жишээ нь гэхэд тэрээр Тесалоникт очоод гурван удаагийн амралтын өдрөөр иудейчүүдэд номлосны дараа нэгэн чуулган үлдээчхээд явсан. Мэдээж хэрэг, тухайн ажлыг чанартай хийх хурд яригдаж байгаа үед Паулын энэ жишээ онцгой тохиолдол мөн. Паул нэг газартаа хамгийн удаан байсан нь хоёр жил. Тэр газар нь Ефес хот байлаа.

Бурхан Өөрийн ариун хүмүүсийг дээр дурдсан Ариун Сүнсний бэлгүүдээс байнга хамааралтай байгаасай гэж хүсдэггүй. Уг бэлгүүдийг хэрэглэж байх зориулалттай. Ариун хүмүүс номлол сургаалыг сайн сонсдог боловч үйлчлэлийн ажилд оролцдоггүй бол зохих ёсоороо сүнсээр өсөж чадахгүй бөгөөд энэ ертөнцөд сайнмэдээ Бурханы хүсэж байгаа шиг хүрэхгүй.

Амжилттай үйлчилдэг гадаадын илгээлтийн эзэд хэзээ ч гадаад хүнд халаагаа өгдөггүй гэж Уилльяам Диллион хэлсэн байдаг. Нутагтаа ажиллаж байгаа хүмүүст ч энэ зарчим ижил. Тухайн хүний ажил дуусвал ариун хүмүүс

шинэ номлогч хайж суулгүй өөрсдөө асуудлыг гартаа авах хэрэгтэй.

Ихэнх тохиолдолд номлогчид өөрсдийгөө бүх амьдралаараа нэг байрандаа томилогдсон гэж боддог. Энэ нь, өөр хүн ажлыг нь сайн хийж чадахгүй гэж үздэгтэй холбоотой. Итгэгчдийн тоо буурна гэж өөрсдийгөө хаацайлдаг. Бусад хүн ажлыг нь зөв хийж чадахгүй, тэд бусдаас хараат гэж гомдоллодог. Гэвч хүмүүс сурах хэрэгтэй байдаг шүү дээ. Сурахын тулд тэдэнд боломж хэрэгтэй. Эхлээд сургаад, үүрэг хариуцлага ноогдуулаад, ахицыг нь үнэлж байх хэрэгтэй.

Хэрэв ариун хүмүүс хэн нэг номлогч багшаас хараат бусаар ажиллах хэмжээнд хүрлээ гэж үзвэл тэдэнд үүрэг хариуцлагыг үлдээх нь зөв. Энэ нь баярлах шалтгаан мөн. Учир нь тухайн номлогч илүү хэрэгцээ байгаа өөр талбар уруу явах боломжтой болж байгаа юм.

Бурханы хүн хэчнээн чадвартай байсан ч, Бурханы ажил тухайн хүнээс хараат болох нь сайнгүй зүйл. Харин түүний хэрэгцээ дуусах хэмжээнд ариун хүмүүсийг бэлтгэх нь гол зорилго билээ. Одоогийнх шиг ертөнцөд өөр газарт ажиллах хэрэгцээ хэзээд байдаг.

## 2 сарын 23

“Мэргэн нь сонсог...” (Сур 1:5)

Сургаалт үгс номд бичсэнээр бол, мэргэн ба тэнэг хүний гол ялгаа нь мэргэн нь сонсог, тэнэг нь сонсоггүй явдал юм.

Энэ нь хүний оюуны чадамжийн асуудал биш. Харин ч тэнэг хүн нь онцгой оюуны чадамжтай байх нь олон. Гол нь, түүнд юм хэлэхээр хүлээж авдаггүй. Өөрийнхөө мэдлэгийг төгс, өөрийнхөө бодлыг алдаагүй гэж бүрэн итгэдэг хөнөөлт төөрөгдөлд тэр автжээ. Найз нөхөд нь зөвлөгөө өгвөл хариуд нь тэднийгээ элэглэн тохуурхдаг. Найзууд нь нүгэл ба мунхаг үйлдлийнх нь хөнөөлт үр дагавраас зайлуулахыг бодсондоо үг хэлдэг боловч өнөөх нь зөрсөөр байгаад асуудалд орооцолдож, нэг асуудлаас нөгөө асуудалд унасаар явдаг. Нэг талд тэрээр мөнгө санхүүгийн гүн хямралтай. Нөгөө талд хувийн амьдрал нь ичгүүр гутамшгаар дүүрэн. Ажил бизнес нь ч зах замбараагүй. Гэтэл тэр бүхэнд амьдралыг буруутгадаг. Өөрөө өөрийгөө сүйтгэж буйгаа эс ухаарна. Тэрээр өөрийнхөө амьдралыг авч явж чадахгүй байж, бусдад зөвлөгөө өгөхдөө тун сайн. Тэрээр өөртөө итгэл төгс, чанга чанга ярьдаг.

Харин ухаантай хүн мунхагтай адилгүй. Тэрээр, хүн бүрийн оюун ухаанд нүглийн нөлөө ямар нэг хэмжээгээр байдгийг мэднэ. Өөрийнх нь олж хараагүйг өөр хүн харсан байж болохыг хүлээн зөвшөөрнө. Заримдаа юмыг мартаж болзошгүйгээ ухаардаг. Тиймээс зөв шийдвэр гаргахад нь хэрэгтэй аливаа үгийг талархан хүлээн авдаг. “Олон зөвлөхтэй аваас аврагдах” (Сур 11:14) гэдгийг тэр мэддэг

болохоор бусдын зөвлөгөөнд дуртай. Тэрээр бусдын адил алдаж энддэг. Тиймдээ ч зэмлэлд хүлээцтэй хандаж, буруугаа хүлээхэд бэлэн. Ухаантай хүүхдүүд эцэг эхийн сахилгажуулалд захирагддаг бол, мунхгууд эсэргүүцдэг. Ухаалаг залуус ариун шударга амьдралын талаарх Библийн зарчмыг дагадаг бол, мунхгууд өөрсдийнхөөрөө явдаг. Ухаалаг томчуул аливааг шүүхдээ Эзэний таалалд нийцэж байгаа эсэхийг шалгадаг бол, мунхгууд өөрсдийнхөө таалалд нийцүүлдэг.

Тиймээс мэргэн нь улам мэргэн болж, мунхгууд мунхаглалынхаа лаг шаварт гүн шигддэг.

## 2 сарын 24

*“Адам...өөрийнхөө төрхтэй, өөрийнхөө дүртэй адилхан хүү төрүүлж...” (Эх 5:3)*

Хүүхдүүд маань бидний дүр төрхийг дуурайж төрдөг нь жам юм. Адам өөртэйгөө ижил хүү төрүүлээд түүнийгээ Сет гэж нэрлэсэн. Хүмүүс Сетийг хараад “Аавтайгаа үнэхээр адилхан юм” гэж хэлцгээсэн биз ээ.

Сүнслэг амьдралд ч мөн хүүхдүүд бидний дүр төрхийг дуурайдаг. Бид бусдыг Эзэн Есүс дээр авчрах үед тэд биднийхтэй ижил зан чанарыг гаргаж эхэлдэг. Энэ нь удамшил биш, харин даган дуурайх үзэгдэл юм. Тэд христэч хүн ямар байдгийг анхнаасаа мэдэхгүй болохоор христэч хүнийг биднээр төсөөлж, өөрсдөө ч мэдэхгүй биднийг даган дуурайдаг. Удалгүй тэд ч, бид ч гэр бүл юм шиг төсөөт зан чанартай болдог.

Тэгэхээр би Библийг амьдралдаа хэр үнэлж цэгнэнэ, хүүхдүүдийн минь итгэлийн жишиг хэмжүүр тэр зэргийн өндөрт байна. Хэрэв би залбирлыг чухалчилбал хүүхдүүд маань ч чухалчилна. Хэрэв би мөргөлийг чухалчилбал хүүхдүүд маань ч надтай ижил хандлагатай болно.

Хэрэв би сахилга батыг чандлан шаардвал тэд ч мөн бүх итгэгчид ийм хэм хэмжээг дагадаг гэж итгэнэ. Харин эсрэгээрээ Эзэний үгийг сулруулж, өөрөө эд баялаг, алдар нэр, биеийн тааламжийн араас амьдарвал тэд ч ялгаагүй миний жишээг дагана.

Хүний сүнсийг аврахын төлөө зүтгэлтэй хүмүүсээс шаргуу ажилсаг хүүхдүүд гардаг. Библийг хайрладаг, хүндэлдэг хүмүүс энэхүү алсын хараагаа сүнслэг хүүхдүүддээ өвлүүлдэг.



Та өөрөө цуглаандаа тогтмол хамрагддаггүй бол хүүхдүүд чинь танаас өөр байна гэж бодох хэрэггүй. Цуглаандаа хоцордог бол хүүхдүүд чинь ч бас хоцордог хүмүүс болно. Та өөрөө арын эгнээнд суухыг илүүд үздэг бол хүүхдүүддээ тэр нөлөөгөө үлдээж л таараа.

Эсрэгээрээ, та сахилга баттай, итгэмжтэй, цагаа барьдаг, идэвхтэй бол таны Тимотууд итгэлийг чинь гарцаагүй даган дуурайна.

Тэгвэл одоо өөрөөсөө асуугаад үз. Миний хүүхдүүд над шиг болоосой гэж би хэлж чадах уу? Элч Паул шиг “Намайг дуурайгсад бай” (1Ко 4:16) гэж хэлж чадах уу?

## 2 сарын 25

*“Итгэлийн чинь дагуу болог.” (Мт 9:29)*

Би та хоёрт хараа оруулж чадна гэж итгэж байна уу хэмээн Есүс хоёр хараагүй хүнээс асуухад тэд “тийм” гэж хариулсан. Эзэн Есүс тэдний нүдэнд хүрээд “итгэлийн чинь дагуу болог” гэсэнд тэд хараатай болсон.

Үүнийг уншаад, итгэл л байвал эд баялаг, эрүүл мэнд гээд хүссэн бүхнээ авч болох нь гэсэн ташаа дүгнэлт хийж магад. Гэвч тийм биш. Итгэл нь Эзэний үгэнд, Бурханы амлалтад, Библийн тушаалд суурилах ёстой. Эс бөгөөс энэ нь итгэл бус, хоосон үнэмшил төдий юм.

Бурханы амлалтаас хэр ихийг хүртэх вэ гэдэг нь бидний итгэлийн хэмжээнээс хамаарна гэдгийг дээрх эшлэлээс ойлгож болно. Елиша, сиричүүдийг ялна гэдгийг нь Иоаш хаанд хэлээд газрыг сумаараа цохь гэсэн. Иоаш хаан гурвантаа цохиод больсон. Тэгэхэд Елиша, гуравхан удаа цохисонд нь уурлаад, одоо та сиричүүдийг гурван л удаа ялна, газрыг тав зургаа цохих байсан юм гэжээ (2Ха 13:14-19). Түүний ялалтын хэмжээ итгэлээс нь хамаарч байжээ.

Дагалдагчийн амьдрал бас ийм. Бид бүхнийг орхиж, итгэлээр алхах дуудлагатай. Мөн газар дээр эд баялаг хурааж болохгүй тушаалтай. Энэ тушаалуудыг хэр зэрэг хэмжээнд дагах вэ? Амь даатгал, эрүүл мэндийн даатгал, хадгаламжийн данс, хувьцаа, бондтой байж болохгүй гэж үү? Эдний хариу нь: “Итгэлийн чинь дагуу болог.” Хэрэв танд “Би өөрийн болон гэр бүлийнхээ одоогийн хэрэгцээний төлөө шаргуу ажиллаж, Эзэний ажлыг бүхнээс дээр тавьж, ирээдүйгээ Бурханд даатгана” гэж

хэлэх итгэл байгаа бол Эзэн таны ирээдүйг харж хандана гэдэг нь ямар ч эргэлзээгүй. Бурхан хэзээ ч итгэл алддаггүй. Түүний үг хэзээ ч хоосон буцдаггүй. Гэхдээ нөгөөтээгүүр, бороотой өдөрт бэлдэх хэрэгтэй гэж үзэн “хүмүүн сэрэмжлэлээр” хандаж болно. Тэглээ ч, Бурхан биднийг хайрласан хэвээр бөгөөд итгэлийн маань хэмжээнд тааруулан биднийг ашиглах болно.

Итгэлийн амьдрал нь Езекиел 47 дээрх сүмээс урсдаг устай адил. Та шагай татам усаар явж болно. Эсвэл өвдгөөр татсан усаар явж болно. Эсвэл бүсэлхийгээр татсан усаар явж болно. Эсвэл тэр дотор сэлээд явсан ч болно.

Бурханы шилдэг ерөөл нь мэдээж Түүнд бүрэн итгэдэг хүмүүст зориулагдсан. Эзэний итгэмжит байдал үргэлж хангалттай өгдгийг нь нэг л мэдчихвэл бид өөр зүйлсэд түшиглэхээ болихыг хүснэ. “Нэг л удаа усан дээр алхаад үзчихвэл дахиж завин дээр суухыг хүсэхгүй” гэж нэгэн хүний хэлснээр болдог.

## 2 сарын 26

*“Та нар цорын ганц Бурханаас алдрыг хайдаггүй атлаа бие биенээсээ алдрыг хүлээн авдаг. Тийм байж яаж итгээж чадах юм бэ?” (Иох 5:44)*

Бид хүний сайшаалыг эрэлхийлэхийн хажуугаар Бурханы сайшаалыг олж чадахгүй гэдгийг Эзэн хэлж байна. Түүнээс гадна, хүний сайшаалыг хайгч нь итгэлийн амьдралаа сүйтгэдэг гэдгийг ч хэлж байна.

Элч Паул үүнтэй ижил бодолтой байжээ. Хүний магтаалыг эрэлхийлэхийн хажуугаар Бурханы магтаалыг хайх нь хоорондоо үл зохицно гэдгийг Паул илэрхийлсэн: “Хэрэв би эдүгээ хүртэл хүмүүст таацуулсаар байсан бол би Христийн зарц биш байх байсан.” (Гал 1:10)

Жишээгээр тайлбарлая. Нэгэн залуу итгэгч теологийн ухаанаар зэрэгтэй болохыг хүсжээ. Гэхдээ түүнийгээ магадлан итгэмжлэгдсэн их сургуулиас авмаар байлаа. Харамсалтай нь тийм зэрэг олгодог магадлан итгэмжлэгдсэн сургуулиуд нь итгэлийн тулгуур үнэнүүдийг үгүйсгэдэг. Зэргээ нэртэйгээ хамт дуудуулж байх нь залууд чухал учраас эрдэмтэд нэртэй боловч загалмайн дайсан болсон хүмүүсээс зэргээ авах сонголтыг залуу хийжээ. Ингээд тэр залуу итгэл үнэмшлээсээ нэг алхам ухарч, эцэст нь үзэл бодол нь ч өөр болсон юм.

Энэ ертөнцөд эрдэмтэн гэж танигдах хүсэл аюулыг дагуулдаг. Энэ хүслийг биелүүлэхийн тулд Библийн зарчмуудаар тахил өргөж, илүү либерал хандлага руу орох шаардлагатай болдог.

Христэч сургуулиуд боловсролын салбарт танигдахын тулд магадлан итгэмжлэл авах уу үгүй юу гэдэг шаналгаат

сонголттой нүүр тулцгааж байна. “Магадлан итгэмжлэгдэх” хүсэл нь Библийн сургаалыг сулруулах хийгээд Ариун Сүнсгүй хүмүүсийн тогтоосон махан биеийн зарчмуудыг хүлээн зөвшөөрнө гэсэн үг юм.

Бид Бурханд таацуулахыг нэгт тавих ёстой. Эс бөгөөс өндөр үнэ төлөх болно. “Үнэнийг зарж олсон зоосон дээр чинь анти-Христийн дүрс байдаг шүү.” (Ф. В. Грант)

## 2 сарын 27

*“Бурхан цэцдийг ичээхийн тулд ертөнцийн мунхгийг сонгож, хүчтэйг ичээхийн тулд ертөнцийн мөхсийг сонгожээ.” (1Ко 1:27)*

Мужаан хүн хэрэггүй муу модыг ашиглаж сайхан тавилга урлавал сайн материал ашигласнаас илүү мужааны чадварыг харуулна. Түүн шиг, мунхаг, хэрэгцээгүй, сул дорой хүмүүсийг ашиглах нь Бурханд илүү алдрыг авчирч, Түүний хүч ба ур чадвар тод томруун харагдана. Өчүүхэн хүмүүс амжилт гаргавал гавьяаг нь тэдэнд биш, харин Эзэнд өгнө.

Бурхан хүчтэйг ичээхийн тулд ертөнцийн мөхсийг сонгосон тухай олон жишээ Шүүгчид номд гардаг. Тухайлбал, Ехүд нь солгой гартай бениамин хүн байлаа. Библид солгой гарыг сул доройн шинж гэж дүрсэлдэг. Ехүд Моабын хаан Еглоныг буулгаж авснаас хойш наян жилийн турш Израильд амар амгалан тогтжээ (Шүү 3:12-30).

Шамгар үхрийн чичүүртэй тулаанд орж, энэхүү муу зэвсгээр 600 филистийг хороон Израилийг аварсан (Шүү 3:31). Дебора сул дорой эмэгтэй хүн байсан ч Бурханы хүчээр канаанчуудыг ялсан (Шүү 4:1; 5:31). Баракийн 10 мянган явган цэрэг Сисерагийн 900 төмөр тэрэгтний хажууд жижиг хүч байсан ч Барак тэднийг арчин хаясан (Шүү 4:10,13). Иаел ч бас сул дорой эмэгтэй хүн байсан ч Сисераг майхны гадсаар хороож чаджээ (Шүү 4:21). Септугинтад бичсэнээр, Иаел гадсыг зүүн гартаа атгаж байв. Гидеон мидианчуудын эсрэг дайтахад Эзэн түүний 32000 цэргийг 300 болтол цөөрүүлсэн (Шүү 7:1-7). Түүний

арми арвайн гурилаар хийсэн бингээр дүрслэгдсэн. Арвайн гурилын бин нь ядуусын хоол учраас Гидеоны армийг ядуу, сул дорой хүмүүс бүрдүүлснийг илтгэдэг (Шүү 7:13). Гидеоны армийн зэвсэг нь ваар, бамбар, бүрээ байлаа (Шүү 7:16). Абимелехийг нэгэн эмэгтэй тээрмийн чулуугаар хөнөөсөн (Шүү 9:53). Тола гэж чөлөөлөгч армийн удирдагчид нийцэмгүй өт хорхой гэсэн утгатай нэр (Шүү 10:1). Анх Самсоны ээжийг харахад нэр төргүй, хүүсэр эмэгтэй байлаа (Шүү 13:2). Харин эцэст нь түүний хүү Самсон хувхай эрүүний ясаар 1000 филистийг хөнөөсөн билээ (Шүү 15:15).

## 2 сарын 28

*“ЭЗЭН Бурхан чинь...тэднийг бут цохин чиний өмнө унагана. Ингэснээр чи ЭЗЭНийхээ айлдсан ёсоор тэднийг хөөн гаргаж, даруй устгах юм.” (Дх 9:3)*

Бурхан хүн төрөлхтөнтэй ажиллах ямар ч үйл явдалд Өөрийн ба хүний аль алиных нь оролцоо байдаг.

Жишээ болгож Библийг бод. Библийн Зохиогч нь Бурхан. Гэхдээ Библийг Ариун Сүнсээр хөдөлгөгдсөн хүмүүс бичсэн.

Авралын тухай бодоход, авралыг эхнээс нь дуустал Эзэн хийсэн. Хүн түүнийг өөрийн гавьяа шагналаар олж авах боломжгүй. Гэвч хүн авралыг итгэлээр хүлээн авах ёстой. Бурхан хүмүүсийг авралд сонгодог нь үнэн боловч тэд хаалгаар өөрсдөө орох ёстой байдаг. Паул, Титэд “Бурханаар сонгогдогсдын итгэл” (Тит 1:1) гэж бичсэн.

Бурханы зүгээс харвал бид “Бурханы хүчээр хамгаалагджээ.” Гэвч хүний тал бас байна. Тэр нь итгэл. Бид “итгэлээрээ Бурханы хүчээр хамгаалагдсан.” (1Пт 1:5)

Зөвхөн Бурхан биднийг ариун болгож чадна. Гэхдээ Тэр бидэнтэй заавал хамтран ажилладаг. Бид итгэл дээрээ сайн чанарыг, мэдлэгийг, өөрийгөө захирахуйг, тэвчээрийг, сүсэглэлийг, ах дүүсэг энэрлийг, хайрыг нэмэх ёстой (2Пт 1:5-7). Мөн Бурханы хуяг дуулгыг өмсөх шаардлагатай (Еф 6:13-18). Хуучин хүнээ тайлж, шинэ хүнээ өмсөх хэрэгтэй (Еф 4:22-24). Тэгээд бас Сүнсээр алхах ёстой (Гал 5:16).

Бурхан ба хүний хосолмол оролцоог христэч үйлчлэлийн бүх талбараас харж болно. “Би тарьсан, Апол усалсан. Харин Бурхан ургуулсан.” (1Ко 3:6)



Нутгийн чуулганы удирдлагыг яривал, Бурхан хүнийг ахлагч болгодгийг харж болно. Паулын хэлснээр Ефесийн ахлагчдыг Ариун Сүнс томилжээ (Үйл 20:28). Гэсэн ч хүний хүсэл бас чухал. Тэрээр харгалзагчийн ажлыг хүсдэг байх ёстой (1Тм 3:1).

Эцэст нь хэлэхэд, Бурхан дайснуудыг маань устгадаг боловч бид тэднийг хөөж устгах ёстойг хамгийн эхний эшлэлээс харж болно (Дх 9:3).

Христигэлийн амьдралыг тэнцвэртэй авч явахын тулд Бурхан ба хүний энэхүү хосолмол ажиллагааг ойлгох хэрэгтэй. Залбирахдаа бүх зүйл Бурханаас хамааралтай гэсэн сэтгэлээр, ажиллахдаа бүх зүйл биднээс шалтгаална гэсэн сэтгэлээр ханд. “Эзэнийг магтаад галаа нээ” гэсэн дайны үеийн уриа бий. Бид сайн ургацыг төлөө залбирах ёстой ч газраа арчлах ажлыг зогсоож болохгүй гэсэн үг хэчнээн үнэн!

## 2 сарын 29

*“Есүс Христ...бүхний Эзэн.”* (Үйл 10:36)

Шинэ гэрээний үндсэн сэдвүүдийн нэг бол Есүс Христийг Эзэн гэж харуулах явдал. Есүс Эзэн учраас бид Түүнд тэр байр суурийг амьдралдаа тавьж өгөх ёстой гэдгийг Шинэ гэрээ ахин дахин сануулдаг.

Есүсийг Эзэн хэмээн өргөмжлөхийн тулд амьдралаа Түүний өлмийд авчрах ёстой. Нэг ёсондоо, бидэнд өөрсдийн маань хүсэл биш, Түүний хүсэл чухал болох юм. Хаа ч явсан, юу ч хийсэн, юу ч хэлсэн, Түүний хүслийг биелүүлнэ гэсэн үг. Эзэний армийн жанжнаас Иошуа, “Та бидний талд уу, бидний дайсны талд уу?” гэж асуухад, жанжин хариуд нь, “Би чамд туслах гэж ирээгүй. Аль эсвэл саад хийх гэж ч ирээгүй. Харин захирахаар ирлээ” гэсэн юм (Иош 5:14-ийг үз). Тиймээс Эзэн туслагч биш. Харин амьдралыг маань захирагч билээ.

Эзэн Есүсийг Аврагч гэж хэлсэн үг Шинэ гэрээнд 24 удаа гарсан бол, Эзэн гэж нэрлэсэн нь 522 удаа гарч байна. Тэгэхээр Есүсийг Эзэн гэж үзэхийн ач холбогдол тодорхой харагддаг. Түүнээс гадна, хүн ер нь “Аврагч Эзэн” гэж хэлдэг бол, Библид “Эзэн ба Аврагч” гэж хэлдэг.

Есүсийг Эзэнээ болгох нь бидний хийж болох хамгийн зөв зүйл мөн. Тэр бидний төлөө амиа өргөсөн. Бидний хийж чадах цорын ганц зүйл бол Түүний төлөө амьдрах. Тэр биднийг худалдаж авсан. Одоо бид өөрсдийн эзэмшлийнх биш. “Үнэхээрийн гайхамшигт, туйлын тэнгэрлэг хайр, сэтгэлийг маань, амьдралыг маань, байгаа бүхнийг маань шаардаж байна.”

Бид мөнх авралынхаа тал дээр Түүнд найдаж болох юм бол, амьдралаа удирдан зохион байгуулахдаа яагаад Түүнд найдаж болохгүй гэж? “Хүмүүн бид Бурханд сэтгэлээ мөнхөд зориулж, үхмэл амьдралыг ардаа орхихдоо хойрго. Түүнийг өргөмжилж, өөрсдийгөө дорд болгохдоо тааруу.” (Р. А. Лайдлоу)

Тэгвэл, Есүсийг яаж Эзэн хэмээн өргөмжилдөг вэ? Эхлээд бид юу ч чадахгүйгээ ухаарах ёстой. Тэр цагт Есүст бүх удирдлагыг атгуулж, эрх мэдэлд нь амьдралынхаа бүх талбарыг өгч чадна. Тэгж байж эргэж буцахгүйгээр, харамсахгүйгээр, юу ч үлдээлгүйгээр бид Түүнд бүхнээ зориулна.

Ийм зориулалт байгаа үед бид алхам тутамдаа Түүний жолоодлогын дагуу хөдөлж, энэ биеэ Түүнд өргөх ба Эзэн Есүс биднээр дамжин амьдардаг. Энэ туршлага бага багаар амьдралд маань батаждаг.

Үүнээс дээр зам гэж үгүй. Эзэн Есүсийн мэргэн ухаан, хайр, хүч чадал амьдралыг маань өөрсдийн маань жолоодлогоос илүү дээр жолоодно.

### 3 сарын 1

*“Өдөрт арван хоёр цаг байдаг бус уу?” (Иох 11:9)*

Есүс Галил уруу буцаж очъё гэж хэлэхэд шавь нар айцгаасан. Иудейчүүд саяхан Түүнийг чулуудаж алахыг завдсан байтал Тэр буцаж очих тухай ярьж байлаа. Шавь нарын зовнилд Есүс, *“Өдөрт арван хоёр цаг байдаг бус уу?”* гэж хариулсан. Өнгөц харахад энэ асуулт харилцан яриатайгаа уялдаагүй юм шиг санагдана. Гэхдээ Аврагчийн үг ийм утгатай: Ажлын өдөр нь арван хоёр цагаас бүрддэг. Хүн Бурханд өөрийгөө зориулсан үед өдөр бүрийн хийх ажил гэж байдаг. Тэр ажлыг гүйцэлдүүлэхэд юу ч саад болж чадахгүй. Есүс Иерусалим уруу буцаж очсон ч, иудейчүүд Түүнийг алахыг санаархсан ч, тэд санаснаа хийж чадахгүй. Түүний ажил дуусаагүй байгаа. Цаг нь хараахан болоогүй.

Бурханы хүүхэд ажлаа дуусгах хүртэл үхэхгүй. Үүнийг ойлгоод бид амар тайван, зоригтой амьдарч болно. Хэрэв бид Бурханы хүсэл дотор амьдарч, эрүүл мэнд, аюулгүй амьдралын зохих дүрмүүдийг дагаж байгаа цагт хэзээ ч цагаасаа өмнө үхэхгүй. Бурхан зөвшөөрөөгүй бол бидэнд юу ч тохиолдохгүй.

Олон итгэгч, идэж байгаа хоол, ууж байгаа ус, амьсгалж байгаа агаараасаа өвчин тусчих вий гэж байнга санаа зовдог. Бохирдол хаа сайгүй газар авсан гэж үздэг энэ нийгэмд үхэл хажууханд байна гэж итгэх өчнөөн шалтгаан бий. Гэхдээ санаа зовох нь бидэнд ямар ч хэрэггүй зүйл. *“Өдөрт арван хоёр цаг байдаг бус уу?”* Бурхан диаволын нэвтэрч үл чадах хана хэрмээр итгэгчдийг хүрээлсэн бус уу? (Иов 1:10)

Энэхүү итгэл үнэмшил нь биднийг “ингэсэн бол, тэгсэн бол” гэдэг бодлоос аварна. “Түргэн тусламж жаахан эрт ирсэн бол,” “Эмч энэ өвчнийг дөрвөн долоо хоногийн өмнө илрүүлсэн бол,” “Нөхөр маань өөр онгоцонд суусан бол” гэж бид ярихгүй. Амьдралыг маань хязгааргүй мэргэн ухаан ба дуусашгүй хүч чадалт Бурхан төлөвлөсөн юм. Бидний хүн нэг бүрд зориулсан Бурханы цагийн хуваарь төгс билээ. Түүний галт тэрэг төгс цагийн хуваариар хөдөлдөг.

### 3 сарын 2

“Сүнсний үр жимс нь хайр...” (Гал 5:22)

“Сүнсний үр жимс” гэдэг нь зөвхөн Ариун Сүнсээр бий болох боломжтой сайн зан чанаруудыг хэлж байна. Үл итгэгч хүн эдгээр зан чанарын алийг нь ч гаргаж чадахгүй. Жинхэнэ итгэгч ч гэсэн өөрийн хүч чадлаар энэ зан чанаруудыг гаргаж чадахгүй. Тэгэхээр энэ зан чанарууд нь ер бусын, өөр ертөнцийнх гэдгийг бүү мартаарай.

Энд яригдаж буй хайр нь дурлалыг илэрхийлдэг **эрос** биш. Мөн нөхөрлөлийг илэрхийлдэг **филиа**, бусдыг энэрдэг **сторгэ** биш. Харин Бурханы бидэнд харуулж өгсөн хайр, бусдад харуулаасай гэж Бурхан биднээс хүсдэг хайр, **агапэ** юм.

Нэг жишээгээр тайлбарлая. Др. Т. Е. Маккали нь Эквадорын аука индианчуудад алагдсан таван илгээлтийн эзний нэг Эдь Маккалигийн аав юм. Нэг орой бид Иллинойсын Оак Паркт хамтдаа өвдөг сөгдөн Эзэнд залбирч байлаа. Тэгэхэд түүний бодлууд хүүгийнх нь цогцсыг хадгалж буй Эквадорын Курарай мөрний эрэг дээр очиж, Эзэнд ийн залбирсан юм: “Эзэн минь ээ, хөвгүүдийг маань хөнөөсөн хүмүүс аврагдахыг харах хүртэл намайг амьд байлгаж өгөөч. Тэгвэл Христийг минь хайрладаг болсон тэднийг би тэвэрч аваад хайртайгаа хэлж чадна” хэмээн залбирсан. Залбирч дуусаад өндийж босоод харахад түүний хацрыг даган нулимсны мөр гарсан байлаа.

Бурхан хайрын энэ залбиралд хариулсан. Хожим нь аука индианчуудаас Христэд итгэгчид төрөн гарчээ. Др. Маккали, Эквадорт очоод хүүг нь хөнөөсөн хүнтэй уулзаж,

түүнийг тэвэрч аваад “Чи миний Христийг хайрладаг болсон учраас би ч чамд хайртай” гэж хэлж чадсан.

Энэ бол агапэ хайр. Энэ хайр хэнийг ч ялгаварладаггүй. Муухай хүнд ч, сайхан хүнд ч, өстөн дайсандаа ч, анд нөхөртөө ч хамгийн сайныг хүсдэг. Энэ хайр ямар ч болзолгүйгээр бусдад өгдөг боловч хариу нэхдэггүй. Энэ хайр золиос гаргадаг. Төлсөн үнээ тооцдоггүй. Энэ хайр хувиа хичээдэггүй. Өөрийнхөө биш, бусдын хэрэгцээг боддог. Энэ хайр цэвэр ариун. Тэвчээргүй зан, хорсол, бардамнал, өс хонзон, ат жөтөө түүнд нэгээхэн ч үгүй.

Хайр бол христэч амьдралын хамгийн агуу хүч мөн. Хайр үгүй бол бусад нь ямар ч утга учиргүй.

### 3 сарын 3

“Сүнсний үр жимс нь...баяр баясгалан...” (Гал 5:22)

Хүн Эзэнийг олохоос нааш жинхэнэ баяр баясгаланг эс олно. Эзэнийг олсон хүн Петрийн хэлсэн шиг “үгээр хэлэхийн аргагүй, алдраар дүүрэн баяр хөөрөөр” (1Пт 1:8) дүүрдэг.

Нөхцөл байдал сайхан үед хэн ч баярлаж чадна. Харин Сүнсний үр жимс болсон баяр баясгалан нь энэ ертөнцийн нөхцөл байдлаас ирдэг зүйл биш. Энэ нь Эзэнтэй харилцах харилцаа ба Түүний бидэнд өгсөн үнэт амлалтуудаас ирдэг ивээл билээ. Чуулган Христийг өргөмжлөхөө больсон цагаас эхлэн баяр баясгалангаа гээдэг.

Христитгэгч зовлон амссан ч баяр баясгалантай байж болно. Паул “баяр хөөртэйгөөр бүхий л тэсвэр, тэвчээрт хүр” (Кол 1:11) гэж хэлэхдээ зовлон ба баяр хөөрийг холбосон. Тесалоникийн ариун хүмүүс “үлэмж зовлон дор Ариун Сүнсний баяр хөөртэйгөөр” (1Тс 1:6) үгийг хүлээсэн авсан. Эзэн харанхуй шөнөөр дуулах дууг өгсөн гэж зовлон амссан ариун хүмүүс зуун зууны турш гэрчилсээр иржээ.

Баяр баясгалан нь уй гашуутай хамт орших боломжтой. Итгэгч хүн хайрт нэгнийхээ оршуулга дээр зогсохдоо, түүнийгээ алдсандаа гашуудаж болох ч, нөгөөтээгүүр хайртай хүн нь Эзэний оршихуйд байгаа гэдгийг мэддэг учраас баяр баясгалантай байна.

Гэхдээ баяр баясгалан, нүгэл хоёр хамт оршдоггүй. Христитгэгч нүгэл үйлдсэн мөчдөө баярын дуугаа алдана. Уг нүглийг улайж, гэмшиж, таягдан хаяхаас нааш авралын баяр баясгалан дахиж ирэхгүй.



Хавчигдаж, гүтгүүлж, доромжлуулсан ч баяр хөөртэй бай гэж Эзэн Есүс шавь нартаа хэлсэн (Мт 5:11,12). Тэд ч энэ үгийн дагуу амьдарчээ. Олон жилийн дараа тэд шүүх танхимаас гарахдаа “Түүний нэрийн төлөө доромжлогдон зовох нь зохистой гэж тооцогддогт баярлалдсан” (Үйл 5:41) гэдгийг бид уншдаг.

Эзэний тухай мэдлэг нэмэгдэх тусам бидний баяр баясгалан нэмэгддэг. Эхэндээ, бид бага зэргийн асуудлууд ирсэн ч баяр хөөрөө алдахгүй байж болох юм. Гэвч нөхцөл байдал тартагтаа тулсан ч, Бурханы замууд төгс гэдгийг мэдэн баяр баясгалантай байж сураасай хэмээн Бурханы Сүнс биднээс хүсдэг. Хэрэв бид Хабаккукийн үгийг хэлж чадаж байвал, сүнслэг төлөвшилд хүрсний шинж юм: “Хэдийгээр инжрийн мод цэцэглээгүй, усан үзмийн мод ч үр жимсгүй, чидуны ургац гарахгүй, талбайд хүнс огт ургахгүй байсан ч, бас хашаандаа хоньгүй, саравчиндаа үхэргүй болсон ч ЭЗЭНий дотор би баясан хөөрч, авралынхаа Бурхан дотор баярлана.” (Хаб 3:17,18)

### 3 сарын 4

“Сүнсний үр жимс нь...амар тайван...” (Гал 5:22)

Бид Эзэн Есүс Христээр дамжуулан итгэлээр зөвтгөгдсөн даруйд Бурхантай энх тайван (амар тайван) харилцаатай болдог (Ром 5:1). Өөрөөр хэлбэл, Бурхан ба бидний хоорондох дайсагнал дуусгавар болж, эвлэрэл тогтож байгаа юм. Учир нь Христ дайсагналын үндсэн шалтгаан болсон нүглийг бүрмөсөн шийджээ.

Мөн бидний мөс чанарт амар тайван ирдэг. Христийн ажил бүрэн төгс дуусгавар болж, Христ нүглийн шийтгэлийг төлж, Бурхан нүглийг мартсан гэдгийг мэддэг болсноор энэ амар амгалан ирнэ.

Түүгээр ч зогсохгүй, Бурханы амар тайвныг зүрхэндээ мэдрээсэй гэж Ариун Сүнс биднээс хүсдэг. Бидний бүх асуудлыг Бурхан атгадаг бөгөөд Бурханы зөвшөөрөлгүйгээр бидэнд юу ч тохиолдохгүй гэдгийг мэддэг болсноор зүрх сэтгэл амардаг.

Түгжрэлтэй замд дугуй хагарсан ч бид уужуу тайван байх боломжтой. Замын түгжрэлээс болж онгоцноосоо хоцорлоо ч тайван байдлаа алдахгүй байж болно. Амар тайван гэдэг нь машин мөргөлдсөн ч уужуу байхыг хэлж байгаа юм. Гал тогоонд тос асгарсан ч бачимдалгүй байхыг хэлж байгаа юм.

Сүнсний энэхүү үр жимсний ачаар Петр шорон дотор бөх нойрсож, Стефан өөрийг нь хөнөөгчдийн төлөө залбирч, Паул живж буй онгоцонд хүмүүсийг тайтгаруулж чадсан.

Онгоц өндрөө авсны дараа хүчтэй салхи дэгдэж, онгоцыг дайвалзуулбал ихэнх зорчигч сандралдан

хашхирна. Харин зүрхэндээ амар тайван бүхий итгэгч толгой гудайн Бурханд залбирч, юу ч тохиолдсон Бурханыг магтаж чадна.

Арай өөр жишээгээр тайлбарлая. Бурханы Сүнсний амар тайван бидний дотор байгаа үед “Та эдгэшгүй өвчин тусжээ” гэсэн үг эмчээс сонслоо ч, бид “Эмч ээ, би явахад бэлэн. Бурханы нигүүлслээр аврагдчихсан болохоор үхэл нь миний хувьд энэ биеэ орхиж, жинхэнэ гэр рүүгээ Эзэнтэй хамт байхаар одох гэсэн үг юм” гэж хэлж чадна.

Тийм ч учраас Бикерстэтийн зохиосон магтаалын дуу ингэж шүлэглэдэг: “Нүгэлт харанхуй энэ ертөнцөд... эргэн тойронд минь уй гашуу хүрээлсэн ч... хайртай хүмүүс минь салан одсон ч... ирээдүй минь яах нь тодорхойгүй ч... амар тайван, амар тайван, амар тайван.” Яагаад гэвэл “Есүсийг бид мэднэ. Тэр хаан ширээндээ заларч байна.”

### 3 сарын 5

“Сүнсний үр жимс нь...тэвчээр...” (Гал 5:22)

Тэвчээр гэдэг нь амьдралын хэцүү нөхцөлийг тэсвэрлэн давдаг, бүр ялгууснаар давдаг сайн чанар билээ. Үүнийг амьдралын жишээгээр хэлбэл, өвчтэй хүн тэрхүү зовлонг нөхцөл байдалдаа гаргаж буй зан чанар юм. Аль эсвэл, хэн нэгэн нь хүмүүсийн уур уцаарыг зөөлнөөр туулж буй хандлага юм.

Бурхан хүн төрөлхтөнд тэвчээртэй ханддаг. Өнөө цагт хүн төрөлхтөн ямар аймшигтай нүгэл үйлдэж буйг хэсэг зуур бодоод үзье. Тэд биеэ үнэлэхийг хуульчлан баталж, ижил хүйстний харилцааг өөхшүүлж, үр хөндөлтийг хуулиар зөвшөөрч, гэрлэлтийн харилцааг сүйтгэж, нийтээрээ ёс суртахууны хэм хэмжээг үгүйсгэсэн. Хамгийн том нүгэл нь Бурханы Хүүг цорын ганц Эзэн ба Аврагч болгон хүлээн авахаас татгалзсан явдал. Ийм муухай нүгэлт хүн төрөлхтнийг Бурхан хормын төдийд арчин хаях бүрэн эрхтэй. Гэвч Тэр тэгдэггүй. Тэр сайхан сэтгэлтэй учраас хүмүүсийг гэмшилд хөтөлдөг. Тэрээр хэнийг ч мөхөөсэй гэж хүсдэггүй.

Бурхан Өөрөө тэвчээртэй учраас Өөрийн хүмүүсийн амьдралаас Ариун Сүнсний энэхүү үр жимс гараасай гэж хүсдэг. Өөрөөр хэлбэл, Бурхан биднийг амархан уурладаггүй, асуудалд хөнгөн хуумгай ханддаггүй, буруутан этгээдтэй тооцоо хийх гэж адгадаггүй, харин бусдыг Христ уруу авчирдаг тэвчээрийг үзүүлээсэй гэж хүсдэг байна.

Эгч дүү Корри, Бэтси хоёр бөөнөөр хорих лагерьд маш их зовлон амссан хүмүүс. Тэр үед Бэтси “Эндээс гарсныхаа

дараа энэ хүмүүст туслах ёстой” гэж хэлдэг байж. Тэгэхэд нь Корри, нацистуудын гарт зовсон хүмүүст туслах ажил хийх талаар Бэтси ярьж байна гэж боддог байлаа. Гэтэл Бэтси нацистуудад туслах тухай ярьж байсныг Корри хожим нь ойлгожээ. Өөрсдийг нь хавчин зовоогчдод явал хүнийг хайрлахыг зааж өгөх вэ гэж Бэтси байнга бодож байсан байна. Корри хожим нь энэ тухай дурсахдаа “Эгч минь ямар гайхалтай хүн байсныг би нэг биш удаа харж байлаа. Би тэрхүү хатуу замаар дөнгөн данган сажилж явахад тэр маань зоримог алхаж байсан юм” гэж бичжээ (Хоргодох газар, хуудас 175).

Бэтси зоримгоор алхаж явсан тэр зам бол тэвчээрийн зам юм. Корри өөрийгөө өндөр үнэлээгүй ч гэлээ, ялгаагүй тэр замаар алхсан хүн билээ.

### 3 сарын 6

“Сүнсний үр жимс нь...энэрэл [сайхан сэтгэл]” (Гал 5:22)

Жэймс хааны орчуулга (KJV) энэ үгийг “gentleness” (дөлгөөн зан) гэж орчуулсан. Гэвч орчин үеийн бараг бүх орчуулга “kindness” (энэрэл, сайхан сэтгэл) гэж орчуулдаг. “Сүнсний үр жимс нь...энэрэл”

Энэрэл гэдэг нь бусдад тусалж, хайр нигүүлсэл үзүүлж, тэдний сайн сайхны төлөө алхам хийдэг дөлгөөн, өгөөмөр, нигүүлсэнгүй зан юм. Энэрэнгүй хүн хатуу биш зөөлөн байдаг. Хайхрамжгүй биш өрөвч байдаг. Бусдын асуудлыг үл ойшоодог биш тусч байдаг. Энэрэнгүй хүн бусдыг бодож, өрөвдөж, тэдний сайны төлөө санаа тавьдаг.

Энэ ертөнцийн хүмүүст ч гэсэн бусдад санаа тавих төрөлхийн сайхан сэтгэл байдаг ч гэсэн Сүнсний үр жимс болсон энэрэл нь ер бусын мөн чанартай. Энэ зан чанарыг хүн өөрийн хүч чадал, нөөц боломжоор гаргаж чадахгүй. Энэрэл нь буцааж нэхэхгүйгээр өгдөг. Ачийг нь хариулж чадахгүй хүнд ч гэсэн зочломтгой ханддаг. Доромжлолд эелдгээр хариулдаг. Их сургуулийн нэгэн итгэгч оюутан энэхүү сайхан сэтгэлийг архичин найздаа үзүүлжээ. Архичин найз нь дэндүү яршигтай болохоор ангийнхан нь ч түүнээс нүүр буруулсан байлаа. Сүүлдээ тэр очих газаргүй болов. Харин итгэгч залуугийн өрөөнд нэг хүний илүү зай байсан учраас архичин найзтайгаа хамт амьдрахыг зөвшөөрсөн байна. Итгэгч залуу олон өдөр найзынхаа бөөлжсийг цэвэрлэж, хувцсыг нь сольж, усанд оруулж, оронд нь оруулах ажил хийжээ. Энэ бол христэч энэрлийн нэг том жишээ мөн.

Архичин найз нь эрүүл болсон үедээ нэг удаа уцаарлангуйгаар, “Чи ер нь яагаад надад ингэж хандаад байгаа юм бэ? Чиний зорилго юу юм?” гэж христитгэгч залуугаас асууж. Өнөөх залуу хариуд нь, “Миний зорилго бол чиний сүнсийг аврах явдал” гэж хэлжээ. Үнэхээр тэр залуу найзынхаа сүнсийг аварч чадсан.

Доктор Айронсайд нэг удаа зоорио цэвэрлээд цаас, даавуу, төмрийн хогоо хог авдаг явуулын машинд тушааж. Хог авагч нь иудей хүн байлаа. Доктор Айронсайд хогоо гайгүй үнээр зарахыг хичээж буй дүр мэт эсгэн түүнтэй жаал ярилцав. Мэдээж хог авдаг хүний тогтоосон үнэ л дийлсэн байж таарна. Харин хог авдаг хүн хамгийн сүүлийн ачааг машиндаа хийж дуусахад доктор Айронсайд түүнийг дуудаад “Би нэг юм мартчихаж. Үүнийг би чамд Эзэн Есүсийн нэрээр өгч байгаа юм шүү” гэж хэлээд тавин цент өгчээ.

Хог авдаг хүн “Хэн ч надад өмнө нь Есүсийн нэрээр юм өгч байгаагүй” гэж хэлээд тэндээс холдов.

“Сүнсний үр жимс нь...энэрэл”

### 3 сарын 7

“Сүнсний үр жимс нь...сайн сэтгэл [сайхан чанар]” (Гал 5:22)

Сайн чанар гэдэг нь хамаг л сайн сайхныг агуулсан чанарыг хэлж байна. Нэг ёсондоо, сайн чанарыг агуулагч хүн нь амьдралын бүх талбарт сайхан сэтгэлтэй, зөв шударга, ёс суртахуунтай гэсэн үг юм.

Сайн чанарын эсрэг нь муу чанар. Муу хүн гэхээр хууран мэхлэгч, ёс суртахуунгүй, шударга бус, зэрлэг догшин, хувиа хичээсэн, хорсол тээсэн, шуналтай, тэвчээргүй хүнийг хэлнэ. Харин сайн хүн гэхээр, төгс хүн биш ч гэлээ, үнэнийг баримталдаг, шударга ариуныг эрхэмлэдэг, бусад сайн чанаруудыг сайшаадаг хүнийг хэлнэ.

Элч Паул Ром 5:7 дээр зөвт хүн ба сайн хүний ялгааг харуулсан. Зөвт хүн нь харилцаандаа шударга, шулуун, эрс шийдмэг зан гаргадаг. Тийм ч болохоор бусдаас хөндий байж болно. Эсрэгээрээ, сайн хүн нь бусдад элэгсэг дотно ханддаг. Хүн зөвт хүний төлөө бараг үхэхгүй байх. Харин сайн хүний төлөө үхэх хүн гарч магадгүй.

Гэхдээ сайн чанар хатуу зан гаргаж чадна гэдгийг мартаж болохгүй. Сайн чанар, нүглийг хүлээн зөвшөөрдөггүй. Тиймээс сайн чанараас зэмлэл, залруулга, сахилгажуулалт гарч болно. Эзэн Есүс сайн сайхны биелсэн дүр боловч сүмийг цэвэрлэснээс үүнийг харж болно.

Сайн чанар нь бузар мууг даван туулж чаддаг онцлогтой. Паул Ромын итгэгчдэд “Мууд бүү дийлд, мууг харин сайнаар дийл” гэж бичсэн (Ром. 12:21). Бид хэн



нэгний үзэн ядалтаас болж зан чанараа эвдвэл мууд дийлдэж байгаа нь тэр. Харин муу муухай хандлагыг давж, нигүүлсэл, өршөөл, хайр харуулбал мууг сайнаар дийллээ гэсэн үг.

Мэрдок Кэмбэлийн ярьсан түүхийг энд сийрүүлье: Эхнэр нь тэвчихийн аргагүй зантай нэгэн номлогч байжээ. Нэг өдөр түүнийг Библи уншиж байтал эхнэр нь Библийг нь булааж аваад галд чулуудчихав. Номлогч эхнэрийнхээ нүүр өөд хараад “Үүн шиг элчтэй галын дэргэд сууж байсангүй” гэж хэлэв. Номлогчийн сайн чанар эхнэрийнхээ мууг ялан дийлсэн юм. Хожим эхнэр нь сайхан сэтгэлтэй, сайн эмэгтэй болсон билээ. Номлогчийн эхнэр Иезебел байснаа Лудиа болов. Өргөст ургамал байснаа сараана цэцэг болов. Сайн чанар ингэж ялалт байгуулжээ!

### 3 сарын 8

“Сүнсний үр жимс нь...итгэлтэй байдал” (Гал 5:22)

Сүнсний энэхүү үр жимс нь найдвартай, итгэмжтэй байдлыг хэлж байна. Энэ нь авралд хүргэдэг итгэлийг яриагүй. Эсвэл өдөр бүр Бурханд итгэж найддаг байх (мэдээж үүнийг агуулдаг ч гэсэн) тухай яриагүй. Харин Эзэнтэй болон бусадтай харилцах харилцаандаа итгэл алдахгүй найдвартай байж чадах зан чанарыг хэлж байна. Нэг хүн үүнийг “өөртөө үнэн байж, өөрийгөө эс хуурч, даалгасан ажилд найдвартай хандаж, өгсөн амлалтдаа үнэнч байх явдал” хэмээн тодорхойлсон.

“Үгэндээ хүрдэг хүн” гэж бид ярьдаг. Энэ нь бичгээр гэрээ үйлдэхгүйгээр хамтран ажиллаж болдог хүнийг хэлдэг. Түүнтэй ямар нэг зүйл хэлэлцэж тохирсон бол түүнд найдаж болно гэсэн үг.

Итгэмжтэй хүн цагаа барьдаг, төлбөрөө хугацаандаа төлдөг, цуглаандаа тогтмол хамрагддаг, даалгасан ажлыг байнга сануулаагүй байсан ч гүйцэтгэдэг. Тэр хүн гэрлэлтийн тангаргаа үнэнчээр сахиж, гэр бүлийнхээ өмнө хүлээсэн үүрэг хариуцлагаа биелүүлдэг. Мөн Эзэний ажлын төлөө мөнгө гаргадаг бөгөөд цаг хугацаа, өгөгдсөн талантуудаа нярвын ёсоор зөв захиран зарцуулдаг.

Итгэмжтэй байна гэдэг нь өөрөөс нь ямар ч золиос гарсан хамаагүй үгэндээ хүрдэг байхыг хэлнэ. Итгэмжит хүн “өөрөө хохирсон ч андгайлснаасаа үл няцна” (Дуу 115:4). Өөрөөр хэлбэл, нэгэнт хоол захиалсан бол, илүү сайхан орцтой цэс харсан ч захиалгаа үл цуцална. Нэгэнт ажил хүлээгээд авчихсан бол түүнийгээ умартаад аялалд эс явна (орны хүн нь томилогдоогүй байхад). Байшингаа

зарах гэж хүнтэй нэгэнт үнэ тохирсон бол өөр хүн 10 мянган доллароор илүү үнэ хэлсэн ч, өмнөх хүнтэйгээ хийсэн тохиролцоогоо үл цуцална.

Хамгийн дээд итгэмжит байдал бол Христэд үнэнч байх явдал юм. Тэр хүн Христийг үгүйсгэхийн оронд үхэхийг илүүд үзнэ. Нэгэн итгэмжит христитгэгч хүнд эзэн хаан нь итгэлээ үгүйсгэхийг шаардахад, “Зүрх минь Түүнийг боддог. Ам минь Түүнийг ярьдаг. Гар минь Түүнд үйлчилдэг. Эдүгээ шаардлагатай гэвэл, Бурханы нигүүлслээр би цусаараа Түүнийг тамгалъя” гэж хариулсан байна. Хэрэв Есүсийг үгүйсгэвэл амьд үлдээе гэдэг саналыг хүлээн авсан Поликарп, “Би энэ наян зургаан жил Эзэнд үйлчиллээ. Тэр надад мууг үйлдсэн удаа нэг ч үгүй. Би ч одоо өөрийн Эзэнийг үгүйсгэж яахан чадах юм бэ?” гэсэн байна.

Итгэлийнхээ төлөө амиа алдагсад үхэл хүртэл үнэнч байсан тул амийн титмийг хүлээн авах болно (Илч 2:10).

### 3 сарын 9

“Сүнсний үр жимс нь...дөлгөөн зан” (Гал 5:23)

Дөлгөөн занг бодохоор комикс зохиолын дүр, бүрэг ичимхий, сул доройн бэлгэ тэмдэг Каспар Милктоост санаанд буудаг. Гэвч Сүнсний энэхүү үр жимс нь түүнээс огт өөр зүйл бөгөөд сул дорой байдлаас бус, ер бусын хүч чадлаас урган гардаг.

Дөлгөөн зан гэж нэгдүгээрт, итгэгч хүн амьдралд нь хийж буй Бурханы бүх ажилд хайрын үүднээс захирагдахыг хэлдэг. Дөлгөөн хүн эсэргүүцэл, гомдол, эргэлзээгүйгээр Бурханы хүслийг дагадаг. “Бурхан эндүүрэх боломжгүй мэргэн, хорсон зэвүүцэх боломжгүй сайхан сэтгэлтэй” гэдгийг дөлгөөн хүн мэднэ. Аз эз, тохиолдол гэж байхгүйг ухаардаг учраас Бурхан өөрийнх нь амьдралын сайн сайхны төлөө бүхнийг ажиллуулдагт тэр итгэдэг.

Хоёрдугаарт дөлгөөн зан нь итгэгчдийн бусадтай харилцах харилцаанд илэрдэг. Дөлгөөн хүн өөрийгөө батлах гэж гүйдэггүй. Сагсуурч онгирдоггүй. Харин өөрийгөө үгүйсгэж, даруу зан гаргадаг. Дөлгөөн хүн бол эмтэрсэн зүрхтэй нэгэн юм. Ямар нэг буруу юм ярих юм уу хийсэн байлаа гэхэд “Миний буруу. Намайг уучлаач” гэж хэлэн бардамналыг үхүүлдэг. Дөлгөөн хүн өөрийгөө өргөмжлөх гэж улайрдаггүй. Түүний оронд, дорд болохыг илүүд үзнэ. Зөвийг хийснийхээ төлөө зовлон амсвал хариуг нь өгөх гэж зүтгэлгүй, тэвчээртэйгээр хүлцэн өнгөрүүлдэг. Өөрийг нь худал гүтгэвэл өөрийгөө өмөөрөхөөс зайлсхийнэ. Трэнчийн хэлсэнчлэн, “Өөрийг нь гэмтээж, доромжлохыг Бурхан зөвшөөрсөн бол дөлгөөн

хүн түүнийг өөрийг нь сахилгажуулж, цэвэршүүлэх зорилготой хэмээн үзэж, тэр бүх зовлонг хүлээн зөвшөөрдөг.”

Дөлгөөн хүний тухай нэгэн тодорхойлолт: “Бурханы хүслийг тээршээлгүйгээр хүлээн авдаг, дотоод сэтгэлдээ хүчирхэг учраас ямар ч үед дөлгөөн зөөлөн байж чаддаг, Бурханаар бүрэн удирдуулдаг хүнийг дөлгөөн хүн гэнэ.” Доктор Александер Вайтад, хамтрагчийг тань хүмүүс үл итгэгч хэмээн шүүмжилж байна гэж цуглааных нь итгэгч хэлэхэд доктор Вайт ихэд уурлав. Доктор Вайтыг өөрийг нь ч бас жинхэнэ итгэгч биш хэмээн шүүмжилсэн гэхэд нь доктор Вайт “Өрөөнөөс гарч бай. Би ганцаараа үлдээд Эзэний өмнө зүрхээ шалгая” гэж хэлжээ. Энэ бол дөлгөөн зан юм.

Бид бүгдээрээ “дөлгөөн, зүрхэндээ даруу” (Мт 5:23) Нэгэний буулгаас үүрэхээр дуудагдсан билээ. Тэгэх аваас сэтгэлдээ амралтыг олж, дэлхийг үнэхээр өвлөх болно.

### 3 сарын 10

“Сүнсний үр жимс нь...өөрийгөө захирахуй нь юм.” (Гал 5:23)

Сүнсний сүүлчийн үр жимс болох өөрийгөө захирахуй (temperance) нь биеэ хянахыг хэлж байна. Өөрийгөө захирахуй (temperance) нь гол төлөв согтууруулах ундааны хэрэглээг хязгаарлахтай холбоотойгоор хэрэглэгддэг. Өөрийгөө захирах гэж амьдралын бүхий л талбарт биеэ зохистой авч явахыг эсвэл бурууг цээрлэхийг хэлнэ.

Итгэгч хүн Ариун Сүнсний хүчээр өөрийн бодол санаа, идэж уух дуршил, хэл яриа, бэлгийн амьдрал, сэтгэл хөдлөлөө хянан удирдаж, Бурханы өгсөн аливаа эрхийг ухаантай ашиглах боломжтой болжээ. Итгэгч хүн дур хүсэлд боолчлуулах шаардлага байхгүй.

Тамирчид бүх зүйл дээр биеэ захирдаг гэж Паул коринтчуудад сануулсан (1Ко 9:25). Паул өөрөө ямар ч зүйлд боолчлогдохгүй гэж шийдсэн (1 Кор. 6:12) бөгөөд бусдад тунхагласан атлаа өөрөө тэнцээгүй байх вий гэсэндээ биеэ залхааж, боолчилдог (1Ко 9:27) хэмээжээ.

Сахилга багтай христитгэгч хүн хэтрүүлж идэхээс зайлсхийдэг. Тэрээр кофе, цай, хийжүүлсэн ундаанд донтох шинжтэй болбол тэдгээрийг шууд таягдан хаягддаг. Мөн тамхины ямар ч хэлбэрээс татгалздаг. Тэрбээр эмчилгээний зориулалтаар эмчийн бичиж өгснөөс бусад тохиолдолд тайвшруулах эм, нойрны эм зэрэг янз бүрийн эмийг хэрэглэхээс болгоомжилдог. Мөн унтах цагаа хянан зохицуулдаг. Хэрэв хүсэл тачаалын асуудалтай тэмцэлдэж байвал цэвэр ариун бодлуудыг хөгжүүлж, цэвэр ариун бодолд төвлөрч, бүтээлч ажлаар өөрийгөө завгүй болгодог.

Түүний хувьд донтолт эсвэл зуршил болсон нүгэл нь ялан дийлэх ёстой Голиат юм.

Христэд итгэгчид зарим зуршлаа хаяж чадахгүй байна гэж гомдоллодог. Ингэж ялагдлыг хүлээн зөвшөөрвөл итгэлийн амьдрал нь гарцаагүй сүйрнэ. Ингэж хэлснээрээ тэд хэрэгтэй ялалтыг нь Ариун Сүнс өгч чадахгүй байна гэж байгаагаас ялгаагүй юм. Гэтэл үнэндээ Ариун Сүнсгүй, үл итгэгч хүмүүс хүртэл архи уух, тамхи татах, мөрийтэй тоглох, ам гардаг муу зуршлуудаасаа салж чаддаг шүү дээ. Тэгвэл дотроо Ариун Сүнснийг агуулагч христитгэгчид тэр Сүнсний хүчээр муу зуршлаа хаях нь илүү хялбар байх биш үү?

Өөрийгөө захирахуй нь Сүнсний бусад найман үр жимсний адил ер бусын зүйл. Энэ үр жимсний тусламжтайгаар итгэгчид бусдын чадахгүй сахилга батыг өөрсдөдөө бий болгох боломжтой.

### 3 сарын 11

*“Замд хамт яваа дээрээ арцалдагчтайгаа аль болох түргэн сайд. Эс тэгвэл арцалдагч чинь чамайг шүүгчид өгч, шүүгч түшмэлд хүргэж, чи шоронд хаягдах вий.” (Мт 5:25)*

Христитгэгчид хууль шүүхийн байгууллага уруу гүйхийг урьтал болгох хэрэггүй гэдгийг энэ эшлэлээс харж болно. Гомдол, хохирлоо барагдуулахын тулд шүүх өөд гүйдэг нь хүний төрөлх хандлага юм. Гэвч итгэгч хүн төрөлх араншингаас илүү дээр зарчмаар удирдуулдаг. Бурханы хүсэл төрөлх хандлагаас илүү дээр зарчим билээ.

Өнөөдөр манай шүүхүүд авто ослын хэрэг, мэргэжлийн ёс зүйн алдаа, гэр бүл цуцлалт, өв залгамжлалын асуудлуудыг шийдэж байна. Олон тохиолдолд хүмүүс хурдан баяжих гэж яарсандаа шууд хуульч уруу гүйдэг. Гэвч итгэгч бид асуудлыг хууль шүүхийн байгууллагаар бус, хайрын хүчээр шийдэх хэрэгтэй. Нэгэн хүний хэлсэнчлэн, “Хэрэв та хууль шүүхээр асуудлаа шийдэх гэвэл, хуулийн процесс таны мөнгийг бүрэн шавхаж, та ч эцсийн зоосыг төлөх болно.”

Хууль шүүхийн үйл ажиллагаанаас баараагүй хожилтой үлдэх цорын ганц хүн бол өмгөөлөгч юм. Түүний төлбөрийг гарцаагүй төлнө. Үүнийг дүрсэлсэн зурагт, үхрийг нэхэмжлэгч толгойноос нь, хариуцагч сүүлнээс нь татах ба өмгөөлөгч үхрийг сааж суудаг.

1Коринт 6-р бүлэгт, христитгэгч нь итгэгч ах дүүгийнхээ эсрэг хууль шүүхийн байгууллагад хандахыг хориглосон. Хэрэв маргаан байвал чуулганы доторх мэргэн хүмүүсийн өмнө маргаанаа шийдүүлэх хэрэгтэй. Бүр цаашлаад энэ ертөнцийн шүүх тогтолцоонд хандахын



оронд хууртагдаж, хохирч үлдэхэд бид бэлэн байх ёстой. Энэхүү зарчим нь итгэгч эхнэр нөхрийн салалтын бүх төрлийн хэрэг дээр үйлчилж байвал зохино.

Тэгвэл итгэгч ба үл итгэгчийн хоорондох маргааныг яах вэ? Христитгэгч нь эрхийнхээ төлөө зогсох ёсгүй гэж үү? Христэч хүний амьдралд өөрчлөлт авчирдгийг харуулахын тулд эрхээсээ татгалзах нь түүнээс хавьгүй дээр зүйл шүү гэж энэ асуултад хариулья. Буруутай этгээдийн эсрэг зарга мэдүүлэхэд тэнгэрлэг амь шаардагдахгүй. Харин хэргээ Бурханд даатгаад, аврах, өөрчлөх чадалтай Христийн хүч чадлыг гэрчлэхэд тэр хэргийг боломж болгон ашиглахад тэнгэрлэг амь хэрэгтэй. Боломж байгаа бол бүх хүнтэй эвтэй байх нь бидэнд нийцнэ (Ром 12:18).

“Нэг хүн өөрийнхөө болон хөршийнхөө дундуур хашаа барьж эхлэв. Хөрш нь ирээд, “Чи энэ газрыг худалдаж авах үед газрын зарга бас цуг ирсэн шүү. Наад хашаагаа миний газар дээр 1.5 метр барих ёстой” гэж хэлэв. Өнөөх хүн хариуд нь, “Хөрш маань ийм сайн хүн байна гэж би мэдээд байсан юм. Би саналаа хэлье. Та хашааг барь. Хашааг хаагуур татмаар байна, түүгээрээ л татчих. Тэгээд зардлын тооцоог надад өгөөрэй. Би зардлыг нь төлье” гэжээ. Тэр хашаа хэзээ ч баригдаагүй юм. Тийм шаардлага ч гарсангүй.” (Э. Стэнли Жонс)

### 3 сарын 12

*“Та нар энэ ах дүүсийн минь дорд нэгэнд ийн үйлдсэн бол Надад хийсэн хэрэг.” (Мт 25:40)*

Энэ эшлэл нэг талаар сайныг үйлдэх сэдэл, нөгөө талаар бодох ёстой анхааруулгыг өгч байна. Христийн ах дүү нарт хийсэн бүхэн маань Христэд хийсэн гэж тооцогддог.

Бид итгэгч ахан дүүдээ сайхан сэтгэл гаргаснаар өдөр бүр Эзэн Есүст сайныг үйлдэх боломжтой. Бурханы хүмүүст зочломтгой хандах нь Бурханд зочломтгой хандсантай ижил. Хэрэв бид Эзэний хүмүүст хамгийн сайн унтлагын өрөөгөө хэрэглүүлбэл Эзэнд хэрэглүүлсэнтэй адил.

Аврагч Есүс хаадын Хаан, эздийн Эзэн ёсоор ирвэл бараг хүн бүр Түүнд байдгаа барьж гүйнэ. Гэвч Тэр ихэвчлэн маш дорд даруугаар бидэн дээр ирдэг бөгөөд энэ нь бидний үнэн мөнийг харуулдаг. Түүний ах дүүсийн хамгийн доройд хэрхэн хандана, Түүнд тийн хандсан гэсэн үг юм.

Өндөр настай, бурханлаг нэгэн номлогч Бурханы үгийг ариун хүмүүст хуваалцахаар нэгэн чуулганд иржээ. Хүнийг байлдан дагуулах ур чадвар, номлолын тусгай арга техник түүнд байсангүй. Гэвч тэрээр Бурханы зарц байсан бөгөөд түүнд Эзэний үг байлаа. Гэтэл ахлагчид нь түүнийг цуглаанд номлуулах боломжгүй гэдгээ хэлж, хар арьстнуудын дүүрэгт байрлах чуулган уруу очихыг зөвлөв. Тэр ч зөвлөгөөг нь дагалаа. Тэндхийн ах дүү нар түүнийг халуун дотноор хүлээн авав. Харамсалтай нь цуглаан хийж байсан тэр долоо хоногийнхоо дундуур номлогч маань

зүрхний шигдээсээр нас баржээ. Энэ явдлаар дамжуулан Эзэн ганган чуулганд хандан, “Та нар түүнийг хүлээн аваагүй ч би хүлээн авлаа. Түүнээс нүүр буруулснаараа та нар Надаас нүүр бурууллаа” гэж хэлэх шиг...

“Ямар эрхэм зочин айлчлав аа” шүлэгтээ Эдвин Маргэм, Эзэнийг гэртээ авчрахыг мөрөөддөг нэгэн хөгшин гуталчны тухай өгүүлсэн. Эзэн түүний гэрт ер ирсэнгүй. Гэтэл нэг гуйлгачин ирэв. Гуталчин түүнд гутал хийж өгчээ. Дараа нь настай эмэгтэй ирэв. Гуталчин түүний ачааг өргөлцөж, хоол ундаар дайлжээ. Дараа нь гэрээсээ төөрсөн хүүхэд ирэв. Гуталчин хүүхдийг ээжид нь аваачиж өгөв.

Тэр үед нам гүм дунд намуухан дуу хоолой ингэж хэлэв:

Бүү гунигла анд минь, хэлсэндээ би хүрсэн шүү!  
Найрсаг чиний үүдэнд гурван удаа ирсэн шүү!  
Шалбархай хөлтэй гуйлгачин би байсан юм шүү!  
Хоолыг чинь идсэн эмэгтэй ч би байсан юм шүү!  
Гэрээсээ төөрсөн хүүхэд бас би байсан юм шүү!

### 3 сарын 13

*“Та нар сонсож байгаа зүйлээ анхаарагтун.”* (Мк 4:24)

Эзэн Есүс сонссон зүйлдээ болгоомжтой хандахыг анхааруулж байна. Чихээр минь орж ирэх зүйлсийг бид хянах үүрэгтэй. Мөн сонссоноо зөв ашиглах үүрэгтэй.

Бид улайм цайм худлыг сонсох ёсгүй. Өнөөдөр гаж урсгалууд өөрсдийн суртал ухуулгыг урьд өмнө үзэгдээгүй их хэмжээгээр тарааж байна. Тэд сонсоход бэлэн хүнийг байнга хайдаг. Буруу сургаалтнуудыг гэртээ оруулж болохгүй, тэдэнтэй мэндэлж ч болохгүй гэж Иохан хэлсэн. Тэд бол Христийг эсэргүүцэгчид.

Заль мэхтэй, сүйрэл авчрагч зүйлийг бид сонсох ёсгүй. Коллеж, их дээд сургуулийн оюутнууд өдөр бүр Бурханы үгэнд эргэлзүүлэх, Бурханы үгийг үгүйсгэх зүйлсийг сонсож байна. Тэнд Бурханы гайхамшгуудыг логикоор тайлбарлаж, Эзэн Есүсийг гутааж, Библийн илэрхий утгуудыг бүрхэгдүүлдэг. Ийм сүйрлийн сургаалуудыг сонсоод нөлөөнд нь автахгүй байх боломжгүй. Тухайн оюутны итгэл сүйрэхгүй ч, оюун санаа нь бохирддог. “Хувцсаа шатаахгүйгээр хүн гал өвөртөлж чадна гэж үү? Хөлөө түлэхгүйгээр хүн халуун нүүрсэн дээгүүр явж чадах уу?” (Сур 6:27,28) Мэдээж “чадахгүй.”

Бохир заваан, уруу татлага төрүүлсэн зүйлийг бид сонсох ёсгүй. Өнөөгийн нийгмийн хамгийн аймшигт бохирдол бол оюун санааны бохирдол юм. Ихэнх сонин, сэтгүүл, ном, радио, телевиз, кино, хүмүүсийн яриа бохир заваан үгээр дүүрчээ. Христитгэгчид үүн дотор байнга байхаар нүглийг нүгэл гэж олж харах мэдрэмжээ гээдэг. Ганц тэр ч биш, тэр бүх бодлууд толгойд байнга эргэлдэж,

хамгийн ариун мөчүүдэд маань ч бидний тархинд оршсоор байдаг.

Бид оюун санаагаа утгагүй хоосон зүйлээр дүүргэх ёсгүй. Амьдрал дэндүү богино, харин Эзэний ажил дэндүү яаралтай. "Ийм ертөнцөд хүн бүр ажилч хичээнгүй байх ёстой."

Эсрэгээрээ, бид Бурханы үгийг чих тавин сонсох ёстой. Бид Бурханы үгээр бодол санаагаа дүүргэж, ариун тушаалуудыг нь сахиж, Бурханы тухай бодох тусам Христтэй улам адил төстэй болж, эргэн тойрныхоо бузар муухайгаас тусгаарлагдаж чадна.

### 3 сарын 14

*“Иймд та нар сонссон зүйлээ нягтлагтун.”* (Лк 8:18)

Христигэлийн амьдралд, юу сонсохоос гадна, яаж сонсох нь чухал байдаг.

Бурханы үгийг сонсохдоо хайхрамжгүй хандлага гаргаж болно. Библийг уншихдаа, жирийн ном уншиж байгаа юм шиг, Төгс Хүчит Бурхан бидэнд ярьж буйг үл тоосон янзаар унших боломжтой.

Сонсохдоо шүүмжилсэн хандлага гаргаж болно. Нэг ёсондоо хүний оюун ухааныг Библиэс дээгүүр тавина гэсэн үг. Библиэр өөрийгөө шүүж суухын оронд Библийг шүүж суухыг хэлж байна.

Сонсохдоо тэрслүү хандлага гаргаж болно. Дагалдагч хүнд тавигддаг хатуу шаардлагыг сонсохоороо, эсвэл эмэгтэй хүн захирагдах ёстой, толгойдоо алчуур зүүх хэрэгтэй гэх мэт үгэнд уурлаж, тэдгээрийг дуулгавартай дагахаас татгалзаж магадгүй.

Иаков номд хэлсэн мартамхай сонсогчид байж болно: “Учир нь сонсоод эс үйлдэгч нь төрөлх царайгаа толинд харж байгаа бөгөөд тэрээр өөрийгөө хараад, эргэхдээ ямар байснаа даруй мартдаг хүнтэй адил юм.” (Иак 1:23,24)

Магадгүй хамгийн түгээмэл хандлага бол дөжирсөн сонсогчдын анги юм. Ийм хүмүүс Бурханы үгийг маш их сонссон тул мэдрэмжгүй болжээ. Тэд номлолыг механик байдлаар сонсдог. Тэдний хувьд энэ нь нэгэн хэвийн уйтгартай хэвшил болсон байдаг. Тэд “Бид бүгдийг нь сонсчихсон шүү дээ” гэсэн хандлагатай.

Сонссоноо хэрэгжүүлдэггүй хүний чих Бурханы үгийг сонсох тусам дүлийрч эхэлдэг. Сонсохоос татгалзвал сонсох чадвараа алддаг. Энэ нь Бурханы шүүлт юм.

Сонсох хамгийн сайн арга бол хүндэтгэлтэйгээр, дуулгавартайгаар, нухацтайгаар сонсох юм. Библийг сонсохоосоо өмнө, бусад хүн хэрэгжүүлэхгүй байсан ч би хэрэгжүүлнэ гэсэн хандлагыг өвөртлөх хэрэгтэй. Ухаантай хүн гэж сонсохоос гадна хэрэгжүүлдэг хүнийг хэлдэг. Бурхан үгэнд нь чичирдэг хүмүүсийг хайж байна (Иса 66:2).

Паул тесалоникчуудыг магтсан. Учир нь тэд Бурханы үгийг сонсохдоо “хүний үг бус, харин Бурханы үнэн үг гэж хүлээн авсан.” (1Тс 2:13). Үүн шиг, бид ч мөн сонсож буй хандлагаа анхаарах ёстой.

### 3 сарын 15

*“Хэн амиа аврахыг хүснэ, тэр түүнийгээ алдана. Харин хэн Миний төлөө амиа алдана, тэр түүнийгээ аварна.”*  
(Лк 9:24)

Итгэгч бидэнд амьдралд хандах хоёр үндсэн хандлага байдаг. Нэг нь амьдралаа аврах гэсэн хандлага, нөгөө нь Христийн төлөө амьдралаа зориудаар өргөх хандлага.

Төрөлх араншин маань амьдралаа аврахыг хичээнэ. Ийм хандлагатай үед өөртөө төвлөрөн амьдрах ба төвөг бэрхшээл, тав тухгүй байдлаас зайлсхийнэ. Ингэхдээ доргилтын эсрэг зөөлөвч дэвсэх, хохирлоос урьдчилан сэргийлэх гэх мэтийг хийж алив таагүй байдлаас зугтдаг. Байшиндаа “Нэвтэрч үл болно” гэсэн тэмдэг тавьдаг. Байшин маань зөвхөн манай гэр бүлд зориулагдсан гэж үздэг болохоор бусдад зочломтгой хандана гэж үгүй. Шийдвэр гаргахдаа, бидэнд ямар үр дагавартай вэ гэдгийг хамгийн түрүүнд боддог. Хэрэв төлөвлөгөөнд маань саад болж, их хэмжээний цаг зав, мөнгө санхүү орохоор харагдвал хүмүүст туслахаас шууд татгалзана. Эрүүл мэнд маань чухал учраас нойргүй хонох, халдвар авах эрсдэлтэй бол өвчтөн дээр очихгүй. Эргэн тойрныхоо хүмүүсийн хэрэгцээнээс илүү өөрсдийн гадаад өнгө зүсэнд ач холбогдол өгдөг. Товчхондоо гэвэл, хэдхэн жилийн настай, үхэхээрээ өт хорхойд идүүлэх энэ биеэ тордохын төлөө бид амьдардаг.

Амиа аврах гэж оролдсон нь амиа алддаг байна. Учир нь тэр хүн амин хувиа хичээж явсны бүх зовлон зүдүүрийг туулж, бусдын төлөө амьдрахын хамаг сайхан ерөөлийг үл амсана.



Гэвч өөр сонголт бий. Энэ нь Христийн төлөө амиа алдах явдал юм. Энэ бол үйлчлэл ба золиостой амьдрал. Бид шаардлагагүй эрсдэлийг гаргаж, дэмий юманд амиа үрж болохгүй ч гэлээ, Христийн төлөө ямар ч золиос гаргахад бэлэн байх ёстой. Нэгэн магтан дуунд шүлэглэсэнчлэн “Сэтгэл ба биеэ Бурханы мутарт өг. Бурхан тэднийг чинь анжис болгоод хатуу хөрсийг хагалаг.” Бурханы төлөө энэ бие минь ашиглагдах хийгээд Бурханы төлөө эд хөрөнгөө зарцуулахаас илүү агуу баяр хөөр гэж үгүй. Хэрэгцээ бүхий хүмүүсийн төлөө бид гэрийнхээ үүдийг нээж, эд хөрөнгө зарцуулж, цаг заваа зориулах ёстой.

Ингэж, Христийн болон бусдын төлөө амь амьдралаа өргөвөл үнэхээр амиа олж авах юм. Амьдралаа алдаж байгаа мэт боловч үнэндээ аварч байдаг.

### 3 сарын 16

*“Би та нарт хэлье. Хэнд байна, түүнд илүү ихээр өгөгдөнө. Харин хэнд байхгүй байна, түүнд байгаа нь хүртэл түүнээс хураагдана.” (Лк 19:26)*

Энэ эшлэлийн эхэнд хэлэгдсэн “байна” гэдэг үг нь ямар нэг юмтай байх гэдгээс өргөн утгатай. Энэ нь сурснаа хэрэгжүүлэх, авснаа ашиглах гэсэн утгыг илэрхийлдэг. Өөрөөр хэлбэл, бидэнд эд юм байх төдийхнийг яриагүй, харин байгаагаа үйлдэл болгохыг ярьж байна.

Библи судлалд маань энэ нь нэг том зарчмыг өгнө. Хүлээн авсан гэрлээ дагах үед Бурхан илүү тод гэрлийг тусгадаг. Бусад хүн хэрэгжүүлэхгүй байсан ч, Библид хэлснийг хэрэгжүүлэхээр шийдсэн хүн л христэч амьдралд ахиц дэвшилтэй явдаг. Энэ нь оюуны чадамжийн асуудал биш. Харин дуулгавартай эсэх асуудал юм. Бурханы үг нь дуулгавартай хүний сэтгэл зүрхэнд үнэт эрдэнэсээ дэлгэдэг. “Тиймээс таньж мэдэцгээе. ЭЗЭНийг мэдэхийн тулд шамдацгаая.” (Хос 6:3) Заалгаснаа хэрэгжүүлэх тусам Эзэн бидэнд илүү ихийг илчилдэг. Мэдээлэл дээр хэрэгжүүлэлтийг нэмбэл үржиж олширдог. Хэрэгжүүлэлтгүй мэдээлэл нь хүнийг нэг түвшинд гацаадаг.

Энэ зарчим нь бэлгүүд болон талантуудаа ашиглахад ч хамаатай. Авснаа арван талант болгож үржүүлсэн хүн арван хотыг захирах эрхтэй болсон. Авснаа таван талант болгож үржүүлсэн хүн таван хотыг захирах эрх авсан (Мт 25:16-19).

Тэгэхээр одоо байгаа үүрэг хариуцлагаа зөв зохистой ашиглаваас түүнээс илүү боломж бололцоо, үүрэг

хариуцлага өгөгддөг байна. Авсан талантаараа юу ч хийгээгүй хүн түүнийгээ алдсан. Байгаагаа Эзэний төлөө зарцуулахаас татгалздаг хүн эцэст нь тэр боломжийг алддаг. “Үл ашиглавал алдах болно.”

Биеийнхээ аль нэг хэсгийг ашиглахгүй байхаар яваандаа суларч, бүр сүүлдээ үхэждэг. Байнга ашиглаж байж биеийн эрхтнүүд хэвийн өсөлт хөгжилттэй байдгийг бид мэднэ. Сүнслэг амьдрал ч үүнтэй ижил. Хэрэв бид Бурханы өгсөн бэлгийг ашиглахгүй бол Бурхан биднийг агуулахад далд хийж, бидний оронд өөр хүнийг ашиглаж эхэлнэ.

Тиймээс Библийн сургаалыг даган мөрдөж, амлалтуудыг нь нэхэж, Бурханы өгсөн чадваруудыг ашиглаж байх нь нэн чухал ажгуу.

### 3 сарын 17

*“Ухаангүй адуу, луус шиг бүү бай.” (Дуу 32:9)*

Морь ба луус нь Эзэний зааврыг эрэлхийлэхэд гаргадаг хоёр буруу хандлагыг харуулж байх шиг надад санагддаг. Морь юу юугүй урагшаа зүтгэдэг. Луус харин хөдлөхдөө хөшүүн хойрго. Морь нь тэвчээргүй, тавтиргүй, адгуу хандлагыг, луус нь хөдөлдөггүй, хөшүүн, залхуу, хойрго хандлагыг илэрхийлж байх шиг. Энэ хоёр амьтны алинд нь ч ухаан байхгүй гэж дууллыг бичигч хэлж байна. Эднийг хазаар ногтоор оосорлохоос нааш эзэндээ ойртохгүй гэжээ.

Өөрсдийн мэргэн ухаанд дулдуйдан ухаан жолоогүй урагш тэмүүлэх нь Бурханы хүсэл биш. Нөгөө талд, Бурхан хүслээ харуулсаар байхад хойш суух нь ч Бурханы хүсэл биш ээ. Гагцхүү Бурханы заавар чиглүүлэг удирдамжид мэдрэмжтэй хандах нь Бурханы хүсэл юм.

Энэ тал дээр тус болохуйц хэдэн дүрмийг танилцуулья. Үүнд:

Удирдамж чиглүүлгээ хоёр ба гурван гэрчийн амаар баталж өгөхийг Бурханаас гуй. Учир нь “Хоёр юм уу гурван гэрчийн амаар хэрэг нь бүрэн нотлогдох болно” (Мт 18:16) гэж бичигдсэн байдаг. Эдгээр гэрч нь Библийн эшлэл, бусад итгэгчдийн зөвлөгөө, нөхцөл байдлын тохироо байж болно. Бурханы хүслийг харуулсан хоёр ба гурван баталгааг харвал эргэлзэж тээнэгэлзэх хэрэггүй.

Бурханы удирдамж зааврыг эрэлхийлэвч ямар нэг тэмдэг дохио ирэхгүй бол одоо байгаа газартаа байх нь Бурханы удирдамж гэдгийг ойлго. “Явах нь харанхуй гэвэл, байрандаа үлдэх нь гэрэл мөн” гэж хэлдэг шүү дээ.

Тухайн заавар удирдамжийг дагахгүй байх нь дуулгаваргүй байдал гэж харагдах хүртэл хүлээ. Израилийн хөвгүүд үүл ба галан багана хөдлөхөөс нааш байрнаасаа хөдөлдөггүй байсан. Өөрсдийн дураар явж хэзээ ч болохгүй байлаа. Үүл хөдлөхтэй зэрэг хөдөлнө. Түүнээс өмнө ч биш, хойно ч биш.

Эцэст нь хэлэхэд, “Христийн амар тайван зүрхийг чинь захираг” (Кол 3:15). Нэг ёсондоо, Бурхан үнэхээр удирдан чиглүүлж байвал, оюун бодол, сэтгэл санаа маань зөв зүйл хийж байгаага мэдэн амар тайван байх юм. Харин түүний эсрэг зүгт явахад амар амгалангүй болно.

Хэрэв бид Бурханы хүслийг мэдэж, дуулгавартай дагах хүсэлтэй бол Бурханы сахилгажуулалтын хазаар ногтоор угзчуулахгүй.

### 3 сарын 18

*“Хүн бүр өөрийн ашиг сонирхлыг бус, харин бусдын ашиг сонирхлыг хар.” (Флп 2:4)*

Филиппой 2-р бүлгийн түлхүүр үг нь "бусад". Эзэн Есүс бусдын төлөө амьдарсан. Паул бусдын төлөө амьдарсан. Тимот бусдын төлөө амьдарсан. Епафродит бусдын төлөө амьдарсан. Бид ч гэсэн бусдын төлөө амьдрах ёстой.

Зөвхөн зөв учраас биш, харин өөрсдийнхөө тусын тулд үүнийг хийх ёстой гэж бидэнд хэлдэг. Бусдын төлөө амьдрах нь хохирол ихтэй нь үнэн. Гэхдээ амин хувиа хичээх нь бүр ч их хохиролтой.

Нийгэм маань зөвхөн өөрийн ашиг сонирхлын төлөө амьдардаг хүмүүсээр дүүрчээ. Хүмүүс бусдад үйлчлээд завгүй байхын оронд гэртээ ялхайн сууцгаадаг. Тэд бага зэргийн өвчинд хэт их анхаарсаар эцэстээ өвчний хэнээтэн болдог. Ганцаардах үедээ өөрсдийг нь хэн ч тоохгүй байна гэж гомдоллосоор удалгүй өөрсдийгөө өрөвдөж эхэлдэг. Тэд өөрсдийнхөө талаар бодох тусам сэтгэлээр унадаг. Амьдрал нь харанхуй нөмөрсөн аймшиг болж хувирдаг. Удалгүй тэд эмчийн хараат болж, эмийг их хэмжээгээр хэрэглэж эхэлдэг. Ингэлээ гээд хувиа хичээсэн сэтгэл эмчлэгдэхгүй. Дараа нь тэд сэтгэл мэдрэлийн эмчийн буйдан дээр очиж уйтгар гуниг, ядрал залхлаасаа ангижрахыг хичээдэг.

Ийм хүмүүст таарах хамгийн сайн эмчилгээ бол бусдад үйлчлэх амьдрал юм. Очих газрууд өчнөөн байна. Найз нөхдөөр дутсан ахмадууд олон байдаг. Сайн дурынхны тусламжийг дуртайяа хүлээн авдаг эмнэлгүүд ч байдаг.

Ганц захидал хүлээн аваад баярлах хүмүүс олон бий. Нутаг усныхаа сонин сайхан мэдээг сонсохыг хүссэн олон илгээлтийн эзэн байгаа. Аврал хэрэгтэй сүнснүүд, сургагдах ёстой итгэгч нар ч олон байна. Товчхондоо гэвэл, уйтгарлан суухын аргагүй олон ажил биднийг хүлээж байна. Амьдралыг маань үр бүтээлтэй болгож чадах хангалттай олон зүйл бий. Бусдын төлөө амьдарснаар найз нөхдийн маань хүрээ тэлж, амьдрал илүү сонирхолтой болж, сэтгэл ханамжийг олж авна. П. М. Деррамын хэлсэнчлэн, “Бусдыг гэсэн сэтгэлтэй зүрх өөрийн уй гашуунд автахгүй бөгөөд өөрийгөө өрөвдөхүйн хоронд өртөх нь бага байдаг.”

*Бусдын төлөө, Эзэн минь, бусдын төлөө  
Энэ л миний уриа лоозон байгаасай  
Бусдын төлөө амьдрахад минь туслаач  
Ингээж би, Тантайгаа адил амьдрахсан*

### 3 сарын 19

*“Мерозыг хараагтун гэж ЭЗЭНий тэнгэрэлч хэлэв. Хараагтун, тийм ээ, түүний оршин суугчдыг хараагтун. Тэд ЭЗЭНд туслахаар ирсэнгүй. Хүчтэний эсрэг зогсоход ЭЗЭНд туслахаар ирсэнгүй.”* (Шүү 5:23)

Израилийн арми канаанчуудтай тулалдах үед зүгээр харан суусан Мероз дээр Деборагийн дуу хараал дуудаж байна. Реубенчүүд ирсэн боловч элэг доог болохоос хэтрээгүй. Тэд гар бие оролцохыг бодсон ч гэлээ хонин сүргээ орхиогүй. Гилеад, Ашер, Дан нар оролцоогүйнхээ төлөө муу нэр зүүж байна.

“Тамын хамгийн халуун хэсэг нь ёс суртахууны их доройтлын үед төвийг сахисан хүмүүст хадгалагдаж байна” хэмээн Дантэ хэлсэн байдаг.

Үүнтэй ижил санааг Сургаалт үгс номоос бид уншдаг. Үүнд: “Үхэл уруу туугдах хүмүүсийг, алагдах газрынхаа зүг гэлдрэх хүмүүсийг буцааж авчрахаас хойш бүү суу. ‘Харагтун, бид үүнийг мэдээгүй’ гэж чи хэлэх аваас зүрхийг чинь дэнслэгч анхаарахгүй гэж үү? Сэтгэлийг чинь хамгаалагч мэдэхгүй гэж үү? Тэрээр үйлсийнх нь хариуг хүмүүнд өгөхгүй гэж үү?” (Сур 24:11,12) Киднерийн тайлбарыг сонсоно уу: “Зовлон шаналан (10), найдвар тасарсан нөхцөл байдал (11), нүдээ анин өнгөрөх хандлагыг (12) хөлсний ажилчин л зүгээр харан суух байх. Жинхэнэ хоньчин хэзээ ч тэгэхгүй. Хайр ийм амархан дуугаа хураадаггүй. Хайрын Бурхан ч бас.”

Манай улсад антисемитизмийн их давллагаа өрнөсөн бол бид яах байсан бэ? Еврейчүүдийг бөөнөөр нь хорих лагерь, хорт хийн өрөө, шатаах зуух уруу авч явж буйг



харсан бол бид яах байсан бэ? Тэднийг аврахын төлөө амиа эрсдэлд оруулах уу?

Христэч ах дүүс минь хавчигдаж, тэднийг гэртээ оруулах нь хууль зөрчсөн хэрэгт тооцогдвол бид гэртээ оруулах болов уу? Яах бол?

Эсвэл арай хөнгөн, ойрхон жишээ авъя. Та нэгэн христэч байгууллагын захирал байлаа. Тэгтэл өөр нэгэн компанийн захирал, баян чинээлэг, нэр нөлөөтэй хүний бах тавыг хангахын тулд танай нэг итгэмжит ажилтан хилсээр гүтгүүлж байвал та чимээгүй л хараад суух уу?

Есүс иудейчүүдийн зөвлөлийн өмнө зогсож байгааг эсвэл загалмай дээр цовдлогдсон байгааг бодоод үзье. Тэр үед бид чимээгүй байх байсан уу эсвэл Түүний талд зогсох байсан уу?

“Чимээгүй байх нь үргэлж алт биш ээ, заримдаа энэ нь зүгээр л шар өнгө юм.”

### 3 сарын 20

“Аав аа, би...нүгэл үйлдэжээ.” (Лк 15:21)

Үрэлгэн хүү гэмшиж ирсний дараа л аав нь түүний өөдөөс гүйж, хүзүүдэн тэвэрч, үнссэн. Гэмшээгүй байхад нь уучилбал шударга бус явдал болох байлаа. “Хэрэв тэр гэмшвэл, түүнийг уучил” (Лк 17: 3) гэдэг нь Библийн зарчим юм.

Эцэг нь хүүгээ алс хол нутагт байхад нь тусламж илгээгээгүй. Тэгж бичигдээгүй. Хэрэв тусламж илгээсэн бол тэрслүү хүүгийн амьдралд хийж буй Бурханы ажилд саад болох байлаа. Эзэний зорилго нь тэрслүү хүүг буулгаж авах байв. Хүү хэн ч биш гэдгээ ухаарч, тартагтаа тулахаас нааш гэмшихгүйг эцэг нь мэдэж байсан. Хэдий чинээ хурдан шалдаа бууна, төдий чинээ хурдан гэмшинэ. Тиймээс аав нь хүүгээ Эзэнд даатгаад туйлд нь хүрэх цагийг хүлээхээр шийдсэн.

Энэ бол эцэг эхчүүдийн хувьд, ялангуяа ээжүүдийн хувьд хамгийн хүнд даваа болдог. Төрөлх хандлага маань тэрслүү хүүхдэд маань Эзэнээс ирэх зовлон бүрээс хүүхдээ хамгаалахыг оролддог. Ингэх тусам хайрт хүүхдүүдэд маань зориулсан Эзэний зорилгод саад болдог учир, хүүхдүүдийнхээ зовлонг л удаашруулдаг.

“Буруудсан хүмүүсийн бурууг хүлээн зөвшөөрөх нь жинхэнэ хайр биш ээ. Харин бүх зүйл дээр Есүст итгэмжтэй байх нь жинхэнэ хайр юм” гэж Спержон хэлсэн. Хүний бузар мууг өөхшүүлэх нь үнэндээ хайр биш. Хайр хүнийг Эзэн өөд эргүүлдэг бөгөөд “Эзээн, ямар ч үнээр хамаагүй түүнийг авраач” гэж залбирдаг.

Давидын хийсэн хамгийн том алдаа нь Абсаломыг гэмшихээс нь өмнө буцаан авчирсан явдал юм. Удалгүй Абсалом хүмүүсийн зүрх сэтгэлийг эзэмдэж, эцгийнхээ эсрэг бослого гаргаж, эцэст нь эцгээ Иерусалимаас хөөж, оронд нь хаан болсон. Түүгээр ч зогсохгүй эцэг Давидыгаа хөнөөх гэж цэрэг арми хөдөлгөсөн. Гэсэн ч Давид, залуу Абсаломтой таарвал амьд үлдээгээрэй гэж өөрийн хүмүүст зааварласан. Гэвч Иоаб үүнийг дэмий гэж үзээд Абсаломыг хөнөөсөн.

Бурхан хөвгүүд охидыг нь гахай маллах хэмжээнд аваачихыг харж чадахгүй эцэг эхчүүд хүүхдүүдээ бүр ч илүү зовлон уруу түлхдэг.

### 3 сарын 21

*“Үнэндээ хүний уур хилэнгээр ч Та магтагдах болно. Харин уур хилэнгийн үлдэгсдээр Та Өөрийгөө хүрээлүүлнэ.”* (Дуу 76:10)

Бурхан хүний уур хилэнгээр Өөрийгөө магтуулж байсан явдлууд нь хүн төрөлхтний түүхэнд гарсан хамгийн гайхамшигтай тохиолдлууд билээ. Хүн нүгэлд унаснаасаа хойш Бурханы эсрэг, Бурханы хүмүүсийн эсрэг, Бурханы үйл хэргийн эсрэг хилэгнэсээр иржээ. Эзэн эдгээр уур хилэнг газар дээр нь шийтгэхийн оронд Өөрийн алдрын төлөө, хүмүүсийнхээ ерөөлийн төлөө ашигладаг.

Хэсэг бүлэг эрчүүд дүүгийнхээ эсрэг хорон мууг сэдэж, түүнийг Египет уруу явж байсан аянчдад заржээ. Гэтэл Бурхан түүнийг босгож, Египетийн хоёр дахь эрх мэдэлтэн болгоод, түүгээр дамжуулан ард түмнээ аварсан. Иосеф хожим нь, “Та нар намайг хорлох гэсэн боловч Бурхан өнөөдрийнх шиг үй олон хүний амийг аврахын төлөө түүнийг сайнаар эргүүлсэн юм” (Эх 50:20) гэж ах дүү нартаа сануулсан.

Хаман иудейчүүдийн эсрэг хорон явуулга сэдсэн боловч эцэст нь өөрөө сүйрч, устгахыг хүссэн иудейчүүд нь өргөмжлөгдсөн.

Гурван еврей залуу галт зууханд хаягдав. Гал дэндүү илчтэй байсан учраас тэр гурвыг зуух уруу шидэх гэж байсан хүмүүс хүртэл шатаж үхжээ. Гэвч еврей залууст ямар ч гэмтэл учраагүйн дээр, тэднээс хэншүү ч үнэртэхгүй байлаа. Харь үндэстний хаан, еврейчүүдийн Бурханы эсрэг үг унагасан хүнийг цаазаар авна гэж зарлиг буулгав.

Даниелыг тэнгэрийн Бурханд залбирсан гэж авслангийн нүхэнд хаясан боловч гайхамшигтайгаар аврагдсан учир шүтээн шүтлэгт улсын эзэн хаан нь Даниелын Бурханыг хүндэтгэж байх зарлигийг гаргасан.

Шинэ гэрээний эрин үе ирэхэд, чуулганыг хавчсан хавчлага сайнмэдээг илүү өргөн хүрээнд түгээх боломж болсон. Стефан амь насаа алдахдаа Саулын дотор үр суулгасан. Паул шоронд орсноор Ариун Библид багтсан дөрвөн захидал бичигдсэн.

Ян Гусын чандар голд хаягдсан бөгөөд уг голын урсгал хүрсэн газар бүхэнд сайнмэдээ тархсан.

Хүмүүс Библийг хэдэн хэсэг тастаж салхинд хийсгэхэд түүний нэг хэсгийг олж уншсан хүн аврагдсан. Хүмүүс Христийн хоёр дахь ирэлтийг шоолдог ба үүгээрээ эцсийн өдрүүдэд элэглэн доромжлогчид гарч ирнэ гэсэн зөгнөлийг биелүүлдэг.

Тиймээс Бурхан хүний уур хилэнгээр Өөрийгөө магтуулдаг. Бүх нөхцөл байдал Түүний мутарт байдаг.

### 3 сарын 22

*“Миний нэр алдарт өргөө барих сэтгэл чиний зүрхэнд байгаа нь маш сайн байна.” (1Ха 8:18)*

Давидын хамгийн том нэг хүсэл нь Иеховад зориулан Иерусалимд өргөө барих явдал байв. Давид дайн тулааны хүн учраас өргөө барихыг Эзэн зөвшөөрөөгүй. Гэхдээ “Чиний зүрхэнд ийм хүсэл байгаа нь сайн” гэж сайшаажээ. Бид Эзэний төлөө гэсэн хүслээ үйлдэл болгож чадахгүй үед Бурхан тэр хүслийг хэрэгжсэнд тооцдогийг эндээс харж болно.

Хүслээ үйлдэл болгож чадахгүй нь хойрго залхуу, идэвхгүй зангаас минь болж байвал энэ хамаагүй. Ийм нөхцөлд зөвхөн хүсэх хангалтгүй. Өмнө дурдсанчлан, тамын гудамжнуудад сайн санал санаачилгын хавтангаар зассан зам байдаг гэсэн үг хүртэл бий шүү.

Заримдаа Эзэнийг баярлуулахын тулд ямар нэг зүйл хийхийг хүсэвч бидний удирдаж чадахгүй нөхцөл байдлын улмаас хийж болохгүй тохиолдол олон байдаг. Жишээлбэл, залуу хүү Христэд итгээд баптисм хүртэхийг хүсэвч үл итгэгч эцэг эх нь хориглосон тул баптисм хүртэж чадахгүй байж болно. Энэ тохиолдолд Бурхан, хүүг эрийн цээнд хүрч, гэрээсээ явах хүртэл баптисм хүртсэнд тооцно.

Христэч эмэгтэй нутгийн чуулганыхаа бүх цуглаанд оролцохыг хүсэвч архичин нөхрийн шаардлагаас болоод цуглаандаа очиж чадахгүй байж болно. Эзэн, нөхөртөө захирагддаг дуулгавартай байдлыг болон Эзэний нэр дээр итгэгч ахан дүүстэйгээ уулзах гэсэн хүслийг аль алийг нь шагнана.

Библийн холбоотой уулзалт, цугларалтын үеэр хоолны үйлчлэл хийж буй хүмүүсийг хараад нэгэн настай эмэгтэй уйлж суулаа. Тэр өөрөө үүнийг олон жил баяр хөөртэйгөөр хийсэн боловч одоо биеийн байдлаас болоод чадахгүй болжээ. Бурхан ийм үйлчлэл хийгчдийг шагнахдаа түүний нулимсыг ч бас мартахгүй.

Илгээлтийн талбарт сайн дураараа үйлчилдэг хүмүүсийн хэд нь төрөлх хотоосоо гарч чадахгүй явааг хэн мэдэх вэ? Бурхан л мэднэ. Тэгээд ч болоогүй, энэ бүх ариун хүсэл эрмэлзэл Христийн шүүх суудлын өмнө шагналаа авна.

Энэ зарчим өгөх асуудалд бас хамаарна. Эзэний ажилд золиос гарган өгч байж дахиад нэмээд өгч чаддаг ч болоосой хэмээн хүсдэг хүмүүс бий. Хожмын өдөр тэнгэрийн тооцооны дэвтрийг үзвэл тэд нэмж өгсөн гэж харагдана.

Өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй, гэрээсээ гарч чаддаггүй, хөгшин настай хүмүүс тэргүүн хүндлэлийг хүртэх боломжоос орхигдоогүй билээ. Яагаад гэвэл Бурхан нигүүлслээрээ биднийг олсон амжилтаар минь зөвхөн шүүхгүй. Бас мөрөөдөл хүслээр минь шүүх болно.

### 3 сарын 23

*“Би төлөөс төлбөргүй зүйлээр Бурхан ЭЗЭНд шатаалт тахил өргөхгүй.” (2См 24:24)*

Эзэн тахлыг зогсоосон газарт шатаалт тахил өргө гэж Давидад зааварлахад Аруна үтрэм, үхэр, гал өрдөх мод бэлэглэхийг хүсжээ. Гэвч Давид энэ бүхний үнийг төлнө гэв. Учир нь өөрөөс нь үнэ төлөгдөөгүй зүйлээр Эзэнд тахил өргөхийг Давид хүссэнгүй.

Христитгэгч болохын тулд ямар нэг үнэ төлдөггүйг бид мэднэ. Гэвч жинхэнэ дагалдагч болохын тулд асар их золиос гаргадгийг мэдэх хэрэгтэй. “Золиосгүй итгэл үнэ цэнэгүй.”

Бид олон удаа өөрсдийн тав тух, нөхцөл боломж, өртөг зардлыг тооцож байж зориулалт гаргадаг. Хэрэв ядраагүй, толгой өвдөөгүй бол залбирлын цуглаанд явна. Хагас бүтэн сайны уулын аяллын цагтай давхцахгүй бол Библийн хичээлд багшила.

Хүмүүсийн өмнө залбирах, гэрчлэх, сайнмэдээг номлох нь эвгүй учраас бид чимээгүй байдаг. Бөөс хуурстай зууралдахаас айсандаа өнчин ядууст тусалдаггүй. Могой, аалзнаас айгаад илгээлтийн талбар уруу орохоос зүрхшээдэг.

Бидний өргөл нь ихэнх тохиолдолд золиос бус, гар цайлгах мөнгөтэй болжээ. Бэлэвсэн эмэгтэй байгаа бүхнээ өгсөн. Харин бид илүүгээ өгдөг. Нэгэн хүн архичдыг аврахын төлөө тэднийг гэртээ оруулж, бөөлжсийг нь хамаг дэвсгэр давуугаараа цэвэрлэдэг байж. Харин бидний зочломтгой занд зардал, тав тух, гэр орны эмх цэгц маш том хүчин зүйл болдог. Нэгэн пастор хэрэгцээтэй хүнд нь



сүнслэг болон материаллаг тусламж үзүүлэхийн тулд хэдэн цагт ч байсан босдог байлаа. Харин бидний сайхан сэтгэл орондоо орсон хойно бүрэн унтардаг.

Христ биднийг дуудахад ихэнхдээ бид “Надад ямар ашигтай вэ?” “Энэ нь цалинтай ажил уу?” гэж өөрсдөөсөө асуудаг. Уг нь бол “Энэ ажлыг хийхэд надаас золиос гарах уу?” гэж асуух ёстой юм. “Сүнслэг амьдралд танд цалин өгдөг нь бус, танаас золиос гардаг нь илүү дээр” гэж үнэн үг юм шүү.

Авралын ажлыг гүйцэлдүүлэхийн тулд Аврагч маань ямар үнэ төлснийг бод доо. Тэгвэл Түүний төлөө золиос гаргахаас зайлсхийх нь хэчнээн ачлалгүй хэрэг вэ!

### 3 сарын 24

*“Христийн бэлгийн хэмжээгээр бидний хүн нэг бүрд нигүүлсэл өгөгдсөн.” (Еф 4:7)*

Эзэн бидэнд ямар нэг юм хий гэж хэлсэн бол шаардлагатай хүчийг хамт өгдөг гэдгийг үргэлж санаарай. Тэр бидэнд тушаасан бол, хийх хүч боломжийг нь бас өгсөн гэсэн үг. Нөхцөл байдал боломжгүй байсан ч Тэр биднээр хийлгэх чадалтай.

Иетро Мосед, “Хэрэв чи ийнхүү хийвэл мөн Бурхан чамд тушаавал чи зогсох чадвартай байх болно” (Гэт 18:23) гэж хэлсэн. “Бурхан Өөрийн хүнд даалгавар өгсөн бол түүнийг хийх хүч боломжоор хангах нь Бурханы үүрэг юм.” (Ж. О. Сандерс).

Эзэн Есүс үйлчлэлийнхээ үеэр доод тал нь хоёр удаа саа өвчтэй хүнтэй уулзсан (Мт 9:6, Иох 5:9). Хоёр тохиолдолд хоёуланд нь Эзэн Есүс тэдэнд “босоод дэвсгэрээ аваад яв” гэж тушаасан. Тэд дуулгавартай дагах мөчид хүч тамиргүй хөл гар нь хүч тэнхээтэй болсон юм.

Хэрэв Эзэн Есүс дуудвал усан дээр алхаж чадна гэдгийг Петр мэдэж байсан. Тиймээс Есүс “Нааш ир” гэж хэлсэн даруйд Петр завинаас бууж, усан дээр алхсан.

Хатангир гартай эрийн хувьд гараа сунгаж чадна гэдэг эргэлзээтэй асуудал байлаа. Харин Эзэн түүнийг гараа сунга гэхэд тэр ч сунгасан, гар нь ч эдгэрсэн.

Таван мянган хүнийг хэдхэн талх загасаар хооллох нь мэдээж боломжгүй хэрэг. Харин Есүс шавь нартаа “Тэдэнд идэх юм өг” гэж хэлэхэд боломжгүй байдал ор мөргүй арилсан.

Есүс “Лазар аа, гараад ир” гэж тушаах үед Лазар булшинд дөрөв хоночихсон байлаа. Тэрхүү тушаал хэрэгтэй хүчийг бий болгосон бөгөөд Лазар ч булшнаасаа гарч ирсэн.

Бид энэ үнэнийг баримтлах ёстой. Бурхан биднийг удирдвал “Хийж чадахгүй” гэдэг үг битгий хэлээрэй. Бурхан хий гэж хэлсэн бол хүч чадлыг ч бас өгөх болно. “Бурханы нигүүлсэл хамт байхгүй газар уруу Бурханы хүсэл чамайг хэзээ ч чиглүүлэхгүй” гэж хэлсэн нь үнэн юм.

Мөн Бурхан ямар нэг зүйл захиалбал үнийг нь заавал төлдөг. Хэрэв Тэр үнэхээр таныг чиглүүлж байвал санхүүгийн хэрэгцээнд бүү санаа зов. Тэр хангах болно.

Улаан тэнгис болон Иордан голыг хувааж, ард түмнээ дундуур нь алхуулсан Бурхан өнөөдөр ч хэвээрээ. Ард түмэн нь хүслийг нь дуулгавартай дагах үед боломжгүйг боломжтой болгодог Бурхан одоо ч өөрчлөгдөөгүй. Өөрийнх нь тушаасныг биелүүлж байгаа хүнд хэрэгтэй бүх нигүүлслийг өгдөг Бурхан хувираагүй. Тэрээр Өөрийнх нь сайн тааллыг хүсдэг бас үйлддэг болгохын тулд бидний дотор ажилласаар байна.

### 3 сарын 25

“Эхэнд Бурхан...” (Эх 1:1)

Эхлэл 1:1-ийн эхний хоёр үгийг эшлэлийн бусад хэсгээс салгаж авахад амьдралын уриа үг гарч ирж байна. “Бурхан эхэнд байна” гэсэн утга харагддаг.

Энэхүү урианы санаа “Чи Надаас өөр бурхадтай Миний өмнө байж болохгүй” гэсэн нэгдүгээр тушаалаас цухалздаг. Үнэн бөгөөд амьд Бурханы урдуур хэн ч, юу ч байж болохгүй.

Елиа болон бэлэвсэн эмэгтэйн түүх үүнийг бидэнд сургадаг. Тэр эмэгтэй болон түүний хүүд ганц удаа бин хайрах гурил, тос үлдсэн бөгөөд түүнээс хойш идэх юмгүй болох байлаа (1Ха 17:12). Хачирхалтай нь Елиа, “Эхлээд надад жижигхэн бин хий” гэж хэлэв. Энэ нь хувиа хичээсэн үйлдэл шиг харагдаж болох юм. Гэвч тийм биш. Елиа Бурханы төлөөлөгч байсан. Тиймээс Елиагийн үг нь “Бурханыг нэгт тавь. Амьдралын чинь хэрэгцээ хангагдах болно” гэсэн утгатай.

Хэдэн зууны дараа Эзэн Есүс уулан дээр үүнтэй ижил санааг номлож, “Эхлээд Бурханы хаанчлал ба зөвт байдлыг хайгтун” (Мт 6:33) гэж хэлсэн. Амьдралын нэн тэргүүний зүйл бол Бурханы хаанчлал ба зөвт байдал ажгуу.

Лук 14:26 дээр Аврагч маань дахин энэ санаагаа давтсан. “Хэрэв хэн нэг нь Над дээр ирж, өөрийн эцэг эх, эхнэр хүүхэд, ах эгч дүүсээ төдийгүй өөрийн амийг хүртэл үл ойшоохгүй бол тэр Миний шавь байж чадахгүй.” Христ нэгдүгээрт байх ёстой.

Тэгвэл Бурханыг хэрхэн нэгт тавих вэ? Санаа тавих ёстой гэр бүл бидэнд бий. Бодох ёстой ажил алба бий. Цаг хугацаа, нөөц бололцоогоо зориулах ёстой олон үүргийг бид хүлээдэг. Бурханыг яаж хамгийн түрүүнд тавих вэ гэвэл, бусад хайр маань хажууд нь харьцуулагдашгүй тийм л хайраар Бурханыг хайрла. Материаллаг зүйлсийг Бурханаас даатгасан зүйл гэж үзэн, Бурханы хаанчлалтай холбоотой зүйлд л зарцуул. Мөнхийн үр дагавартай юмсыг тэргүүнд тавь. Заримдаа сайн юмс шилдгийн дайсан байдгийг сана.

Ингэж бид Бурханыг нэгт тавих бөгөөд ингэснээр бидний ашиг сонирхол Бурханыхтай уялдана. Бурхан нэгт байгаа үед бидний харилцаа зөв байрандаа ордог. Хүн Бурханыг нэн түрүүнд тавихад зарим нэг асуудал гарч ирэх боловч амьдралын дүүргэлтийг олох болно. Харин Бурханыг хоёрт тавивал зөвхөн асуудал, зовлон шаналлаас өөр зүйл үлдэхгүй.

### 3 сарын 26

*“Чамд ямар хамаа байна? Чи Намайг дага.” (Иох 21:22)*

Эзэн Есүс Петрийг насан өндөр болоод итгэлийнхээ төлөө амиа алдана гэж хэлсэн. Тэгэхэд Петр, Иохан уруу заагаад, “Энэ хүн яах вэ?” гэж асуусан. Эзэн түүнд “Чамд ямар хамаа байна? Чи Намайг дага” гэж хариулав.

Петрийн хандлага нь Даг Хаммархёлдын үгийг санагдуулдаг: “Танд зөвшөөрөгдөөгүй зүйл бусдад зөвшөөрөгдсөнийг харахаар уур хүрэх нь амархан. Үгүй дээ л, хэдэн өдөр таныг нойргүй хонуулдаг. Таны нөхцөл байдал хэцүүхэн байхад бусад хүн сайн сайхан явахыг харахаар үхмээр санагдтал хорсол төрдөг.”

Хэрэв бид Эзэний үгсийг зүрхэндээ авбал христэд хүмүүсийн дундах олон асуудал шийдэгдэхсэн.

Бусад хүн биднээс илүү гарахыг харахаар өөрийн эрхгүй атаархал төрдөг. Эзэн тэдэнд шинэ байр, шинэ машин, нуурын хажууд зуслангийн байшин өгдөг.

Бид өвчинд шаналж суухад Бурханд өөрсдийгөө бага зориулдаг хүмүүс эрүүл саруул амьдардаг.

Бусдын хөөрхөн хүүхдүүд сурлага спортын амжилт гаргадаг. Харин манай хүүхдүүд онцлох юмгүй.

Бид өөрсдийгөө хазаарладаг зүйлсийг бусад итгэгч чөлөөтэй хийдэг. Тэдний хийж байгаа нь нүгэл биш ч гэлээ, тийм эрх чөлөөтэй байгаа нь л өөрөө нүдний хор төрүүлдэг.

Хэлэхэд гунигтай ч гэлээ, номлогч үйлчлэгчдийн дунд хүртэл атаархал явагддаг. Нэг номлогч нь илүү алдартай, илүү олон танилтай, илүү олны хүндэтгэл хүлээх үед нөгөө номлогч нь гомддог. Нэг нь өөр арга хэрэглэхээр нөгөө нь унтууцдаг.

Энэ бүх утга учиргүй хандлагыг Эзэн шүүмжилж байна. “Бусдын хэрэг чамд ямар хамаа байна. Чи намайг дага” гэж айлдаж байна. Эзэн бусад итгэгчид яаж хандах нь бидний хэрэг биш. Бидний үүрэг болбоос, Эзэний бэлдсэн замаар Эзэнийг дагах билээ.

### 3 сарын 27

*“Салхи дуртай газраараа үлээдэг.” (Иох 3:8)*

Бурханы Сүнс бол дээдийн дээд эрх мэдэл. Тэр хүссэнээрээ хөдөлдөг. Бид Түүнийг тодорхой нэг хэвд нь оруулах гэж оролдовч хэзээ ч бүтдэггүй.

Ариун Сүнсийг ихэвчлэн салхи, гал, тос, ус гэсэн хэлбэргүй зүйлсээр илэрхийлдэг. Эдгээрийг атгах гэвэл “Биднийг хаших хэрэггүй” гэж хэлэх мэт нэг хэвд үл орно.

Ариун Сүнс ёс суртахууны хувьд буруу зүйл хэзээ ч хийхгүй. Бусдаар бол Түүний арга зам нэг хэвийн, цутгамал, баригдмал байдаггүй. Жишээ хэлье. Бурхан эр хүнийг тэргүүн болгосон нь үнэн боловч Бурханы хүмүүсийг удирдуулахаар Дебораг Ариун Сүнс босгосон.

Ёс суртахууны доройтлын өдрүүдэд, ерийн тохиолдолд хориглодог зүйлсийг Ариун Сүнс зөвшөөрч, зөвхөн тахилчид идэх ёстой тавиг талхыг Давид нөхөдтэйгөө хамт идсэн. Амралтын өдөр үр тариа шувтарч идсэн шавь нар энэ жишээгээр зөвтгөгдсөн.

Хүмүүс Үйлс номын үйл явдалд тодорхой нэг дараалал, загвар байна гэж хэлдэг. Гэвч би тэднээс Ариун Сүнсний бүрэн эрхт үйлсээс өөр ямар ч загвар олж хардаггүй.

Элч нар тэргүүтэй хүмүүс сурах бичиг дагаагүй. Тэд Ариун Сүнсний чиглүүлгийг дагасан ба энэ нь ихэнхдээ энгийн ухаалаг төсөөллөөс эрс өөр байсан.

Жишээлбэл, Газ хүрэх зам дээр Етиопын тайган амбанд ганцаарханд нь сайнмэдээ тунхаглуулахын тулд Ариун Сүнс эхлээд Филиппийг Самари уруу удирдаж, тэнд сэргэлт авчирсан.



Тэгэхээр Ариун Сүнс энийг чадна, энийг чадахгүй гэж хатуу итгэл үнэмшилтэй байхаас зайлсхийх хэрэгтэй. Тэр хэзээ ч нүгэлт зүйл хийхгүй. Харин бусад талаар Тэр юуг ч хийх боломжтой. Ариун Сүнс тодорхой нэг аргад баригддаггүй. Бидний уламжлалт арга замаар хязгаарлагддаггүй. Тэрбээр дэг жаяг, ёслол, баригдмал хэлбэр, үхмэл байдлын эсрэг сэргэлтийн хүчээр шинэ хөдөлгөөн өрнүүлдэг. Тиймээс бид Ариун Сүнсний эрх мэдэлт ажилд нээлттэй байж, уг ажлыг шүүмжлэлгүй, харин гар бие оролцох хэрэгтэй.

### 3 сарын 28

*“Тэр үзэн ядалт нь түүнийг хайрлаж байсан хайраас нь ч илүү хүчтэй байлаа.” (2См 13:15)*

Амнон эх өөр, эцэг нэгтэй дүү Тамарт шунаан тачааджээ. Тамар нь үзэсгэлэнт бүсгүй байсан тул түүнийг эзэмдэхээр шийдэв. Энэ үйлдэл Бурханы хуулиар хориотойг мэдэж байсан тул тэр бухимдав. Гэхдээ хүсэл тачаалдаа автсан түүнд бусад юмыг бодох сөхөө байсангүй. Тэгээд өвдсөн мэт дүр эсгээд, Тамарыг өрөөндөө оруулан хүчирхийлэв. Хүсэл тачаал шатаж байх үед Амнон бүхнээ золиослоход бэлэн байлаа.

Гэвч дараа нь хүсэл тачаал үзэн ядалт болж хувирав. Амнон дүүгээ бузар хүсэлдээ ашиглачхаад гутаан доромжилж, түүнийг хэзээ ч хараагүй байсан болоосой гэж хүсэв. Тиймээс түүнийг өрөөнөөсөө хүчээр гаргаад хаалгаа дотроос нь түгжлээ.

Энэ гутамшигт түүх өнөөдөр өдөр бүр давтагдаж байна. Чөлөөт амьдралыг хөхүүлэн дэмжигч нийгэмд маань ёс суртахууны хэм хэмжээ үндсэндээ орхигджээ. Нийгэм маань гэрлэлтийн өмнөх бэлгийн харьцааг хэвийн гэж үздэг. Хосууд албан ёсоор гэрлэхгүйгээр хамт амьдардаг. Биеэ үнэлэх явдлыг хуульчилж өгдөг. Ижил хүйстний харилцааг амьдралын өөр нэг хэв маяг хэмээн хүлээн зөвшөөрдөг.

Хөгшин залуу бүгдээрээ таалагдсан л бол уулзана. Дээрээ захирагдах хууль гэж тэдэнд үгүй. Цадиг жудаг гэж ч байхгүй. Хүссэн зүйлээ авах нь тэдний зорилго. Тэд зөв бурууг ялгаж салгах сонирхолгүй. Зөв бурууг ялгаж салгавал хэвийн сайхан амьдарч болохгүй гэж үздэг.

Тиймээс тэд Амноны адил үйлдэл гаргадаг. Энийг л хийчихвэл аз жаргалыг олно гэж эндүүрдэг.

Эхэндээ сайхан байсан зүйл дараа нь ой гутам санагдана. Хэчнээн их няцаасан ч буруутгал огт салахгүй. Өөрийгөө ч, нөгөө хүнээ ч хүндлэхгүй харилцаа эргээд сэтгэл дундуур байдлыг төрүүлдэг. Үр дүнд нь хэрүүл маргаан, үзэн ядалт үүсдэг. Нэгэн цагт зайлшгүй хэрэгтэй санагдаж байсан хүн одоо зэвүү хүргэм санагдана. Ингээд л эхнэрээ зодох, бие биеийнхээ эсрэг шүүхэд хандах, нэгнээ хөнөөх нь хялбар алхам болдог.

Шунал тачаал суурилсан харилцаа эргээд амьдралыг сүйрүүлдэг. Хүн ариун байдлын тухай Бурханы хуулийг уландаа гишгэвэл өөрөө өөрийгөө сүйтгэнэ. Гагцхүү Бурханы нигүүлсэл л уучлал, эдгэрэл, сэргэлтийг авчрах чадалтай.

### 3 сарын 29

*“Ямар ч цэрэг цэрэгт татагчдаа таалагдахын тулд аж амьдралын явдалд хутгалддаггүй.” (2Тм 2:4)*

Христитгэгч нь Эзэний армид татагдсан бөгөөд Түүний цэрэг юм. Тиймээс өдөр тутмын аж амьдралын явдалд хутгалддаггүй. Энэ эшлэлийн түлхүүр үг нь “хутгалдах.” Бид мэдээж энэ ертөнцийн амьдралаас бүрмөсөн хөндийрөх боломжгүй. Гэр бүлийнхээ хэрэгцээг хангахын тулд ажил хийх зайлшгүй шаардлага гардаг. Тиймээс энэ ертөнцийн өдөр тутмын амьдралд оролцохоос өөр аргагүй. Эс бөгөөс 1Коринт 5:10 дээр Паулын хэлсэн шиг, ертөнцийн гадна гарахаас өөр замгүй болно.

Гэхдээ бид амьдралын зүйлсэд хутгалдахыг өөрсдөдөө зөвшөөрч болохгүй. Тэргүүн зорилгоо үргэлж нүднийхээ өмнө байлгах хэрэгтэй. Заримдаа сайн зүйлс ч гэсэн шилдгийн дайсан болдгийг санаж явууштай.

Уилльяам Келлигийн хэлснээр, “Аж амьдралын явдалд хутгалдах гэдэг нь энэ ертөнцөөс тусгаарлагдахаа больж, түүний нэг хэсэг болон амьдрах юм.”

Хүмүүний асуудлуудыг шийдэх гэж улс төрд орвол би аж амьдралын явдалд хутгалдаж байгаа нь тэр. Үүнийг зүйрлэвэл, сүйрч буй Титаникийн сандал ширээг өрж эмхлэх гэсэн оролдлоготой адил цаг завийг минь гарзадсан ажил юм.

Эсвэл энэ ертөнцийн өвчин шаналлыг эдгээхийн тулд сайнмэдээг барьж очихын оронд нийгмийн халамжийн ажил хийж байвал би аж амьдралын явдалд хутгалдаж байгаа нь тэр.

Эсвэл мөнгө олохын төлөө бизнест улайрч байвал би аж амьдралын явдалд хутгалдаж байгаа нь тэр. Би амиа олох биш алдах болно.

Бурханы хаанчлал ба Түүний зөвт байдал амьдралын минь нэгдүгээр байранд байхаа боливол би аж амьдралын явдалд хутгалдаж байгаа нь тэр.

Хэрэв би, томатны эрдэс бодисын хэмжээг анзаарах, ангийн улиралд хошуурах, богино ханцуйтай цамцныхаа бохирдлын агууламжийг бодох, шарсан төмсний гаж нөлөөнд санаа зовох, тагтааны нүдний эргэлдэх хөдөлгөөнийг сонирхох гэх мэтээр, мөнх амьтай хүний хувьд жижигдэх асуудлуудад хэтэрхий ач холбогдол өгөөд байвал аж амьдралын явдалд хутгалдаж байгаа нь тэр. Иймэрхүү зүйл амьдралд хэрэгтэй нь мэдээж. Гэхдээ амьдралын зорилго, зорилт, утга учир болох нь зохисгүй юм.

### 3 сарын 30

*“Бурханыг хайрладаг, Түүний зорилгын дагуу дуудагдсан хүмүүсийн сайн сайхны төлөө бүх юм хамтдаа ажилладаг гэдгийг бид мэднэ.” (Ром 8:28)*

Хүнд хэцүүгийн дундуур явж байхад хамгийн их гайхал төрүүлдэг эшлэлүүдийн нэг нь энэ юм. Салхи зөөлөн үлээж байхад “Эзээн, би итгэж байна” гэж хэлэх амархан. Харин амьдралын шуурга дэгдэхэд бид “Миний итгэлгүй байдалд туслаач” гэж хэлдэг.

Гэсэн хэдий ч энэ эшлэл үнэн гэдгийг бид мэднэ. Бурхан бүх зүйлийг бидний сайн сайхны төлөө хамтад нь ажиллуулдаг. Библи хэлсэн учраас энэ үнэн гэдгийг бид мэднэ. Бидэнд харагдахгүй, ойлгогдохгүй байсан ч, итгэл үүнийг баталж байна.

Мөн Бурханы зан чанарт үндэслэн энэ эшлэл үнэн гэдгийг бид мэднэ. Хэрэв тэр хязгааргүй хайр, хязгааргүй мэргэн ухаан, хязгааргүй хүч чадлын Бурхан юм бол, бидний сайн сайхны төлөө төлөвлөж, ажилладаг нь гарцаагүй үнэн байх ёстой.

Мөн Бурхны хүмүүсийн туршлагад үндэслэн энэ эшлэл үнэн гэдгийг бид харж болно. Нэгэн хүн сүйрсэн онгоцноос ганцаараа амьд үлдэж эзгүй арал дээр хаягдав. Тэрээр хөлгөөс үлдсэн бүхнийг нийлүүлээд өөртөө нэг овоохой босголоо. Тэгээд аврагдахын төлөө өдөр бүр Бурханд залбирч, хөлөг онгоц харуулдан тэнгис ширтдэг болов. Нэг өдөр овоохой нь шатаж, байсан бүхэн нь утаа болон замхрав. Гэвч түүнд тохиолдсон хамгийн муу явдал үнэндээ хамгийн сайхан тохиолдол байжээ. Түүнийг аврахаар ирсэн хөлгийн ахмад, “Бид утаагаар өгсөн дохиог

чинь хараад ирлээ” гэж хэлж байлаа. Хэрэв бидний амьдрал Бурхны гарт байгаа бол “сайн сайхны маань төлөө бүх юм хамтдаа ажилладаг” гэдгийг санацгаая.

Заримдаа итгэл алдрах, даагдашгүй ачаа үүрсэн мэт санагдах, харанхуйг тэсэж давахгүй мэт мэдрэгдэх үе олон гардаг. Туйлдаа хүрэхээрээ бид “Үүнээс ямар сайн зүйл гарах юм бэ?” гэж асуудаг. Үүнд хариулт бий. Бурханы бүтээж буй сайн сайхныг дараагийн эшлэлээс харж болно. Тэр нь “Түүний Хүүгийн дүртэй адил болох” (Ром 8:29). Барималчны алх хасуур гантиг чулууг цохих бүрд тэр Есүсийн дүр төрх улам тодорно. Амьдралын зовлон бидний дотроос зохисгүй юмсыг авч хаях бүрд бид Түүний дүр төрхтэй улам бүр адил болж өөрчлөгдөнө. Тиймээс, амьдралын хүнд хэцүүгээс сайн зүйл олж чадахгүй бол үүнийг санаарай. Бид Христтэй адил болж байна.

### 3 сарын 31

*“Шинэ итгэгч байж болохгүй. Эс бөгөөс биеэ тоон  
диаволын шүүлтэд унах вий.” (1Тм 3:6)*

Элч Паул, ахлагчдын шалгуурыг жагсаахдаа, энэ ажлыг шинэ итгэгчээр хийлгэх бодлыг шууд үгүйсгэсэн. Харгалзагч хүнд мэргэн ухаан, эрүүл шүүлт зайлшгүй хэрэгтэй. Ийм чанарууд нь сүнслэг төлөвшил ба бурханлаг туршлагаас бий болдог. Гэвч энэ зарчим хэчнээн их зөрчигдөж байна вэ! Амжилттай залуу бизнесмен эсвэл улс төрч эсвэл мэргэжлийн хүн нутгийн чуулганы нөхөрлөлд иржээ. Бид түүнийг чуулганы ажилд даруй оролцуулахгүй бол өөр газар уруу явчхаж магад гэж бодсондоо түүнийг удирдлагын байр сууринд тавьчихдаг. Паул үйлчлэгчдийн талаар “Эхлээд тэд шалгагдаг” гэж хэлснийг дагадаг бол бид хэчнээн зовлонгоос аврагдах бол доо!

Энэхүү сүнслэг зарчмыг бүр муугаар зөрчдөг нь гэвэл, одууд Христэд итгэсэн даруйд тэднийг олны өмнө өргөмжилж, сурталчлах явдал юм. Жишээ нь Христэд итгэхээсээ өмнө хөл бөмбөгийн ертөнцөд алдартай шилдэг тамирчин байсан нэг хүн байж. Гэтэл зарим нөхөд түүнийг Данаас Беершеба хүртэл мандуулдаг. Холливудын жүжигчин Христэд итгэсэн даруйд онцлох мэдээ болдог. Тэгээд түүнээс, гэрлэлтийн өмнөх бэлгийн харилцаа, төр засгийн оноодог ял шийтгэл гээд юм болгоны тухай санал бодлыг нь асуудаг. Итгэсэн даруйдаа бүхий л мэргэн ухааныг олж авахгүй шүү дээ! Тэгвэл өмнө нь гэмт хэрэгтэн байсан хүн Эзэнийг мэддэг болбол яах бол?



Түүнийг бид, хурдан мөнгө олох гэсэн этгээдүүдийн гар хөл болчих вий гэж эмээдэг шүү дээ! Ийм их ялгаатай.

Доктор Пол Ван Гардер ингэж хэлж байна: “Христэд дөнгөж итгэсэн хүнийг олны өмнө гаргахыг би огт дэмждэггүй. Бурханы үгийн үр зүрхэнд гүн үндэслэж, зохих үр жимсээ гаргах хүртэл тодорхой хугацаа хэрэгтэй. Гэтэл урлаг, спорт, улс төрийн ертөнцийн нөлөө бүхий хүмүүсийг Христэд итгэсэн даруйд сайнмэдээний тайзан дээр олны өмнө гаргаж мандуулах нь Христийн үйл хэрэгт нөхөж баршгүй гарз учруулдаг.”

Хэн нэг хар тамхичин эсвэл улс төрч Христэд итгэлээ гэдгийг сонсохоор зарим итгэгчдийн шашных нь талаарх бахархал улам нэмэгддэг бололтой. Христийнхэн гэхээр л, сул доройчууд, нэр төргүйчүүд байдагт сэтгэл дундуур байдаг тэдний хувьд алдартай хүн итгэсэн гэдэг үг өөртөө итгэх итгэлийг нь нэмэгдүүлдэг бололтой.

Гэвч тэдгээр баатрууд диаволын зэмсэг болж байдаг. Өөрсдөө ч мэдэхгүйгээр түүний зальт явуулгын гар хөл болж, нүгэлд унан, Эзэн Есүсийн гэрчлэлд маш их буруутгал бий болгоцгоодог.

Алдартай ч, алдаргүй ч, жинхэнэ аврагдсан хүн бүрийн төлөө бид Бурханд талархдаг. Гэхдээ Христийн ажлыг урагшлуулахын тулд шинэ итгэгчдийг индэр дээр гаргах юм уу камерын өмнө зогсоох нь шилдэг санаа гэх төөрөгдлөөсөө бид салах цаг болжээ.

## 4 сарын 1

*“Түүн дотор та нар төгс болгогдсон.”* (Кол 2:10)

Ихэнх хүн, мөнхийн улсад орох хүмүүсийг янз бүрийн зэрэглэлтэй гэж ойлгодог. Их буян үйлдсэн нь дээгүүр байр, бага буян үйлдсэн нь доогуур байр эзэлнэ гэж төсөөлцгөөдөг. Сайхан сэтгэлтэй, сайн хүмүүс хамгийн дээр нь, дээрэмчин луйварчид хамгийн доор нь байна гэж эндүүрдэг. Гэвч тийм зэрэг дэв байхгүй. Энэ бол маш том төөрөгдөл. Хүн нэг бол мөнхийн улсад орох шаардлага хангасан байна, эсвэл хангаагүй байна. Ийм л хоёр хувилбар бий.

Үнэндээ мөнхийн улсад орох шаардлага хангасан хүн нэг ч байхгүй. Бид бүгд нүгэлтэй бөгөөд үүрд шийтгэл хүртэх ёстой хүмүүс. Бид бүгд нүгэлтэн учраас Бурханы цог жавхланд хүрэхгүй. Бид цөм төөрч, өөрсдийн замаар явцгаажээ. Бид бүгд бузар. Бидний хамгийн сайн үйл хүртэл Бурханы нүдэнд хог шаар юм.

Мөнхийн улсад орох шаардлагыг хангасан хүн нэг ч байхгүйгээс гадна, шаардлагыг хангахын тулд бидний зүгээс хийж чадах юм юу ч байхгүй. Бидний хамгийн сайн шийдвэр, хамгийн эрхэм үйлс хүртэл нүглийг маань зайлуулж чадахгүй бөгөөд Бурханы шаардсан зөвт байдлыг бидэнд өгөхгүй. Гэвч сайн мэдээ бий. Бурханы хайр нь Бурханы шаарддаг зөвт байдлыг ханган өгчээ. Өгөх өгөхдөө үнэгүй өгчээ. “Нигүүлслийн учир итгэлээрээ аврагдсан нь та нараас бус харин Бурханы бэлэг бөгөөд үйлсээр чинь биш тул хэн ч үл сайрхах болно.” (Еф 2: 8,9).

Мөнхийн улсад орох шаардлага Христийн дотор хангагддаг. Нүгэлтэн дахин төрөх үедээ Христийг хүлээн

авдаг. Түүнээс хойш Бурхан түүнийг махан бие доторх нүгэлтэн гэж харахгүй. Харин Христийн дотор байгаагаар харах ба тэрхүү үндэслэлээр түүнийг хүлээн зөвшөөрдөг. “Нүглийг үл мэдэгч Түүнийг бидний төлөө Тэрээр нүгэл болгосны учир Түүний дотор бид Бурханы зөвт байдал болох юм.” (2Ко 5:21)

Тэгэхээр эндээс нэг дүгнэлт хийж болно. Бидэнд нэг Христ байна, эсвэл байхгүй. Хэрэв бидэнд Христ байвал Бурхан биднийг мөнхийн улсад орох шаардлага хангасан хүн болгодог. Христийн төгс байдал биднийх болно. Бид Христийн дотор байгаа учраас Түүн шиг үнэ цэнтэй болдог.

Тэгвэл эсрэгээрээ, бидэнд Христ байхгүй бол аврал үгүй. Христгүй хүн эцсийн эцэст мөнхийн галд хаягдана. Учир нь тэр хүн шаардлагыг хангаагүй юм. Түүний дутууг ямар ч зүйл нөхөж чадахгүй.

Түүнээс гадна, нэг итгэгч нөгөөгөөсөө илүү ариун биш. Итгэгчид бүгдээрээ ижил үндэслэлээр аврагдсан. Тэр үндэслэл нь Христ. Тиймээс, нэг итгэгч нь нөгөөгөөсөө илүү Христийг хүлээн авах боломжгүй. Бид бүгдээрээ ижил хэмжээгээр мөнхийн улсад орох шаардлагыг хангасан билээ.

## 4 сарын 2

*“Учир нь хүн бүр мууг ч, сайныг ч, юу үйлдсэнийхээ төлөө биеэрээ хариугаа авахаар бид бүгдээрээ Христийн шүүх суудлын өмнө гарч ирэх ёстой.” (2Ко 5:10)*

Мөнхийн улсад орохуйц хүмүүсийн зэрэглэл гэж байхгүй гэдгийг өмнө нь өгүүлсэн. Энэ үнэн. Тэгвэл мөнхийн улсад авах шагналд зэрэглэл байдаг нь ч үнэн юм. Христийн шүүх суудлын өмнө, аврагдсан хүмүүс үйлсээ шалгуулж шагналаа авцгаана. Ингэхдээ зарим нь ихийг, зарим нь багыг авна.

Түүнээс гадна, тэнгэрийн цог жавхланд хүмүүс өөр өөр байр суурь эдэлнэ. Бүгд аз жаргалтай байх нь мэдээж. Гэхдээ тэр аз жаргал дотор зарим нь өндөр байр суурийг, зарим бага байр суурийг эдлэх юм. Хүн бүрийн аяга дүүрэн байх нь дамжиггүй. Гэхдээ заримынх нь аяга том, заримынх нь аяга жижиг байна.

Цог жавхланд орсны дараа бүгд ижил байна гэдэг үзлээс хол байх хэрэгтэй. Хүмүүсийг нэг хэвд цутгана гэсэн тийм утгагүй санаа Библийн хаана ч байхгүй. Харин ч итгэмжит үнэнч амьдарсан хүмүүсийг титмээр шагнаана гэж Библи тунхагладаг. Зарим хүний үйлс шагнагдаж, зарим хүний үйлс шатаагдана гэж Библи заадаг.

Нас чацуу хоёр залуу яг нэг өдөр аврагджээ. Түүнээс хойш дөчин жил өнгөрөхөд нэг нь Бурханы хаанчлал ба зөвт байдлыг нэгдүгээрт тавьж амьдрав. Харин нөгөө нь мөнгө олох гэж амьдралынхаа хамаг сайхан цагийг зарцуулав. Эхний залуу Эзэний юмсыг байнга ярина. Хоёр дахь залуу зах зээлийн үйл явдлыг байнга ярина. Нэг дэх залуу энэ дэлхий дээр байхдаа Эзэнтэй илүү нөхөрлөлтэй

бөгөөд тэнгэрт очоод ч илүү том байр суурийг эзэлнэ. Харин хоёр дахь залуу, Христ хэн бэ гэдэгт үндэслэн, Христийн хийсэн ажлын үр шимээр мөнхийн улсад гарцаагүй очих боловч сүнслэг байдлын хувьд балчир учир бага байр сууринд хүрнэ.

Бид мөнхийн гэртээ очихоороо хэр их шагнал авахаа энэ дэлхий дээр өнгөрөөж буй өдөр тутмынхаа амьдралаар шийддэг. Библийн мэдлэг, түүнийг хэрэгжүүлж байгаа дуулгавартай зан, өдөр бүрийн залбирал, Бурханы хүмүүстэй нөхөрлөх нөхөрлөл, Эзэнд үйлчлэх үйлчлэл, Бурханы даатгасан зүйлст хэр итгэмжтэй нярав байгаагаараа бид ирээдүйн шагналаа тодорхойлдог. Бид өдөр тутмынхаа амьдралаар мөнхийн байр сууриа босгож буйг ойлгох аваас өдөр тутамдаа ямар сонголт хийх, юуг эн тэргүүнд тавихаа зөв тодорхойлно.

## 4 сарын 3

“Учир нь тэр дотроо боддогтойгоо адил юм.” (Сур 23:7 АБ 2004)

“Өөрийгөө хэн гэж боддог чинь бус, юу бодож байгаа тань та юм” гэж А. П. Гибс байнга хэлдэг байж билээ. Өөрөөр хэлбэл, бодол санаа нь үйл хөдлөлийн эх булаг юм. Эх булгийг нь хянавал урсгалыг хянасантай ижил. Тиймээс бодол санаагаа удирдах нь хамгийн чухал. Соломон “Зүрх юугаан урьтан хамгаал. Амийн булгууд түүнээс ундарюу” (Сур 4:23) гэсэн нь ийм учиртай. Зүрх гэж бодол санаа гэдэгтэй ижил утгатай үг. Нүгэл нь бодол санаанд эхэлдэг гэж Иаков сануулсан (Иак 1:13-15). Бид нэг зүйлийг удаан бодвол түүнийгээ заавал гүйцэлдүүлнэ.

Бодлыг тариад үйлдлийг хураа.

Үйлдлийг тариад дадлыг хураа.

Дадлыг тариад зан чанарыг хураа.

Зан чанарыг тариад хувь тавиланг хураа.

Эзэн Есүс ч мөн бодол санаа хэчнээн чухлыг ярьсан. Тэрээр үзэн ядалтыг алагатай (Мт 5:21-22), тачаадан харахыг завхайралтай (Мт 5:28) адилтгасан. Түүнчлэн, хүний идэж уусан нь биш, харин зүрхнээс гарах бузар бодлууд нь хүнийг бузарладаг гэж сургасан (Мк 7: 14-23).

Бодож байгаа зүйлдээ бид хариуцлага хүлээнэ. Учир нь түүнийг удирдах боломж бидэнд байдаг. Бид бохир заваан зүйл бодож болно. Аль эсвэл цэвэр ариун, Христийн таалдаг зүйлсийг бодож болно. Бид бүгд хаантай адил. Бидний захирдаг эзэнт гүрэн нь бодол санаа маань юм. Тэрхүү эзэнт гүрэн нь сайн сайхан байх ч боломжтой, муу муухай байх ч боломжтой. Ямар байхыг бид шийддэг.

Үүний тулд бид юу хийж чадах вэ? Хэдэн сайн зөвлөгөө өгье. Нэгт, бүх зүйлийг залбирлаар Эзэнд даатгаж, “Бурхан, миний дотор цэвэр зүрхийг бүтээж, миний дотор зөв сүнсийг шинэчлэн авчраач” (Дуу 51:10) гэж хэл. Хоёрт, бодол бүхнээ Христийн өмнө хэрхэн харагдах вэ гэж шүүн тунгаа (2Ко 10:5) Гуравт, бузар бодол бүрийг тэр дор нь хүлээн зөвшөөрч, хөөж гарга (Сур 28:13). Дөрөвт, бодлоо хоосон байлगाхаас зайлсхийж, эерэг, зохистой, зөв бодлуудаар дүүргэ (Флп 4:8). Тавт, унших, харах, сонсох зүйлдээ сахилга батыг хөгжүүл. Бохир юмсаар тархиа гэжээж байгаа үед бодол санаа цэвэр байх боломжгүй. Эцэст нь, Эзэний төлөө завгүй бай. Завтай хүний бодолд элдвийн утгагүй зүйлс орж ирэх нь амархан.

## 4 сарын 4

“...бид итгэлээр ойлгодог.” (Евр 11:3)

“Бид итгэлээр ойлгодог.” Энэ үгс нь сүнслэг амьдралын тулгуур зарчмуудын нэг юм. Бид эхлээд Бурханы үгэнд итгэж, дараа нь ойлгодог. Дэлхий “Харах нь итгэл” гэдэг бол, Бурхан “Итгэх нь харах” гэдэг. Эзэн Есүс Мартад “Хэрэв чи итгэвэл Бурханы алдрыг харна” (Иох 11:40) гэж хэлсэн. Хожим нь Томаст хандаж “Хараагүй атлаа итгэсэн нь ерөөлтэй еэ!” (Иох 20:29) гэж айлдсан. Элч Иохан, “...мэдээсэй гэсэндээ...итгэдэг та нарт үүнийг бичлээ” гэж бичсэн (1Ио 5:13). Эхлээд итгэ. Тэгвэл мэдэх болно.

Билли Грэйм энэ зарчмыг хэрхэн ойлгосон тухайгаа ярьсан байдаг: 1949 он. Надад Библийн талаар маш олон эргэлзээ байлаа. Библид илэрхий зөрчилтэй зүйл олон байна гэж би бодлоо. Зарим зүйлүүд нь Бурханы тухай явцуу үзэл бодолтой минь зохицохгүй байв. Номлох гэхээр өнгөрсөн үеийн агуу номлогчдын гол шинж болсон эрх мэдэл гэдэг зүйл надад дутагдаад байв. Библийн сургуулийн олон зуун оюутны нэгэн адил би оюун санаандаа тэмцэлдэж байлаа. Үр дүн нь миний ирээдүйн үйлчлэлд нөлөөлж чадах байв.

Тэр жилийн 8 сард би Лос Анжелесийн ойролцоох ууланд байрлах пресбитериан цуглааны Форест Хоум төвд уригдлаа. Ойн жимээр ороод, модон дунд алхаж явахдаа би Бурхантай барилдаж байснаа санадаг. Эргэлзээнүүдтэйгээ тэмцэлдэж байхад сэтгэл минь галын шугамд байх шиг мэдрэгдэж билээ. Эцэст нь Библид илчлэгдсэн амьд Бурханы өмнө цөхрөнгөө барсан би



өөрийн хүслээ орхин бууж өглөө . Библиэ нээгээд өмнө нь өвдөг сөхөрч, “Эзээн, энэ номын олон зүйл надад ойлгомжгүй байна. Гэвч Та, ‘Зөвт хүн итгэлээр амьдарна’ гэж хэлсэн. Танаас авсан болгоныг би итгэлээр хүлээн авсан. Яг одоо энд би Библийг Таны үг гэж хүлээн авч байна. Бүгдийг нь хүлээн авч байна. Юу ч үлдээхгүйгээр. Ойлгохгүй зүйл гарвал, илүү ухаарал ирэх хүртэл тэр хэсгийг нухацтай тунгаан бодно. Энэ нь Таны таалалд нийцвэл Таны үгийг тунхаглах эрх мэдэл өгөөч. Тэрхүү эрх мэдлээр би нүгэлт хүмүүсийг сэнхрүүлж, нүгэлтнүүдийг Аврагч уруу эргүүлье” гэж залбирсан.

Зургаан долоо хоногийн дотор бид Лос Анжелесын хөдөлгөөнийг эхэлсэн. Одоо энэ бүхэн түүх болжээ. Тэрхүү хөдөлгөөний үер би үйлчлэлийг минь өөрчилсөн нууцыг нээсэн юм. Би Библийг үнэн хэмээн батлах гэж оролдохоо больсон. Бодол дотроо би үнэн гэж хатуу итгэсэн бөгөөд тэрхүү итгэл сонсогчид уруу минь хүрч байлаа.

## 4 сарын 5

*“Бурхан та нарыг Христ дотор уучилсны адил бие биенээ уучлан, нэг нэгнээ энэрч аядуу зөөлөн сэтгэлээр ханд.”* (Еф 4:32)

Библийн дагуух уучлалд тодорхой дараалал гэж бий. Энэ дарааллыг дагадаг бол бид олон толгойны өвчин, зүрхний зовууриас ангижрахсан.

Эхлээд хийх зүйл бол буруутай этгээдийг зүрхэндээ уучлах. Тэр үедээ чамайг уучилсан гэж тухайн хүнд хэлэхгүй. Зүрхэндээ уучилснаар асуудлыг Эзэн болон тэр хүний хооронд үлдээж байгаа юм. Энэ нь таны ходоодны шүүсийг хүхрийн хүчил болохоос сэргийлж, бие махбодын болон сэтгэл санааны аймшигт эмгэгүүдээс таныг аврах болно.

Дараа нь буруутан дээр очоод түүнийг зэмлээрэй (Лк 17:3). Танд ямар буруу хийснийг бусдад ярихын оронд “явж түүнтэй ганцаарчлан уулзаж зэмлэ” (Мт 18:15). Асуудлыг аль болох өөртөө үлдээхийг хичээ. Өөрөөр хэлбэл, асуудлыг аль болох хувийн байлгахыг хичээ.

Хэрэв тэр буруугаа хүлээж уучлал гуйхгүй бол түүн дээр нэг юм уу хоёр гэрчийн хамт очоорой (Мт 18:16). Энэ нь буруутны хандлагын талаар Библид суурилсан хангалттай нотолгоо болно.

Тэгсэн ч тэр хүн өөрчлөгдөхгүй бол асуудлыг гэрч нарын хамт чуулганы өмнө авчир. Тэрээр чуулганы үгийг сонсохоос татгалзвал мэдээж түүнийг чуулганы нөхөрлөлөөс хасах хэрэгтэй (Мт 18:17).

Гэхдээ энэхүү үйл явцын дунд үед тэр хүн гэмшвэл түүнийг уучил (Лк 17:3). Та түүнийг зүрхэндээ аль

хэдийнээ уучилсан. Харин одоо албан ёсоор уучлал үзүүлж байгаа юм. Энд анхаарах ёстой зүйл бий. “Өө зүгээр дээ. Чи ямар ч буруу зүйл хийгээгүй” гэж бүү хэлээрэй. Түүний оронд “Би чамайг уучилж байна. Асуудал ингээд дууслаа. Хамтдаа залбирцгаая” гэж хэлээрэй.

Нүглээ улайж, гэмшсэн ичгүүрээсээ болоод тэр хүн танд дахиж бурууг хийхгүй байх. Гэхдээ нүглээ давтан хийгээд дахиад гэмшвэл, та түүнийг уучлах ёстой. Нэг өдөрт долоо удаа бурууг хийгээд долоон удаа гэмшсэн ч, үнэн сэтгэлээсээ эсэхийг нь бодохгүйгээр уучлах ёстой (Лк 17:4).

Бид олон сая удаа өршөөгдсөн гэдгээ мартаж өсгүй. Тиймээс бусдыг хэдхэн удаа уучлахаас хэзээ ч татгалзаж болохгүй. Зүйрлэвээс, өөрсдөө хэдэн сая долларын өрөө цайруулуулсан байж, бусдаас авах хэдхэн долларын авлагыг цөөн хэдэн удаа цайруулах нь бидэнд том асуудал байх өсгүй юм (Мт. 18: 23-35).

## 4 сарын 6

*“Хэрэв хэн нэгэн нь Түүний хүслийг үйлдэхийг хүсвэл тэрээр энэ сургаал Бурханаас уу эсвэл Би Өөрөөсөө ярьж байна уу гэдгийг мэднэ.” (Иох 7:17)*

Энэ эшлэлийн эхний хэсгийг Өнөөгийн Англи Хэлний Орчуулгад (Today’s English Version): “Бурхан юу хүсдэгийг үйлдэхийг хүсэгч нь...мэдэх болно” гэж орчуулсан. Хэрэв хүн мэдье гэж чин сэтгэлээсээ хүсвэл Бурхан харуулж өгнө гэдэг нь юутай гайхалтай амлалт вэ!

Нүгэлтэн бүрэн бууж өгөөд үнэн сэтгэлээсээ “Бурхан минь, надад Өөрийгөө илчлээч” гэж залбирахад Бурхан заавал илчилж өгнө. Ийм залбирлын хариу заавал ирдэг.

Баруун өмнөд нутгийн нэгэн агуйд амьдардаг хиппи залуу бүхнээ дуусгахад бэлэн байлаа. Архи, хар тамхи, секс, далд ертөнцийн гэх юмсаар сэтгэлээ дүүргэхийг оролдсон ч сэтгэлийнх нь хоосрол дүүрсэнгүй. Энэхүү хоосролоосоо яаж салахаа ч мэдэхгүй байлаа. Цөхрөнгөө барсан хиппи залуу, хамаг юм нь хөглөрсөн агуйдаа “Бурхан минь ээ, үнэхээр Бурхан гэж байдаг бол, Та Өөрийгөө надад илчлээч, эс бол би үхлээ” гэж хашхирчээ.

Тэгтэл аравхан минутын дараа түүгээр өнгөрч явсан христэч залуу агуйн аман дээр шагайхдаа хиппи залууг олж хараад “Сайн уу? Таныг дургүйцэхгүй бол танд Есүсийн тухай ярьж өгч болох уу?” гэж хэлж гэнэ.

Тэгээд юу болсон гэж санана. Хиппи залуу, Эзэн Есүс Христэд итгэх итгэлээр дамжин авралд хүрэх сайнмэдээг сонсжээ. Тэрээр Аврагч дээр ирж, уучлал, нигүүлсэл, шинэ амийг хүлээн авав. Тэрээр гүн шаналлынхаа дундаас залбирсанд Бурхан сонсож хариулсан юм. Сэтгэлд нь

Эзэний онцгой илчлэл байхгүй мөртөө тэгж залбирсан хүний талаар би ер сонсож байгаагүй.

Мэдээж энэ амлалт жинхэнэ христэч хүний хувьд ч баттай. Хүн өөрийнхөө амьдралд зориулсан Бурханы хүслийг мэдэхийг үнэхээр хүсвэл Бурхан түүнд харуулж өгнө. Чуулганы нөхөрлөл ямар замаар явах ёстойг мэдэхийг хүсвэл Бурхан мэдүүлж өгнө. Тухайн хүнд ямар ч хэрэгцээ байж болно. Гагцхүү Бурханы хүслийг мэдэхийг үнэн сэтгэлийн угаас хүсвэл Бурхан тэр хэрэгцээг заавал шийднэ. Гол нь бидэнд чин үнэн хүсэл л дутдаг юм.

## 4 сарын 7

*“Гэвч би бүгдийг хүлээн авч хангагдсан. Би Енафродитоос та нарын юмсыг хүлээн аваад дүүрэн байна. Бэлэг чинь Бурханд таашаагдах тааламжит тахил ба анхилуун үнэр юм.” (Флп 4:18)*

Паулаас филиппойчуудад бичсэн захидал нь Филиппойн итгэгчдээс ирсэн бэлгийг хүлээн зөвшөөрсөн явдал байв. Энэ бэлэг нь мөнгө байсан гэж үзэж болох байх. Хамгийн гайхалтай нь элч Паул тэдний бэлгийг ямар үгээр магтсан нь юм. Тэрээр бэлгийг “Бурханд таашаагдах тааламжит тахил ба анхилуун үнэр” гэж нэрлэсэн. Ефес 5:2-т Паул, Голгота дээр өгсөн Христийн агуу бэлгийг ийм үгээр дүрсэлсэн байдаг. Тэрээр, “Бурханд анхилуун үнэрт өргөл ба тахил” гэж хэлсэн. Эзэний зарцад өгсөн бэлэг нь үгээр илэрхийлэхийн аргагүй Бурханы жинхэнэ бэлэгтэй ижил хэмжээнд үнэлэгдэж буйг бодохоор юутай гайхалтай!

Ж. Х. Жовет энэ эшлэлийг маш сайхан тайлбарласан: “Бидний жижигхэн тусламж ямар том цар хүрээг хамраа вэ! Бид ядуу эрд үйлчилж байна гэтэл үнэндээ Эзэн Хаанд үйлчилж байжээ. Анхилуун үнэр нь манай хотоос цааш үнэртэхгүй гэж бодтол орчлон дэлхийд тархжээ. Зөвхөн Паулд тусалж байна гэж бодтол Паулын Аврагч ба Эзэнд үйлчилж байжээ.” Христэч өргөлийн сүнслэг мөн чанар, нөлөөлөх цар хүрээг нь ойлговол бид албадлагаар буюу дуртай дургүй өгөхөө болих нь дамжиггүй. Гэхдээ мэдээж албадах, өрөвдүүлэх, хөгжөөх замаар мөнгө босгодог байдалд бид харшилтай байх хэрэгтэй. Энэ төрлийн өргөл нь зүй бус. Бид харин хайрласандаа, өгөх дуртайдаа өгөх болно.

Аугаа Бурханд өгсөн миний өчүүхэн өргөл нь Бурханы сэнтий буй танхимыг анхилуун үнэрээр дүүргэдэг бөгөөд даруухнаар мөргөж, баяр хөөртэйгөөр өгөх ухаарлыг надад хайрлаад зогсохгүй ням гарагийн өргөл өргөх цаг нь цаашид уйтгартай байхаа болино! Энэ нь Эзэн Есүст шууд өгч байгаатай агаар нэгэн хэрэг болой.

## 4 сарын 8

*“Учир нь Бурханы үг амьд бөгөөд идэвхтэй, хоёр талдаа иртэй ямар ч илдээс хурц.” (Евр 4:12a)*

Христэч их сургуулийн нэг оюутан либерал үзэлт сургуулийн өөр нэг оюутанд Эзэнийг гэрчилж байлаа. Итгэгч оюутан Библиэс нэг үг эш татахад нөгөө нь “Би Библид итгэдэггүй” гэв. Итгэгч оюутан өөр нэг эшлэлийг эш татав. Нөгөө нь “Би Библид итгэдэггүй гэж хэлсэн шүү дээ” гэв. Итгэгч оюутан Библиэс гурав дахь удаагаа эш татахад нөгөө оюутан нь уурлаж “Надад Библийг ярихаа боль. Би наадахад чинь итгэдэггүй гэдгээ чамд хэд хэлэх юм бэ?” гэв. Итгэгч оюутан сэтгэлээр унав. Хүний сүнснийг аварч чадахгүй юм байна гэж өөртөө гутрав.

Итгэгч оюутан орой нь доктор Х. А. Айронсайдын гэрт зочлов. Хоол идэж байх зуураа итгэгч оюутан урам хугарсан явдлаа ярилаа. Тэгээд доктор Айронсайдаас “Хүнд Эзэнийг гэрчлэх үед тэр хүн чинь “Би Библид итгэдэггүй” гэвэл та яах вэ?” гэж асуув. Доктор Айронсайд инээмсэглээд “Тэгж хэлсэн ч би дахиад л Библиэс эш татна” гэж хариуллаа.

Авралын зар түгээгч бүхэнд энэ бол гайхалтай зөвлөгөө юм. Хүмүүс “Би Библид итгэдэггүй” гэж хэлбэл Библиэс бүр ч олон удаа эш тат. Бурханы үг амьд бөгөөд эрх мэдэлтэй. Хүмүүс түүнд итгэдэггүй байсан ч, Бурханы үгэнд хүч нөлөө байдаг.

Хоёр хүн ирүүл тулаан хийж байна гээд төсөөл дөө. Нэг нь нөгөөдөө, “Чиний илд чинь жинхэнэ ган гэдэгт би итгэхгүй байна” гэж хэллээ гэж бодъё. Тэглээ гээд илдээ хуйнд нь хийгээд ялагдлаа хүлээн зөвшөөрөхгүй шүү дээ.



Эсвэл жинхэнэ гангаар хийсэн гэж батлахын тулд хими, шинжлэх ухааны маргаан хийхгүй. Тэгвэл ухаангүй хэрэг болно. Харин ч өрсөлдөгч этгээддээ илднийхээ ирийг амсуулж, жинхэнэ илд гэдгийг нь мэдрүүлнэ. Библи ч гэсэн адил. Бурханы үг бол Сүнсний илд. Түүнийг өмгөөлж хамгаалах бус, ашиглах хэрэгтэй. Библи өөрөө өөрийгөө хамгаалах чадвартай.

Библийг Бурханы үг гэж батлах нь буруу гэж би хэлээгүй. Нэгэнт аврагдсан хүмүүсийн итгэлийг батжуулахад тийм баталгаанууд маш тустай. Тийм баталгааг сонссоны ачаар авралд хүргэх итгэлийг хүлээн авсан цөөн хэдэн тохиолдол бий. Гэхдээ нийтлэг тохиолдолд хүмүүс, цэцэрхэл ба маргаанаар юмыг ухаардаггүй. “Хүн хэчнээн үнэмшлээ ч тэр нь хүслийнх нь эсрэг байвал хуучин бодолдоо үнэнч хэвээр үлддэг.” Хүн Бурханы хүчирхэг үгтэй нүүр тулах хэрэгтэй. Библийн ганц эшлэл мянган цэцэрхлээс илүү.

Тэгэхээр Библийн эшлэл цээжлэх нь маш чухал юм. Та Библийн эшлэл цээжилдэггүй бол хэрэгтэй цагт нь Ариун Сүнс тэднийг бодол санаанд чинь оруулж ирэхгүй. Гол нь, Бурхан миний үгийг хүндэлнэ гэж амлаагүй. Харин Өөрийнхөө үгийг хүндэлнэ гэж амласан билээ. Тэгэхээр үл итгэгчтэй харилцахдаа Сүнсний илдийг харамгүйгээр ашигла. Тэгээд нигүүлсэл ямар гайхамшиг хийж чадахыг үз. Хүмүүст ухаарал ирж, тэд аврагдах болно.

## 4 сарын 9

“...нядлагдахаар хөтлөгдөх хурга шиг...” (Иса 53:7б)

Би нэг удаа хурга нядлахыг үзсэн юм. Нэг талаараа маш сэтгэл хөдлөм, нөгөө талаар аймшигтай дүр зураг байлаа.

Хурга, нядалгааны газар уруу явж байхдаа онцгой хөөрхөн харагдаж байв. Хүүхдүүд түүнийг ихэд өхөөрдөнө. Ер нь аливаа амьтны үр төл эгдүүтэй байдаг. Муурын зулзага, гөлөг, дэгдээхэй, тугал, унага бүгдээрээ эгдүүтэй. Гэхдээ хурга гэдэг амьтан онцгой хөөрхөн ажээ.

Тэр хурга надад ямар ч гэм зэмгүйн зураглалыг харуулсан. Цав цагаан өнгөтэй, ямар ч толбогүй, цэвэр сайхны бэлгэдэл гэлтэй. Зан чанар нь дөлгөөн тайван. Өөрийгөө хамгаалах чадваргүй сул дорой.

Нүд нь юм яриад ч байх шиг. Нүднээс нь айдас, гуниг, зүдүүр мэдрэгдэж байв. Ийм жаахан, ийм хөөрхөн амьтан яагаад үхэх ёстой юм бэ гэж өөрийн эрхгүй бодож билээ.

Тэгтэл хөлийг нь хүлээд хөөрхий хургыг хажуугаар нь хэвтүүлэв. Хурга удахгүй үхэхээ мэдэж байгаа мэт хүндээр амьсгалах аж. Нядлагч жинтэй ганцхан хөдлөөд хутгаар хоолойг нь хэрчлээ. Газраар нэг цус урсав. Бяцхан бие нь үхлийн өвдөлтөөс болж татвалзаад удалгүй хөдлөхөө болив. Дөлгөөхөн хурга үхэх нь тэр.

Үйл явдлыг үзэж байсан хүмүүсийн зарим нь нүүр буруулав. Харахад дэндүү нүд халтирам дүр зураг болохоор тэгэхээс ч аргагүй. Зарим нь нулимсаа арчиж суулаа. Хэн ч үг дуугарахыг хүссэнгүй.

Дараа нь би итгэлээр өөр нэгэн Хурга үхэхийг харлаа. Тэр бол Бурханы Хурга. Нэг талаар үнэхээрийн ерөөлтэй, нөгөө талаар аймшигтай дүр зураг байлаа.

Бурханы Хурга үнэхээр хөөрхөн, олны дунд онцгой, хамгийн сайхан нь билээ. Тэрээр цаазын тавцан уруу хүргэгдэх үедээ амьдралынхаа ид үедээ явж байв.

Тэрээр гэм зэмгүй, ариун, гэм хоргүй, бузартаагүй, нүгэлгүй, толбогүй, өө сэвгүй байсан. Тийм цэвэр ариухан нэгэн яагаад үхэх ёстой гэдгийг бодохоор зүрх шимширмээр.

Гэвч цаазлагчид нь Түүнийг авч яваад загалмайд цовдлов. Гар хөлд нь хадаас цоо хатгав. Тэрээр загалмай дээр нүгэлтнүүдийг орлож тамын тарчлал ба аймшгийг амсжээ. Гэсэн ч Түүний нүд хайр ба уучлалаар дүүрэн байв.

Эцэст нь Түүний зовлон дуусгавар боллоо. Тэрээр сүнсээ гаргаж, бие нь загалмайд өлгөгдөөд үлдлээ. Нэгэн цэрэг үхсэн эсэхийг нь шалгахаар хавирга руу нь жадлахад цус ба ус асгарав. Бурханы Хурга амь тасрав.

Зүрх минь шархирлаа. Нулимс минь хацар даган урслаа. Би өвдөг сөхөрч Түүнд талархал магтаалыг өргөлөө. Бодоод үз дээ. Тэр миний төлөө үхжээ. Би Түүнийг хайрлахаа хэзээ ч болихгүй.

## 4 сарын 10

“...өөрсдөд чинь заах хэн нэгэн та нарт хэрэггүй.” (1Ио 2:27)

Эхлээд өнгөцхөн уншихад энэ эшлэл асуудалтай санагддаг. Хэрэв бидэнд заах хүн шаардлагагүй юм бол ариун хүмүүсийг үйлчлэлийн ажилд бэлтгэхийн тулд амилсан Эзэн яагаад багш нарыг өгдөг юм бэ? (Еф 4: 11,12).

Иоханы хэлж буй санааг ойлгоё гэвэл захидал бичсэн үеийн нөхцөл байдлыг мэдэх хэрэгтэй. Түүнийг захидал бичиж байх үед чуулганд гностик үзэлтнүүд гэх хуурамч багш нар газар аваад байлаа. Энэ буруу сургаалтнууд нэгэн цагт өөрсдийгөө Эзэн Есүст итгэгчид хэмээн нэрлэж, нутгийн чуулганы нөхөрлөлд багтаж байлаа. Гэвч удалгүй, Христ 100 хувь хүн бас 100 хувь Бурхан гэдэг үзлийг няцааж, чуулганы нөхөрлөлөөс гарцгаажээ.

Тэд өөрсдийгөө бусдаас илүү мэдлэгтэй гэж сайрхдаг байснаас гностикууд нэртэй болжээ. Учир нь грекээр гносис гэж “мэдэх” гэсэн утгатай. Тэд Христэд итгэгчдэд иймэрхүү зүйлийг хэлдэг байж: “Та нарын сургаал сайн боловч дутуу дулимаг юм. Та нарын номлол хэтэрхий энгийн. Харин бид та нарт илүү гүн гүнзгий, шинэ нууцуудыг зааж өгч чадна. Хэрэв та нар бүрэн төлөвшиж, жинхэнэ утгаараа сэтгэл хангалуун болохыг хүсвэл бидний сургаалыг дагах хэрэгтэй.”

Энэ бүхэн тэр чигтээ заль мэх гэдгийг Иохан итгэгчдэд анхааруулж байна. Итгэгчид, тэд мэтийн хуурамч этгээдүүдээр заалгах шаардлага байхгүй ажээ. Учир нь итгэгчдэд Ариун Сүнс байдаг. Үнэний үг байдаг. Мөн Бурханы томилсон багш нар байдаг. Ариун Сүнс үнэн

худлыг ялгах чадварыг өгдөг. Христитгэл бүх үнэнийг ариун хүмүүст өгсөн (Иуд 3) учраас нэмэлт үнэн гэсэн бүхэн худал хуурмаг юм. Христэч багш нар Библийг тайлбарлаж хэрэгжүүлэх үүрэгтэй. Харин Библиэс хальж гарч болохгүй.

Иохан өөрөө чадварлаг багш байсан боловч чуулганд заавал багш байх шаардлагагүй гэж мэдэгдсэн шалтгаан нь гэвэл, тэрээр Ариун Сүнсийг хамгийн дээд эрх мэдэл гэж тунхаглахыг хүссэн. Ариун Сүнс Өөрийн хүмүүсийг ариун бичвэрүүдээр дамжуулан бүх үнэн рүү хөтөлдөг гэж ойлгуулахыг хүссэн. Бүх сургаалыг Библиэр шалгах ёстой. Хэрэв уг сургаал Библи дээр нэмж байвал, Библитэй эн тэнцүү эрх мэдэлтэй гэж байвал, Библитэй зөрчилдөж байвал, тэр сургаалаас татгалзах ёстой.

## 4 сарын 11

*“Тэд ахлагчидтай чуулж зөвлөлдөөд, цэргүүдэд их мөнгө өгч, ‘Шавь нар нь шөнө ирээд, биднийг унтаж байх зуур Түүнийг хулгайлчихлаа’ гэж та нар хэл...гэв.”* (Мт 28:12,13)

Эзэн Есүс үхлээс амилсан даруйд дайснууд нь гайхамшгийг нь тайлбарлах худал хуурмагийг зохиож эхэлсэн. Тэдгээр худал хуурмагийн хамгийн шилдэг нь, шавь нар шөнөөр ирээд цогцсыг нь хулгайлчихлаа гэдэг цуу яриа билээ. (Есүс үнэндээ үхээгүй, ухаан алдсан байсан гэж үздэг таамаг хэдхэн зуун жилийн өмнө гарч ирсэн.) Харамсалтай нь, цогцос хулгайлагдсан гэх онол бусад онолуудын адил, хариулт өгөхөөсөө нэмэлт асуултуудыг үүсгэдэг. Жишээлбэл:

Ахлах тахилчид болон ахлагчид хоосон булшны талаарх харуулуудын эхний мэдээг яагаад лавлаж асуусангүй вэ? Тэд үүнийг үнэн гэж хүлээн зөвшөөрсөн нь илэрхий байна. Тиймдээ ч гуйвуулах гэж худал тайлбар яаравчлан зохиосон.

Цэргүүд манаанд гарч байж яагаад унтав? Ромын хууль ёсоор манаан дээр унтсан цэрэгт үхэх ял оноодог. Тэднийг шийтгэлээс мулталж өгнө гэж амласан. Яагаад?

Бүх цэргүүд яаж нэг зэрэг унтав? Тэд бүгдээрээ үхлийн шийтгэлээс айхгүй унтацгааж байсан гэж үү?

Шавь нар харуулуудыг сэрээхгүйгээр чулууг хэрхэн өнхрүүлсэн бэ? Чулуу нь дэндүү том тул чимээ гаргахгүй хөдөлгөх боломжгүй юм.

Шавь нар чулууг яаж хөдөлгөж чадав? Херодын үеийн булшны чулууг өнхрүүлсээр ховилд оруулан булшны амыг тагладаг байсан. Тиймээс нээх нь хаахаасаа илүү хэцүү

ажил байлаа. Дээрээс нь, Есүсийн булшийг Ромын эрх мэдлээр “лацадсан” байлаа.

Саяхан амиа алдахаас айн зугтаж байсан шавь нар Ромын харуулуудтай тулалдаж, булшийг нь дээрэмдэх зориг гаргах байсан болов уу? Ийм гэмт хэрэгт хатуу шийтгэл онооно гэдгийг тэд мэдэхийн дээдээр мэдэж байсан.

Хэрэв цэргүүд бүгд унтаж байсан бол шавь нар нь цогцсыг хулгайлсан гэдгийг яаж мэдсэн юм бэ?

Хэрэв шавь нар цогцсыг хулгайлсан юм бол даавууг тайлж, эвхэж тавих гэж юунд цаг алдав? (Лк 24:12; Иох 20:6,7). Шавь нар яагаад цогцсыг хулгайлахыг хүсэв?

Тэдэнд тэгэх шалтгаан байхгүй. Харин ч тэд, Есүсийг амилсан гэж сонсоод гайхаж балмагдан итгэж чадаагүй.

Эцэст нь хэлэхэд, шавь нар нь амилал худлаа гэдгийг мэдсээр байж, амь насаараа дэнчин тавин үүнийг тунхаглах уу? Пол Литл, “Хүн худлааг нь мэдсээр байж түүнийхээ төлөө амиа өгдөггүй юм” гэж хэлсэн. Тэд Есүсийг амилсан гэдэгт чин сэтгэлээсээ итгэсэн байжээ. Эзэн амилсан! Тэр үнэхээр амилсан!

## 4 сарын 12

*“Иймээс хэрэв та нар шударга бус эд баялагт итгэмжтэй байгаагүй бол хэн та нарт жинхэнэ баялгийг даатгах билээ?” (Лк 16:11)*

Шударга бус эд баялаг гэж дэлхийн баялаг, материаллаг эд зүйлийг хэлж байна. Маш их материаллаг эд хөрөнгөтэй хүнийг баян гэж үзэхээс илүү төөрөгдөл үгүй билээ. Бид байшин, газрыг жинхэнэ хөрөнгө (үл хөдлөх хөрөнгийг англиар real estate буюу жинхэнэ хөрөнгө гэдэг) гэж нэрлэдэг. Учир нь тэднийг бид жинхэнэ эд хөрөнгө гэж үздэг байна. Бид хувьцаа, бондыг баталгаа (үнэт цаасыг англиар security буюу баталгаа гэдэг) гэж нэрлэдэг. Учир нь бид тэднийг баталгаа гэж үздэг байна.

Тэгвэл Лук 16:11-д Эзэн шударга бус эд баялгийг жинхэнэ баялгаас ялгаж байна. Хүмүүсийн баялаг гэж боддог зүйл үнэндээ баялаг биш ажээ.

Жон нь чинээлэг язгууртны өмчийг хариуцдаг сүсэгт христэч байлаа. Нэг шөнө Жон зүүдэндээ, хотынх нь хамгийн баян хүн маргааш шөнө дундаас өмнө нас барна гэж сонсжээ. Жон өглөө нь даргадаа зүүдээ ярих. Эхэндээ саятан тэр яриаг тоогоогүй мэт дүр эсгэв. Өнөөдрийнх шиг эрүүл чийрэг мэдрэмж төрж байсангүй гэж хэлэв. Баян эр ч зүүдэнд итгэдэггүй ажээ.

Харин Жоныг гараад удаагүй байхад баян эр жолоочоо дуудаад эмнэлэг орлоо. Тэрбээр эмчийн үзлэгт бүрэн хамрагдав. Бодож байсанчлан, шинжилгээний хариугаар бүх юм сайн гарлаа. Гэсэн ч тэр Жонын зүүдийг бодон санаа зовсоор байсан тул эмчийн өрөөнөөс гарахдаа “Эмч ээ, та өнөө орой манайд зочилж оройн хоол идэж болох уу?



Манай гэрээр зочлооч” гэж гуйлаа. Эмч урилгыг хүлээн авав.

Оройн хоол ч болдог журмаараа болж, тэд олон сэдвээр яриа өрнүүллээ. Эмч явах гэж хэд хэдэн удаа боссон боловч гэрийн эзэн тухай бүрд нь саатуулсаар байлаа.

Эцэст нь цаг шөнө дундыг заахад бурхангүй баяны санаа амарч, эмчийг үдэн гаргалаа.

Түүнээс хэдхэн минутын дараа хаалганы хонх дуугарлаа. Баян эр хаалгаа тайлтал Жонын том охин зогсож байх нь тэр. “Эрхэм ээ, аав минь дөнгөж сая зүрхний шигдээсээр нас барчихлаа. Энэ мэдээг танд хэлээд ир гэж ээж намайг явууллаа” гэж хэлэв.

Хотын хамгийн баян хүн тэр шөнө нас баржээ.

## 4 сарын 13

*“Тиймээс та нар идсэн ч, уусан ч, юу ч хийсэн Бурханы алдрын төлөө бүхнийг хий.” (1Ко 10:31)*

Христэд итгэгчийн хийж болох болохгүй зүйлийг тодорхойлох нэг сайн шалгуур бол “Энэ нь Бурханыг алдаршуулах уу?” гэдэг асуулт юм. “Энэ зүйлд хор хөнөөл байна уу?” гэж ихэвчлэн асуудаг нь тохиромжгүй. Харин “Бурханыг алдаршуулах зүйл байна уу?” гэж асуух хэрэгтэй.

Аливаа ажлыг хийхээсээ өмнө Эзэний өмнө толгой гудайн, үүгээр дамжуулан Та Өөрийгөө алдаршуулаач гэж гуйгаарай. Хэрэв Бурхан түүгээр хүндлэгдэж чадахгүй бол түүнийг хийхээс татгалз.

Бусад шашин хор хөнөөлгүй зүйлийг хийснээрээ ханаж болох юм. Харин христитгэл муугаас зайлахад төвлөрдөггүй, харин сайныг үйлдэхэд төвлөрдөг. Кэйт Л. Брукс ингэж хэлсэн: “Хэрэв та итгэлээр өсмөөр байвал мууг агнах ажлаа зогсоо. Харин сайныг эрэлхийл. Аз жаргалтай амьдармаар байвал “хор хөнөөлөөс” зугтагсадтай биш, сайныг үйлдэхийг эрмэлзэгсэдтэй нийл.”

Өөртөө хор хөнөөл агуулдаггүй боловч христэч уралдаанд төвөг учруулах зүйл гэж бий. Олимпын тамирчин 1500 метрийн уралдаанд шуудайтай төмс үүрч болохгүй гэсэн хууль байхгүй. Тэр ачааг үүрч болох ч уралдаандаа ялахгүй нь ойлгомжтой. Энэ зарчим итгэгч бидэнд мөн адил. Зарим зүйл хор хөнөөлгүй боловч тээг саад болж болно.

“Энэ зүйл хор хөнөөлтэй юу?” гэдэг асуулт нь далд эргэлзээг маань илчилдэг. Залбирал, Библи судлал, мөргөл,

гэрчлэл, өдөр тутмын ажил зэрэг илэрхий зөв зүйлсийн талаар бид асуулт асуудаггүй шүү дээ.

Дашрамд дурдахад, аливаа хүндтэй ажил бүхнийг Бурхны алдрын төлөө хийж болдог. Гийм ч учраас зарим гэрийн эзэгтэй гал тогооны угаалтуур дээрээ “Бурханы үйлчлэл энд өдөрт гурван удаа явагддаг” гэсэн уриа үгийг бичиж тавьдаг.

Хэзээ нэгэн цагт эргэлзээ төрвөл Жон Уэслигийн ээжийн зөвлөгөөг дагаарай: “Хэрэв чи дур хүслээ зөв буруу эсэхийг тодорхойлж чадахгүй бол энэ дүрмийг баримтлаарай. Хэрэв оюун бодлыг булингартуулж, сэтгэлийн уян зөөлөн чанарыг алдагдуулж, Бурханд мэдрэг байхыг болиулж, сүнслэг юманд дурлах хүслийг бууруулж байвал, бие чинь сүнс сэтгэлийг чинь захирах тийшээ хандаад байвал, тэр чинь нүгэл мөн.”

## 4 сарын 14

*“...Та нарын дунд хэн чинь агуу болохыг хүснэ, тэр нь та нарын зарц болог. Мөн та нарын дунд хэн чинь тэргүүнд байхыг хүснэ, тэр нь та нарын боол болог.” (Мт 20:26,27)*

Жинхэнэ агуу байдал гэж юу вэ?

Энэ ертөнцийн хаант улсад агуу хүн гэдэг нь эд баялаг, эрх мэдлийн байр сууринд хүрсэн хүн юм. Түүнд тушаалыг нь дагадаг туслахууд байдаг. Хаана ч очсон тэрээр VIP үйлчилгээ авч, хүндлэл хүртдэг. Хүмүүс цол хэргэмээс нь болж түүнээс эмээж, түүнд хүндэтгэлтэй ханддаг. Тэр хэзээ ч дорд ажил хийхгүй. Тийм ажлыг өөр хүмүүс өмнөөс нь хийж өгдөг.

Харин бидний Эзэний хаант улсад бүх зүйл тэс өөр. Эзэний хаанчлалд агуу байдал нь үйлчлүүлдэг хэмжээгээр минь биш, харин бусдад үйлчилдэг хэмжээгээр минь үнэлэгддэг. Агуу хүн бусдын боол болдог. Түүний хувьд дэндүү дорд ажил гэж үгүй. Тэрээр тусгай үйлчилгээ, талархал магтаал хүлээдэггүй. Жорж Вашингтон хар бор ажил хийж буйг нэг цэрэг нь хараад, “Генерал аа, та ийм ажил хиймгүй том хүн шүү дээ” гэхэд Вашингтон “Үгүй дээ, би ердийн хэмжээтэй хүн” гэсэн гэдэг.

Рой Хэшинь, Лук 17:7-10-ыг тайлбарлаж байхдаа боолын таван тэмдгийг бидэнд хэлж өгчээ. Үүнд: (1) Ажил нэмж өгсөн ч үг дуугүй хийдэг байх. (2) Хийсэн ажлынхаа төлөө талархал магтаал горьдохгүй байх. (3) Ажлаа хийж дуусгачхаад Эзэнээ хувиа хичээсэн этгээд гэж үл буруутгах. (4) Дорой нэг муу боол гэдгээ хүлээн зөвшөөрөх. (5) Ажлаа уур унтууцалгүй, дорд даруу сэтгэлээр хийж, өөрөө дур мэдэн юм хийхгүй байх.

Эзэн маань хүн болохын тулд цог жавхлангийн дээдийн дээд байр суурийг орхихдоо “боолын дүрийг авсан” (Флп 2:7). Тэрээр хүмүүн төрөлхтний дунд зарц боолын адилаар амьдарсан (Лк 22:27). Тэрээр, “Хүний Хүү үйлчлүүлэхийн тулд бус, харин үйлчлэхийн тулд мөн олны төлөө амиа золиос болгон өгөхийн тулд ирсэн билээ” гэж хэлсэн (Мт 20:28). Тэрээр алчуур авч, боолын хормогч өмсөөд, шавь нарынхаа хөлийг угаасан (Иох 13:1-17).

“Боол нь эзнээсээ илүү агуу биш.” (Иох 13:16). Хэрэв Тэр бидэнд үйлчлэхийн тулд дорд болсон юм бол, яагаад бид бусдад үйлчлэхийг дорд хэрэг гэж үзнэ гэж?

*Гэм үгүй Аврагч минь Та дорд даруу байв  
Гэтэл өт хорхой мэт над шиг хүн  
Гэм нүгэлтэй, сул дорой, бузар хүн  
Өөрийгөө өргөмжилж яахин зүрхлэх вэ?*

## 4 сарын 15

*“Бие биендээ хайраар үйлчил.”* (Гал 5:13)

“Би төвтэй хүн өөрийгөө агуу гэж үздэг бөгөөд үйлчлүүлэх ёстой гэж боддог. Харин хайр бусдад үйлчилдэг учраас үнэндээ агуу юм” гэж нэгэн хүн хэлжээ.

Алдартай магтан дуучин ресторанд сууж байхдаа дэргэдэх хүндээ сайнмэдээг хуваалцаж, түүнийг Христ уруу дагуулж чаджээ. Дараагийн хэдэн долоо хоногт тэрээр шинэ итгэгчийг дагалдуулав. Шинэ итгэгчийг Фрэд гэнэ. Харамсалтай нь, Фрэд эдгэшгүй хорт хавдар тусч, эмнэлэгт хэвтлээ. Хэвтсэн эмнэлгийн үйлчилгээ тун муу байлаа. Магтан дуучин, радиогийн олны танил маань түүнийг итгэмжтэйгээр эргэж, орны даавууг нь сольж өгч, найзыгаа усанд оруулж, хооллож, шаардлагатай олон зүйлийг хийж өгчээ. Ингээд нэг шөнө нэрт дуучин маань Фрэдийн гараас атгаад “Бие биендээ хайраар үйлчил” гэх тайтгарлын үгийг Библиэс хэлээд найзыгаа эцсийн замд нь үджээ.

Библийн сургуулийн багш өглөөний яарал сандралын дараа эрчүүдийн өрөө нул ус болдгийг анзаарчээ. Тэрээр өрөөг тэвчээртэйгээр цэвэрлэж, доош бөхийн шалыг нь арчдаг байлаа. Тэр багш хичээлээ ч сайн заадаг байв. Харин оюутнууд нь хүндтэй багшийнхаа үлгэр жишээгээр даруу болж, ухаажсан билээ. “Бие биендээ хайраар үйлчил.”

Уг Библийн сургуулийн сагсан бөмбөгийн багийн нэг гишүүн жинхэнэ зарцын зүрх сэтгэлтэй байлаа. Тоглолт дууссаны дараа хүн бүр эхэлж шүршүүрт орох гэж яардаг бол нөгөө залуу маань зааланд үлдээд бүх юмыг эмхэлж цэгцэлж маргашид бэлэн болгодог байж. Бусад нь

өөрсдийгөө нэгт тавьж байгаа нь, Эзэнтэй адил бүгдийн зарц болох боломжийг түүнд олгожээ. “Бие биендээ хайраар үйлчил.”

Туркийн хөдөө нутгийн нэгэн христэч ээж өвчтэй хүүдээ бөөрний донор болохоор Лондонд очжээ. Бөөрөө өгөх нь түүний амь насанд аюултайг тэр мэдэж байлаа. Англи эмч түүнээс, хүүдээ бөөрөө өгөхөд бэлэн үү гэж асуухад тэр ээж “Би хоёр бөөрөө өгөхөд ч бэлэн байна” гэж хариулсан юм. “Бие биендээ хайраар үйлчил.”

Хувийн ашиг сонирхол ноёлсон дэлхийд амин хувиа хичээдэггүй, золиос гаргахад бэлэн хүн тийм ч олон биш. Тиймээс зарцын зүрх сэтгэлээр ажиллах боломж өдөр бүр хаа сайгүй гардаг.

## 4 сарын 16

“...үхэгсэд шиг боловч, харагтун, бид амьд...” (2Ко 6:9)

Библи парадоксуудаар дүүрэн. Парадокс гэдэг нь бидний бодлогоос өөр юм уу бие биетэйгээ логикийн хувьд зөрчилддөг үнэнүүдийг хэлдэг. Г. К. Честертоны тодорхойлсноор парадокс нь хүний анхаарлыг татах гэж үнэнийг урвуугаар мэдэгдэхийг хэлдэг байна. Тэгвэл бидний анхаарлыг татах гэсэн Библийн парадоксуудаас энд дурдъя.

Бид алдвал амиа олдог. Амиа хайрлавал алддаг. (Мк 8:35)

Бид сул дорой байхдаа хүчирхэг (2Ко 12:10), хүчирхэг байхдаа сул дорой (Иох 15:5).

Бид Христийн боол байхдаа жинхэнэ эрх чөлөөг олж, Христийн буулгаас чөлөөтэй байхдаа боолчлуулдаг (Ром 6:17-20).

Бид байгаагаа хуваалцах тусам баяр хөөртэй болдог. “Авахаасаа өгөх нь илүү ерөөлтэй” гэж Эзэн айлдсан (Үйл 20:35).

Бид байгаагаа хуваалцвал илүү баяждаг. Харамлавал улам ядуурдаг (Сур 11:24).

Бидэнд нүгэл хийж чаддаггүй шинэ хүн байдаг (1Ио 3:9), тэгсэн мөртөө хийдэг бүхэн маань нүглийн толботой (1Ио 1:8).

Бид бууж өгснөөр ялалт байгуулдаг (Эх 32:24-28), тэмцэлдвэл ялагддаг (1Пт 5:5).

Бид өөрийгөө өргөмжилбөл дорд болгогддог, өөрсдийгөө даруу болговол Бурхан биднийг өргөмжилдөг (Лк 14:11).



Бид дарамт шахалтаар улам тэлдэг (Дуу 4:1), амжилттай байхаар улам хумигддаг (Иер 48:11).

Бид бүгдийг эзэмшдэг боловч юу ч үгүй. Ядуу боловч олныг баяжуулдаг (2Ко 6:10).

Бид (хүний нүдэнд) мэргэн үедээ (Бурханы нүдэнд) мунхаг болдог. Бид Христийн төлөө мунхаг болох үедээ үнэхээр мэргэн болдог (1Ко 1:20,21).

Итгэлийн амьдрал нь зовнил, санаа зоволтоос чөлөөлдөг. Харснаараа явдаг амьдрал нь хорхой, зэв, хулгайчид хамгаа алдахаас айх айдсыг авчирдаг (Мт 6:19).

Христэч амьдралыг эхнээсээ эцэс хүртлээ парадокс хэмээсэн нэг шүлэг бий:

*Явах зам минь хэчнээн хачин!*

*Туулах жим минь ямар гайхмаар!*

*Жаргалын найдварыг айдаст мөчөөс олж*

*Мөнхийн амийг үхсэн Нэгнээс хүртэв.*

*Шударга зөв маань хүчин мөхөстөж*

*Шилдэг шийдвэр маань утгаа алдаж*

*“Би” гэсэн бүхэн маань үгүй болоход*

*Төгс аврал над дээр ирэв.*

*Нүгэл хилэнц маань уучлагдаж*

*Сэтгэл зүрхэнд минь амгалан ирж*

*Одоо л нэг боллоо гэтэл*

*Жинхэнэ тэмцэл дөнгөж эхлэв.*

## 4 сарын 17

*“Та нар ‘Багш аа’ гэж битгий дуудуул. Та нарын Багш ганц бөгөөд та нар бүгд ахан дүүс билээ. Газар дээр хэн нэгнийг эцгээ болгож битгий дууд. Учир нь та нарын Эцэг ганц бөгөөд Тэр тэнгэрт буй. Та нар удирдагчид гэж битгий дуудуул. Та нарын Удирдагч ганц бөгөөд Тэр нь Христ юм. (Мт 23:8-10 АБ2004)*

Эзэн Есүс хүмүүний “би” үзлийг тэтгэсэн өндөр дээд цол гуншингаас зайлсхийж явахыг анхааруулсан. Гурвалыг хүмүүнээр орлуулж болохгүйг хэлсэн. Бурхан бол бидний Эцэг, Христ бол бидний Эзэн, Ариун Сүнс бол бидний Багш. Энэ эрхэм алдар нэрсийг бид Чуулганд өөрсдөдөө өгч, өөрсдийгөө хүндлүүлэх нөхцөлийг бүрдүүлж болохгүй. Мэдээж бидэнд энэ биеийг төрүүлсэн аав гэж бий. Ажил дээр минь дарга, эзэн гэж бий. Сургууль дээр минь багш нар бий. Харин сүнслэг талбар дээр Бурханы Гурвал эдгээр үүргийг гүйцэтгэдэг бөгөөд тийн хүндлүүлэх ёстой юм.

Бурхан амь амьдралыг Өгөгч гэдэг утгаараа бидний Эцэг. Христ биднийг эзэмшдэг, бид Түүний харьяат учраас бидний Эзэн. Библийн Бичээч ба Тайлбарлагч гэдгээр Ариун Сүнс бидний Багш. Бүх сургаал маань Түүний удирдамжаар байх ёстой.

Гэтэл энэ нэр алдрыг чуулганууд өргөнөөр хэрэглэдэг. Христ тэдэнд энэ талаар юу ч хэлээгүй мэт хэрэглэцгээдэг. Санваартнууд ба номлогчдыг Эцэг ба Падре гэж дууддаг. Заримдаа Эзэн гэсэн утгатай Доминэ гэдэг нэрээр нэрлэдэг. Чуулганы үйлчлэгчдийг англиар Reverend буюу “биширмээр, сүрдмээр, хүндлүүштэй” гэж өргөмжилдөг.

Уг нь Библид энэ үгийг зөвхөн Бурханд хамаатуулан хэлжээ (Дуу 111:9 “Түүний нэр ариун болоод сүрдмээр билээ.”). Доктор гэж цол латин хэлний докере буюу заах гэсэн үгнээс гаралтай. Тэгэхээр доктор гэдэг нь багш гэсэн үг юм. Энэ цол нь хүндэтгэлийн утгатай ч бай, эрдмийн зэрэг ч бай, христитгэлийн хүрээнээс бус, үл итгэгчдийн дотроос гаралтай. Гэтэл эдүгээ чуулганд доктор гэгдэх хүмүүс олон болжээ. Ийм зэрэг цолтой учраас түүний үг илүү эрх мэдэлтэй байх ёстой юм гэнэ. Мэдээж энэ бүхэн Библийн ямар ч үндэслэлгүй. Ариун Сүнсээр дүүрсэн энгийн нэгэн хог түүгч Бурханы сургаалыг тэднээс илүү зөв ярих байх шүү!

Христитгэлийн бус ертөнцөд цол гуншин, зэрэг дэв байдаг. Энэ нь “Айж эмээвэл зохих хүнээс айж эмээ, хүндэтгэл хүлээх ёстой хүнийг хүндэл” (Ром 13:7) гэсэн зарчимд нийцнэ. Харин чуулганы баримтлах зарчмыг Эзэн ингэж хэлсэн: “Та нар бүгд ахан дүүс билээ.” (Мт 23:8)

## 4 сарын 18

*“Бид одоо толинд бүдэг бадаг хардаг...” (1Ко 13:12)*

Бидний төлөө амиа өргөсөн Эзэнийгээ дурсахаар Эзэний зоогийг барих үед маань заримдаа энэ үг бодитой харагддаг. “Бид одоо толинд бүдэг бадаг хардаг.”

Яг л үл нэвтрэх зузаан хөшиг урдуур минь татсан мэт! Хязгаарлагдмал оюун ухаан маань хөшигний нэг талд байна. Биднийг аварсан золилтын агуу үйл явдал, Бетлехем, Гетсемани, Габбата, Голгота, хоосон булш, Бурханы баруун талд сууж буй Христ хөшигний нөгөө талд байна. Тэнд өргөн уудам зай байдгийг мэддэг ч, үүнийг ухаарч ойлгохыг чадлаараа хичээвч, бид амьд хүн биш чулуун хөшөө болсон мэт мэдрэмж төрөх нь олон.

Нүглийн маань төлөө Аврагч ямар их зовлон эдэлснийг ойлгох гэж хичээдэг ч, Бурханд орхигдсон тэр аймшгийг ухаарах гэж яддаг ч, мөнхийн шийтгэлийг маань Тэр эдэлснийг мэддэг ч, мэддэг бүхэн маань бүрэн гүйцэт биш гэдгийг ч мэддэг. Бид бүрэн судлаагүй далайн эрэг дээр зогсож байх шиг санагддаг.

Тэнгэрийн охь нь газрын хог шаарны төлөө хайраа илгээжээ. Бурхан алдагдсаныг хайж аврахын тулд нүгэлт ертөнц рүү цорын ганц Хүүгээ явуулжээ. Гэвч тэр нь мэдлэгийг давсан хайр билээ. Бид ердөө хэсэгхэнийг мэдэж чадна.

Баян атлаа бидний төлөө ядуурч, биднийг баян болгохын тулд Өөрөө ядуурсан Аврагчийн нигүүлслийг бид дуулдаг. Тэнгэрэлч нар хүртэл түүнийг нь амьсгаа даран ширтсэн. Харамсалтай нь, энэ нигүүлслийн хэчнээн өргөнийг харъя хэмээн нүдээ чилтэл ширтэвч бид харж

чаддаггүй. Учир нь хүмүүн бидний хараа хязгаарлагдмал ажээ.

Голгота дахь Христийн тахилыг бодож ялалт байгуулах ёстойгоо мэддэг ч олон тохиолдолд сэтгэл минь хөдөлдөггүй. Өмнө маань байгаа хөшигний цаана гарвал нулимс маань урсахгүй байхын аргагүй. Гэтэл заримдаа:

*Биднийг хайрласан Хурга*

*Цусаа урсган амиа өргөснийг харсаар байж*

*Огтхон ч сэтгэл минь хөдөлдөггүй*

*Би ер нь ямар гээч хүн бэ!* гэж хэлмээр болдог.

Аль эсвэл:

*Христ ээ, загалмайн тань доор зогсоод*

*Дусал дуслаар урсах цусыг тань харсан ч*

*Сэтгэл минь шимширч уйлдаггүй би*

*Хүн биш чулуунаас өөр юу байх билээ?* гэж асуумаар болдог.

Еммау тосгон уруу явж байсан хоёр шавийн нүд нээгдсэн шиг бидний нүд ч бас нээгдэх болтугай! Хөшиг авагдаж, хугачсан талх, урссан дарсны утга учрыг илүү тод харах үеийг бид халуун сэтгэлээр хүсэн хүлээх болтугай!

## 4 сарын 19

*“Та нар мөнх амьтай гэдгээ мэдээсэй гэсэндээ би Бурханы Хүүгийн нэрд итгэдэг та нарт үүнийг бичлээ.” (1Ио 5:13)*

Авралын баталгаа нь мэдрэмжээр бус, зөвхөн Бурханы Үгээр дамжуулж ирдэг гэдгийг заасан учраас энэ эшлэлийн төлөө бид Бурханд үүрд талархах учиртай. Бурханы Хүүгийн нэрд итгэдэг хүн мөнх амьтай гэдгээ мэдэх гол үндэслэл бол Библи гэдгийг энд хэлсэн.

Авралын баталгаа нь сэтгэл хөдлөлөөс ирдэггүй нь юутай талархмаар! Учир нь сэтгэл хөдлөл өдөр бүр өөрчлөгддөг. “Надад сайхан мэдрэгдэж байгаа болохоор Бурханд талархъя” гэж хэлэхийг Бурхан хүсдэггүй. Харин Есүс рүү болон Түүний үг рүү хараагаа талбиасай гэж хүсдэг. Нэг удаа Мартин Лютерээс “Нүгэл чинь уучлагдсан юм шиг санагдаж байна уу?” гэж асуужээ. Мартин Лютер хариуд нь “Үгүй ээ. Тэнгэрт Бурхан байдаг нь үнэн адил би аврагдсандаа бат итгэлтэй байна. Сэтгэл хөдлөл байнга өөрчлөгдөж байдаг. Харин миний баталгаа бол Бурханы үг. Бурханы үгээс өөр итгэл даах зүйл үгүй” гэж хэлсэн. С. И. Скофилд “Арвалын баталгаа нь итгэгчийн мэдрэлийн тогтолцоонд биш, харин Бурханы бодол дотор явагддаг” гэж сануулсан. Х. А. Айронсайд “Би аз жаргалтай учраас аврагдсан юм биш, харин аврагдсан гэдгээ мэддэг учраас аз жаргалтай байдаг” гэж хэлсэн. Айронсайд Бурханы бичмэл үгээс аврагдсан гэдгээ мэдэж авсан юм.

Сүнс биднийг Бурханы хөвгүүд гэдгийг бидний сүнстэй хамт гэрчилдэг гэдгийг (Ром 8:16) унших үедээ Сүнс Библиэр дамжуулан гэрчилдэг гэдгийг санаж байх

ёстой. Жишээ нь Иохан 6:47-д “Надад итгэдэг хүн мөнх амьтай” гэж бичигдсэн. Бид Христэд итгэсэн учраас мөнхийн авралтайгаа мэдэж байна. Тэр бол мөнхийн улсад орох цорын ганц найдвар маань юм. Тиймээс Бурханы Сүнс биднийг Бурханы хүүхдүүд гэдгийг энэ эшлэлээр дамжуулан гэрчилж байна.

Мэдээжийн хэрэг, авралын баталгааг харуулах өөр зүйлс ч бий. Бид ах дүүстээ хайртай учраас, нүглийг үзэн ядаж, шударга зөвийг үйлддэг учраас, Бурханы үгийг хайрладаг учраас, залбирах хүсэлтэй учраас аврагдсан гэдгээ мэддэг. Гэхдээ авралын баталгааны анхны бөгөөд гол үндэслэл бол Бурханы үг юм. Бурханы үг нь хорвоогийн хамгийн найдвартай зүйл билээ. Жорж Каттинг “Аврал, Баталгаа, Баяр хөөр” номдоо, “Цус биднийг аварч, Библи бидэнд баталгаа өгсөн” гэж хэлсэн нь үнэхээр үнэн.

## 4 сарын 20

*“Хэрэв энэ нь нигүүлслээр юм бол цаашид үйлсээр биш ажээ. Эс тэгвэл нигүүлсэл нь нигүүлсэл биш болно.”* (Ром 11:6)

Хүн нигүүлслийн сургаалыг хэдий чинээ эрт хүлээн авна, амьдралд ирэх олон бэрхшээлээс өөрийгөө аварна. Аврал нь Бурханы нигүүлслийн үнэгүй бэлэг бөгөөд үүнийг хүртэх зохисгүй хүмүүст өгөгджээ. Мөнх амийг гавьяат үйлс, буянаар олж авдаггүй. Өөрөө үнэ цэнэгүй боловч Аврагчийн үнэ цэнийг хүлээн авсан хүмүүст мөнх амь өгөгддөг.

Аврал нь зөвхөн нигүүлслийн улмаас ирдгийг олж харвал, хөдөлшгүй баталгаатайг ойлгоно. Бид аврагдсан гэдгээ мэдэж болно. Хэрэв аврал нь бидний хичээл зүтгэлээс хамаардаг бол аврагдсан гэдгээ баттай мэдэх ямар ч боломжгүй. Яагаад гэхээр, хангалттай сайн хийсэн эсэхээ, зөв үйлдсэн үгүйгээ мэдэж чадахгүй. Харин аврал нь Христийн ажилд суурилбал, бидэнд эргэлзэх зүйл үгүй.

Мөнхийн аюулгүй байдлын тухайд ч энэ зарчим адил. Хэрэв бидний аюулгүй байдал нь бидний өөрсдийн хүчин зүтгэлээс хамаардаг бол бид өнөөдөр аврагдлаа ч маргааш алдаж магадгүй юм. Гэхдээ аюулгүй байдал маань Аврагчийн хүч чадлаас хамаардаг учраас бид мөнхөд аюулгүй гэдгээ мэдэж чадна.

Нигүүлслийн дор амьдардаг хүмүүс нүглийн дураар хөдөлдөг шатрын хүү төдийхөн биш юм. Нүгэл нь хуулийн доорх хүмүүсийг захирдаг. Яагаад гэвэл хууль хүнд юу хийх ёстойг заадаг боловч хийх хүчийг өгдөггүй. Нигүүлсэл нь хүмүүнд Бурханы өмнө төгс байр суурийг



өгч, түүнийг байр сууриндаа зохистой явахыг уриалж, Ариун Сүнсээр дамжуулан тийн явах хүчийг өгч, тийн явсных нь төлөө шагнадаг.

Нигүүлслийн доорх үйлчлэл нь хуулийн боолчлол албадлага бус, харин баяр баясгалант завшаан болой. Итгэгч хүн айдсаар бус хайраар хөтлүүлдэг. Аврагч маань авралыг өгөхийн тулд ямар зовлон эдэлснийг санахаар өөрийн эрхгүй амь амьдралаа Эзэндээ зориулах сэтгэлтэй болдог.

Нигүүлсэл нь талархал, мөргөл, магтаал, хүндэтгэлээр амьдралыг баяжуулдаг. Аврагч гэж хэн бэ, нүгэлтэн бид ямар мөн чанар, дадал хэвшилтэй вэ, Тэр бидний төлөө юу хийсэн бэ гэдгийг мэдэхээр зүрх сэтгэл минь Түүнийг хайрлан хүндлэх хайр бахдалаар дүүрнэ.

Бурханы нигүүлсэлтэй эн зэрэгцэх юу ч үгүй. Нигүүлсэл бол Бурханы хамгийн агуу зан чанар юм. Бурханы бүрэн эрхт нигүүлсэлд бат суурил. Тэгвэл амьдрал чинь бүрэн өөрчлөгдөх болно.

## 4 сарын 21

*“Шавь нь багшийнхаа дээр байдаггүй. Бүрэн суралцах аваас хэн ч багш шигээ болж болно.” (Лк 6:40)*

Бусдыг дагалдуулах үед дагалдагчдын сүнслэг түвшин багшийнхаасаа илүү гарч чадахгүй гэж Эзэн Есүс арван хоёртоо сануулж байна. Өөрөөр хэлбэл, бид өөрсдийн хэмжээнээс илүү гарсан сайн нөлөөг бусдад үзүүлж чадахгүй гэсэн үг. О. Л. Кларкийн хэлснээр “Та мэдэхгүй зүйлээ зааж чадахгүй. Очиж үзээгүй газар уруугаа бусдыг хөтөлж чадахгүй.”

Аврагч маань энэхүү сургаалаа улам тодруулж дүнз ба үртэсний жишээг ярьсан. Нэг хүн үтрэмийн хажуугаар өнгөрч явтал салхи дэгдэж ширхэг сүрэл нүд рүү нь хөндөлдөөд орчихжээ. Тэрээр нүдээ нухаж нэг үзэв. Зовхио татаж чангааж, сүрлийг гаргах гэж оролдов. Сүрэл нүднээс нь гарсангүй. Тэгсэн мөртөө нүдэнд нь үртэс торсон найздаа үртсийг яаж авах талаар зөвлөж байх юм гэнэ. Тэгэхэд нь нүдэндээ дүнз оруулсан би түүн рүү дөхөж ирээд “Анд минь, наад жаахан юмыг чинь яаж нүднээсээ авахыг чамд хэлж өгье” гэж хэлэв. Өнөөх хүн над руу юм тороогүй нүдээрээ харснаа “Эхлээд чи нүдэн дэх дүнзээ авбал дээргүй юу?” гэж хэлнэ.

Мэдээж шүү дээ! Өөрөө салж чадахгүй нүглээсээ бусдыг салгана гэдэг боломжгүй юм. Бурханы үгийг өөрөө дагадаггүй байж бусдыг дагадаг болгоно гэвэл бүтэхгүй. Амьдралын минь ямар талбарт нүгэл байна, тэр талбартаа би дугарах эрхгүй болдог.

Дагалдагч маань миний сургалтыг дуусгалаа гэхэд миний сүнслэг хэмжээнээс илүү гарна гэж бодох хэрэггүй.

Тэрээр миний түвшинд хүрч болох ч түүнээс илүү түвшинд түүнийг би хүргэж чадахгүй.

Тэгэхээр бид өөрсдөдөө анхаарах ёстойг эндээс ухаарах ёстой. Бидний үйлчлэл нь зан чанарын үйлчлэл билээ. Энэ төрлийн үйлчлэлд дотоод хүн чухал байдаг. Бид мэдлэгтэй, боловсролтой, ярихдаа сайн байж болно. Гэхдээ амьдралд маань ямар нэг дуулгаваргүй байдал байвал бусдыг дагалдуулах ажил маань сохор сохроо дагуулахтай агаар нэгэн буюу.

## 4 сарын 22

*“Хэрэв та Есүсийг Эзэн гэж амаараа хүлээн зөвшөөрч, Бурхан Түүнийг үхэгсдээс амилуулсан гэдэгт зүрхэндээ итгэвэл, аврагдах болно.” (Ром 10:9)*

Сайнмэдээний утга агуулсан, хүмүүсийн сайн мэддэг энэ эшлэл, нүгэлт хүмүүний хүлээн зөвшөөрөх дургүй хоёр үндсэн үнэнийг тунхагладаг. Нэгт Бурхан хүн болсныг, хоёрт амиллыг. Энэ хоёр сургаалыг цохон тэмдэглэж байгаа бүхнийг хүлээн зөвшөөрөхгүйгээр аврагдах боломжгүй.

Юуны түрүүнд бид Есүсийг Эзэн гэж амаараа хүлээн зөвшөөрөх ёстой. Өөрөөр хэлбэл, Бетлехемд малын тэвшинд төрсөн Хүү бол махан биеэр илчлэгдсэн Бурхан гэж хүлээн зөвшөөрнө гэсэн үг. Авралын төлөвлөгөөнд Эзэн Есүсийн бурхан чанар хамгийн чухал юм.

Хоёрт, Есүсийг үхлээс Бурхан амилуулсан гэдэгт зүрхэндээ итгэх ёстой. Гэхдээ энэ нь амилалд итгэх төдийхөн биш. Эзэн Есүс нүгэлтний өмнөөс загалмай дээр амиа өргөсөн гэдэг баримт ч үүнд багтдаг. Тэрээр бидний нүглийн ялыг эдэлж, бидний үүрд амсах байсан Бурханы уур хилэнг амсаж үхсэн бөгөөд гурав дахь өдөрт Бурхан Түүнийг үхэгсдээс амилуулсан. Үүгээрээ бидний нүглийн төлөөх Христийн тахилд Бурхан бүрэн ханаснаа батлан харуулсан.

Бид Есүсийг Эзэн ба Аврагч хэмээн хүлээн авбал аврагдана гэж Библид хэлжээ.

Үүнийг сонсоод зарим хүн “Яагаад амаараа хүлээн зөвшөөрөх нь итгэхийн өмнө байгаа юм бэ? Бид эхлээд

итгээд дараа нь амаараа хүлээн зөвшөөрдөггүй гэж үү?” хэмээн асууж магад.

Паул 9-р эшлэлд түүхэн дарааллын дагуу ярьж байгаа юм. Христ эхлээд хүн болж мэндэлсэн. Амилал нь түүнээс гучин гурван жилийн дараа болсон.

Харин дараагийн эшлэлд, итгэх нь амаараа хүлээн зөвшөөрөхийн өмнө дурдагдсан. “Хүн зүрхэндээ итгэн зөвт байдалд хүрч, амаараа хүлээн зөвшөөрч авралд хүрнэ.” Энд бидний дахин төрөх дарааллыг өгүүлж байна. Бид эхлээд Аврагчид итгэлээ өгч зөвтгөгддөг. Дараа нь, хүлээн авсан авралаа амаараа хүлээн зөвшөөрдөг.

Энэхүү эшлэл маань авралын талаар чимэг хачиргүй энгийн атлаа мөнхийн мөнхөд шинээрээ байх үнэнийг өгүүлжээ. Тийм ч учраас ийм нэгэн хүүхдийн дуу байдаг биз ээ:

*Ром арвын ес бол*

*Миний дуртай эшлэл*

*Христийг Эзэн гэж зөвшөөрөөд би*

*Тэнгэрлэг нигүүлслээр аврагддаг.*

*Ром арвын ес дээр*

*Амлалтын сайхан үгс*

*Алтан үсгээр бичигдсэн байдаг.*

## 4 сарын 23

*“Иймээс Түүнийг доромжилсныг нь бид үүрэн, хуарангийн гадна гарч Түүн уруу очицгооё.” (Евр 13:13)*

Нэгт, Христ бол хүмүүсийнхээ цуглардаг төв гэдгийг энэ эшлэлээс ойлгож авдаг. Бид ямар нэг урсгал чиглэл, сүмийн барилга, агуу номлогч дээр цугладаггүй. Харин зөвхөн Христ дээр цугладаг. “Бүх хүн түүнийг дуулгавартай дагах болно.” (Эх 49:10). “Тахилаар дамжуулан Надтай гэрээ хийсэн бишрэлтнүүдийг минь Над уруу цуглуул.” (Дуу 50:5).

Бид хуарангийн гадна Түүн уруу очих ёстой гэдэг нь энэ эшлэлээс авах хоёр дахь сургамж. Энд гарч байгаа хуаран нь “төрөлх хүний таалан хүлээн авдаг дэлхийн бүх шашны тогтолцоо” юм. Энэ бол Христийг гутааж доромжилдог шашны ертөнц юм. Өнөөдөр христитгэлийн дүр өмссөн, хуурамч шүтээний бурангуй дэглэм юм. “Тэд итгэл сүсэгт дүртэй ч хүчийг нь үгүйсгэдэг.” (2Тм 3:5) Христ хуарангийн гадна байгаа тул бид Түүн уруу очих ёстой.

Мөн энэ эшлэлээс хуарангийн гадна гарч Христтэй уулзах нь доромжлол дагуулдаг гэдгийг харж болно. Эдүгээ чуулганы нөхөрлөлийн хэрэг явдалд Эзэнд дуулгавартай байлаа гээд доромжлол буруутгал хүлээн авдаг үзэгдэл итгэгч нарт тун ховор тохиолддог. Харин ч бүр Христийн цуглаанд явахаар нэр төр, байр сууринд хүрдэг болжээ. Гэтэл Шинэ гэрээний сургаалыг үнэхээр баримтлах тусам Христийг доромжилж байсан доромжлол бидэн дээр ч бууж эхэлдэг. Бид ийм золиос гаргахад бэлэн байна уу?

*Будагдсан хувцастай Хүн гадагш намайг дуудлаа  
Цовдлуулсан Эзэнийхээ дуу хоолойг би танилаа  
Тэр үнэхээр мөн байна, дотор үлдэж яахин болох вэ?  
Би Түүнийг дагах ёстой, дуулгавартай дагах ёстой.*

*Ертөнцөд гологдож, доромжлуулж, цаазлуулсан  
Түүнийг*

*Ертөнцийг захируулахаар Бурхан эрх чадлаараа  
амилуулжээ*

*Зүрх минь Түүнийг дээдлэн өргөмжилдгийг мэдсэн  
даруйдаа*

*Ертөнц намайг өөрийнхөө дотроос хөөж гаргалаа.*

*Миний Эзэн бид хоёрт хуаран гэж одоо үгүй*

*Гэхдээ зүгээр, Түүний оршихуй ертөнцийн юунаас ч  
сайхан*

*Нэгэн цагт би тэднийг Эзэнийхээ дуудлагаас илүү үздэг  
байсан ч*

*Одоо харин бүгдийг таягдан хаяад Түүний нэр дээр  
ирлээ.*

## 4 сарын 24

*“Хэрэв хэн нэг нь Бурханы сүмийг устгавал Бурхан тэр хүнийг устгана. Учир нь Бурханы сүм бол ариун бөгөөд энэ нь та нар мөн.” (1Ко 3:17)*

Энэ эшлэлд Бурханы сүм гэж нутгийн чуулганыг хэлж байна. Паул итгэгч хувь хүнийг бус, итгэгчдийн бүлгийг хэлсэн. Учир нь “энэ нь та нар (олон тоо) мөн” гэсэн. Коринтын ариун хүмүүс Бурханы сүмийг бүрдүүлж байлаа.

Мэдээжийн хэрэг итгэгч хувь хүн бол Ариун Сүнсний сүм мөн. Элч Паул үүнийг 1Коринт 6:19 дээр тодорхой хэлсэн: “Та нарын бие бол Бурханаас та нарт буй, дотор чинь байдаг Ариун Сүнсний сүм бөгөөд та нар ч өөрсдөө өөрсдийнх бус гэдгээ мэддэггүй юм уу?” Бурханы Ариун Сүнс нь Бурханы хүүхэд бүрийн биед оршдог.

Гэхдээ өнөөдрийн бидний эшлэлд Бурханы сүм нь чуулган юм. Тэгэхээр, хэн сүмийг устгана, Бурхан түүнийг устгана гэж Паул хэлж байгаа юм. Энэ эшлэлд нэг ижил үгийг англи орчуулгад эхлээд “[defile] бузарлах” дараа нь “[destroy] устгах” гэж орчуулжээ [монгол орчуулга хоёуланг нь “устгах” гэж орчуулсан]. Нэг ёсондоо алив нэг нутгийн чуулганыг онол сургаалын гажуудалд хүргэж, ариун амьдралаас холдуулж, зөв замаас хазайлгасан хүний дээр Бурханы сүйрэл буух болно. (В. Э. Вайн)

Тиймээс эшлэл маань нутгийн чуулганы нөхөрлөлийг талхлах нь хэчнээн ноцтойг сануулж байна. Үнэндээ энэ нь өөрийгөө хөнөөснөөс ялгаагүй. Гэсэн хэдий ч ингэж галаар нааддаг олон хүн бий. Жишээлбэл чуулганд юм бүхэн өөрийнх нь хүссэнээр болдоггүй нэгэн залуу байж. Эсвэл тэрээр өөр нэгэн итгэлийн ахан дүүтэйгээ зөрчилдсөн



байлаа. Харамсалтай нь тэрээр асуудлыг Библийн дагуу ном журамд нь оруулахын оронд бусдыг талдаа татаж, чуулган дотор бүлэглэл үүсгэдэг. Асуудал улам хурцадсаар эцэстээ чуулган хуваагддаг.

Эсвэл хаа сайгүй хов жив тарааж, бусдыг хэмлэх эмэгтэйг бод доо. Тэрээр чуулганыг гомдол хорсол, хэрүүл тэмцлээр дүүрэх хүртэл хорт хэлээ амраадаггүй. Нэгэн цагт цэцэглэж байсан чуулган нурж унах хүртэл тэр зогсдоггүй.

Иймэрхүү хүмүүс аюултай тоглоом тоглож байна. Тэд үүнийгээ тийм ч амар больдоггүй. Орчлон ертөнцийн агуу Бурхан чуулганыг нь сүйтгэсэн хүмүүсийг заавал сүйтгэнэ. Чуулганд бүлэг фракц үүсгэдэг хүмүүс анхаарагтун!

## 4 сарын 25

*“Биднийг Христ дотор ямагт ялуулдаг бөгөөд Түүний тухай мэдлэгийн анхилуун үнэрийг хаа сайгүй биднээр түгээдэг Бурханд харин талархал нь байг.” (2Ко 2:14)*

Цэргийн жанжид харийг дайлаар мордоод эргэж ирэхдээ ялалтын жагсаалаар орж ирдэг байжээ. Паул уг дүр зургийг бодож энэ эшлэлийг бичсэн хэмээн судлаачид үздэг. Ялалт байгуулсан жанжин жагсаалын манлайд явж, ялалтын гавьяагаа гайхуулна. Араас нь ялгуусан арми нь дагана. Хамгийн ард нь дайны хоригдлууд явна. Тэднийг үхлийн ял хүлээж байж ч болох юм. Жагсаалын хажуугаар утлага уугиулагчид явдаг. Ингэж тэд агаарыг анхилуун үнэрээр дүүргэнэ. Гэхдээ уг үнэр нь хүн бүрд өөр утга учиртай. Тухайн хүн хэний талд байгаагаас хамаарч үнэр өөр өөр сэтгэгдэл төрүүлдэг. Жанжины үнэнч цэргүүдийн хувьд энэ нь мэдээж ялалтын үнэр. Харин олзлогдогсдын хувьд энэ нь ялагдал ба шийтгэлийн үнэр билээ.

Эзэний зарц нарын зам энэхүү зураглалтай хэд хэдэн талаар тохирдог. Эзэн биднийг үргэлж ялалтаар удирдана. Дандаа ялж буй мэт санагдахгүй ч, бид ялсан талынх бөгөөд Бурханы зорилго заавал биелдэг.

Бид хаа ч явсан Христийн анхилуун үнэрийг авч явдаг. Гэхдээ энэ үнэр хүн бүрд адилгүй утга илэрхийлнэ. Эзэн Есүсийн өмнө бөхийдөг хүмүүст энэ нь мөнх амийн үнэр юм. Эсрэгээрээ, сайнмэдээнээс татгалзсан хүмүүст энэ нь үхэл ба сүйрлийн үнэр юм.

Гэхдээ энэ хоёр тохиолдол хоёулаа Бурханыг алдаршуулдаг. Тэрбээр гэмшигчдийн авралаар алдаршиж, мөхөгсдийн татгалзлаар зөвтгөгддөг. Мөхөгсөд шүүлтийн

агуу их цагаан сэнтийн өмнө зогсохдоо өөрсдийгөө хаацайлж, Бурханыг буруутгаж чадахгүй. Тэд аврагдах боломжтой байсан ч үүнээс татгалзжээ.

Бид ер нь хэчнээн олон хүн аврагдсанаар Христчин үйлчлэлийн амжилтыг тодорхойлдог. Гэтэл энэ эшлэлээс харвал, сайнмэдээг тодорхой танилцуулсны дараа хэдэн хүн түүнээс татгалзаж, тамд унаж байгаа нь ч мөн тухайн үйлчлэлийн амжилт ажээ.

Бурхан хоёуланд нь алдаршдаг. Эхний тохиолдол нь нигүүлслийн анхилуун үнэр. Хоёр дахь нь шударга ёсны анхилуун үнэр болой.

Ямар нухацтай хэрэг вэ! Элч Паул төгсгөлд нь “Хэн эдгээрт чадвартай вэ?” гэж хэлсэнд гайхах зүйл алга.

## 4 сарын 26

*“Та миний хөлийг хэзээ ч угаахгүй шүү!” (Иох 13:8)*

Эзэн Есүс алчуур авч, хувинд ус дүүргээд шавь нарынхаа хөлийг угаахаар дөхөв. Тэрээр Петр дээр ирэхэд Петр эсэргүүцэж, “Та миний хөлийг хэзээ ч угаахгүй шүү” гэж татгалзсан.

Петр яагаад Эзэний сайхан үйлчлэлийг авахаас татгалзав? Нэг талаар тэрээр өөрийгөө зохисгүй гэж үзсэн байж болох юм. Тэрээр өөрийгөө Эзэнээр үйлчлүүлэх хүн биш гэж бодсон байж магад. Эсвэл Петрийн дотор бардамнал ба хараат бус байх хандлага оршиж байсан бололтой. Өөрөөр хэлбэл, бусдын тусламжаас хамааралтай байх дургүй гэсэн үг.

Ийм хандлагаас болж олон хүн аврагдаж чаддаггүй. Тэд авралыг гавьяа зүтгэлээрээ олж авахыг хүсдэг. Авралыг үнэгүй бэлэг болгож авахаар нэр төр нь сэвтэх мэт тэдэнд санагддаг. Тэд Бурханд өртэй үлдэхийг хүсдэггүй ажээ. Гэвч “Бурханд мөнхөд өрөнд орохыг хүсэхгүй бардам хүн хэзээ ч христэч болж чадахгүй.” (Жэймс С. Стюарт)

Түүнээс гадна, христэч хүмүүст энэ эшлэлээс сурах зүйл бий. Юу гэвэл, бусдад л өгөөд байдаг итгэгч нар бий. Тэд үргэлж бусдын төлөө үйлчилдэг. Хамаатан садан, найз нөхөд, хөршүүдийнхээ төлөө бүхнээ зориулдаг. Тэдний өгөөмөр зан үнэхээр магтууштай. Гэвч тэдэнд нэг асуудал бий. Тэр нь бусдаас юм авч чаддаггүй явдал. Өөр хүн өөрсдийнх нь төлөө ямар нэг зүйл хийхийг тэд хүсдэггүй. Тэд өгөөмрөөр өгөхийг сурчихсан боловч нигүүлсэл дотор хүлээн авахыг сураагүй аж. Өөрсдөө болохоор бусдад

үйлчлэхийн ивээлийг хүртдэг байж, бусад хүмүүст тэр ивээлийг хүртэх боломжийг олгодоггүй.

Паул филиппойчуудын бэлгийг талархалтайгаар хүлээн авч “Би бэлгийг нь эрж байгаа юм биш, харин та нарын үнэлгээнд нэмэгдэж буй үр ашгийг эрж байна” (Флп 4:17) хэмээн хэлсэн. Тэрээр өөрийн хэрэгцээнээс илүү филиппойчуудын шагналыг бодож байв.

“Бишоп Вэсткотын талаар ингэж дурссан байдаг: Тэрээр амьдралынхаа эцсийн мөчид амьдралдаа хийсэн нэг том алдаагаа ухаарчээ. Юу гэвэл, тэрээр бусдын төлөө л үйлчилж байсан болохоос өөрийнх нь төлөө үйлчлэх гэсэн хүмүүст боломж олгож байсангүй. Эцэст нь түүний амьдралын сайн сайхан, бүрэн дүүрэн байдал нэг дутуу байх шиг санагджээ. Хариу нэхээгүй олон сайхан сэтгэлт хүний тусыг хүлээн авахаас татгалзсан нь ийм байдалд хүргэсэн байна.” (К. О. Сандерс)

Нэр нь үл мэдэгдэх шүлэгч энэ тухай үнэнийг хэлсэн:

*Хайрын улмаас өгөөмрөөр өгөгч нь*

*Яахын аргагүй агуу сэтгэл мөн*

*Хайрын улмаас даруугаар авагч нь гэхдээ*

*Түүнээс илүү агуу сэтгэл мөн*

## 4 сарын 27

*“Тэр хүрч ирээд...шийдэмгий зүрхээр Эзэнд үнэнч байхыг тэдэнд ятгажээ.” (Үйл 11:23)*

Христэд дуулгавартай эсэхийг нь харахгүйгээр, эрдэмтэн мэргэд гэх хүмүүсийг хэт аялдан дагах аюулт хандлага христитгэлийн зарим хүрээлэлд байдаг.

Жишээлбэл, чадварлаг зохиолч, уран илтгэгч, үг судлалд гарамгай нэгэн байлаа гэж бодъё. Гэхдээ тэр хүн Христ онгон эмэгтэйгээс төрснийг үгүйсгэдэг. Мөн бидний Эзэний гайхамшгуудыг хүний ухаанаар тайлбарладаг. Аврагч биеэрээ амилсныг няцаадаг. Есүсийг дэлхийн бусад суутнуудын нэг гэж үздэг. Түүний хувьд Есүс бол ердөө л баатарлаг хүмүүсийн нэг. Энэ нь өнгөн дээрээ магтаал юм шиг боловч, Бурханы Хүүг доромжилж байгаа хэрэг юм. Энэ хүн Эзэнийх биш.

Хачирхалтай нь эрдэмтэй номтой гэдгээр нь ийм хүмүүсийг христчид хаацалж хамгаалж, ухаантай мундгийг нь магтан сайшаах боловч Христийг яаж гутааж байгааг үл анзаарна. Мөн христчид тэдний үгнээс эш татах, тэдний эгнээнд орох дуртай. Тэгээд зогсохгүй Христийн загалмайн дайсантай нийлэхдээ нүглийнх нь ноцтойг зөөлрүүлж, зальжин үгс хэрэглэдэг. Харин тэдний эсрэг дуугарсан, Библийг хатуу баримталдаг итгэгчид рүү байнга дайрч давшилдаг.

Аврагч маань эрдэмтэн мэргэдийн ам хэл, үзэг цаасан дунд доромжлогдож байхад христэч бид шударга унтууцлаа гаргах цаг болжээ. Одоо тэдэнтэй эвлэрч суух цаг биш ээ. Христ гэж хэн бэ, Христ юу хийсэн бэ гэдгийг

өгүүлдэг үнэн сургаалын эсрэг буулт хийж огт болохгүй. Бид үүн дээр хатуу зогсох ёстой.

Бурханы үнэн гуйвахад эш үзүүлэгчид найрсаг үгээр хэзээ ч ярьж байсангүй. Тэд Эзэнд хатуу үнэнч байсан бөгөөд Түүнийг үгүйсгэх юм уу доромжилсон этгээдийг хатуу зэмлэдэг байлаа.

Элч нар ч ялгаагүй. Тэд Эзэний сүр жавхланг булаах гэсэн оролдлого бүхнийг няцааж байсан. Тэд теологийн ертөнцөд алдартай хүмүүс байхыг бус, Христэд үнэнч үлдэхийг илүүд үзсэн.

Итгэлийнхээ төлөө амиа алдагсад, Бурханы Хүүг үгүйсгэснээс үхэхийг илүүд үзсэн. Тэд хүний сайшаалыг бус, Бурханы сайшаалыг хүртэхийг хүссэн.

Бидний үүрэг болбоос бүхий л зүйл дээр Эзэн Есүст үнэнч үлдэж, Эзэн Есүсээс зохих ёсны алдрыг булаадаг алив зүйл, хэн хүнд найр тавихгүй байх явдал юм

## 4 сарын 28

*“Эцгийнхээ сургамжийг сонс, хөвгүүд минь. Ухаарлаас суралцахын тулд анхаар.” (Сур 4:1)*

Сургаалт үгс 4-р бүлгийн эхний дөрвөн эшлэлд Соломон, ахмад үеэс залуу үед сайн зөвлөгөө уламжлагдан дамждаг бөгөөд дамжих ёстойг өгүүлж аав нь түүнд хэрхэн сургаж байсныг дурдаад, эрүүл зөв зааварт анхаарлаа хандуулахыг хүүдээ захидаг.

Залуу хүмүүс махан биеийн эцэг эхээсээ амьдралын ухааныг аль болох боломжоороо сурч мэдэх учиртай. Тэгвэл сүнслэг талбарт ч гэсэн, залуу итгэгчид сүнслэг зөвлөгчтэй байх хэрэгтэй. Тэр нь мэдэхгүйгээ асуух, туршлагаасаа хуваалцах, итгэл даах, тусламж хэрэгтэй үед тусалж чадах хүн юм. Хэрэв энэ үүргийг эцэг эх нь гүйцэтгэвэл бүр сайн. Тэгэх боломжгүй бол өөр хэн нэгэн заавал байх шаардлагатай.

Бурханлаг төлөвшсөн итгэгчид их хэмжээний практик мэдлэг хуримтлуулсан байдаг. Тэд олон удаа ялагдал хүлээж, түүнээсээ үнэ цэнтэй хичээл сурч, дараагийн удаа хэрхэн хандахаа ойлгосон байдаг. Настай итгэгчид асуудлаас залуу хүмүүсийн олж харж чаддаггүй талуудыг олж хардаг. Тэд тэнцвэртэй байхыг сурсан бөгөөд утга учиргүй туйлшрал уруу хэлбийдэггүй.

Ухаалаг залуу Тимотууд Паулуудаас мэргэн ухааныг нь, мэдлэг туршлагыг нь сурч авах нь зөв. Тэд эхлээд Паулуудаас асууж тодруулж, зөвлөлдөж шийдвэр гаргавал олон асуудлаас өөрсдийгөө аварна. Өндөр насыг дорд үзэх бус, амьдралын олон асуудлыг даваад гарч ирсэн тэднийг хүндлэх нь зүйтэй.



Ер нь бол настай хүмүүс залуучууд уруу өөрөө гүйж очдоггүй. Асуугаагүй байхад нь зөвлөгөө өгвөл уг зөвлөгөө үр дүнгээ өгдөггүйг тэд сайн мэддэг болохоор тэр. Харин залуучууд өөрсдөө асуувал тэд баяртайгаар мэдлэг туршлагаа хуваалцахад бэлэн.

Залуу хүн хүсэл тачаалтай тэмцэж байвал, Бурханы удирдамжийг мэдэж авахыг хүсвэл, Эзэний төлөө гэр бүлээ барьж босгохыг хүсвэл, Бурхан өөрийг нь илгээлтийн талбар уруу дуудаж буй эсэхэд эргэлзэж байвал, санхүүгээ удирдан зохицуулахад тусламж хэрэгтэй бол, илүү үр нөлөөтэй залбирлын амьдралыг хүсэж байвал – иймэрхүү ямар ч асуудалд Библийн мэргэн ухаанаар гэрэл тусгаж чадах сүнслэг хүнээс зөвлөгөө авах нь мэргэн ухаан болно. Тэдгээр буурал толгойтнууд мэргэн ухааны сан хөмрөг билээ. Бусдын өнгөрсөн туршлагаас ухаарал олж болох атал яагаад заавал зовлонтой замаар юмыг сурах ёстой юм бэ?

## 4 сарын 29

*“Итгэл бол найддаг зүйлсийн маань бодит байдал, харагдахгүй зүйлсийн баталгаа мөн.” (Евр 11:1)*

Итгэл нь Бурханы үгэнд найдах, Бурханы итгэмжтэй занг түшиглэх, Бурханы үнэн гэснийг үнэн гэж үзэх, Бурханы амлалтуудыг биелнэ гэж итгэх явдал юм. Итгэл нь ирээдүй рүү чиглэдэг (“найддаг зүйлс”) бөгөөд үл үзэгдэх зүйлстэй холбоотой (“харагдахгүй зүйлс”).

Витиер: “итгэл нь хоосон мэт харагдах зүйлс дээр хөлөө тавиад хөдөлшгүй хадыг олдог” гэж хэлжээ. Гэвч тийм биш ээ. Итгэл гэж харанхуйгаар үнэмшихийг хэлэхгүй. Итгэл нь баталгаа шаарддаг бөгөөд баталгаагаа Бурханы үгээс олдог.

Аливаа зүйлд үнэн голоосоо итгэвэл тэр нь биелдэг гэж зарим хүн буруу боддог. Гэвч үүнийг итгэл гэхгүй, үнэмшил гэнэ. Итгэл нь Бурханы илчлэлтэд түшиглэж, Бурханы амлалтаас зуурдаг. Бурхан амласан л бол заавал биелдэг. Бурхан ирээдүйг зөгнөсөн бол тэр үйл явдал заавал тохиолдоно. Өөрөөр хэлбэл, итгэл нь ирээдүйг одоо цагт авчирч, үзэгдэхгүй зүйлсийг олж хардаг.

Бурханд итгэхэд ямар ч эрсдэл үгүй. Учир нь Бурхан худал хэлдэггүй, хуурч мэхэлдэггүй, бас Өөрөө ч хууртдаггүй. Бурханд итгэх нь хүмүүний хийх хамгийн ухаалаг, мэргэн, цэцэн, учир зүйтэй үйлдэл мөн. Бүтээл нь Бүтээгчдээ итгэхээс илүү зөв зүйл гэж юу байх вэ?

Итгэл нь боломжоор хязгаарлагддаггүй. Харин ч боломжгүйг боломжтой болгодог. “Итгэл нь боломж дууссан газар эхэлдэг. Хэрэв хүний хувьд боломжтой

байвал Бурханд алдар гавьяа ирэхгүй. Харин боломжгүй бол хийгдэх боломжтой гэсэн үг” гэж нэгэн хүн хэлжээ.

*Хүчирхэг итгэл нь амлалтаас зуурч*

*Зөвхөн Бурхан уруу хараа талбиж*

*Боломжгүй нөхцөл рүү инээж*

*“Энэ бүхэн биелнэ” гэж хаширдаг*

Итгэлийн амьдралд асуудал бэрхшээл олон тулгардаг нь мэдээж. Учир нь Бурхан итгэлийг минь жинхэнэ эсэхийг батлахын тулд янз бүрийн сорилт зовлонгоор шалгадаг (1Пт 1:7). Олон тохиолдолд Бурханы амлалтын биеллийг харахын тулд бид олон жил хүлээх ёстой болдог. Заримдаа үхсэнийхээ дараа л биеллийг нь харж магад. Гэвч “итгэлийн минь хүнс тэжээл бол зовлон бэрхшээл мөн.” (Жорж Мюллер)

“Итгэлгүйгээр [Бурханд] таалагдана гэдэг боломжгүй юм.” (Евр 11:6) “Бурханд итгэдэггүй нь Түүнийг худалч болгож байна.” (1Ио 5:10) Өөрийг нь худалч болгож байгаа хүмүүс Бурханы тааллыг яаж олох юм бэ?

## 4 сарын 30

*“Та нар Намайг хайрладаг бол тушаалуудыг минь сахь.”*  
(Иох 14:15)

Тушаалууд аа? Шинэ гэрээнд үү? Хүмүүс тушаал гэсэн үгийг сонсонгуутаа хууль дагах үзлийг (легализм) боддог. Гэхдээ энэ хоёр үг өөр утгатай. Эзэн Есүсээс илүү тушаалуудыг ярьсан хүн байдаггүй. Гэтэл хууль дагахуйг Түүнээс бага онцолсон хүн үгүй.

Хууль дагах үзэл гэж юу вэ? Энэ үг өөрөө Шинэ гэрээнд гардаггүй боловч энэ нь өөрийн гавьяагаар Бурханы тааллыг олох гэсэн хүний хандлагыг хэлдэг. Үндсэндээ энэ нь хуулийг сахиснаар зөвтгөл ба ариусгалд хүрэх гэсэн оролдлогыг хэлнэ. Хууль дагах үзэл буюу легализмын жинхэнэ утга энэ.

Гэхдээ өнөөдөр энэ үг илүү өргөн утгаар хэрэглэгдэж байна. Легализм гэж ёс суртахууны аливаа хатуу дүрэм журмыг хэлдэг болж. Ямар нэг үйлдлийг (жишээ нь шивээс хийлгэхийг) буруу гэнгүүт түүнийг “легализм” (хууль дагах үзэл) гэж нэрлэдэг болжээ. Үнэндээ христэч хүний сахилга баттай холбоотой бүх цээр хориог энэ үгээр далайлган үгүй хийх гэж оролдож байна.

Тэгвэл христэч хүн “легализм”-тай холбоотой аюулаас зайлсхийхийн тулд ямар үзэл бодолтой байх ёстой вэ?

Нэгт, Христэд итгэгч нь хуулиас чөлөөлөгдсөн нь үнэн боловч хуульгүй болоогүй гэдгийг ойлгох хэрэгтэй. Тэрээр Христийн хуульд захирагддаг. Тэрээр өөрийн тааллыг бус, Христийн тааллыг үйлдэх ёстой.

Хоёрт, Шинэ гэрээнд олон тушаалууд байдгийг санах хэрэгтэй. Тэдний дотор “болохгүй” гэсэн тушаалууд ч хэд

хэд бий. Ялгаа нь гэвэл энэ тушаалууд нь хууль биш. Тиймээс шийтгэл гэж үгүй. Уг тушаалууд нь Бурханы хүмүүст зориулж өгөгдсөн шударга зөвийн зааварчилгаа юм.

Дараагийн бодох ёстой зүйл гэвэл, христитгэгчдийн чөлөөтэй хийж болох зүйл ашиг тусгүй байх боломжтой. Христитгэгчид чөлөөтэй хийж болох ч гэлээ энэ нь боолчлолд оруулдаг байж болно (1Ко 6:12).

Итгэгч хүн ямар нэг юм хийх эрх чөлөөтэй байж болох ч түүнийг хийснээрээ өөр хэн нэгнийг бүдрүүлж болзошгүй. Итгэгч хүн ийм зүйлийг хийх ёсгүй.

Хориг цээрийг хэн нэгэн нь “хууль дагах үзэл” гэж нэрлэсний зоргоор тэр нь муу зүйл болчихгүй. Хүмүүс зарим нэг ёс зүйн дүрэм журмыг үгүйсгэхдээ “пуританик *[пуританчуудын нэрээс гаралтай бөгөөд бэлгийн ариун журмыг сахих, ёс суртахууны өндөр хэм хэмжээг баримтлахыг ингэж хэлдэг.]*” гэж хэмээн цоллодог боловч пуританчуудын зан байдал нь тэднийг шүүмжилдэг олон хүнийхээс илүү Христийг хүндэтгэдэг байжээ.

Христитгэгчид бурханлаг зан чанарын хэм хэмжээг “хууль дагах үзэл” хэмээн гоочилж эхэлбэл ёс суртахууны хэм хэмжээг уландаа гишгэн, дур зоргоороо авирлахыг хүсэж байгаагийн илрэл юм. Тэд ёс суртахууны өндөр хэм хэмжээг баримталдаг, сахилга баттай, буруугаас цэрвэдэг хүмүүсийг “легалист,” “пуритан” гэж гоочлон, шавар шидсэнээрээ өөрсдийгөө мундаг харагдана гэж төөрөгдөж байгаа юм.

Бид ангалын ирмэг дээр явахын оронд Библийн сургаалд аль болох ойр алхвал хамгийн аюулгүй билээ.

## 5 сарын 1

*“Та нар нэрээр минь юм гуйвал Би түүнийг чинь үйлдэнэ.” (Иох 14:14)*

Бурхан залбиралд хариулдаг. Бид хязгааргүй мэргэн ухаан, төгс хайр, бүхнийг чадагч хүч, дээдийн дээд эрх мэдлийг атгадаг бол хэрхэн хандах байсан, яг тийм замаар Бурхан залбиралд хариулдаг. Бурхан заримдаа хүссэнийг маань, заримдаа илүү сайныг өгдөг. Гэхдээ ямар ч тохиолдолд Тэр хэрэгтэйг маань өгдөг. Бурхан заримдаа залбиралд хурдан хариулдаг. Харин заримдаа тэвчээртэй хүлээхийг бидэнд заадаг.

*Бурхан залбиралд хариулдаг  
Зүрх сэтгэл дорой үед минь  
Хүссэнийг цааргалалгүй өгдөг  
Гэхдээ заримдаа чив чимээгүй болж  
Гуйвалгүй найдахын хичээлийг заадаг  
Нэрд нь хайр шингэсэн Тэрээр  
Хамгийн сайныг л надад хайрладаг  
Од мичид бөхөж, уул хад үл хөдлөвч  
Өөрийг нь чин сэтгэлээс хайдаг бүхэнд  
Бурхан үнэн, Түүний амлалт баттай.*

Залбиралд болзол бий. Есүс “юуг ч гуйсан” гэж хэлсэн ч, “Миний нэрээр” гэдэг болзол тавьжээ. Хувь хүмүүст өгөгдсөн залбирлын амлалтуудыг залбирлын тухай Библийн бусад хэсэгтэй хамтад нь харах хэрэгтэй.

Залбиралд ойлгомжгүй зүйлс бий. “Яагаад?” гэдэг олон асуулт бидэнд гардаг. Гэхдээ эдгээр нь ихэнхдээ босгон байгуулдаггүй. Залбиралтай холбоотой ойлгохгүй зүйлсийг ойлгох гэж толгойгоо гашилгаж суухын оронд

залбираад, Бурханы ажлыг нүдээр үзэх нь дээр. Тэргүүн бишоп Темплийн хэлсэн үгэнд би дуртай: “Залбирах үед маань тохиолдлын биш гэмээр үйл явдлууд болдог. Харин залбираагүй үед тийм юм болдоггүй.”

Бид Эзэн Есүсийн нэрээр Бурханд залбирах үед Эзэн Есүс, Эцэг Бурханаас тэдгээрийг хүсэж байгаатай ижил юм. Тиймээс Эзэн Есүсийн нэр залбирлыг маань ач холбогдолтой, эрх мэдэлтэй болгодог. Тийм болохоор бид залбирах үедээ л бүхнийг чадагч болдог. Мэдээж, бид хэзээ ч бүхнийг чадагч болохгүй. Мөнхийн улсад очсон ч болохгүй. Гэхдээ Эзэн Есүсийн нэр дээр залбирсан залбирал бидэнд хязгааргүй боломжийг олгодог ажээ.

Шилдэг залбирал нь дотоод сэтгэлд үүссэн хүчтэй хэрэгцээнээс гардаг. Өөрөөр хэлбэл, Эзэнээс зуурах тусам залбирал маань илүү үр нөлөөтэй болно.

Залбирч эхэлбэл боломж ба байгалийн хуулиар хэзээ ч биелэхгүй зүйлс тохиолдохыг бид харна. Амьдрал маань ер бусын зүйлсээр дүүрнэ. Ариун Сүнсний ажлууд идэвхэжнэ. Залбиралтай үедээ бусдын амьдралд хүрвэл Бурханы алдрын төлөө ямар нэг зүйл заавал тохиолдоно.

“Би өөрийн нөлөөг хэмжихдээ миний залбирал хэдэн хүнд хэрэгтэйг болон хэдэн хүн миний төлөө залбирдгийг хардаг” гэж хэлсэн нэгэн итгэгчээс бид үлгэр авах хэрэгтэй.

## 5 сарын 2

*“Есүс Галил даяар явахдаа синагогуудад нь зааж, хаанчлалын сайнмэдээг тунхаглаж, ард олны доторх алив төрлийн өвчин эмгэгийг эдгээж байлаа.” (Мт 4:23)*

Сайнмэдээний ажил ба нийгмийн оролцоог тэнцвэртэй байлгах талаар христитгэгчдийн дунд байнга яригддаг. Сайнмэдээ тараагчид ихэнх тохиолдолд хүмүүсийн бие махбодын материаллаг хэрэгцээг орхигдуулаад сүнсэнд нь голлон анхаарч байна гэж шүүмжлүүлдэг. Өөрөөр хэлбэл, өлсгөлөнг хооллох, хувцасгүйг хувцаслах, өвчтэйг эмчлэх, бичиг үсэггүйчүүдэд боловсрол олгох ажилд хангалттай цаг зарцуулахгүй байна гэж тэднийг шүүмжилдэг.

Эдгээр үйлчлэлийн эсрэг ярих нь эх хүний хайр халамжийг шүүмжлэхтэй адил юм. Эзэн Есүс хүний бие махбодын материаллаг хэрэгцээнд анхаарал тавьж байсан бөгөөд шавь нартаа ч тийн хандахыг номлосон. Түүхээс харахад, христитгэгчид нийгмийн халамжийн үйлчлэлд тэргүүн эгнээнд явж байлаа.

Гэхдээ амьдралын бусад асуудлын нэгэн адил, нэн тэргүүний хэрэгцээ юу вэ гэдгийг бодох хэрэгтэй. Аль нь илүү чухал вэ? Зуурдынх нь уу эсвэл мөнхийнх нь үү? Энэ үүднээс бодож үзвэл сайнмэдээ хамгийн гол зүйл юм. Есүс үүнийг илэрхийлж, “Та нар...итгэх нь Бурханы ажил мөн” (Иох 6:29) гэж хэлсэн. Сургаал номлол нь нийгмийн ажлын өмнө байх ёстой.

Нийгмийн хамгийн тулгамдсан асуудлын зарим нь хуурамч шашны үр дагавар байдаг. Жишээлбэл, үхэр нядалж идэхгүйгээс болж олон хүн өлсгөлөнгөөр нас барж байна. Учир нь тэд хамаатан саднаас нь хэн нэг нь үхэр



төрлийг олсон байж магадгүй гэж итгэдэг. Зарим улсад тариа будааг арвинаар тариалдаг ч, ихэнх хэсгийг нь хүн биш оготно идчихдэг. Учир нь тэд хулгана алахаас зүрхшээдэг. Тэд мухар сүсэгт хүлэгджээ. Христ тэдний асуудлын шийдэл билээ.

Сайнмэдээний ажил ба нийгмийн оролцооны тэнцвэрийг хадгална гэдэг нэрийн доор сайнмэдээг орхигдуулаад жижиг сажиг зүйлст хэт төвлөрөх үзэгдэл байнга гардаг. Христитгэлийн түүхэнд ийм жишээ дэндүү олон. Сайн зүйл заримдаа шилдгийн дайсан болох нь бий.

Нийгмийн оролцоонуудын дундаас христитгэгчдийн хэзээ ч оролцох ёсгүй зарим зүйлс бий. Тухайлбал, төр засгийг унагах санаатай бослого тэмцэлд бид оролцох ёсгүй. Нийгмийн шударга бус явдлыг засахын тулд улс төрийн аргаар явах нь христитгэгчдийн зам биш ээ. Бидний Эзэн ийм юм хийгээгүй. Элч нар ч ялгаагүй. Нийгмийг засахын тулд улс төр хөөцөлдсөнөөс сайнмэдээг дэлгэрүүлэх нь илүү үр дүнтэй арга юм.

Христийг дагахын тулд бүхнээ орхисон, ядууст тараахын тулд бүгдийгээ зарсан, бусдын хэрэгцээг харахдаа зүрх сэтгэл ба хэтэвчээ нээхэд бэлэн итгэгч хүн нийгмийн орхигдсон асуудлуудад өөрийгөө буруутгах шаардлагагүй.

## 5 сарын 3

*“Махбоддоо таригч нь махбодоосоо ялзралыг хурааж авна.” (Гал 6:8)*

Нүгэл үйлдчихээд зүгээр өнгөрч чадах нэг ч хүн үгүй. Нүглийн үр дагавар нь зайлшгүй төдийгүй маш гашуун. Нүгэл нь гэм хоргүй муужгайтай адил харагдаж болох ч, эцэст нь өршөөлгүй арслан шиг залгидаг.

Нүгэл эхэндээ маш сэтгэл татам санагддаг. Гэвч үр дагавар нь аймшигтай. Харамсалтай нь нүглийн үр дагаврын талаар бид бага сонсдог. Яагаад гэвэл, өөрийн уналт ялагдлыг ярьдаг хүн цөөн ажээ.

Харин Ирландын алдарт зохиолч Оскар Уайлд тэр цөөн хүмүүсийн нэг байв. Тэрээр аажим аажмаар мунхаглалын зам уруу хэлбийсээр, эцэст нь хуулийн өмнө дуудагдан шоронд орсон юм. Шоронд тэрээр дараах захиаг бичжээ:

“Бурхад надад бараг бүх зүйлийг өгсөн. Надад авьяас, нэр хүнд, байр суурь, чадвар, оюуны потенциал цөм байлаа. Би урлагийг философи, философийг урлаг болгож байв. Би хүмүүсийн сэтгэлгээ ба аливаа зүйлсийн өнгө будгийг өөрчилсөн билээ. Намайг юу ч ярьсан, юу ч хийсэн хүмүүс шагшин алмайрна...Би урлагийг жинхэнэ бодит байдал гэж, амьдралыг жирийн нэг зохиол хэмээн амьдардаг байлаа. Би эрин цагийнхаа олон түмний төсөөллийг сэрээж, өөрийнхөө тухай үлгэр домог бий болгосон. Би бүтэн системийг ганц өгүүлбэрээр, бүх амьдралыг ганц бадаг шүлгээр дүгнэн хэлчихдэг байсан.”

“Үүний зэрэгцээ надад өөр зүйлс ч байлаа. Би өөрийгөө удаан хугацаанд сул тавьж, мунхаглал ба хүсэл тачаалын

таашаалд эзэмдүүлэв. Загварлаг, дэгжин, тансаг хувцаслалтаар өөрийгөө гайхуулав. Мөн би өчүүхэн бодолтой, увайгүй хүмүүсээр хүрээлүүлэв. Авьяас чадвараа ч үрэн таран хийж, мөнхийн залуу насны маань соёрхон хайрласан бүхнийг зугаа цэнгэлд зарцуулжээ. Өндөрт байхаас залхсандаа шинэ мэдрэмжийг хайж сайн дураараа гүн ёроол уруу шигджээ. Этгээд хачин зүйлс сонирхлыг минь татаж, тэнэг мунхаг байх нь дур таашаалыг минь хангаж эхлэв. Эцэст нь хүсэл тачаал гэдэг чинь өвчин эмгэг, солиорол байжээ. Би бусдын амьдралыг нэгээхэн ч бодож явсангүй. Өөрийнхөө хүслийг хангахын тулд дуртай бүхнээ л хийж байлаа. Өдөр тутмын жижиг үйлдлүүд зан чанар болдгийг умартжээ. Нууц өрөөнд үйлддэг зүйл минь сүүлдээ байшингийн дээвэр дээр хашхирдгийг мартжээ...Эцэст нь над дээр аймшигт гутамшиг л ирлээ.”

Буруугаа бичсэн түүний энэ захиа **De Profundis** буюу “гүн ёроолоос” гэж нэрлэгдсэн нь нүдээ олжээ.

## 5 сарын 4

*“Хүнд өөрт нь зөв мэт зам харин эцэс нь үхлийн зам.”* (Сур 14:12)

Зөв замын талаар хүмүүний дүгнэлт найдваргүй гэж Сургаалт үгс ном хоёр ч удаа хэлж байна (Сур 14:12; 16:25). Хүнд зөв харагдавч эцэс нь гамшиг ба үхэлд хүрэх боломжтой.

Дэлхийн хоёрдугаар дайны үеэр нисэх хүчний багийнханд заасан хичээл энэ зарчмыг тодорхой харуулдаг. Өндөрт нисэж байхдаа хүчилтөрөгч хэрэглээгүй бол мэдрэмждээ найдаж болохгүйг уг хичээл заадаг. Хичээлийг заахдаа нисгэгчийг тусгай өрөө рүү оруулаад математикийн бодлого тавьсан ширээн дээр суулгана. Дараа нь өндрийн симуляцид буюу загварчилсан орчинд оруулж, өрөөн дэх хүчилтөрөгчийн хэмжээг бууруулна. Агаарын нягтрал буурах үед ширээн дээрх бодлогыг бодох даалгаврыг нисгэгчид өгнө. Энэ бодлогыг хэн ч зөв бодож чадаагүйг хэлнэ.

Нисгэгч бодлогыг харахад тун амархан санагдах бөгөөд ямар ч алдаагүй бодсон гэдэгтээ бүрэн итгэдэг. Түүнд ямар ч эргэлзээ төрөхгүй.

Гэтэл өрөөнд хүчилтөрөгчийн хэмжээг буцааж хэвийн байдалд оруулаад бодолтыг өөрөөр нь шалгуулахад тэр чигтээ алдаа байдаг. Учир нь түүний тархи хүчилтөрөгчийн дутагдлаас болоод зөв сэтгэх чадвараа алддаг ажээ. Эндээс нисгэгч маань, өндөрт нисэж байхад хүчилтөрөгч хэрэглээгүй үедээ өөрийн мэдрэмжид найдаж болохгүйг ойлгож авдаг. Эс бөгөөс онгоцоо гарцаагүй осолдуулна.

Хүний дүгнэлт нүглийн улмаас бурууджээ. Тэрээр сайн хичээвэл диваажинд гарцаагүй хүрнэ гэдэгтээ бүрэн итгэдэг. Хэн ч сайн үйлсээр аврагдахгүй гэж хэлсэн ч, өөрийнх нь зөв гэдэгт огт эргэлзэхгүй. Бурхан тэнгэрийн хаалгыг өөрт нь нээж өгнө гэдэг нь түүнд гарцаагүй үнэн санагдана.

Гэвч түүний бодол буруу. Тэрээр “сүнслэг хүчилтөрөгчийн” дутлаас үүдэлтэй буруу бодлоосоо зуурсаар байвал зайлшгүй мөхөлд хүрнэ. Түүний аюулгүй байдал нь өөрийн мэргэн ухаанд бус, Бурханы үгэнд бий. Хэрэв тэр хүн Бурханы үгэнд итгэвэл нүглүүдээ гэмшиж, Эзэн Есүс Христийг Эзэн ба Аврагч болгон хүлээн авна. Яагаад гэвэл Бурханы үг үнэн бөгөөд түүнд итгэгчид нь зөв замаар алхаж байгаадаа бүрэн найдаж болно.

## 5 сарын 5

“Ууган хүүгийн эрхээ хоолоор арилжсан Есав...” (Евр 12:16)

Амьдралын хамгийн үнэ цэнтэй зүйлийг хоромхон зуурын дур хүслээ хангах зүйлээр сольчих явдал бий.

Есав үүнийг хийжээ. Тэр хээрээс ирэхдээ ядарч, өлссөн байв. Тэр үед Иаков улаан зармагны шөл хийж байлаа. Есав “улаан зармагны шөлнөөсөө өгөөч” гэж гуйхад Иаков хариуд нь “Өгч бололгүй яах вэ. Гэхдээ та хариуд нь надад ууган хүүгийн эрхээ зар” гэв.

Ууган хүүгийн эрх нь айлын ууган хүүд хамаатай үнэ цэнтэй эрх дарх ажээ. Ууган хүүгийн эрхтэй хүн тухайн гэр бүл эсвэл овгийн тэргүүн болох, цаашлаад хоёр дахин их өв хөрөнгө авах эрхтэй.

Гэтэл тухайн үед Есав ууган хүүгийн эрхийг үнэ цэнэгүйд тооцжээ. Над шиг өлссөн хүнд ууган хүүгийн эрх ямар хэрэгтэй юм бэ? гэж бодсон. Түүний өлсгөлөн маш хүчтэй санагдсан бөгөөд өлсгөлөнгөө дарахын тулд Есав юугаа ч өгөхөд бэлэн байлаа. Есав хоромхон зуурын идэх дуршлаа дарахын тулд өнө удаан орших үнэ цэнтэй зүйлээсээ татгалзжээ. Тэрээр үнэхээрийн алдаатай наймаа хийв.

Үүнтэй төстэй үйл явдал бараг өдөр бүр тохиолддог. Олон жилийн турш сайн гэрчлэлтэй явсан нэгэн хүн байлаа. Түүнд халамжит сайхан гэр бүл, өөрийг нь хүндэлдэг христэч хүрээлэл байв. Түүний номлол сүнслэг эрх мэдэлтэйгээр бусдад хүрч, үйлчлэл нь Бурханы ерөөл авчирдаг байлаа. Тэрээр үлгэр жишээ итгэгч байжээ.

Гэтэл нэг удаа хүсэл тачаалын ширүүн сорилт ирэх нь тэр. Бэлгийн дур хүслийн гал биед нь шатжээ. Энэ л хүслээ хангаж байвал өөр юу ч хамаагүй мэт байлаа. Тэрээр эрүүл ухаанаа гээжээ. Хүслээ хангахын тулд тэр бүхнээ золиослоход бэлэн байв.

Тиймээс тэр гэр бүлээс гадуурх харилцаанд орлоо. Ингээд тэрээр Бурханыг хүндлэх хүндлэл, өөрийн гэрчлэл, гэр бүлийн үнэ цэнэ, найз нөхдийн хүндлэл, христэд эрхэмлэл бүхнийг орхиод дур хүслээ хангав. Александер Макларены хэлсэнчлэн, “тэрээр зөвт байдлыг хүсэмжлэхээ умаргаж, Бурхантай нөхөрлөхийн баяр хөөрөөс холдон одож, сэтгэлдээ харанхуйг авчирч, хөгжил цэцэглэлээ үгүй хийж, үлдсэн амьдралаа гутамшигт хутгаж, өөрийн нэр төр, итгэл үнэмшлийг элэглэн дооглогчдын бай болгожээ.”

Библийн сонгодог үгээр хэлбэл, тэрээр ууган хүүгийн эрхээ аяга шөлөөр арилжив.

## 5 сарын 6

*“Израилийн хаан байхыг нь болиулж Миний үл хэрэгссэн Саулын хойноос хэдий болтол гашуудах юм бэ?” (1См 16:1)*

Өнгөрсөнд гашуудахаа больж, одоогийн ажлаа цааш үргэлжлүүлэх үе амьдралд ирдэг.

Саулыг хаан байлгахаас Бурхан татгалзсан. Энэ нь эргэж буцахгүй шийдвэр байлаа. Харин Самуелд энэ шийдвэр хүнд тусав. Тэрээр Саултай дотно байсан бөгөөд найдвар нь унтарсанд гашууджээ. Саулыг дахин олж авахгүйгээр алдсандаа халаглаж байлаа. Тэгтэл Бурхан, “Гашуудахаа боль. Яваад Саулын дараагийн хүнийг тосол. Миний төлөвлөгөө бүтэлгүйтэхгүй. Би Израилийн түүхэнд Саулаас дээр хүнийг оруулж ирнэ” гэж хэлэв.

Энэ хичээлийг Самуелээс гадна, Саулын оронд хаан болсон Давид ч сайн сурч авчээ. Давид үүнийг сайн ухаарснаа ямар ч нөхцөлд харуулдаг байлаа. Тухайлбал, хүүхэд нь үхлүүт өвчтэй болоход Давид мацаг барьж, гашуудаж, Бурхан хүүхдийг нь хэлтрүүлнэ хэмээн найдан залбирч байв. Харин хүүхдийг нас барахад Давид усанд орж, хувцсаа сольж, сүмд ороод мөргөл үйлдэж, хоол иджээ. Үүнийг нь гайхсан хүмүүст тэрээр “Тэр өөд болчихлоо. Би юунд мацаг барих ёстой билээ? Би түүнийг дахин эргүүлж авчирч чадах бил үү? Би өөрөө түүн дээр очих болно. Харин тэр над дээр эргэж ирэхгүй” (2См 12:23) гэж хариулсан.

Христэч бид үүнээс өөрсдийн амьдрал үйлчлэлд сургамж авах ёстой. Заримдаа үйлчлэл минь өөр хүнд очиж болно. Үйлчлэл минь дуусгавар болоход гашуудаж болно.



Заримдаа нөхөрлөл эсвэл түншлэл минь үгүй болж, амьдрал хоосон санагддаг. Дотнын хайртай хүн минь биднийг гомдоодог. Үнэ цэнтэй харилцаа минь бөхдөг.

Заримдаа насаараа мөрөөдсөн мөрөөдөл минь бүтэлгүйтдэг. Зорилго минь бүүдийдэг. Алсын хараа, урам зориг минь унтардаг. Ийм зүйлс ирэхэд бид гашууддаг.

Гашуудалд буруу юм үгүй. Гэхдээ гашуудал цаашдын амьдралыг сүйтгэх хэмжээнд удаан байж болохгүй. Э. Стэнли Жонс энэ санааг цохон тэмдэглэхдээ, уй гашуу, харуусал, амьдралын цохилтоос “нэг цагийн дотор сэргэ” гэж хэлсэн. Зарим хүнд энэ хугацаа хангалтгүй. Гэхдээ гол нь өөрчилж чадахгүй нөхцөл байдалд үүрд халаглан сууж болохгүй юм.

## 5 сарын 7

*“Тэр та нарт санаа тавьдаг.” (1Пт 5:7)*

Бурхан өөрийн хүмүүсийг анхаарч халамжилдаг жишээ Библид дүүрэн бий. Израиль цөлд дөчин жил тэнүүчлэхэд Бурхан тэднийг тэнгэрийн талхаар хооллож, (Гэт 16:4), цэнгэг усаар тэтгэж (1Ко 10:4), эдэлгээ сайтай гутлаар хангасан (Дх 29:5).

Христэч бидний цөлийн аялалд ч Бурхан ийн ханддаг. Үүнийг батлахын тулд Эзэн Есүс шувууд, цэцэгс, амьтдад санаа тавьдгаа сануулж, биднийг хэд дахин илүү үнэ цэнтэй гэж хэлсэн. Жишээ нь, Тэр бор шувуудын тухай ярьсан. Тэр тэдэнд хоолыг нь өгдөг (Мт 6:26). Тэдний нэг нь ч Бурханы өмнө мартагдаагүй (Лк 12:6). Түүнийг зөвшөөрөөгүй байхад тэднээс нэг нь ч газар унадаггүй (Мт 10:29). Х.А.Айронсайдын хэлснээр “Бурхан бор шувуу болгоны оршуулгад оролцдог.” Мэдээж, бид Түүний хувьд олон бор шувуунаас ч эрхэм үнэтэй гэдэг нь гол санаа юм (Мт 10:31).

Бурхан талын сараана цэцэгсийг Соломоны тансаг хувцаснуудаас ч сайхан ургуулдаг юм бол биднийг бүр ч илүү хувцаслахгүй гэж үү? (Мт 6:30) Бурхан үхэрт хүртэл санаа тавьдаг юм бол бидний хэрэгцээнд бүр ч илүү анхаарахгүй гэж үү? (1Ко 9:9)

Эзэн Есүс маань бидний Тэргүүн Тахилч болохын хувьд нэрсийг маань мөр [хүч чадлын илэрхийлэл] (Гэт 28:9-12) болон цээжин [хайрын илэрхийлэл] (Гэт 28:15-21) дээрээ тээж явдаг. Мөн бидний нэрс Түүний алган дээр сийлэгдсэн (Иса 49:16). Энэ нь Голгота дээр бидний төлөө гартаа хадаас зоолгосон утга учрыг сануулж байх шиг.

Тэрээр толгойн үсний минь ширхгийн тоог мэддэг (Мт 10:30). Бас шөнө эргэж хөрвөөхийг минь тоолж, нулимсны минь тоог номдоо тэмдэглэдэг (Дуу 56:8).

Бидэнд хүрсэн нь Түүний нүдний цэцгийг хүрдэг (Зех 2:8). Бидний эсрэг бүтээгдсэн ямар ч зэвсэг бүтэлтэй болохгүй (Иса 54:17).

Үндэстнүүд бурхдаа мөрөн дээрээ үүрдэг бол (Иса 46:7) бидний Бурхан биднийг тээдэг (Иса 46:4).

Биднийг ус, гал, гол мөрөн дундуур туулахад Тэр бидэнтэй хамт явдаг (Иса 43:2). Зовж шаналахад минь Тэр бас зовж шаналдаг (Иса 63:9).

Биднийг хамгаалдаг Нэгэн үүрэглэдэггүй, унтдаггүй (Дуу 121:3,4). Бурханы энэхүү зан чанарыг нэгэн хүн “тэнгэрлэг нойргүйдэл” гэж нэрлэжээ.

Бидний төлөө амиа өгсөн Сайн Хоньчин бээр биднээс сайн зүйлсийг хармалддаггүй (Иох 10:11; Дуу 84:11; Ром 8:32).

Тэрээр жилийн эхнээс эцэс хүртэл биднийг халамжилдаг (Дх 11:12) ба өтөл болсон болсон ч биднийг авч явдаг (Иса 46:4). Тэр биднийг хэзээ ч мартдаггүй, хэзээ ч орхидоггүй (Евр 13:5). Бурхан үнэхээр халамжлан анхаардаг.

## 5 сарын 8

*“Би чамд харанхуйн эрдэнэс, далд газруудын нууцалсан эд баялгийг өгнө.” (Иса 45:3)*

Бурхан энэ амлалтыг Корешт өгөхдөө Корешийн эзэлж авсан харанхуй газруудын материаллаг эд баялгийн тухай ярьж байсан. Харин бид үүнийг энд сүнслэг зарчмаар авч үзэх боловч утга санааг нь гажуудуулахгүй.

Гэрэл гэгээтэй өдрүүдэд олдохгүй атлаа амьдралын харанхуй шөнөөр илэрдэг эрдэнэс гэж бий.

Жишээ нь, амьдрал тэгш дардан үед хэзээ ч дуулахгүй дууг хамгийн харанхуй шөнө Бурхан өгч чаддаг (Иов 35:10). Тийм ч учраас ийм нэгэн шүлэг зохиогдсон биз ээ:

*Гэрлийн хөвгүүдийн дундах*

*Олон сайн дуучин хожим*

*Хамгийн сайхан ая дуугаа*

*Харанхуй шөнө сурсан гэнэ.*

*Эцэгийн гэрт дуурьсах*

*Бадралт магтаалуудаа тэд*

*Харанхуй өрөөнд анх*

*Эшиглүүлэн зохиосон гэнэ*

Амьдралд заримдаа ийм харанхуй үе ирдэг. Ж. Стюарт Холден энэ тухай, “Амьдралд ирдэг гамшиг сүйрэл, гай зовлон, гэнэтийн тооцоолоогүй явдал, урьдчилан сэргийлэх боломжгүй асуудлууд нь ойлгох аргагүй амьдралын нууцууд юм. Гуниг, харуусал, урам хугарал, шударга бус явдал, буруу сэдэл, гүжир гүтгэлэг зэргээс болж амьдрал харанхуй болдог” гэж хэлсэн.

Хүнийхээрээ бодвол ямар ч хүн харанхуйг сонгохгүй. Гэтэл харанхуй үеийн ашиг тус нь тооцохын аргагүй их.

Лэсли Вэдерхэд ингэж бичжээ: “Хүн бүрийн адил би энх тунх, аз жаргалтай, амжилт дүүрэн гэрэл гэгээтэй амьдралыг сонгоно. Гэвч нар гийсэн өдрүүдээс илүү, айдас хүйдэс, алдаа бүтэлгүйтэл дүүрсэн харанхуй үедээ би Бурханы тухай, амьдралын тухай, өөрийнхөө тухай илүү сайн мэдэж авсан юм. Харанхуйн эрдэнэс гэдэг шиг зүйл үнэхээр байдаг. Тэр харанхуй өнгөрөн одсон учраас Бурхандаа талархъя. Гэхдээ харанхуйд сурсан зүйлээ хүн хэзээ ч мартдаггүй юм.”

## 5 сарын 9

*“Израилийн нутгаас авчирсан тэр охин...”* (2Хаа 5:4)

Бурханы төлөө агуу үйл бүтээхийн тулд заавал нэр алдраа мэдүүлэх албагүй. Харин ч мөхөшгүй алдрыг хүртэх библийн зарим хүний нэр огт дурдагдаагүй байна.

Бетлехемийн худгаас Давидад ус авчирсан гурван эр бий (2См 23:13-17). Давид энэ үйлдлийг дэндүү үнэ цэнтэй гэж үзэн, усыг уулгүй ариун өргөл болгож асгасан. Гэхдээ гурван эрийн нэр дурдагдаагүй.

Бид шунем эмэгтэйн нэрийг мэдэхгүй (2Ха 4:8-17). Гэвч тэрээр эш үзүүлэгч Елишад тусгай өрөө барьж өгснөөрөө үргэлж дурсагдах болно.

Нааман хэн гэдэг иудей охины зөвлөгөөгөөр Елиша руу очиж уяман өвчнөө эдгээсэн нь нууц үлджээ (2Ха 5:3-14). Бурхан түүний нэрийг мэднэ. Энэ л хамгийн чухал хэрэг билээ.

Есүсийн толгойг тосолсон эмэгтэй хэн байсан бэ (Мт 26:6-13)? Матай түүний нэрийг бичээгүй боловч Эзэн гавьяаг нь үнэлж “Үнэнээр Би та нарт хэлье. Энэхүү сайнмэдээ ертөнцийн хаа ч тунхаглагдсан, энэ эмэгтэйд дурсаж, үйлс нь яригдах болно” (Мт 26:13) гэж мэдэгдсэн.

Нэр нь үл дурдагдсан хүмүүсийн бас нэг жишээ бол хоёр зэс зоосоо эрдэнэсийн санд өргөсөн ядуу бэлэвсэн эмэгтэй (Лк 21:2). Хүний биш Бурханы магтаалд л ач холбогдол өгдөг бол Бурханы төлөө ямар их зүйл хийж болдгийг тэр эмэгтэй бидэнд харуулсан.

Дараагийн жишээ бол мэдээж таван талх, хоёр загсаа Эзэнд өгөөд эмэгтэйчүүд хүүхдүүдээс гадна 5000 эрийг

хооллосон хүүхэд (Иох 6:9). Бид түүний нэрийг мэдэхгүй. Гэхдээ түүний үйлс хэзээ ч мартагдахгүй.

Миний дурдах сүүлийн жишээ бол Иерусалим дахь ядуу итгэгчдэд зориулсан хандивыг цуглуулахаар Паулын зүгээс Титтэй хамт Коринт уруу илгээгдсэн хоёр итгэгч. Паул тэдний нэрийг дурдаагүй боловч тэднийг чуулгануудын элч нар, Христийн алдар хэмээн магтсан (2Ко 8:23).

Грэй, хөдөөгийн нэгэн сүмийн хашаанд оршуулагдсан, нэр нь үл мэдэгдэх хүмүүсийн булшийг үзэхдээ дараах шүлгийг бичжээ:

*Хээрийн цэцэгс өнгө алгалан ургадаг ч  
Хүний нүдэнд өртөлгүй хагдрах нь олон  
Анхилуун үнэр нь хий дэмий үрэгдэж  
Агаар мандалд таран замхрах нь олон*

Гэвч Бурханы хувьд юу ч дэмий үргэддэггүй. Тэрээр Өөрт нь үнэнчээр үйлчилсэн хүмүүсийн нэрийг бүгдийг мэддэг бөгөөд Өөрийнхөө эрхэм чанарын дагуу шагнах болно.

## 5 сарын 10

*“Түүний санааг бид ямар мэдэхгүй биш.” (2Ко 2:11)*

Бид өөрсдийн дайсан болох диаволын санааг мэдэх нь чухал. Эс бөгөөс түүний арга зальд унах болно.

Диавол худалч бөгөөд анхнаасаа худалч байсан гэдгийг бид мэдэж байх ёстой. Чухамдаа худал хуурмагийн эцэг нь тэр мөн (Иох 8:44). Тэрээр Евад Бурханы талаар худал мэдээлэл өгөхдөө худал хэлсэн бөгөөд одоо ч үүнийгээ хийсээр байна.

Диавол бол мэхлэгч (Илч 20:10). Тэрээр үнэний багахан хэсгийг авч худал хуурмагтай хольдог. Тэрээр Бурханы гэсэн болгоныг хуулбарлаж, хуурамчаар үйлддэг. Тэрээр гэрлийн тэнгэрэлч болж, элч нараа зөв шударгын үйлчлэгч мэтээр харуулдаг (2Ко 11:14,15). Тэрбээр агуу тэмдэг болон хуурамч гайхамшгуудыг ашиглан хууран мэхэлдэг (2Тс 2:9). Тэр хүмүүсийн бодол санааг завхруулдаг (2Ко 11:3).

Сатан бол алуурчин (Иох 8:44; 10:10). Түүний болон бүх чөтгөрийн зорилго нь алж устгах. Энэ үг үнэхээр үнэн. Тэрээр архирах арслан мэт залгих хүнээ хайж явдаг (1Пт 5:8). Тэрээр Бурханы хүмүүсийг хавчиж (Илч 2:10), хар тамхи, чөтгөр шүтлэг, архидалт, ёс суртахуунгүй байдал, бусад ёс бус явдлаар дамжуулан өөрийн боолуудыг устгадаг.

Тэр бол ах дүүсийг минь буруутгагч (Илч 12:10). “Диавол” (грекээр диаболос) гэдэг нь буруутгагч, гүтгэгч гэсэн утгатай бөгөөд энэ нь түүний мөн чанарыг оновчтой илэрхийлсэн нэр юм. Ах дүүсийг минь гүжирдэн гүтгэгч бүгд чөтгөрийн ажил хийж байна.



Тэр цөхрөлийн үрийг тарьдаг. Паул коринтчуудад бичсэн захидалдаа, буруутай хүн гэмшихэд эс уучилбаас Сатанд олз болж, ах дүүгээ хэт уй гашууд автуулах вий гэж сануулсан (2Ко 2:7-11).

Сатан Петрээр дамжуулан Есүсийг загалмай уруу очиход саад хийхийг санаархсан (Мк 8:31-33). Тэрээр үүн шигээ Христэд итгэгчдийг загалмайн ичгүүр ба зовлонгоос холдуулахыг хичээдэг.

Муу нэгний хамгийн дуртай арга бол хагалан бутаргах замаар эзлэн авах явдал юм. Тэрээр “айл гэр дотроо хуваагдвал оршин тогтнохгүй” гэдгийг мэддэг учраас ариун хүмүүсийн дунд хэрүүл маргаан, зөрчилдөөн үүсгэх дуртай. Харамсалтай нь түүний энэ стратеги маш амжилттай хэрэгждэг.

Тэрээр үл итгэгчдийн оюун ухааныг сохолж, Христийн алдрын сайнмэдээний гэрлийг харахгүй болгож, тэднийг авралаас холдуулдаг (2Ко 4:4). Ингэхдээ зугаа цэнгэл, хуурамч шашин, хойрго зан, бардамналыг ашигладаг. Тэр тэдний анхаарлыг баримтад бус мэдрэмжид, Христэд бус өөрсдөд нь төвлөрүүлдэг.

Эцэст нь хэлэхэд, Сатан агуу сүнслэг ялалтын дараа эсвэл оргилд гарсан үед довтолдог. Учир нь энэ үед бардамнах магадлал хамгийн их билээ. Тэрбээр бидний хуяг дуулганы сул хэсгийг хайж, яг тэр хэсгийг онилж харвадаг.

Диаволоос хамгаалах хамгийн сайн хамгаалалт бол Эзэнтэй гүн бат нөхөрлөлтэй байж, ариун шударга амьдрах явдал юм.

## 5 сарын 11

*“Моаб залуугаасаа л тайван байжээ. Шавар саван дотроо тэрээр сандаачуулагдаагүй байв. Тэрээр савнаас сав уруу уудлуулаагүй, цөллөгт ч яваагүй. Тиймээс тэрээр амтаа хадгалсан агаад тааламжит үнэр нь өөрчлөгдөөгүй.”*  
(Иер 48:11)

Иеремиа дарс исгэх урлагаас жишээ авч, амар хялбар амьдрал хүчтэй зан чанар бий болгодоггүйг бидэнд заадаг.

Дарсыг торхонд эсвэл ваарт исгэх үед шаар нь ёроолд тунана. Хэрэв тэр чигт нь зөнд нь орхивол амт муутай болдог. Тиймээс дарсыг нэг савнаас нөгөө рүү уудалж, шаар тунадсыг нь арилгах ёстой. Тэгснээр дарс улам шимтэй, сайхан үнэр, өнгө, амттай болдог.

Моаб улс амар тайван амьдарч байлаа. Тэрээр хэзээ ч олзлуулж, цөллөгт явж байсангүй. Зовлон бэрхшээл, сорилт, гачигдал дутагдал түүнээс алсад байлаа. Үүний улмаас Моабын амьдрал нэгэн хэвийн бөгөөд амт чанаргүй болов. Түүнд анхилуун үнэр, амт чанар дутжээ.

Дарсны энэ зарчим бидэнд ч мөн адил. Христээр дүүрэн амьдрахын тулд доторх хог шаарыг маань хөдөлгөж цэвэрлэх зовлон, эсэргүүцэл, бэрхшээл, саад тотгор амьдралд хэрэгтэй.

Төрөлх хандлага өөрсдийг минь зовоох алив зүйлээс зайлсхийдэг. Бид тав тухыг байнга эрэлхийлдэг.

Гэвч Бурхан биднийг Өөрийг нь түшдэг байгаасай гэж хүсдэг учраас тав тухыг минь олонтоо эвддэг.

Хатагтай Ховард Тэйлор, Хадсон Тэйлорын намтарт ингэж бичжээ: “Дэлхий даяар ерөөл болох учиртай энэ амьдрал их өөр замаар явах ёстой байжээ (тав тухад

шигддэг амьдралаас огт өөр). Нэг савнаас уудлагдаж, нөгөө сав уруу юүлэгдэж, дорд байдлаар явах байж. Үнэндээ энэ л биднийг цэвэршүүлдэг юм.”

Тэнгэрийн Дарс Исгэгч амьдралд минь юу хиймээр байгааг ухаарах үед бид тэрслэхээ зогсоож, хүлцэнгүй болж, Бурханаас хараат байхыг сурдаг. Бид дараах шүлгийг өөрийн болгодог:

*Бурханы бүрэн эрхт удирдлагад*

*Амьдралын жолоогоо атгуулаарай*

*Түүний замууд хэчнээн гайхалтайг*

*Түүний мутар хэчнээн хүчтэйг*

*Түүний мэргэн ухаан бодлоос тань дэндүү өндрийг*

*Төлөвлөсөн төлөвлөгөө нь төгс төгөлдрийг*

*Хийсэн ажил нь бүрэн дүүрнийг*

*Айдас тань хий хоосон болохыг*

*Тэгж байж л та олж харна.*

## 5 сарын 12

*“Бурханы мэргэн ухаан дор ертөнц мэргэн ухаанаараа Бурханыг таньж мэдсэнгүй. Иймд тунхагласан мэдээний мунхаглалаар итгэгчдийг аврах нь Бурханд тааламжтай байсан юм.” (1Ко 1:21)*

Коринтын чуулганы зарим хүн сайнмэдээг хүний ухаанаар нэр хүндтэй болгохыг оролдож байв. Ертөнцийн мэргэн ухаанд анхаарснаараа тэд философичдыг бүдрүүлдэг сайнмэдээний үндсэн чанарыг гээх байлаа.

Итгэлийг орхих бодол тэдэнд байсангүй. Гагцхүү сайнмэдээг арай өөр аргаар тунхаглаж эрдэмтдэд таалагдах арга зам олохыг хүсжээ.

Ертөнцийн мэргэн ухааныг Бурханыхтай нийлүүлэх гэсэн энэхүү оролдлогыг Паул хатуу шүүмжилсэн. Оюун ухааныг шүтвээс сүнслэг хүчийг алдана гэдгийг Паул сайн мэдэж байсан.

Үнэнтэй нүүр тулцгаая! Христийн сайнмэдээ нь иудейчүүдэд гутамшиг, харь үндэстнүүдэд мунхаглал гэж тооцогдох чанарыг агуулж байдаг. Тэгээд ч зогсохгүй, ихэнх Христитгэгчид ертөнцийн хувьд ухаалаг, хүчирхэг, дээд зиндааны хүмүүс биш. Энэ ертөнцийн мэргэдийн эгнээнд багтах гэж хичээхийн оронд, мунхаг, сул дорой, гадуурхагдсан, доод зиндааны хүмүүс гэдэг үнэнтэйгээ бид нүүр тулах хэрэгтэй. Үнэндээ бид энэ ертөнцийн нүдээр хэн ч биш.

Гэхдээ хамгийн гайхалтай нь, Бурхан мунхаг хэмээн тооцогддог мэдээгээр итгэгчдийг аварч, бидэн шиг хэн ч биш хүмүүсээр зорилгоо биелүүлдэг. Ийм дорой хүмүүсийг сонгохдоо Тэрээр энэ ертөнцийн бүхий л

бардамнал ба өргөмжлөлийг юу ч биш болгож, сайрхах боломжуудыг маань үгүй хийж, бүх магтаалыг Өөртөө авдаг.

Гэхдээ эрдэм мэдлэг хэрэггүй гэсэн үг биш. Мэдээж хэрэгтэй. Гол нь эрдэм мэдлэгт гүн сүнслэг байдал үгүй бол энэ нь онц аюултай зүйл болж хувирна. Жишээлбэл, зарим бичээч Бурхны Үгийг шүүж, түүнээс илүүг хэлж чадна гэдэг. Энэ нь Бурханы үнэнээс холдуулах аюултай. Эрдэм номтнуудын иймэрхүү баталгааг Бурханы үгийн дээр тавиад байвал бид гаж сургаалын замаар орох нь зайлшгүй.

Паул коринтчууд уруу уран илтгэл ба мэргэн үгстэй очоогүй. Тэрбээр цовдлогдсон Есүс Христээс өөр юуг ч мэдэхгүй байхаар шийдсэн. Учир нь ашиг өгөхгүй онолууд, ээдрээтэй асуудлуудын талаар цэц булаалдаж, оюун ухааныг шүтсэнээр биш, харин сайнмэдээг энгийнээр, шууд тунхагласнаар хүч оршдогийг Паул мэдэж байжээ.

## 5 сарын 13

*“Надад итгэгч энэ балчруудаас нэгийг нь хэн бүдрүүлнэ, тэр нь хүзүүндээ тээрмийн чулуу зүүгээд, тэнгисийн гүнд живсэн нь дээр.” (Мт 18:6)*

Тээрмийн чулуу зүүгээд усанд унасан байна гээд төсөөл дөө. Ямар ч авралгүй живэх нь мэдээж. Энд ярьж байгаа тээрмийн чулуу бол гараар ажиллуулдаг жижиг чулуу бус, илжгээр эргүүлдэг том чулуу юм. Ийм чулуу хүзүүндээ зүүсэн хүн яаж ч хичээгээд уснаас гарч чадахгүй, бараагүй живнэ.

Эхэндээ Аврагчийн энэ хурц үгэнд бид гайхаж магад. Балчруудыг бүдрүүлэх нүглийг Тэр юутай чанга ниргэнэ вэ! Юунаас болж Тэр ингэж их уурласан юм бол?

Хэдэн жишээ татъя. Сайнмэдээний нэгэн үйлчлэгч байжээ. Олон хүн түүнээс зөвлөгөө авах гэж ирдэг. Тэдний дотор завхайралд боолчлогдсон залуу байв. Уг залууд тусламж үнэхээр хэрэгтэй байлаа. Залуу сайнмэдээний үйлчлэгчийг нүглээс чөлөөлөгдөх зам зааж өгч чадах хүн гэдэгт бат итгэжээ. Гэтэл сайнмэдээний үйлчлэгч маань өөрөө дур тачаалын галд шатаж, муу үлгэр жишээ үзүүлсэн учраас залууг завхайрлын зам уруу нь буцаан түлхэв. Энэхүү итгэл эвдсэн явдлаас болж залуу итгэлээс бүр мөсөн хөндийрч, үлдсэн амьдралдаа сүнслэг амьдралаар алхаж чадсангүй.

Эсвэл оюутнуудынхаа итгэлийг мохоож байдаг их сургуулийн профессор байж болно. Тэрээр эргэлзээ ба үгүйсгэлийн үрийг тарьж, Библийн эрх мэдлийг доош хийж, Эзэн Есүс Христийн хэн болохыг үргэлж няцааж байдаг.

Эсвэл залуу итгэгчдийг бүдрүүлдэг буруу хандлагатай христитгэгч байж болно. Тэрээр эрх чөлөөний хязгаарыг давж, үл бүтэх үйлдэл гаргадаг. Үүнийг нь харсан залуу итгэгчид, христэч хүн ийм байж болно гэж үзээд ертөнцөөс тусгаарлагдах ариун шударга замналыг орхидог.

Эзэнд итгэсэн балчруудыг ёс суртахууны, ёс зүйн, сүнслэг байдлын гэм нүгэлд хөтлөх нь ямар ноцтой хэрэг болохыг бид Аврагчийн үгнээс ухаарч, сэрэмжилж явууштай. Эзэний балчруудыг нүгэлд унагасан буруутгал, ял зэм, харуусал, гутамшгийн далайд живснээс жинхэнэ ус уруу тээрмийн чулуу зүүгээд үсэрсэн нь хамаагүй дээр.

## 5 сарын 14

*“Бузар булай болон мунхаг яриа, эсвэл тоглоом тохуу нь зохимжгүй. (Еф 5:4 АБ2004)*

Алиа марзан яриа хэтэрвэл аажим аажмаар сүнслэг эрх мэдлийг үгүй хийдэг. Тиймээс ийм ярианаас зайлсхийх хэрэгтэй.

Номлогч, үхэл амьдрал дэнсэлсэн, мөнхийн хувь тавиланг шийдэх нухацтай асуудлыг ярьж байлаа гэж бодъё. Тэрээр сургаалаа чадварлаг заав. Гэвч номлолд нь хэт олон хошигнол орвол хүмүүс марзганалаас нь бусдыг мартаж магадгүй.

Заримдаа номлолын дараах хөнгөн хийсвэр ярианаас болоод номлолын хүч нөлөө үгүй болдог. Сайнмэдээний хүчирхэг номлолын дараа хүмүүс бодолд автан, нэгийг эргэцүүлж байтал, зарим нэг нь амьдралын аахар шаахар юмсыг ярьж эхэлдэг. Тэнд нэг нь хөл бөмбөгийн тэмцээний тухай, нөгөө нь ажил бизнесийн тухай яриа өрнүүлдэг. Ариун Сүнс гомдож, Бурханы ажлууд явагдахгүй байгаад гайхах юм алга.

Байнга хошигнодог ахмадууд залууст сүнслэг нөлөө үзүүлэх нь ховор. Уг нь бол залуус ахмадуудаасаа ухаарал авахыг боддог билээ. Тийм хүмүүс өөрсдийнхөө алиа хошин занг залуустай ойлголцох сайн арга гэж бодож магад. Гэвч үнэндээ ихэнх тохиолдолд залуучууд тийм ахмадуудад урам хугардаг.

Туйлын хорон нөлөөтэй марзганалын нэг нь Библийг хошигнолын хэрэгсэл болгох явдал юм. Бичвэрийн хэсгүүдийг ашиглаж амьдралыг өөрчлөхийн оронд инээдэм наргиан болгох нь аюултай. Библиэр хошигнох



тоолондоо бид түүний эрх мэдлийг өөрийн болон бусдын амьдралд унагаж байдаг.

Гэхдээ итгэгч хүн хошин шогийн мэдрэмжгүй, дүнсгэр байх ёстой гэсэн үг биш ээ. Гол нь өөрийн тунхагласан мэдээний хүч, эрх мэдлийг сулруулах хэмжээнд хэтрүүлэх хэрэггүй.

Киркегаард нэгэн циркийн алиалагчийн тухай ярьсан байдаг. Нэг өдөр цирк нь шатахад алиалагч хот уруу гүйж очин тусламж гуйн хашхирчээ. Гэтэл хүмүүс түүний өөдөөс инээлдээд ер хөдөлж өгсөнгүй. Тэрээр байнга алиалсаар байгаад үгэнд нь итгэх хүнгүй болжээ.

Чарльз Симеон суралцаж байхдаа Хэнри Мартини зургийг байнга авч явдаг байлаа. Хаа явсан газар нь Мартин түүн рүү хараад “Хичээнгүй бай, хичээнгүй бай. Бүү хойш суу. Бүү хойш суу” гэж хэлж байгаа юм шиг санагддаг байж. Тэгэхэд нь Симеон “Тийм ээ, би хичээх болно. Хичээх болно. Би хойш суухгүй. Учир нь хүмүүс мөхөж байна. Есүс алдарших ёстой” гэж хэлдэг байлаа.

## 5 сарын 15

*“Тэдний зарим нь гонгинож, устгагчаар хөнөөгдсөн болохоор тэдэн шиг бид үл гонгиноцгооё.” (1Ко 10:10)*

Цөлд явсан израильчууд архаг гомдоллогчид байлаа. Тэд усны талаар гомдоллосон. Хоол хүнсний талаар гомдоллосон. Удирдагчдынхаа талаар гомдоллосон. Бурхан тэнгэрээс манна өгөхөд тэд удалгүй залхаж, Египетийн ногоо, сонгино, саримсыг хүсэмжлэв. Цөлд хүнсний зах, гутлын дэлгүүр байгаагүй ч Бурхан дөчин жилийн турш тасралтгүй хоол хүнсийг өгч, эдэлгээ сайтай гутлаар хангасан. Гэтэл израильчууд энэхүү гайхамшигт хангамжид талархахын оронд зогсоо зайгүй гонгиножээ.

Хүний мөн чанар огт өөрчлөгдсөнгүй. Хүмүүс өнөөдөр цаг агаарын талаар гомдоллодог. Халахаар халлаа гэж, хүйтрэхээр хүйтэрлээ гэж гомдоллодог. Эсвэл агаар дэндүү чийгтэй байна гэцгээдэг. Хуурай болохоор дэндүү хуурай байна гэдэг. Тэд хоол хүнсний талаар гомдоллодог. Ажлынхаа талаар, цалингийнхаа талаар гомдоллодог. Ажилгүй болчихоороо ажилгүйдлийн талаар гомдоллодог. Тэд засгийн газрыг, татварыг буруутгах атлаа байнга халамж үйлчилгээг сайжруулахыг шаарддаг. Тэд бусдад гомдоллодог. Өөрсдийнхөө машинд сэтгэл дундуур байдаг. Ресторанд орохоороо үйлчилгээнд нь гомдоллодог. Тэд бага зэргийн өвчин зовуурт гомдоллодог. Тэгээд болоогүй, илүү өндөр эсвэл илүү туранхай эсвэл илүү царайлаг байсан ч болоосой гэцгээдэг. Бурхан тэдэнд хэчнээн сайн хандсан ч “Бурхан надад юу хийж өгсөн юм бэ?” гэж хэлдэг.

Гомдоллосон, гонгиносон хүмүүс Бурханд тээртэй ажээ. Бурхан бидэнд үргэлж сайнаар ханддаг. Тэр амьдралын хэрэгцээг минь хангаад зогсохгүй, Хүү нь энэ дэлхийд байхдаа эдлээгүй тансаг байдлыг бидэнд өгдөг. Бидэнд сайхан хоол, цэвэр ус, тохь тухтай гэр орон, олон тооны хувцас байна. Бидэнд хараа, сонсгол, хоолны дуршил, ой санамж гээд дурдаад байвал дуусахгүй олон ивээл байна. Бурхан биднийг хамгаалж, удирдан чиглүүлж, тэтгэж тэжээдэг. Бурханы өгсөн хамгийн агуу бэлэг бол Эзэн Есүс Христэд итгэх итгэлээр дамжин ирсэн мөнх амь билээ. Тэгвэл Бурхан ямар талархлыг хүлээж авдаг вэ? Тэрээр ихэнхдээ л гомдол гонгиноогоос өөр юу ч сонсдоггүй.

Хэдэн жилийн өмнө Чикагод нэг найз минь байлаа. Түүнээс “Ажил амьдрал ямар байна даа?” гэж асуухаар “Гомдолловол нүгэл болно” гэж хэлдэг байж билээ. Гомдоллох уруу татлага ирэх болгонд би найзынхаа үгийг боддог. Гомдоллох нь нүгэл юм. Гомдоллохыг эдгээх арга бол талархал. Эзэн бидний төлөө хийсэн бүхнийг дурсан санавал бидэнд гомдоллох ямар ч шалтгаан байхгүйг ойлгоно.

## 5 сарын 16

*“Ертөнц болон ертөнцөд байгаа зүйлсийг бүү хайрла. Хэрэв хэн нэгэн нь ертөнцийг хайрладаг бол түүний дотор Эцэгийн хайр байхгүй.” (1Ио 2:15 АБ2004)*

Ертөнц гэдэг нь Шинэ гэрээний утгаар бол Бурханыг эсэргүүцдэг хаанчлал юм. Түүний захирагч нь Сатан бөгөөд үл итгэгч бүхэн түүний албат. Энэ хаанчлал нүдний хуял тачаал, махан биеийн хүсэл, амьдралын бардамналаар дамжуулан хүмүүсийг захиргаандаа байлгадаг. Энэ хаанчлалд хүн, Бурхангүйгээр өөрийгөө аз жаргалтай болгохыг эрмэлзэж, Христийн нэрийг тээршээдэг. Доктор Глисон Л. Арчер Жюнёрийн тодорхойлсноор “Ертөнц бол Бурханыг эсэргүүцдэг, Бурхантай дайсагнадаг, Бурханд тэрсэлдэг, хүмүүнийг дөвийлгөдөг, хүн төрөлхтний зохион байгуулсан тогтолцоо” ажээ.

Ертөнц өөрийн гэсэн зугаа цэнгэл, улс төр, урлаг, хөгжим, шашин шүтлэг, үзэл санаа, амьдралын хэв маягтай бөгөөд хүн бүрийг түүндээ мөргүүлэхийг хүчилж, эс дагагсдыг үзэн яддаг. Ертөнц Эзэн Есүсийг үзэн ядаад байгаагийн шалтгаан энэ.

Христ биднийг ертөнцөөс аврахын тулд амиа өргөсөн. Одоо ертөнц бидний хувьд, бид ертөнцийн хувьд цовдлогдсон. Итгэгч хүн ертөнцийг ямар нэг хэлбэрээр хайрлах нь урвалт юм. Үнэндээ элч Иохан ертөнцийг хайрлагсад Бурханы дайсан гэж хэлжээ.

Итгэгчид энэ ертөнцийнх биш. Харин энэ ертөнц рүү илгээгдсэн хүмүүс. Илгээлтийн зорилго нь ертөнцийн эсрэг гэрчилж, бузар муу үйлсийг нь тунхаглаж, Эзэн Есүс

Христэд итгэх итгэлээр дамжин ирэх авралыг тунхаглах явдал билээ.

Христэд итгэгчид ертөнцөөс тусгаар алхахаар дуудагдсан. Өнгөрсөн үед бүжиглэх, театрт очих, тамхи татах, архи уух, хэзэр тоглох, мөрийтэй тоглох зэргээс хол байхыгаа ертөнцөөс тусгаар алхах гэж явцуу ойлгодог байсан. Гэтэл ертөнцөөс тусгаарлагдах гэдэг нь илүү том өргөн ухагдахуун. Телевизээр гардаг зүйлсийн ихэнх нь ертөнцийн юмст уруу татаж, нүдний тачаал, махан биеийн хүслийг өдөөдөг. Бардамнал ертөнцийнх. Тэр дундаа албан тушаал, зэрэг цол, цалин хангамж, өв хөрөнгө, алдар нэрээр бардамнах нь ертөнцийнх. Тансаг амьдрал бол ертөнцийнх. Орд харш шиг байшин, тансаг хоол, анхаарал татахуйц хувцаслалт, үнэт эдлэл, тансаг автомашин, амар хялбар амьдрал, тааламж, үнэтэй аялал зугаалга, үрэлгэн зан, спорт тоглоом, найр наадам бүгд ертөнцийнх. Түүгээр ч зогсохгүй, хэчнээн сүнслэг, сүсэглэл шиг харагдаж болох ч, өөрсдийнхөө болон үр хүүхдийнхээ төлөөх зорилго хүсэл маань ертөнцийнх байж болно. Эцэст нь хэлэхэд, гэр бүлээс гадуурх бэлгийн харилцаа ертөнцийнх.

Бид Аврагчтай хэдий чинээ ойр дотно байна, төдий чинээ Түүний төлөө амьдарч, ертөнцийн тааламж, зугаа цэнгэлд гаргах цаг завгүй болно. С. Стэйси Вүүдсийн хэлснээр, “Бид хэр хэмжээгээр Христэд үнэнч байна, тэр хэмжээгээр ертөнцөөс тусгаар алхдаг.”

*Христ Таныг цовдолсон энэ ертөнцөд бид*

*Харь элгийн цагаач болохоор орон гэр барихгүй*

*Хорвоод уягдсан холбоог маань загалмай тасалж*

*Хамаг өв, үнэт эрдэнэс маань зөвхөн Та л боллоо*

## 5 сарын 17

*“Хуурамч ч бай, үнэнээс ч бай аливаа замаар Христ тунхаглагдаж байна. Үүнд л би баярладаг. Мөн баярлах ч болно.” (Флп 1:18)*

Хүн бид өөрөөсөө бусдыг хүлээн зөвшөөрч чаддаггүй сул талтай. Бид л сайныг хийх ёстой юм шиг, бусдын сайныг хүлээн зөвшөөрч бусдыг дэмжиж чаддаггүй. “Би бол сайн. Харин чи яах вэ дээ л юм” гэж хэлдэг. Зарим хүний хувьд ингэж хэлэх нь хүртэл хүнд байдаг.

Тэдэнд өөрийнх нь чуулган цор ганц зөв, өөрийнх нь үйлчлэл цорын ганц чухал, өөрийнх нь үзэл бодол хамгийн үнэн. Тэд өөрсдийгөө хамгийн ухаантай гэж сэтгэн, мэргэн ухаан өөрсөдтэй нь хамт дуусах юм шиг санадаг.

Паул тэдний нэг биш ажээ. Бусад хүн бас сайнмэдээг тунхаглаж буйг Паул хүлээн зөвшөөрсөн. Зарим нь атаархлын улмаас, Паулыг цухалдуулъя гэсэндээ тунхагласан нь үнэн. Гэсэн ч Паул тэднийг сайнмэдээ тунхагласных нь төлөө үнэлж, Христ тунхаглагдаж байгаад баяртай байсан.

Доналд Гатри пасторуудын захидалд хийсэн тайлбартаа ингэж бичжээ: “Үнэн өөрөөс нь өөр сувгаар дамжин урсаж болохыг хүлээн зөвшөөрнө гэдэг агуу төлөвшил, эрх чөлөөт сэтгэхүй билээ.”

Гаж урсгалынхны нэг нийтлэг онцлог байдаг. Юу гэвэл, итгэлийн болоод ёс суртахууны асуудалд хэлсэн удирдагчдынх нь үг туйлын үнэн гэж тэд үздэг. Тэд өөрсдийн тунхаглалыг сохроор дагахыг шаардаж, өөрсдийн дагалдагчдыг өөр үзэл санаанаас тусгаарлахыг эрмэлздэг.

Библийн Жэймс Хааны орчуулгын (KJV) ховорхон уншигддаг удиртгал хэсэгт, “өөртөө эрдсэн, өөрийнхийгөө л зөв гэж бат итгэдэг, өөрөөсөө бусдыг хүлээн зөвшөөрдөггүй итгэгч” гэсэн үг гардаг. Эндээс бид нэг зүйлийг ухаарах ёстой. Юу гэвэл, сайныг хэн ч хийж байсан хүлээн зөвшөөрөх уужим бодолтой байж, ямар ч итгэгч, ямар ч чуулган ганцаараа зөв, ганцаараа үнэн байх боломжгүйг ухаарах хэрэгтэй.

## 5 сарын 18

“...тэрээр гоомой үгс хэлсэн юм.” (Дуу 106:33)

Израилийн ард түмэн Кадешт усаар дутагдахдаа гомдоллон гонгиноход Бурхан Мосед, хад уруу үг хэлмэгц ус урсана гэж хэлсэн. Гэвч Мосе ард түмний дарамт шахалтад унтууцахдаа “Сонсогтун, тэрслэгчид ээ. Бид энэ хаднаас та нарт ус гаргах ёстой юу?” гэж хэлээд хадыг таягаараа хоёр цохисон. Түүний ууртай үгс, дуулгаваргүй үйлдэл Бурханыг хүмүүст буруугаар илэрхийлсэн. Үүнээсээ болж Мосе, Израилийн хөвгүүдийг амласан газар уруу авч орох онцгой эрхээ алдсан (Тоо 20:1-13).

Шургуу зүтгэлтэй хүн бусад итгэгчдээс болж цухалдах амархан. Тэр өөрөө маш сахилга баттай атал, нөгөөдүүл нь нялх балчир зангаа тавьдаггүй. Тэр өөрөө их мэдлэгтэй атал бусад нь юу ч мэддэггүй. Тэгэхээр бухимдал төрдөг.

Гэхдээ түүний сурах ёстой зүйл бий. Юу гэвэл, тэд хэчнээн сул дорой байсан ч Бурханы хайртай хүмүүс хэвээр бөгөөд тэднийг хэл амаар доромжлохыг Эзэн тэвчихгүй. Хүмүүсийг гэмшүүлэхийн тулд Бурханы үгийг хүчтэй тунхаглах нэг хэрэг. Харин өөрийн уур уцаараас болж тэднийг хахир үгээр дайрах өөр хэрэг юм. Ийм зангаасаа болж Бурханы хамгийн сайхан шагналыг ч алдах боломжтой аж.

Давидын гайхамшигт эрчүүдийг 2Самуел 23-р бүлэгт жагсаан бичсэн. Гэтэл тэнд нэг хүний нэр гардаггүй. Тэр бол Давидын жанжин Иоаб юм. Яагаад түүний нэр алга байна вэ? Иоаб, Давидын зарим найзыг илд мэсээр далайлгасан учраас түүний нэрийг энд бичээгүй гэж таамагладаг. Хэрэв энэ үнэн бол бид өөрсдийн хэлийг



Бурханы хүмүүсийн өөдөөс сэлэм мэт ашиглах нь буруу гэдгийг харуулж байгаа бус уу?

Аянгын хөвгүүд Иаков, Иохан нар самаричуудын дээр тэнгэрээс гал буулгахыг хүсэх үед Есүс “Та нар ямар сүнснээс байгаагаа мэдэхгүй” гэж хэлсэн (Лк 9:55). Бүтээл нь болохын хувьд Бурханд хамаатай хүмүүсийг (самаричууд шиг хүмүүсийг) төдийгүй, цусаа урсгаж Өөрийн болгосон хүмүүсийнх нь талаар амаараа гоомой үгс хэлэх хэчнээн аюултайг Эзэний зэмлэл эрхгүй сануулж байна.

## 5 сарын 19

*“...Бурханы шүүлт нь үнэний дагуу байдгийг харин бид мэднэ.” (Ром 2:2)*

Энэ ертөнц дээр шүүх болзлыг хангасан цорын ганц Нэгэн бол Бурхан юм. Тэр эцсийн шүүлтийг бидэнд даатгаагүйд бид үүрд талархаж болно. Дэлхийн шүүгчдийн гаргаж болох сул талуудыг бодоод үзье. Тэд хэргийг бүрэн үнэн зөв олж харж чадахгүй байж болно. Эсвэл шүүгдэгчийн нэр төрд автах юм уу гадаад үзэмжид нь анхаарч болзошгүй. Эсвэл хээл хахууль авч болно. Эсвэл заль мэхэнд унаж магадгүй. Гэрч худал хэлж буйг шүүгч үргэлж мэдэж чадахгүй. Гэрч нь худал хэлээгүй байсан ч үнэнийг нуух боломжтой юм. Эсвэл үнэнийг бүрхэгдүүлэхийг үгүйсгэх аргагүй. Аль эсвэл, чин үнэнээ хэллээ ч, зарим баримтыг орхигдуулсан байж болно.

Шүүгч хүн бусдын сэдлийг үргэлж мэдэх аргагүй. Хэргийг шүүн хэлэлцэхэд хүний сэдлийг тогтоох нь нэн чухал юм.

Тэр ч байтугай, полиграф ба үнэн худал яриаг илрүүлэгч багажийг ч хуурах боломжтой. Мэргэжлийн зарим гэмт хэрэгтнүүд буруутгалын үед төрдөг бие физиологийн хариу үйлдлийг хянах чадвартай байдаг.

Харин Бурхан бол төгс Шүүгч юм. Тэрээр хүмүүсийн бүх үйлдэл, бодол санаа, сэдлийг бүрэн мэддэг. Тэрээр хүмүүсийн зүрхний нууцуудыг шүүж чадна. Бурхан бүх үнэнийг мэддэг. Түүнд юу ч саад болж чадахгүй. Тэрээр хүн бүрд эрх тэгш зарчмаар хандаж, хэнийг ч ялгаварлахгүйгээр шүүх болно. Тэр хүн нэг бүрийн оюуны чадамжийг мэднэ. Хэнд илүү боломж, хэнд илүү завшаан,

хэнд илүү чадвар, хэнд илүү гэрэл өгөгдсөнийг мэднэ. Тэр хэн нь уруу татлагыг илүү эсэргүүцэх чадвартайг ч мэднэ. Тэрээр мартагдсан нүглийг ч санадаг бөгөөд нууцаар үйлдэгдсэн нүглийг олны өмнө үйлдсэн үйл явдал мэт ил болгох чадалтай.

Тийм учраас сайнмэдээг хэзээ ч сонсоогүй хүн шударга бусаар шүүгдэнэ гэж бид санаа зовох хэрэггүй. Амьдралынхаа турш шударга бусаар зовсон хүн шударга ёсыг үзэхгүй өнгөрнө гэж айх шаардлагагүй. Энэ амьдралдаа нүглийнхээ горыг амсаагүй увайгүй этгээд шийтгэлгүй өнгөрнө гэж ч бодох хэрэггүй.

Хүн төрөлхтний Шүүгч төгс бөгөөд шударга ёс нь үнэний дагуу тул шүүлт нь туйлын төгс байх болно.

## 5 сарын 20

*“Хэн ч шинэ дарсыг хуучин туламд хийдэггүй. Тэгвэл шинэ дарс тулмыг зад татна. Дарс асгарч, тулам ч сүйднэ. Харин шинэ дарсыг шинэ туламд л хийх ёстой.”* (Лк 5:37-38)

Тулам бол амьтны арьсаар хийсэн сав юм. Шинэ тулам нь зөөлөн, уян хатан шинж чанартай. Харин хуучрах тусмаа хатуурч, уян хатан чанараа алддаг. Хуучин туламд хийсэн шинэ дарс исэх явцдаа хэт их даралт өгч тулмыг зад татна.

Лук 5-р бүлэгт Есүс үүнийг ашиглан иудейзм ба христигтэлийн хоорондох зөрчлийг дүрсэлжээ. Тэрээр “Иудейзмын ёслол, ёс заншил, зан үйлүүд нь шинэ эрин үеийн баяр баясгалан, хөөр баяр, эрч хүчийг дотроо агуулах боломжгүй хэтэрхий хатуу хуучин тулам мэт баригдмал” гэж хэлж байна.

Энэ бүлэгт үүнийг дүрслэн харуулах жишээ хэд хэд гардаг. 18-21-р эшлэлд, дөрвөн хүн саа өвчтөнийг Есүс дээр авчрахдаа байшингийн дээврийг эвдэж орсон. Тэдний шинэлэг бөгөөд уламжлалт бус арга нь шинэ дарсны дүрслэл болж байна. 21-р эшлэлд, хуулийн багш нар ба фарисайчууд Есүсийг буруутгасан. Тэд бол хуучин дарсны төлөөл аж. Дараа нь 27-29-р эшлэлд Христийн дуудлагыг урам зоригтойгоор хүлээн авсан Леви Есүст найз нараа танилцуулахаар цайллага зохион байгуулсан тухай гардаг. Энэ бол шинэ дарс. 30-р эшлэлд хуулийн багш нар ба фарисайчууд дахин Есүсийг буруутгасан. Тэд хуучин тулам юм.

Үүнийг бид өөрийн болон өрөөл бусдын амьдралаас байнга олж хардаг. Хүмүүс аливаа зүйлийг уламжлалт бус аргаар хийхэд дургүйцэж, өөрчлөлтөд дасан зохицож чаддаггүй. Гэрийн эзэгтэй нар аяга тавгаа угаах өөрийн гэсэн арга барилтай бөгөөд угаалтуурыг нь өөр хэн нэгэн ашиглахыг хараад унтууцдаг. Нөхрүүд машин барих өөрийн гэсэн арга барилтай. Эхнэр хүүхдүүдээ жолооных нь ард суухад сандарч тэвдэн бачимддаг.

Сүнслэг талбар дээр ч гэсэн эндээс авах сургамж бий. Бидэнд танил бус арга замаар ирсэн байсан ч христитгэлийн баяр хөөр, ивээл ерөөл, сайн сайхныг бид хүлээн авах уян хатан, уужим дотортой байх хэрэгтэй. Бурхан ажиллаж байхад Түүнийг шүүмжилж суусан фарисайчууд шиг хатуу, баригдмал бодол бидэнд хэрэггүй.

## 5 сарын 21

*“Үнэнээр үнэнээр Би та нарт хэлье. Буудайн үр газар эс унан, эс үхвээс тэр ганцаараа үлдэнэ. Харин тэр үхвээс олон үр гаргана.” (Иох 12:24)*

Нэг өдөр хэсэг грекчүүд Филип дээр ирээд “Эрхэм ээ, бид Есүсийг харъя” гэж хэлжээ. Тэд яагаад Түүнийг харахыг хүссэн юм бол? Магадгүй алдартай шинэ философичийн хувиар Түүнийг Афин уруу авч явахыг хүссэн байх. Эсвэл Түүнийг загалмай ба үхлээс аварья гэж бодсон ч юм уу? Яг ямар санаатай байсныг нь бид одоо тодорхой мэдэхгүй.

Есүс тэдэнд үр тарианы зарчмаар хариуг нь өгсөн. Хэрэв үр олон буудай ургуулъя гэвэл газарт унаад үхэх ёстой. Есүс Өөрийгөө үхлээс аврахыг хүссэн бол ганцаараа үлдэх байсан. Мэдээж Тэр тэнгэрийн цог жавхлангаа эдэлнэ. Гэвч Түүний алдрыг хуваалцах нэг ч нүгэлтэн аврагдахгүй байх байсан юм. Гэхдээ Тэр үхсэн. Ингэж Тэр олныг мөнх амьтай болгох авралын замыг бэлтгэсэн. Тэрээр тав тухтай амьдрахын оронд золиос гарган үхэх замыг сонгожээ.

Т. Г. Регланд нэгэн удаа ингэж хэлсэн: “Заавал амжилтад хүргэдэг зарчмуудаас улаан буудайн үр болоод газарт унаж үхэх ёстой гэдэг Христийн зарчим хамгийн баталгаатай нь юм. Хэрвээ бид буудайн үр болохоос татгалзаад, Христийн төлөө үзэл бодол, нэр төр, эд хөрөнгө, эрүүл мэндээ эрсдэлд оруулахыг хүсэлгүй, дулаан гэртээ шигдэх аваас ганцаараа үлдэнэ. Үр жимстэй байя гэвэл Эзэн Есүсийн үлгэр жишээг дагах ёстой. Тэрээр

улаан буудайн үр болж газарт унаад үхсэн юм. Энэ жишээг дагавал бид маш их үр жимс гаргаж чадна.”

Хэдэн жилийн өмнө би Африк уруу явсан хэсэг илгээлтийн эздийн талаар уншиж байлаа. Тэд олон жил эцэж цуцалгүй ажилласан боловч үр жимс гарахгүй л байлаа. Цөхрөнгөө барсан тэд хамтдаа цугларч, Бурханы өмнө сууж, залбирч, мацаг барихаар шийдэв. Тэдний дундаас нэг нь “Үр газарт унаад үхэхээс нааш бид үр жимс олж харна гэж би бодохгүй байна” гэж хэлжээ. Түүнээс нэг их удалгүй энэ үгийг хэлсэн илгээлтийн эзэн хүндээр өвдөж нас баржээ. Түүний дараа л илгээлтийн эзний яриад байсан үр жимс ургаж эхэлсэн юм.

Самуел Звемер ингэж бичжээ:

*Алдагдал нь ололтыг авчирна*

*Аврал нь загалмайгаар ирнэ*

*Тарианы үр газарт унаад үхвэл*

*Тал дүүрэн ургац гаргана*

*Алтранхан найгах арвин буудай*

*Амиа нэг нь өгснийг харуулна*

*Зовлонг сөрж үхсэнийг гэрчилнэ*

*Зориулж, зүтгэж, залбирсныг илтгэнэ*

## 5 сарын 22

*“Хамартаа амьсгал нь байдаг хүмүүнд хандахаа боль. Юуны учир тэр хүндлэгдэх ёстой гэж?” (Иса 2:22)*

Бид Бурханы эзлэх байр суурийг өөр хэн нэгэн хүнд өгөх үед хэзээ нэгэн цагт заавал урам хугарна. Хүн гэж хүн л юм байна гэдгийг бид ухаарна. Хэчнээн сайн хүн ч ямар нэг алдаа дутагдалтай. Энэ нь хүнийг дорд үзсэн мэт санагдаж болох ч тийм биш. Энэ бол бодит байдал.

Иерусалим дайсны халдлагад өртөх үед Иудагийн ард түмэн Египетээс тусламж хүссэн. Энэ байдлыг Исаиа зэмлэж, “Харагтун, чи энэ цуурсан хулсан таяг шиг Египетэд найдаж байна. Хүн ийм таягийг тулбал алгыг нь тэр шааж, цоо хатгана. Египетийн хаан Фараон өөрт нь түшиглэгч бүгдийг ингэдэг юм” (Иса 36:6) гэж хэлсэн. Хожим Иеремиа ч бас үүнтэй адил нөхцөл байдал үүсэхэд, “ЭЗЭН ингэж айлдаж байна. Аяа, итгэл нь хүн төрөлхтөнд, хүч чадал нь бие махбод уруугаа, зүрх сэтгэл нь ЭЗЭНээс эргэсэн нэгэн нь хараалтай яа” (Иер 17:5) гэж хэлсэн.

Дуулал зохиогч энэ сэдвээр тодорхой мэдэгдэл хийжээ. “Хүнд итгэхээс ЭЗЭНий дотор хоргодох нь дээр. Ноёдод итгэхээс ЭЗЭНий дотор хоргодох нь дээр” (Дуу:118:8,9). “Ноёдод, авралгүй хүний хүүд ч бүү итгэ. Сүнс нь гарч явах үед тэд газар шороо уруу буцдаг. Яг тэр өдөр бодлууд нь мөхдөг билээ.” (Дуу:146:3,4).

Мэдээж хүн бид бие биедээ итгэх зайлшгүй шаардлага байдаг. Жишээлбэл итгэлцэл, хүндлэл үгүй бол гэр бүл яаж оршин тогтнох юм бэ? Бизнесийн ертөнцөд чекийг мөнгөний зориулалтаар ашигладаг нь харилцан итгэлцлийн үндсэн дээр суурилдаг. Эмчид үзүүлэхдээ



намайг зөв оношилж, зөв жор бичиж өгсөн гэж бид итгэдэг. Хоол хүнсний сав баглаа боодлын шошго дээр бичсэн үгэнд бас итгэдэг. Хүн нэг нэгэндээ итгэхгүйгээр нийгмийн амьдрал явах ямар ч боломжгүй.

Гол нь Бурханы хийж чадах зүйл дээр хүнд итгэлээ тавьж, Эзэнийг хаан сэнтийнээс нь буулгаж, хүнийг оронд нь тавих нь аюул юм. Бид хүнийг Бурханаас дээгүүр тавьж, хүнд итгэл найдвараа өгч, Бурханы эзлэх байр сууринд хүнийг залбал эргээд өөрсдийн минь урмыг хугалдаг. Эрт орой хэзээ нэгэн цагт хүн гэгч амьтан итгэл даахгүй гэх гашуун сургамжийг бид хүртэнэ.

## 5 сарын 23

*“Энэ нь Эцэг Та Миний дотор, Би Таны дотор байгаатай адил, тэд бүгд нэг байхын тулд бөгөөд мөн тэд Бидний дотор байж, Та Намайг илгээсэн гэдэгт ертөнцийг итгүүлэхийн тулд билээ.” (Иох 17:21)*

Эзэн Есүс тэргүүн тахилчийн хувиар бидний төлөө залбирахдаа биднийг нэг байлгаж өгөхийг Бурханаас хоёр удаа гуйсан (21, 22, 23-р эшлэл). Итгэгчдийг нэгдмэл байлгахын төлөө залбирсан энэ залбирлыг баримтлан Христийн нэртэй бүх чуулганыг нэгтгэх хөдөлгөөн (экуменик буюу дэлхийн хэмжээний хөдөлгөөн) гарч ирсэн. Харамсалтай нь энэхүү хөдөлгөөний нэгдэл нь Христийн тулгуур сургаалуудыг умартаж, өөрөөр тайлбарлаж эхэлсэн. Малкольм Магриж: “Христийн дотор нийлэх юу ч байхгүй мөртлөө олон чуулганыг нэгтгэж чадаж байгаа экуменик хөдөлгөөн бол энэ цагийн нэг аюул юм. Сургаалын жижиг сажиг ялгааг үл харгалзан ямар ч урсгал чиглэлийн чуулган бие биетэйгээ хялбархан нэгдэж чадаж байна. Гэвч тэдний жижигхэн гэж байгаа ялгаа нь үнэндээ жижиг байдаггүй.”

Эзэн Есүс Иохан 17 дээр ийм нэгдлийн төлөө залбирч байсан уу? Би үгүй гэж хэлнэ. Бурхан Хүүгээ илгээсэн гэдэг ижил итгэл үнэмшилтэй л бол нэгдмэл байна гэж Есүс хэлээгүй. Түүний хэлж байгаа нэгдлийн үр дүнд Бурхан Есүсийг илгээсэн гэдэгт энэ ертөнц итгэнэ гэж Тэр хэлсэн. Гадна талын эв нэгдэл ийм үр дүнд хүргэнэ гэж би бодохгүй байна.

Эзэн ямар эв нэгдлийг ярьж байснаа Өөрөө тодорхойлж хэлсэн: “Эцэг Та Миний дотор, Би Таны дотор

байгаатай адил, тэд бүгд нэг байхын тулд...” “Бид нэг байдгийн адил...Би тэдний дотор, Та Миний дотор. Ингэснээр тэд бүрэн төгс нэг болно...” Эцэг, Хүү нэг гэдэг нь ямар утгатай вэ? Бид Тэдэн шиг нэгдмэл байна гэдэг нь юу гэсэн үг вэ? Нэг Бурханд итгэдэг итгэл үнэмшлээр нэгдэхийг хэлж байна уу? Үгүй! Эзэн Есүс ижил зан чанараар нэгдэхийг хэлсэн гэж би үздэг. Итгэгчид Бурханы болон Христийн зан чанарыг энэ ертөнцөд харуулахдаа адил байхын тулд Тэр залбирсан. Нэг ёсондоо, зөвт байдал, ариун чанар, хайр, цэвэр ариун байдал, тэвчээр, биеэ захирах, даруу төлөв байдал, өгөөмөр зангаараа ижил байхыг хэлж байна. Рональд Сайдер “Өлсгөлөн үеийнхний дундах баян итгэгч” номдоо “Христийн залбирсан тэрхүү нэгдэл нь хэрэгцээтэй нэгэндээ байгаагаа үнэгүй хуваалцаж байсан анхны итгэгчдээс тод харагдсан” гэж цохон тэмдэглэсэн. Тэдэнд жинхэнэ нэгдмэл байдал байлаа. Энэ ертөнцөд үнэнийг ойлгуулж чаддаг хайрын эв нэгдэл, дагалдагчдынх нь дунд байгаасай гэж залбирсан Эзэн Есүсийн залбиралд Эцэг Бурхан дор хаяж нэг удаа хариулжээ. Энэ нь Иерусалимын чуулганд тохиолджээ. Тэд хамтдаа нэгэн хүн мэт амьдарч байсан нь элч нарын сургаалд хүч нэмсэн байна. (Үйл 2:45-47; 4:32-35-ыг үз)

Өнөөдөр ийм нэгдэл байх юм бол энэ ертөнцөд гүн гүнзгий сэтгэгдэл төрүүлнэ. Итгэгчид нэгэн сэтгэлээр Эзэн Есүс Христийн амьдралыг гэрчилбэл үл итгэгчид нүгэлт байдлаа ухаарч, амийн усыг хүсэмжлэн цангах болно. Харамсалтай нь өнөөдөр олон итгэгч үл итгэгч хөршөөсөө ялгарах юмгүй амьдарч байна. Ийм байхад үл итгэгчид Христ уруу тийм ч амар эргэхгүй нь аргагүй шүү дээ.

## 5 сарын 24

“Гэнэт олсон эд хөрөнгө хорогдох...” (Сур 13:11)

“Та зуун мянган доллар хожих боломжтой.” Энэ мэт сайхан уриа лоозон биднийг ямар нэг хэлбэрийн мөрийтэй тоглоомд уруу татдаг. Жирийн нэг гэрийн эзэгтэй дэлгүүрт хүнс цуглуулаад явж байтал хонжворт сугалаа нүдийг нь татна. Ихэнх хүн сая долларын азын шагнал амласан сонин сэтгүүлийг захиалдаг. Эсвэл гарцаагүй ялна гэсэн итгэл төрүүлэхүйц бинго уралдаан байж ч болох юм.

Мэдээж мөрийтэй тоглоомын илэрхий хэлбэрүүд гэж байна. Жишээ нь рулет, морин уралдаан, нохой уралдаан, тооны тоглоом гэх мэт.

Библи энэ талаар юу гэж хэлсэн бэ? Сайн юм нэг ч хэлээгүй.

“Гэнэт олсон эд хөрөнгө хорогдох. Хөдөлмөр шингэсэн аваас арвижих.” (Сур 13:11)

“Хорон нүдтэй хүн эд баялгийн араас яаравчлах, Харин ядуурал түүнд ирчхээд буйг үл анзаарах.” (Сур 28:22)

“Шударга бусаар эд хөрөнгөтэй бологч нь гаргаагүй байж өндөг дардаг ятуутай адил. Хижээл насанд нь энэ нь түүнийг орхиж, эцэст нь тэр мунхаг болно.” (Иер 17:11)

Арван тушаалд “Чи бүү мөрийтэй тогло” гэж байдаггүй нь үнэн. Гэхдээ “Чи бүү шунахайр” (Гэт 20:17) гэж бичигдсэн. Тэгвэл мөрийтэй тоглоом нь шунахайрлын нэг хэлбэр биш гэж үү?

Мөрийтэй тоглоом нь итгэгчдэд хэзээд муухай сэтгэгдэл төрүүлэх учиртай. Учир нь бидний Аврагч Эзэн

цовдлогдож байхад Ромын цэргүүд хувцсыг нь шодон мөрийцсөн.

Мөрийтэй тоглоомд донтсон хүн гэр бүлдээ ямар их ядуурал, уй гашуу авчирдгийг бодоод үз. Эд хөрөнгөө алдсан хүмүүс гэмт хэрэгт орооцолддогийг тунгаа. Мөрийтэй тоглоом үргэлж бузар муу үр дагаврыг авчирдаг. Энэ бүхнийг бодоход л христэч хүнд мөрийтэй тоглоом огт зохицохгүй гэдэг нь илэрхий байна.

Итгэгч хүн идэх хоол өмсөн хувцастай байхад л сэтгэл хангалуун байх ёстой гэж Пуал Тимотод сануулсныхаа дараа “баяжих хүсэлтэйчүүд нь уруу татлага ба урхи, зүсэн бүрийн мунхаг, хор хөнөөлтэй хүсэлд унадаг. Эдгээр нь хүмүүсийг үгүйрэл ба сүйрэлд живүүлдэг” (1Тм 6:9) гэж сэрэмжлүүлсэн.

## 5 сарын 25

*“Ах дүү чинь нүгэл үйлдвээс явж түүнтэй ганцаарчлан уулзаж зэмлэ.” (Мт 18:15а)*

Хэн нэгэн таныг гомдоох юм уу танд бурууг үйлдлээ гэж бодъё. Библи энэ тохиолдолд ах дүү дээрээ очоод бурууг нь өөрт нь хэл гэдэг. Гэвч та тэгэхийг хүссэнгүй. Энэ нь танд дэндүү хэцүү алхам байлаа.

Тиймээс та энэ талаар байнга бодож эхэлнэ. Түүний хийсэн зүйлийг, ямар буруутайг нь ахин дахин бодно. Ажлаа хийх цагаар болсон үйл явдлын нарийн ширийнийг хүртэл дурсаж, ходоодны шүүс чинь хүхэрлэг болж эхэлдэг. Унтах цагаар тэр муухай явдлуудыг эргэн санаж, уур хилэндээ автана. Ах дүү дээрээ очиж бурууг нь өөрт нь хэл гэж Библи хэлсээр байтал та түүнтэй нүүр тулан уулзаж чадахгүй.

Та шууд бус замаар түүнд өөрийнхөө санааг ойлгуулах арга саам бодно. Эсвэл хийсэн зүйлийнхээ төлөө ичгүүрт орох ямар нэг зүйл түүнд тохиолдоосой гэж хүснэ. Гэвч тийм юм болохгүй. Та юу хийх ёстойгоо мэдэж байвч нүүр тулж уулзахаас зүрхшээнэ.

Энэ нь тэр хүнийг биш эргээд таныг өөрийг чинь хохироодог. Хүмүүс таныг хараад сэтгэлд чинь ямар нэг юм болохгүй байгааг хэлцгээнэ. Та тэдэнтэй ярьж байвч бодол санаа чинь өөр газар явж байдаг. Үүнээсээ болоод ажлаа ч олигтой хийж чадахаа болино. Учир нь санаа сэтгэл чинь ерөөсөө тогтож өгөхгүй ажээ. Гэтэл Библи “Явж очоод хоёулхнаа уулзаж түүнд бурууг нь хэл” гэж сануулсаар л байдаг. Та хов жив хөөцөлдөхгүй гэж маш их хичээсэн боловч дотроо байгаа тэр их дарамтыг даахаа

болино. Эцэст нь тэсэхээ больж түүний талаар өөр хүнд буюу залбирлын хамтрагчид нь хэлэхээр шийднэ. Гэтэл тэр таны бодож байсан шиг таныг өрөвдөхийн оронд “Чи яагаад өөртэй нь уулзаж ярилцаж болохгүй байгаа юм бэ?” гэж хэллээ.

Ингээд та зугтах газаргүй болж, Бурханы үгийг дагахаар шийдэн таныг гомдоосон хүн дээр очиж бурууг нь хэлэв. Анд нөхөр чинь ч гэсэн муу юм бодсонгүй, харин ч уучлалт гуйж буруугаа хүлээлээ. Та хоёрын ярилцлага залбирлаар төгсөв.

Ингээд таны дотор бугласан бул хар чулуу зайлуулагдаж, ходоод чинь өвдөхөө больж, бодисын солилцоо чинь хэвийн байдалдаа орлоо. Би ер нь яагаад Бурханы үгийг дагаагүй юм болоо гэж та өөрийгөө зэмлэлээ.

## 5 сарын 26

*“Харагтун, дуулгавартай дагах нь нядлах тахилаас илүү, анхааран үзэх нь хуцын өөхнөөс илүү.” (1См 15:22)*

Бурхан, Саул хаанд маш тодорхой заавар өгсөн. “Амалекчуудийг хүйс тэмтэрч, бүх эд хөрөнгийг нь устга. Ямар ч олз авахгүйгээр бүгдийг нь арчин хая” гэж Бурхан тушаасан. Гэвч Агаг хааныг Саул хэлтрүүлж, шилмэл хонь, үхэр, хурга, ишгийг нь үлдээжээ. Самуел өглөө эрт Саултай уулзахаар Гилгалд ирлээ. Саул “Би Эзэний тушаалыг ёсчлон биелүүлсэн” гээд маадгар зогсож байв. Гэтэл яг тэр мөчид Саулын үлдээсэн хонь мал хоолой нийлүүлэн майлж, мөөрч эхлэв. Саул нүүр хийх газаргүй болжээ.

Мэдээж Самуел юу болсныг тодруулж “Хэрэв чи бүгдийг нь устгасан юм бол энэ майлж, мөөрөлдөөд байгаа мал хуй ямар учиртай юм бэ?” гэж асуусан. Саул хаан өөрийн дуулгаваргүй байдлыг хаацайлахын тулд ард түмнийг буруутгаж, шашны ёслолоор шалтаг гаргасан. Тэрээр “Энэ ард түмэн Эзэнд тахил өргөх гэж шилмэл мал сүргийг үлдээсэн юм” гэж хариулав.

Үүнийг сонссон эш үзүүлэгч Самуел аянгын нүргээн мэт хатуу үгээр Саулыг зэмлэсэн: “Харагтун, дуулгавартай дагах нь нядлах тахилаас илүү, анхааран үзэх нь хуцын өөхнөөс илүү. Тэрслэл нь мэргэ төлгийн адил нүгэл бөгөөд гөжүүдлэх нь ёс бус агаад шүтээнд мөргөх адил билээ.”

Дуулгавартай байдал нь тахил, өргөл, зан үйл, шашны ёслолоос хэдэн мянга дахин чухал юм. Ээжийгээ амьд сэрүүн байхад хүйтэн хөндий хандаж, дуулгаваргүй байсан хүүхдүүд нас барсных нь дараа цогцост нь гоёмсог



хувцас өмсүүлж, цэцэг навчаар гоёжээ. Олон жил ачлалгүй, дуулгаваргүй явсныгаа ийм өрөвдөлтэй аргаар цайруулж байгаа нь тэр аж.

Хүмүүс Библийн үндэсгүй үзэл санаа, Бурханд таалагдахгүй холбоо харилцаагаа өмөөрөхдөө “Ийм аргаар хүмүүст хүрч нөлөөлнө” гэх маягийн юм ярьдаг. Гэвч Бурхан ийм утгагүй ярианд хууртахгүй. Тэр зөвхөн дуулгавартай байдлыг хүсдэг. Бусдыг нь Бурхан Өөрөө хийх болно. Үнэндээ дуулгаваргүй байвал бусдад хэзээ ч сайнаар нөлөөлж чадахгүй. Зөвхөн Эзэнтэй ойр дотно харилцаатай байгаа цагтаа л бид бусдад бурханлаг нөлөө үзүүлнэ.

“Дуулгаваргүйн тахил нь Бурханыг доромжлохтой адил.” (Уилльям Гарнел) Дуулгаваргүй байдлыг шашинлаг, сүсэглэг шалтгаар халхлах нь түүнээс бүр долоон дор хэрэг мөн. Бурхан тэнэг биш шүү!

## 5 сарын 27

*“Мунхаг, сохрууд аа, аль нь чухал вэ? Алт уу эсвэл алтыг ариусгадаг сүм үү?” (Мт 23:17)*

Есүсийн үеийн хуулийн багш нар болон фарисайчууд хүн сүмээр тангараглавал тангаргаасаа няцаж болно, харин сүмийн алтаар тангараглавал тангаргаа заавал биелүүлэх ёстой гэж сургадаг байв. Мөн тахилын ширээгээр тангараглавал тангаргаасаа няцаж болно, харин тахилаар тангараглавал тангаргаа заавал биелүүлэх ёстой гэж заадаг байжээ.

Тэдний аливаа юмыг үнэлэх үнэлэмж гажуудсан байгааг Эзэн хэлсэн. Алтыг онцгой болгож байгаа нь сүм юм. Түүн шиг тахилыг онцгой болгож байгаа нь тахилын ширээ.

Дэлхий дээр Бурханы орших газар нь сүм байсан. Тэгэхээр тухайн газарт ашиглагдсан алт нь биш, сүм нь өөрөө хүндлэлийг авах ёстой юм. Бурханы өргөөний нэг хэсэг болсон болохоор л тэр алт онцгойд тооцогддог. Тахил ба тахилын ширээний асуудал ч үүнтэй ижил. Тахилын ширээ нь Бурханы мөргөлийн салшгүй хэсэг байлаа. Уг тахилын ширээн дээр тахил болж өргөгдөх нь мал амьтдын хувьд нэр төрийн хэрэг юм. Хэрэв мал амьтанд хүсэл мөрөөдөл гэж байдаг бол тэд тахилын ширээн дээр өргөл болохыг бүх зорилгоо болгох байсан биз ээ.

Нэгэн жуулчин Парисын хуучин эд зүйлийн дэлгүүрээс хямд хуванцар зүүлт худалдаж авчээ. Тэгээд Нью Йоркт ирээд гаалиар гарах гэтэл түүнд нь өндөр татвар ногдуулав. Гайхсан жуулчин түүнийгээ үнэт

эдлэлийн худалдаачинд аваачиж үзүүлэхэд 25 мянган доллароор авах санал тавив. Өөр нэгэн худалдаачин 35 мянган долларын үнэ хэлэв. Жуулчин түүнээс “Энэ зүүлт яагаад ийм үнэтэй байгаа юм бэ?” гэж асуухад үнэт эдлэлийн худалдаачин жуулчинд томруулдаг шилээр зүүлтийг харууллаа. Зүүлтэд “Наполеон Бонапартаас Жозефинд дурсгав” гэсэн бичиг байж. Наполеоны нэр хүзүүний зүүлтийг ийм үнэ цэнтэй болгожээ.

Эндээс бид юу ойлгох ёстой нь тодорхой байна. Бид өөрсдөө бол юу ч биш, юу ч хийж чадахгүй. Харин Эзэнтэй холбогдож, Эзэнд үйлчилдэг учраас үнэ цэнтэй болж байгаа юм. "Голготатай холбоотой чинь л чиний хамгийн гайхамшигт зүйл юм шүү!" гэж Спержон хэлсэн.

Та үнэхээр ухаантай хүн байж болно. Мэдээж энэ бол талархмаар хэрэг. Гэхдээ таны ухаан Эзэн Есүс Христийн төлөө ашиглагдах үедээ л хамгийн агуу хувь тавиланг олно. Таны ухааныг бусдынхаас онцгойруулж байгаа нь Христ юм.

Магад та энэ ертөнцөд өндрөөр үнэлэгдэх авьяас чадвартай байж болно. Түүнийгээ чуулганы төлөө хэрэглэнэ гэхээр доошоо орох юм шиг санагддаг байх. Гэвч таны авьяас чадварыг онцгойруулагч нь чуулган болохоос таны авьяас чадвар чуулганыг онцгойруулахгүй.

Эсвэл та асар их хөрөнгө чинээтэй хүн байж болно. Та тэр их мөнгөө нэг бол өөрийнхөө сайн сайхны төлөө, эс бол Бурханы хаанчлалын төлөө зарцуулж болно. Хөрөнгө мөнгөө Христийн үйл хэрэгт зарцуулбаас хамгийн утга учиртай зарцуулалт мөн. Гэхдээ таны мөнгө Бурханы хаанчлалыг гийгүүлж байгаа юм биш. Харин Бурханы хаанчлал таны мөнгийг үнэ цэнтэй болгож байгаа юм.

## 5 сарын 28

*“Харин бид бүгд бүтээлэггүй нүүрээрээ Эзэний алдрын тусгалыг тольдох мэт хараад, Түүний дүрд Эзэний Сүнсээр алдраас алдарт өөрчлөгддөг.” (2Ко 3:18)*

Бид шүтэж мөргөдөг зүйлтэйгээ адилхан болдог гэж Библи сургадаг. Энэ чухал санаа өнөөдрийн эшлэлээс харагдана. Энэ эшлэлийг задалж ярьцгаая.

Харин бид бүгд – Бүх жинхэнэ итгэгч

бүтээлэггүй нүүр – Нүгэл нь бидний нүүр болон Эзэний урдуур бүтээлэг татдаг. Бид нүглээ улайж, түүнээсээ гэдрэг эргэвэл бидний нүүрэн дэх бүтээлэг авагдана.

Эзэний алдрын тусгал – Түүний яруу сайхан зан чанар гэсэн утгатай. Библиэс бид Түүний төгс зан чанар, ажил үйлсийнх нь гоо сайхныг олж хардаг.

тольдох мэт харах – Бидэнд Эзэнийг толь мэт тунгалаг харуулах зүйл бол Бурханы үг юм.

Түүний дүрд өөрчлөгддөг – Бид Түүнийг олж харснаараа Түүнтэй адил болдог. Бодол санаа маань хэдий чинээ Түүгээр дүүрнэ, төдий чинээ бид Түүнтэй адил болно.

Эзэний Сүнсээр – Библид илчлэгдсэн Аврагчийг итгэлээр олж харах үед маань Ариун Сүнс биднийг улам бүр Христтэй адил болгодог.

алдраас алдарт – Нэг түвшнээс нөгөө түвшинд гэсэн үг. Бидний өөрчлөлт нэг байрандаа зогсдоггүй. Эзэнээс хараагаа салгахгүй байвал бидний дотор өөрчлөлтийн үйл явц байнга явагдана. Энэхүү зан чанарын хувьсан өөрчлөлт нь Ариун Сүнсний ажил билээ.

Натаниел Хоуторнын үлгэрүүдэд Эрнест том чулуун нүүрэн дээр чимээгүй суугаад бясалгадаг байв. Ингэхдээ чулуун нүүрийг байнга ширтэнэ. Эцэст нь тэр түүнтэйгээ адилхан болдог. Харин түүний дэргэд байсан ноён Гэйдергоулд, генерал Блүүд ба Тандр, хөгшин Стони Физ, яруу найрагчийн хэн нь ч тийм болдоггүй.

Би нэг хүний тухай сонссон юм. Тэр хүн өдөр бүр Буддын сүмд очоод завилан суугаад ногоон өнгийн шүтээн рүү ширтэн бясалгадаг байжээ. Ийнхүү олон жил бясалгаад Буддатай яг адилхан болсон гэж хүмүүс ярьдаг. Энэ нь үнэн худлыг би мэдэхгүй. Гэхдээ Бурханы Хүүг эмээн хүндлэн байж байнга бодож явах нь биднийг Түүнтэй адил зан чанартай болгодгийг баттай мэднэ.

Бид Эзэн Есүсийг нүд салгалгүй ширтсэнээр ариун байдалд хүрнэ. Христийг бодохынхоо хажуугаар нүглийг бодох боломж байдаггүй. Тэр үед Христ бидний бодлыг эзэмдсэн байдаг учраас нүглээс бид ангид байдаг. Тэгэхээр Эзэн Есүсийг ширтэн харж, Түүний тухай бодох цагаа нэмэгдүүлэх нь бидний зорилго болох ёстой.

## 5 сарын 29

*“Би үүнийг дутагдсаны улмаас ярьж байгаа юм биш.”*  
(Флп 4:11)

Паул санхүүгийн хэрэгцээгээ бусдад ер хэлдэггүй байсан. Тэр итгэлийн хүн байлаа. Бурхан өөрийг нь үйлчлэлдээ дуудсан учраас бүх хэрэгцээг нь хангана гэдэгт Паул итгэж амьдарсан.

Итгэгчид өөрсдийн хэрэгцээг олон нийтэд хэлж мөнгө гуйх хэрэгтэй юу? Энд би хэд хэдэн бодууштай зүйлийг хэлмээр байна. Итгэгчид өөрсдийнхөө хэрэгцээг зарлаж мөнгө гуйдаг байдал Библийн зарчим ерөөсөө биш. Элч нар бусдын хэрэгцээг хүмүүст хэлж байсан боловч өөрсдийнхөө төлөө хэзээ ч мөнгө гуйж байгаагүй.

Аливаа хэрэгцээгээ зөвхөн Бурханд даатгаж, Бурханы хангамжийг хүлээх нь итгэлийн амьдралтай зохицно. Бурхан биднээр ямар нэг зүйл хийлгэх гэж байгаа бол шаардлагатай санхүүг заавал хангаж өгдөг. Бурхан хэрэгтэй цагт нь хэрэгтэй хэмжээний мөнгө санхүүг хангаж өгвөл бидний итгэл ч гэсэн өснө. Түүгээр ч зогсохгүй үнэхээр Бурхан хангасан гэдгийг үгүйсгэх аргагүй байх юм бол Бурхан ч ихээр алдаршина. Нөгөө талд, бид мөнгө босгох ухаалаг арга хэрэгслээр дамжуулан санхүүгийн хэрэгцээгээ хангавал Бурханд тийм ч их алдар магтаал очихгүй.

Бусдыг сэнхрүүлэх, ятгах замаар мөнгө босгож, Бурханы ажлыг хийнэ гэвэл магадгүй тэр нь Бурханы хүсэл биш ч байж болно. Аль эсвэл Ариун Сүнс тухайн ажлаас холдон одсоны дараа бид тэрхүү ажилтай

зууралдаад байх боломжтой. Харин бид Бурханы ер бусын хангамжийг түшиглэвэл Эзэний замчилснаар явж чадна.

Хэт их ятгалаг, албадлага нь Христийн ажлын амжилтыг хэмжих шинэ хандлагыг бий болгосон. Олон нийттэй хэн сайн харилцаж чадна, тэр нь хамгийн баян болдог гажууд үзэгдэл газар авсан. Мөнгө босгох аянууд мөнгөнд итгэмжгүй хандлагаас болоод үнэ цэнтэй ажлууд муугаар хэлэгддэг. Энэ нь мөн атаархал, хагарлыг бий болгодог.

Ч. Х. Макинтош өөрийн хувийн хэрэгцээг олон нийтэд танилцуулах явдлыг зэмлэсэн байна. Тэрээр ингэж бичжээ: “Өөрийн хэрэгцээг хүмүүст шууд ба шууд бус замаар мэдүүлэх нь итгэлийн амьдралд харш бөгөөд Бурханыг гутаан доромжилсонтой адил. Үнэндээ Бурханаас урвасан хэрэг мөн. ‘Бурхан миний хэрэгцээг хангаж чадахгүй байгаа учраас би бусдаасаа тусламж гуйхаас өөр аргагүй боллоо’ гэж хэлж байгаагаас ялгаагүй. Мөн амийн усны ундаргыг хаяад эвдэрхий усны савыг сонгосонтой адил. Бурханаас илүү хүмүүст найдлага тавиад ирэхээр сэтгэл минь ивээл ерөөлөө алдаж Бурханд зүй ёсоор алдрыг авчирч чадахаа больдог.”

Корри Тэнь Бүүм “Эзэний төлөө тэнүүлч” номдоо Макинтоштой санаа нэгтэй үг хэлсэн: “Би энэ дэлхийн хүмүүсийн хаалган дээрх гуйлгачин байснаас баян Аавдаа найддаг хүүхэд нь байхыг илүүд үзнэ.”

## 5 сарын 30

*“Эцэгээс өөр хэн ч Хүүг мэдэхгүй.” (Мт 11:27)*

Эзэн Есүс Христийн бодгаль, мөн чанар, хэн бэ гэдэг тухайд ойлгох аргагүй зүйл их байдаг. Тэрээр зуун хувь Бурхан, зуун хувь хүн юм. Христ Бурханы бүх чанарыг агуулсан атлаа хүний хязгаарлагдмал цар хүрээнд хэрхэн амьдарч чаддаг вэ гэсэн асуулт өөрийн эрхгүй урган гардаг. Жирийн хүн бид үүнийг хэзээ ч бүрэн гүйцэд ойлгож чадахгүй. Зөвхөн Бурхан Эцэг ойлгож чадна.

Христийн нэрээр гарсан ихэнх гаж урсгал яг энэ сэдвийг барьж авдаг. Тэд хүмүүний хязгаарлагдмалыг хүлээн зөвшөөрөлгүй өөрсдөдөө хэтэрхий ахадсан гүн сэдвийг ухаж төнхдөг. Зарим нь Эзэний бурхан чанарыг дэндүү онцлоод хүн ахуйг нь бүдгэрүүлдэг. Зарим нь Есүсийг жирийн нэг хүн гээд бурхан чанарыг нь доош дардаг.

Уилльяам Келли: “Бурханы Хүү хүн болсон тухай сэдэв маш их гажуудлыг төрүүлдэг. Нэг талд, Эзэн Есүсийг жирийн нэг хүн гэх хандлага бий. Энэ үнэхээр аюултай сургаал юм. Гэхдээ Эзэн Есүсийг жирийн нэг хүний хэмжээнд аваачихаас илүү зальтай үзэл санаанууд бас бий. Тэд Эзэн Есүсийг Бурхан хэмээн хүлээн зөвшөөрдөг боловч хүн гэдэг өнцгийг нь бүрхэгдүүлдэг. Энэ нь эхнийхээсээ ямар ч ялгаагүй гажууд сургаал. Яг энэ сэдэв дээр иймэрхүү гажуудлаас хамгаалах ганцхан арга бий. Юу гэвэл, бид Эзэн Есүсийн мөн чанар, хэн болох, бодгалийнх нь талаар ухаарч ойлгохгүй гэдгээ хүлээн зөвшөөрч, энэ тухай цэцэрхэн ярихаа больж, энэхүү ариун газарт хүний мунхаглалыг гишгүүлэхээс эмээж, бид бол



зөвхөн хүндлэн мөргөгчид билээ гэсэн байр суурин дээр зогсох хэрэгтэй. Ийм хандлагыг умартсан хүнийг Бурхан хэзээ ч дэмжихгүй. Тэр хүн Эзэн Есүсийн талаар бүгдийг мэддэг юм шиг өөртөө итгэлтэй байгаа нь бардамнал төдийгүй мунхаглал болой. Бурханы цорын ганц Хүүгийн талаар Ариун Сүнсний илчилснээс илүүг бид мэдэж чадахгүй.”

Эзэний эрхэм хүндтэй нэгэн зарц, Эзэний хоёр мөн чанарын тухай ярихдаа Библийн үг хэллэгээс битгий хальж байгаарай гэж оюутнууддаа захидаг байжээ. Бид өөрсдийн санаа бодлыг нэмж эхлэхээр л алдаа гажуудал гарч ирдэг юм шүү!

Хүүг хэн ч мэдэхгүй. Зөвхөн Эцэг л мэднэ.

*Түүний нэрийн агуу нууцуудад*

*Хүмүүн ухаан яахин хүрэх*

*Эцэг Бурханаас өөр хэн ч*

*Хүүг мэдэж яахин чадах*

(Жозаиа Кондер)

## 5 сарын 31

*“Харин төрөлх хүн Бурханы Сүнсний зүйлсийг хүлээж авдаггүй. Ийм хүнд эдгээр нь мунхаглал бөгөөд сүнслэгээр цэгнэгдэх учиртай эл зүйлсийг тэр мэдэж чаддаггүй.”*  
(1Ко 2:14)

Төрөлх хүн гэдэг нь дахин төрөөгүй хүн юм. Түүнд Бурханы Сүнс байдаггүй. Түүнд сүнслэг үнэнүүд утга учиргүй сонсогддог учраас сүнслэг үнэнүүдийг тэр хүлээж авдаггүй. Зөвхөн тэгээд дуусахгүй. Тэр сүнслэг үнэнүүдийг ойлгож **чадахгүй**. Яагаад гэвэл тэдгээрийг зөвхөн Ариун Сүнсний гэгээрүүлээр ойлгох боломжтой.

Үүнийг бид сайн бодох ёстой юм. Аврагдаагүй хүн Бурханы юмыг ойлгохыг хүсэхгүйгээс гадна угаасаа ойлгож чадахгүй. Түүний төрөлх чанарт тэдгээрийг ойлгох чадвар байдаггүй.

Үүнийг мэдсэнээр энэ ертөнцийн эрдэмтэн, гүн ухаантан, мэргэжлийн гэх хүмүүсийг би зөв үнэлж дүгнэдэг болсон юм. Тэднийг өөрсдийн салбарын асуудлыг ярих үед мэргэжилтэн болохынх нь хувьд би хүндэлдэг. Гэвч сүнслэг зүйлсийг яриад эхлэхээр тэднээс зайгаа барьдаг. Учир нь ямар нэг эрх мэдэлтэйгээр сүнслэг зүйлийг ярих чадвар тэдэнд угаасаа байхгүй юм.

Их сургуулийн профессор, либерал үзэлтэй зарим санваартан Библид эргэлзэж, Библийг үгүйсгэж байгааг одоо би гайхдаггүй. Тэгэх нь ч зүй ёсны юм шиг санагддаг. Тиймээс ч тэдний яриаг тоож үздэггүй. Дээрээс төрөөгүй хүмүүс Бурханы Сүнсний зүйлсийг ярьж эхлэх үедээ өөрсдийнхөө оюун ухааны цар хүрээнээс хэтэрсэн сэдэв рүү орсныг нь би мэддэг.

Ф. В. Борем шинжлэх ухаан, философийн мундгуудыг усан онгоцны хоёрдугаар зэрэглэлийн зорчигчидтой зүйрлэсэн. “Эрдэмтэн ба гүн ухаантнууд, мөн өөрсдийгөө мэргэн цэцэн хэмээгчид нь хоёрдугаар зэрэглэлийн зорчигч юм. Тэднийг нэгдүгээр зэрэглэлийн зорчигчоос тусгаарладаг тусгаарлагч байдаг. Тэд тэр хүрээндээ л байх хэрэгтэй. Тэдэнд Христитгэлийн талаар ямар ч эрх мэдэл байхгүй. Үнэндээ бидний итгэл нь хоёрдугаар зэрэглэлийн зорчигчдоос дэмжлэг туслалцаа авах хэмжээний дорд биш ээ. Эсвэл тэдний буруутгалаар ганхахаар хэврэг ч биш.”

Мэдээж хэрэг, Эзэн Есүст итгэдэг эрдэмтэн, гүн ухаантнууд бий. Борем тэдний талаар ингэж хэлсэн байна: “Заримдаа нэгдүгээр зэрэглэлийн тасалбартай эрдэмтэн, гүн ухаантнуудтай би таардаг. Би ч тэдэнтэй нөхөрлөхдөө баяртай байдаг. Гэхдээ би Жон Буняаныг даяанч гэж боддоггүй шигээ тэднийг ч гэсэн эрдэмтэн гэж бодохгүй. Тэд надтай адил нэгдүгээр зэрэглэлийн зорчигч юм.”

“Хүн хад чулуу, атом молекул, түмэн бодисын талаар бүхнийг мэддэг, эрдэм мэдлэгтэй, логик сэтгэлгээтэй байж болно. Тэглээ гээд Христитгэл болон Библийн талаар үнэн зөв үнэлэлт өгч чаддаг байх албагүй.” (Роберт Г. Ли)

## 6 сарын 1

*“ЭЗЭН Иосефтой хамт байсан учир түүний бүх ажил үйлс бүтэмжтэй болов.” (Эх 39:2)*

Англи Библийн нэн эртний нэгэн орчуулгад энэ эшлэлийг “And the Lord was with Joseph, and he was a **luckye fellow**” гэж орчуулсан байдаг гэнэ. “Luckye” (орчин цагийн англи хэлэнд “азтай” гэсэн утгатай) гэдэг нь тухайн үед өөр утгатай байсан биз ээ. Хожуу үеийн орчуулагчид Иосефийг азтай гэж ойлгогдохоор үг сонгоогүйд би баяртай байна.

Учир нь Бурханы хүүхдэд аз гэж байдаггүй. Түүний амьдралыг тэнгэрлэг Эцэг нь удирдаж, хамгаалж, төлөвлөдөг. Түүний амьдралд тохиолдол гэж үгүй. Тэгэхээр христэч хүн бусдад аз хүсэх нь зохимжгүй. Эсвэл “Би өнөөдөр их азтай байлаа” гэж хэлэх нь ч нийцэхгүй. Иймэрхүү хэллэгүүд Бурханы чиглүүлэг, удирдлага, замчлахуйг үгүйсгэсэнтэй адилхан.

Зарим хүн, туулайн хөл, шувууны цээжний яс, дөрвөн навчит хошоонгор зэргийг аз дагуулдаг гэж итгэдэг. Харин зарим нь хуруугаа салаавчлаад модон дээр тогшвол золгүй явдлыг зайлуулж, нөхцөл байдлыг таатай болгодог хэмээн үздэг.

Харин зарим нь хар муур, 13-ны баасан гараг, шатны доогуур явах, 13 номерын өрөө, 13 давхар зэргийг муу ёртой холбодог. Хүмүүс ийм их мухар сүсэгт боолчлогдож, ямар ч утга учиргүй хүлээсэнд байгааг харах үнэхээр харамсалтай.

Исаиа 65:11-ийг үзвэл аз төөргийн бурханд мөргөдөг иудейчүүдэд шийтгэл оноохоо Бурхан мэдэгдсэн.

*Харин ЭЗЭНийг орхин  
Ариун уулыг минь мартаж,  
Аз завшаанд ширээ засаж,  
Хувь тавилангийн төлөө найруулсан дарсыг дүүргэгч  
хүмүүс ээ.*

Аз тохиолд итгэхийг шуудхан нүгэл гэж хэлэхэд хэцүү. Гэхдээ аз тохиолтой холбоотой шүтээнд хүмүүс өргөл өргөж байсныг Бурхан үзэн ядсан. Тэр одоо ч үзэн яддаг.

Хэрвээ бид сохор азын шатрын хүү, төөрөг тавилангийн нэг тохиолдол юм бол юунд итгэж найдаж явах юм бэ? Энэ амьдралын бүх зүйл төлөвлөгдсөн бөгөөд утга учир зорилготой. Бидний хувьд энэ нь хувь тавилан биш бидний Эцэг, тохиол биш Христ, аз биш хайр билээ.

## 6 сарын 2

*“Одоо хангалттай. ЭЗЭН минь, би эцэг өвгөдөөсөө дээрдэх юмгүй тул одоо миний амийг аваач.”* (1Ха 19:4)

Бурханы хүмүүс Елиагийн нэгэн адил сэтгэл гутралд орох тохиолдол цөөнгүй. Мосе, Иона нар ч гэсэн, болдогсон бол үхэхийг хүссэн (Гэт 32:32, Ион 4:3). Эзэн итгэгчдэд ийм асуудал ирэхгүй гэж амлаагүй. Ийм асуудалд орлоо гээд сүнслэг бус, итгэлгүй хүн болчихгүй. Хэнд ч ийм юм тохиолдож болно.

Амьдралд хүнд хэцүү асуудал ирэх үед Бурхан таныг хаясан юм шиг санагддаг. Бурхан хүүхдүүдээ хэзээ ч хаяхгүй гэдгийг сайн мэдэж байгаа ч энэ мэдрэмж төрдөг. Тэр үедээ та Бурханы үгээс тайтгарлын үгсийг хайж, уучлагдашгүй нүгэл, найдваргүй нөхцөл байдалд Бурхан яаж хандсан талаар олж уншихыг хичээдэг. Эсвэл та эмчилгээгүй өвчнөөс болж шаналж байж болно. Найзууд тань “Наадахаа ялан дийл” гэж уриалах боловч яаж гэдгийг нь хэлж өгч чадахгүй. Та олонтоо залбирч, эдгэрэхийг маш их хүссэн боловч асуудал зовлон чинь өчүүхэн төдий ч багасахгүй. Таны толгойд зөвхөн зовлон эргэлдэнэ. Ингэж зовж шаналж байхдаа “Бурхан намайг үхүүлдэг ч болоосой” гэж хүснэ.

Иймэрхүү гутрал, цөхрөл янз бүрийн шалтгаантай. Энэ нь бие физиологийн асуудал байж болно. Жишээ нь цус багадалтаас болоод гутардаг. Эсвэл сүнслэг асуудал байж болно. Гэмшээгүй, уучлаагүй нүгэл хүнийг зовоодог. Эсвэл сэтгэл санааны нөлөө байж болно. Хань ижил нь завхайрвал хүн сэтгэл гутралд ордог. Эсвэл хэт их ажил, оюуны ачаалал хүнийг туйлдуулдаг. Эсвэл энэ нь эмийн

нөлөө байж болно. Зарим хүн тодорхой эмүүдэд дэндүү мэдрэг, эм нь гаж нөлөө үзүүлдэг.

Ийм үед бид юу хийх ёстой вэ? Эхлээд залбирлаар Бурханы өмнө очиж, гайхамшигт зорилгоо миний амьдралд хэрэгжүүлээч гэж гуй. Нүгэл байвал түүнийгээ гэмшиж, улайж, таягдан хая. Танд буруу юм хийсэн хүнийг уучил. Тэгээд дараа нь биеэ эмчид үзүүлж шинжилгээ хийлгэ. Бие физиологийн ямар нэг асуудал байгаа эсэхийг шалгуул. Ачаалалтай ажил, санаа зовнил гэх зэрэг стресс үүсгэдэг зүйлсээс зайлсхий. Тогтмол амарч, шим тэжээлтэй хоол идэж, дасгал хөдөлгөөн хийвэл сайн эмчилгээ болно.

Үүний дараа таны бодол санаа цэгцрээд ирнэ. Цаашид яах ёстойгоо ч ойлгоод ирнэ. Харин дараа нь сэтгэл гутралд оруулах зүйлсэд үгүй гэж хариулах сэтгэлийн хаттай ч болсон байна.

## 6 сарын 3

*“Иймээс би Бурхан ба хүмүүсийн өмнө сайн мөс чанартай байхыг үргэлж хичээдэг билээ.” (Үйл 24:16)*

Ялзарсан нийгэм, төрөлхийн нүгэлт чанарт амьдардаг бид ёс суртахууны хэм хэмжээг баримталж, Христийн зарчмуудад үнэнч эсэхээ шалгуулах уруу татлагатай байнга тулгардаг.

Жишээлбэл, шалгалтдаа хуулах уу үгүй юу гэдэг сорилт оюутнуудад ирдэг. Үнэнч бусаар авсан бүх дипломыг буцааж авбал их сургуулиуд дүүрэн дипломтой болох нь дамжиггүй.

Татвар төлөгчид орлогоо багаар мэдүүлэх, зарлагаа өсгөж хэлэх, чухал мэдээллээ нуун дарагдуулах сорилттой байнга тулгардаг.

Бизнес, улс төр, хуулийн салбарт хээл хахууль мөнхийн дагуул байсаар ирсэн. Шударга ёсыг гажуудуулахын тулд авлигал өгч, эмх журмыг алдуулахын тулд гар цайлгаж, бизнесээ урагшлуулахын тулд хахууль өгдөг. Хатуу шаардлагатай байцаагчийг хүртэл бэлэг сэлтээр зөөллөж болдог.

Бараг бүх салбарт шударга бус хандах зайлшгүй шаардлага тулгардаг. Христэч эмч даатгалын худал нэхэмжлэлд гарын үсэг зурах эсэхээ шийднэ. Гэм буруутайг нь мэдсээр байж гэмт хэрэгтнийг өмгөөлөх үү үгүй юу, христэч хосын салах асуудалд оролцох уу үгүй юу гэдэг асуулт өмгөөлөгчийн өмнө тулгарна. Хуучин машины худалдаачин, миль заагчид нь тохиргоо хийж бага явсан гэж харагдуулах уу үгүй юу сорилтод орно. Жирийн ажилтан үйлдвэрчний эвлэлд нэгдэж, эсэргүүцлийн



хөдөлгөөнд оролцох эсэхээ шийдэх ёстой болдог. Христэч онгоцны үйлчлэгч зорчигчдодоо архиар үйлчилж болох уу гэдэг асуудалтай нүүр тулна (онгоцны үйлчлэгчийн ажилд орвол сонголт угаасаа байхгүй). Христэч тамирчин Эзэний өдөр тэмцээнд орох нь зөв үү буруу юу гэдэг асуулт урган гарна. Христэч худалдагч хорт хавдар үүсгэдэг тамхийг зарж болох уу үгүй юу? Үүнийг ч бас бодно.

Итгэгч архитектур шөнийн цэнгээний газар юм уу либерал чуулганы барилгын зураг төсөл гаргах нь зөв үү буруу юу? Христийн байгууллага архи үйлдвэрлэдэг компани эсвэл нүглээ гэмшдэггүй итгэгчээс хандив тусламж авах нь зөв үү буруу юу?

Энэ мэт эргэлзээтэй асуулт бидний өмнө байнга тулгардаг. Тэгвэл хариултыг нь хэлье: *“Бурхан ба хүмүүсийн өмнө сайн мөс чанартай байхыг эрмэлз.”*

## 6 сарын 4

*“ЭЗЭН бол агуу ба өндөрт магтууштай. Түүний агуу байдал хэмжээлиггүй билээ.” (Дуу 145:3 АБ2004)*

Бурханы тухай бодол нь хүмүүний оюун ухааныг эзэмдэх хамгийн агуу бодол билээ. Бурханыг хэр агуу гэж бодно төдий чинээ амьдрал өнгө орно. Бурханыг жижгээр боддог хүн амьдралаа тэр хэмжээгээр сүйрүүлдэг.

Бурхан үнэхээр агуу. Бурханы аугаа сүр жавхлангийн талаар Иов, “Харагтун, Түүний замуудын өчүүхэн нь энэ юм. Түүний талаар бидний сонсдог үг ямар амархан бэ! Гэвч Түүний хүчит нүргээнийг хэн ойлгож чадах вэ?” (Иов 26:14) гэж тодорхойлсон. Бид Бурханы аугаа зүйлсийн өчүүхнийг харж, багахныг л сонсдог.

“Түүнийг дэлхий уруу харахад тэр нь чичирдэг. Уулсад хүрэхэд нь тэд утаа уугиулдаг.” (Дуу 104:32) Эзэн тэнгэр газар дээрхийг үзэхээр өөрийгөө бөхийлгөх шаардлагатай болдог (Дуу 113:6). Тэр оддыг нэрээр нь дууддаг тийм агуу (Дуу 147:4).

Бурханы нөмрөгийн хормой сүмийг дүүргэсэн гэж Исаиа хэлсэн (Иса 6:1). Хэрэв хормой төдийхөн нь л тийм агуу юм бол Бурханы алдар бүхлээрээ илчлэгдвэл бид яах бол доо гэсэн төсөөллийг Исаиа бидэнд үлдээжээ. Дараа нь тэр, Бурхан далайг алгандаа хэмжиж, тэнгэрийг төөлж тооцоолдог хэмээн Бурханыг дүрсэлсэн (Иса 40:12). Бурханы хувьд үндэстнүүд хувингийн дусал мэт, дэнсэн дээрх ширхэг тоос мэт тооцогддог (Иса 40:15). Бурханд тохирох шатаалт тахилыг өргөхөд, Ливаны бүх ой, бүх ан амьтад ч хүрэлцэхгүй (Иса 40:16).

Эш үзүүлэгч Нахумын тодорхойлсноор “Хуй салхи, шуурган дотор Түүний зам байдаг. Үүлс бол Түүний хөл доорх тоос юм.” (Нах 1:3).

Хабаккук Бурханы яруу алдрын тухай өгүүлэхдээ “Түүний хүч чадал нууцлагдсан” (Хаб 3:4) хэмээсэн. Энэ бүхэн нь Бурханы аугааг хүний хэлээр чадан ядан тодорхойлсон тодорхойлолт юм.

Маргаашаас эхлээд хэдэн өдөр бид Бурханы зарим мөн чанарын тухай үзнэ. Тэдгээр мөн чанар бидэнд дараах хандлагыг төрүүлэх учиртай.

Гайхан бишрэх – Яагаад гэвэл тэр гайхамшигтай

Хүндлэн мөргөх – Түүний хэн болох, бидний төлөө юу хийснээс болоод

Итгэж найдах – Яагаад гэвэл Тэр бидний итгэлийг хэзээ ч алдахгүй найдвартай

Үйлчлэх – Ийм Эзэнд үйлчлэх нь амьдралын хамгийн агуу ерөөл билээ.

Дуурайх – Тэр биднийг Өөртэй нь улам бүр адил болоосой гэж хүсдэг. (Гэхдээ уур хилэн гэх мэт Бурханы зарим зан чанарыг дуурайх ёсгүй. Хязгааргүй, мөнх гэх мэт зарим чанарыг нь бид дуурайж чадахгүй.)

## 6 сарын 5

*“Бурхан, ... бүхнийг мэддэг.” (1Иох 3:20)*

Бурхан бүхнийг мэдэгч. Өөрөөр хэлбэл, Түүний мэдлэг төгс, бүрэн дүүрэн. Тэр хэзээ ч суралцаагүй. Түүнд сурах юм байхгүй.

Энэ сэдвээр хамгийн тодорхой хэлсэн Библийн нэг хэсэг бол Дуулал 139:1-6. Давид ингэж бичжээ: “Аяа ЭЗЭН, Та намайг судлан намайг мэдлээ. Миний сууж, босохыг Та мэддэг бөгөөд хаа холоос санаа бодлуудыг минь ойлгодог. Та миний зам мөр хийгээд хэвтэхийг минь ч нарийвчлан үзэж, замнал бүрийг минь сайн мэддэг. Хэлэн дээр минь ганц үг ч байхаас өмнө, харагтун, ЭЗЭН Та бүгдийг мэддэг. Та хойноос ба урдаас минь нөмөрлөж, миний дээр мутраа тавьсан. Мэдлэг нь надад дэндүү гайхамшигтай, өндөр бөгөөд би түүнд хүршгүй билээ.”

Бурхан оддыг тоолж бүгдийг нь нэрээр нь дууддаг болохыг Дуулал 147:4-өөс мэдэж авдаг. Сер Жэймс Жинс энэ эшлэлийг уншсанахаа дараа “Сансар огторгуйн нийт оддын тоо нь дэлхийн бүх далайн эргийн элсний ширхгийн тоотой адил байх даа” гэж хэлсэн байдаг.

Эзэн Есүс шавь нартаа, газарт унах бор шувуу болгоныг Эцэг мэддэг гэж хэлсэн. Мөн бидний толгойн үсний ширхгийг Бурхан тоолсон гэж хэлсэн. (Мт 10:29,30)

“Түүний мэлмийн өмнө бүгд нүцгэн бөгөөд ил болой. Түүнд бид тооцоотой.” (Евр10:29,30) Энэ бүхнийг бодохоор Паулын нэг адил “Аяа, Бурханы мэргэн ухаан болон мэдлэгийн баялаг нь юутай гүн бэ! Түүний шүүлтүүд нь ямар ойлгож баршгүй, Түүний замууд нь

ямар олж илрүүлшгүй вэ!” (Ром 11:33) гэж өөрийн эрхгүй дуу алддаг.

Бурхан бүхнийг мэддэг нь бидний практик амьдралд ямар нөлөө үзүүлэх вэ? Энэ нь нэг талаар сануулга. Бурхан хийж байгаа бүхнийг минь хардаг. Түүнээс бид юу ч нууж чадахгүй.

Бурхан бүхнийг мэддэг нь бидний тайтгарал. Бурхан бидний юун дундуур явж байгааг мэднэ. “Тэр миний замыг мэддэг.” (Иов 23:10) “Миний төөрөгдөл бүрийг Та тоолсон билээ. Нулимсыг минь туламдаа цуглуулан хийгээч. Таны номд бичигдээгүй гэж үү?” (Дуу 56:8)

Бурхан бүхнийг мэддэг нь урам зориг өгдөг. Тэр бидний талаар бүхнийг мэддэг хэр нь биднийг аварчээ. Залбирал ба мөргөлд илэрхийлж чадахгүй сэтгэлийг минь ч Бурхан мэддэг.

Бурхан бүхнийг мэддэг нь гайхал бишрэлийг төрүүлдэг. Тэр бүгдийг мэддэг байж уучилсан нүглүүдээ мартаж чаддаг. “Бүхнийг мэдэгч Бурхан яаж мартдагийг би мэдэхгүй. Гэхдээ л тэр мартжээ.” (Девид Симандс)

## 6 сарын 6

*“Би тэнгэрс хийгээд газрыг дүүргэдэггүй гэж үү? гэж ЭЗЭН тунхаглаж байна.” (Иер 23:24)*

Бурхан хаа сайгүй оршигч гэдэг нь нэг цагт, бүх газарт, нэгэн зэрэг оршдог чадварыг хэлж байгаа юм. Жон Эроусмит гэгч пуритан залуугаас үл итгэгч философич

-Бурхан хаана байдаг вэ?” гэж асуухад хариуд нь

-Эхлээд би танаас нэг юм асууя. Бурхан хаана байдаггүй вэ? гэж хэлжээ.

Нэгэн бурхангүй үзэлтэн ханан дээр “God is nowhere (Бурхан хаана ч алга)” гэж бичтэл нэг хүүхэд хүрч ирээд жижиг зай авахад “God is now here (Бурхан одоо энд байна)” гэдэг үг үүсжээ.

Бурханы хаа сайгүй оршдог тухай Давидын хэлсэн үгэнд бид талархахаас өөр аргагүй. Тэр ингэж бичжээ: “Таны Сүнснээс би хаашаа одох вэ? Эсвэл Таны оршихуйгаас би хаашаа зугтах вэ? Хэрэв би тэнгэр өөд очвол, Та тэнд. Хэрэв би Үхэгсдийн оронд ор дэрээ засвал, Харагтун, Та тэнд. Үүрийн гэгээгээр жигүүрлэн далайн хамгийн алсын хэсэгт суувал тэнд ч мутар тань намайг удирдаж, баруун мутар тань надаас зуурна.” (Дуу 139:7-10)

Бурхан хаа сайгүй оршдог гэж ярихдаа бид пантеизмыг ерөөсөө хэлээгүй. Пантеизм гэдэг нь бүх зүйлийг бурхан гэх үзэл. Тэд модыг, гол горхийг, байгаль дэлхийг шүтдэг. Жинхэнэ Бурхан орчлон ертөнцийг удирддаг бөгөөд дүүргэдэг. Гэхдээ Өөрөө орчлон ертөнцөөс ангид бөгөөд илүү агуу.

Бурхан хаа сайгүй оршдог гэдэг нь Бурханы хүмүүсийн амьдралд ямар нөлөө үзүүлэх вэ? Юун түрүүнд,

бид Бурханаас нуугдаж чадахгүй гэдгийг маань сануулна. Бурханаас бид хаашаа ч зугтаж чадахгүй. Хоёрт Бурхан Өөрийн хүмүүстэй үргэлж хамт байгааг мэдэх нь үгээр илэрхийлшгүй тайвшрал тайтгарлыг өгдөг. Бурхан биднийг хэзээ ч орхихгүй. Бид хэзээ ч ганцаардахгүй.

Тэгэхээр ийм уриалга байна. Хэрэв Тэр бидэнтэй хамт юм бол бид ариун шударга амьдарч, энэ ертөнцөөс өөрсдийгөө тусгаарлах ёстой бус уу?

Бурхан Өөрийнх нь нэр дээр хоёр ба гурван хүн цуглахад онцгойлон хамт байна гэдгээ амласан. Тэр тэдний дунд оршино. Тэгэхээр ариун хүмүүсийн цуглаанд хүндэтгэлтэй нухацтай хандах ёстой гэсэн үг.

## 6 сарын 7

*“Төгс хүчит Эзэн Бурхан маань хаанчилж байна.”* (Илч 19:6)

Бурхан бол төгс хүчит. Өрөөр хэлбэл бүхнийг чадагч гэсэн үг. Тэр Өөрийн бусад мөн чанарт харшлах юуг ч хийхгүй. Библи энэ тухай юу гэж хэлснийг сонсогтун! “Би бол Төгс Хүчит Бурхан.” (Эх 17:1) “ЭЗЭНд дэндүү хэцүү юм байна уу?” (Эх 18:14) “Та бүхнийг үйлдэж чаддаг.” (Иов 42:2) “Танд юу ч дэндүү хэцүү биш.” (Иер 32:17) “Бурханд бүх юм боломжтой.” (Мт 19:26)

Гэхдээ Бурхан Өөрийн зан чанарт харшлах зүйл хийдэггүй. Жишээлбэл, Бурхан худал хэлэх боломжгүй. (Евр 6:18) Тэр Өөрийгөө үгүйсгэхгүй. (2Тм 2:13) Тэр туйлын ариун учраас нүгэл үйлдэхгүй. Тэр төгс төгөлдөр учраас алдаа гаргахгүй.

Бурханы бүхнийг чадагч чанар нь бүтээлээс нь харагддаг. Тэрээр орчлон ертөнцийг тогтоон барьж, тэтгэж байдаг. Мөн энэ чанар нүгэлтнүүдийн аврал, үл гэмшигчдийн шүүлтээс харагддаг. Хуучин гэрээн дээр Түүний хүч чадлыг харуулсан хамгийн том жишээ бол Гэтлэл юм. Шинэ гэрээн дээр бол Христийн амилал.

Бурхан бүхнийг чадагч юм бол Түүнийг амжилттай эсэргүүцэж чадах ямар ч хүн байхгүй. “ЭЗЭНийг сөрөн чадах мэргэн ухаан, бодрол ухаан, зөвлөгөө ч гэж ер үгүй.” (Сур 21:30)

Бурхан бүхнийг чадагч юм бол итгэгч бид ялж буй талд нь зогсож байна. Бурхантай хамт байгаа хүнийг хэн ч, юу ч эсэргүүцэж чадахгүй. “Хэрэв Бурхан бидний талд юм бол, хэн биднийг эсэргүүцэх вэ?” (Ром 8:31)



Бурхан бүхнийг чадагч юм бол залбирлаар бүх зүйл боломжтой гэж бид үзэх ёстой. Бид боломжгүйн өөдөөс инээж, “Биелэгтүн” хэмээн хэлж чадна.

Бурхан бүхнийг чадагч юм бол бид айх айдасгүй амар амгалан байж чадна:

*Аврагч бүх асуудлыг шийдэж чадна*

*Амьдралын бэрхшээлүүдийг нурааж чадна*

*Есүсийн хувьд дэндүү хэцүү юм үгүй*

*Ер боломжгүй юм Түүнд нэг ч байхгүй*

Би сул дорой ч Түүний хүч чадлыг түшвэл бүх зүйл гэрэл гэгээтэй харагдана.

## 6 сарын 8

*“Цорын ганц мэргэн Бурханд, Есүс Христээр алдар нь үүрд мөнх байх болтугай.” (Ром 16:27)*

Бурханы мэргэн ухааны талаар Библи байнга ярьдаг. Жишээлбэл: “Мэргэн ухаан хийгээд хүч Түүнтэй хамт байх бөгөөд зөвлөгөө хийгээд ухаарал Түүнд харьяалагддаг.” (Иов 12:13) “Хүч чадал хийгээд мэргэн ухаан Түүнтэй хамт бөгөөд Төөрөлдөгч хийгээд төөрөлдүүлэгч нь Түүнд харьяалагддаг юм.” (Иов 12:16) “Аяа ЭЗЭН, Таны үйлс хэчнээн их вэ! Мэргэн ухаанаар Та тэр бүхнийг бүтээжээ. Дэлхий баялгаар тань дүүрэн юм.” (Дуу 104:24) “Мэргэн ухаанаар газрыг ЭЗЭН суурилуулж, мэдлэг ухаанаар тэнгэрсийг тогтоожээ.” (Сур 3:19) “Бурханы нэр мөнхийн мөнхөд магтагдах болтугай. Учир нь мэргэн ухаан хийгээд хүч чадал Түүнийх.” (Дан 2:20) “Учир нь Бурханы мэргэн ухаан дор ертөнц мэргэн ухаанаараа Бурханыг таньж мэдсэнгүй. Иймд тунхагласан мэдээний мунхаглалаар итгэгчдийг аврах нь Бурханд тааламжтай байсан юм.” (1Ко 1:21) “Тэрээр [Есүс Христ] бидэнд Бурханаас ирсэн мэргэн ухаан...” (1Ко 1:30)

Бурханы мэргэн ухаан гэдэг нь Бурханы төгс бодол, алдаа мадаггүй ухаан, эндэж осолдохгүй шийдвэрийг хэлдэг. Энэ нь боломжит хамгийн сайн аргаар, байж болох хамгийн сайн үр дүнг бий болгох Бурханы чадвар юм. Мэргэн ухаан гэдэг нь мэдлэгээс илүү зүйл. Мэдлэгийг зөв ашиглах чадварыг мэргэн ухаан гэнэ.

Бурханы бүх ажил мэргэн ухааныг нь тусган харуулдаг. Тухайлбал хүний биеийн гайхалтай бүтэц тогтолцоо Бурханы мэргэн ухааны тод илрэл юм.

Мөн Бурханы мэргэн ухаан нь авралын төлөвлөгөөнд харагддаг. Хэрхэн хүний нүгэл төлөгдөж, Бурханы шударга ёс хангагдаж, Бурханы өршөөл зөвт байдлаар хэрэгжиж, Христийн доторх итгэгч хүн Адамыг нүгэлд унаагүй байснаас ч илүү дээр болсныг сайнмэдээ бидэнд өгүүлдэг.

Одоо бид аврагдсан. Бурханы мэргэн ухаан сэтгэл зүрхэнд минь амар амгаланг төрүүлдэг. Бурхан ямар ч алдаа гаргамгүй дэндүү мэргэн гэдгийг бид мэднэ. Амьдралд ойлгож ухаарахын аргагүй хэцүү зүйлс байдаг ч гэсэн Бурхан алдаж эндэж чадахгүйг бид мэднэ.

Бид Түүний замчлалд бүрэн итгэх боломжтой. Тэр эхнээс нь дуустал мэдэж байгаа. Тэрээр ивээл ерөөлийн замыг мэднэ. Харин бид энэ талаар юу ч мэдэхгүй. Түүний зам төгс төгөлдөр.

Эцэст нь хэлэхэд Бурхан биднийг мэргэн ухаан дотор өсөөсэй гэж хүсдэг. Бид сайнд мэргэн байх ёстой. (Ром 16:19) Бид мэргэн хүмүүсийн адилаар хэрсүү байж цагийг аврах ёстой. Яагаад гэвэл эдгээр өдрүүд бузар муу юм. (Еф 5:15,16) Бид могой шиг ухаантай, тагтаа шиг гэмгүй байх ёстой. (Мт 10:16)

## 6 сарын 9

*“Байсан, байгаа, мөн хожим ирэх Төгс хүчит Эзэн Бурхан ариун, ариун, ариун” (Илч 4:8)*

Бурхан ариун гэдэг нь Түүний бодол, үйлдэл, сэдэл бүгдээрээ ёс суртахууны болон сүнслэг байдлын хувьд төгс гэсэн утгатай. Тэрээр ямар ч нүгэлгүй бөгөөд бузар бохиросоос бүрэн ангид. Тэрээр туйлын цэвэр ариун. Үүнээс өөр байх боломжгүй.

Бурханы ариун байдлын талаар Библи маш олон удаа ярьсан байдаг. Цөөн хэдэн жишээг үзье. “Та нарын Бурхан ЭЗЭН Би ариун.” (Лев 19:2) “ЭЗЭНтэй адил ариун нь үгүй.” (1См 2:2) “Миний Ариун Нэгэн, ЭЗЭН, Бурхан минь,...Таны мэлмий муу муухайг зөвшөөрч чадахааргүй дэндүү ариун юм.” (Хаб 1:12,13) “Бурхан муу муухайд уруу татагддаггүй бас Өөрөө хэнийг ч уруу татдаггүй.” (Иак 1:13) “Бурхан бол гэрэл, Түүний дотор харанхуй огт үгүй.” (1Ио 1:5) “Зөвхөн Та ариун билээ.” (Илч 15:4) “Түүний мэлмийд одод ч цэвэр биш.” (Иов 25:5)

Хуучин гэрээний тахилчийн үйлчлэл, тахилын хуулиуд нь Бурханы ариун байдлыг хамгийн тод харуулдаг. Тэр бүхнээс үзвэл нүгэл нь Бурхан, хүн хоёрын дунд ангал мэт зай бий болгодог ба энэ хоёрын дунд заавал нэг гүүр шаардлагатай болжээ. Ариун Бурхан золиос болсон тахилын цусанд үндэслэн нүгэлтэнд ойртон очих боломжтой.

Бурханы ариун байдал загалмай дээр онцгой илэрсэн. Бурхан нүглийг үүрсэн Хүүгээ хараад аймшигт харанхуй нөмөрсөн гурван цагийн туршид хайрт Хүүгээ орхисон.

Үүнээс бид юуг амьдралдаа хэрэгжүүлэх вэ гэдэг нь тодорхой байна. Бурхан биднийг ариун байгаасай гэж хүсдэг. “Бурханы хүсэл нь та нарын ариусал.” (1Тс 4:3) “Та нарыг дуудсан Ариун Нэгэний адил өөрсдийн бүх л зан байдалдаа бас ариун байгтун.” (1Пт 1:15)

Бурхан ариун гэдгийг бодох үед бидний дотор эмээн хүндлэл төрөх учиртай. Тэрээр Мосед “Чиний зогсож байгаа газар ариун газар учраас хөл дэх шаахайгаа тайл” (Гэт 3:5) гэж хэлсэн юм.

Бурханы оршихуйд зогсоход ариун байдал шаардагдана. Т. Бинни энэ тухайд ингэж шүлэглэжээ.

*Үүрдийн гэрэл! Мөнхийн гэрэл!*

*Үнэнийг минь хайсан харцтай тулгарахад*

*Үнэнхүү цэвэр сэтгэл шаардагдана*

*Сэвгүй тунгалаг ариун санаатан*

*Сэтгэл тэвдэлгүй Тан руу харна*

Эзэн Есүст итгэх итгэл, шаардлагатай ариун байдлыг маань бидэнд өгсөн гэдгийг мэдвэл зүрх минь хүндлэл мөргөлөөр бялхана.

## 6 сарын 10

“ЭЗЭН Би өөрчлөгдөшгүй.” (Мал 3:6)

Бурхан өөрчлөгдөшгүй гэдэг нь Түүний хувиршгүй нэгэн хэвээрээ байх чанар юм. Бурханы орших ахуйн мөн чанар өөрчлөгдөхгүй. Бурханы зан чанар өөрчлөгдөхгүй. Бурханы ажилладаг зарчмууд өөрчлөгдөхгүй.

Дуулал бичээч тэнгэр газрын өөрчлөгдөх хувь тавиланг Бурханы үл өөрчлөгдөх чанартай харьцуулсан: “Тэд солигдоно. Харин Та хэвээрээ.” (Дуу 102:26,27) Иаков Эзэнийг “өөрчлөлт ч, өөрчлөгдөх сүүдэр ч үгүй, гэрлүүдийн Эцэг” (Иак 1:17) гэж тодорхойлсон.

Бурхан гэмшиж, эргэж буцдаггүйг сануулах Библийн хэсгүүд бий. “Бурхан бол худал хэлдэг хүн биш, гэмшин харамсдаг хүмүүн ч бус.” (Тоо 23:19) “Израилийн Алдар худал ярихгүй, харамсаж буцах ч үгүй.” (1См 15:29)

Тэгвэл Бурхан гэмшсэн харамссан гэж бичсэн эшлэлүүдийг юу гэж хэлэх вэ? “[Эзэн] хүнийг газар дээр бүтээсэндээ харамсан зүрхэндээ ихэд халаглав.” (Эх 6:6) “ЭЗЭН Саулыг Израилийн хаан болгосондоо харамсав.” (1См 15:35) Мөн Гэтлэл 32:14, Иона 3:10-ыг үз.

Энд ямар ч зөрчил байхгүй. Бурхан дуулгавартай байдлыг шагнаж, дуулгаваргүй байдлыг шийтгэдэг. Бурхан үргэлж энэ хоёр зарчмаар ажилладаг. Хүн дуулгавартай байдлаас эргэж, дуулгаваргүй болох үед Бурхан Өөрийн мөн чанарт үнэнч хэвээр боловч эхний зарчмаасаа хоёр дахь уруу нь шилждэг. Энэ нь бидэнд харамсал мэт харагдаж байгаа юм. Хүний хэлээр ингэж

илэрхийлэгдэж байна. Тэрнээс биш Бурхан харамссан, бодлоо өөрчилсөн гэсэн үг биш.

Бурхан үргэлж хэвээрээ. Үнэндээ энэ нь Түүний нэг нэр юм. “Та бол Хэвээрээ. Та дэлхий дээрх бүх хаанчлалын ганц Бурхан мөн.” (Иса 37:16, Дарбигийн орчуулга) Энэ нэр Дарбигийн орчуулга дээр 2См 7:28, Дуу 102:27, Иса 41:4-ийн хажуугийн тайлбар дээр мөн гардаг.

Бурханы хувиршгүй чанар бүх үеийн ариун хүмүүст тайтгарлыг өгч, дууных нь сэдэв болдог. Бид Бурханы энэхүү чанарыг Хенри Ф. Лайтын мөртүүдээр магтан дуулдаг:

*Хамаг зүйл л өөрчлөгдөж гундана*

*Харин хувиршгүй Та л надтай хамт байна*

Бурханы өөрчлөгдөшгүй чанарыг бид даган дуурайх ёстой. Бид нэг янзаараа, тогтвортой, бат суурьтай байх хэрэгтэй. Хэрэв бид байнга зангаа хувиргаж, салхи шиг тогтворгүй байвал Эцэг Бурханыг энэ ертөнцөд буруугаар ойлгуулна.

“Тиймээс хайрт ах дүү нар минь, та нарын зүдэл зүтгэл Эзэн дотор хоосон биш гэдгийг мэдэж, тууштай байж, гуйвж дайвалгүй, Эзэний үйл хэргээр үргэлж бялхаж бай.” (1Ко 15:58)

## 6 сарын 11

*“Бид Бурханыг хайрласан бус, харин Тэр биднийг хайрлаж, бидний нүглийн улмаас Хүүгээ эвлэрүүлэл болгон илгээсэнд л хайр байгаа юм.” (1Ио 4:10)*

Хайр бол Өөрийгөө бусдад харамгүй зориулахад хүргэдэг Бурханы нэг чанар юм. Түүний хайр нь хайртай хүндээ сайныг болон төгс бэлгүүдийг өгөх замаар илэрдэг.

Тэрхүү хайрын тухай өгүүлсэн цөөн хэдэн эшлэлийг энд эш татъя: “Би чамайг үүрдийн хайраар хайрласан. Тиймээс Би чамайг хайр энэрлээр татсан билээ.” (Иер 31:3) “Гэтэл биднийг нүгэлтнүүд байхын л Христ бидний төлөө үхсэнээр Бурхан биднийг хайрлах хайраа харуулсан.” (Ром 5:8) “...биднийг хайрласан аугаа хайраараа өршөөлөөр баян Бурхан маань...” (Еф 2:4) “Бурхан ертөнцийг үнэхээр хайрласандаа цорын ганц Хүүгээ өгсөн тул Хүүд итгэдэг бүхэн мөхөхгүй харин мөнх амьтай байх болно.” (Иох 3:16)

Иохан “Бурхан бол хайр” (1Ио 4:8) гэж хэлэхдээ Бурханыг тодорхойлсон юм биш. Харин Бурханы мөн чанар дотор хайр бол гол элемент гэдгийг хэлсэн. Бид хайранд биш, хайрын Бурханд мөргөдөг.

Түүний хайранд эхлэл гэж үгүй. Төгсгөл ч байхгүй. Тэр хайр хэмжээ хязгааргүй бөгөөд хувиа хичээсэн чанар ба ямар нэгэн нүгэл агуулаагүй цэвэр ариун. Тэр хайр ямар ч үнэ төлөхөд бэлэн золиос гаргадаг хайр. Тэр хайр зөвхөн бусдын сайн сайхныг бодож хариу нэхдэггүй. Тэр хайр сайныг ч мууг ч, сайхныг ч муухайг ч, дайснаа ч нөхрөө ч хайрладаг. Тэр хайр хайрлагдаж байгаа этгээдийн гавьяа



зүтгэлийн улмаас бус, харин Хайрлагчийн сайн чанараас ундран гардаг.

Энэхүү агуу үнэн амьдралд хэрхэн тусгалаа олох ёстой нь ойлгомжтой. “Иймд хайрлагдсан хүүхдүүдийн хувьд Бурханыг дуурайгчид бай. Христ та нарыг хайрласан бөгөөд Өөрийгөө бидний төлөө Бурханд анхилуун үнэрт өргөл ба тахил болгон өргөсний адил хайр дор яв.” (Еф 5:1,2) Бидний хайр Эзэн өөд өгсөж, ах дүүс уруу минь урсаж, аврагдаагүй дэлхий рүү тэлэх ёстой.

Бурханы хайрыг бодохоор хүндлэн мөргөх сэтгэл өөрийн эрхгүй төрдөг. Түүний өлмийд сөгдөхөд доорх дууны мэт үгс ар араасаа ундрах учиртай:

*Хэмжээлшгүй агуу Бурхан байж Та*

*Хэрхэн намайг ингэж хайрлав аа?*

*Хэчнээн бодоод ч ойлгож чадахгүй нь*

*Хэдий тийм ч, зүрхэнд минь тусжээ*

## 6 сарын 12

*“Христ дотор та нарыг Өөрийн мөнх алдарт дуудсан, бүх нигүүлслийн Бурхан...” (I Пет 5:10)*

Бурханы нигүүлсэл гэдэг нь сайныг хүртэх зохисгүй, шийтгүүлэх ёстой боловч Есүс Христийг Эзэн ба Аврагч хэмээн хүлээн авсан хүмүүст Бурхан хайр ивээл үзүүлж, тэднийг хүлээн авахыг хэлнэ.

Нигүүлслийн тухай хамгийн сайн танигдсан зарим эшлэлийг энд эш татъя. “Хууль Мосегоор өгөгдсөн бол, нигүүлсэл ба үнэн нь Есүс Христээр ирсэн билээ.” (Иох 1:17) “Христ Есүсийн золилтоор дамжин Бурханы нигүүлслээр үнэгүй зөвтгөгджээ.” (Ром 3:24) “Учир нь баян байсан ч та нарын тусын тулд хоосорсон Эзэн Есүс Христийн маань нигүүлслийг мөн Түүний хоосролоор баян болсноо та нар мэдэх билээ.” (2Ко 8:9) “Нигүүлслийн учир итгэлээрээ аврагдсан нь та нараас бус харин Бурханы бэлэг бөгөөд үйлсээр чинь биш тул хэн ч үл сайрхах болно.” (Еф 2:8,9) “Та нарын яриа үргэлж нигүүлсэнгүй бөгөөд давсаар амталсан мэт байг.” (Кол 4:6)

Зарим хүн Бурханы нигүүлслийг Бурханы хамгийн дээд чанар гэж үздэг. Жишээлбэл Самуел Дэвис ингэж бичжээ:

*Гайхамшигийн агуу Бурхан минь ээ Таны бүх замууд  
Тэнгэрлэг зан чанаруудыг тань тусган харуулдаг.  
Гэхдээ нигүүлслийн тань жавхлант туяа  
Бусад зан чанараас тань илүү тод гэрэлтэнэ.  
Бурхан Тан шиг хэн уучилдаг вэ?  
Ийм баян, ийм үнэгүй нигүүлсэл өөр хэнд байдаг вэ?*

Гэхдээ Бурханы зан чанаруудын аль нэг нь бусдаасаа илүү гэж хэн хэлж чадах юм бэ?

Бурхан Хуучин гэрээнд ч тэр, Шинэ гэрээнд ч тэр нигүүлслийн Бурхан байсан. Гэхдээ Есүс Христийг ирэх үед нигүүлсэл шинэ өнцгөөр ичлэгдсэн.

Бид Бурханы нигүүлслийг ямар нэг хэмжээнд ойлгохоороо үүрдийн мөргөлчид болдог. Бид өөрсдөөсөө "Тэр намайг яагаад сонгосон юм бэ? Над шиг муу хүний төлөө Эзэн Есүс яагаад цусаа урсгасан юм бэ? Тэр намайг тамаас авраад зогсохгүй тэнгэрийн бүх сүнслэг ерөөлөөр ерөөж, үүрд мөнх Өөртэйгөө хамт диваажинд амьдруулахаар шийдсэн нь ямар учиртай юм бэ?" гэж асуудаг. Ийм өөдгүй хүмүүсийг аварсан гайхамшигт хайр нигүүлслийг бид магтан дуулах нь дамжиггүй.

Цаашлаад Бурхан бидний амьдралаас энэхүү нигүүлсэл урсан гарч бусдын амьдралд хүрээсэй гэж хүсдэг. Тэр биднийг бусадтай нигүүлсэнгүй хандаасай гэдэг. Бидний хэл яриа үргэлж нигүүлсэнгүй, давсаар амталсан мэт байх ёстой (Кол 4:6). Бид бусдыг баяжуулахын тулд өөрсдөө ядуурах ёстой (2Ко 8:9). Бид зохисгүй, үнэ цэнэгүй, хайрлагдамгүй хүмүүст ивээл нигүүлслээр хандаж, тэднийг хүлээж авах ёстой.

## 6 сарын 13

“*өршөөлөөр баян Бурхан*” (Еф 2:4)

Бурханы өршөөл гэдэг нь буруугаа мэдэрсэн, алдаж эндсэн, шаналж зовсон, асуудалд унасан хүмүүсийг Бурхан өрөвдөн хайрлах, энэрэн нигүүлсэхийг хэлнэ. Библид Бурханыг өршөөлөөр баян (Еф 2:4), хайр энэрлээр элбэг (Дуу 86:5) гэж хэлдэг. Бурханы өршөөл агуу (1Пт 1:3). Энэ нь тэнгэрт тулам (Дуу 57:10). “Учир нь тэнгэр нь газрын дээгүүр өндөрт байдаг шиг Түүнээс эмээгчдэд энэрэл хайр нь агуу их.” (Дуу 103:11) Бурханыг “өршөөлийн Эцэг” гэж нэрлэдэг (2Ко 1:3). “Эзэн энэрлээр дүүрэн агаад өршөөнгүй.” (Иак 5:11) Тэр өршөөл үзүүлэхдээ ялгаварладаггүй: “Учир нь муу ба сайн дээр ч нараа Тэрээр мандуулж, зөвт болоод зөвт бус дээр ч бороо оруулдаг юм” (Мт 5:45). Хүн зөвт байдлын дотор хийсэн үйлсээр бус (Тит 3:5), Бурханы бүрэн эрхт өршөөлөөр аврагддаг (Гэт 33:19; Ром 9:15). Бурханы өршөөл Өөрөөс нь эмээгчдэд мөнхөд оршдог (Дуу 136:1). Харин үл гэмшигчдэд энэ амьдралыг дуустал үргэлжилнэ.

Нигүүлсэл өршөөл хоёр хоорондоо ялгаатай. Нигүүлсэл гэдэг нь хүртэх зохисгүй ивээл ерөөлийг Бурхан надад соёрхон хайрлахыг хэлнэ. Өршөөл гэдэг нь хүртэх ёстой шийтгэлийг өгөхгүй өнгөрөхийг хэлнэ.

Библийн ухагдахуун болгон бидэнд үүрэг дагуулж байдаг. Тухайлбал Бурханы өршөөл нь биднийг “өөрсдийн биеийг Бурханд тааламжтай, амьд, ариун тахил болгож өргөхийг” шаарддаг (Ром 12:1). Энэ нь бидний хийж чадах хамгийн ухаалаг, эрүүл, зөв зүйл мөн.

Түүнээс гадна Бурхан биднийг нэг нэгэндээ өршөөнгүй хандаасай гэж хүсдэг. Өршөөнгүй хүмүүст онцгой амлалт өгөгдсөн: “Тэд өршөөл энэрлийг хүртэх болно.” (Мт 5:7) Эзэн тахилаас илүү энэрэл өршөөлийг хүсдэг (Мт 9:13). Нэг ёсондоо зөвт бус амьдралтай бол хэчнээн агуу тахил өргөөд ч Бурханд таалагдахгүй.

Сайн Самари хүн хөршдөө өршөөл энэрэл үзүүлсэн нэгний жишээ юм. Бид өлссөнийг хооллож, ядууг хувцаслаж, өвчтэйг асарч, өнчин ба бэлэвснийг эргэж, гашуудагсадтай хамт гашуудвал өршөөл үзүүлж байгаа нь тэр.

Бид өөрсдөд маань бурууг үйлдсэн хүмүүст хариуг нь өгөх боломжоос татгалзаж, алдаж эндсэн хүмүүст энэрэнгүй хандвал өршөөл үзүүлж байгаа хэрэг.

Бид өөрсдийн хэн болохыг ухаарч явбал өөрсдийнхөө төлөө (Евр 4:16) болон бусдын төлөө (Гал 6:16, 1Тм 1:2) өршөөл энэрлийг залбиран гуйх ёстой.

Эцэст нь хэлэхэд Бурханы өршөөлүүд бидний зүрхийг Бурханыг магтах дуугаар хөглөдөг.

*Өршөөлийг тань миний сэтгэл харах үед  
Өөрийгөө бас нүгэлтэйг мэдрэх үед  
Бурхан минь ээ хэмээн магтдаг билээ  
Бишрэл, хайр, хүндлэлээр дүүрдэг билээ*

## 6 сарын 14

*“Аливаа итгэл сүсэггүйдэл ба зүй бусын эсрэг Бурханы уур хилэн тэнгэрээс илчлэгддэг.” (Ром 1:18)*

Бурханы уур хилэн гэдэг нь үл гэмшигч нүгэлтнүүдийн эсрэг шатсан ширүүн уур, хариуг нь өгсөн шийтгэл юм. Бурхан уур хилэнгээ энэ амьдралд ч, мөнхийн цаг үед ч үзүүлэх боломжтой. А. В. Пинкийн хэлсэнээр: “Бурханы уур хилэн нь Түүний итгэмжит байдал, эрх мэдэл, хүч чадал, өршөөл энэрлийн нэг адил тэнгэрлэг төгс чанар юм.” Бид Бурханы уур хилэнгийн төлөө бусдаас уучлалт гуйх шаардлагагүй.

Бид Бурханы уур хилэнгийн талаар тунгаан бодохдоо хэд хэдэн зүйлийг санаж байх хэрэгтэй.

Бурханы уур хилэн ба хайр хоорондоо зөрчилддөггүй. Жинхэнэ хайр нүгэл, тэрслэл, дуулгаваргүй байдлыг шийтгэдэг.

Хүн Бурханы хайраас татгалзвал түүнд Бурханы уур хилэнгээс өөр юу үлдэх вэ? Бидний мөнхөд оршин байх хоёр л газар байдаг. Нэг нь мөнхийн улс, нөгөө нь мөнхийн зовлон. Хүн диваажингаас татгалзвал тамыг сонгосон хэрэг юм.

Бурхан тамыг хүмүүст зориулж бүтээгээгүй. Харин диавол болон түүний тэнгэр элч нарт зориулсан (Мт 25:41). Эзэн хорон муу хүний үхлийг хүсдэггүй (Езк 33:11). Гэхдээ Христээс татгалзсан хүнд өөр сонголт байхгүй.

Шүүлт шийтгэлийг Бурханы этгээд ажил гэж нэрлэдэг (Иса 28:21). Тэгэхээр Тэр энэрэл өршөөлийг үзүүлэх дуртай гэсэн үг юм (Иак 2:13). Бурханы уур хилэнд өс

хонзонгийн сэдэл байдаггүй. Энэ нь зөвт уур бөгөөд нүглийн өчүүхэн ч хэлтэрхий агуулдаггүй.

Бурханы уур хилэнг бид даган дуурайх ёсгүй. Учир нь Бурхан л ганцаараа шударга ёсыг хэрэгжүүлж чадах учраас уур хилэн бол Бурханых юм. Тиймээс Паул ромчуудад, “Хайртууд минь, хэзээ ч өөрийн өшөө хонзонг бүү ав. Харин Бурханы уур хилэнд зай гарга. Учир нь ‘«Өшөө авалт нь Минийх, Би буцааж төлнө» гэж Эзэн хэлэв’ гэж бичигджээ” (Ром 12:19) гэж бичсэн.

Мэдээж христитгэгч шударга зөвөөр уурлан унтууцах ёстой. Гол нь энэ нь шударга зөвт байх бөгөөд зорилгоосоо хазайж нүгэл, хилэгнэл болж болохгүй (Еф 4:26). Гэхдээ өөрийгөө өмгөөлөх юм уу өөрийгөө зөвтгөх гэж биш харин Бурхан доромжлогдоод, Бурханы хүндлэл алдагдаад ирэх үед уурлаж болох юм.

Хэрэв бид Бурханы уур хилэнд итгэдэг бол сүйрэл рүү хөтөлдөг өргөн замаар алхаж буй хүмүүст сайнмэдээг хуваалцахыг хүснэ. Тэгээд Бурханы уур хилэнг тунхаглаж байхдаа мөхөж буй хүмүүсийг хараад өр зүрх минь өвдөх учиртай.

## 6 сарын 15

*“Өршөөл юунд нь төгсгөл үгүй. Өглөө бүр энэ нь цоо шинэ. Таны итгэлт байдал юутай аугаа вэ.” (Гаш 3:22, 23)*

Бурхан итгэмжит бөгөөд үнэн. Тэр худал ярьж хууран мэхлэхгүй. Тэр үгнээсээ буцахгүй. Тэр туйлын найдвартай. Түүний амлалтын нэг нь ч бүтэлгүйтэхгүй.

“Бурхан бол худал хэлдэг хүн биш, гэмшин харамсдаг хүмүүн ч бус. Тэрээр айлдчихаад, түүнийгээ хийхгүй гэж үү? Эсвэл Тэр ярьчихаад, түүнийгээ сайн болгохгүй гэж үү?” (Тоо 23:9) “Тиймээс чи мэдэж ав. Бурхан ЭЗЭН чинь Бурхан бөгөөд Тэрээр итгэмжит Бурхан юм.” (Дх 7:9) “Таны итгэлтэй байдал бүх үеийн туршид үргэлжилдэг.” (Дуу 119:90 АБ2004)

Бурханы итгэмжит байдал нь биднийг Өөрийн Хүүтэйгээ нөхөрлүүлэхээр дуудсанаар харагддаг (1Ко 1:9). Мөн Бидний үүрч чадахаас илүүг бидэнд үүрүүлдэггүй нь бас нэг илрэл юм (1Ко 10:13). Тэр биднийг батжуулж, бузар муугаас хамгаалдаг нь Бурханы итгэмжит байдлын нэг мөн (2Тс 3:3). Зарим нь итгэхгүй байсан ч Тэр итгэмжит хэвээр үлддэг. Учир нь Тэр Өөрийгөө үгүйсгэж үл чадна (2Тм 2:13).

Эзэн Есүс бол махан бодод биелсэн үнэн юм (Иох 14:6). Бурханы үг бол ариусгагч үнэн (Иох 17:17). “Хүн бүр худалч байсан ч Бурхан үнэн.” (Ром 3:4)

Бурхан итгэмжит бөгөөд үнэн гэдэг мэдлэг нь бидний сэтгэлд хөдөлшгүй итгэлийг төрүүлдэг. Бурханы үг хэзээ ч алддаггүй бөгөөд Тэр амласан бүхнээ биелүүлдэг гэдгийг бид мэднэ (Евр 10:23). Тэр хонин сүргээсээ нэгийг ч алдахгүй гэж амласан учраас бидний аврал мөнхөд



алдагдахгүй гэдгийг бид мэднэ (Иох 10:28). Тэр бидний бүх хэрэгцээг хангана гэж амласан учраас бид юугаар ч дутахгүйгээ мэддэг.

Бурхан Өөрийн хүмүүсийг итгэмжит бөгөөд үнэн байгаасай гэж хүсдэг. Тэр биднийг хэлсэндээ хүрдэг, амласнаа биелүүлдэг, итгэл алддаггүй, худал хэлдэггүй, хэтрүүлж ярьдаггүй, хагас үнэнийг ярьдаггүй байгаасай гэж хүсдэг. Бид амлалтаа биелүүлж, итгэмжит байх хэрэгтэй. Христигтэгчид хамгийн түрүүнд гэрлэлтийн тангарагтаа үнэнч байх ёстой. Дээрээс нь чуулган, ажил алба, гэр бүлдээ өөрсдийгөө үнэнчээр зориулж, итгэмжит найдвартай байх ёстой. Эзэний итгэмжит байдал бидэнд магтаал ба талархлыг төрүүлдэг. Тэр хэзээ ч амласнаасаа буцдаггүй Бурхан.

*Эзэн хэзээ ч алдахгүй*

*Учир нь Тэр Бурхан*

*Эзэн хэзээ ч алдахгүй*

*Учир нь Тэр үгээ өгсөн*

*Эзэн хэзээ ч алдахгүй*

*Учир нь Тэр чамайг нэвт хардаг*

*Эзэн хэзээ ч алдахгүй*

*Учир нь Тэр чамд хариулна*

К. Э. Масон, жуниор

## 6 сарын 16

*“Бурхан маань тэнгэрт байдаг. Тэр хүссэн бүхнээ үйлддэг. (Дуу 115: 3)*

Бурхан бол бүрэн эрхт. Өөрөөр хэлбэл Тэр орчлон ертөнцийн дээд эрх мэдэл бөгөөд хүссэн бүхнээ үйлдэх эрхтэй. Гэхдээ Бурханы хүсэл үргэлж зөв байдаг гэдгийг нэмж хэлэх ёстой байх аа. Түүний зам төгс.

Исаиа Эзэний талаар: “Зорилго минь хэрэгжинэ. Би тааламжит бүхнээ үйлдэнэ” (Иса 46:10) гэж хэлсэн. Небухаднезарт эрүүл ухаан нь эргэж ирэх үед “Тэрээр тэнгэрсийнхэнд ч, газар дэлхийн суугчдад ч хүслээрээ үйлддэг. Хэн ч мутрыг нь хорьж чадахгүй, 'Та юу үйлдэнэ вэ?' гэж асуух хүн нэг ч үгүй” (Дан 4:35) гэж мэдэгдсэн. Элч Паул, хүн Бурханы үйл хэргийг байцаах эрхгүй гэж мэдэгдсэн: “Бурханы эсрэг хариу хэлдэг хүн чи хэн юм бэ? Баримал нь 'Та яагаад намайг ингэж хийв?' гэж барималчинд хэлдэг үү?” (Ром 9:20) Паул өөр нэгэн газарт Бурханыг “бүх юмсыг хүсэл хийгээд шийдвэрээрээ үйлддэг” (Еф 1:11) Нэгэн гэж тодорхойлсон.

Спержон: “Бидний тунхагладаг Бурхан бол Хаан Эзэн бөгөөд Өөрийн хүмүүсээр хүссэнээ үйлдэж, хэнтэй ч зөвлөлдөхгүйгээр Өөрийн бүтээлүүдийг сайн гэж үзсэнээрээ зохион байгуулах эрхтэй Нэгэн юм.”

Товчхондоо гэвэл, Бурханы бүрэн эрхийн тухай сургаал нь Бурханыг Бурхан байлгадаг сургаал юм.

Энэ үнэн намайг эмээн хүндлэл, бишрэлээр дүүргэдэг. Би энэ сургаалын бүх үр шимийг ухааран ойлгож чадахгүй. Гэхдээ хүндлэн мөргөж, биширч чадна.

Энэ үнэн намайг Бурханы өмнө бууж өгөхөд хүргэдэг. Тэр бол Ваарчин. Би харин шавар. Тэр миний Бүтээгч бас Золигч. Тиймээс надад хүссэнээ үйлдэх эрхтэй. Ямар ч нөхцөл тохиолдсон надад гомдох эрх байхгүй. Шийдвэрүүдэд нь эргэлзэх эрх ч байхгүй.

Энэ үнэн сэтгэл зүрхэнд амар амгалан, тайтгарлыг өгдөг. Тэрээр дээдийн Дээд, бүрэн эрхт Захирагч юм бол Бурханы бүх зорилго биелж, хүссэн үр дүндээ хүрнэ гэдгийг би мэднэ.

Амьдралд ойлгохгүй зүйл олон байдаг нь үнэн. Гэхдээ төгс үр дүнд хүрэхийн тулд энэ нь хамгийн зөв зам байсан гэдэгт бид бүрэн итгэж болно.

## 6 сарын 17

*“Бурханы гүн гүнзгийг чи олж чадах уу, Төгс Хүчит Нэгэний хязгаарыг чи олж чадах уу?” (Иов 11: 7)*

Заавал дурдах ёстой Бурханы өөр олон мөн чанар бий. Энд би товч дурдъя. Бурханы эдгээр төгс чанарыг тунгаан бодох үед бидний сэтгэл газраас тэнгэрт гарсан мэт, хүхнээс уулын оргилд хүрсэн мэт дээш өргөгддөг.

Бурхан бол зөвт. Өөрөөр хэлбэл Бурхан хийж байгаа бүх ажилдаа шударга, эрх тэгш, үнэн зөв ханддаг гэсэн үг. Тэр бол “зөвт Бурхан, Аврагч.” (Иса 45:21)

Бурхан ойлгон ухаарагдашгүй (Иов 11:7,8) Бурхан хүний ухаанд ойлгогдохын аргагүй дэндүү агуу. Стефен Чарнок: “Бурхан байгааг ойлгож болно. Харин Бурхан ямрыг ойлгох боломжгүй.” Ричард Бакстер: “Та Бурханыг мэдэж болно. Гэхдээ бүрэн ойлгож чадахгүй.”

Бурхан бол мөнх. Түүнд эхлэл ч, төгсгөл ч байхгүй (Дуу 90:1-4). Бурханы амьдрал мөнх.

Бурхан бол сайн. (Нах 1:7) “ЭЗЭН бүгдэд сайн. Түүний өршөөлүүд бүтээл бүхнийх нь дээр байна.” (Дуу 145:9)

Бурхан хязгааргүй. (1Ха 8:27) Түүнд хэмжээ, хязгаар, хил зааг байхгүй. Түүний агуу байдлыг хэмжих, тооцох аргагүй бөгөөд хүний ухаанаар төсөөлөх боломжгүй.

Бурхан Өөрөө оршигч. (Гэт 3:14) Тэрээр оршин байх эх үүсвэрээ өөр хэн нэгнээс хүлээж аваагүй. Тэр Өөрөө Өөрийнхөө болон бусад бүх амьдралын эх булаг.

Бурхан Өөрөө Өөртөө хангалттай. Өөрөөр хэлбэл, Гурвалын дотор түүний хэрэгтэй бүх зүйл байдаг.

Бурхан юунд ч үл хязгаарлагдана. Тэрээр орчлон ертөнц, цаг хугацаанаас хэт том бөгөөд материаллаг ертөнцөөс ангид тусдаа.

Миний хэлэх Бурханы хамгийн сүүлийн мөн чанар бол Бурхан бүгдийг урьдаас мэддэг. Христитгэгчид энэ тал дээр хоёр хуваагддаг. Нэг хэсэг нь, Бурханы урьдаас мэдэх мэдлэг хэн аврагдахыг шийддэг гэж үздэг. Нөгөө хэсэг нь, хэн Эзэнд итгэлээ өгөхийг Бурхан зүгээр л урьдчилан мэддэг гэж үздэг. Ром 8:29-г үзвэл Бурхан тодорхой хүмүүсийг бүрэн эрхийнхээ дагуу сонгож, тийнхүү урьдаас мэдсэн бүх хүн нь эцэстээ цог жавхланд орно гэж би итгэдэг.

Ингээд бид Бурханы мөн чанаруудын тухай үзэж дууслаа. Гэхдээ энэ нь хэзээ ч дуусахгүй сэдэв юм. Бурхан туйлын агуу, үнэхээрийн цог жавхланта, дэндүү том учраас бид Түүнийг бүрэн тодорхойлж чадахгүй. Бид бүрсгэр шилний цаанаас харж байна. Бурхан хязгааргүй учраас хүмүүн бидний хязгаарлагдмал оюун ухаан Бурханыг гүйцэд мэдэх боломжгүй. Мөнх цагийн турш бид Бурханыг таньж мэдсээр байх бөгөөд "Талыг нь ч мэдэж дуусаагүй байна" хэмээн хэлсээр байх болно.

## 6 сарын 18

*"Бурхан ба Эцэгийн өмнө цэвэр бөгөөд бузартаагүй сүсэглэл бол өнчин хүмүүс, бэлэвсэн эхнэрүүдийг зүдрэхэд нь эргэж тойрон, өөрийгөө ертөнцөөс бохирдуулалгүй хамгаалах нь ажгуу."* (Иак 1:27)

Иаков энэ үгийг хэлж байхдаа итгэгч хүнээс шаардагдах бүх зан чанарыг хэлээгүй. Харин жинхэнэ итгэл сүсгийг харуулах гол хоёр жишээ бол өнчин ба бэлэвснийг эргэж, өөрийгөө цэврээр сахих явдал гэж хэлж байгаа юм.

Иаков үгийн номлол, илгээлтийн ажил, хүмүүсийг аврах зэргийг ерөөсөө чухалд тооцдоггүй хэмээн бид бодож магад. Гэхдээ тийм биш. Тэрээр хэрэгцээ бүхий хүмүүс дээр очихыг нэн түрүүнд бодож байгаа юм.

Элч Паул "айлаас айлд" (Үйл 20:20) очдог байснаа Ефесийн ахлагч нарт сануулсан. Ж. Н. Дарби айлаар зочлохыг "ажлын хамгийн чухал хэсэг" хэмээн үзсэн. Тэрээр ингэж бичжээ: "Цагийн хонх цаг тутамд дуугарч, өнгөрөн явагчид түүнийг нь сонсдог. Гэхдээ цагийг явуулж, хонхыг зөв цагт нь дуугаргаж, зүүнүүдийг алдаагүй ажиллуулдаг нь дотоод механизм юм. Үүн шиг, хүний нүднээс далд ажил байхгүй үед дэндүү их олны өмнө гэрчилдэг явдлаас би жийрхдэг. Та ч гэсэн айлуудаар явах ажлыг чухалчлаарай. Бусад нь болдгоороо болно." (Г. В. Виграмд явуулсан захидлаас 1839.08.02)

Ганцаараа амьдардаг нэгэн бэлэвсэн эмэгтэй нас дээр гарч хүмүүсийн тусламжаас хараат болжээ. Хийж чадах зүйл бараг үлдээгүй тэрээр өдөр тутмынхаа

амьдралыг өдрийн тэмдэглэлд бичдэг болов. Ялангуяа гаднаас ирж буй хүмүүсийн талаар бичдэг байжээ. Нэг өдөр хөршүүд нь түүний гэрээс ямар ч чимээ анир гарахаа больсныг анзаарлаа. Ингээд цагдаа дуудаж гэрт ороход бэлэвсэн эмэгтэй нас бараад нэлээд хэд хоносон байдалтай олдов. Нас барахаасаа өмнөх гурван өдөрт бичсэн өдрийн тэмдэглэл дээр нь "Хэн ч ирсэнгүй," "Хэн ч ирсэнгүй," "Хэн ч ирсэнгүй" гэж бичсэн байлаа.

Өдөр тутмын завгүй амьдралаасаа болоод бид ганцаардсан, бусдаар дутсан, хэрэгцээ бүхий хүмүүсийг амархан мартдаг. Бид өөр зүйлд анхаарч, хүний анхааралд өртдөг үйлчлэл хийх дуртай. Гэвч итгэл сүсгээ цэвэр бөгөөд бузартаагүй байлгая гэвэл өнчин, бэлэвсэн, настай, өвчтэй хүмүүсийг мартаж болохгүй. Эзэн ийм хүмүүст онцгой анхаарал хандуулдаг ба тэдэнд гараа сунгасан хүмүүст тусгай шагнал бэлдсэн.

## 6 сарын 19

*"Амьдрах өдрийн чинь уртад хүч чадал оршино."* (Дх 33:25)

Бурхан хэрэгцээ тулгарсан үед тухайн цагт нь хэрэгцээнийх нь хэмжээгээр хүч чадлыг өгнө гэж хүмүүстээ амласан. Тэрээр урьдчилж өгнө гэж амлаагүй. Хүнд хэцүү үе ирэхэд яг тэр цагт нигүүлсэл заавал өгөгдөнө.

Магадгүй та хүнд өвчин тусч, зовж шаналах амьдралыг туулах гэж байж болно. Урьдаас харахад тэр зовлон үнэхээр хүнд санагдаж "Би үүнийг дааж чадахгүй" гэж хэлмээр болох байх. Гэвч зовлонгийн хажуугаар Бурханы тусламж ч хамт байх болно. Ингээд та өөрөө болон бусад хүн гайхан алмайрна.

Заримдаа бид хайртай хүмүүсээ алдахаас айдаг. Тийм зүйл тохиолдоход амьдралын бүх утга учир үгүй болж, түүнийг давж гарч чадахгүй юм шиг санагддаг. Гэвч үнэндээ тэгдэггүй. Тэр цаг ирэхэд Эзэний оршихуй ба хүч чадлыг бид урьд өмнөхөөсөө илүү мэдэрдэг.

Олон тохиолдолд амьдралын хатуу шуурга бидэнд нүүрэлдэг. Энэ дунд яаж ийм байв аа гэмээр амар амгалан зүрх сэтгэлд минь ирдэг. Хэцүү үед Эзэн хамт байгаа нь тэр аж.

Христийн төлөө амь амьдралаа өгсөн баатарлаг хүмүүсийн түүхийг бид олонтоо уншдаг. Хүнээс гарамгүй эр зориг тэднээс гарсныг үзээд бид гайхан биширдэг. Үнэндээ тэдний эр зоригийг Бурхан өгсөн бөгөөд үхэх хэрэгтэй өдөр үхэх хүчийг Бурхан өгдөг билээ.



Цаг нь ирээгүй байхад наана нь санаа зовох нь  
бидэнд ямар ч ашиг тусгүй. Хэрэг нь болох хүртэл  
Бурхан нигүүлсэл ба хүч чадлыг өгдөггүй юм.

*Маргааш надад тохиолдох зүйлст  
Өнөөдөр би юу хийж чадах юм бэ?  
Миний Аврагч л түүнд санаа тавина  
Маргааш өгөгдөх нигүүлсэл ба хүчийг  
Өнөөдөр би зээлж чадахгүй хойно  
Маргааш ирэх санаа зовнилыг  
Өнөөдөр яагаад зээлэх ёстой юм бэ?*

(Д. В. Витль)

*Ачаа минь хүндрэхэд Тэр илүү хүчийг өгдөг  
Ажил маань нэмэгдэхэд Тэр илүү нигүүлслийг  
илгээдэг  
Зовлон нэмэгдэхэд Тэр өршөөлөө илүү нэмдэг  
Замд сорилт олироход Тэр амар амгалангаа  
цутгадаг  
Тэвчээрийн маань агуулах шавхагдахад  
Хийх ёстой ажлаа дуусгаж амжилгүй  
Хагасыг нь л хийгээд хүч минь барагдахад  
Хамаг нөөц боломж маань эцэстээ тулахад  
Хайрт Эцэгийн маань дүүрэн өгөлт  
Харин дөнгөж эхэлж байдаг*

(Энни Жонсон Флинт)

## 6 сарын 20

*" Зохистой чадварлаг эхнэрийг хэн олж чадах вэ? Тийм эхнэр эрдэнэсээс ч үнэтэй." (Сур 31:10)*

Христитгэгч эр хүн эхнэрээ сонгохдоо ямар ямар зан чанарыг эмэгтэй хүнээс харах ёстой вэ? Дараах хэдэн саналыг би хэлье. Мэдээж нэг хүнд энэ бүхэн бүгдээрээ байх боломжгүй.

Юуны өмнө бурханлаг эмэгтэй байх ёстой. Дахин төрсөн байх нь хангалтгүй. Мөн сүнслэг бодолтой байх ёстой. Тэрээр Христийг амьдралынхаа тэргүүн эгнээнд тавьдаг, залбирагч, Эзэний үйлчлэлд идэвхтэй эмэгтэй байвал зохино. Мөн Христийн зан чанарыг тусган харуулдаг, сүнслэг хүндлэлийг хүлээхүйц, нөхрөө ч бас тийн хүндэлдэг байх.

Тэрээр Бурханы өгсөн захирагдах байр суурийг хүлээн авдаг, нөхрөө өрхийн тэргүүн байхад нь тусалдаг, гэрлэлтийн тангарагтаа үнэнч, сайн эхнэр, хүүхдүүдийнхээ сайн ээж, биеэ зөв зохистой авч явдаг, задгай хувцасладаггүй байх.

Сайн эхнэр нь гэр орондоо анхаарал тавьдаг, гэр орноо цэвэр цэмцгэр байлгадаг, гэрийн асуудлаа ухаалгаар зохицуулдаг, гэрийнхэндээ хоол ундыг нь бэлтгэж өгдөг, бусдад найрсаг зочломтгой, нөхөртэйгөө нэгэн ижил санаа зорилготой байдаг.

Зөрчилдөөн гарах үед дуугаа хураах юм уу унжийж муухай аашлахын оронд асуудлыг ил тод ярилцах хүсэлтэй. Ялгаатай үзэл бодлынхоо талаар нээлттэй санал бодлоо солилцдог. Шаардлага гарвал буруугаа хүлээж уучлалт гуйх чадвартай байх. Мөн хов жив хөөцөлддөггүй, бусдын

хэрэгт хөндлөнгөөс оролцдоггүй, даруу төлөв, чимээгүй, чалчаа биш байх нь сайн эмэгтэйн чанар юм.

Ийм эхнэр гэр бүлийнхээ орлогод тааруулж амьдралаа зохицуулдаг бөгөөд хий хоосон юмсыг хүсэн шунадаггүй, өөрийгөө бусадтай харьцуулдаггүй. Тэрээр шаардлага гарвал хүнд хэцүүг хүлээн авахад бэлэн.

Тэрээр нөхрийнхөө эрхийг дуртай дургүй биш, баяртайгаар хүлээн зөвшөөрдөг. Тэрээр ааш зан сайтай бөгөөд атаа жөтөөгүй, нийгмийн зэрэг зиндааны хойноос хөөцөлддөггүй, итгэж найдаж болох хүн юм.

Хэрэв эхнэрт чинь эдгээр зан чанар байх аваас эр нөхрүүд талархах ёстой. Харин эхнэрүүд үүгээр өөрсдийгөө шалгаж улам бүр хичээх хэрэгтэй.

## 6 сарын 21

*"Нөхрүүд ээ, Христ чуулганыг хайрлаад түүний төлөө Өөрийгөө өгсний адил эхнэрүүдээ хайрла." (Еф 5:25)*

Христитгэгч эмэгтэй, нөхрөө сонгохдоо ямар ямар зан чанарыг эр хүнээс харах ёстой вэ? Юун түрүүнд гадаад үзэмжийг бус сүнслэг амьдралыг нь харах ёстой.

Эр хүн эхлээд Бурханы хаанчлал ба зөвт байдлыг хайдаг, Эзэнд үйлчлэхийг зорилгоо болгодог, нутгийн чуулганд идэвхтэй хамрагддаг, гэр бүлээ Бурхан руу дагуулдаг, итгэгч хүний үлгэр жишээ болдог, Бурханы хүн байх ёстой.

Эр хүн өрхийн тэргүүний үүрэг хариуцлага дээрээ зогсох ёстой. Гэхдээ дарангуйлагч байна гэсэн үг биш.

Тэрээр эхнэрээсээ шаардаж биш, харин хайрлаж, хайраараа эхнэрийнхээ дуулгавартай байдлыг олж авдаг. Мөн эхнэрээ хүндэлж, амьдралынхаа цорын ганц эмэгтэй байлгадаг. Тэрээр итгэмжтэй, бусдыг ойлгодог, тэвчээртэй, халамжтай, сайхан сэтгэлтэй, ухаалаг, баяр хөөртэй хүн юм

Сайн нөхөр нь гэр орныхоо хэрэгцээг хангахын тулд хичээнгүй ажилладаг. Гэхдээ мөнгө түүний гол зорилго биш. Түүнд шунал байх ёсгүй.

Тэрээр хүүхдүүдээ хайрлаж, сургаж, хүүхдүүддээ цаг гаргаж, хүүхдүүдийнхээ төлөө үйл ажиллагаа зохион байгуулж, хүүхдүүддээ нэг бүрчлэн анхаарал тавьж, сайн үлгэр дуурайл болдог байх.

Тэрээр зочломтгой зантай байх ёстой. Орон гэр нь Эзэний зарц нарт, бүх итгэгч нарт, дээрээс нь аврагдаагүй хүмүүст нээлттэй байдаг.

Сайн эр хүн эхнэртэйгээ болон гэр бүлийнхээ бусад гишүүдтэй нээлттэй харилцаж, тэдний сул талыг ойлгож, хүлээн зөвшөөрч, алдаж эндүүрэхэд нь бухимдалгүй байж чаддаг, тэдэнтэй эрүүл ухаанаар, нөхөрсгөөр харилцдаг. Буруу юм хэлэх юм уу хийсэн тохиолдолд тэр даруй алдаагаа хүлээн зөвшөөрч, уучлалт гуйдаг. Гэрийнхнийхээ санаа оноог сонсож чаддаг. Эхнэрээ манлайлж, эхнэрийнхээ чадахгүй зүйл дээр түрүүлж явах нь эр хүний нэгэн сайн чанар юм.

Мөн биеэ цэвэр цэмцгэр авч явдаг, хувиа хичээдэггүй, шударга, итгэл даадаг, өгөөмөр, талархаж чаддаг, хошин шогийн мэдрэмжтэй, гомдоллож гонгинодоггүй байх нь эр хүнд байх ёстой чанарууд юм.

Мэдээж энэ бүх чанар нэг хүнд байх боломжгүй. Эр хүнээс бүгдийг нь хүлээвэл бодит байдалд нийцэхгүй. Хэрэв нөхөр чинь энэ чанаруудын ихэнхийг өөртөө шингээсэн бол эхнэр хүн та талархаж, бусад дутуу чанаруудаа хөгжүүлэхэд нь нөхөртөө хайраар туслаарай.

## 6 сарын 22

*"Харин бүхнийг шалга, сайнаас зуур." (1Тс 5:21)*

Заримдаа итгэгчид сургаалын салхи, түр зуурын хэлбэр загварыг аялдан дагах хандлагатай байдаг. Жон Бланчардын бичсэн нэг түүхийг ярья. Жуулчид тээвэрлэсэн хоёр автобусны жолооч ярьж байна гэнэ:

- Манай автобусанд дандаа христэч хүмүүс суужээ.
- Өө тийм үү? Тэд чинь юунд итгэдэг юм?
- Миний хэлсэн болгонд итгэж байна лээ.

Заримдаа хоол ундны тухайд ч тэр. Энэ үед зарим хоолыг хор мэт танилцуулж, заримыг нь ид шидийн юм шиг л ярьцгаадаг. Зарим үед ямар нэг эмийг тэнгэрт тултал магтдаг. Энэ л эмийг уучихвал мөнхийн рашаан хүртсэн мэт болно гэх нь холгүй юм ярьдаг.

Христитгэгчид мөнгө босгох үйл ажиллагаанд маш итгэмтгий гэнэн ханддаг. Манай орны байдлыг харвал өнчин ядуусын төлөөх аян, коммунизмын эсрэг хөдөлгөөнд юу ч бодохгүйгээр олноороо оролцоцгоодог. Түүнийг санхүүжүүлж байгаа газар нь зөв шударга байгууллага уу гэж ерөөсөө нягталдаггүй.

Худалч луйварчид итгэгчдийн итгэлийг амархан олдог. Тэдний өрөвдүүлэх түүх хэчнээн утгагүй байсан ч тэд хялбархан мөнгө босгож чаддаг.

Гол асуудал нь бид итгэлийг итгэмтгий байдлаас ялгаж салгахгүй байгаа юм. Итгэл бол энэ хорвоогийн хамгийн найдвартай зүйл буюу Бурханы үгэнд үндэслэдэг. Харин итгэмтгий байдал нь ямар ч баталгаа нотолгоогүй үндэслэлгүй зүйлсийг юу ч байсан хамаагүй хүлээн авч чаддаг.

Бурхан Өөрийн хүмүүсийг юуг ч шүүн тунгаадаггүй байгаасай гэж хүсдэггүй. Харин ч эсрэгээрээ Библи өөр зүйл хэлдэг. Дараах ятгалгуудыг сонсоно уу: "Харин бүхнийг шалга, сайнаас зуур." (1Тс 5:21) "Үнэгүйгээс үнэтэйг гаргаж ав [ялгаж салга]." (Иер 15:19) Хайр чинь мэдлэг ба бүх хэрсүү ухаанаар улам бүр бялхах болтугай гэж би залбирдаг. (Фил 1:9)

"Хайртууд минь, сүнс болгонд бүү итгэ. Харин сүнснүүдийг Бурханаас эсэхийг шалга. Учир нь олон хуурамч эш үзүүлэгч дэлхийд гарч ирсэн. (1Ио 4:1)

Мэдээж хэрэг сургаалын асуудалд ийм гэнэн итгэмтгий хандвал маш их аюул дагуулна. Гэхдээ өөр олон асуудал дээр итгэгчид хэт туйлширч, утга учиргүй зүйлст итгэж, түүнийхээ араас халуун сэтгэлээр явж эхэлбэл аюултай.

## 6 сарын 23

*"Есүс дотор нойрссон хүмүүс..." (1Тс 4:14)*

Эзэн доторх хайрт хүмүүс маань нас барах үед бид ямар хандлагатай байх ёстой вэ? Зарим итгэгч сэтгэл санааны хувьд бүрэн уналтад ордог. Харин зарим нь хэчнээн гунигтай байлаа ч энэ бүхнийг баатарлагаар тэсвэрлэдэг. Энэ нь бид Бурханы дотор хэр гүн үндэслэсэн гэдгээс, мөн итгэлийнхээ тулгуур сургаалуудыг хэр сайн ойлгосон гэдгээс шууд хамаардаг.

Юуны өмнө бид үхлийг Эзэн Есүсийн өнцгөөс харах хэрэгтэй. Үхэл бол Иохан 17:24 дээрх Эзэний залбирлын хариулт юм: "Аав аа, Надад өгсөн хүмүүс тань бас Миний байдаг газарт Надтай хамт байж, сүр жавхланг минь үзээсэй гэж Би хүсэж байна." Бидний хайртай хүмүүс Эзэнтэй хамт байхаар одох үед Эзэн зовлонгоороо аварсан хүнээ харж баярлан, сэтгэл хангалуун болно. (Иса 53:11) "Итгэлтнүүдийнх нь үхэл Эзэний мэлмийд үнэ цэнтэй." (Дуу 116:15)

Дараа нь бид үхлийг нас барсан хүний өнцгөөс харах хэрэгтэй. Тэрээр Хааныг гоо үзэсгэлэн, цог жавхлангаар нь харах завшааныг олжээ. Тэр одоо нүгэл, өвчин, зовлон, шаналлаас үүрд ангижирчээ. Тэрээр ирэх бузар муугаас авагджээ (Иса 57:1). "Ариун хүн гэртээ очихоос илүү сайхан зүйл гэж үгүй. Гэртээ харьсан тэрээр энэ хуучин шавар шалбаагийг орхиж, материаллаг ертөнцийн хамаг хүлээснээс ангижирч, үй түмэн тэнгэрэлч нараар угтуулна." "Итгэгч хүн нас барсан даруйдаа диваажинд очдог. Түүний тулаан дуусаж,



тэмцэл нь төгсжээ. Бид бүхний хэзээ нэг өдөр туулах ёстой бүрхэг хөндийг тэрээр нэгэнт туулжээ. Бид бүхний хэзээ нэг өдөр гатлах ёстой харанхуй голыг тэрээр нэгэнт гаталжээ. Нүглээс болж хүн бүхний уух ёстой болсон гашуун ундаатай аягыг тэр уужээ. Одоо түүнд ямар ч зовлон, шаналал байхгүй. Түүнийг дахиж ирээсэй гэж бид хүсэх ёсгүй. Бид түүний төлөө гашуудах биш, харин өөрсдийнхөө төлөө гашуудах ёстой." (Бишоп Райл) Итгэл энэ үнэнийг талархан хүлээн авч, үүгээр батжин, урсгал усны дэргэд таригдсан мод мэт эс ганхана.

Хайртай хүмүүсийн маань үхэл бидэнд үргэлж гуниг төрүүлдэг. Гэхдээ бид ямар найдваргүй хүмүүсийн адил гашууддаггүй (1Тс 4:13). Бидний хайртай хүмүүс Христтэй хамт, илүү дээр газар байгааг бид мэднэ. Бид түрхэн зуур л тусдаа байгаа гэдгийг ч мэднэ. Хожим бид Иммануелын нутагт дахин уулзаж, бие биеэ одоогийнхоос илүү сайхан нөхцөл байдалд таних болно. Христ дотор нойрсогсод эхлээд амилж, амьд үлдсэн бид тэдэнтэй хамт үүлэн дунд Эзэнтэй уулзахаар, Эзэнтэй үүрд хамт байхаар агаар мандалд өргөгдөх үе, Эзэний ирэлтийг бид хүлээж байна (1Тс 4:16, 17) Энэ найдвар бүх зүйлийг өөр өнцгөөс харуулдаг.

Бурханы тайтгарууллыг бид чамлаж болохгүй (Иов 15:11). Бидний уй гашуунд баяр хөөр бий. Хайрт хүнээ алдсан алдагдал маань мөнх ерөөлийн амлалтаар нөхөн төлөгддөг.

## 6 сарын 24

*“Хүүхдүүдэд зөвшөөрч, Тэднийг Над дээр ирэхийг нь бүү хоригло. Учир нь Бурханы хаанчлал эдний адил хүмүүсийнх юм.”* (Мк 10:14)

Хүүхдийн үхэл Бурханы хүмүүсийн итгэлд үргэлж хүнд сорилт байдаг учраас ийм тохиолдол ирэхэд зогсох тэнхээтэй байх нь чухал.

Хариуцлага үүрэх наснаасаа өмнө нас барсан хүүхэд Есүсийн цусаар дамжуулан аврагдана гэж христитгэгчид ерөнхийдөө үздэг. Хүүхэд өөрөө Аврагчийг хүлээн авах эсвэл үгүйсгэх чадваргүй тул Бурхан загалмай дээрх Христийн ажлын бүх үнэ цэнийг нас барсан хүүхдэд тооцдог, нас барсан хүүхэд Христийн ажлын аврах үнэ цэнийг бүрэн ойлгоогүй байсан ч, Эзэн Есүс Христийн үхэл ба амиллаар дамжуулан аврагдана гэж христитгэгчид үндэслэлээ тайлбарладаг.

Хэдэн настай болбол хариуцлага хүлээх насанд хүрэх вэ гэдгийг яривал түүнийг Бурхан л мэднэ. Учир нь хүүхэд болгон адилгүй. Зарим хүүхэд эрт, зарим хүүхэд орой төлөвшдөг.

Хариуцлага үүрэх насанд хүрээгүй хүүхэд диваажинд очно гэж шууд хэлсэн Библийн хэсэг байхгүй боловч энэ үзлийг дэмжих хоёр эшлэл бий. Нэг нь өнөөдрийн эш татсан эшлэл: *“Хүүхдүүдэд зөвшөөрч, Тэднийг Над дээр ирэхийг нь бүү хоригло. Учир нь Бурханы хаанчлал эдний адил хүмүүсийнх юм.”* (Мк 10:14) Есүс хүүхдүүдийн тухай ярихдаа *“Бурханы хаанчлал эдний адил хүмүүсийнх юм”* гэж хэлсэн. Хүүхэд Бурханы хаанчлалд орохын тулд том болох ёстой гээгүй, харин хүүхэд Бурханы хаанчлалд

орохуйц чанарыг агуулж байдаг гэж хэлсэн. Бяцхан хүүхдүүдийн авралын асуудалд энэ маш том баталгаа юм.

Өөр нэгэн баталгаа нь энэ: Есүс томчуудын тухай ярихдаа “Хүний Хүү алдагдсаныг хайж, аврахаар ирсэн билээ” (Лк 19:10) гэж хэлсэн. Харин хүүхдүүдийн тухай ярихдаа хайх гэсэн үгийг дурсалгүй “Учир нь Хүний Хүү алдагдсаныг аврахаар ирсэн юм” (Мт 18:11) гэж хэлсэн. Юу гэсэн үг вэ гэвэл, хүүхдүүд томчууд шиг төөрч одоогүй бөгөөд Аврагч бүрэн эрхийнхээ дагуу нас барах үед нь тэднийг Өөрийн сүрэгтээ хураан цуглуулна. Тэд хэдийгээр Христийн ажлын тухай мэдэхгүй боловч Бурхан түүнийг мэдэж байгаа учраас тэдэнд аврах хүчийг нь тооцно.

Бурхан биднээс хүүхдүүдийг минь аваад, Өөрийн эрхээрээ тэднийг аварвал бид Бурханыг байцаан, яагаад гэж асуух хэрэггүй. Жим Эллиот ингэж бичжээ: “Бид энэ дэлхий дээр өтөл болтол нь байлгах гэдэг хүмүүсийг маань Бурхан хүүхэд ахуйд нь аваад явахад би гайхахгүй. Бурхан мөнхөд хамт байх хүмүүсээ цуглуулж байна. Бурхан яагаад заавал хөгшин хүмүүсийг л авна гэж?”

## 6 сарын 25

*“Миний хөвгүүн Абсалом минь, хүү минь. Миний хөвгүүн Абсалом минь. Чиний оронд би үхсэн бол дээр байсан юм. Абсалом хүү минь, миний хүү!”* (2См 18:33)

Абсалом аврагдсан эсэхийг мэдэхгүй. Гэхдээ түүний эцгийн гашуудал, олон жил авралынх нь төлөө залбирсан дотнын хүнийхээ үхэлд гашуудаж буй олон итгэгчийн тусгал болдог. Ийм тохиолдолд найдвар байгаа болов уу? Библийн дагуу бид ямар байр суурьтай байх ёстой вэ?

Юун түрүүнд хэлэхэд, тухайн хүн үхэхдээ Христийг хүлээн аваагүй гэж хэлэх баталгаа байхгүй. Мориноос унахдаа Христэд итгэлээ өгсөн хүний гэрчлэлийг би сонсож байлаа. “Дөрөө, газар хоёрын дунд Бурханы өршөөлийг гуйгаад түүнийгээ олсон” гэж тэр хүн ярьж байсан юм. Өөр нэг хүн гарам дээр халтираад унахдаа ус уруу орохоосоо өмнө Христэд итгэсэн гэдэг. Энэ хоёр хүн нас барсан бол, тэднийг итгэл дотор үхсэн гэж хэн ч мэдэхгүй өнгөрнө шүү дээ.

Комд байгаа хүн аврагдах боломжтой гэж би итгэдэг. Эмнэлгийн ажилтнуудын хэлж байгаагаар комд байгаа хүн өөрөө ярьж чадахгүй ч өрөөн доторх яриаг сонсож ойлгодог байна. Хэрэв тэр хүн сонсож ойлгодог юм бол яагаад итгэлээр Есүс Христийг хүлээн авч чадахгүй гэж?

Гэхдээ муугаар бодож үзье. Тухайн хүн аврагдалгүйгээр нас барлаа гэж бодъё. Энэ үед бид ямар хандлагатай байх ёстой вэ? Бид мах цусан холбооноос үл хамааран Бурханы талд л зогсох ёстой. Хүн нүглүүд дотроо нас барах нь Бурханы буруу биш ээ. Бурхан асар их үнэ цэнээр нүглүүдээсээ аврагдах замыг хүмүүст тавьж

өгчээ. Түүний аврал бол үнэгүй бэлэг. Тэр ямар ч гавьяа, хичээл зүтгэл, буян шаарддаггүй. Хүн мөнх амийн бэлгээс татгалзвал Бурхан өөр юу хийж чадах юм бэ? Диваажинд байхыг хүсэхгүй хүмүүсийг Бурхан диваажинд очуулахгүй нь мэдээж. Тэгэхээр тэд диваажинд бус, тамд очихоос өөр замгүй.

Хэрэв хайрт хүмүүс минь найдваргүйгээр мөнх цагийг зорин одвол Бурханы Хүү Иерусалимын төлөө “Би хэчнээн ч удаа хүслээ дээ. Харин та нар хүсээгүй” хэмээн гашуудсан шиг бид ч мөн тэднийхээ хойноос гашуудах ёстой.

Дэлхийн Шүүгч хэзээд зөвийг үйлддэгийг бид мэднэ (Эх 18:25). Тиймээс гэмшсэн нүгэлтнүүдийн авралд Бурханыг зөвтгөдөг шигээ авралгүйчүүдийн мөхөлд ч Түүний талд зогсох хэрэгтэй.

## 6 сарын 26

*“Тэр тэдэнд ‘Та нар зэлүүд газарт оч. Жаахан амар’ гэжээ...Тэд тусдаа байхаар зэлүүд газар уруу завиар явав. Хүмүүс тэдний хөдлөхийг хараад, олонх нь таньжээ. Тэд хот бүрээс тийш явган гүйсээр тэднээс урьтаж ирэв...Есүс үй олон хүн байхыг харж тэднийг өрөвдөв.”*  
(Мк 6:31-34)

Төлөвлөөгүй саатал, ажлыг минь тасалдуулсан зүйлст бид амархан бухимддаг. Яг төлөвлөсөн ёсоороо юмаа хийгээд явж байтал хэн нэг хүн гэнэт гарч ирээд ажлыг минь зогсоохоор бид ер нь л дургүй. Жишээ нь би ном бичээд сууж байлаа. Үг урсаад сайхан явж байв. Гэтэл хонх дуугарч, надаас зөвлөгөө авъя гээд нэг хүн хаалган дээр зогсож байвал надад тийм ч сайхан санагдахгүй.

Эзэн Есүс харин иймэрхүү тохиолдлыг төвөгшөөж байсангүй. Тэр бүхнийг Тэрээр тухайн өдөрт зориулсан Эцэгийн төлөвлөгөөний нэг хэсэг хэмээн хүлээж авдаг байжээ. Энэ нь Түүний амьдралыг туйлын тогтвортой, амар амгалан болгож байлаа.

Үнэндээ хүмүүс биднийг гээд ирж байвал тэр хэмжээгээр бид хэрэгтэй хүмүүс гэдгээ ойлгох хэрэгтэй. Англикан сэтгүүлийн нэгэн бичээч, “Хүмүүс таныг тайван байлгахгүй, байн байн амьдралд чинь орж ирж унтууцлыг чинь төрүүлж байвал түүний давтамж нь таны амьдралын үнэ цэнийг харуулдаг гэдгийг санаарай. Бусдад туслах чадалтай, боломжтой хүмүүс л бусдын ачааг үүрэлцэж явдаг юм шүү! Та хэдий чинээ чухал байна, төдий чинээ олон хүн таны амьдралд төвөг учруулна. Тиймээс хүмүүс таныг зориод ирэхэд төвөгшөөж, тэднийг цааш түлхсээр

байгаад, хэнд ч хэрэггүй, дэндүү биеэ даасан, хэн ч таныг зорьж ирдэггүй, ганцаардмал нэгэн болчих вий гэж болгоомжлоорой” хэмээн бичжээ.

Маш завгүй нэгэн гэрийн эзэгтэй байжээ. Нэг өдөр түүнийг ажилдаа дарагдчихсан сууж байтал нөхөр нь ажлаасаа эрт хүрээд ирэв. Эхнэр, “Чи энд юу хийж байгаа юм бэ?” гэхэд нөхөр инээмсэглээд “Би энд амьдардаг шүү дээ” гэж хариулсан гэдэг. Хожим нь тэр эмэгтэй “Тэр өдрөөс хойш би нөхрийгөө гэртээ ирэхэд хийж буй ажлуудаа хойш тавиад түүнийгээ эелдгээр угтан авч, чи чухал хүн шүү гэдгийг нь мэдрүүлэхийг хүсдэг болсон” гэж бичсэн байдаг. Өглөө бүр бид тухайн өдрөө Эзэнд даатгаж, бүх зүйлийг удирдан зохион байгуулж өгөөч хэмээн Түүнээс гуйх хэрэгтэй. Хэрэв хэн нэгэн ирж, ажлыг минь саатуулбал, Эзэн тэр хүнийг илгээжээ гэж ойлго. Тэгж бодвол бид түүнд үйлчилж чадна. Тэр хүн ажлын минь цагаас хороож болох ч, түүнд гаргасан зориулалт тухайн өдрийн хамгийн чухал ажил ч байж мэдэх юм.

## 6 сарын 27

*“Гэвч эмэгтэйчүүд...хүүхэд төрүүлэхээр аврагдана.”*  
(1Тм 2:15)

Паул чуулганы зарим үйлчлэлийг эмэгтэйчүүдэд хязгаарласан. Жишээ нь эмэгтэйчүүд номлох болон эрэгтэй хүний дээгүүр эрх мэдэлтэй байхыг Паул хориглосон. Харин түүний оронд чуулганд чимээгүй байхыг зааварласан (12-р эшлэл). Үүнийг үзээд эмэгтэй хүн христитгэлд доогуур байр суурьтай юм байна, эмэгтэй хүн хэн ч биш юм байна гэж зарим хүн ойлгож болох юм.

Тэгвэл 15-р эшлэлд иймэрхүү буруу ойлголтыг үгүйсгэж байна. “Эмэгтэйчүүд хүүхэд төрүүлэхээр аврагдана” гэж Паул хэлжээ. Энэ нь мэдээж эмэгтэй хүний сүнсний авралыг яриагүй. Харин чуулган доторх байр суурийнх нь авралыг ярьж байна. Эмэгтэй хүн хүүхдийг Бурханы төлөө өсгөх онцгой хувь тавиланд дуудагджээ.

“Хүүхэд өсгөдөг гар ертөнцийг удирддаг гар мөн” гэж Уилльяам Росс Уалланс хэлсэн. Хүчирхэг удирдагчдын ард хүчирхэг ээжүүд байдаг.

Сузанна Уэсли индэрийн араас үйлчлээгүй нь мэдээж. Гэвч тэрээр Жон, Чарльз нэртэй хоёр хүүгээ гэртээ сурган хүмүүжүүлснээрээ дэлхий дахинд хүрч чадсан юм.

Өнөөгийн нийгэмд олон эмэгтэй гэртээ суухыг дорд ажилд тооцож, бизнесийн болон ажил мэргэжлийн талбарт өндөр карьер хөөцөлдөхийг илүүд үздэг болжээ. Тэдний хувьд гэрийн ажил нь ял бөгөөд орон гэрээ барьж босгох нь яршигтай ажил ажээ.

Христэч эмэгтэйчүүд хамт хооллож суугаад яриа нь ажил карьер руу орчхож гэнэ. Хүн бүр л өөрийнхөө албан



тушаал, цалин хөлсний тухай ярьж эхлэв. Мэдээж тэнд өрсөлдөх сэтгэл байсан биз. Гэтэл нэг нь гэртээ суудаг эмэгтэйгээс “Шарлот, чи ямар ажил хийдэг вэ?” гэж асууж гэнэ. Шарлот даруухнаар, “Би Бурханы төлөө эрчүүдийг өсгөдөг” гэж хариулжээ.

Фароаны охин, Мосегийн ээжид “Энэ хөвгүүнийг авч, надад хөхүүлж өг. Би чамд хөлсийг нь өгнө” (Гэт 2:9) гэсэн. Магад хөвгүүд охидоо Бурханы төлөө, мөн мөнх цагийн төлөө өсгөж хүмүүжүүлэхэд амьдралаа зориулсан эмэгтэйчүүд Христийн шүүх суудлын өмнө хамгийн өндөр хөлс авч, олны гайхлыг төрүүлэх биз ээ.

Тийм ээ, эмэгтэй хүн хүүхэд төрүүлэхээрээ аврагдана. Эмэгтэй хүн чуулган дотор олны өмнө үйлчлэхээр дуудагдаагүй. Бурханлаг хүүхдүүдийг өсгөх нь Бурханы нүдэнд түүнээс чухал харагддаг.

## 6 сарын 28

*“Хэн итгээж баптисм хүртэнэ, тэр аврагдах болно. Харин итгээгүй нь яллагдах болно.” (Мк 16:16)*

Энэ нь авралын талаарх Библийн цорын ганц эшлэл байсан бол аврагдахын тулд итгэлээс гадна баптисм зайлшгүй чухал гэж бид дүгнэж болох байлаа. Гэвч авралыг зөвхөн итгэлээр авна гэсэн 150 орчим эшлэл Библид байдаг болохоор энэ мэт нэг хоёр эшлэлийг бид тэдгээр 150 эшлэлийн гэрэл доор харах ёстой.

Баптисм нь авралын зайлшгүй шаардлага биш боловч дуулгавартай байдалд нэн чухал юм. Өөрийнх нь Хүүг Эзэн ба Аврагч хэмээн итгэлээ өгсөн бүхэн усан баптисмаар Түүнийх болсноо нийтэд харуулаасай гэж Бурхан хүссэн.

Шинэ гэрээнд баптисм хүртээгүй итгэгч байж болно гэсэн юм огт дурсаагүй. Харин ч хүн аврагдсан даруйдаа баптисм хүртдэг тухай л бичсэн. Үйлс номыг үзвэл шавь нар итгэсэн хүмүүсийг тэр даруй баптисм уруу дуудсан байдаг. Тэд ямар нэг албан ёсны ёслол хийх гэж хүлээгээгүй. Харин, тухайн хүний итгэлийн тунхаглалд үндэслээд тэр даруй түүнд баптисм хүртээж байлаа.

Итгэх, баптисм хүртэхийн дараалал зэрэг шахуу байдаг. Библид “Тэр итгэсэн, баптисм хүртсэн” гэж бичигдсэн.

Бид баптисмаар дахин төрдөг гэсэн гаж сургаалаас зайлсхийх гэж оролдохдоо нөгөө тал руу хэт хэлбийжээ. Баптисм хүртсэн эсэх нь тийм ч чухал биш гэж боддог хүн олширчээ. Гэвч баптисм хүртсэн эсэх нь маш чухал шүү!

“Баптисм хүртээгүй байсан ч би диваажинд очно” гэж хөнгөн хуумгай үгсийг бид олонтоо сонсдог. Би тийм хүмүүст “Тийм ээ, тэр үнэн. Та баптисм хийлгээгүй байсан ч диваажинд очно. Гэхдээ мөнхөд баптисм хийлгээгүй чигээр амьдарна” гэж хэлдэг. Диваажинд баптисм хүртэх боломж байхгүй. Бид энэ тал дээр Эзэнд дуулгавартай байх цорын ганц боломжит цаг нь одоо энэ дэлхий дээр юм.

Есүс Христийг Эзэн ба Аврагч хэмээн хүлээн авч, Түүнд итгэлээ өгсөн бүхэн баптисм хүртэх боломжийг огт алдаж болохгүй. Хойшлуулж хүлээх ч хэрэггүй. Баптисмаар дамжуулан тэрээр Христийн үхэл ба амилалтай нэг болсноо, шинэ амь дотор алхаж эхэлснээ нийтийн өмнө зарлаж байгаа юм.

## 6 сарын 29

*“Үнэнээр үнэнээр Би та нарт хэлье. Үгийг минь сонсоод, Намайг илгээгч Түүнд итгэгч нь мөнх амьтай болох бөгөөд яллагдахгүй. Харин үхлээс гэтэлж аминд шилжив.”* (Иох 5:24)

Энэ бол олон хүний амьдралд хувьсгал авчрагч, өөрчлөгч хүчтэй үг мөн.

“Үнэнээр” гэдгийг хоёронтоо давтсан нь маш чухал үг хэлэх гэж байгааг илэрхийлнэ. Энэ үг бидний урмыг хугалахгүй.

“Би та нарт хэлье.” “Би” гэдэг нь Эзэн Есүс. Энэ нь 19-р эшлэлээс тодорхой ойлгогдоно. Эзэн үг хэлсэн бол тэр нь гарцаагүй үнэн байдаг. Тэр худал хэлэхгүй, хууран мэхлэхгүй, юунд ч хууртагдахгүй. Түүний хэлснээс илүү баталгаатай, найдвартай зүйл гэж үгүй.

Эзэн хэнд хандаж хэлж байна вэ? “Би та нарт хэлье.” Бурханы Мөнх Хүү танд, надад хэлж байна. Өмнө нь хэн ч бидэнд ийм эрх мэдэлтэй ярьж байсангүй. Цаашид ч ийм хүн гарахгүй. Бид Түүний үгийг сонсох ёстой.

“Үгийг минь сонсоод...итгэгч нь...” Сонсоод, итгэх “хэн ч байж болно” гэсэн утгаар хэлж байна. Түүний үгийг сонсох гэдэг нь зүгээр чихээрээ сонсохыг хэлдэггүй. Харин сонсоод итгэх, сонсоод хүлээн авах, сонсоод дагахыг хэлдэг.

“Намайг илгээгч Түүнд итгэгч нь.” Түүнийг Бурхан Эцэг илгээснийг бид мэднэ. Гэхдээ гол нь “Тэр яагаад Түүнийг илгээсэн бэ?” Эцэг намайг орлуулж шийтгэхийн тулд, миний хүртэх байсан ялыг эдлүүлэхийн тулд, миний

нүглүүдийг хэлтрүүлэх гэж цусыг нь урсгахаар Түүнийг илгээсэн гэдэгт би итгэдэг.

Тэгээд гурван талт амлалт бидэнд өгөгдсөн байна. Нэгт нь “мөнх амьтай болох.” Хүн итгэсэн даруйдаа мөнх амьтай болдог. Ийм л энгийн бөгөөд тодорхой. Хоёрт гэвэл, мөнх амьтай болсон хүн “яллагдахгүй.” Өөрөөр хэлбэл, тэр хүн нүглүүдээсээ болж хэзээ ч там руу явахгүй гэсэн үг. Яагаад гэвэл, Христ өрийг нь төлчихсөн юм. Бурхан төлбөрийг хоёр удаа нэхэхгүй. Гуравт, тэр хүн “үхлээс гэтэлж аминд шилждэг.” Тэрээр Бурхантай харилцах харилцааны хувьд сүнсний үхмэл байдалтай байсан боловч хэзээ ч дуусахгүй шинэ аминд дахин төржээ.

Хэрэв та Түүний үгийг үнэхээр сонссон бол, Эцэг Түүнийг илгээсэнд итгэсэн бол Эзэн Есүс таныг аврагдсан гэдэг баталгааг өгч байна.

Үүнийг “Сайнмэдээ” гэж нэрлэдэгт гайхах юм алга.

## 6 сарын 30

*“Мосе гараа өргөхөд Израиль ялж, буулгахад Амалек ялж байв.” (Гэт 17:11)*

Израиль, Амалектай дайтаж байв. Мосе уулын орой дээрээс тулааны талбарыг харан зогсоно. Тэгэхэд Мосегийн гарын байрлал тулааны ялалт, ялагдлыг шийдэж байлаа. Мосе гараа өргөхөд Амалек ялагдаж, буулгахад Израиль ялагдав.

Мосегийн гар өргөөтэй байх үе нь бидний Зуучлагч, “хайр ба өршөөлөөрөө бидний төлөө гараа өргөдөг” Эзэн Есүсийг бэлгэддэг. Эзэн Есүсийн зуучлалаар бид үүрд аврагдсан. Тэр цагаас хойш Эзэн Есүс гараа хэзээ ч буулгаагүй. Учир нь Тэр хэзээ ч ядардаггүй, огтхон ч цуцдаггүй. Тэр бидний төлөө зуучлахаар үргэлж амьд байна.

Энэ түүхээс итгэгчдийн зуучлан залбирлын утга учрыг харж бас болно. Гараа өргөсөн Мосе нь илгээлтийн талбарын сүнслэг тулаанд оролцож байгаа итгэгчдийн төлөө итгэмжтэй зуучлан залбирагч хүмүүсийн дүрслэл болдог. Бид залбирлын үйлчлэлийг огоорох үед дайсан ялдаг.

Нэгэн илгээлтийн эзэн хамтрагчтайгаа дээрэмчид орогносон газар шөнийг өнгөрөөжээ. Тэд өөрсдийгөө Эзэнд даатгаад унтсан байна. Хэдэн сарын дараа дээрэмчдийн толгойлогч илгээлтийн эзний ажиллуулдаг эмнэлэгт хүргэгдэн ирээд илгээлтийн эзнийг таньж, “Бид тэр шөнө та хоёрыг дээрэмдэхээр төлөвлөж байсан боловч хорин долоон цэргээс чинь айгаад чадаагүй” гэж хэлжээ.

Илгээлтийн эзэн энэ тухайгаа чуулгандаа мэдээлжээ. Тэгэхэд чуулганы нэг гишүүн “Тэр орой бидний хорин долоон хүн залбиралын цуглаанд залбирсан юм” гэж хэлжээ.

*Залбирахыг минь харахаараа*

*Заавал Бурхан тусалдаг юм*

*Тэмцэлд бид ялдаг юм*

*Тэгээд эзлэн авдаг юм*

*Үнэний туг манддаг юм*

*Өстөн Сатан дарагддаг юм*

*Айдас хүйдэс замхардаг юм*

*Алдарт ялалт ирдэг юм*

*Сүнслэг тулаанд оролцож*

*Сөхрөн залбирахыг сургаач Эзээн*

Мосегийн дээрх түүхээс өөр нэгэн сургамжийг харж болно. Эзэн Амалектай үеийн үед дайтна гэж амласан. Амалек нь махан биеийн дүрслэл. Христэч хүн махбодын эсрэг зогсолтгүй дайтах ёстой. Түүний гол зэвсэг нь залбирал юм. Залбирлын амьдралд итгэмжтэй байснаар ялалт, ялагдлын аль нь ирэхийг шийднэ.

## 7 сарын 1

*“...би өөрөө бүрэн мэдэгдсэн шигээ дараа нь би бүрэн мэдэх болно.” (1Ко 13:12)*

Хайртай хүмүүсээ диваажинд таних болов уу гэж гайхах нь христитгэгч бидний хувьд хэвийн үзэгдэл. Энэ сэдвээр тусгайлан ярьсан зүйл Библид байхгүй ч, тодорхой дүгнэлт гаргаж болохуйц хэд хэдэн хэсэг бий.

Эхнийх нь гэвэл, Эзэн Есүс алдрын биеэр амилсны дараа шавь нар Түүнийг таньж байсан явдал. Түүний биеийн төрх байдал өөрчлөгдөөгүй байна. “Энэ Есүс байна” гэж тэд шууд таньсан. Тэгэхээр диваажинд бид алдрын биетэй болох боловч царай төрх хэвээр үлдэх ажээ. Хүн бүр ижил царайтай болно гэсэн сургаал Библид байхгүй. 1Иохан 3:2 дээр биднийг Эзэн Есүс шиг болно гэсэн нь зан чанарын хувьд Түүнтэй адил болохыг хэлж байгаа юм. Бид үүрд мөнхөд нүгэлгүй ариун болохын хувьд Есүстэй адил болно. Харин царай төрхийн хувьд Түүнтэй ижил болохгүй учраас биднийг Есүс гэж андуурахгүй.

Хоёрт гэвэл, диваажинд очихоор энэ дэлхий дээр байгаагаасаа дутуу мэднэ гэж үзэх ямар ч шалтгаан байхгүй. Энэ дэлхий дээр бид бие биеэ таньдаг бол, тэнгэрт очихоороо бие биеэ танина гэдэг этгээд сонин санагдах учиргүй. Тэр үед, биднийг танихын адил бид ч бусдыгаа танина.

Паул тесалоникчуудыг өөрийнх нь найдвар, баяр хөөр, өргөмжлөлийн титэм болно гэж хэлсэн нь хожим тэнгэрт тэднийг танина гэдгийг илэрхийлж байна (1Тс 2:19).

Өмнө нь харж байгаагүй хүмүүсээ таних чадвар хүмүүст өгөгдсөн, хожим бас өгөгдөнө гэдгийг илтгэх



жишээнүүд Библид бий. Тухайлбал Петр, Иаков, Иохан нар өндөр уулан дээр Есүстэй хамт буй Мосе, Елиа нарыг таньсан (Мт 17:4).

Баян эр үхэгсдийн оронд байхдаа Абрахамыг таньсан (Лк 16:24). Хүмүүс Бурханы хаанчлалд Абрахам, Исаак, Иаков болон бүх эш үзүүлэгчдийг харна гэж Есүс иудейчүүдэд хэлсэн (Лк 13:28). Өгөгдсөн эд хөрөнгөөрөө найзуудтай болж (хүмүүсийг аварч), мөнх нутагт хүлээн авах хүмүүсийг өөртөө бий болго гэж Есүс хэлсэн нь тэр хүмүүс өөрсдийнх нь төлөө үйлчилсэн хүнийг танина гэдгийг цаагуураа илэрхийлж байна (Лк 16:9).

Гэхдээ нэг үгийг нэмж хэлэх хэрэгтэй. Бид диваажинд хайртай хүмүүсээ таних боловч дэлхий дээр байсан харилцаа байхгүй болно. Жишээ нь эхнэр нөхрийн харилцаа тэнд байхгүй болно. Үүнийг Матай 22:30 дээр Аврагч Эзэн маань тодорхой хэлсэн: “Амилалд тэд гэрлэх ч үгүй, нөхөрт ч гарахгүй.”

## 7 сарын 2

*“Марта, Марта, чи мөн ч олон юманд санаа зовж үйлээ үзэх юм даа. Үнэндээ ганцхан л юм хэрэгтэй. Өөрөөс нь булаагдашгүй сайныг Мариа сонгон авчээ.”* (Лк 10:41,42)

Мариа Есүсийн хөлд чимээгүй сууж, Түүний үгийг сонсов. Марта үйлчлэлдээ түүртэн бухимдаж, Мариа өөрт нь туслахгүй байгаад гомдоллов. Эзэн Есүс Мартагийн үйлчлэлийг биш, харин хийж буй хандлагыг залруулсан. Мөн Мартагийн гол хараа буруу байна гэж ойлгуулахыг хүссэн. Үйлчлэл нь мөргөлөөс илүү байх ёсгүй.

Бидний олонх нь Мартатай адил. Бид суух биш, хийж бүтээх дуртай хүмүүс. Зохион байгуулалттай, үр дүнтэй, амжилттай байгаагаар бид бахархдаг. Хийх ажилдаа улайраад, түмэн янзын төлөвлөгөөндөө түүртээд өглөөний Библи уншлагаа мартдаг. Бодол санаа минь Данаас Беершеба хүртэл тэнүүчилж, өдрийнхөө ажлыг төлөвлөж яваад залбирлаа хойш тавьдаг. Бусад хүн ажилд минь туслахгүй бол амархан бухимддаг. Хүн бүр бидний хийж байгааг хийх ёстой гэж бид санадаг.

Мэдээж Мариатай адилхан хүмүүс бий. Тэд бол хайрлагчид. Тэдний амьдралаас бусдыг гэсэн хайр урсдаг. Тэд сав суулганаас илүү хүмүүсийг чухалчилдаг. Ялангуяа нэг Хүн тэдний хайрын гол эзэн юм. Тэд залхуу биш. Гэвч Марта шиг хүмүүст тэд залхуу харагддаг. Үнэндээ тэдний гол хараа ялгаатай байгаа юм.

Хүн бид ер нь хүйтэн хөндий, чадвартай, бүтээмж өндөртэй хүмүүсээс илүү халуун дулаан, хайр гэрэлтсэн хүмүүст дуртай. Тоглоомдоо улайраад биднийг тоох

сөхөөгүй хүүхдээс илүү тэврэлт, үнсэлт бэлэглэдэг хүүхэд бидний хайрыг татдаг.

Бурхан ч ялгаагүй үйлчлэлээс илүү мөргөлийг маань сонирхдог. Тэнгэрлэг сүйт залуу хөлсний ажилчдыг бус, сүйт бүсгүйг дуудаж байна.

*Эзэний хөлд суух завдалгүй*

*Тэвчээртэйгээр хүлээх дургүй*

*Ажилдаа түүртсэн завгүй үйлчлэлийг*

*Аврагч маань биднээс шаардаагүй юм шүү*

Мариа өөрөөс нь авагдахгүй сайныг сонгожээ. Бид ч бас түүнтэй адил байх болтугай!

## 7 сарын 3

*“Гаднынханд зочломтгой хандахаа бүү март. Учир нь зарим нь үүгээрээ тэнгэрэлчүүдийг мэдэлгүй зочилсон юм.”*  
(Евр 13:2)

Зочломтгой хандлага нь бидний ариун үүрэг (Гаднынханд зочломтгой хандахаа бүү март) төдийгүй дотроо гайхамшигт амлалтыг багтаадаг (Учир нь зарим нь үүгээрээ тэнгэрэлчүүдийг мэдэлгүй зочилсон юм).

Абрахамын жирийн нэгэн өдөр эхэлж байлаа. Майхныхаа үүдэнд сууж байтал өмнө нь гурван хүн гэнэт гараад ирэв. Абрахам тэдэнд Ойрх Дорнодынхны заншлаар хандаж, хөлийг нь угааж, модны сүүдэрт амраан, тугал нядлан, эхнэр Сарадаа талх барих заавар өгөөд, зочдыг сайхан хоол ундаар дайллаа.

Энэ хүмүүс хэн байв? Тэдний хоёр нь тэнгэрэлч, гурав дахь нь Эзэний тэнгэрэлч байв. Эзэний тэнгэрэлч гэдэг нь Хүн биеэр үзэгдсэн Эзэн Есүс гэдэгт би итгэдэг (Эхлэл 18:13-д уг тэнгэрэлчийг “Эзэн” хэмээн нэрлэсэн).

Абрахам тэнгэрэлч нарыг төдийгүй, Эзэнийг дайлжээ. Бидэнд ч гэсэн ийм хувь завшаан бий.

Эзэний бурханлаг хүмүүсийг зочилсноороо христэч айлууд ямар их ивээл ерөөлийг хүртэх боломжтой гэж санана. Тэр айлын хүүхдүүд Бурханы хүмүүсээс нөлөө авч, цааш цаашдын амьдралдаа тэднийг даган дуурайж амьдрах хүсэлтэй болдог. Эзэний хүмүүсийг зочилсноор Эзэний төлөөх сэтгэл дахин бадарч, шаналсан зүрх тайтгарлыг олж, асуудлууд шийдэгддэг. Гэрт минь ирснээрээ ивээл ерөөл болсон тэр “тэнгэрэлч нарт” бид талархаад баршгүй.

Түүнээс гадна Эзэн Есүсийг гэртээ зочлох сайхан завшаан бидэнд өгөгджээ. Бид Эзэний хүнийг Эзэний нэрээр хүлээн авбал Эзэнийг Өөрийг нь хүлээн авсанд тооцогддог (Мт 10:40). Бид үүнд үнэн голоосоо итгэдэг бол урьд өмнө хэзээ ч байгаагүйгээрээ бусдад зочломтгой хандана. Бид “Гомдол үгүйгээр бие биедээ зочломтгой байна.” (1Пт 4:9) Зочин бүрээ Есүс Христ хэмээн үзэж, тэдэнд тийн хандана. Тэгээд бидний гэр орон Есүсийн очих дуртай байсан Мариа, Марта нарын Бетан дахь гэр шиг болно.

## 7 сарын 4

*“Таны хүмүүс Танд баярлахын тулд Та Өөрөө биднийг сэргээхгүй гэж үү?” (Дуу 85:6)*

Хөрсөн сэтгэл гэдэг хорт хавдартай адил. Бид өөрсдөө ийм болсноо мэддэггүй. Сүнслэг байдал маань хүйтэн царцмаг болоход бид өөрсдийгөө махан биеийн дагуу явж байгаагаа олж харахаа больдог. Заримдаа зовлон шаналал, амьдралын хямрал, Бурханы эш үзүүлэгчийн дуу хоолой биднийг сэрээдэг. Ингэж бид, “Би ангамал газар дээр ус асгаж, хуурай газар горхи урсгана. Би үр удам дээр чинь Сүнсээ асгаж, хойч үед чинь ерөөлөө өгнө” (Иса 44:3) гэсэн Бурханы амлалтаас зуурдаг.

Бурханы үгэнд дурлахаа больж, залбирал маань амьгүй болж, анхны хайраа гээх үед бидэнд сэргэлт хэрэгтэй. Чуулганд очихоос илүү телевиз үзэх нь сонирхолтой санагдаж, ажилдаа цагаа барих атлаа цуглаандаа хоцордог болж, ажлаа тасалдаггүй мөртлөө цуглаандаа алдаг оног очдог болоод ирвэл бидэнд Бурханы шинэ хүрэлт хэрэгтэй болжээ гэсэн үг. Аврагчийн төлөө ажиллахгүй мөртлөө, мөнгөний төлөө цаг заваа зориулж, мөнгөө Эзэний ажилд зарцуулахаас илүү биеийн тааламжид үрж эхэлбэл бидэнд сэргэлт хэрэгтэй.

Бусдад гомдоллож, бусдыг буруутгаж, гашуун сэтгэл тээж эхэлбэл бидэнд сэргэлт хэрэгтэй. Хов жив хөөцөлдөж, бусдыг муулж эхэлбэл бидэнд сэргэлт хэрэгтэй. Буруу юм хийчхээд гэмшихгүй, биднийг гомдоосон хүмүүсийг уучлахгүй байх үед сэргэлт хэрэгтэй. Орон гэртээ араатан мэт авирлачхаад чуулганд ирэхээрээ гэгээнтэн болдог бол бидэнд сэтгэлт хэрэгтэй. Ярих яриа, явдал үйл, амьдралын

хэв маяг минь бүхэлдээ энэ ертөнцтэй энх тайвнаар оршиж байвал бидэнд сэргэлт хэрэгтэй. Содомын нүглүүд болох бардамнал, элбэг дэлбэг хоол, налгар тайван байдал амьдралд минь байвал бидэнд сэргэлт хэрэгтэй. (Езк 16:49)

Хэрэв таны анхны хайр хөрж, хоосон хөндий сэтгэлтэй болж байгаагаа олж харах л юм бол тэр даруй 2Шастир 7:14-т хэлсэнчлэн, “Нэрээр минь дуудагдсан Миний хүмүүс өөрсдийгөө даруу байлган залбирч, нүүрийг минь эрэлхийлж, хорон муу замуудаасаа эргэх аваас, Би тэнгэрээс сонсож, тэдний нүглийг уучлан, тэдний газар нутгийг эдгээнэ” гэсэн Бурханы амлалтын дагуу үйлдээрэй.

Нүглээ улайх нь сэргэлтэд хүрэх зам юм.

*Ариун Сүнс ээ, сэргэлт Танаас ирдэг*

*Ажлаа эхлээч, сэргэлтээ илгээгээч миний дотор*

*Хэрэгцээг минь хангана гэж Таны үг тунхагладаг*

*Харин Эзээн, эдүгээ би Таны ивээлийг гуйж байна*

(Ж.Эдвин Опп)

## 7 сарын 5

*“Сүнсийг бүү бөхөө. Эш үзүүлэгийг бүү басамжил.”* (1 Тс 5:19,20)

Бөхөөх гэдгийг ихэвчлэн галтай холбож ойлгодог. Гал руу ус цацах үед гал бүрэн унтрах юм уу тодорхой хэмжээнд бөхөж, цар хүрээ, илч дулаан нь буурдаг.

Галыг Библид Ариун Сүнсний бэлгэдэл гэдэг. Ариун Сүнс шатам халуун, эрч хүчтэй. Хүмүүс Ариун Сүнсээр удирдуулах үедээ халуун дулаан сэтгэлтэй, эрч хүчтэй, урам зоригтой болдог. Сүнсийг бөхөөнө гэдэг нь Бурханы хүмүүсийн цуглаанд Ариун Сүнсний илрэлийг дарахыг хэлнэ.

Паул "Сүнсийг бүү бөхөө. Эш үзүүлэгийг бүү басамжил" гэж хэлсэн. Сүнсийг бөхөөхүйг эш үзүүлэгийг басамжлахтай холбосноос үзэхэд бөхөөх үйлдэл нь нутгийн чуулганы цуглаантай холбоотой гэсэн дүгнэлтэд хүргэж байна.

Залбирал, мөргөл, үгийн үйлчлэлийн үеэр Христийг гэрчилж буй хүнийг ичээх нь Сүнсийг бөхөөж байдаг. Бусдад санаа оноогоо хэлэх нэг хэрэг. Харин утга учиргүй шүүмжилж, өө хайх нь тухайн хүний урмыг хугалж, Бурханы төлөө үйлчлэхэд нь бүдрүүлэл болдог.

Хоёрдугаарт, Бурханы үйлчлэлийг хэт зохион байгуулалтад оруулж, Ариун Сүнсийг чөлөөтэй ажиллах боломжгүй болгосноор Сүнсийг бөхөөдөг. Зохион байгуулалтыг залбиралтайгаар, Ариун Сүнсийг түшиглэж хийвэл хэн ч эсэргүүцэж чадахгүй. Харин хүний ухаанд суурилсан зохион байгуулалт нь Ариун Сүнсийг Удирдагч биш, Үзэгчийн байр сууринд аваачдаг.



Бурхан чуулганд олон бэлгүүдийг өгсөн. Тэрээр аль хэрэгтэй бэлгийг нь хэрэгтэй газар нь, хэрэгтэй цагт нь ашигладаг. Жишээ нь нэгэн итгэгч чуулганыг ятгах бэлэг авьяастай байж ээ. Гэтэл тухайн чуулганы үйлчлэл ганц хүн дээр төвлөрсөн байвал Ариун Сүнс уг чуулганд хэрэгтэй үгийг зохих цагт нь өгөхөөр чөлөөтэй ажиллаж чадахгүй. Энэ нь Сүнсийг бөхөөх нэг хэлбэр юм.

Эцэст нь хэлэхэд, Ариун Сүнсний өдөөлтийг эс дагаснаараа бид Сүнсийг бөхөөдөг. Жишээлбэл тодорхой нэг сэдвээр номлохыг Ариун Сүнс ятгахад бид хүнээс айсандаа түүнийг нь ярихаас зүрхшээдэг. Эсвэл нийтийн залбирлыг удирдахыг Ариун Сүнс ятгахад ичиж зовсноосоо болоод чимээгүй суудаг. Тухайн цуглаан дээр энэ дуу тохирно гэж Ариун Сүнсийг хэлэхэд зориг дутсанаасаа болоод түүнийг нь гаргаж тавьдаггүй.

Энэ мэтээр бид Сүнсний галыг бөхөөдөг бөгөөд эцэст нь цуглаан маань эрч хүч, урам зориггүй болж, нутгийн чуулган маань доройтдог.

## 7 сарын 6

*“Бурханы Ариун Сүнсийг бүү гомдоо. Золилтын өдрийн төлөө та нар Түүгээр тамгалуулсан юм шүү..” (Еф 4:30)*

Чуулган дотор Сүнсийг бөхөөх боломжтойн адил хувийн амьдралдаа бид Түүнийг гомдоож болзошгүй.

Гомдоох гэдэг үг цаагуураа дотно хандлагыг агуулна. Бид зөвхөн өөрсдийг минь хайрладаг хүмүүсийг гомдоодог. Бид танихгүй хүмүүст гомддоггүй. Харин сахилгагүй хүүхдүүддээ гомддог.

Тэгэхээр бид Ариун Сүнсний дотно бөгөөд хайртай хүмүүс нь гэсэн үг юм. Тэр бидэнд хайртай. Тэр биднийг золилтын өдрийг хүртэл тамгалсан. Тэгэхээр бид Түүнийг гомдоож болзошгүй.

Тэгвэл Ариун Сүнс юунд гомддог вэ? Нүглийн аливаа хэлбэр Түүний зүрхэнд гуниг харууслыг төрүүлдэг. Паул Түүнийг Ариун Сүнс гэж нэрлэсэн нь тохиолдлын хэрэг биш ээ. Ариун бус бүхэн Түүнийг гомдоодог.

“Бүү гомдоо” гэсэн ятгалаг нь хэд хэдэн нүглийг сэрэмжлүүлж байх дунд хэлэгдсэн. Бидний цээрлэж явах бүх нүглийг энд жагсаагаагүй. Харин нүглээс ангид байхыг сануулсан хэрэг юм.

Худал ярих нь (гэм хоргүй худал, хууран мэхлэл, дэгсдүүлэл, ялих шалихгүй худал үг, хагас үнэн, мушгин гуйвуулалт) Ариун Сүнсийг гомдоодог (25-р эшлэл). Бурхан худал ярьдаггүй учраас Өөрийн хүмүүсийг ч гэсэн худал ярихыг зөвшөөрөхгүй.

Нүгэлд хүргэдэг уур хилэн Ариун Сүнсийг гомдоодог (26-р эшлэл). Бурханы үйл хэргийн төлөөх уур хилэнг л

зөвхөн зөвтгөх боломжтой. Бусад уур хилэн үргэлж  
диаволд боломж олгодог (27-р эшлэл).

Хулгай хийх нь Ариун Сүнснийг гомдоодог (28-р  
эшлэл). Ээжийнхээ түрийвчнээс хумслах, даргынхаа  
цагаас хулгайлах, ажлын газрынхаа эд зүйлийг авах, аль нь  
ч бай хулгай юм.

Ялзарсан яриа Ариун Сүнснийг гомдоодог (29-р эшлэл).  
Ялзарсан яриа гэдэг нь утгагүй тоглоом шоглоом, хий  
хоосон маазрал, завхай зайдан яриа зэрэг нь юм. Бидний  
яриа үргэлж нигүүлсэнгүй, үнэн зөв, бусдыг босгон  
байгуулдаг байх ёстой.

Ариун Сүнснийг гомдоодог бусад нүглүүд гэвэл, 4-р  
бүлэгт хэлсэнчлэн, хорсол, уур, хилэн, хашхираан,  
гүтгэлэг, бүх муу муухай нь билээ.

Ариун Сүнсний нэг гол үйлчлэл нь бидний харааг Эзэн  
Есүс Христээр дүүргэх. Харин нүгэл үйлдэх үед минь  
биднийг Эзэн Есүстэй зөв нөхөрлөлтэй болгож сэргээхийн  
тулд Ариун Сүнс энэ үйлчлэлээ түр зогсоодог.

Ариун Сүнс гомдлоо ч гэсэн хэзээ ч биднийг орхиж  
явдаггүй. Учир нь Тэр золилтын өдрийг хүртэл биднийг  
тамгалжээ. Гэхдээ ингэлээ гээд хайнга байж болно гэсэн үг  
биш юм шүү! Харин ч энэ нь улам илүү ариун шударга  
амьдрах сэдэл болох учиртай.

## 7 сарын 7

*“Энэ цагийн зовлонгууд бидэнд илчлэгдэх тэрхүү алдрын дэргэд юу ч биш гэж би боддог.” (Ром 8:18)*

Бидэнд илчлэгдэх ирээдүйн алдрыг орхиод зөвхөн энэ цагийн зовлонгууд дээр төвлөрөх юм бол үнэхээр аймшигтай санагдана. Христийн төлөө амь үрэгдэгсдийн туулсан харгислал, Бурханы зарим хүний бөөнөөр хорих лагерьд тэссэн зовлонгуудыг бодохоор өөрийн эрхгүй зориг мохдог. Дайн байлдааны аймшигт зовлон шаналал, ослоос үүдэн тахир дутуу болсон хүмүүс, элдэв өвчин, хорт хавдраас болж зэрэмдэглэгдсэн бие эрхтэн – Энэ бүхэн үгээр хэлэхийн аргагүй хүнд.

Биесийн өвдөлт шаналлаар хүний зовлон дуусдаггүй. Сэтгэлийн зовлон түүнээс ч хүнд байх нь бий. “Хүмүүний сүнс өвчнөө тэсвэрлэх авч хэн цөхөрсөн сүнсийг тэнхрүүлэх вэ?” (Сур 18:14) гэж Соломон үүнийг л ярьсан биш үү? Эхнэр, нөхөр нь хуурах, хайртай хүн нь нас барах, хүсэл мөрөөдөл нь нурах, бусдад хаягдах, дотнын нөхөр нь урвах гээд сэтгэлийг өвтгөх олон асуудал бий. Сэтгэлийн зовлон шаналал, уй гашууг даах хүний чадвар хэр их юм бол доо гэж гайхширах үе ч бидэнд төрдөг.

Энэ бүх зовлонг дангаар нь бодохоор дааж давшгүй мэт санагдана. Харин ирэх алдрыг зэрэгцүүлэн бодвол эдгээр зовлон юу ч биш санагдана. “Энэ цагийн зовлонгууд бидэнд илчлэгдэх тэрхүү алдрын дэргэд юу ч биш” гэж Паул хэлсэн. Хүний туулдаг зовлон ийм том юм бол ирээдүйн тэр алдар бүр ч том байх биш үү?

Өөр нэгэн газар элч Паул баяр бахдалтайгаар: "Учир нь агшин төдий ялихгүй зовлон нь бидэнд алдрын мөнхийн жинг үлэмж арвижуулж байна" (2Кор 4:17) гэж мэдэгдсэн. Жин дээр тавьж харьцуулан үзвэл одоогийн зовлон нь өд мэт хөнгөн, ирээдүйн жавхланта алдар нь хязгааргүй хүнд жин дарна. Цаг хугацаагаар бодож үзвэл одоогийн зовлон нь агшин зуурынх, ирээдүйн алдар нь мөнхийнх.

Аялал минь төгсөж, Аврагч Эзэнтэйгээ нүүр тулан уулзах үед одоогийн энэ зовлон ялихгүй зүйл болж замхран мартагдана.

*Ертөнцөд эдэлсэн амьдралын зовлон  
Христтэй учрах үед ялихгүй санагдана  
Есүстэй уулзах үед оргүй мартагдана  
Туулсан зовлон шаналлуудыг минь  
Түүний царай нэг мөсөн арилгана  
Тиймээс Христтэй уулзах хүртлээ  
Түүнийг чиглэн зоригтой гүйцгээе*

(Эстер К. Рустой)

## 7 сарын 8

*"...Уурлаж хилэгнээд эхийн минь хөвгүүд усан үзмийн талбайн арчлагч болгочихсон юм, намайг. Амь хувийн талбайгаа арчлалгүй ийм болчихсон юм, би."* (Сд 1:6)

Ах нар нь өөрсдийн усан үзмийн талбайг арчлуулахаар шулаам эмэгтэйг явуулжээ. Тиймээс тэр өөрийнхөө усан үзмийн талбайг төдийгүй, өөрийн гадаад үзэмжийг ч анхаарч чадаагүй байна. Арьс нь хуурайшин борлож, үс зүс нь өнгө алджээ.

Бусдын талбайд анхаарал хандуулаад өөрийнхийг орхигдуулах явдал бий. Жишээлбэл, ертөнцийг аврах их үйлсэд амьдралаа зориулаад гэр бүлээ умартдаг явдал олон. Бурхан бидэнд хүүхдүүдийг өгсөн юм бол тэр хүүхдүүд бидний эн тэргүүний илгээлтийн талбар мөн. Эзэний өмнө зогсох үедээ "Намайг болон Надад Бурханы өгсөн хүүхдүүдийг харагтун" (Евр 2:13) гэж хэлэхээс илүү баяр жаргал хаана ч үгүй. Өчнөөн хүнийг аварч, тэдний магтаал талархлыг сонслоо ч өөрийн хөвгүүд охидоо алдсан уй гунигийг минь хэзээ ч нөхөж чадахгүй.

Библийг харвал бидний үйлчлэл гэр орноос минь эхэлдэг. Есүс түмэн чөтгөрийг зайлуулсны дараа цэвэр болсон хүнд "Гэртээ, өөрийнхөндөө оч. Эзэн чамд хэчнээн ихийг үйлдэж, чамд хэрхэн өршөөлөө үзүүлснийг тэдэнд мэдэгд" (Мк 5:19) гэж тушаасан. Ихэнх тохиолдолд өөрийнхнийгөө Христэд итгүүлэх хамгийн хэцүү байдаг ч гэсэн бид тэндээс л эхлэх ёстой.

Эзэн Есүс шавь нартаа үүрэг чиглэл өгөхдөө "Та нар...Иерусалим, бүх Иудей, Самари тэр байтугай дэлхийн хязгаар хүртэл Миний гэрч болно"(Үйл 1:8) гэж хэлсэн.

Тэдний үйлчлэл төрөлх хотоос нь буюу Иерусалимаас эхлэх ёстой байлаа.

Андрей өөрийн усан үзмийн талбайг орхигдуулахгүй байхыг хүсжээ. Тийм учраас түүний тухай "Андрей эхлээд өөрийн ах Симоныг олоод, түүнд 'Бид Мессиаг (грекээр Христ) оллоо' гэв" (Иох 1:41) гэж бичигджээ.

Итгэгч хүн хайртай дотнын хүмүүсээ Эзэн Есүст итгүүлэхийн тулд хэчнээн итгэмжтэй байсан ч нөгөө хүмүүс нь үл итгэлээсээ тас зуурсаар байх тохиолдол мэдээж гардаг. Гэр бүлийнхэн, хамаатан садан, найз нөхөд маань мөнхийн авралыг олно гэсэн баталгаа бидэнд байхгүй. Гэхдээ тэглээ гээд дотнын хүмүүсээ орхигдуулаад бусдад үйлчлэхийг нэн тэргүүнд тавих ёстой гэсэн үг биш ээ. Бид өөрсдийн усан үзмийн талбайг юун түүрүүнд арчлах ёстой.

## 7 сарын 9

*“Эзэний нэрийг дууддаг бүхэн аврагдах болно.”* (Ром 10:13)

Эзэний нэрийг дуудаад аврагдахгүй үлдэх хүн байхгүй. Чин зүрхнээсээ Эзэн рүү хашхирсан хашхираан заавал хариугаа авна. Бүх найдвар минь барагдаж, явах замгүй болж, өөрийн гэсэн бүхэн маань дуусаад зовлон шаналал дотроосоо Эзэнийг дуудахад Тэр гарцаагүй сонсон хариу өгнө.

Сикх шашинтай залуу Садху Сундар Сингх амар амгаланг олж чадахгүй бол амиа хорлохоор хатуу шийджээ. Тэрээр: "Бурхан гэж байдаг бол өнөө шөнө надад Өөрийгөө илчлээч" хэмээн залбирчээ. Долоон цагийн дотор ямар нэг хариу ирэхгүй бол төмөр зам дээр толгойгоо тавиад Лахор явж буй галт тэргэнд дайруулж үхье хэмээн тэр шийдсэн байлаа. Тэгтэл үүрээр өрөөнд нь Есүс үзэгдэж, энэтхэг хэлээр "Чи үнэн замыг мэдэхийг хүсэж залбирсан. Би бол тэр зам. Одоо үүнийг дага" гэж хэлжээ.

Садху Сундар Сингх аавынхаа өрөө рүү яаран гүйж ороод "Би христитгэгч боллоо. Одоо би Есүсээс өөр хэнд ч үйлчилж чадахгүй. Үхэх хүртэл миний амьдрал Түүнийх боллоо" гэж хэлжээ.

Үнэн сэтгэлээсээ Эзэний нэрийг дуудаад хариугаа аваагүй хүнийг би дуулаагүй. Мэдээж зовж шаналж байхдаа Эзэнийг дуудаж, эндээс аврах л юм бол Таны төлөө амьдаръя гэж амладаг ч зовлон арилахаар амлалтаа мартдаг хүмүүс байдаг. Бурхан тэдний сэтгэлийг мэднэ. Тэд бол үнэн зүрхээ Түүнд өгөгчид биш. Зөвхөн боломж хайгчид юм.



Бурханыг бэдрэн хайсан бүхэнд Бурхан Өөрийгөө илчилдэг нь хөдөлшгүй үнэн. Библи олодохгүй газруудад Тэр үзэгдлээр өөрийгөө илчлэх нь бий. Бусад газар Библийн хэлтэрхийнүүдээр, хүмүүсийн гэрчлэлээр, христэч ном зохиолоор, эсвэл нөхцөл байдлаар дамжуулан Тэр Өөрийгөө илчилсэн олон тохиолдол бий. Ямар ч байсан Бурханыг хайсан бүхэн олно. Энэ бол гарцаагүй үнэн.

## 7 сарын 10

*"Үүнийг мэдэж, үйлдвээс та нар ерөөлтэй." (Иох 13:17)*

Христигэлийг зааж номлодог хүн, номлодог зүйлээ хэрэгжүүлдэг байх ёстой. Тэд энэ ертөнцөд үнэний амьд жишээ болох учиртай. Бурхан Өөрийнхөө үгийг хүмүүсийнхээ амьдралд махан бодоор амилаасай гэж хүсдэг.

Энэ ертөнц үг ярианаас илүү бодит үйлдэлд анхаардаг. Эдгар Гест: "Би номлолыг сонсохоос харахыг илүүд үздэг. 'Чи яагаад чанга орилоод байгаа юм бэ? Би хэлж байгааг чинь сонсож чадахгүй байна' гэдэг егөөдөл байдаг шүү дээ" гэж бичсэн.

Хүмүүс индэр дээр байхад буулгахыг хүсдэггүй, индрээс буухад нь дахиж гаргахыг хүсдэггүй нэгэн номлогч байсан тухай яриа байдаг.

"Амьдралаас илүү амыг минь хязгаарладаг зүйл гэж үгүй." (Х. А. Айронсайд) "Хүн өөрөө номлол юм." (Хэнри Драммонд) "Факт баримтыг чухалчилдаг энэ үеийнхэнд Бурханыг батлах хамгийн том баталгаа бол ариун амьдрал...Үгийн ард хүн байхад тэр үг жин дардаг." (Карлайл) "Үгийг хүчтэй болгоё гэвэл өөрсдийнхөө дотор махбодоор амилуулах ёстой." (Э. Стэнли Жонс) "Бид зөв зүйлийг номлоод түүнийгээ хэрэгжүүлдэггүй бол Бурханы тухай худал хэлсэнтэй адил." (Освалд Чэмберс)

Зааж сургаснаа төгс хэрэгжүүлдэг цорын ганц хүн бол Есүс Христ байсныг бид мэднэ. Түүний үг, үйлдэл хоёр хэзээ ч зөрж байгаагүй. Иудейчүүд Есүсээс "Та хэн юм бэ?" гэж асуухад "Есүс "Эхнээсээ та нарт өгүүлж байгаа Тэр байна" (Иох 8:25) гэж хариулсан. Есүсийн үйлдэл

үгтэйгээ яв цав таарч байлаа. Биднийх ч мөн адил байх ёстой.

Ах дүү хоёр доктор байв. Нэг нь докторын зэрэгтэй номлогч. Нөгөө нь хүний их эмч доктор. Нэг өдөр зовлонд унасан эмэгтэй номлогчтой уулзахаар гэрт нь иржээ. Гэхдээ аль доктор нь тэнд амьдардгийг сайн мэдэхгүй байлаа. Номлогч хаалгаа нээж өгөхөд эмэгтэй түүнээс "Та ярьдаг доктор нь уу эсвэл хийдэг доктор нь уу?" гэж асуужээ. Энэ асуулт номлогчид нэгийг бодуулж, зааж номлодгоо хэрэгжүүлэх ёстойг ухааруулжээ.

## 7 сарын 11

*"Би хэдийнээ олж авсандаа эсвэл хэдийнээ төгс болчихсондоо бус..."* (Флп 3:12)

Өчигдрийн судлалаар бид үйлдэл маань үгтэйгээ таарч байх ёстойг ярьсан. Гэхдээ энэ сэдвийг тэнцвэртэй байлгах үүднээс нөгөө талыг нь өнөөдөр ярья.

Юуны түрүүнд хэлэхэд, бид энэ дэлхий дээр амьдарч байхдаа Бурханы үнэнийг бүрэн гүйцэд төгс хэрэгжүүлж чадахгүй гэдгээ хүлээн зөвшөөрөх ёстой. Бид хамгийн сайнаараа хичээсэн ч зохисгүй боол гэж хэлэхээс өөр аргагүй. Гэхдээ ингэлээ гээд буруу амьдралаа үүгээр хаацалж болохгүй. Бидний үүрэг болбоос үйлдлээ үг яриатайгаа чадах чинээгээрээ адил байлгах.

Хоёрт гэвэл бидний дамжуулдаг мэдээ нь биднээс үргэлж агуу юм. Бид хэн байх нь хамаагүй, бидний мэдээ илүү чухал. "Эзэний зарц бидэнд хэзээ нэгэн цагт өөрсдийнхөө биелүүлж чадахгүй үгийг номлох хэрэгтэй үе заавал ирдэг" гэж Эндрью Мюрри хэлсэн байдаг. Эндрью Мюрри "Христийн дотор оршин суу" номоо бичснээс хойш 35 жилийн дараа ингэж бичжээ: "Номлогч хүн, христитгэгч зохиолч заримдаа өөрийн туулж үзсэнээс илүүг хэлэх шаардлагатай байдгийг та ойлгоорой. Тухайн үед ("Христийн дотор оршин суу" номоо бичиж байхдаа) би бичсэн бүхнээ өөрийн биеэр үзэж туулсан байгаагүй. Одоо ч бүгдийг нь үзэж туулсан гэж хэлж чадахгүй."

Бурханы үнэн, хүн бидний хүрч чадашгүй дэндүү өндөрт байдаг. Энэ нь Гая Кингийн бичсэнчлэн "Би түүнд хүрчихлээ хэмээн хэн ч хэлж чадахгүй" тийм өндөр дээд билээ. Бид үнэндээ түүнийх нь хамгийн нам хязгаарт нь ч

хүрээгүй учраас Бурханы үнэнийг мөнхөд ярьсаар л байх болно. Өөрсдөө хүрээгүй учраас зохисгүй мэт санагдаж байсан ч бид тунхаглах л болно. Биеэрээ үзэж туулаагүй байсан ч Бурханы үнэнийг зүрхнийхээ хүсэл мөрөөдөл болгоно.

Дахин хэлье. Энд яригдаж байгаа зүйлийг далимдуулж Аврагч Эзэнд зохисгүй зан хандлагаа өмгөөлөх эрх бидэнд байхгүй. Би яагаад үүнийг ярьж байна вэ гэвэл, Бурханы жинхэнэ хүн өөрөөсөө хэтийдсэн агуу юмсыг ярихад түүнийг бүү яллаж буруутгаасай гэсэндээ юм. Түүнээс гадна, өөрсдөө хүрээгүй гээд Бурханы зорилго төлөвлөгөөг тунхаглахаас бүү зүрхшээгээрэй гэдгийг хэлэх гэсэн юм. Бурхан зүрх сэтгэлийг минь мэднэ. Хоёр нүүр гаргаж байна уу эсвэл үнэн сэтгэлээсээ хичээж байна уу гэдгийг Тэр ялгаж салгадаг.

## 7 сарын 12

*"Энэ тулаан та нарынх биш, харин Бурханых юм."* (2Шс 20:15)

Загалмайн цэрэг эрт орой хэзээ нэгэн цагт заавал дайралтад өртөнө. Бурханы үнэнийг зоригтойгоор тунхаглаж, өөрийн амьдралаараа гэрчлэн харуулах тусам дайралтын бай болно. "Жанжинтайгаа ойр байгаа дайчин харваачдын бай болдог жамтай" гэж нэгэн настай пуритан хэлсэн.

Тэрээр буруу юм хийгээгүй байж буруутгагдана. Хов жив гүтгэлэг доромжлолын бай болно. Хүмүүс түүнийг хавчин гадуурхаж, элэглэн дооглоно. Ийм хандлага энэ ертөнцөөс ирнэ. Гэхдээ харамсалтай нь заримдаа бусад итгэгчээс нь ч ирнэ.

Амьдралд ийм үе ирэхэд, тулаан биднийх биш, Бурханых гэдгийг санаж байх хэрэгтэй. "ЭЗЭН та нарын төлөө байлдана. Та нар зөвхөн чимээгүй бай!" (Гэт 14:14) гэсэн амлалтаас зуурах ёстой.

Ф. Б. Мэйер: "Үгээрээ бид ямар их юм алддаг гэж санана! Зүгээр л чимээгүй бай! Дуугаа хураа! Нэг хацрыг чинь алгавал нөгөө хацраа тавьж өг. Хариуг нь өгөх гэж бүү оролд. Нэр төрөө март. Энэ бүхэн Бурханы гарт байгаа. Нэр төрөө хамгаалах гэж оролдвол түүнийгээ улам алдах болно" гэж бичсэн.

Гүтгүүлсэн ч өөрийгөө хамгаалах гэж оролдоогүй хүний тод жишээ бол Иосеф. Тэр өөрийн учир шалтгааныг Бурханд даатгасан. Бурхан Иосефын нэрийг цэвэрлэж, агуу их хүндлэлийг өгсөн.

Нас дээр гарсан Христийн нэгэн зарц олон жилийн турш хүмүүст буруутгуулж байснаа ярьсан. Тэрээр Августины үгээр "Эзэн минь, өөрийгөө өмөөрөх гэсэн шуналт хүслээс намайг авраач" хэмээн залбирдаг байжээ. Эзэн цаг нь болоход түүний зөвийг батлан харуулж, буруутгагчдынх нь бурууг заавал илчилж байсан гэж тэр ярьсан юм.

Мэдээж Эзэн Есүс бол бидний хамгийн дээд үлгэр жишээ. "Тэр зүхэгдэж байхдаа, хариуд нь зүхээгүй. Тэр зовон тарчилж байхдаа заналхийлээгүй, харин шударгаар шүүдэг Нэгэнд Өөрийгөө даатгасаар байлаа." (1Пт 2:23)

Тэгэхээр энэ бол өнөөдрийн үг. Буруугүй үедээ буруутгагдаж, гүтгүүлж байхдаа өөрсдийгөө өмөөрч хамгаалах хэрэггүй. Тулаан бол Эзэнийх юм. Тэр бидний төлөө тулалдана. Харин бид тайван байх хэрэгтэй.

## 7 сарын 13

*“Хайртууд минь, сүнс болгонд бүү итгэ. Харин сүнснүүдийг Бурханаас эсэхийг шалга. Учир нь олон хуурамч эш үзүүлэгч дэлхийд гарч ирсэн. (1Ио 4:1)*

Эдүгээ бид гаж сургаалтнууд асар хурдацтай олширч байгаа цаг үед амьдарч байна. Үнэндээ цоо шинэ гаж урсгал гэж байдаггүй. Тэд бүгдээрээ Шинэ гэрээний үед гарч ирсэн гаж сургаалтнуудын зүсээ хувиргасан хойч үе нь юм. Тэдний гадаад хэлбэр өөрчлөгдсөн боловч үндсэн сургаал яг хэвээрээ.

Сүнснүүдийг шалга гэдэг нь бүх багш нарыг Бурханы үгээр шалгаж, худал хуурмагуудыг нь илрүүл гэсэн үг юм. Гаж урсгалынхныг гурван зүйлээр илрүүлж болно. Тэдний нэг нь ч энэ шалгуурыг давдаггүй.

Ихэнх гаж урсгал Библийн талаар туйлын буруу сургаалтай. Тэд Библийг Бурханы алдаа мадаггүй үг, хүн төрөлхтөнд өгсөн Бурханы эцсийн илчлэл гэж хүлээн зөвшөөрдөггүй. Харин удирдагчдынхаа ном зохиолыг Библитэй эн тэнцүү эрх мэдэлтэйд тооцдог. Тэд Эзэнээс шинэ илчлэл авсан хэмээн тунхаглаж, шинэ үнэнээрээ сайрхдаг. Мөн Библийг өөрсдийнхөөрөө орчуулж, үнэнийг мушгин гуйвуулдаг. Библийг ашиглахдаа зүсэн бүрийн арга заль хэрэглэдэг. Дээрээс нь хүний ёс уламжлалыг Библитэй энэ тэнцүү хэмжээнд тавьдаг.

Хоёрт нь, ихэнх гаж урсгал Эзэн Есүсийн талаар буруу сургаал номлодог. Тэд Есүсийг Бурхан гэдгийг үгүйсгэж, ариун Гурвалын нэг болохыг нь няцаадаг. Есүсийг Бурханы Хүү хэмээн мэдэгдэх боловч үнэн утга нь Бурхан Эцэгээс доор гэсэн санаагаар ярьж байдаг. Түүнээс гадна



тэд Есүсийг Христ биш гэж заадаг. Харин Есүс гэдэг нэг хүн дээр тэнгэрийн нөлөө ирснээр Тэр Христ болсон гэх утгатай юм ярина. Мөн тэд Аврагч Эзэнийг ямар ч нүгэлгүй жинхэнэ хүн байсныг үггүйсгэнэ.

Гуравт гэвэл, гаж урсгалууд авралын талаар буруу номлолтой. Зөвхөн Эзэн Есүст итгэх итгэлээр дамжуулан нигүүлслээр аврагдана гэдгийг тэд үгүйсгэдэг. Гаж урсгал бүр өөрийн гэсэн тунхаглах мэдээтэй бөгөөд аврагдах зам нь сайн үйлс, буян, гавьяа зүтгэл, сайн зан чанарыг онцолдог.

Ийм гаж урсгалын хөгжөөн дэмжигчдэд бид яаж хандах ёстой вэ? Иохан яах ёстойг минь тодорхой хэлсэн: "Хэн нэгэн нь та нар дээр ирэхдээ энэ сургаалыг авчрахгүй бол, түүнийг гэртээ бүү оруул, бүү мэндэл. Түүнтэй мэндэлж буй нь ёрын үйлсэд нь оролцож буй хэрэг юм." (1Ио 1:10,11)

## 7 сарын 14

*“Бид нууцлагдсан, ичгүүрт зүйлсээс татгалзан, заль мэх хэрэглэлгүй, Бурханы үгийг будлиулалгүй, харин үнэний илрэлээр Бурханы өмнө өөрсдийгөө хүн бүрийн мөс чанарт нотолдог.” (2Ко 4:2)*

Ариун хүмүүст бүрэн бүтнээрээ уламжлагдан ирсэн христитгэлийг мушгин гуйвуулагч гаж урсгалуудыг илчилдэг гурван талбарыг өмнөх хуудаст бид үзсэн. Тэгвэл өнөөдөр өөрсдөө сэрэмжлэн анхаараад зогсохгүй нутгийн чуулганаа болгоомжлуулах ёстой тэдний өөр шинж чанаруудыг ярья.

Гаж урсгалын удирдагчид бусдыг татах онцгой чадвар дээрээ дөрөөлдөг. Тэд өөрсдийгөө Бурханы аврагч, онцгой хүн гэх мэтээр илэрхийлдэг. Тэд бусдыг татах уран чадвартай боловч хатуу ширүүн дарангуйллыг бий болгож, хүмүүсээс дуулгавартай байдлыг шаардаж, дуулгаваргүй нэгнийг нь шийтгэлээр айлгадаг.

Тэд өөрсдийгөө л зөвхөн үнэний тунхаглагч хэмээж, бусдаас ялгарах ялгарал үүсгэж, өөрсөдтэй нь санаа нийлэхгүй хүмүүсийг бүгдийг шүүмжилдэг. Зарим нэг нь өөрсдийгөө шилдэг сургаалуудыг эмхэтгэж, хамгийн эцсийн илчлэлийг гаргаж ирсэн хэмээн мэдэгддэг. Өөрсдийнх нь нууц ухааныг ойлгоогүй цагт хэн ч төгс аз жаргалд хүрэхгүй гэж тэд хэлдэг.

Түүнээс гадна тэд гишүүдээ бусад бүх багш нараас тусгаарлаж, итгэгч гэсэн хүмүүсээс холдуулж, удирдагчдынх нь бичсэнээс өөр номуудаас хөндийрүүлдэг. Тэд ихэвчлэн хууль жаягийг чухалчилж, хүмүүсийг боолчлолд барьдаг. Ариун байдлыг ямар нэг ёслол, сахил

санваар зэрэгтэй адилтгаж, тэнгэрлэг амиар биш хүний хүүчээр ариун байдалд хүрнэ хэмээн ухуулдаг.

Тэд сэтгэлзүйн ухаалаг заль мэх хэрэглэн хүмүүсийг ашиглаж, санхүүгийнхээ хэрэгцээг хангадаг. Удирдагчид нь баян чинээлэг, тансаг амьдарч байхад бусад гишүүд нь ядуу зүдүү амьдардаг.

Ихэнх гаж урсгал шинэ хүмүүст хүрэхийн оронд бусад чуулганаас хүмүүсийг хулгайлдаг.

Тэд нэг юм уу хэд хэдэн сургаалыг хэтэрхий онцолж, Бурханы сургаалын амин чухал хэсгүүдийг орхигдуулдаг.

Тэд үнэнийг номлодог хүмүүсийг дайсан мэт үздэг. "Тиймээс та нарт үнэнийг хэлснээрээ би дайсан чинь болсон хэрэг үү?" (Гал 4:16) гэж Паулын хэлсэн нь ийм учиртай.

Дээр дурдсан хандлагууд эрүүл сургаалтай Христийн чуулганд нэвтрэн орвол маш харамсмаар хэрэг юм. Бид Христийн биеийн нэг хэсэг учраас ийм аюулаас хичээнгүйлэн бусдыгаа сэрэмжилж хамгаалах ёстой.

## 7 сарын 15

*“Харин явж ‘Би тахилыг бус, энэрлийг хүсдэг’ гэсэн нь ямар учиртайг мэд.” (Мт 9:13)*

Бид шашны ямар ямар ёслол дэг жаяг сахиж байгаагаас илүү бусад хүнд яаж хандаж байгааг Бурхан сонирхдог. Бурхан тахилаас илүү энэрэл өршөөлийг хүсдэг. Ёслолоос илүү ёс зүйг хүсдэг. Бурхан Өөрөө тахилын тогтолцоог бий болгосон мөртлөө тахилыг хүсдэггүй гэдэг нь хачирхалтай санагдаж болох юм. Үүнд ямар ч зөрчилдөөн байхгүй. Бурхан Өөрийн хүмүүсийг өргөл тахил авчрахыг тушаасан нь үнэн боловч шударга ёс, хайр энэрлийг өргөл тахилаар орлуулахыг хүсээгүй. "Үнэн ба шударгыг үйлдэх нь ЭЗЭНд нядлах тахилаас ч илүү хүлээн авагдах." (Сур 21:3)

Ёслолуудыг зүй ёсоор нь сахидаг атлаа бусдыг хууран мэхэлж, хөршүүдээ дарладаг хүмүүсийг Хуучин гэрээний эш үзүүлэгчид хатуу зэмлэсэн. Израильчууд өнчин, бэлэвснийг дарладаг учраас тэдний өргөл, тахил, шашны баяр ёслолд Бурхан ой нь гутаж байна хэмээн Исаиа тунхагласан (Иса 1:10-17). Мөн тэрээр, ажилчдадаа шударга хандахыг, өлсгөлөнг хооллохыг, ядууг хувцаслахыг Бурхан хүсэж байна хэмээн мэдэгдсэн (Иса 58:6,7). Амьдрал нь зөв биш бол тэд нохойн толгой, гахайн цус өргөсөнтэй адил байлаа (Иса 66:3).

Шударга ёс, энэрэл өршөөл гол мөрөн мэт урсахаас нааш шашны зан үйлүүдийг Бурхан жигших учраас тэднийгээ боль гэж Амос израильчуудад хэлж байв (Амо 5:21-24). Шашны зан үйлээс илүү Бурхан бодит үнэнийг,

тэгш эрх, шударга ёс, энэрэл өршөөлийг хүсдэг хэмээн  
Мика сануулсан (Мик 6:6-8).

Эзэн Есүсийн өдрүүдэд бэлэвсэн эмэгтэйн гэрийг  
цөлмөдөг атлаа олны өмнө нурушсан урт залбирал үйлддэг  
шашинлаг фарисайчуудыг Эзэн хатуу зэмлэсэн (Мт 23:14).  
Тэд талбайд нь ургасан гаа, гоньдынхоо аравны нэгийг  
хүртэл нарийн өргөдөг атлаа шударга ёс, итгэлтэй байдлыг  
ер тоож байсангүй (Мт 23:23). Ах дүүсээс минь хэн нэгэн  
бидний эсрэг заргатай бол өргөл өргөх нь зохисгүй хэмээн  
Эзэн Есүс айлдсан (Мт 5:24). Ах дүүдээ хийсэн буруугаа  
залруулсны дараа л Бурхан өргөлийг минь хүлээж авдаг.  
Ажил бизнесээ шударга бусаар явуулсныгаа тогтмол  
цуглаанд хамрагдсанаар цайруулах боломжгүй. Ээжийгээ  
хайрлан халамжлахгүй байж ээжүүдийн өдөр ганц  
шоколад өгөөд нэмэргүй. Аавыгаа хүндлэн хайрлахгүй  
байж аавуудын өдрөөр цамц бэлэглэх нь утгагүй юм.

Бурхан гаднах хэлбэрт хууртахгүй. Тэр бидний зүрх  
сэтгэлийг, өдөр тутмын минь амьдралын үнэн мөнийг  
хардаг.

## 7 сарын 16

*"Туслаач ЭЗЭН, Сүсэг биширэлтэн тасарч, хүний хөвгүүдийн дундаас итгэлтэн үгүй боллоо."* (Дуу 12:1)

Итгэмжит хүмүүс үнэхээр ховорджээ. Хүн төрөлхтний дотор ийм хүмүүс улам багассаар байна. Өөрийнх нь өдрүүдэд ийм хүмүүс цөөрсөн хэмээн Давид халаглаж байлаа. Тэгвэл тэр өнөөдрийг харвал яах бол? Итгэмжит хүн гэдэг нь үнэнч, найдвартай, найдаж болох хүн юм. Тэрээр амласандаа хүрдэг, хүлээсэн үүргээ биелүүлдэг, баримталдаг зарчимдаа үнэнч ханддаг.

Итгэмжгүй хүн болзоо тогтоочхоод товлосон цагтаа очдоггүй. Эсвэл хоцордог. Бүтэнсайны цуглаанд номлоно гэж ярьчихаад цаг нь тулахаар ирдэггүй. Тийм хүний үгэнд хэзээ ч итгэж болохгүй. Хэлсэн үг нь түүний хувьд юу ч биш. "Хэцүү цагт урвагч хүнд найдах нь хорхойтсон шүд, доголсон хөл мэт"(Сур 25:19). Соломон яагаад ингэж хэлснийг гайхах хэрэг алга.

Бурхан итгэмжит хүмүүсийг хайж байна. Тэрээр Өөрийнх нь даалгасан зүйлст няхуур нямбай ханддаг итгэмжит нярвуудыг хүсэж байна (1Ко 4:2). Бурхан, христитгэлийн сургаалыг итгэмжтэйгээр дамжуулах багш нарыг хүсэж байна. Тэрээр Эзэн Есүст үнэнч, загалмайгаа үүрдэг, Эзэний хамт жигшигдэхэд бэлэн, итгэмжит итгэгчдийг хүсэж байна. Тэрээр Ариун Сүнсний амьсгалаар бичигдсэн алдаа мадаггүй Библид гуйвшгүй үнэнчээр итгэх хүмүүсийг хүсэж байна. Тэрээр чуулганаас чуулган хэсдэггүй, нэг цуглаандаа үнэнч итгэгчдийг хүсэж байна. Бурхан итгэгч нарт төдийгүй аврагдаагүй хүмүүст найдвартай хандаж чадах ариун хүмүүсийг хүсэж байна.

Итгэмжит байдал бол Эзэн Есүсийн нэг мөн чанар юм. Энэ тал дээр Тэр бидний жинхэнэ үлгэр дуурайл. Тэрээр итгэмжит бөгөөд үнэн гэрч (Илч 3:14). Тэрээр Бурханы өмнө өршөөнгүй итгэмжит Тэргүүн Тахилч (Евр 2:17). Тэрээр нүглийг минь уучилж, бүхий л зүй бусаас биднийг цэвэрлэхдээ итгэмжит зөвт (1Ио 1:9). Эзэний үгс үнэн, амлалтууд нь итгэмжтэй, замууд нь найдвартай.

Хүмүүс итгэмжит байдлыг чухалд тооцохгүй байж болох ч Бурхан чухалд тооцдог. Эзэн Есүс Өөрийн шавь нарт "Намайг сорилтод байх үед Миний хажууд зогсож байсан нь та нар мөн. Миний Эцэг Надад хаанчлалыг өгсөнчлөн Би та нарт өгнө" (Лу 22:28,29) гэж хэлэхдээ итгэмжит байдлыг номлосон. Эцсийн эцэст, итгэмжит хүмүүс Эзэний сайшаалыг хүлээж, "Сайн байна, итгэмжит сайн зарц минь! Эзнийхээ баяр баясгаланд ор" (Мт 25:21) гэдэг үгийг сонсоно.

## 7 сарын 17

*“Чамайг ерөөгчдийг Би ерөөж, чамайг хараагчийг Би хараана. Газар дэлхийн бүх овог чамаар ерөөгдөх болно гэв (Эх 12:3)*

Бурхан анх Абрахамыг дуудаж, энэ дэлхий дээрх ард түмнийхээ тэргүүн болгохдоо тэрхүү үндэстний анд нөхдийг ерөөж, дайснуудыг хараахаа амласан. Энэ олон зуун жилийн хугацаанд еврейчүүд үгээр хэлэхийн аргагүй олон дайсагналыг үзсэн боловч Бурханы хараал семитийн эсрэг үзэл дээр үргэлж оршсоор ирсэн.

Персэд амьдран сууж байсан еврейчүүдийг устгах төлөвлөгөөг Хамаан гаргасан. Тэрээр хааныг ятгаж, хувиршгүй зарлиг дээр гарын үсэг зуруулсан. Эхэндээ бүх юм бүтэмжтэй сайн явж байлаа. Гэвч удалгүй янз бүрийн бэрхшээл гарч ирж, зорилго төлөвлөгөөнд нь саад учирч, еврей хүн Мордехаид бэлдсэн дүүжлүүртээ эцэст нь тэр дүүжлүүлж үхсэн юм.

Адольф Гитлер түүхээс сургамж авалгүй өөрөө өөрийнхөө булшийг ухжээ. Тэрээр бөөнөөр хорих лагерь, хорт утааны өрөө, галт зуух, олноор буудан хөнөөх зэрэг олон аргаар еврейчүүдийг газрын хөрснөөс арчихыг оролдсон. Эхэндээ юу ч түүнийг зогсоож чадахгүй мэт харагдаж байлаа. Гэтэл салхины чиг өөрчлөгдсөн. Тэрээр Берлин дэх хоргодох байрандаа амрагтайгаа хамт ичгүүртэйгээр нас барсан юм.

Семитийн эсрэг үзэл нь дэлхий дээр болох Их гамшгийн үед оргилдоо хүрнэ. Еврейчүүд зовлон ба үхэлд тушаагдана. Бүх үндэстэн тэднийг үзэн ядна. Тэднийг үй олноор нь хөнөөнө. Гэвч энэ аймшигт хэрцгийллийг Эзэн



Есүс Христ биеэрээ ирж таслан зогсооно. Бурханы хүмүүсийг зовоогсад устгагдана. Христийн еврей ах дүү нарт туслагсад Бурханы хаанчлалд орно.

Жинхэнэ итгэгч хүн хэзээ ч семитийн эсрэг үзэлд санаа сэтгэл нийлэхгүй. Учир нь түүний Эзэн, Аврагч, хамгийн сайн жинхэнэ найз нь еврей хүн билээ. Бурхан еврейчүүдийг ашиглаж Библийг өгсөн. Бас еврейчүүдийг ашиглаж Библийг хадгалсан. Израильчууд Мессиагаас нүүр буруулсан учраас Бурхан тэр үндэстнийг түр зуур хажуу тийш тавьсан нь үнэн боловч Абрахамын төлөө тэднийг одоо ч хайрласан хэвээрээ байгаа. Еврейчүүдийг үзэн яддаг хүн өөрийн амьдрал болоод үйлчлэлд Бурханы ивээлийг хүртэнэ гэж бодох хэрэггүй.

"Иерусалимын амар тайвны төлөө гуй! Чамайг хайрлагчид өөдөлтүгэй" (Дуу 122:6). Еврейчүүдийг хайрлагчид өөдлөн дэвжих болно.

## 7 сарын 18

*“Саулын охин Михал насан эцэс болтлоо үр хүүхэдгүй байв.” (2См 6:23)*

Давид гэрээний авдрыг Иерусалимд авчирч, түүнийг байх ёстой газар майхан сүмд нь байрлуулахдаа туйлын их баярлаж байлаа. Энэ нь түүний хувьд хамгийн том амжилт, амьдралынх нь торгон агшин учраас Давид хаан, Эзэний өмнө хамаг чадлаараа бүжиглэсэн. Харин түүний эхнэр Михал энэ үйлдлийг ичгэвтэр явдал гэж үзсэн. Энэхүү шүүмжлэх хандлагаасаа болоод Михал насан эцэс болтлоо үр хүүхэд төрүүлээгүй.

Шүүмжлэх сэтгэл үр жимсгүй байдлыг бий болгодгийг эндээс сурч болно. Мэдээж бусдыг барьж босгодог шүүмжлэлийг яриагүй. Шүүмжлэл үнэн бол бид түүнийг уриалгахан хүлээн авч, ашиг тусыг нь хүртэх ёстой. Амьдралыг минь засаж залруулдаг, үнэн зөв шүүмжлэл хэлдэг, биднийг хайрладаг хүмүүс байдаг.

Гэхдээ бусдыг нураадаг шүүмжлэл нь аюултай. Энэ нь хэн нэгний амьдрал дахь Бурханы ажлыг сүйтгэж, олон жилийн турш босгосон үр дүнг хэдхэн хормын дотор үгүй хийдэг.

Давидын түүхийг яривал, гэрээний авдар нь Христийн бэлгэдэл бөгөөд гэрээний авдар Иерусалимд ирэх нь Христ хүний сэтгэлийн хаан сэнтийд заларч буйн илэрхийлэл юм. Ийм явдал тохиолдвол Сүнсээр дүүрэн итгэгч хүн баярлаж хөөрөхөөс аргагүй. Энэ нь ихэнхдээ үл итгэгчдийн дургүйцлийг төрүүлж, бусад итгэгчдийг унтууцуулдаг. Гэхдээ тэрхүү шүүмжлэх хандлага нь үр жимсгүй байдлыг авчирна.

Шүүмжлэх хандлага нь хувь хүний амьдралыг үр жимсгүй болгоод зогсохгүй чуулганыг ч үр жимсгүй болгож болно. Жишээ нь, залуу хүмүүсийг байнга шүүмжилдэг чуулган байлаа гэж бодъё. Тэдний юу өмсөх, үсээ яаж засуулах, хөгжим яаж тоглох гээд бүх юмыг шүүмжилнэ. Удирдагчид нь залуусыгаа тэвчээртэйгээр сургахын оронд тэднээс бүрэн төлөвшсөн хүний зан чанар шаардаж нэхсэнээс болоод удалгүй залуус нь чуулганаасаа дайжиж, уг чуулган өсөлт хөгжилтгүй зогсоно.

Михалын шүүмжлэх сэтгэлээс сургамж авцгаая. Энэ нь шүүмжлүүлсэн хүнийг хохироогоод зогсохгүй шүүмжилсэн хүнээс ч хариугаа авдаг. Тэр нь сүнсний үр жимсгүй байдал юм.

## 7 сарын 19

*"Бид энэ ертөнцөд Түүн шиг байдаг."* (1Ио 4:17)

Шинэ гэрээний дэндүү зоригтой зарим мэдэгдэл биднийг гайхшируулдаг. Энэ эшлэл тэдний нэг юм. Бид заримдаа ийм зоригтой мэдэгдлийг амнаасаа унагахаас ч айдаг. Гэвч энэ үг туйлын үнэн бөгөөд бид ч түүнд баярлах ёстой.

Тэгвэл бид юугаараа энэ ертөнцөд Христтэй адилхан юм бэ? Ингэж асуунгуут Түүнтэй адил биш чанаруудаа бид хамгийн түрүүнд бодно. Бид Түүн шиг бүхнийг мэдэгч, бүхнийг чадагч, хаа сайгүй оршигч биш. Тэр төгс ариун атал бид гэм нүгэл, алдаагаар дүүрэн. Бид Түүн шиг бусдыг уучилдаггүй. Бусдыг Түүн шиг хайрладаггүй.

Тэгвэл бид юугаараа түүнтэй адил юм бэ? Эшлэл өөрөө тайлбар өгч байна: "Үүгээр шүүлтийн өдөр биднийг зоригтой байлгахын тулд хайр нь бидний дунд төгс болов. Учир нь бид энэ ертөнцөд Түүн шиг байдаг." Бурханы хайр бидний амьдралд ажилласан болохоор бид Христийн шүүх суудлын өмнө очихдоо айхгүй. Бид Аврагч Эзэнтэй ижил чанаруудыг агуулдаг нь биднийг ийм итгэл зоригтой болгож байгаа юм. Шүүлт ард хоцорсон. Шүүлтийн тал дээр бид Түүнтэй адил. Тэрээр Голгота толгод дээр загалмайд бидний нүглийн шийтгэлийг үүрч, нүглийн асуудлыг нэг мөр бүгдийг шийдсэн. Тэр нүглийн шийтгэлийг маань эдэлсэн учраас одоо бид шийтгэл амсахгүй. Тиймээс бид "Үхэл ба шүүлт ард хоцров. Нигүүлсэл ба алдар өмнө минь хүлээж байна. Бүх давлагаа Эзэнийг нөмөрсөн. Одоо тэд яаж ч чадахгүй" хэмээн итгэлтэйгээр дуулж чадна. Шүүлт Түүний хувьд өнгөрөн

одсон адил бидний хувьд ч өнгөрөн одсон. Тиймээс бид "Ямар ч ял байхгүй. Надад ямар ч там, тарчлал, гал байхгүй. Миний нүд тэднийг хэзээ ч харахгүй. Надад ямар ч буруутгал үгүй. Үхэл надад хүчингүй. Учир нь намайг хайрладаг Эзэн жигүүр дороо намайг халхална" хэмээн хэлж чадна.

Бид шүүлтийн тал дээр Түүнтэй адил төдийгүй Бурханд хүлээн зөвшөөрөгдөх талаараа ч Түүнтэй адил. Бид Эзэн Есүсийн дотор байдаг учраас Бурхан Эзэн Есүсийг хэрхэн таалдагчлан биднийг бас тийн таалдаг. "Би Бурханд маш ойр байна. Үүнээс илүү ойртох боломжгүй. Би Бурханы Хүүгийн дотор оршдог учраас Түүний адил Бурханд ойр байна."

Эцэст нь хэлэхэд Христ, Эцэг Бурханд хэрхэн хайрлагдсан шиг бид ч мөн тийн хайрлагддаг. Үүгээрээ бид Христтэй адил. Эзэн Есүс тэргүүн тахилчийн хувиар бидний төлөө зуучлан залбирахдаа "Та...Намайг хайрласны адилаар тэднийг хайрласан..." (Иох 17:23) гэж хэлсэн. "Хүүгээ хайрласан хайраараа намайг Тэр хайрласан. Би Түүнд тийм үнэтэй, тийм эрхэм. Үүнээс илүү Тэр яаж эрхэмлэх юм бэ?"

Тэгэхээр бид энэ ертөнцөд Түүн шиг байдаг нь гарцаагүй үнэн.

## 7 сарын 20

*“Анд нөхөртэй хүн нөхөрсөг байх ёстой.”* (Сур 18:24 KJV-ийн хувилбараар орчуулав)

Энэ эшлэлийг орчин үеийн бүх орчуулга өөрөөр орчуулдаг ч гэсэн KJV (Жэймс хааны орчуулга)-д нөхөрлөлийг тордох ёстой гэсэн чухал үнэнийг тодотгон харуулсан. Нөхөрлөл байнгын анхаарал халамжаар амь орж, тоохгүй орхивол бөхдөг.

"Нөхөрлөл өөрөө үүсдэггүй. Харин тордох ёстой. Товчхондоо гэвэл нөхөрлөл биднээс хөдөлмөр шаардана. Зөвхөн аваад байвал нөхөрлөл барьж босгогдохгүй. Харин өгөх ёстой. Зөвхөн сайн сайхан үед ч биш, хүнд хэцүү цагт ч нөхөрлөл байх ёстой. Жинхэнэ найзаасаа гар татан харамлаж болохгүй. Эсвэл хэрэгтэй үедээ л найзыгаа санадаг байж болохгүй" хэмээн “Шийдвэр” сэтгүүлийн нэгэн редактор бичсэн байна.

Сайн найзыг алдаж болохгүй. Тэрээр гүтгүүлэхэд чинь таны талд зогсож, амьдралд чинь сайн сайхныг хүсэж, алдаа бурууг чинь залруулж, олон жил хамт алхаж, баяр хөөр, гуниг зовлонг чинь хуваалцдаг.

Найзтайгаа байнгын харилцаатай байх нь чухал. Захиа бичих, ил захидал илгээх, утсаар ярих, гэрт нь зочлох гэх мэт. Нөхөрлөлийн харилцаа хоёр урсгалтай. Найз маань захиа бичихэд хариу өгдөггүй бол “Нөхөрлөлийг цааш үргэлжлүүлэх сонирхол надад алга” гэж хэлсэнтэй ялгаа юун. “Би завгүй байна. Надад бүү саад бол. Би захиа бичих дургүй” гэсэнтэй агаар нэгэн билээ. Байнга умартдаг харилцааг тэсэж үлдэх нөхөрлөл цөөн.

Харилцаа холбоо үүсгэдэггүй байдал маань ихэнхдээ нэг төрлийн хувиа хичээсэн зан байдаг. Бид өөрсдийгөө, цаг хугацаагаа, зардал мөнгөө, юу гарздахаа бодоод бусдад цаг гаргахаас цааргалдаг. Жинхэнэ нөхөрлөл бусдыг боддог. Бусдыг яаж урамшуулах вэ, яаж тайтгаруулах вэ хэмээн боддог. Тэдэнд яаж туслах вэ, яавал сүнслэг хоол өгөх вэ хэмээн арга зам хайдаг.

Хэрэгтэй цагт минь Ариун Сүнсний өгсөн үгийг бариад ирдэг найз хэчнээн сайхан. Христийн үйлчлэлд нэлээн урам хугарч, сэтгэлээр унасан үе надад тохиолдож байсан. Намайг сэтгэлээр унасныг мэдээгүй найз минь тэгэхэд урмын үгтэй захиа бичиж, Исаиа 49:4-ийг эш татсан байлаа: "Харин би 'Дэмий хөдөлмөрлөж, хүчээ юунд ч биш, хоосон зарцуулжээ би. Гэвч үнэхээр шударга ёс минь ЭЗЭНтэй хамт, шагнал минь Миний Бурхантай хамт юм' гэсэн." Энэ нь надад яг хэрэгтэй үг байлаа. Энэ үг намайг барьж босгон, дахин шинээр эхлэхэд тусалсан.

Чарльз Кингсли: "Эцэс хүртэл намайг дэмжиж, уралдаанд минь намайг хөглөдөг ганц найзыгаа мартана гэж үү? Тэр ганц царайг мартаж чадна гэж үү? Сайхан сэтгэлтэй тэр андынхаа ач тусыг мартаж яахин болно" хэмээн бичсэн.

Бидний ихэнх маань амьдралын цөөн хэдэн дотно найзтай. Энэхүү нөхөрлөлөө бат бэх, эрүүл байлгахын тулд чадах бүхнээ хийгээрэй.

## 7 сарын 21

*"Тэр та нарт санаа тавьдаг учраас бүх зовнилоо Түүнд хая." (1Пт 5:7)*

Итгэгч болоод олон жил болсон ч Эзэнд бүх зовнилоо даатган орхиж сурахгүй явах нь бий. Энэ эшлэлийг цээжилж, бусдад номловч өөрсдийн амьдралд хэзээ ч хэрэгжүүлдэггүй хүмүүс байдаг. Бурхан бидэнд санаа тавьж, бидний асуудлыг анхаарч, төсөөлж байгаагаас минь ч илүү санаа зовнилуудыг минь боддог гэж бид теологийн хувьд мэднэ. Гэсэн атлаа ирээдүйг муугаар төсөөлж, санаа зовж, орондоо эргэж хөрвөөхөө бид больдоггүй.

Заавал ийм байх албагүй. Бидний мэддэг ихэнх хүнээс илүү олон асуудалтай нэгэн найз надад бий. Найз маань өөрөө бүгдийг үүрнэ гэвэл дааж чадахгүй. Тэр юу хийдэг гэж бодно? Тэрээр бүх асуудлаа Эзэн дээр авчраад, бүгдийг Түүнд орхиод, өвдөг дээрээсээ өндийн босож, магтан дуу дуулаад орондоо ороод унтдаг.

Билл Брайт, Лерой Эймст нэгэн удаа ингэж хэлжээ: "Лерой, 1 Петр 5:7-гоос би маш их тайтгарлыг олж авлаа. Амьдралын минь ачааг нэг бол би өөрөө үүрнэ, нэг бол Эзэн Есүст үүрүүлнэ гэдгийг ойлголоо. Бид хоёр тэр ачааг нэгэн зэрэг үүрч чадахгүй. Би ачаануудаа Эзэнд даатган орхихоор шийдлээ."

Эймс энэ зарчмаар алхахаар шийдсэн байна. Тэрээр ингэж бичжээ: "Би өрөөндөө ороод залбирч эхэлсэн. Хамаг чадлаараа Биллийн хэлснээр хийх гэж хичээсэн. Энэ олон сарын турш даагдашгүй хүнд ачааг үүрсээр маш их зүдэрчээ. Тэгээд Би Бурханы чөлөөлөлтийг мэдэрч эхэлсэн. Мэдээж асуудал алга болоогүй. Өнөөдөр ч асуудал



хэвээрээ байна. Гэхдээ сэтгэлийн дарамт арилсан юм. Цаашид нойргүй шөнийг өнгөрөөх шаардлагагүй болсон. Одоо би ачаа дарамтын өөдөөс баяр талархалтайгаар харж чадахаар болжээ."

"Өдөр бүр санаа зовнилоо Өөрт нь үүрүүлж, итгэл найдвараа алдахгүй байхыг Бурхан хүсдэг. Гэтэл бид олон тохиолдолд итгэл алдарч, юм бүхэнд санаа зовж, хамаг ачаагаа өөрөө үүрэх гэж мунхагладаг." Бидний ихэнх нь энэ үгэнд бичсэн шиг байдаг.

*Ямар ч ачааг өөрөө үүрэх гэж бүү оролд  
Ямхын төдий ганц нь ч чамд хүндэднэ  
Чиний өмнөөс Би ажиллая, ачаа чинь Минийх  
Чиний хийх ажил бол Миний дотор амрах*

## 7 сарын 22

*"Хараач, Эзэн,...хэрэв би хэн нэгнээс залилан авсан байвал түүнийгээ дөрөв дахин нугалж эргүүлэн өгнө."* (Лк 19:8)

Закхай Эзэн Есүст зүрх сэтгэлээ нээсэн дарууд тэнгэрлэг бодол санаа түүнд орж ирж, өнгөрсөн хугацаанд залилан авсан мөнгөө нөхөн төлөх ёстойг ухаарчээ. Закхай хүнээс мөнгө залилсан гэж дээрх эшлэлд тодорхой бичээгүй боловч, "хэрэв" гэсэн үгийг баян татвар хураагч маань "учраас" гэсэн утгаар хэрэглэсэн гэж ойлгогдохоор байна. Тэр шударга бусаар мөнгө олсноо мэдэж байсан. Тиймээс энэ талаараа ямар нэг юм хийхийг хүсжээ.

Нөхөн төлөх нь Библийн дагуух сургаал, Библийн дагуух зөв үйлдэл юм. Христэд итгэсэн үедээ бид буруу замаар олж авсан зүйлээ зохих эзэнд нь буцаан өгөх ёстой. Мөнхийн авралыг оллоо гээд өнгөрсөн хугацаанд хийсэн буруу үйлдлийн үр дагавар арилахгүй. Аврагдахаасаа өмнө мөнгө хулгайлсан бол аврагдсаныхаа дараа түүнийгээ буцаан өгөх нь Бурханы нигүүлслийг ухаарсны шинж юм. Дахин төрөхөөсөө өмнө тавьсан өр дахин төрснөөр цайрчихгүй.

Хэдэн жилийн өмнө В. П. Николсоны номлолын нөлөөгөөр Белфастад олон зуун хүн Христэд итгэжээ. Тэгэхэд шинээр итгэсэн хүмүүс хулгайлсан багаж хэрэгслээ орон нутгийнхаа үйлдвэрт буцаан авчирч өгөхөд тэднийг нь байлгах том байр барих шаардлагатай болсон байна.

Энэ улс оронд зөвхөн зэвсэгт хүчний салбараас хулгайлсан эд юмсыг багтаах байр барина гэвэл асар том агуулах хэрэг болох биз ээ. Үйлдвэр, албан байгууллага,

дэлгүүр хоршооноос хууль бусаар авсан эд бараа, багаж хэрэгслийг яривал бүр ч тамтаггүй их юм болно.

Итгэгч хүн нөхөн төлбөрийг хийхдээ Эзэний нэрээр хийх нь зөв. Жишээ нь, "Би хэдэн жилийн өмнө танайд ажиллаж байхдаа энэ багаж хэрэгслийг хулгайлсан юм. Харин би саяхан Есүст итгэн аврагдсан. Эзэн Есүс Христ миний амьдралыг өөрчилсөн. Энэ багаж хэрэгслийг танд буцаан өгч, танаас уучлалт гуйхыг Эзэн Есүс зүрх сэтгэлд минь ойлгуулж өгсөн юм" гэж хэлж болно. Ингэснээрээ Эзэний хүртэх ёстой алдрыг Эзэнд өгнө.

Христийг гэрчлэх үүднээс хулгайлсан мөнгөн дээрээ илүү хүү нэмж өгөх тохиолдол байдаг. Хуучин гэрээний ялын тахил үүнийг дүрсэлдэг. Энэ тахил нь хохирлыг барагдуулахдаа дээр нь нэмж тавны нэгийг нь нэмж төлөхийг шаарддаг.

Мэдээж цаг хугацаа өнгөрч, нөхцөл байдал өөрчлөгдөөд нөхөн төлбөр өгөх боломжгүй болсон тохиолдлууд бий. Эзэн үүнийг ойлгоно. Хүн нүглээ улайж, нөхөн төлөхийг чин сэтгэлээсээ хүсэвч нөхөн төлөх боломжгүй болсон бол Эзэн түүний чин сэтгэлийг хүлээн авна.

## 7 сарын 23

*"Тэр ч байтугай ард олон Петрийг ирэхэд ядаж түүний сүүдэр нь тэдний хэн нэгэн дээр тусаасай гэж өвчтэй хүмүүсийг гудамжинд авчран, дамнуурга болон дэвсгэр дээр тавьдаг байлаа. " (Үйл 5:15)*

Петрийн үйлчлэл хүч чадал, эрх мэдэлтэй байсныг хүмүүс анзаарсан. Түүний явсан газар бүр өвчтэй хүн эдгэрч байлаа. Олон түмэн Петрийн сүүдэрт ч болов хүрэхийг хүсэх нь аргагүй. Тэрээр асар их нөлөө үзүүлж байсан юм.

Хүн бүрд өөрийн гэсэн сүүдэр байдаг. Бид уулзсан, хүрсэн хүн болгондоо нөлөө үзүүлдэг. Херман Милвилл: "Бид зөвхөн өөрсдийнхөө төлөө амьдарч болохгүй. Хүн бидний амьдрал мянга мянган үл харагдах холбоосоор хоорондоо холбогддог. Эдгээр холбоос нь бидний үйлдлийг нэг бол учир шалтгаан, нөгөө бол үр дүн болгодог" гэж бичсэн.

Та сайнмэдээний ном бичиж байна. Өдөр бүр нэг бүлгийг. Хийж байгаа үйлсээрээ, ярьж байгаа үгээрээ. Хүмүүс таны бичсэнийг уншдаг. Тэр нь үнэн ч бай, худал ч бай бүгд уншиж байгаа. Надад хэлээч. Таны бичсэн сайнмэдээ ямар вэ?

Нэг хүнээс таны дуртай сайнмэдээний ном аль нь вэ гэж асуухад "Миний ээжийн бичсэн сайнмэдээ" гэж хариулсан байдаг. Жон Уэсли нэгэн удаа: "Английн бүх теологичдоос илүү ээжээсээ би христитгэлийг сурч авсан юм" гэж хэлсэн байдаг.

Хүмүүс биднийг хараад "Христэч хүн ийм байх ёстой юм байна" гэж дүгнэдэг. Тэр нь бидний хүүхдүүд, найз

нөхөд, хөршүүд, багш, сурагчийн аль нь ч байж болно. Та бол тэдний баатар, үлгэр дуурайл, хүрэх оргил нь. Тэд таныг боддогоос чинь илүү нарийн шинжин хардаг. Таны ажил бизнес, чуулганы амьдрал, гэр бүлийн амьдрал, залбирал бүгдээрээ тэдэнд даган дуурайх хэв загвар үзүүлдэг. Тэд таны сүүдрийн нөлөөг авдаг.

Сүүдэр бол юу ч биш гэж та бодож магадгүй. Гэхдээ бидний тусгадаг сүнслэг сүүдэр бодит үр дагавартай. "Миний амьдрал бусдад хүрэхээрээ баяр жаргал өгч байна уу гуниг харуусал төрүүлж байна уу хэмээн хамгийн сүүлд хэзээ бид бодсон бэ? Тэд миний нэрийг, надтай өнгөрүүлсэн цаг хугацааг, миний дэргэд байсан газраа бодохоороо ямар сайн нөлөөг аваа вэ гэж дурсдаг уу? Эсвэл ямар муухай дурсамж вэ гэж жийрхдэг үү?" (Стриклэнд Гиллилан)

"Бие чинь нарыг сүүдэр тусгахаас болиулж чаддаггүйн адил хэлэх үг, хийх үйлдэл чинь бусдад нөлөөлөхийг та саатуулж чадахгүй. Та өөрийнхөө мөн чанарыг хэчнээн нуулаа ч өөрөө л тэд чинь ил гараад байдаг. Хүн бүр бусдад нөлөөлдөг. Тэр нөлөө ямар хүчтэй гэдгийг үгээр илэрхийлэхийн аргагүй." (Роберт Г.Ли)

## 7 сарын 24

*"Зарим нь нэг өдрийг нөгөөгөөс нь онцгойлон үздэг байхад, зарим нь өдөр бүрийг адилхан гэж үздэг. Хүн бүр өөрийн бодолдоо бат итгэлтэй байг."* (Ром 14:5)

"Адилхан" гэдэг үг эх грек текст дээр байхгүй. Үүнийг орчуулгын найруулгын шаардлагаар нэмсэн. Эх текстийг нь үгчлэх юм бол "Зарим нь өдөр бүрийг үнэлдэг" гэсэн утга гарна. Өөрөөр хэлбэл тэр хүмүүс өдөр бүрийг ариунд тооцдог.

Хуулийн дор амьдарч байсан иудейчүүд долоо дахь өдөр буюу Шаббатыг онцгой ариунд тооцдог байлаа. Энэ өдөр ажиллах, аялах зэргийг хуулиар хориглодог. Мөн тусгай өргөл өргөхийг шаарддаг.

Нигүүлслийн дор амьдарч буй христитгэгчид Шаббатыг сахих тушаалгүй. Библид долоон өдрийн нэгийг нь амралт гэж заасан зарчим байдаг ч христитгэгчдийн хувьд бүх өдөр ариун. Шаббатыг сахиагүйн төлөө тэднийг буруутгаж болохгүй (Кол 2:16).

Шинэ гэрээнд долоо хоногийн нэг дэх өдөр буюу Эзэний өдрийг онцолдог. Энэ нь Шинэ гэрээний хэд хэдэн хэсгээс илэрхий ойлгогдоно. Эзэн Есүс тэр өдөр үхлээс амилсан (Иох 20:1). Амилсныхаа дараах хоёр ням гарагт Эзэн Есүс шавь нартайгаа уулзсан (Иох 20:19,26). Ариун Сүнс Пентэкостын өдрөөр долоо хоногийн эхний өдөр буусан. Пентэкоост нь Христийн амиллын бэлгэдэл (1Ко 15:20,23) болох анхны үр жимсний баярын дараах долоо дахь ням гарагт болдог (Лев 23:15,16; Үйл 2:1). Шавь нар долоо хоногийн эхний өдөр цугларч талх хуваадаг байсан (Үйл 20:7). Паул тусгай хандивыг долоо хоногийн эхний

өдөр цуглуулах зааврыг коринтчуудад өгсөн (1Ко 16:1,2). Гэхдээ ням гараг нь Шаббат шиг заавал сахих ёстой үүрэг биш. Харин онцгой ерөөлтэй өдөр юм. Бид ням гарагт нийтээр амардаг учраас ням гарагийг бусад өдрөөс илүү Эзэний мөргөл ба үйлчлэлд зориулах боломжтой.

Бүх өдрийг адилхан ариунд тооцох эрх чөлөө бидэнд байгаа ч гэсэн ням гарагт юу дуртайгаа хийж бусдыг бүдрүүлэх эрх чөлөө байхгүй. Энэ өдөр гэрийнхээ ажлыг хийх, машинаа засах, хөл бөмбөг тоглох зэргээр ах дүүгээ бүдрүүлснээс өөрсдийнхөө эрхээс татгалзахыг бид илүүд үзэх хэрэгтэй. "Иймд цаашид бид бие биеэ шүүхээ больё. Харин ч та нар ах дүүдээ бүдрүүлгийн чулуу эсвэл саад тотгор тавихгүй байя гэж шийдэгтүн." (Ром 14:13)

Хуулийн доорх иудейчүүд ажиллаж ажиллаж байгаад долоо хоногийн төгсгөлд амардаг. Харин нигүүлслийн доорх христэч бид долоо хоногоо амралтын өдрөөр эхэлдэг. Яагаад гэвэл Христ золилтын ажлыг дуусгасан юм.

Эзэний өдрийг Эзэн Есүс Өөрөө хэрхэн ашигласан байдлаас тухайн өдрийн жинхэнэ мөн чанарыг С. И. Скофилд дүрслэн гаргаж ирсэн юм: "Эзэн Есүс энэ өдөр гашуудсан Мариаг тайвшруулж, будилсан хоёр шавьтайгаа долоон бээр газар алхаж, Библийн тухай зааж, бусад шавь нартаа мэдээ хүргэж, няцсан Петртэй хувьчилсан уулзалт хийж, дээд өрөөнд байсан эрчүүд дээр Ариун Сүнсээ цутгасан."

## 7 сарын 25

*“Леа хайр хүртээгүйг ЭЗЭН үзээд Леагийн умайг нээв. Харин Рахел нь хүүсэр байжээ” (Эх 29:31)*

Амьдралд эрх тэгш хуваарилалтын хууль гэж байдаг. Энэ хуулийн дагуу хүний аль нэг талбарын дутууг, өөр нэг талбарын илүүгээр тэнцүүлдэг. Энэ хууль нь нэг хүнд бүх юм өгөгдөхөөс хамгаална. Гоо үзэсгэлэнгээр дутуу нэгэнд амьдралын ухаан илүү өгөгдөнө. Яруу найрагчид практик амьдралд маруухан, зураачид санхүүгээ зохицуулахдаа тааруу байх нь элбэг.

Иаков, Рахелийг Леагаас илүү хайрласныг Бурхан харжээ. Тиймээс Леаг Рахелаас олон хүүхэдтэй болгосон. Хожим нь Ханна, Пенинна нарт тэгш хуваарилалтын хууль адил үйлчилсэн. Елкана, Ханнагаа Пениннагаас илүү хайрласан боловч Пенинна нь үр хүүхэдтэй болж, Ханна хүүхэд төрүүлж чадаагүй (1См 1:1-6).

Фэнни Кросбид орчлонг харах аз дутсан ч, түүнээс гайхамшигт дуунууд төрдөг байлаа. Түүний зохиосон магтан дуунууд чуулганы агуу домгуудын нэг юм. Александр Крүденс сэтгэлийн хүнд гутралаар шаналж байсан ч, өөрийнх нь нэрээр нэрлэгдсэн Библийн конкордонс зохиож чадсан юм.

Хүмүүст номлож чаддаггүй нэгэн даруухан итгэгч байлаа. Чуулганд үйлчлэх ямар нэг бэлэг авьяас түүнд байсангүй. Гэхдээ тэр машин техникийн мэргэжилтэн байв. Түүний ачаар номлогчийн машин хэзээ ч эвдэрч, зогссонгүй. Харин номлогч болохоор машин техникт "А" ч байхгүй. Машинд нь асуудал гарч зогслоо гэхэд номлогч



маань толгойгоо гудайн залбирахаас өөр юу ч хийж чадахгүй.

Зарим нэг нь тэгш хуваарилалтын хууль энэ хорвоод бүрэн үйлчилдэггүй шүү дээ гэвэл бүү хүлээн зөвшөөрөөрэй. Шударга бус явдал, тэгш бус байдал дэлхийд олон. Гэхдээ энэ амьдрал бүтэн зураг биш юм. Сүүлийн бүлэг хараахан бичигдээгүй байна. Бурхан хөшиг татаж, энэ ертөнцийн цаадхыг харуулах үед бүх дутуу гүйцээгдэж, тэгш байдал хангагдаж, шударга ёс тогтсон байхыг бид харна. Жишээлбэл, Абрахам баян эрд юу гэж хэлснийг сонсоно уу: "Хүү минь, чи амьдралынхаа туршид сайн сайхан зүйлээ хүлээн авахад Лазар ч тэрчлэн муугаа авсныг чи санаач. Харин одоо тэр энд тайтгарч, чи тэнд зовж байна." (Лук 16:25)

Харин тэр болтол амьдралыг шударга хэмээн харах нь бидэнд тустай. Ингэснээр өөрсдийн дутуу дулимгийг олж харахын оронд бусдад өгөгдөөгүй ямар боломжийг Бурхан надад өгсөн бэ гэдгийг олж харж чадна. Энэ нь өөрийгөө голох, бусдад атаархах, амьдралд сэтгэл дундуур байхаас биднийг хамгаална.

## 7 сарын 26

*“Хүүг эцгийнх нь эсрэг, охиныг эхийнх нь эсрэг, бэрийг хадам эхийнх нь эсрэг болгохын тулд Би ирсэн. Хүний дайсан нь гэр бүлийнхэн нь болно.” (Мт 10:35,36)*

Эзэн Есүс Өөрийн ирэлтийн шууд зорилгыг энд яриагүй. Харин Эзэн Есүс ирснээс болж хүмүүсийн амьдралд гарах үр дагаврыг ярьсан. Хэн нэгэн хүн Есүсийг дагахаар шийдэх үед гэр бүл, ойр дотнынхон, найз нөхдөөс нь ширүүн эсэргүүцэл ирнэ гэдгийг Эзэн Есүс ярьж байна. Энэ утгаар бодвол, Тэр энх тайван авчрахаар биш, илд сэлэм зөрөлдүүлэхээр иржээ (34-р эшлэл).

Түүх энэ зөгнөлийг биелүүлсэн. Хүмүүс Эзэн Есүс рүү эргэх үед есөн бусын доромжлол, хавчлага амсдаг. Тэд доромжлуулж, гутаагдаж, гэрээсээ хөөгдөж, ажлаасаа халагдаж, олон тохойлдолд амиа алдсан.

Хүмүүсээс ирж буй эсэргүүцэл нь ихэнхдээ ямар ч утга учиргүй байдаг. Хар тамхинд донтсон хүүтэй нэгэн аав байлаа. Хүү нь нэг өдөр хар тамхиа хаяж, Христэд идэвхтэй үйлчилдэг болов. Энэ тохиолдолд аав нь баярлана гэж хүн бодно. Гэтэл тэгсэнгүй. Аав нь уурлаж, “Ийм хүүтэй байсанд орвол хар тамхичин хүүтэй байсан нь дээр” гэж хэлжээ.

Архичин хүн архинаас гарч, гэмт хэрэгтэн шударга иргэн болж, бэлгийн буруу зуршилтай хүн цэвэр ариун явдалтай болж, зан чанар сайжирсан олон тохиолдол бий. Тэднийг хараад хамаатан садан нь баярлаад өөрсдөө Христийг дагана гэж анхандаа бодмоор. Гэтэл ийм юм ерөөсөө болдоггүй. Эзэн Есүсийн ирэлт гэр бүлд зөрчил үүсэх шалтгаан болдог.

Христийн төлөө эцэг эхийнхээ шашин шүтлэгийг хаяхаар эцэг эх нь маш их гомддог. Жишээ нь иудейн шашиндаа нэр төдий итгэдэг гэр бүл байлаа. Гэрийн нэг гишүүн Христэд итгэсэн даруйд бусад гишүүдийн дотор яагаад ч юм улангассан хорсол зэвүүцэл бий болов. Тэд гэр бүлийнхээ итгэгч болсон гишүүнийг урвагч, тэрслэгч, иудейчүүдын дайсан Гитлерийн хамсаатан гэж цоллоно. Тэдэнд юу ч тайлбарлаад нэмэр болохгүй.

Исламын олон оронд Христэд итгэх нь үхэл дагуулдаг. Христэд итгэсэн хүнийг төр засаг нь цаазлахаас гадна гэр бүлийн дотнын хүмүүс нь тэдэнд үхлийн аюул занал учруулдаг. Эхнэр нь нөхрийнхөө хоолонд хор хийх жишээтэй.

Гэхдээ шинэ итгэгчдийн зоригтой тунхаглал, тэвчээр, үзэн ядалт ба хавчлагыг Христ шиг даван туулж буйг хараад нөгөө талын хүмүүс өөрсдийнхөө амьдралын утгагүй хоосон, шашин шүтлэгийнхээ худал хуурмагийг олж харж, гэмшил ба итгэл дотор Эзэн Есүс Христ руу эргэдэг. Тэгэхээр эсэргүүцэл хавчлагаар дамжуулан Христийн бие хил хязгаараа тэлдэг байна.

## 7 сарын 27

*"Харагтун, чи тэдний хувьд хөгжмийн зэмсгүүдээр сайн тоглодог, сайхан хоолойтой хүний дуулсан тачаангуй дуу мэт юм. Учир нь тэд үгийг чинь сонсдог боловч түүнийг биелүүлдэггүй."* (Езк 33:32)

Эзэний үгийг тунхаглахад гардаг инээдтэй ч гэмээр нэг асуудал бол хүмүүс номлогчийг анхаарах боловч өөрсдөөс нь үйлдэл гарахыг шаардаж буй номлолыг сонирхдоггүй явдал юм.

Хүмүүст номлож байхад энэ хандлага байнга ажиглагддаг. Хүмүүс номлогчийг биширч, наргианыг нь дурсаж, ярьсан юмыг нь мартдаггүй. Номлол нь л тэдэнд сонирхолтой санагддаг. "Номлогч маань 'Месопотами' гэх ерөөлт үгийг хэлэх тоолонд л би нулимсаа барьж чадахгүй юм" гэж хэлсэн эмэгтэйгээс тэд ялгаагүй. Дуулгавартай байдал яригдаад ирэхээр тэд дүлий хүн шиг болдог. Тэд үйлдлийн эсрэг дархлаатай. Бурханы үгийг дагах тал дээр тэд мэдээ алдсан хүн шиг.

Зөвлөгөө өгдөг хүмүүс үүнийг сайн мэддэг. Зарим хүнд зөвлөгөө авч байгаа нь л сайхан байдаг. Тэрхүү уулзалтын цагт анхаарлын төвд байх нь тэдний гол зорилго. Тэд зөвлөгчтэй сайхан ярилцах л дуртай.

Гаднаас нь харахад тэд зөвлөгөө хүссэн мэт. Гэвч үнэн чанартаа тэдэнд зөвлөгөө ямар ч хэрэггүй. Тэд яахаа аль хэдийнээ шийдчихсэн байдаг. Юу хийхээ ч мэдэж байгаа. Зөвлөгчийн зөвлөгөө өөрсдийнх нь хүсэлтэй таарч байвал тэд бодлоо улам батжуулна. Харин өөрсдийнх нь бодолтой таарахгүй бол уг зөвлөгөөг тээршээгээд өөрсдийнхөө гөжүүд замаа цааш үргэлжлүүлдэг.

Херод хаан иймэрхүү сонирхогчдын нэг байлаа. Тэрээр баптисч Иоханыг сонсох дуртай боловч (Марк 6:20) боловч ердөө сонирхогч төдий байлаа. Иоханы номлолыг сонсоод амьдралаа өөрчлөх санаа түүнд ер байгаагүй.

“Зөвлөгөө авахаар ирж байгаа хүмүүст тусалъя гэхээр нэг том асуудал байдаг. Юу гэвэл, тэдний ихэнх нь өөрчлөгдөх ямар ч хүсэлгүй. Зан чанар нь амьдралд нь гай болж байвал бага зэрэг өөрчлөлт оруулахад бэлэн боловч ямар нэг асуудал үүсээгүй бол тэдний ихэнх нь хийж буй нүгэлдээ дуртай байдаг. Тэд Бурханыг өөрсдийнх нь тэнэг үйлдлийг хүлээн зөвшөөрөөсэй гэж хүсдэг.” (Эрвин Люцер)

Зарим зөвлөгч үйлчлүүлэгчдийгээ сонссоноо хэрэгжүүлдэг болгох үүднээс зарим нэг стратеги ашигладаг. Тухайлбал дараагийн уулзалтад ирэхээсээ өмнө биелүүлэх ёстой даалгаврыг өгдөг байна. Ингэснээр нухацтай хандаж байгаа хүн л уг зөвлөгчид ханддаг болно. Дээрээс нь, хэн хэнийх нь цаг завьг үрэхээс хамгаалдаг.

Бурханы үгийг сонсовч дуулгавартай дагах хүсэл төрөхгүй байна гэдэг туйлын ноцтой асуудал. Бид Эзэний дуу хоолойнд мэдрэг байж, юу ч хэлсэн дуулгавартай дагахын төлөө байнга залбирах ёстой.

## 7 сарын 28

*"Хорон муу нь замаа, буруу нэгэн нь бодол санаануудаа орхиг. Өөрийг нь өрөвдөх ЭЗЭН өөд эргээг. Өгөөмрөөр уучлах Бурханд маань эргээг."* (Иса 55:7)

Дагжин чичрэгч нүгэлтэн Бурхан өөрийг нь хүлээн авахгүй хэмээн айна. Итгэгч хүн буруу замаар будаа тээгээд дараа нь гэмшсэн ч Бурхан өнгөрснийг нь мартаж болов уу хэмээн эргэлзэнэ. Гэвч өнөөдрийн эшлэл, Эзэн рүү эргэсэн хүмүүст өршөөл нигүүлсэл, уучлал дүүрэн байгааг сануулсан байна.

Бурханы нигүүлсэл уучлалыг дүрслэн ярихын тулд өгүүлдэг нэг түүх бий. Энэ түүхийг хүмүүс өөр өөрөөр ярьдаг боловч сургамж нь ижил. Тэрслүү нэг хүү байжээ. Тэрээр гэрээсээ явж Нью-Йоркт очоод нүгэлт ба ичгүүрт, гутамшигт амьдралаар амьдрал. Эцэст нь шоронд оржээ. Дөрвөн жил шоронд хоригдоод суллагдахдаа гэртээ харихыг ихэд хүсжээ. Гэвч аав нь түүнийг хүлээн авахгүй байх вий хэмээн маш их айж байлаа. Очиход нь хөөгөөд гаргачих болов уу гэдгээс айж байв.

Тэгээд хүү аавдаа буцах хаяггүй захиа бичив. “Би дараагийн долоо хоногийн тав дахь өдөр вагоноор очно. Хэрэв гэр бүл минь намайг хүлээн авна гэвэл гэрийн урд талын царс модон дээр цагаан алчуур уяарай. Модон дээр цагаан алчуур уяагүй байвал би галт тэрэгнээс буухгүй цаашаа яваад өгөх болно” гэж бичжээ.

Ингээд хүү галт тэргэнд суугаад юу болох бол хэмээн санаа зовнин явлаа. Түүний хажууд нэг итгэгч хүн сууж таарчээ. Итгэгч хүн түүнтэй яриа өрнүүлж, амьдралыг нь яриулж чадав. Гэрт нь хүрэхэд тавин бээр дутуу байлаа.

Хүүгийн зүрх айдас хийгээд найдварын хооронд савлаж байв. Дөчин бээр үлдлээ. Эцэг эхдээ ямар их гутамшиг авчирч, зүрх сэтгэлийг нь яаж шархлуулснаа хүү ярина. Гучин бээр үлдлээ. Өнгөрсөн он жилүүдээ үрэн таран хийж байснаа дурсана. Хорин бээр. Арван бээр. Таван бээр.

Эцэст нь нэг юм гэрийнх нь бараа харагдав. Хүү гайхан алмайрлаа. Царс модны мөчир бүрээс цагаан даавуу уясан харагдана. Тэрээр босоод цүнхээ аваад уг өртөөн дээр буулаа.

Энэ мод мэдээж загалмайг харуулж байна. Уучлалын тоо томшгүй олон амлалтаар чимэглэгдсэн, тоссон гараа дэлгэсэн загалмай, “Гэртээ ирээч” хэмээн гэмшсэн нүгэлтнийг дуудаж байна. Эцгийн гэрт ирэх ямар сайхан бэ! Төөрсөн тэнүүчлэгч буцаад ирэхэд ямар их уучлал хүлээж байна вэ!

## 7 сарын 29

*"Та гэм буруутнуудад туслан ЭЗЭНийг үзэн ядагчдыг хайрлана гэж үү? Үүнээс чинь болоод ЭЗЭНээс ирэх уур хилэн өөр дээр чинь буув."* (2Шс 19:2)

Иехошафат хаан Сирийн эсрэг тулалдаанд хорон муу Ахаб хаантай нэгдсэн. Энэ нь зүй бус нэгдэл байсан бөгөөд Иехошафат хааны амийг авч одохоо шахсан. Сиричүүд Иехошафатыг Ахабтай андуурч амийг нь хөнөөх гэв. Иехошафат үхлээс зугтаж чадсан ч эш үзүүлэгч Иехүгийн хатуу зэмлэлээс зугтаж чадаагүй. Өөрийнх нь хүмүүс Бурханыг үзэн ядагчдыг хайрлаж, хорон муу хүмүүстэй хамтрахаар Бурхан уурладаг.

Өнөөдөр ийм үзэгдэл хаана болж байна вэ? Эвангелийн гэх чуулганууд, шашны томоохон хөдөлгөөнүүдэд либералуудтай нийлж байгаа нь үүний хамгийн том жишээ юм. Уг либерал үзэлтнүүд христитгэлийн хамгийн чухал сургаалуудыг үгүйсгэдэг. Тэд өөрсдийн эргэлзээ ба үгүйсгэлээрээ Библийн эрх мэдлийг няцаахыг оролдож байна. Тэд өөрсдийгөө Христэч гэдэг боловч үнэндээ Христийн загалмайн дайснууд юм. Тэдний бурхан нь тэдний ходоод. Тэдний алдар нь тэдний ичгүүр. Тэд газрын юмсыг боддог (Флп 3:18,19-г үз). Христийн үйл хэрэг тэдний тусламжийг авахгүй. Тэд Христийн үйл хэргийг нураахаас өөр юу ч хийж чадахгүй.

Эдүгээ экуменизмийн хөдөлгөөн газар авч байгаа бөгөөд Библийн дагуу итгэлтэй христитгэгчид Христийн Биед зүсэн бүрийн дарамт шахалтыг үзэж эхэлж байна. Өөрсдийг нь дагаагүй хүмүүсийг тэд доромжилж, гутааж,



шүүмжилж, эрх чөлөөг нь боомилдог. Гэсэн ч Христэд үнэнч байя гэвэл тэднээс салан тусгаарлагдахаас өөр аргагүй. Тэдэнтэй нэгдэж болохгүй.

Хамгийн харамсалтай нь, үнэн итгэгчид хорон муу хүмүүстэй хамтран ажиллахгүй гэсэн ах дүүсийнхээ эсрэг дайсагнаж байна. Христэч удирдагчид модернистуудад тал засах атлаа Христийн талд зогсогчдыг хурцаар шүүмжилцгээнэ. Тэд либерал эрдэмтдэд тал засаж, либерал зохиолчдын үгнээс эш татаж, либерал гаж сургаалуудыг чимээгүй хүлцсээр байна. Үүгээрээ тэд, шударга ба шударга бусын хооронд зааг хязгаар тогтоох гэсэн үнэн итгэлт ах дүү нараа элэглэн дооглуулж байгаагаас цаашгүй юм.

Бурханы дайснуудаас тусламж хүсэж, тэдэнд найр тавих нь итгэл эвдсэн хэрэг. Христэд үнэнч байхын тулд Түүний үнэнч дагалдагч нартай хамт дайсны эсрэг хатуу зогсох ёстой.

## 7 сарын 30

*"Тулалдаанд явсан хүмүүсийн хувь нь ачаа барааны дэргэд байсан хүмүүсийн хувьтай адилхан. Тэд адилхан хуваах ёстой."* (1См 30:24)

Давид амалекчуудаас Зиклаг хотыг буцаан авах үед зарим эрчүүд нь Бесор горхины дэргэд үлдсэн 200 хүнтэй олзоо хуваахыг хүссэнгүй. Тэгэхэд нь Давид, ачаа барааны дэргэд үлдсэн хүмүүс тулаанд оролцсон хүмүүстэй ижил хувь хүртэх ёстой гэж зарлиг гаргасан.

Дайн тулааны үед фронтын ард ажилладаг хүмүүс гэж байдаг. Дэлхийн хоёрдугаар дайнд Америкийн зэвсэгт хүчний гучин хувь нь л тулаанд биеэр оролцжээ. Бусад нь арын албаны хүмүүс буюу инженерүүд, зэвсгийн хангамжийнхан, харилцаа холбооны ажилчид, химийн бодис хариуцсан ажилчид, тээврийн алба, захиргааны ажилтан зэрэг хүмүүс байв.

Эзэний ажилд ч гэсэн нөхцөл байдал ижил. Бүх итгэгч цэрэг боловч бүгдээрээ тулааны фронтын шугамд тулалддаггүй. Бүгдээрээ номлогч, сайнмэдээ тараагч, багш пастор болдоггүй. Бүгдээрээ дэлхий даяар явж, тулааны талбарт үйлчилдэг илгээлтийн эзэн болдоггүй.

Өөрийнх нь цэрэг армийн ар талд зогсдог, хангамжийн ажилтнууд гэж Бурханд байдаг. Ялалт ирэх хүртэл, өдөр бүр санаа сэтгэлээ чилээн, итгэмжтэй залбирдаг дайчид гэж бий. Зарим нь фронтын шугам руу илүү их мөнгө явуулахын төлөө золиос гарган ажилладаг итгэмжит нярвууд. Зарим нь дайсантай нүүр тулан учирдаг хүмүүсийг хоол байраар хангадаг. Алс нутаг руу Бурханы үгийг хүргэхээр ном бичиж суугаа хүмүүсийг ч бас бодож

үз. Христэч ном зохиолыг хянан засварлаж, орчуулж, хэвлэдэг хүмүүсийг ч бас бод. Хаан Есүсийн үйлчлэлд бэлтгэн, охид хөвгүүдээ хүмүүжүүлж гэртээ суугаа эмэгтэйчүүд ч гэсэн байгаа. Тулаанд гар бие оролцож байгаа хүн нэг бүрийн ард, арын албыг нь хариуцдаг хангамжийн ажилтнууд гэж байдаг.

Шагнал гардуулах болоход тэдгээр арын албаныхан тулаанд эрэлхгээр оролцсон хүмүүстэй ижил хувь хүртэх болно. Фронтын ард чимээгүйхэн үйлчилж байсан хүмүүс сайнмэдээний төлөө нэр алдраа цуурайтуулагсадтай ижил хүндлэлийг хүртэнэ.

Бурхан бүгдийг нь ялгаж салгах чадвартай. Хэн нь ямар хувь нэмэр оруулсан бэ гэдгийг Тэр үнэн зөвөөр дүгнэж чадна. Ач холбогдолгүй санагдсан олон хүн өндөр байр суурийг эзэлнэ. Тэд үгүй бол бид мөхөс билээ.

## 7 сарын 31

*"Үнэнээр Би та нарт хэлье. Хэн Миний төлөө болон сайнмэдээний төлөө гэр орон эсвэл ах эгч дүүсээ эсвэл эцэг эх эсвэл хүүхдүүдээ эсвэл эдлэн газраа орхино, тэр одоо энэ үед гэр орон, ах эгч дүүсээ, эхээ, хүүхдүүдээ, эдлэн газраа хавчлагатай хамт зуу дахин илүү авна. Мөн ирэх үед мөнх амийг авна."* (Мк 10:29,30)

Хамгийн ашигтай хөрөнгө оруулалт бол амьдралаа Есүс Христийн төлөө зориулах юм. Аливаа хөрөнгө оруулалтыг авч үзэхдээ хэр баталгаатай, ямар ашиг өгөх вэ гэдгийг чухалчилдаг. Энэ үүднээс бодвол, Бурханы төлөө зориулсан амьдралаас илүү сайн хөрөнгө оруулалт гэж байхгүй. Энэ хөрөнгө оруулалт нь туйлын найдвартай. Яагаад гэвэл Бурхан бидэнд хариуцуулснаа хамгаалах чадалтай. (2Тм 1:12) Ашгийн тухай яривал, энэ хөрөнгө оруулалтын үр ашиг хэмжээлшгүй их.

Өнөөдрийн эшлэлийг үзвэл, Эзэн Есүс зуу дахин нугалж өгөхөө амлажээ. Энэ нь 10,000 хувийн хүү юм. Энэ дэлхий дээр ийм өндөр хүүтэй хөрөнгө оруулалт хаа ч байхгүй. Гэхдээ ингээд болчихгүй.

Эзэн Есүс Христэд үйлчлэхийн тулд гэр орон, тав тухаа орхисон хүмүүсийг, Есүсийн төлөө Бурханы сайхан сэтгэлийг харуулах олон хүний халуун дулаан гэр орон хүлээж байна.

Сайнмэдээний төлөө гэрлэлтийн аз жаргал, гэр бүлийн холбоо сүлбээгээ умартсан хүмүүсийг даян дэлхийн гэр бүл, цусан төрлөөс ч дотно олон найз нөхөд хүлээж байна.

Эдлэн газраа орхисон хүмүүс Есүсийн нэрийн төлөө улс орнууд, тив дэлхийг ч эзэмших илүү агуу хувь тавиланг олж авна.

Түүнээс гадна, Эзэн Есүс хавчлагыг амласан. Анх сонсоход хэцүү даваа мэт санагдаж магад. Гэвч Эзэн Есүс хавчлагыг хөрөнгө оруулалтын нэг сайн ашиг хэмээн хэлсэн. “Христийн төлөө буруутгагдах нь Египетийн эрдэнэсээс агуу их баялаг мөн.” (Евр 11:26)

Эдгээр нь энэ амьдралдаа авах ногдол ашиг. Эдгээрийн дээр Эзэн Есүс, “Ирэх үед мөнх амийг авна” гэж нэмж хэлсэн. Энэ нь мөнх амийг бүрэн дүүрнээр авах цаг үе рүү харж байна. Мөнх амь нь өөрөө итгэлээр ирдэг бэлэг боловч мөнх аминд орсон хүмүүсийн авах шагналын хэмжээ өөр өөр. Есүсийг дагахын тулд бүхнээ орхисон хүмүүс ирээдүйн тэр жавхлант хотод бусдаасаа илүү агуу шагнал авна.

Бурханы төлөө амьдралаа зориулах нь ийм их ашигтай гэдгийг мэдсээр байж үүнд хөрөнгө оруулдаг хүн цөөн байдаг нь хачирхалтай. Хөрөнгө оруулагчид хувьцаа ба бондын тал дээр маш ухаалаг үнэлгээ хийдэг хэр нь дэлхийн хамгийн сайн хөрөнгө оруулалтыг бодож үздэггүй нь сонин.

## 8 сарын 1

*"Зохимжтой хэлсэн үг мөнгөн хээ угалзны дундах алтан алим мэт буюу." (Сур 25:11)*

Мөнгөн хээ угалзанд алтан алим шигтгэх нь үнэхээрийн зохицолтой харагдана. Цагаа олсон үг үүнтэй яг ижил. "Онож хэлсэн хариултад хүн бүр баярладаг. Цагаа олсон үг юутай сайхан бэ!" (Сур 15:23).

Нас дээр гарсан илгээлтийн эзэн эмэгтэй хорт хавдрын улмаас хэзээ мөдгүй нас барах гэж байлаа. Ухаан санаа нь эрүүл боловч тамир тэнхээ доройтсон учраас ярьж чадахгүй байв. Оройны эргэлтийн цаг дуусахын өмнөхөн бурханлаг нэгэн ахлагч түүн дээр иржээ. Тэрээр орных нь хажууд зогсоод Соломоны дуун 8:5-аас эш татан, "Эзгүй хээрээс хайртаа түшсээр ирж яваа тэр хэн бэ?" гэж хэллээ. Настай эмэгтэй нүдээ нээн инээмсэглэв. Энэхүү шаналант ертөнцөд сонссон хамгийн сүүлийн үг нь энэ байлаа. Тэрээр үүр хаярахын өмнө энэхүү эзгүй хээрийг орхихдоо Хайртыгаа түшсээр оджээ. Энэ нь цагаа олсон үг байсан юм.

Хайрт хүнээ алдсан гэрийнхэн нь гуниг харуусалдаа дарагдан нам гүмхэн байцгаана. Найз нөхөд нь гашуудлын номлолыг тойрон зогсоцгооно. Хэн ч юу хэлэхээ эс мэднэ. Тэгэхэд доктор Х. А. Айронсайдаас ирсэн захидалд "Шөнөд уйлаан байж болох ч, өглөөд баярын уухай ирдэг" хэмээн Дуулал 30:5-аас эш татсан байлаа. Эзэнээс ирсэн энэ үг яг л цагаа олж гуниг гашуудлын гинжийг таслав.

Хэсэг бүлэг залуу итгэгчид холын аянд явж байв. Гэтэл нэг нь хичээл дээрээсээ сонссон Библийн талаарх эргэлзээтэй асуудлаар яриа эхлэв. Яриаг сонсож байсан

хүмүүсийн дундаас нэг нь Сургаалт үгс 19:27-оос эш татаж, "Хүү минь, сургамж үл сонсвоос мэдлэгийн үгсээс төөржү" хэмээн хэлжээ. Энэ үг мөнгөн хээн дундах алтан алим байлаа.

Ингерсоллын талаар нэгэн алдартай түүх байдаг. Тэрээр олон үзэгчдийн өмнө зогсоод "Хэрэв Бурхан гэж байдаг бол таван минутын дотор намайг ниргэж үхдэл болго" хэмээжээ. Таван минут ч өнгөрлөө. Хүмүүс яах нь вэ гэсэн мэт түүнийг ширтэцгээнэ. Таван минут өнгөрөхөд Ингерсолл амьд байгаа нь Бурхан гэж байдаггүйг нотолсон нь тэр ажээ. Гэтэл үзэгчдийн дундаас нэгэн итгэгч босож ирээд "Ноён Ингерсолл, та таван минутын дотор Бурханы өршөөл нигүүлслийг барчихна гэж санаа юу?" гэж асуужээ. Үнэхээр голыг нь олсон үг байлаа.

Зөв цагт оновчтой үг хэлэх нь яах аргагүй Бурханы бэлэг мөн. Бүгдээрээ энэ бэлэгт тэмүүлцгээе. Тэгвээс Бурханы Сүнс биднийг ашиглаж, оновчтой үгээр бусдыг тайтгаруулж, урамшуулж, анхааруулж, зэмлэж чадна.

## 8 сарын 2

*"Тэд үүлэн дотор байхдаа ихэд айжээ." (Лк 9:34)*

Петр, Иаков, Иохан нар Есүстэй хамт уулан дээр байлаа. Тэд түүхийн торгон мөчийн гэрч болсноо мэдэрч, яруу алдрыг нь ямар нэг байдлаар хадгалж үлдэхийг хүсжээ. Есүс, Мосе, Елиа нарт тус бүрд нь нэг цацар барьж өгье гэж Петр саналаа хэллээ. Энэ нь мэдээж Эзэн Есүсийг Хуучин гэрээний хоёр ариун хүний түвшинд аваачна гэсэн үг. Бурхан Петрийн саналыг тасалдуулж тэднийг үүлээр бүрхсэн. "Тэд үүлэн дотор байхдаа ихэд айжээ" гэж Лук тэмдэглэн үлдээсэн байна.

Тэдэнд айх шаардлага байсангүй. Учир нь энэ нь шүүлтийн биш, яруу алдрын үүл юм. Энэ нь түр зуурын үзэгдэл болохоос амьдралын байнгын зүйл биш байв. Хэдий харагдахгүй ч Бурхан үүлэн дотор байсан.

Заримдаа бидний амьдралд үүл ирдэг. Бид үүлэн дунд орохоороо дээрх гурван элчийн адил айж сандардаг. Жишээ нь, Бурхан биднийг үйлчлэлийн шинэ талбарт дуудахад үл мэдэхүйн айдас биднийг нөмрөн авдаг. Ирэх аюул, тав тухгүй байдал, таагүй нөхцөл байдал гээд тохиолдож болох хамаг муу бүхнийг төсөөлнө. Үнэндээ бид ерөөгдөхөөс айж байгаа хэрэг юм. Үүл алга болоход Бурханы хүсэл нь сайн бөгөөд төгс байсныг бид олж харна.

Бид өвчин зовлонгийн үүлэнд орохоороо айдаг. Бодол сэтгэлд маань аюулын харанга дэлддэг. Эмчийн царайн дахь хөдөлгөөн бүрийг, амнаас гарах үг болгоныг үхлийн дохио юм шиг ойлгодог. Өвчний шинж тэмдэг болгоноос эдгэшгүй өвчин тусчихлаа гэж онош гаргадаг. Гэтэл өвчин эдгэрч нөхцөл байдал сайжрахад "Миний зовон шаналсан



нь, Таны зарлигуудыг сурах болсон нь надад тустай" (Дуу 119:71) хэмээн хэлж чаддаг. Бурхан үүлэн дунд байсан бөгөөд бид түүнийг нь мэдээгүй ажээ.

Бид гуниг гашуудлын үүлэн дунд орохоороо айдаг. “Энэ их нулимс, сэтгэлийн өвдөлт надад ямар сайныг авч ирж чадах юм бэ?” гэж бид асуудаг. Хамаг ертөнц маань нуран унах шиг санагддаг. Гэвч тэр үүлэн дотор бид олон зүйлийг сурдаг. Эзэн биднийг тайтгаруулж байсны адил бусдыг тайтгаруулахыг суралцдаг. Бурханы Хүүгийн нулимсыг урьд өмнөхөөсөө илүү ойлгож эхэлдэг.

Амьдралд үүл буухад бүү айгаарай. Тэр үүл биднийг нураадаггүй, харин барьж босгодог бөгөөд түр зуурынх. Тэр үүл Эзэний царайг халхалж болох ч хайр ба хүчийг нь халхалж чадахгүй.

Тиймээс бүгдээрээ Уиллъяам Ковферийн үгээр зүрхээ чангалцгаая:

*Ариун хүн та айхаа больж зориг ор  
Айлгаад байгаа тэр үүл чинь  
Энэрэл өршөөлөөр дүүрэн бөгөөд  
Ивээл ерөөлийг тан дээр цутгана*

## 8 сарын 3

*"Тэрээр хүний хөлд ч баярладаггүй."* (Дуу 147:10)

Энэ үгийг спортын ертөнцтэй холбон ойлгож болно. Уян хатан, хурдан шалмаг гүйлтийн тамирчин барианы шугамыг давж, гараа өндөрт өргөн түрүүлснээрээ бахархана. Сагсан бөмбөгийн тоглогч чадварлаг хууралт хийж урагш давшин хожлын бөмбөгийг оруулна. Булчинлаг, хүчтэй хөл бөмбөгчин уран тоглолт үзүүлж, ялалтын гоолыг хийнэ.

Үзэгч олон дэвхцэж, орилж, уухайлж, хөгжөөн дэмжигчид нь сэтгэл зүрхээрээ тоглолттой хамт байна. Үүнийг хүний хөлд баярлах гэж Библийн үгээр хэлж болох юм.

Өнөөдрийн эшлэл спортын сонирхлыг хориглосон утгатай бишээ. Биеийн дасгал хөдөлгөөний үнэ цэнийг Библи сайшаадаг. Гэхдээ “Бурхан хүний хөлд баярладаггүй” гэдэг нь юуг нэн тэргүүнд тавих ёстой вэ гэдгийг маань сануулж байна.

Залуу итгэгч хүн өөрийн сонирхсон спортоо амьдралынхаа гол хараа болгох тун амархан. Тэрээр амжилтад хүрэхийн тулд хамаг чадлаараа хичээж зүтгэнэ. Цаг нар, идэх хоол, унтах нойроо ч хатуу сахилгажуулна. Ур чадвараа сайжруулахын тулд өдөр шөнөгүй бэлтгэл сургуулилт хийнэ. Тэрээр дасгал сургуулилтын дэглэмийг сахиж, шилдэг тамирчин болохоор улайрна. Энэхүү спортынхоо тухай байнга бодож, амь амьдрал нь мэт ярина. Үнэндээ ч түүний амь амьдрал болжээ.

Заримдаа залуу итгэгчид “Бурхан хүний хөлд баярладаггүй” гэдгийг сонсохоороо урам хугардаг.

Бурхантай нөхөрлөж алхахыг хүсвэл Бурханы үзэл санааг хүлээж авах хэрэгтэй.

Тэгвэл Бурхан юунд баярладаг вэ? Дуулал 147:11-д бидэнд ингэж хэлж байна: "ЭЗЭН Өөрөөс нь эмээгчийг, энэрэл хайранд нь найдагчдыг таалдаг." Өөрөөр хэлбэл, Бурхан бие махбодоос илүү сүнслэг зүйлст анхаардаг байна. Элч Паул үүнтэй ижил санааг хэлсэн. "Учир нь биеийн дасгал нь өчүүхэн тустай. Харин одоогийн болон ирэх амийн төлөөх амлалт бүхий итгэл сүсэг нь бүх зүйлд тустай." (1Тм 4:8).

Өнөөдрөөс зуун жилийн дараа хүмүүсийн хөгжөөн дэмжлэг үгүй болж, цэнгэлдэх хүрээлэн хоосорч, авсан оноонууд мартагдахад, эхлээд Бурханы хаанчлал ба зөвт байдлыг хайсан амьдрал л үнэ цэнтэй хэвээр үлдэнэ.

## 8 сарын 4

*"ЭЗЭН зөвт. Тэрээр зөв үйлдэлд дуртай."* (Дуу 11:7)

Эзэн Өөрөө зөв шударга учраас Өөрийнх нь хүмүүс зөв шударга зантай байхыг харах дуртай. Итгэгчид Бурханы зарчим, шударга ёс зүйд нийцсэн сонголт хийх нь Бурханд таалагддаг.

Гэвч биднийх шиг ертөнцөд ийм сонголт хийх үргэлж амар байдаггүй. Ёс зүй хийгээд ёс суртахуунаа уландаа гишгэх сорилт бидэнд байнга тулгардаг. Зарим сорилт нь ил цагаан, зарим нь далд. Шулуун шударга алхахын тулд юмыг ялгаж салгадаг мэргэн ухаан ба хатуу зарчимч чанар хоёулаа хэрэгтэй.

Шударга бус зүйлсийг бүгдийг жагсаан бичнэ гэвэл боломжгүй. Гэхдээ ирээдүйн шийдвэрт чинь чиглүүлэг болохуйц хэдэн зүйлийг бичье.

Авлигал, хээл хахууль нь шударга бусын нэгэн хэлбэр юм. Хүний шийдвэрт нөлөөлөхийн тулд бэлэг өгөх нь ч мөн ялгаагүй. Өөрийн чинь дансанд хангалттай мөнгө байхгүй байхад хүмүүст итгэл найдвар төрүүлэн, хуурамч чек бичиж өгөх нь ч буруу. Бараа материал шуудангаар илгээхдээ задалж үзэхийг хориглоно хэмээн бичиж нэмэлт төлбөр төлөхөөс зугтах нь хууль бус. Даргыг чинь асууж хүн залгахад, хажууд чинь байсаар байхад, “Байхгүй” гэж хэлэх нь хууран мэхлэл мөн. Ажлын цагаа эсвэл компанийнхаа мөнгийг тухайн ажилд холбогдолгүй хувийнхаа хэрэгт зарцуулах нь ч буруу. Татварын тайланг өгөхдөө орлогоо багаар, зардлаа ихээр мэдүүлэх нь ч шударга бус явдал мөн. Даатгалын хуурамч нэхэмжлэл гаргах нь ялгаагүй шударга бус явдал. Ажлын цагийг

дэмий үрэх, ажлаа чанаргүй хийх зэрэг нь буруу. Магадгүй хамгийн түгээмэл зөвт бус явдал бол ажил олгогчийнхоо цагийг хувийн эрх ашигтаа зарцуулах явдал юм.

Хамаатан садан, найз нөхөд чинь буруутай байхад тэднийхээ талд зогсох нь зөвт байдал биш. Энэ нь үнэн хайр биш бөгөөд хуурамч үнэнч байдал юм. Буруутай этгээд нь хэн байсан ч нүглийн эсрэг үнэний талд зогсож байж л шударга ёс болно.

Үүний нэгэн адилаар, өрөвдсөн сэтгэлээс болоод хохирогчийн талд орж, нэг тал руу туйлшрах нь ч буруу. Энэ нь чуулганд хагарлыг бий болгож, буруутай этгээдийг улам хатууруулдаг.

Хүн өөрийнхөө хийгээгүй зүйлд буруутгалыг үүрэх нь ерөөсөө ч зөв биш. Амар тайвныг тогтоох дуртай зарим нэг хүн, буруутан гарч ирж буруугаа хүлээгээгүй байхад буруутгалыг хүлээж авах дуртай байдаг. Иймэрхүү золиосоор амар тайван бий болохгүй.

*Зоригтой бай дүү минь, бүү шантар*

*Зам чинь түнэр харанхуй байж болох ч*

*Замчлах од даруу хүнд гийдэг юм шүү*

*Зөвийг үйлд дүү минь, зөвхөн Бурханд найд*

(Норман Маклойд)

## 8 сарын 5

*"Хүний уур хилэн Бурханы зөвт байдлыг биелүүлдэггүй юм."* (Иак 1:20)

Нэгэн чуулганы ажлын уулзалт явагдаж байлаа. Сургаалын талаар биш, харин өргөтгөл барих, гал тогоог будах, санхүү мөнгийг хэрхэн зарцуулах тухай хуралдаж байв. Гэтэл санал зөрөлдөөн гарч, зарим нь уурлаж хашхичиж эхлэв. Энэ маргаанд хэл амтай хүмүүс нь дийлж, Бурханы ажлыг урагшлуулж чадлаа хэмээн мунхаглан бодоод гарч одлоо. Тэд ямар ч ажлыг бүтээсэн бай, Бурханы ажлыг лав ургашлуулаагүй нь тодорхой. Бурханы хүслийг ч биелүүлээгүй юм. Учир нь хүний уур хилэн Бурханы зөвт байдлыг биелүүлдэггүй.

Эмерсон үүнтэй адил маш их маргаан дагуулсан хурал уулзалтыг тараад явж байв. Уур бухимдал нь гараагүй алхаж явтал тэнгэрийн одод түүнд "Бяцхан залуу минь юундаа ингэтлээ уурлана вэ?" гэж хэлэх шиг санагджээ. Лэсли Вээдрхэд үүнд ийм тайлбар бичсэн: "Алс тэртээ оршигч үзэсгэлэнт одод цог жавхлан дундаа анир чимээгүй гялтганахдаа 'Бурхан чиний бүх асуудалд анхаарч чадах агуу их билээ. Чамайг түгшээж байгаа бүхэн харагдаж байгаа шигээ чухал биш ээ' гэж хэлэх шиг болдог."

Мэдээж зөв шударга уур хилэнгийн цаг гэж байдаг. Энэ нь Бурханы хүндлэлийг хамгаалах цаг юм. Гэхдээ Иаков хүний уур хилэнг ярьж байхдаа энэ тухай бодоогүй. Хүн өөрийнхөөрөө хийх гэж улайрч, болохгүй болохоор нь уурлаж уцаарладаг талаар Иаков бодож байсан. Өөрийнхөө бодлыг алдаа мадаггүй зөв гэж санасан бардам

хүн хийгээд бодлыг нь эсэргүүцэгчийг үл тэвчигч хүний тухай Иаков ярьж байна.

Энэ ертөнцийн хүмүүсийн хувьд уурлаж хашхичих нь хүч чадлын тэмдэг юм. Уураар тэд хүндлэлийг авч, бусдыг удирдаж болно гэж боддог. Тэдний хувьд даруу дөлгөөн зан нь сул доройн шинж.

Итгэгч хүн илүү сайн замыг мэднэ. Уурлан хилэгнэх үедээ хүндлэлээ алддагийг тэр мэднэ. Биеэ барьж чадахгүй уурлан хилэгнэх нь ялагдал юм. Энэ нь Сүнсний үр жимс биш, махбодын ажил билээ.

Христ бидэнд илүү сайн замыг заасан. Биеэ захирч, Бурханы уур хилэнд зай тавьж өгч, хүн бүрд даруу дөлгөөн хандахыг Тэр заасан. Буруу бүхнийг хүлцэн тэвчиж, нөгөө хацраа тавьж өгөхийг Тэр сургасан. Уурлаж бухимдах нь Бурханы ажилд саад болж, өөрийг нь үл итгэгчдээс ялгаагүй харагдуулдгийг итгэгч хүн мэднэ. Бурханыг гэрчлэхийн төлөө тэрээр уруулдаа манаач тавьдаг.

## 8 сарын 6

*"Замаар өнгөрөгч та бүгдэд энэ юу ч биш гэж үү? Дүрэлзэх хилэнгийнхээ өдөр ЭЗЭН надад учруулж энэлгэсэн тэр шаналал шиг шаналал байна уу? Хараач, үзээч." (Гаши 1:12).*

Заримдаа би Эзэний зоогийг барьж байхдаа “Би яах нь энэ вэ? Эзэний зовлонг бодож суухдаа нулимс минь яагаад үл урсана вэ?” гэж өөрөөсөө асуудаг.

Нэр нь үл мэдэгдэх нэг шүлэгч над шиг өөрөөсөө энэ асуултыг асуужээ:

*Христ ээ, загалмайн тань доор зогсоод  
Дусал дуслаар урсах цусыг тань харсан ч  
Сэтгэл минь шимширч уйлдаггүй би  
Хүн биш чулуунаас өөр юу байх билээ?  
Нар, сар ч харж чадалгүй нүүрээ нууж  
Тэнгэр бүүдийн харанхуй нөмөрсөн  
Газар дэлхий ч гашиуудахдаа тийчилсэн  
Гагцхүү би л яах ч үгүй зогсох юм  
Агуу Бурхан минь, ийм байж таарахгүй  
Амссан зовлонг тань би үл ухаарсан бололтой  
Эзэн Бурхан минь, надад ухааруулж өгөөч  
Энэ хад шиг сэтгэлийг хага цохиж хайрлаач*

Өөр нэгэн нь үүнтэй адил сэтгэлээр ингэж бичжээ:

*Биднийг хайрласан Хурга  
Цусаа урсган үхсэнийг харсаар байж  
Огтхон ч сэтгэл минь хөдөлдөггүй  
Би ер нь ямар гээч хүн бэ!*



Аврагч Эзэний үхэл ба зовлонг бодохдоо сэтгэл нь шимширч нулимс унагадаг өр нинжин хүмүүсийг би биширдэг. Жишээ нь миний үсчин, итгэгч найз Райлф Руокко байна. Заримдаа тэр үсийг минь засаж байхдаа Аврагч Эзэний зовлон шаналлын тухай ярьдаг. Тэгээд нулимс дуслуулан байж “Тэр яагаад миний төлөө амиа өгснийг би мэдэхгүй. Би чинь нүгэлт муу хүн шүү дээ. Гэсэн ч Тэр загалмай дээр Өөрийнхөө биеэр миний нүглийн шийтгэлийг үүрсэн” гэж хэлдэг.

Аврагч Эзэний хөлийг нулимсаараа угааж, үсээрээ арчиж, үнсэж, үнэт тосоор тосолсон нүгэлт эмэгтэйг би боддог (Лк 7:38). Тэрээр загалмайн үхлийг хараахан хараагүй байхдаа ч ийм ихийг мэддэг, энэ их боломж завшааныг хүртсэн надаас илүү сэтгэл нь өвдөж байжээ.

Яагаад би ийм мөс шиг цэвдэг юм бэ? Эр хүн уйлдаггүй гэж заалгаж өссөнтэй минь холбоотой юм болов уу? Хэрэв тийм бол, энэ сургаалыг хэзээ ч сонсоогүй болоосой. Загалмайн өмнө уйлах нь ичгүүр биш ээ. Харин уйлахгүй байх нь ичгүүр мөн.

Тиймээс би Иеремиагийн үгийг зээлдэж, “Өдөр, шөнөгүй би уйлахсан. Толгой минь ус, нүд минь нулимсны ундарга байсан ч болоосой!” (Иер 9:1) гэж залбирах ёстой. Миний нүглийг үүрсэн нүгэлгүй Аврагчийнхаа зовлон шаналал, үхлийг хараад би уйлах учиртай. Исаак Уотсын мөртүүд сэтгэл зүрхнээс минь ундрах ёстой:

*Эзэний минь загалмай өмнө минь харагдахад*

*Энэ нүүрээ би нуун далдалж чадахгүй нь*

*Өр зүрх минь талархлын үгсээр дүүрч*

*Өөрийн эрхгүй нүдний нулимс урсах юм.*

Эзэн минь ээ, нулимс унагадаггүй христитгэгч байхаас намайг хамгаалаач.

## 8 сарын 7

*“Гашуудагсдад үнсний оронд гоёл чимгийг, гашуудлын оронд баяр хөөрийн тосыг, гаслант сүнсний оронд магтаалын хувцас өгөх...” (Иса 61:3)*

Мессиа Өөрийг нь хүлээн авсан хүмүүстэй гайхамшигт солилцоо хийх тухай энэ эшлэлд дүрсэлжээ. Тэрээр үнсний оронд гоёл чимгийг, гашуудлын оронд баяр хөөрийг, гаслант сүнсний оронд магтаалыг өгдөг.

Бид Түүнд, дур зоргоороо явснаас болж шатаж үнс болсон амьдралыг, архи тамхинд сүйдэж үнс болсон биеийг авчирдаг. Бас төөрч тэнүүлчлэн үрэн таран хийж үнс болгосон он жилүүдийг, алдарч, тасарч, бүтэлгүйтэн үнс болсон найдвар ба мөрөөдлийг авчирдаг. Оронд нь бид юу авдаг бэ? Тэр бидэнд гоёл чимэглэлийг өгдөг. Сүйт бүсгүйн гялалзсан титэм бүхий гоёл чимгийг өгдөг. Ямар сайхан солилцоо вэ! “Нүгэлд боолчлогдон зүдэрсэн хүн, ариун Бурханы эхнэр болж хүндлүүлжээ.” (Ж. Х. Жовет) Долоон сүнсэнд олзлуулсан Магдалын Мариа бузар сүнснээс чөлөөлөгдөөд зогсохгүй Хааны охин болсон. Коринтчууд Түүн дээр ирэхдээ элдвийн ялзралд баригдсан байсан ч Тэр тэднийг угааж, ариусгаж, зөвтгөсөн.

Бид Түүнд гашуудлын нулимс авчирдаг. Энэ нь нүгэл, ялагдал, алдаанаас үүдсэн нулимс. Шаналал, зовлонгоос үүдсэн нулимс. Бүтэлгүйтсэн гэр бүл, дуулгаваргүй хүүхдүүдээс болсон нулимс юм. Энэ гашуун нулимсны талаар Тэр ямар нэг юм хийж чадах уу? Тийм ээ, Тэр чадна. Тэрээр нулимсыг минь арчиж, оронд нь баяр хөөрийн тосыг бидэнд өгдөг. Тэр бидэнд уучлалын баяр хөөр, хүлээн зөвшөөрөгдсөний баяр хөөр, гэр бүлийнхээ баяр

хөөр, амьдралын утга учрыг олсны баяр хөөрийг өгдөг. Тэрээр зовлонг амьдралыг минь хурим найрын баяр хөөрөөр сольдог.

Тэр биднээс гаслант сүнсийг зайлуулдаг. Энэ сүнс ямар гэдгийг бид бүгдээрээ мэднэ. Буруутгалын ачаа, харамсал халаглал, ичгүүр гутамшиг, ганцаардал, гачигдал, урвалт, айдас, зовнил бүхэн энэ сүнснийх. Тэрээр эдгээрийг бүгдийг нь зайлуулж, оронд нь магтаалын хувцас өмсгөдөг. Тэрээр аманд минь шинэ дуу хийж, Бурханыг магтах магтаалыг өгдөг (Дуу 40:3). Үглэн гомдлогч нь талархагч болно. Бурханыг доромжлогч нь Бурханд мөргөгч болно.

“Юутай сайхан! Юутай үзэсгэлэнтэй! Тэр миний бүх зовлонг ойлгодог. Би Түүнд зөвхөн зовлон гунигийг авирсан ч, амьдралыг минь Тэр үзэсгэлэн төгс болголоо.”  
(Гайтер)

## 8 сарын 8

*“...сайныг үйлд, хариу харж бүү зээлдүүл. Тэгвэл шагнал чинь агуу болно...” (Лк 6:35)*

Эзэн Есүсийн энэ тушаал нь итгэгч хийгээд үл итгэгч бүх хүнд яаж хандах ёстойг минь хэлж байна. Харин бид итгэгч хүн санхүүгийн асуудалд хэрхэн хандах ёстой талаас нь энэ эшлэлийг авч үзье. Итгэгчдийн дундах хамгийн ноцтой маргаан зөрчлийн нэг нь мөнгөний асуудал байдаг нь их харамсалтай. Уг нь ийм байх ёсгүй. Гэвч “Мөнгө хаалгаар орж ирэхэд хайр цонхоор гарч оддог” гэсэн хуучны үг хаана ч адил ажээ.

Уг нь ариун хүмүүсийн хоорондох бүх мөнгөний харилцааг хориглочихвол энэ бүх асуудал шийдэгдэнэ. Гэвч Библи дээр “Гуйсан хүнд өг,” “Хариу харж бүү зээлдүүл” (Лк 6:30, 35) гэж хэлсэн болохоор ингэх боломжгүй. Тиймээс Бурханы үгийг дагахын сацуу нөхөрлөлөө эвдэхгүй, хэрүүл маргаан гаргахгүй байлгах хэд хэдэн зарчмыг хэлж өгье.

Юуны түрүүнд, үнэхээр хэрэгцээтэй хүнд л өгөх хэрэгтэй. Ингэхдээ ямар ч болзол тавьж болохгүй. Өгсөн зүйл маань тухайн хүнийг бидний өмнө үүрэгтэй болгож, чуулганы хуралд бидний төлөө санал өгөх, эсвэл буруу үед минь бидний талд зогсох гэх мэт үүрэгт унагаж болохгүй. Бид сайхан сэтгэлээрээ хүмүүсийг “худалдаж авах” ёсгүй.

“Гуйсан хүнд өг” гэсэн тушаалыг хэрэгжүүлж болохгүй тодорхой хэдэн тохиолдол бий. Тухайлбал мөрийтэй тоглоом, архидан согтуурал, мансуурлыг санхүүжүүлэх гэсэн хүнд өгч болохгүй. Мөн хүний

шуналыг тэжээдэг, баян болгоно гэж амладаг тогтолцоог ивээн тэтгэж болохгүй.

Бид ямар нэг үнэ цэнтэй зорилгын төлөө мөнгө өгөхдөө, хариу ирэхгүй байсан ч хамаагүй гэсэн хандлагатай байх ёстой. Эргүүлж төлөхгүй байх нь нөхөрлөлд минь нөлөөлөх ёсгүй. Мөн зээлийн хүү бодож болохгүй. Хуулийн дор амьдарч байсан иудей хүн өөр иудей хүнээс хүү авч болохгүй (Лев 25:35-37) байсан юм бол, нигүүлслийн дор амьдардаг христэч хүн ах дүү болсон бусад итгэгчээсээ хүү авах нь хэр зохимжтой вэ?

Хэрэв юм гуйсан хүн үнэхээр хэрэгцээтэй байгаа эсэхийг баттай мэдэх боломжгүй бол гуйсан юмыг нь өгөх хэрэгтэй. Магадгүй тэр нь жинхэнэ хэрэгцээ биш байж ч болно. Гэсэн ч нигүүлслийн зарчмаар үүнийг хийх хэрэгтэй.

Нэмж хэлэхэд, авагч нь өгөгч этгээдийнхээ эсрэг гомдол хорсол гаргадаг гэдгийг мэдэж байвал зохино. Энэ бол бидний төлөх үнэ. Дизраелд өөрийг нь үзэн яддаг хүний тухай сануулахад тэрээр “Яагаад намайг үзэн ядаад байгааг мэдэхгүй. Ойрд би түүнд сайн зүйл хийж өгөөгүй л юмсан” гэжээ.

## 8 сарын 9

*"Тэр бүхнээ орхин босож, Түүнийг дагалаа." (Лк 5:28).*

Олны хөлийн газар ширээнд суугаад хүмүүсээс татвар хурааж байгаа Левийг төсөөлөн бодоорой. Хэрэв тэр бусдын адил татвар хураагч бол асар их хэмжээний мөнгийг Ромын төрд өгөлгүй хувьдаа завшсан байж таарна.

Тэр нэгэн өдөр Есүс түүний хажуугаар өнгөрөхдөө "Намайг дага" гэж хэлжээ. Энэ нь Левийн амьдралыг орвонгоор нь өөрчлөв. Тэрээр гэм нүглээ харж, амьдралынхаа утгагүй хоосныг ухаарч, илүү сайн зүйлсийн амлалтыг сонсжээ. Леви тэр даруй босож Есүсийг дагасан. Энэ үйлдэл нь Эми Кармайклын үгийг санагдуулдаг: "Намайг дага гэх Түүний дуудлагыг би сонслоо. Хэлсэн бүх үг нь энэ. Тэгэхэд энэ дэлхийд үнэлдэг байсан бүхэн минь утга учраа алдаж, сэтгэл зүрх минь Түүний хойноос явсан. Би босоод Түүнийг дагасан. Ердөө л тэр. Түүний дуудлагыг сонсоод хэн дагахгүй байх вэ?"

Леви буюу бидний мэддэгээр Матай нь Христийн дуудлагад хариулсан тэр өдрөө өөрийнх нь дуулгавартай байдал ямар агуу зүйлс авчрахыг мэдээгүй нь лавтай.

Юуны түрүүнд, тэрээр үнэлж баршгүй авралыг авсан. Тэр цагаас хойш Матай алхах биш гүйдэг болсон. Гуниг гашуудалтай байхдаа ч, өмнөх амьдралынх нь баяр хөөрөөс илүү баяр хөөртэй байдаг болсон. Тэр цагаас хойш Матай, Жорж Ваде Робертсон шиг "Амьдрал минь бүх талаар өнгө орлоо. Христгүй нүд хэзээ ч үүнийг харж чадахгүй" гэж хэлж чаддаг болсон.

Тэгээд зогсохгүй, Матай 12 элчийн нэг болж, Эзэн Есүстэй хамт явж, сургаалыг нь сонсож, амиллыг нь нүдээр үзэж, яруу алдарт мэдээг нь тунхаглаж, эцэст нь Аврагчийнхаа төлөө амиа өгсөн.

Матай нь анхны сайнмэдээг бичих боломж завшааныг хүртсэн. Матай бүхнээ орхисон хэдий ч Эзэн түүнд харандаагаа авч үлдэхийг зөвшөөрчээ. Матай тэр харандаагаар иудейчүүдийн жинхэнэ Хаан болох Эзэн Есүсийг дүрслэн зурсан юм.

Тийм ээ, Матай бүхнээ орхисон. Ингэснээрээ тэр бүгдийг олж авч, амьд явсны жинхэнэ утга учрыг олсон.

Хэзээ нэгэн цагт хүн бүрд Христийн дуудлага ирдэг. Бид тэр дуудлагад хариулж болно, эсвэл тэр дуудлагыг тасалж болно. Хэрэв бид дуудлагад хариу өгвөл Тэр биднийг мөрөөдсөнөөс минь ч илүүгээр ерөөнө. Ирсэн дуудлагыг тасалбал Өөрийг нь дагах өөр хүнийг Тэр олно. Харин бид дагаж болох илүү сайн Христийг хэзээ ч олж чадахгүй.

## 8 сарын 10

*"Тэнд зогсож байсан хүмүүс үүнийг сонсоод тэнгэр дуугарлаа гэгцгээв."* (Иох 12:29).

Бурхан тов тодорхой тэнгэрээс ярьсан. Зарим нь үүнийг тэнгэр дуугарлаа гэж ярьж байна. Тэд Бурхан гайхамшгийг байгалийн үзэгдэл хэмээн тайлбарлажээ.

Өнөөдөр ч гэсэн зарим хүн Бурханы гайхамшгийг ийм хандлагаар тайлбарладаг. Тэд гайхамшгийг байгалийн нэгэн тохиолдол хэмээж, жирийн үзэгдлээс өөр юу ч биш гэж тайлбарлахыг оролддог.

Зарим нь харин, Бурхан гайхамшиг хийхээ больсон гэж хэлдэг. Бурхан цаг үе болгонд өөрөөр ажилладаг бөгөөд гайхамшиг болдог цаг ард хоцорсон гэж тэд хэлцгээдэг.

Гурав дахь төрлийн хандлага нь эдний яг эсрэг тал буюу юу ч болоогүй байхад өөрсдийн төсөөллөө гайхамшиг боллоо гэж тунхагладаг туйлшрал юм.

Зөв хандлага нь юу вэ гэвэл, Бурхан гайхамшиг үйлдэж чадна, одоо ч үйлддэг гэх итгэл юм. Бурхан хүссэн бүхнээ хийж чадна. Тэр Өөрийгөө илчлэхийн тулд гайхамшиг хийхээ больсон гэж үзэх ямар ч үндэслэл Библид байхгүй.

Хүн Сүнсээр дахин төрөх болгонд гайхамшиг болж байдаг. Энэ нь Бурханы хүч чадлын илэрхийлэл. Хүнийг харанхуйн хаанчлалаас аварч, Бурханы хайрт Хүүгийн хаанчлалд оруулахаас илүү агуу гайхамшиг гэж үгүй.

Анагаахын шинжлэх ухаан арга мухардаж, хүний бүх найдвар тасрах үед эдгэрлийн гайхамшиг болох нь бий. Итгэлийн залбирлын хариуд Бурхан заримдаа өвчтэй хүнд мутраа хүргэж түүнийг эрүүл болгодог.



Ямар ч мөнгөгүй болоход Бурханы хангамж ирдэг гайхамшиг бий. Эсвэл салаа замын уулзвар дээр зогсоод хаашаа явахаа мэдэхгүй үед замчлахын гайхамшиг байдаг.

Бурхан Өөрийн хүмүүсийг хамгаалдаг гайхамшиг гэж бас байна. Аймшигт осол аваараас шалбархай ч үгүй гарч ирдэг тохиолдлууд байдаг.

Бурхан одоо ч гайхамшиг үйлдсээр байгаа. Гэхдээ заавал хоорондоо адилхан байх албагүй. Тэрээр Египетэд буулгасан арван гамшгаа дахиж хэзээ ч буулгаагүй. Есүс Христ өчигдөр, өнөөдөр, үүрд хэвээрээ ч гэсэн нэг хэрэглэсэн аргаа дахин хэрэглэнэ гэсэн үг биш ээ. Тэр дэлхий дээр байхдаа нас барсан хүнийг амилуулсан гээд өнөөдөр нас барсан хүмүүсийг амилуулна гэсэн үг биш.

Эцэст нь хэлэхэд, гайхамшиг болгон Бурханаас байдаггүй. Диавол болон түүний чөтгөрүүд илбэ шид үйлдэж чаддаг. Ирээдүйд Илчлэл 13 бүлэгт гардаг хоёр дахь араатан өөрийн үйлдэх илбэ шидээр дэлхийн оршин суугчдыг мэхэлнэ. Өнөөдөр ч гэсэн бид гайхамшиг гэсэн болгоныг Бурханы үгээр болон хүмүүсийг чиглүүлж байгаа зүг чигээр нь шалгах ёстой.

## 8 сарын 11

*"Бид ухаанаа алдсан бол энэ нь Бурханы төлөө юм."* (2Ко 5:13)

Бурханы армид юмыг бусдаас өөр хийдэг хүмүүс байдаг. Ихэвчлэн энэ хүмүүс хамгийн агуу ялалтыг байгуулдаг. Эзэний төлөө гэсэн гал халуун сэтгэл нь тэднийг этгээд гажууд харагдуулдаг. Тэд уламжлалт арга барилд баригддаггүй. Тэд дандаа хүний бодож санаагүй юмыг ярьж хийж байдаг. Тэд англи хэлийг эвдэж, сургаал номлол заах тогтсон дүрэм журмыг зөрчдөг. Гэсэн ч тэд Бурханы хаанчлалд асар их олз авчирдаг. Тэд хүмүүсийг алмайруулсан үйлдэл олныг хийдэг ч хэзээ ч мартагддаггүй.

Юмыг бусдаас өөр хийдэг энэ хүмүүс ном журмыг баримтлагч нарыг байнга эвгүй байдалд оруулж, нийгмийн хэвшмэл ойлголтыг эвддэг. Бусад итгэгч тэднийг өөрчилж, хэвийн хүн шиг болгох гэж оролдон, галыг нь унтраах гэж хичээдэг. Гэвч чуулганы тусын тулд тэдний оролдлого бүтэлгүйтдэг.

Итгэхэд хэцүү байж болох ч, бидний Эзэн бас Өөрийн цаг үедээ этгээд гаж харагддаг байсан. "Тэрээр ажилдаа халуун сэтгэлээр ханддаг учраас заримдаа юм ч идэх завгүй байлаа. Тийм болохоор ээж, дүү нар нь Түүнийг гэр рүүгээ авч явах гэж ирсэн. Яагаад гэвэл тэд Түүнийг солиорчхож гэж бодсон. Тэд Түүнийг "ухаанаа алджээ" гэгцгээж байлаа. Гэхдээ эрүүл ухаантай нь Түүний дүү нар биш Есүс Өөрөө байсан юм." (В. Макинтош Макги)

Хүмүүс элч Паулыг этгээд гажууд гэж буруутгажээ. Паул өөрийг нь буруутгагсад хандан "Бид ухаанаа алдсан бол энэ нь Бурханы төлөө юм" (2Ко 5:13) гэж хэлсэн.

Юмыг бусдаас өөр хийдэг Бурханы хүмүүсийн нэг нь, урд хойноо бичигтэй хавтан зүүгээд явж байсныг би сонсож байлаа. Хавтангийн урд талд "Би Христийн төлөө мунхаг" гэж, ард талд "Та хэний мунхаг вэ?" гэж бичсэн байлаа.

Бидний ихэнхийн маань асуудал бол бусдаас ялгарахгүй байж байгаад нийгэмд Бурханыг гэрчлэх гэж оролддог явдал юм. Бид бусдын адил байвал ямар ч өөрчлөлт гарахгүй. Ийм байвал Христийг шүүж байсан хашааны гадна өөрийгөө дулаацуулж зогссон Петрээс ялгаагүй болно.

Лондоны агуу номлогч Ровлэнд Хилл этгээд, бусадтай адилгүй хүн байлаа. Ч. Т. Стадд, Билли Брэй, ирланд сайнмэдээ тараагч В. П. Николсон нар ч ялгаагүй. Та тэднийг өөр байсан ч болоосой гэж бодож байна уу? Мэдээж үгүй. Бурхан тэднийг хэрхэн ашигласныг бодохоор харин ч тэдэнтэй адил болохыг бид хүсдэг биш үү? "Ямар ч үр нөлөөгүй эгэл жирийн хүн байснаас, үр нөлөөтэйгөөр мянган мянган удаа бусдаас ондоо амьдарсан нь дээр. Анхны хайр заримдаа бусдаас ондоо, содон үйлдэл гаргадаг. Гэхдээ үр нөлөөтэй байдагт нь Бурханд талархъя. Гэвч одоо зарим нь анхны хайраа алджээ." (Фрэд Мичель)

## 8 сарын 12

*"Зөрчилдсөн хүнээс анхны ба хоёр дахь удаагийн сануулгын дараа татгалз. Тийм хүн гажууд бөгөөд нүгэл үйлдэж, өөрийгөө ялладгийг мэд."* (Тит 3:10,11)

Зөрчилдсөн хүн [буруу номтон, гаж сургаалтан] гэдгийг бид ихэнхдээ итгэлийн үндсэн сургаалуудаас өөр үзэл баримтлалыг заадаг, номлодог хүн гэж ойлгодог. Тухайлбал МЭ 2-р зуунд амьдарч асан Ариус, Монтанус, Маркион, Пелагиус гэх мэт хүмүүсийг боддог.

Би энд буруу номтны энэхүү тодорхойлолтыг үгүйсгэх гээгүй. Харин илүү дэлгэрүүлэх гэж байна. Шинэ гэрээний утгаар буруу номтон гэдэг нь чуулганд хуваагдал үүсгэдэг, хоёрдугаар зэргийн ач холбогдолтой үзэл санааг номлогчдыг ч бас хэлдэг. Тэр хүн үндсэн сургаалуудыг баримталдаг байж болно. Гэхдээ өөрийн итгэлийн хүрээнийхний хүлээн зөвшөөрсөн итгэл үнэмшлээс өөрийг зааж, хүмүүсийн хооронд зөрчилдөөн үүсгэдэг.

Орчин үеийн ихэнх орчуулга “буруу номтон” гэхийн оронд “зөрчилдсөн хүн” гэж хөрвүүлдэг болсон. Зөрчилдөгч хүн нь чуулганд хагарал хуваагдал гаргасан ч гэсэн нэг л юмаа гөжүүдлэн ярьсаар байдаг. Библийн хаанаас ч харсан өөрийнх нь зөв гэж тэр хатуу итгэдэг. Тэрээр нэг үзэл санааг үргэлж ярина. Түүнийг хийл хөгжимчинтэй зүйрлэвэл ганц утастай хийлэн дээр ганц нот тоглохтой адил.

Түүний зан хандлага зөв биш. Ариун хүмүүсийн итгэлийг барьж босгодог Библийн түмэн сургаалыг тэрээр огт хайхрахгүй мөртөө хагарал үүсгэдэг нэг хоёр гажуудсан сургаалаа ярьсаар байна. Магадгүй эш

үзүүлэгийн тодорхой нэг өнцгийг байнга давтана. Эсвэл Сүнсний аль нэг билэг авьяасыг дэндүү чухалчилна. Эсвэл Калвинизмын таван тунхгийг үргэлж онцолно.

Чуулганы удирдагчид дур зоргоороо байдлыг нь зэмлэвч тэр үл гэмшинэ. Эднийг л ярихгүй бол Эзэнээс урвасан болно гэж өөрийгөө өмгөөлнө. Тэрээр ерөөсөө дуугүй болохгүй. Өөрийнх нь эсрэг гаргаж ирэх ямар ч маргаанд супер сүнслэг хариултууд түүнд бий. Чуулганыг хувааж зөрчилдүүлж байгаагаа тэр юман чинээ бодохгүй. "Хэрэв хэн нэг нь Бурханы сүмийг устгавал Бурхан тэр хүнийг устгана" (1Ко 3:17) гэсэн Бурханы мэдэгдэл ч түүнд нөлөөлөхгүй.

Библи ийм хүнийг гажууд, нүгэл үйлдэгч, өөрийгөө буруутгагч хэмээн хэлж байна. Тэрээр "ёс суртахууны доголдолтой" (Philips), "буруу бодолтой" (NEB), "хазайсан" (NIV) гэдэг утгаар гажууд юм. Библи тийм зан хандлагыг буруутгадаг учраас тэр нүгэл үйлдэгч мөн. Түүний эсэргүүцэл итгэл сүсгийн дүртэй боловч буруугаа тэр мэддэг. Ийм хүнд нэг хоёр удаа сануулаад гэмшихгүй бол түүнээс харилцаа холбоогоо таслах хэрэгтэй. Энэхүү сахилгажуулалт нь түүнийг мунхаглалаас нь аварч магад.

## 8 сарын 13

*"Хоёр буюу гурвуулаа Миний нэрээр хаана цуглана, тэнд Би тэдний дунд байна."* (Мт 18:20)

Есүс энэ үгсийг айлдахдаа, нүгэл үйлдчихээд гэмшихээс татгалзсан хүнтэй уулзаж буй чуулганы цугларалтын тухай хэлж байсан. Буруутныг гэмшүүлэх гэсэн бусад оролдлого амжилт олоогүй учраас түүний хэргийг чуулганы өмнө авчирна. Тэрээр чуулганы үгийг ч гэсэн сонсохгүй байвал түүнийг нөхөрлөлөөс хөөх ёстой. Чуулганы сахилгажуулал явагдаж буй тийм цуглаан дээр Эзэн Есүс хамт байна гэдгээ амласан.

Гэхдээ энэ эшлэл илүү өргөн хүрээг хамарна. Эзэн Есүсийн нэрээр хоёр буюу гурвуулаа хэзээ ч, хаана ч цугласан Тэр тэдний дунд байна. Түүний нэрээр цуглана гэдэг нь христэч цуглааны хувиар уулзана гэсэн үг. Түүний эрх мэдлээр цуглаж, Түүний нэрийн өмнөөс үйлдэнэ гэсэн үг. Түүн дээр гол хараагаа тавьж цуглана гэсэн үг. "Тэд элч нарын сургаалд мөн нөхөрлөлд, талх хуваалт, залбиралд өөрсдийгөө зориулдаг байлаа" (Үйл 2:42) гэсэнчлэн, эртний итгэгчдийн адилаар цуглана гэсэн үг. Христийг төвөө болгож, Түүн рүү цуглана гэсэн үг (Эх 49:10; Дуу. 50:5).

Итгэгчид ийнхүү цуглахад Эзэн Есүс тэдний дунд байхаа амласан. "Тэр хаа сайгүй оршигч биш үү? Тэр газар сайгүй оршдог. Тэр нэг мөчид бүх газар зэрэг оршдоггүй гэж үү?" хэмээн асуух хүн гарч магад. Мэдээж тийм. Гэхдээ ариун хүмүүс Өөрийнх нь нэр дээр цуглахаар Тэр онцгой замаар тэдний дунд байна гэж амласан.

“Тэнд Би тэдний дунд байна.” Яагаад бид цуглаан бүрийг алгасахгүй хамрагдах ёстойн хамгийн том шалтгаан энэ юм. Эзэн Есүс тэнд онцгой замаар байх болно. Түүний хамт байгааг мэдрэхгүй байж болно. Гэсэн ч Түүний амлалтыг барин, Тэр хамт байгаа гэж итгэлээрээ хүлээн авах ёстой. Гэхдээ олон тохиолдолд Тэр Өөрийн хамт байгааг онцгой замаар илэрхийлдэг. Тэнгэр бидэнд ойрхон ирсэн мэт үе байдаг. Бурханы үг зүрх сэтгэлд хүчтэй нөлөөлдөг цаг бий. Эзэний яруу алдар тухайн газрыг дүүргэж, хүмүүсийн зүрхэнд эмээн хүндлэл төрүүлж, нүдэнд нь нулимс хуруулах үе ч гардаг. Заримдаа Эзэний оршихуй онцгойгоор илчлэгдэхэд зүрх сэтгэл минь галаар шатдаг.

Эзэний энэ ариун айлчлалууд хэзээ ирэхийг таашгүй. Энэ нь бодоогүй цагт, санаагүй үед ирдэг. Хэрэв би цуглаандаа очоогүй бол магад энэ гайхалтай цагийг алдана. Эзэн Есүс үхлээс амилж, цог жавхлантай болсон биеэрээ тэр орой нь шавь нарынхаа дунд үзэгдэхэд тэдэнтэй цуг байгаагүй Томасыг сана (Иох 20:24). Энэ нь дахиж хэзээ ч харж чадахгүй яруу жавхлант мөч байлаа.

Христ Өөрийнхөө нэрээр цугласан хүмүүсийн дунд байдаг гэдэгт бид үнэн сэтгэлээсээ итгэх юм бол ерөнхийлөгч очно гэж хэлснээс илүү цуглаандаа тогтмол хамрагдахыг хүснэ. Өндийж чадахгүй өвчин тусаагүй л бол, үхэл ирээгүй л бол бид цуглаандаа явах ёстой.

## 8 сарын 14

*"Бурханы авах тахил нь эмтэрсэн сүнс юм. Эмтэрсэн, гэмшсэн зүрхийг Бурхан Та жигшихгүй." (Дуу 51:17)*

Бурханы сүнслэг бүтээлүүдийн дотроос итгэгч хүн эмтэрсэн зүрхтэй байхаас илүү гоо үзэсгэлэнтэй юм гэж энэ хорвоод үгүй. Ийм хүнийг Бурхан эсэргүүцэж чаддаггүй. Тэрээр "бардмыг эсэргүүцдэг" (Иак 4:6), харин эмтэрсэн даруу хүнийг эсэргүүцэж чаддаггүй.

Төрөлх чанараараа байгаа хүн бүгд эмтрээгүй байдаг. Бид яг л тэрслүү, гөжүүд, адгуу, зэрлэг илжигний дудран шиг. Бид Бурханы хүслийн хазаар, ногт, амгай, эмээлийг эсэргүүцдэг. Өөрсдийнхөө замаар явах гэж хөллөгөөнд орохыг хүсдэггүй. Бид эмтрээгүй үедээ Бурханы үйлчлэлд үл тэнцэнэ.

Христэд итгэх нь эмтэрч, даруу болох үйл явцын эхлэл юм. Гэмшсэн нүгэлтэн "Миний зүрх бардам байжээ, дотор минь дур зоргоороо авир оршдог. Тиймээс ч Бурханы хүслийг эсэргүүцэж, дайснуудад нь тусалж байлаа. Бурхан Та л намайг даруу болгов" гэж хэлж чадна. Христэд итгэснээрээ бид буулгыг нь өөр дээрээ авдаг.

Гэхдээ Христэд итгэчхээд дуртай зүгтээ тэнүүчилдэг зэрлэг адуу шиг байж болохгүй. Бид өөрсдийнхөө эрх мэдлийг Эзэн Есүст атгуулж сурах ёстой. Булгиж, өшиглөж, цовхчихгүйгээр амьдралаа Эзэнд даатгах хэрэгтэй. "Түүний замууд төгс. Тиймээс би хэрэгтэй хэрэггүй төлөвлөгөө гаргаж, өөрөө амьдралаа жолоодохоо больж, амьдралынхаа бүх удирдлагыг Эзэнд даатгая" хэмээн хэлдэг болох ёстой.



Бид эмтэрсэн сэтгэлийг зөвхөн Бурханы өмнө гаргаад зогсохгүй бусад хүний өмнө ч гаргах хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, биеэ тоосон, сэхүүн, бардам, өөртөө эрдсэн байхаа болино гэсэн үг. Гүтгүүлж, шударга бусаар буруутгагдах үедээ эрхийнхээ төлөө зогсож өөрийгөө хамгаалахаа ч болино гэсэн үг. Доромжлуулж, муулуулж байхдаа хариуг нь өгөх гэж оролдохгүй. Эмтэрсэн сэтгэлтэй хүмүүс буруугаа тэр даруй хүлээдэг. Бусдаас буруу хайдаггүй. Бусдыг өөрөөсөө дээр гэж үздэг. Хүмүүс хожимдож, ажилд нь саад болж, осол эндэл гаргаж, төлөвлөгөөгөө өөрчилж, урмыг нь хугалсан ч гэсэн тэд уурлаж бухимдахгүй, гайхаж алмайрахгүй, өрвөлзөхгүй. Амьдралд нь ямар ч хямрал ирсэн тайван тогтуун байдаг.

Гэрлэсэн хосууд эмтэрсэн зүрхтэй бол салах өргөдлөө хэзээ ч өгөхгүй. Эцэг эх ба хүүхдүүд эмтэрсэн зүрхтэй бол бие биеэ хүндэлж хайрлана. Эмтэрсэн зүрхтэй хөршүүд дундуураа хашаа хайс хатгахгүй. Эмтэрсэн зүрхтэй хүмүүсийн чуулганд үргэлж сэргэлт ирнэ.

Эзэний зоогийг барьж байх үед "Энэ бол та нарын төлөөх Миний бие мөн" гэсэн Эзэний үгийг бид сонсдог. Бидний төлөө гэмтэж, шархадсан биеийнх нь хариуд хүслээ орхиж, амьдралаа Эзэнд өргөө.

## 8 сарын 15

*"Алив шуналаас өөрсдийгөө хамгаал, болгоомжил."* (Лк 12:15)

Шунал бол хэрээсээ хэтэрсэн эд баялаг, өмч хөрөнгийг хүсэх хүсэл юм. Энэ нь илүү ихийг цуглуулъя гэсэн ховдог сэтгэл, хэрэг болохгүй зүйлсийн араас хөөцөлдсөн солиорол.

Шуналыг сэтгэл нь хэзээ ч ханадаггүй бизнесмен хүнээс харж болно. Тодорхой хэмжээний хөрөнгө цуглуулаад зогсоно гэж хэлдэг ч тэр цаг ирэхэд дахиад л илүүг тэр хүсдэг.

Эцэс төгсгөлгүй худалдан авалт хийдэг амьдралтай гэрийн эзэгтэйгээс бид шуналыг хардаг. Тэрээр дээврийн хөндий, гарааш, агуулахаа элдэв бусын зүйлээр пиг дүүргэдэг.

Христмасын болон төрсөн өдрийн бэлэг өгдөг уламжлалаас бид шуналыг хардаг. Хөгшин залуу ялгаагүй хэр их эд хогшил цуглуулснаараа амжилтыг дүгнэдэг.

Эд хөрөнгө хуваах асуудлаас бид шуналыг хардаг. Хэн нэгэн хүн нас барахад хамаатан садан, найз нөхөд нь эцсийн замд нь үдэх ёслол дээр нулимс дуслуулж дуусчхаад яг араас нь олзоо хуваан булаацалдах тас шувуу мэт, иргэний дайн эхэлж байгаа юм шиг эд хөрөнгийг нь булаалддаг.

Шунал бол шүтээн, шүтлэг (Еф 5:5; Кол 3:5). Энэ нь Бурханы хүслийн оронд хүний хүслийг тавьдаг. Шунал нь Бурханы өгсөн зүйлд сэтгэл үл ханаж, ямар ч үнээр хамаагүй илүү ихийг олж авах гэж улайрдаг.

Шунал бол худал хуурмаг. Материаллаг зүйлсээс амьдралын аз жаргалыг олж авч болно гэсэн хий төсөөллийг үүсгэгч. Э. Стэнли Жонс, хүссэн бүхэн нь тэр даруй биелдэг нэгэн эрийн тухай өгүүлдэг. "Тэрээр байшин хүсэхэд байшинтай болов. Тансаг машин хүсэхэд тэр даруй л гараад ирэв. Эхэндээ ч энэ бүхэн сэтгэл хөдөлгөм сайхан байсан ч сүүлдээ уйтгартай санагдаж эхэлжээ. Тэгэхээр нь тэр, 'Одоо ер нь больё. Би өөрөө ямар нэг юм бүтээж, ямар нэг зовлон амсмаар байна. Энд байснаас тамд байсан нь дээр юм' гэжээ. Хүсэл биелүүлэгч хариуд нь, 'Чи өөрийгөө хаана байна гэж бодоо вэ?' гэжээ."

Шуналаас болоод хүн хүссэн бүхнээ авахын тулд хэнтэй ч тохиролцож, хэнийг ч хуурч, ямар ч буруу юм хийхэд бэлэн болдог.

Шуналтай хүн чуулганы удирдагч болж болохгүй (1Тм 3:3). Рональд Сайдер "Эд хөрөнгөний шуналтай, юм цуглуулах дуртай хүмүүсийг ахлагчдын зөвлөлд сонгох биш сахилгажуулах нь Библид илүү нийцэх биш үү?" гэж асууж байна. Итгэгч хүн шуналдаа хөтлөгдөөд хууль бус аргаар мөнгө олох, луйвар хийх гэх мэт элдвийн шившигтэй үйлд хутгалдваас тэднийг чуулганы нөхөрлөлөөс зайлуулах хэрэгтэй (1Ко 5:11).

Шуналыг хүлээн зөвшөөрч түүнээс гэдрэг эргэхгүй аваас Бурханы хаанчлалд орж чадахгүй (1Ко 6:10).

## 8 сарын 16

*"Хэрэв хоол хүнс, хувцас хунар байвал эдгээрээр бид сэтгэл хангалуун байх болно."* (1Тм 6:8)

Энэ үгийг Иохан 3:16 шиг үнэхээр Бурханы үг гэж нухацтай хүлээж авдаг итгэгч цөөхөн. Идэх хоол, нөмрөх юм байхад л сэтгэл хангалуун бай гэж энд хэлсэн байна. "Нөмрөх юм" гэдэг нь хувцаснаас гадна толгой хоргодох орон байрыг хэлнэ. Өөрөөр хэлбэл, хүний үндсэн хэрэгцээ хангагдсан бол бид сэтгэл хангалуун байж, бусдыг нь Эзэний ажилд зарцуулах хэрэгтэй гэсэн үг.

Сэтгэл хангалуун хүнд мөнгөөр худалдаж авч болдоггүй онцгой чанар байдаг. Э. Стэнли Жонс: "Юу ч хүсдэггүй хүнд бүх юм байдаг. Юу ч үгүй байснаараа амьдралын бүх зүйлийг эзэмшдэг. Амьдралыг өөрийг нь хүртэл. Элбэг дэлбэг эд хөрөнгөгүй ч амьдралаас өчүүхэн багыг хүсдэг нь өөрөө түүний баялаг юм" хэмээжээ.

Рүдьярд Киплинг, Макгелийн Их Сургуулийн төгсөгчдөд мөнгө төгрөг, эрх мэдэл, алдар нэрийн хойноос бүү хөөцөлдөөрэй гэж зөвлөснийг гайхах юмгүй. Тэрээр "Хэзээ нэгэн өдөр та нар энэ бүхнийг ер хайхарч үздэггүй хүнтэй уулзах болно. Тэр үед та нар ямар ядуу гэдгээ мэднэ" гэсэн байдаг.

"Христэч хүн энэ дэлхий дээр хэдий чинээ цөөн юм хүснэ төдий чинээ аз жаргалтай амьдарна. Зүрхэнд нь Христ, нүдэнд нь мөнхийн улс байгаад амьдралын үндсэн хэрэгцээ нь хангагдсан байхад зовлон гуниг түүнд юу ч биш. Учир нь түүнд алдах юм гэж байдаггүй." (Уилльям Ч. Бюрнс)

Бурханы итгэлийн баатрууд сэтгэл хангалуун байдлыг эрхэмлэдэг байсан. Тухайлбал Давид Ливингстон, "Би Бурханы хаанчлалтай холбоогүй юуг ч хүсэхгүй байхаар шийдсэн" гэжээ. Вочман Ни, "Би өөртөө юуг ч хүсдэггүй. Бүхнийг Эзэний төлөө хүсдэг" гэж бичсэн байдаг. Хадсон Тэйлер "сэтгэл зовних цөөн юмтай байхын тансаглалыг " эдэлдэг хэмээн өөрийгөө хэлсэн байдаг.

Сэтгэл хангалуун байна гэхээр зарим нэгэн нь, ямар ч хүсэл зорилгогүй, тэмүүлэлгүй хүн гэж ойлгодог. Сэтгэл хангалуун хүмүүсийг тэд бусдын юмаар хүүдгэнэгч гэж хардаг. Гэвч энэ нь бурханлаг сэтгэл хангалуун байдал биш. Байгаадаа сэтгэл хангалуун итгэгч хүн хүсэл мөрөөдөл, тэмүүлэл дүүрэн бөгөөд ганц ялгаа нь материаллаг зүйлст биш, сүнслэг зүйлст ач холбогдол өгдөг юм. Тэрээр бусдыг завшдаг биш, харин хэрэгцээ гарсан хүмүүст өгч чадахын тулд ажиллаж хөдөлмөрлөдөг. "Бурхан шуналт сэтгэлийнх нь улангаслыг үхүүлсэн хүнийг сэтгэл хангалуун хүн гэнэ" гэж Жим Элиот хэлсэн.

## 8 сарын 17

*"Намайг хүндэтгэгчдийг Би хүндэтгэнэ."* (1 См. 2:30)

Эзэнийг олон аргаар хүндэтгэж болно. Үүний нэг нь Бурханы зарчим дээр хатуу зогсож, буулт хийхээс татгалзах явдал юм.

Адам Кларк залуу байхдаа торгоны худалдаачинд ажилладаг байжээ. Нэг өдөр дарга нь ирээд, хүнд торго зарахаар хэмжиж өгөхдөө торгоо сунгаж бай гэж аргыг нь зааж өгөв. Тэгэхээр нь Адам "Эрхэм ээ, таны торго сунах л байх. Харин миний ухамсар сунахгүй" гэж хэлсэн гэдэг. Хожим нь Бурхан энэхүү эрхэм хүнийг хүндэтгэн үзэж Адам Кларкын гэх тодотголтой Библийн тайлбар бичүүлсэн.

Эрик Лиддел олимпын тэмцээнд зуун метрт гүйх ёстой байлаа. Гэтэл хуваарь нь ням гарагт таарчихав. Үүнийг мэдсэн Эрик Лиддел тэмцээнд оролцож чадахгүйгээ менежертээ хэлэв. Ням гарагт уралдаанд оролцох нь Эзэний өдрийг үл хүндэтгээд, цаашлаад Эзэнийг Өөрийг нь үл хүндэтгэсэн хэрэг гэж Эрик үзсэн байна. Шүүмжлэлийн ширүүн шуурга дэгдэв. Түүнийг хүмүүс бусдынхаа оноог доош татагч, улс орноо гутаагч, шашны туйлшрагч хэмээн буруутгаж эхэлжээ. Гэсэн ч тэрбээр шийдвэрээсээ ухраагүй.

Тэмцээний хуваарийг харахад 220 метрийн гүйлт Эзэний өдөртэй давхцаагүй байгааг мэдсэн Эрик Лиддел өөрийнх нь гүйх зай биш байсан ч гэсэн уг зайнд гүйх зөвшөөрлийг менежерээсээ гуйлаа. Тэрээр эхний болон хоёр дахь тэмцээнд түрүүлж, улмаар хагас финалд шалгарчээ. Финалын тэмцээнд орох гээд гараа уруу алхаж

явтал нэг хүн түүнд жижигхэн цаас атгуулав. Цаасыг унштал "Намайг хүндэтгэгчийг би хүндэтгэнэ" гэж бичсэн байлаа. Тэр өдөр Эрик Лиддел түүрүүлээд зогсохгүй дэлхийн шинэ рекордыг тогтоосон юм.

Хожим нь Эзэн түүнд илүү том хүндлэлийг үзүүлж, алс дорнодод Өөрийн элчин сайд болгосон юм. Эрик Лиддел дэлхийн хоёрдугаар дайн дэгдэхэд япончуудад олзлогдож бөөнөөр хорих лагерьд нас барсан. Ийнхүү тэр итгэлийнхээ төлөө амиа өгөгсдийн титмийг хүртэх эрхтэй болсон юм.

Адам Кларк, Эрик Лиддел нар нь Иосеф, Мосе, Даниел, Эзэн Есүс нарын үлгэр жишээгээр алхсан хүмүүс билээ. Иосеф нь итгэмжит байдлаараа Бурханыг хүндэлж, өлсгөлөнгийн цагт ард түмнээ аврах эрхэм үүргийг хүлээн Бурханаар хүндлүүлсэн. Мосе нь Бурханд үнэнч байсны хариуд Израилийг Египетийн боолчлолоос аврах хүндлэлийг Бурханаас авсан. Даниел нь буулт хийгээгүйнхээ төлөө Персийн эзэнт улсад онцгой эрх мэдэлтэй хүн болсон. Хамгийн агуу нь Эзэн Есүс. Тэрээр ямар ч хүнээс илүү Эцэгийг хүндэлж, эргээд бүх нэрээс дээгүүр нэрийг хүртсэн.

## 8 сарын 18

*"Хуяг дуулгаа өмсөж буй хүн хуяг дуулгаа тайлж буй хүн шиг бүү сайрхаг."* (1Хд 20:11)

Энэ үгийг хорон муу хаан Ахаб хэлсэн ч гэсэн үнэний ортой. Бурханд итгэдэггүй хүн ч гэсэн заримдаа үнэн юм хэлэх нь бий.

Сирийн хаан Ахабыг доромжилж, байж боломгүй шаардлага тавьж, шаардлагыг эс биелүүлбээс халдан довтолж устгана хэмээн сүрдүүлсэн. Гэвч тулаанд сиричүүд ухарч, хаан нь амиа аврахаар зугтсан. Сирийн хаан бодит байдал дээр бардамнасан шигээ байж чадсангүй.

Өнөөдрийн энэ эшлэл Голиатад бас сайн зөвлөгөө болох байлаа. Голиат Давидыг хараад "Нааш ир, би чиний махыг огторгуйн шувууд, хээрийн араатанд өгье" гэж занасан (1См 17:44). Гэвч Давид дүүгүүрийнхээ ганцхан чулуугаар түүнийг унагасан. Аварга эрийн бардамнал ачир дээрээ нэмэр болсонгүй.

Залуу байхдаа бид өөрсдийн чадварыг хэтэрхий өндрөөр үнэлэх хандлагатай байдаг. Бид энэ ертөнц, махан бие, Сатаныг ганц цохилтоор унагах юм шиг санадаг. Дэлхий дахинд яагаад сайнмэдээ хүргээгүй юм бэ гэж настай итгэгчдийг буруутгах янзтай. Яаж хийдгийг нь тэдэнд харуулаад өгнө дөө гэж боддог. Гэтэл үнэндээ энэ маань хоосон ойворгон зангаас өөр юу ч биш. Тулаан дөнгөж эхэлж байхад бүгд дуусчихсан юм шиг хандах нь буруу юм.

Нэгэн цуглаан дээр эрч хүчтэй залуу номлогч номлож байв. Тэрээр анхаарлын төвд байгаадаа ихэд



сэтгэл хангалуун байлаа. Багийнхан дунд нь номлогчийн амьдралд гүнзгий нөлөө үзүүлсэн багш нь бас явж байв. Цуглааны дундуур нэг хүн багшаас нь “Та шавиараа бахархдаг байх даа?” гэж асуутал “Эзэний замаар эцэс хүртлээ явж чадвал тэгэлгүй яах вэ” гэж гэнэ. Залуу номлогч дотроо “Ийм сайхан орой яагаад онцгүй үг хэлж байгаа юм бол доо” гэж бодоод өнгөрчээ. Түүнээс хойш хэдэн жил өнгөрөхөд настай багшийнх нь зөв байж гэдгийг номлогч ойлгосон юм. Хуяг дуулгаа өмсөх нь гол биш. Тулаанаа дуусгах нь л хамгийн чухал.

Үнэндээ энэ амьдралд бидний тулаан хэзээ ч дуусахгүй. Тэнгэр дэх их Жанжиныхаа өмнө зогсох хүртэл дуусахгүй. Тэнд зогсох үед бид түүнээс жинхэнэ утга учиртай магтаалыг сонсох болно. Тэр ямар ч магтаал хэлсэн, сайрхах шалтгаан бидэнд үгүй. “Бид тусгүй боолууд. Бид зөвхөн юу хийх ёстойгоо л хийсэн” (Лк 17:10) гэж даруугаар хэлнэ.

## 8 сарын 19

*"Чи Бурханыг бүү хараа. Мөн ард түмнийхээ удирдагчийг бүү хараа."* (Гэт 22:28)

Бурхан Мосед хууль өгөхдөө эрх мэдэлтэй хүмүүсийн эсрэг хүндлэлгүй үг ярихыг хориглосон. Шалтгаан нь тодорхой. Удирдагч ба захирагчид нь Бурханы төлөөлөгч юм. "Бурханаас гадуурх эрх мэдлүүд гэж үгүй бөгөөд Бурханы тогтоосноор л байгаа тул дээд эрх мэдлүүдэд хүн бүхэн захирагд" (Ром 13:1). Захирагч нь "таны сайн сайхны төлөөх Бурханы үйлчлэгч юм" (Ром 13:4). Тухайн удирдагч Эзэнийг хувьчлан мэддэггүй байсан ч гэсэн Эзэний ажлыг хийж байгаа хүн юм.

Бурхан болон хүмүүн удирдагчийн хооронд маш ойр холбоо байдаг учраас Библи заримдаа тэднийг бурхан хэмээн нэрлэсэн. Жишээлбэл өнөөдрийн эшлэлд "Чи Бурханыг бүү хараа" гэж бичжээ. Энд хэлэгдэж байгаа бурхан бол төр засгийн эрх мэдэлтнүүд юм. Дуулал 82:1, 6 дээр Эзэн шүүгчдийг "бурхад" гэж нэрлэсэн. Тэр хүмүүс Тэнгэрбурхан гэсэн үг биш. Гагцхүү Бурханы элч төлөөлөгч учраас тийн нэрлэгдсэн юм.

Саул хаан Давидыг алах гэж оролдсон ч гэсэн Давид өөрийн хүмүүсийг Саулд гар хүрэхийг зөвшөөрөөгүй. Яагаад гэвэл Давид, Саулыг Эзэний тослогдсон хүн гэж үзэж байсан (1 См 24:6).

Паул тэргүүн тахилчийг таниагүйн улмаас зэмлэмэгцээ тэр даруй гэмшиж уучлалт гуйгаад "Ах дүү нар аа, би түүнийг тэргүүн тахилч гэж мэдсэнгүй. 'Ард түмнийхээ удирдагчийг бүү муул' гэж бичигдсэн байдаг" (Үйлс 23:5) гэж хэлсэн.

Эрх мэдлийг хүндлэх нь сүнслэг ертөнцөд ч хэрэгжинэ. Тухайлбал тэргүүн тэнгэрэлч Михаел Сатаны эсрэг доромжлолын шүүлт хийхийг үл зүрхлэн, зүгээр л “Эзэн чамайг буруушааг” (Иуд 9) гэж хэлсэн байна.

Эцсийн өдрүүдийн цөвүүн цаг ирсний нэг тэмдэг нь хүмүүс төрийн эрх мэдлийг доромжлох, айж эмээхгүйгээр эрх мэдэлтэй хүмүүсийн эсрэг ёрын мууг ярина (2Пт 2:10).

Эндээс хэлэх гээд байгаа сургамж тодорхой байна. Бид удирдагч, төрийн эрх мэдэлтнийг Бурханы албан хаагч гэж үзэж, улс төрийн бодлогыг нь зөвшөөрөхгүй байсан ч, зан чанарт нь дургүй байсан ч тэднийг хүндлэх ёстой. Юу ч болж байсан христэч хүн улс төрийн компанит ажилд оролцон "Ерөнхийлөгч бол өөдгүй новш" гэж уриа лоозон барьж зогсож болохгүй.

Харин түүний оронд "хаад болон эрх мэдэлтэй бүхний төлөө залбир. Тэгвэл бид итгэл сүсэгтэй бас хүндлэлтэй, тогтуун, төвшин амьдрах болно" (1Тм 2:2).

## 8 сарын 20

*"Та нарын тэвчдэг чинь сахилга баттай болохын төлөө юм. Бурхан хөвгүүдтэйгээ шигээ та нартай харьцдаг. Учир нь эцэг нь сахилгажуулдаггүй хүү хаа байна?"* (Евр 12:7)

Сахилгажуулах, сахилгажуулал, сахилгажуулсан гэх үгнүүд Еврей 12 дугаар бүлгийн эхний 11 эшлэлд 7 удаа гарчээ. Өнгөц уншсан хүн энэ үгийг буруугаар ойлгох магадлалтай. Үүнээс харахад, Бурхан хүүхдүүдээ байнга зодож байдаг ууртай аав мэт санагдана. Яагаад ингэж буруу ойлгогдож байна вэ гэвэл, сахилгажуулах гэдэг үгийг бид зөвхөн шийтгэлтэй холбож ойлгодог.

Сахилгажуулах нь Шинэ гэрээний хувьд түүнээс өргөн утгатайг мэдэж авбал таны санаа амрах байх. Энэ нь үнэндээ хүүхдийг сурган хүмүүжүүлэх гэсэн утгатай. Өөрөөр хэлбэл, хүүхдийг өсгөхөд шаардагддаг эцэг эхийн бүхий л үйл ажиллагааг энэ үг илэрхийлнэ. Кител сахилгажууллыг дараах байдлаар тодорхойлсон: "Хүүхдийг өсгөж, төлөвшүүлж, шаардлагатай чиглүүлэг, зааварчилгаа, сургаалаар хангаж, сахилга батыг бий болгох үйл явц".

Еврей номыг хүлээн авсан анхны итгэгчид хавчлага дунд байлаа. Бичээч энэхүү хавчлагыг Эзэний сахилгажууллын нэг хэсэг хэмээн ярьсан. Тэгвэл Бурхан хавчлагыг илгээсэн гэсэн үг үү? Мэдээж үгүй. Энэ хавчлагыг сайнмэдээний дайснууд өдөөн турхирсан. Бурхан итгэгчдийг нүглээс нь болж шийтгэж байсан хэрэг үү? Үгүй. Тэрхүү хавчлага нь Эзэнийг итгэмжтэйгээр гэрчилснээс нь болж гарч ирсэн. Тэгэхээр хавчлагыг

Эзэний сахилгажуулал гэж хэлсэн нь ямар утгатай юм бэ? Бурхан хавчлага болохыг зөвшөөрч, Өөрийн хүмүүсийн амьдралыг төлөвшүүлж, барьж босгоход хавчлагыг ашигласан гэсэн утгатай юм. Өөрөөр хэлбэл, Бурхан хавчлагыг ашиглаж Өөрийн хүмүүсийг цэвэршүүлж, төлөвшүүлж, Өөрийнхөө Хүүгийн дүртэй адил болгож байна гэсэн үг.

Иймэрхүү сахилгажуулал нь хэзээ ч сайхан санагддаггүй. Гантиг чулууг хасуураар чанга нүдэх хийгээд, алтыг цэвэршүүлэхийн тулд халуун галаар төөнөхийг бодоод үз дээ. Тухайн үедээ аль нь ч тийм амархан үйл явц биш боловч эцсийн үр дүнд нь гантиг чулуунаас уран баримал үүсэж, алт хог шаарнаасаа цэвэршүүлэгддэг.

Эзэний сахилгажууллыг басамжлах юм уу сахилгажуулал ирэх үед унжуу дорой болох нь бидэнд өөрт маань хортой. Сахилгажууллын хамгийн зөв хандлага бол Бурхан үүнийг ашиглаад намайг сургаж байна гэж бодох явдал юм. Тэгээд түүнээс үр ашгийг нь хүртэх гэж хичээх хэрэгтэй. "Түүгээр дасгалжсанд нь зөвт байдлын амар амгалан бүхий үр жимсийг гаргаж өгдөг" (Евр 12:11) гэж хэлсэн нь ийм л утгатай юм.

## 8 сарын 21

*"Чуулган дотор хэл ярихуйгаар түмэн үг хэлснээс бусдыг ч мөн сургахын тулд ухаанаараа таван үг хэлэхийг би хүсдэг."* (1Ко 14:19)

Итгэгчдийн цуглаанд тайлбаргүйгээр хэл ярихуйг ашиглахын тухай энд ярьж байна. Паул үүний эсрэг байр суурьтай байсан. Чуулганд хэлэгдэж байгаа үг бүр хүнд ойлгогдож, итгэгчдийг барьж босгох ёстой гэж тэр үзсэн.

Гэхдээ энэ эшлэлийг илүү өргөн хүрээнд ойлгож болно. Тухайлбал, бид ярьж байхдаа хүн бүрд сонсогдохоор чанга ярих хэрэгтэй. Эс бөгөөс гадаад хэлээр ярьж байгаатай адил болно. Сонсогчдын дунд хатуу чихтэй хүн үргэлж байдаг. Номлогчийн яриа сул байвал тэд ярьж байгаа зүйлийг ойлгох гэж зүдэрнэ. Хайр нь өөрийгөө биш бусдыг боддог учир сонсогдохоор чанга ярьдаг.

Түүнээс гадна, хайр нь бүх хүний ойлгож чадах энгийн үгсийг ашигладаг. Бидэнд энэ дэлхийн хамгийн агуу мэдээ байна. Хүмүүс энэ мэдээг сонсож ойлгох нь чухал. Хэрэв бид далд утгатай юм уу мэргэжлийн хэллэг ашиглавал зорилгодоо хүрч чадахгүй.

Нэг номлогч алс дорнодод очиж хүмүүст номложээ. Мэдээж орчуулагч ашигласан. Түүний сургаалын эхний өгүүлбэр нь "Хүмүүсийн бодлыг хоёр хэсэгт хувааж болно. Нэг нь бодит бодол, нөгөө нь хийсвэр бодол" гэсэн үг байлаа. Орчуулагч сонсогчдын дунд сууж байсан настай эмээ, хүүхдүүдийг хараад уг өгүүлбэрийг "Би алс холын Америк орноос та бүхэнд Есүсийн тухай ярихаар ирлээ" гэж орчуулжээ.

Саяхан би нэг христэч сэтгүүл уншиж байлаа. Тэр сэтгүүлд мэргэжлийн гэмээр маш олон үг агуулагдаж байв. Тухайлбал: "Нийт түүхийн категорийн норматив өгөгдөл, олон цар хүрээг хамраагүй боловч оршин буйн ач холбогдол бүхий бүтээл, ухамсрын босоо үргэлжлэл, баталгаажуулах зорилготой каноны хэл, хэмжигдэхүүний туйлын хязгаар дахь сонгодог учир холбогдол" гэх мэт үгнүүд байлаа. Ийм үгнүүдийг жирийн хүмүүс яаж ойлгох юм бэ? Мөнхийн утга учиртай мэдээг хүргэхийн тулд ийм хүнд үгнүүдийг ашиглахаас биднийг хамгаалж өгөөч.

Телевиз, радиогийн ихэнх хөтөлбөр гуравдугаар ангийн боловсролтой хүмүүс ойлгох түвшинд хийгддэг. Авралын тухай мэдээг энэ дэлхийд хүргэхийг хүсэж байвал энэ зарчмыг ашиглах ёстой. Бидний мэдээ тодорхой, ойлгомжтой байх хэрэгтэй. ХРИСТ НҮГЭЛТНҮҮДИЙН ТӨЛӨӨ ИРСЭН. Ийм л энгийн. Хэний ч ойлгохгүй хэлээр түмэн үг хэлснээс хэн бүхний ойлгодог таван үгийг хэлсэн нь хамаагүй дээр.

## 8 сарын 22

*"Би Эцэгтээ хараахан дээш очоогүй байгаа тул Надад гар бүү хүр."* (Иох 20:17)

Хүмүүсийн дуртай хүүхдийн нэгэн дуунд:

*Өршөөлт Христ энэ дэлхийд амьдарч ахуйдаа*

*Өөрийн сүргийнхээ хурга гэж*

*Бяцхан хүүхдүүдийг дуудсан*

*Эртний тэр түүхийг сонсохоор*

*Эзэн Есүс Христтэй хамт*

*Байсан ч болоосой гэж бодох юм*

Хэзээ нэгэн цагт та бидэнд ч гэсэн ийм хүсэл төрж байсан биз ээ. Бурханы Хүүг энэ дэлхий дээр биеэрээ алхаж явахад нь хамт байсан бол хэчнээн сайхан бэ гэж бодож байсан байх.

Гэхдээ өнөөдөр Түүнийг Бурханы үгээс, Ариун Сүнсээр дамжуулан таньж мэдэх нь Есүстэй биеэрээ уулзсанаас илүү гэдгийг ойлгох хэрэгтэй. Бид Есүсийн шавь нараас илүү ерөөлтэй тавиланг хүртсэн хүмүүс юм шүү. Ингэж бодож үзье: Матай Есүсийг Матайн нүдээр харсан. Марк Есүсийг Маркийн нүдээр харсан. Лук Есүсийг Лукийн нүдээр харсан. Иохан Есүсийг Иоханы нүдээр харсан. Харин бид сайнмэдээг бичсэн дөрвөн хүний нүдээр Есүсийг олж хардаг. Цааш нь бас бодож үзье. Бид энэ дэлхий дээр Есүстэй хамт байсан шавь нараас нь илүү Шинэ гэрээний бүхэл бүтэн илчлэлийг авсан.

Түүнээс гадна, бид Есүсийн үед байсан олон хүнээс илүү ерөөлт тохиолыг хүртжээ. Тэрээр Назар юм уу Капернаум хотод олон түмний дунд алхаж явахдаа зарим нэгэнтэй нь бусдаас илүү дотно байсан. Иохан дээд өрөөнд



Есүсийн өврийг түшиж байсан бол бусад нь арай зайтай байлаа. Тэгвэл өнөөдөр байдал өөрчлөгджээ. Аврагч Эзэн маань бүх хүнтэй ойр байдаг. Тэр бидэнтэй зөвхөн хамт биш, бас бидний дотор байдаг.

Мариа амилсан Эзэнтэй уулзах үедээ урьд өмнөх шигээ түүнд дөхөж ойртохыг хүссэн. Тэрээр Эзэний бие махбодын оршихуйг алдахыг хүсээгүй. Гэтэл Есүс түүнд "Би Эцэгтээ хараахан дээш очоогүй байгаа тул Надад гар бүү хүр" гэж хэлсэн. Өөрөөр хэлбэл "Мариа энэ дэлхий дээрх бодит биед минь бүү хүр. Ариун Сүнс удахгүй бууж ирнэ. Тэр цагт чи намайг урьд өмнөхөөсөө илүү, тодорхой, ойр дотно, бүрэн дүүрэн мэднэ" гэж хэлж байгаа юм.

Эндээс дүгнээд үзэхэд, газар дэлхий дээр Есүстэй хамт байхыг хүссэнээс одоо Түүнтэй хамт байх нь илүү сайхан зүйл гэдгийг ойлгох хэрэгтэй.

## 8 сарын 23

*"Учир нь Миний хүмүүс хоёр мууг үйлдсэн билээ. Тэд өөрсдөдөө ус тогтоон барьдаггүй эвдэрхий усан санг чулуу ухан хийхийн тулд амийн усны ундарга Намайг умартсан."*  
(Иер 2:13)

Усны ундаргыг усны саваар солих нь ашиггүй наймаа мөн. Ялангуяа тэр сав эвдэрхий бол бүр ч хэрэггүй. Усны ундарга гэдэг нь газраас ундарч гардаг цэвэр тунгалаг, цэв хүйтэн, хүний цангааг тайлдаг ус юм. Харин усны сав нь ус хадгалах зорилгоор хүмүүсийн бүтээсэн хиймэл сав. Саван доторх ус хөдөлгөөнгүй учраас амархан мууддаг. Уг сав эвдэрвэл ус гоожиж дуусаад, савны дотор бохирдол орж ирнэ.

Эзэн бол амийн усны ундарга. Түүний хүмүүс Бурханы дотроос мөнхийн ханамжийг олж чадна. Энэ ертөнц бол усны сав. Үнэндээ эвдэрхий усны сав. Энэ нь хүмүүст тааламж, аз жаргалыг амладаг боловч уг усны савнаас сэтгэл ханамжийг хайсан хүмүүс эцэст нь урам хугарна.

Мэри Бурханы үгийг уншиж цээжилдэг христэч айлд өсөж хүмүүжжээ. Гэвч тэр эцэг эхдээ тэрсэлж, гэрээ орхиж, өөрийнхөөрөө амьдрахаар шийджээ. Түүний амьдралд бүжиг нэн чухал байр эзэлж байлаа. Урьдын христэч орчинд өсөж торнисон дурсамжуудаа мартахыг хичээж, нэг бүжгээс нөгөө бүжгийн хооронд амьдарч байв. Нэг орой тэрээр бүжгийн талбай дээр хамтран бүжиглэгчтэйгээ бүжиглэж байтал хүүхэд байхдаа цээжилж байсан Библийн нэг эшлэл санаанд нь орж ирэв. "Учир нь Миний хүмүүс хоёр мууг үйлдсэн билээ. Тэд өөрсдөдөө ус тогтоон барьдаггүй эвдэрхий усан санг чулуу ухан хийхийн тулд

амийн усны ундарга Намайг умартсан." Бүжиглэж байх дундаа тэр өөрийн нүглийг ухаарчээ. Амьдрал нь ямар утга учиргүй байгааг ойлгож, Эзэн рүү эргэлээ. Үүнээс хойш тэр тасралтгүй бүжиг бүжиглэдэг амьдралаа зогсоож, дахиж бүжгийн талбайд очоогүй юм.

*Эвдэрхий савнаас ууж үзлээ би, Эзэн  
Энэ ус гэвч цангааг минь тайлсангүй  
Уух тусам улам ам хатаж  
Ундаалж ердөө чадсангүй  
Христээс өөр юу ч намайг  
Харин дүүргэж чадсангүй  
Эзэн Есүс Таны дотор л  
Энэ амь амьдрал, баяр хөөр байдгийг  
Эргэлзээгүй би одоо ухаарсан*

Тэр цагаас хойш Мэри энэ шүлгийг бичсэн хүнтэй ижил бодолтой болжээ.

"Энэ уснаас уух хүн бүр дахин цангана. Харин Миний өгөх уснаас уух хэн ч хэзээ ч цангахгүй. Харин Миний өгөх ус тэр хүний дотор мөнх амь өөд оргилох булгийн ус болно" (Иох 4:13,14). Эзэн Есүсийн энэ үгийн утга учрыг амьдралаараа ойлгож ухаарсан олон хүн байдаг.

## 8 сарын 24

*"Уйлахаас дуу хоолойгоо, нулимснаас нүдээ тэвчин барь. Учир нь үйлс чинь шагнагдана гэж ЭЗЭН тунхаглаж байна. Тэд дайсны нутгаас буцаж ирнэ."* (Иер 31:16)

Стефаны аав ээж илгээлтийн эзэд байлаа. Тиймээс тэрээр илгээлтийн талбарт өсөж өндийсөн юм. Стефан хүүхэд байхдаа христитгэлийг хүлээн зөвшөөрдөг байсан бөгөөд олон хүнийг Эзэн рүү эргүүлжээ. Дараа нь Америкт эргэж ирээд их сургуульд оров. Эхэндээ Христийг сайнаар гэрчилдэг байлаа. Гэвч удалгүй итгэлээсээ ухарч, нүгэлд хутгалдан, дорнын шашнуудыг сонирхож эхлэв.

Ээж аав нь амралтаараа гэртээ ирээд байдлыг хараад хэлэх үггүй болов. Тэд хүүгээсээ гуйж, учирлаж, загнаж, байдаг аргаа хэрэглэсэн боловч хүү нь ер ухаарсангүй. Сүүлд нь тэд хүүгийнхээ гурван найзтай амьдарч байсан газарт очиж үзэхэд үнэхээрийн сэтгэл өвдөм дүр зураг харжээ. Гэртээ ирээд уйлахаас өөр зүйл хийж чадсангүй.

Орондоо орж унтахыг хичээсэн боловч нойр нь хулжжээ. Тиймээс үүрийн дөрвөн цагт босоод чимээгүй цагаа хийцгээлээ. Хуваарь ёсоор тэд Иеремиа 31 дүгээр бүлгийг уншив. Нөхөр нь "Иеремиа л биш шүү!" гэж уулга алдлаа. Уйлж байсан эш үзүүлэгч Иеремиа тэдэнд тайтгарлыг өгөхгүй гэж бодохдоо ийн хэлжээ. Гэсэн ч Эзэн тэдний дотор ажиллаж, Иеремиа 31 дүгээр бүлгийг уншууллаа. 16 дугаар эшлэл дээр иртэл "Уйлахаас дуу хоолойгоо, нулимснаас нүдээ тэвчин барь. Учир нь үйлс чинь шагнагдана гэж ЭЗЭН тунхаглаж байна. Тэд дайсны нутгаас буцаж ирнэ" гэсэн үг гарч ирэв.

Өнөөдөр мянга мянган христэч эцэг эх, тэрслүү хөвгүүд охидынхоо төлөө гашуудаж, сэтгэл нь эмтэрч байна. Тэд хэчнээн залбиралч Бурхан чихээ тагласан мэт санагддаг. Бурхан төөрч тэнүүчилсэн хүүхдүүдийг нь буцааж авчрах болов уу, ер нь буцааж авчирч чадах болов уу гэж гайхширна.

Эзэнд дэндүү хэцүү зүйл байхгүй гэдгийг санах хэрэгтэй. Тэд залбирлаа үргэлжлүүлсээр, хөвгүүд охидынхоо төлөө талархсаар байх ёстой. Мөн Бурханы үгэн дэх амлалтуудаас зуурах ёстой.

Ээж нь Иеремиа 31:16-г уншаад, энэ үнэхээр Бурханы хэлж байгаа амлалт мөн үү гэж бодтол "Чамтай тэрсэлдэгчтэй Би тэмцэлдэж, хөвгүүдийг чинь аврах болно" гэсэн үгийг мөн Бурхан Исаиа 49:25-аас өгсөн байна.

## 8 сарын 25

*"Гэхдээ бид өөрсдөө үхлийн ял дор байсан нь өөрсдөдөө бус, харин үхэгсдийг амилуулдаг Бурханд найдахын тулд билээ."* (2Ко 1:9)

Паул Ази мужид байхдаа үхэх дөхжээ. Яг юу болсныг тодорхой мэдэхгүй ч хэрэв бид түүнээс "Үхэл амьдралын аль нь вэ?" гэж асуувал "үхэл" гэж хариулахаар тийм ноцтой асуудал байлаа. Бурханы ашигладаг ихэнх хүн Паултай адил зүйлийг туулсан байдаг. Бурханы агуу хүмүүсийн намтрыг үзвэл үхэл, осол аваар, халдлага довтолгооноос гайхалтайгаар аврагдсан түүхүүд олон бий.

Бурхан заримдаа хүний анхаарлыг Өөр рүүгээ татахын тулд ийм тохиолдлуудыг ашигладаг. Хүн баян чинээлэг байдалд хэт төвлөрөөд ирэхээр Бурхан амьдралд нь гэнэтийн цохилт өгдөг. Бүх юм бодсон санаснаар нь биелдэг нэгэн хүн байлаа. Гэнэт тэр өвчин тусаад хэвтчихэв. Хагалгаанд орж маш том хорт хавдар авхууллаа. Энэ үйл явдал түүнд нэгийг бодуулж, амьдралын утга учрыг дахин тунгаан бодоход хүргэж, юуг нэн тэргүүнд чухалчлах ёстойг нь сануулжээ. Амьдрал гэдэг хэчнээн богинохон гэдгийг тэр ойлгоод үлдсэн насаа Эзэнд зориулахаар шийдсэн байна. Бурхан түүнийг илаарьшуулж, Өөрт нь үр жимстэйгээр үйлчлэх олон жилүүдийг хайрласан юм.

Паулын тохиолдол үүнээс арай өөр. Тэрээр аль хэдийнээ өөрийнхөө амьдралыг Эзэний үйлчлэлд зориулж байсан. Гэвч Паул өөрийн хүч чадал, мэргэн ухаанаар үйлчлэлээ явуулах эрсдэл байсан учраас Паулыг үхэлтэй нүүр тулуулж, өөртөө биш зөвхөн үхэгсдийг амилуулдаг

Бурханд найдахыг сургасан. Паул хүний арга чарга мухардам олон бэрхшээлтэй тулгарсан. Гэвч Бурхан үхэлд хүртэл өөрийг нь хамгаалж чадах тийм агуу гэдгийг мэдэж авснаас хойш дахиж юунаас ч айж хулгахаа больжээ.

Үхэх шахсан цаг мөч нь үнэндээ Бурханы дүрээ хувиргасан ивээл ерөөл юм. Нэгт, энэ нь биднийг ямар өчүүхэн дорой гэдгийг ойлгуулна. Хоёрт гэвэл, энэ ертөнцийн үнэлэмжүүд ямар мунхаг болохыг сануулна. Гуравт гэвэл, амьдрал хэчнээн богинохон, хэзээ ч дуусаж магадгүй гэдгийг бидэнд сургана. Үхэлтэй нүүр тулахаар хэн ч ажиллаж чадахгүй шөнө ирэхээс өмнө, өдөр байгаа дээр Эзэний ажлын төлөө амьдрах ёстойгоо бид ойлгодог. Энэ утгаар бодвол бид бүгдээрээ үхлийн ял дор байгаа бөгөөд энэ нь Христийн ашиг сонирхлыг нэгт тавих, Түүний хүч чадал, мэргэн ухаанд найдах ёстойг ухааруулдаг эрүүл дохио юм.

## 8 сарын 26

*"Гарын маань үйлсийг бат тогтоогооч!" (Дуу 90:17)*

Шинэ Стандарт Америк Библийн хөлийн тайлбарт энэ хэсгийг "Бидний гарын үйлсийг бат бэх болгооч" гэж өөр хувилбараар орчуулсан байна. Энэ нь бидний бодож залбирах ёстой зүйл мөн. Амьдралаа хий хоосонд биш, үлдэж хоцрох зүйлд зарцуулах нь бидний хүсэл зорилго байх учиртай.

Эзэн Есүс Шинэ гэрээн дээр энэ санааг бас хэлсэн: "Та нарыг явж, жимс гаргаж, үр жимс чинь үүрд байгаасай гэсэндээ Би та нарыг томилсон" (Иох 15:16).

“Хүмүүний үүрэг болбоос үхсэнийх нь дараа ч үргэлжилсээр байх нэр төртэй ажлыг хийх явдал мөн. Хүн бүр үхлээс цаадхыг бодож мөнхөд орших зүйлд амьдралаа зарцуулах хэрэгтэй.” (Ф. В. Борэм)

Бидний нийгэм түр зуурын зүйлст дэндүү их ач холбогдол өгч, хий хоосны хойноос байнга хөөцөлддөг. Лийрийн хальсан дахь тавин янзын ууршимтгай химийн бодисын шинжилгээнд бүх амьдралаа зориулсан хүн байдаг гэнэ. Христитгэгчид хүртэл элсэн дээр цайз барих, хөөсний хойноос хөөцөлдөх, ялих шалихгүй юмсын мэргэжилтэн болох занганд унадаг. Ийм хүмүүсийг шатаж буй байшингийн доторх зургийг тэгшлэх гэж хамаг амьдралаа үрдэг мунхгууд хэмээн нэгэн хүн тодорхойлжээ.

Мөнхийн утга учиртай олон төрлийн ажил бий. Бид тийм ажлууд дээр гол анхаарлаа хандуулах хэрэгтэй. Нэн тэргүүнд, христэч зан чанарыг хөгжүүлэх. Мөнхийн улс уруу авч явах цөөн зүйлсийн нэг нь бидний зан чанар юм. Тиймээс зан чанараа одоо ч гэсэн тордох нь зөв.



Хүмүүсийг Христэд итгүүлж аврах нь мөнхийн утга учиртай. Тэд Бурханы Хурганд үүрдийн үүрд мөргөх болно.

Үнэний үгийг зааж, залуу итгэгчдийг дагалдуулж, Христийн хонин сүргийг тэжээдэг хүмүүс мөнхөд үргэлжлэх амьдралдаа хөрөнгө оруулж байна.

Хөвгүүд охидоо Бурханы хаанчлалын үйлчлэлд бэлтгэн хүмүүжүүлдэг эцэг эх гарцаа байхгүй мөнхөд үргэлжлэх ажил хийж байна.

Өөрсдийн мөнгийг Христийн төлөө болон Бурханы ажилд зориулдаг итгэмжит нярвууд нь хэзээ ч үл устах ажилд оролцож байна.

Залбиралд өөрсдийгөө зориулдаг хүмүүс бүх залбирал нь Бурханы цагт, Бурханы замаар хариугаа авсныг хэзээ нэгэн цагт харна.

Бурханы хүмүүст үйлчилдэг бүхэн мөнхийн утга учиртай ажлыг хийж байна. Христийн хамгийн даруу зарц болбоос энэ дэлхийн хамгийн ухаантай хүнээс ч илүү алсын хараатай. Учир нь Христийн зарцын ажил мөнхөд үлдэх бол нөгөө хүмүүсийнх нь үүл мэт замхран арилна.

## 8 сарын 27

*"ЭЗЭН, Таны асарт хэн оршин суух вэ? Таны ариун ууланд хэн амьдран суух вэ?...Тэр өөрөө хохирсон ч андгайлснаасаа үл няцна."* (Дуу 15:1,4)

Ямар хүн агуу Бурханы анд нөхөр болох болзлыг хангах вэ гэдгийг Дуулал 15 дээр Давид тодорхойлсон. Тэрхүү болзлыг хангасан хүний нэг зан чанар нь өөрөө хохирсон ч үгэндээ заавал хүрэх явдал. Амласан бол түүнийгээ заавал биелүүлэх.

Жишээлбэл, нэг христитгэгч байшингаа зарах гэж байлаа. Худалдан авагч ирээд хэлсэн үнийг нь төлөхийг зөвшөөрөв. Ингээд тохиролцоо хийгдлээ. Гэтэл гэрээнд гарын үсэг зурахын өмнөхөн өөр хүн хүрч ирээд 5000 доллар илүү үнэ санал болгожээ. Хуулийн талаас нь яривал худалдагч тал эхний үнээс татгалзаад 5000 доллар илүүг санал болгож байгаа хүнд байшингаа зарж болох ч ёс зүйгээ бодвол хүн хэлсэндээ хүрэх ёстой. Дээрээс нь Христийн гэрчлэл энд яригдаж байгаа юм.

Өөр нэг жишээ татъя. Нэг итгэгчийн агт арааг хорхой иджээ. Тэрээр шүдний эмнэлэгт очоод үзүүлтэл эхлээд антибиотикоор эмчилгээ хийгээд хэсэг хугацааны дараа шүдийг нь авахаар цаг тохиров. Нөгөө итгэгч, эмчдээ Есүсийн тухай ярьж өгөөд эмнэлгээс явж оджээ. Гэр рүүгээ харьж явтал найз нь тааралдаад өмнөх шүдний эмнэлгийн хагас үнээр шүдийг нь авах эмнэлэг байгааг хэлж өгөв. Мэдээж тэр хийлгэсэн эмчилгээнийхээ үнийг төлчихсөн учраас өөр шүдний эмнэлэг орох нь буруу биш. Гэхдээ тэр яасан нь дээр вэ?

Ахмад настай гэр бүлээс Сьюд оройн хоолны урилга ирэхэд очно гэдгээ хэлэв. Удаагүй байтал утас дугарч үеийнх нь залуус цагийг хөгжилтэй өнгөрөөнгөө оройн хоол идэх санал тавилаа. Сью яах ёстойгоо бодож эхлэв. Тэрээр настай хүмүүсийг гомдоомооргүй байвч залуучуудтайгаа хамт цагийг өнгөрөөхийг маш их хүссэн.

Их хэмжээний мөнгө алдахаар байвал шийдвэр гаргах бүр хэцүү болдог. Гэхдээ ямар ч хэмжээний мөнгө алдах бай амласнаасаа няцах, хэлснээсээ буцах, христэч гэрчлэлээ унагаах, Эзэний нэрийг гутаах шалтгаан болж болохгүй. Ямар ч хохирол гарах бай "Мөнгөн дээр тулахаар бүх хүн ижил шашинтай болдог" гэсэн Вольтерын үг худал болохыг бид батлах ёстой.

Бурханы хүн юу ч болж байсан амлалтаа сахидаг. Өөрт нь хэчнээн гарз учирсан ч хэлсэндээ хүрдэг.

## 8 сарын 28

"Нүгэл чинь та нарыг олно гэдгийг сайн мэдтүгэй." (Тоо 32:23)

Бурхан энэ ертөнцөд хэний ч өөрчилж чадахгүй тодорхой зарчмуудыг тогтоосон. Хүн хэчнээн ухаан гаргаад ч уг зарчмаас зугтаж чадахгүй. Тэдгээр зарчмын нэг нь хүний үйлдсэн нүгэл эзнээ заавал олдог явдал юм.

Хүүхэд байхдаа жимсний чанамал хулгайлж идчихээд баригдахгүйг хичээсэн ч толбо үлдээснээ анзаарахгүй ээждээ баригдаад энэ зарчмыг аль эрт ухаарсан хүмүүс байдаг. Гэвч энэ зарчим амьдралын бүх талбарт үнэн бөгөөд сонин болгон дээр баталгаа нь гарч байдаг.

“Южинь Арамын зүүд” шүлэгт энэ зарчмыг маш тодорхой дүрсэлсэн. Тэрээр төгс гэмт хэрэг хийж чадна хэмээн бодож, нэгэн хүний амийг бүрэлгэн цогцсыг нь голд хаяв. Ус нь бэх мэт гүн хар булингартай гол байлаа. Маргааш өглөө нь гэмт хэрэг үйлдсэн голын эрэг дээр очлоо.

*Нөгөө булингартай усан дээр очтол  
Нүд минь орой дээрээ гарах нь тэр  
Гайтай гол итгэл алдан ширгээжээ  
Голын сайран дээр цогцос харагдлаа*

Тэгэхээр нь тэр том том навчис овоолон цогцсыг нуух гэж оролдсон боловч тэр шөнө их салхи гарч бүгдийг нь хийсгээд цогцсыг ил гаргав.

*Нүүрээ даран анх удаагаа уйллаа  
Нууцаа би сайн мэдэж байгаа  
Энэ дэлхий далдлахыг хүссэнгүй  
Эгнэгт олдохооргүй хэчнээн гүн ч  
Далай тэнгис хадгалахыг хүссэнгүй  
Далдалж ердөө нууцалсангүй*

Эцэст нь цогцсыг холын нэгэн агуйд булжээ. Гэвч хэдэн жилийн дараа араг яс нь олдож гэмт этгээд шүүхийн өмнө дуудагдан яллуулж, цаазаар авхуулсан. Нүгэл нь түүнийг олсон нь тэр.

Э. Стэнли Жонс нүгэл маань биднийг олж авдаг өөр нэгэн замыг сануулсан. "Нүгэл нь бидний дотоод мөн чанарт тэмдэглэгдэн үлдэж, дотроос минь идэж, өөрийгөө үл хүндлэхүйн дотоод тамд шаналган зовоож, сохор харалган будилаан дунд амьдруулдаг."

Хүний нүгэл энэ амьдралд илчлэгдэхгүй байсан ч ирэх амьдралд заавал илчлэгдэнэ. Нүглээ Есүсийн цусаар угаалгаагүй л бол шүүлтийн өдөр бүх юм гэрэлд гарна. Энэ нь үйлс, бодол, сэдэл аль нь ч байсан хүнийг өөрийнх нь эсрэг гэрчилж, ял тулгуулна. Тэр ял нь мөнхийн үхэл билээ.

## 8 сарын 29

"Христ бол бүгд." (Кол 3:11)

Өнөө цагт христитгэгчид амьдралын ороо бусгаа байдлаас нь чөлөөлөх, эрх чөлөө, ялалт амласан цоо шинэ сүнслэг мэдрэмжүүдийн хойноос гүйх хандлагатай болжээ. Тэд хурал, цуглаан, уулзалт, семинар, сургалтад олонтоо сууж, амьдралынх нь энхэл донхлыг тэгшлэх ид шидийн шийдэл хайж явцгаадаг. Хаа сайгүй зурагт хуудас, брошнор дээр тэр доктор, энэ пастор, ийм ийм агуу үнэнүүдийг заана, ийм ийм агуу сэргэлт болно, таныг Сүнсээр дүүргэнэ гэх мэт сурталчилгаанууд явдаг. Эсвэл хэн нэг идэвхтэй найз маань биднийг хотын цэнгэлдэх хүрээлэнд болох гайхалтай цуглаанд оч хэмээн ятгаж, дүүрэн амьдралд хүрэх товч зам юу болохыг сонс хэмээн уриална.

Нэг номлогч дүүрэн амьдралын зам юу болохыг заана. Нөгөө нэг нь ялалтад хүрэх гурван нууцыг сурталчилна. Өөр нэг нь гүн гүнзгий амьдралын түлхүүрийг сургана. Дараагийн долоо хоногт нь ариун амьдралд хүрэх таван хялбар алхмыг таниулна. Цуглаан бүрийн дараа хүмүүсийг урагш дуудаж, Ариун Сүнсний дүүргэлтийн төлөө залбирна. Хэн нэг нь өвчнөөсөө эдгэрсэн хэмээн амьдралын хамгийн чухал зүйл мэт шагшин гайхуулна. Сүнсээр улам илүү дүүргэх, илүү дээд түвшний зүйлийг хайсаар бид энд тэндгүй тэнүүчилдэг.

Мэдээж тэдгээр номлогчийн ихэнх нь үнэн сэтгэлээсээ ярьж байгаа. Хэлж буй зүйлд нь авахаар юм олон. Гэвч тэндээс эргээд гэртээ харихад асуудал минь яг хэвээрээ, ариун шударга амьдралын товч зам байхгүй гэдэг нь

ойлгомжтой, өдөр тутмынхаа амьдралд Эзэнд найдаж амьдрахаас өөр замгүй гэдэг үнэн эс өөрчлөгдөнө.

Эцсийн эцэст, туршлагаас илүү Есүс Христээр сэтгэл зүрхээ эзэмдүүлэх нь дээр гэдгийг бид ойлгох хэрэгтэй. Есүс хэзээ ч бидний урмыг хугалахгүй. Хэрэгтэй бүхэн минь Түүний дотор байгаа. Бүхнийг хангагч, бүрэн хүрэлцээтэй Нэгэн бол Тэр.

Залуудаа элдвийн туршлагыг хүсэж хайж явсан ч сэтгэлийн ханамжийг олоогүй А. Б. Симпсон "Зөвхөн Тэр" нэртэй магтан дуу зохиосон юм. Дууных нь эхний бадаг дахилтыг энд оруулья:

*Өмнө нь би ивээл хайдаг байлаа*

*Одоо зөвхөн Эзэн Есүс*

*Өмнө нь би мэдрэмжийг дагадаг байлаа*

*Одоо зөвхөн Түүний үг*

*Өмнө нь би бэлгүүдийг хүсдэг байлаа*

*Одоо зөвхөн өгөгч Бурхан*

*Өмнө нь би эдгэрлийг эрдэг байлаа*

*Одоо зөвхөн Тэр*

*Есүсийг л бүхнээ болгож*

*Үүрдийн үүрд би дуулна*

*Есүсийн дотор бүгд бий*

*Есүс Өөрөө бүх юм*

## 8 сарын 30

*"Өөртөө ба сургаалдаа анхаар."* (1Тм 4:16)

Бурханы үгийн нэг онцлууштай чанар гэвэл үүрэг хариуцлагыг сургаалаас тусад нь ялгадаггүй явдал юм. Жишээ болгож Филиппой 2:1-13-г авч үзье. Христийн тухай онол сургаалын хамгийн сонгодог хэсгүүдийн нэг нь Шинэ гэрээний энэ хэсэг. Есүс Христ Эцэг Бурхантай эн тэнцүү, Өөрийгөө хоосолсон, махан биеэр бууж ирсэн, зарц мэт үйлчилсэн, үхсэн, эцэст нь тэнгэрт одож цог жавхланд орсон зэрэг олон онол сургаалыг энэ эшлэлээс ойлгож болно. Гэхдээ тэглээ гээд зөвхөн онол сургаал яриад байдаггүй. Түүнийхээ хажуугаар Христийн адил бодолтой байхыг филиппойчуудад болон бидэнд уриалдаг. Хэрэв би Есүс Христийн адил бусдын төлөө амьдарвал энэ нь зөрчил маргаан, хоосон бардамналыг үгүй хийнэ. Хэрэв бид Есүс Христийн адил дорд газрыг сонговол цаг нь ирэхээр Бурхан биднийг өргөмжилнө. Тэгэхээр Филиппой 2:1-13 нь бодит амьдралд шууд хандаж ярьсан байна.

Би системчилсэн теологийн номуудыг уншихаар энэ тухай их боддог. Ийм номуудад итгэлийн талаарх Библийн заадаг бүхий л онол сургаалыг нэг дор цуглуулсан байдаг. Бурхан, Христ, Ариун Сүнс, тэнгэрэлч, хүн, нүгэл, аврал гэх мэт сэдвүүдийг тэнд өгүүлнэ. Эдгээр нь үнэ цэнтэй боловч бурханлаг амьдралаас салгачихаар маш хүйтэн хөндий болох эрсдэлтэй. Хүн агуу сургаалуудыг ойлгож мэддэг байж болно. Гэхдээ Христэч зан чанарын доголдолтой бол тэр их мэдлэг үнэ цэнэгүй. Бурхан Библийг бидэнд өгч судлуулдаг юм бол онол сургаал ба үүрэг хариуцлагыг хэзээ ч битгий салгаарай. Энэ хоёр нь



салшгүй хэлхээ холбоотой. Аль нэгийг нь л авахад тэнцвэр алдагддаг.

Хүний үүрэг хариуцлагыг хамгийн их салгаж умартдаг онол сургаал бол эш үзүүллэгүүд. Эш үзүүллэгийг ихэнхдээ маш сонирхол татахуйцаар заадаг. Антихрист гэж хэн бэ гэдгийг зөв таних нь олон хүний анхаарлыг татаж магадгүй. Гэхдээ ариун шударга амьдралыг бий болгохгүй. Эш үзүүллэг нь сониуч занг минь татах гэж бус, христэч зан чанарыг минь төлөвшүүлэх гэж анх бичигдсэн. Христийн хоёр дахь ирэлт нь бидний сургаалын мэдлэг, зан чанар, бодит амьдралд нөлөө үзүүлж болох 65 арга замыг Жорж Петрс жагсаан бичсэн. Мэдээж түүнээс ч олон байж таарна.

Миний хэлэх гээд байгаа гол санаа бол, теологийг ариун шударга амьдралаас хэзээ ч бүү салгаарай. Библийг хувьчлан судлах хийгээд бусдад номлож байхдаа Паулаас Тимотод хэлсэн ятгалгыг байнга бодож байх ёстой:" Өөртөө ба сургаалдаа анхаар."

## 8 сарын 31

*"Гэвч миний хувьд ололт байсан болгоныг би Христийн төлөө хохирол болгон тооцов. Тэр ч байтугай, би Христ Есүс Эзэнээ танин мэдэхүйн хосгүй давуу талын төлөө бүх юмсыг хохирол болгон үздэг. Би Түүний төлөө бүх юмсын хохирлыг амсаж, тэдгээрийг хог гэж үздэг нь Христийг олохын тулд." (Флп 3:7,8)*

Итгэгч хүн Есүс Христийн төлөө үнэтэй бүхнээсээ татгалзах нь үнэхээрийн сайхан явдал билээ. Авьяас чадвараараа эд хөрөнгө, нэр алдартай болсон хүн байлаа. Бурханы дуудлагад дуулгавартай байхын тулд тэрээр бүхнийгээ Аврагчийн хөлд тавив. Дэлхийн алдартай тайзууд дээр гардаг сайхан хоолойтой дуучин эмэгтэй байлаа. Харин нэг л өдөр өөр зорилгын төлөө амьдрах ёстойгоо ойлгож, Христийг дагахын тулд бүх карьераа орхив. Тэглээ гээд Христийг олж авахуйн юутай ч харьцуулшгүй олз ашигтай энэ зэрэгцэх алдар нэр, авьяас чадвар, эд хөрөнгө байна гэж үү?

"Бурханы олон бэлгүүдээр ерөөгдсөн хүн тэр бүхнийгээ Аврагч Эзэний хөлд хүндэтгэлтэйгээр тавихаас өөр сэтгэл хөдөлгөм зүйл байдаг гэж үү?" хэмээн Иан Макферсон асууж байна. Уг нь тэр бүхэн Христийн хөлд л байх ёстой шүү дээ. Уэльсийн мэргэн настай теологч: "Еврей, Грек, Латин хэл тус тусын байрандаа бүгд маш сайхан. Гэвч Пилат тэднийг Есүсийн толгой дээр тавьсан нь зохих газраа олсонгүй. Тэдний байх ёстой газар нь Есүсийн хөлд юм" гэж хэлжээ.

Элч Паул эд хөрөнгө, соёл, шашны хэргэм зэрэг бүхнээ Христийн төлөө гарз болгон тооцсон. "Тэрээр Эзэн Есүсийг олж хараагүй байхдаа нийгмийн дээд зиндааны

боломж, түүнээс олж авсан нэр төр, эд хөрөнгөө агуу олз ашиг гэж үзэж байлаа. Харин Эзэний цог жавхлан түүний нүдэн дээр тусахад энэ бүхэн сүүдэр мэт сарнин алга болов. Элч Паулын өмнөх амьдралын олз ашиг нь Эзэний хурц гэрэл дотор үнэ цэнээ алдаад зогсохгүй хов хоосон гэдэг нь илчлэгдсэн. Үүнээс хойш элч Паул тэр бүхний тухай бодохоо больсон. Өмнө нь дээдийн дээд, ариун дагшин хэмээн тооцож байсан бүхэн нь бодлоос нь ор мөргүй арчигдав." (Жоветын тайлбар)

Христийг дагахын тулд бүхнээ орхисон хүнийг зарим нэг нь ухаанаа алджээ гэж боддог нь нэн хачирхалтай. Тэд гайхан балмагдаж, уйлж, харуусч, янз бүрийн өөр замуудыг санал болгодог. Зарим нь ухаалгаар ятгаж, сэнхрүүлэх гэж оролддог. Цөөн хүмүүс л Христийн төлөө бүхнээ орхихын утга учрыг ойлгож дэмждэг. Гэхдээ хүн итгэлээр алхаж байгаа үед бусдын бодол санааг зөвөөр үнэлж цэгнэх чадвартай болдог.

Ч. Т. Стад илгээлтийн үйлчлэлд амьдралаа зориулахын тулд нутагтаа олж болох байсан амжилт нэр алдраас татгалзсан. Жон Нельсон Дарби Бурханы үгийн номлогч, багш, сайнмэдээ тараагч болохын тулд өсөн дэвжих боломжтой ажлаа орхисон. Эквадорын аука омогт Христийг авчрахын тулд таван залуу АНУ дахь тав тух, материализмыг орхиж, Эквадорт амиа алдсан.

Хүмүүс үүнийг агуу золиос гэж нэрлэдэг. Гэвч үнэндээ энэ нь золиос ердөө ч биш. Нэг хүн Хадсон Тэйлорыг Христийн төлөө агуу золиос гаргаж байна шүү гэж магтахад "Хүн гуай, би амьдралдаа ямар ч золиос гаргаагүй" гэж хариу өчжээ. Дарби "Амьдралаа Бурханд өргөх нь ерөөсөө ч золиос биш" гэж хэлсэн.

## 9 сарын 1

*"Та нар тавь дахь жилийг ариусгаж, нутаг даяар бүх оршин суугчдад нь эрх чөлөөг зарлагтун. Энэ нь та нарт эвэр бүрээдэлт болох бөгөөд хүн нэг бүр чинь эзэмшилдээ буцаж, хүн нэг бүр чинь ураг уруугаа эргэж явагтун."* (Лев 25:10)

Израилийн хуанлийн тавин жил тутамд эвэр бүрээдэлтийн жил тохионо. Энэхүү жилд хөрсийг хагалахгүй орхиж, газрыг анхны эзэнд нь буцааж, боолуудыг чөлөөлдөг. Энэ нь эрх чөлөө, нигүүлсэл, золилт, амралтын жил билээ.

Хүн газар худалдан авахаар бол эвэр бүрээдэлтийн жил хэр ойрхон байгааг тооцон үзнэ. Жишээлбэл, эвэр бүрээдэлтийн жил болоход 45 жил дутуу бол газар илүү үнэд хүрнэ. Ганцхан жил дутуу бол газрыг худалдаж авах ашиггүй болно. Яагаад гэвэл худалдан авагч тухайн газар дээр ганц л жил тариа тарих боломжтой.

Эзэний ирэлт нь өнөөдрийн итгэгч нарын хувьд эвэр бүрээдэлтийн жилтэй ижил. Итгэгчид Эзэнийг ирэхэд Эцэгийн гэрт мөнхийн амралтад орж, нүглийн ялзралаас чөлөөлөгдөж, цог жавхлант биеийг хүлээн авна. Тэдэнд нярвын ёсоор хариуцуулсан бүх эд хөрөнгө анхны эзэндээ буцаж очно.

Бид өөрсдийн материаллаг эд хөрөнгөө үнэлж цэгнэхдээ үүнийг бодож үзэх ёстой. Бидэнд мянга мянган доллароор үнэлэгдэх үл хөдлөх хөрөнгө, хөрөнгө оруулалт, банкны хадгаламж байж болох юм. Гэвч Эзэн өнөөдөр ирвэл тэр бүхэн ямар ч үнэ цэнэгүй болно. Эзэний ирэлт ойрхон байх тусам өмч хөрөнгө маань төдий чинээ үнэ

цэнэгүй юм. Юу гэсэн үг вэ гэвэл, бид өөрсдийн эд хөрөнгийг Христийн үйл хэрэгт болон хүний хэрэгцээнд зарцуулах ёстой.

Эвэр бүрээдэлтийн жил эхлэхэд бүрээ үлээдэг шиг Эзэний хоёр дахь ирэлт “эцсийн бүрээн” дуунаар зарлагдана. “Бид эндээс сургамж авах хэрэгтэй. Зүрх сэтгэл минь Эзэний дахин ирэлтийг найдан хүлээдэг бол энэ дэлхийн зүйлсээс зууралдахгүй. Бурханы Хүүг тэнгэрээс буун ирэхийг хүлээх зуураа энэ ертөнцөөс зууралдаж чадах хүн байхгүй...Христийн ирэхийг тэсэж ядан хүлээдэг хүн, Христийн ирэлтээр шүүгдэж юу ч биш болох зүйлсээс тусгаарлагдах нь зөв...Туйлын үнэ цэнтэй, шударга ариун амьдралыг өдөөдөг энэхүү үнэн бидний зүрх сэтгэлд нөлөөлж, бүхий л зүйл дээр амьдралыг минь удирдах болтугай.” (Ч. Х. Макинтош)

## 9 сарын 2

*"Би Таныг хаа ч явсан дагая."* (Лк 9:57)

Христ бол Эзэн, Бурханд бүхнээ зориулах, Бурханд бууж өгөх – энэ сэдвүүдээр бид маш итгэл төгс ярьж, дуулдаг гэж надад санагддаг. “Тэр, бүгдийн Эзэн биш бол ерөөсөө ч Эзэн биш” гэх утгатай үгсийг бид тоть шиг давтдаг. “Есүст би бүхнээ өгнө. Түүнээс би юу ч харамлахгүй” гэсэн дуунуудыг олонтоо дуулдаг. Бидний хувьд Эзэнд бүхнээ зориулна гэдэг нь бүтэн сайн өдөр цуглаанаа таслахгүй очих гэсэн утгатай мэт харагддаг.

Эзэнийг бүх зүрхээрээ дагана гэж юу болохыг бид арай л ойлгоогүй бололтой. Христийг Эзэн хэмээн хүлээн зөвшөөрнө гэдэг нь ядуурсан ч, зүхэгдсэн ч, жигшигдсэн ч, зовсон ч, үхэх байсан ч Есүсийг дагана гэсэн үг.

“Зарим хүн жоохон цус үзэхээрээ ухаан алдаж унадаг. Нэгэн өдөр өөдрөг сэтгэлтэй залуу Есүс дээр ирээд зүрхнийхээ хамгийн сайхан үгийг хэлэв. ‘Эзэн Таныг хаа ч явсан би дагая’ гэж итгэл төгс мэдэгдэв. Үүнээс илүү сайхан үг хаана байх билээ. Гэхдээ Есүс энэ үгэнд баярлаагүй. Учир нь тэр залуу хэлсэн үгнийхээ утгыг ойлгоогүйг Есүс сайн мэдэж байсан. Тийм ч учраас ‘Үнэг хүртэл үүртэй байхад Надад толгой хорогдох газар байхгүй. Чи хээр гадаа ч хонож магадгүй шүү’ гэж хэлсэн байна. Энэ үг залууд хүнд санагдаж, хамаг зориг нь мохжээ. Тэрээр сайхан зорилго өвөртөлж ирсэн ч төлөх үнэ нь бодож байснаас нь их байлаа. Олон хүн түүн шиг байдаг. Та бүхний зарим нь тулаанд ер оролцоогүй байгаа. Христ та нарыг дуудаагүй учраас биш, харин та цус үзэхээс айсандаа тулаан руу орохгүй байгаа. Тийм ч болохоороо

‘Буу зэвсэг хэрэглэдэггүй байсан бол би цэрэг болох л байлаа’ гэж хэлдэг.” (Чапль)

Лук 9 дүгээр бүлэгт гарч буй залуу сайн дураараа, Эзэнийг хаа ч явсан дагая гэхэд Есүс хөөрөөгүй ч гэсэн Жим Элиотийн өдрийн тэмдэглэлд бичсэн үгэнд хөөрч баярласан гэдэгт би итгэлтэй байна: “Хэрэв би амиа Эзэнийхээ адилаар тахил болгон өргөвөл, Бурханы өмнө эмээх зүйлгүй зогсож чадна. Аав аа, миний амьдралыг ав. Цусыг минь ч ав. Та хүсвэл амьдралыг минь Өөрийнхөө төлөө шатаа. Би амиа хайрлахгүй. Учир нь энэ амь минийх биш. Бүгдийг нь та Өөртөө ав. Амьдралыг минь энэ ертөнцийн төлөө өргөл болгон ашигла. Цус минь таны тахилыг ширээний өмнө урссан цагтаа л үнэ цэнтэй.”

Жим Элиот энэ үгийг бичихдээ Эзэний төлөө амьдрахын утга учрыг үнэн голоосоо ойлгодог байснаа харуулж, үнэхээр ч Эзэнд цусаа тахил болгон өргөж, Эквадорт амиа алдсан. Түүний үгийг уншаад, амиа хайрлалгүй амьдарсныг нь эргэн дурсвал, бүхнээ Эзэнд өргөнө гэдгийг бидний ихэнх нь хараахан ухаараагүйг олж харах биз ээ.

## 9 сарын 3

*"Харин бэлэг бол алдаа зөрчилтэй адилгүй. Хэрэв ганц хүний алдаа зөрчлөөс болж олон хүн үхсэн бол, тэгэх тусмаа Бурханы нигүүлсэл болон Есүс Христ гэгч ганц Хүний нигүүлслээр ирсэн бэлэг нь олон хүнд бялхсан юм."*  
(Ром 5:15)

Ром 5:12-21 дээр хүн төрөлхтний хоёр тэргүүн Адам ба Христийг Паул харьцуулан тавьжээ. Адам нь анхны бүтээлийн тэргүүн. Христ нь шинэ бүтээлийн тэргүүн. Адам нь махан биеийнх. Христ нь сүнснийх. Паул "тэгэх тусмаа" гэдгийг гурван удаа ашиглаж, Христийн ажлаас урсдаг ивээл ерөөл нь Адамын нүглээс улбаатай алдагдал хохирлыг хэд дахин нугалахаар их гэдгийг цохон тэмдэглэсэн. Өөрөөр хэлбэл, Адамын хөвгүүд өвөг эцгийнхээ алдсанаас хамаагүй их ивээл ерөөлийг Христийн дотор хүртэнэ гэж байгаа юм. Итгэгчид нүгэлд унаагүй Адамын дотор байснаас ч илүүг Христийн дотроос олж авсан. Адам хэзээ ч нүгэл үйлдээгүй, хориглосон жимснээс идээгүй, эхнэртэйгээ хамт Бурханыг дуулгавартай дагахаар шийдсэн гэж бодож үзье. Үр дүнд нь тэдний амьдрал ямар байх байсан бэ? Тэд Еден цэцэрлэгт амьдарсаар л байх байсан биз. Тэдний шагнал нь дэлхий дээр урт удаан амьдрах явдал байх байсан. Тэдний үр удам ч ялгаагүй.

Тэд нүгэл үйлдэхгүй л байвал Едендээ амьдарсаар байх байсан. Мэдээж бас үхэхгүй.

Нүгэлгүй байдал дотор тэнгэрт очих шаардлага тэдэнд гарахгүй. Ариун Сүнс дотор нь оршиж тамгалах амлалт ч өгөгдөхгүй. Тэд хэзээ ч Есүс Христийн хамтран өв



залгамжлагч болохгүй. Дээрээс нь, Бурханы Хүүгийн дүр төрхтэй адил болох найдвар ч үгүй байх байсан. Хамгийн муухай нь Еден цэцэрлэгт эдэлж байсан энэ дэлхийн ивээл ерөөлийг нь үгүй болгох, нүгэл хийх боломж байсаар л байна.

Тэгвэл эвлэрүүллийн ажлаараа Есүс Христийн бидний нөлөө олж авсан илүү дээр нөхцөл байдлыг бодож үзье. Бид Христийн дотор тэнгэрийн бүх сүнслэг ерөөлөөр ерөөгдсөн. Бид Бурханы хайрт Хүүгийн дотор хүлээн авагдаж, Христийн дотор бүрэн төгс болж, аврагдаж, уучлагдаж, зөвтгөгдөж, ариусгагдаж, цагаадаж, Бурхантай эвлэрч, Христийн биеийн эрхтнүүд болсон. Ариун Сүнс дотор минь оршин сууж, биднийг тамгалж, Бурханы өв залгамжлагч болгосон. Одоо бид Христийн дотор мөнхөд аюулгүй бөгөөд Бурханы хүүхдүүд, өвлөгчид Есүс Христийн хамтран өв залгамжлагч болжээ.

Бурхан Хүүгээ хэр их дотночилж үнэлж хайрладаг шиг биднийг ч мөн тийн үздэг болсон. Үүнээс ч их зүйлс бий. Гэхдээ гэм нүгэлгүй Адамын дотор байсан бол авах сайн сайхнаас илүү их ивээл ерөөл, сайн сайхныг өнөөгийн итгэгчид Есүс Христийн дотор хүлээн авсныг харуулахад энэ үгс хангалттай гэж бодож байна.

## 9 сарын 4

*"Би хулгайлаагүй зүйлээ буцааж өгөх ёстой болж байна."*  
(Дуу 69:4)

Дуулал 69-т өгүүлэгч нь Эзэн Есүс. Золилтын жавхланта ажлаараа хүний нүглээс болж алдагдсан зүйлсийг Бурханд буцаан өгч буй тухайгаа 4-р эшлэлд Тэр ярьж байна. Эзэн Есүс Өөрийгөө жинхэнэ ялын тахил болгон дүрсэлжээ.

Еврей хүн өөр еврей хүнээс хулгайлах үед ялын тахилын хуулийн дагуу, хулгайч хулгайлсан эд зүйлээ нөхөн төлөөд, дээр нь тухайн эд зүйлийн үнийн тавны нэгтэй тэнцэх хэмжээний мөнгийг өгөх ёстой.

Бурхан хүний нүглээс болж олон зүйлээ хулгайд алдсан. Түүнээс үйлчлэл, мөргөл, дуулгавартай байдал, алдрыг хулгайлсан. Хүн өөртөө болон нүгэлд, мөн Сатанд үйлчлэх гэж Бурханаас нүүр буруулсан учраас Бурханы үйлчлэл хулгайлагдсан юм. Хүн гараараа урласан шүтээндээ мөргөдөг учраас Бурхан мөргөлөө хулгайд алдсан. Хүн Бурханы эрх мэдлийг эсэргүүцсэн учраас дуулгавартай байдал хулгайд алдагдсан. Хүн Бурханд очих ёстой алдрыг өргөдөггүй учраас Бурханы алдар хулгайд алдагдсан.

Эзэн Есүс хулгайлаагүй зүйлээ сэргээж өгөхөөр ирсэн.

*Хулгайлаагүй байж буцааж өгөхөөр*

*Христ Эзэн энэ дэлхийд иржээ*

*Гайхамшигт хайраа харуулахаар*

*Газрын шавар биеийг Тэр өмсжээ*

*Аваагүй зүйлээ буцааж өгөхөөр*

*Алдар суу, жавхлангаа Тэр орхижээ*

Хүний нүглээр дамжуулан хулгайлагдсан зүйлийг Эзэн Есүс сэргээгээд зогсохгүй илүү олон зүйл нэмж авчирсан. Адамын нүглээр дамжуулан алдсанаас илүү их яруу алдрыг Христийн төгс ажлаар Бурхан хүлээн авсан. Бурхан нүглээс болж бүтээлүүдээ алдсан. Харин нигүүлслээр дамжуулан хөвгүүдийг олж авсан. Хүн төрөлхтөн мөнхөд нүгэлгүй байсан бол Бурханд өргөх алдар нь Аврагчийн ажлаар дамжин ирэх алдрыг хэзээ ч гүйцэхгүй.

Тэгвэл Бурхан яагаад нүгэл орж ирэхийг зөвшөөрсөн юм бэ? Бурхан хүнийг сонголт хийх эрх чөлөөгүйгээр бүтээх боломжгүй байсныг бид мэднэ. Хүнийг өөрийнхөө хүсэл сонирхлын үндсэн дээр Бурханыг хүндлэх, хайрлах чадвартайгаар бүтээсэн. Ийм чадварыг өгөхөөр нөгөө талд, хүн Бурханыг эс дагах, үгүйсгэх, Бурханаас эргэх чадвартай болсон. Хүн нүгэл үйлдсэнээрээ Бурханыг эс дагах шийдвэр гаргасан. Гэхдээ Бурхан Өөрийн бүтээлүүдийн нүгэлд ялагдаагүй. Эзэн Есүс Өөрийнхөө үхэл, оршуулга, амилал, дээш одсоноороо нүглийг, тамыг, Сатаныг ялсан. Энэ дэлхийд нүгэл орж ирээгүй байхаас ч илүү их алдрыг Есүсийн ажлаар дамжуулан Бурхан авч, аврагдсан хүн илүү их ерөөлийг хүртсэн.

## 9 сарын 5

*"Тэрээр ертөнцөд байсан ба ертөнц нь Түүгээр буй болсон атлаа ертөнц Түүнийгээ эс танив. Тэр өөрийнхөндөө ирсэн боловч өөрийнхөн нь Түүнийг эс хүлээн авчээ. Харин Өөрийг нь хүлээн авсан болгонд, Өөрийнх нь нэрд итгэгчдэд Тэрээр Бурханы хүүхэд болох эрхийг өглөө. "* (Иох 1:10-12)

"Тэр ертөнцөд байсан." Амь ба алдрын Эзэн энэ жижигхэн гараг дээр амьдрахаар ирнэ гэдэг юутай ч зүйрлэшгүй нигүүлсэл билээ. Жирийн нэгэн хүнийг тэр ертөнцөд байсан гэж ярих нь сонин содон хэрэг биш. Хүн энэ дэлхийд төрөхөө өөрөө шийддэггүй. Харин Эзэн Есүсийн хувьд энэ нь зориудын сонголт, хайр нигүүлслийн үйлдэл юм.

"Ертөнц нь Түүгээр буй болсон." Юутай гайхалтай хэрэг вэ! Ертөнцөд байсан Нэгэн бол ертөнцийг Бүтээгч ажээ. Ертөнцийг дүүргэдэг Нэгэн, бяцхан хүү, өсвөр насны хүүхэд, залуу эр болж, хүний жижигхэн биед Өөрийгөө оруулжээ. Тэр бие дотор Бурханы гурвалын нэг нь дүүрнээрээ оршин суужээ.

"Ертөнц Түүнийгээ эс танив." Энэ бол уучилшгүй алдаа юм. Бүтээлүүд нь Бүтээгчээ таних ёстой. Нүгэлтнүүд Түүний нүгэлгүй байдалд бууж өгөх ёстой байлаа. Жирийн хүнээс гарамгүй үг ба үйлсээр нь Түүнийг хүмүүс таних ёстой байсан.

"Тэр өөрийнхөндөө ирсэн." Энэ ертөнцийн бүх зүйл Түүнийх. Тэр Бүтээгч учраас бүгдийг эзэмших эрхтэй. Тэрээр хэний ч эд хөрөнгөнд бурууг үйлдээгүй.

"Өөрийнхөн нь Түүнийг хүлээн авсангүй." Юутай их доромжлол вэ! Иудейчүүд Түүнээс татгалзсан. Тэрээр Мессиа гэдгээ бүх талаар нотолсон боловч иудейчүүд Түүгээр захируулахыг хүсээгүй.

"Харин Өөрийг нь хүлээн авсан болгонд..." Бурхан хүн бүхэнд урилга өгч байна. Иудей, грек гэж ялгалгүйгээр бүгдийг Тэр урьж байна. Ганцхан шаардлага нь Түүнийг хүлээн авах.

"Өөрийнх нь нэрд итгэгчдэд..." Үүнээс энгийн болзол гэж байхгүй. Бурханы хүүхэд болох эрх нь Есүс Христийг Эзэн ба Аврагч хэмээн итгэлээр хүлээн авсан болгонд өгөгдөнө.

"Бурханы хүүхэд болох эрхийг өглөө." Зохисгүй этгээдүүдэд хүртээсэн ямар их хүндлэл вэ! Тэрслүү нүгэлтнүүд Бурханы хүүхэд болно гэдэг ямар их хайр нигүүлсэл вэ!

Тэгэхээр дээрх эшлэлд муу ба сайн мэдээ агуулагджээ. Муу мэдээ нь гэвэл, ертөнц Түүнийг таниагүй бөгөөд өөрийнхөн нь Түүнийг хүлээн аваагүй. Сайн мэдээ нь гэвэл, "Өөрийг нь хүлээн авсан болгонд, Өөрийнх нь нэрд итгэгчдэд Тэрээр Бурханы хүүхэд болох эрхийг өглөө." Хэрэв та Түүнийг хүлээн аваагүй бол өнөөдөр яагаад Түүний нэрд итгэж болохгүй гэж?

## 9 сарын 6

*"ЭЗЭН Бурхан хүнийг авчирч, Еден цэцэрлэгийг арчлуулан сахиулахаар тэнд суулгав."* (Эх 2:15)

Зарим хүний боддог шиг ажил хөдөлмөр бол хараал биш ерөөл юм. Энэ ертөнцөд нүгэл орж ирэхээс өмнө Бурхан Адамд Еден цэцэрлэгийг арчлах үүрэг даалгавар өгсөн. Хүнийг нүгэлд унасны дараа Бурхан газар шороог хараасан болохоос ажлыг хараагаагүй. Хүн газрын үр шимээр амьдрахдаа бэрхшээл зовлон үзэж, хөлсөө дуслуулна гэж Бурхан тунхагласан (Эх 3:17-19).

Нэгэн хуучны үгэнд “Ажил хөдөлмөр гэдэг ямар их ерөөл вэ! Хэрэв чи Бурханы хараалыг үүрдэг гэвэл, Түүний ерөөл нь юу байх ёстой юм бэ” гэж хэлдэг. Гэхдээ ажил хөдөлмөрт Бурханы хараал байдаггүй. Ажил хөдөлмөр нь хүн байхын нэгэн хэсэг юм. Үр бүтээлтэй байж, утга учиртай амьдрахад ажил хөдөлмөр зайлшгүй хэрэгтэй. Юу ч хийхгүй зүгээр суугаа үед л нүгэл үйлдэх сэдэл хамгийн их төрдөг. Ажил хөдөлмөрөөс хөндийрч эхлэхээр хүний амьдрал уруудан доройтдог.

Бурхан Өөрийн ард түмэнд ажил хөдөлмөр хий гэж тушаасныг мартаж болохгүй. (“Чи зургаан өдөр ажилла” Гэт 20:9). Хүн энэ тушаалаас зөвхөн долоо дахь өдөр амар гэснийг онцлоод, зургаан өдөр ажилла гэснийг нэг их анзаардаггүй.

Шинэ гэрээнд ажил хийдэггүй хүнийг “зах замбараагүй”, “захиргаагүй” гэж цоллосон бөгөөд ажил хийдэггүй хүнд хоол бүү өг гэж тушаасан (2Тс 3:6-10).

Эзэн Есүс хичээнгүй шаргуу ажилладаг хүний дээд үлгэр дуурайлал юм. “Тэрээр өдрийн цагаар зогсоо зайгүй

ажиллаж, шөнийн цагаар залбирлаараа хөдөлмөрлөдөг байсан. Гурван жилийн үйлчлэл нь Түүний царайг гундаажээ. Хүмүүс түүний насыг тааж ядахдаа “Та тавь ч хүрээгүй байж” хэмээн хэлж байсан. Тэр дөнгөж гучхан настай байсан шүү дээ. Яагаад тийм овортой болсныг би ер гайхдаггүй.” (Иан Макферсон)

Зарим хүн ажлыг их голж шилдэг. Энэ дэлхий дээр төгс ажил гэж байхгүйг ойлгох хэрэгтэй. Ажил бүхэнд ямар нэг хэцүү тал байдаг. Харин итгэгч хүн ажлыг Бурханы алдрын төлөө хийх ёстой. Аргацааж биш, ялгууснаар хийх ёстой.

Итгэгч хүн зөвхөн өөрийн хэрэгцээний төлөө биш, мөн гачиж дутсан хүнд туслахын тулд ажиллаж хөдөлмөрлөх ёстой (Еф 4:28). Тэгэхээр бид зөвхөн өөрийгөө бодож ажил хийдэггүй байх нь.

Мөнхийн улсад ч гэсэн бид ажилласаар байх болно. Учир нь "Зарц нар нь Түүнд үйлчилнэ" (Илч 22:3) гэж бичигдсэн.

Тэр болтол бид Спержоны зөвлөгөөг дагах хэрэгтэй: "Ажил хөдөлмөрөөр өөрийгөө үхүүл. Дараа нь залбирлаар өөрийгөө амилуул."

## 9 сарын 7

*"Тиймээс тэдний дундаас гарч тусгаар бай» гэж Эзэн айлддаг. 'Бузар юманд бүү хүр. Би та нарыг хүлээн авч, Би та нарын Эцэг болж Та нар Миний хөвгүүд, охид болно' гэж Төгс хүчит Эзэн айлддаг." (2Ко. 6:17,18)*

Чуулган нь либерал үзэл санаатай болж, буруу номлол зааж эхэлбэл христэч хүн яах ёстой вэ? Библийн алдаа мадаггүйд итгэдэг, итгэлийн зөв сургаалыг баримталдаг хүмүүс тухайн чуулганыг анх байгуулсан. Сайнмэдээ, илгээлтийн ажилд идэвх зүтгэл гаргасан түүх ч түүнд бий. Номлогчид нь нэр хүндтэй, итгэмжтэй. Гэтэл өдөр ирэх тусам сургаал нь бага багаар гажуудаж, тэр чуулганаас гарч ирж байгаа номлогчид өөр сайнмэдээг номлох болов. Библийн үг хэллэгийг ашиглавч өөр утгаар ярьдаг болжээ. Тэд Библийн сургаалуудыг гуйвуулж, гайхамшгуудыг байгалийн үзэгдэл хэмээн тайлбарлаж, Библийн ёс суртахууныг уландаа гишгэж, Библийн хатуу баримтлалтай хүмүүсийг шүүмжилдэг боллоо.

Ийм үед христэч хүн юу хийх хэрэгтэй вэ? Магадгүй гэр бүл нь хэдэн үеэрээ тэр цуглаанд хамрагдсан байж болно. Өөрөө ч гэсэн олон жил цуглаандаа сэтгэл зүрхээ зориулсан. Дотно найзууд нь ч уг чуулганд явдаг. Намайг явчихвал хүүхэд залуус нь яах бол хэмээн сэтгэл нь өвдөнө. Би энэ чуулганд үлдэж чадах чинээгээрээ Бурханы дуу хоолой болох ёстой биш үү гэж хааяа бодогдоно.

Түүний энэ бодол өөрт нь зөв мэт санагдана. Гэвч чуулганд явж байгаа хүмүүс өдрөөс өдөрт буруу тийш хазайж буйг харах тусам сэтгэл зүрхэнд нь эмгэнэл харуусал төрнө. Чуулганд явдаг дотно хүмүүс нь түүнд үнэ



цэнтэй санагдавч Аврагч Эзэнийг гажууд номлолоороо гутаан доромжилж байгааг сонсохоор сэтгэл нь өвдөнө.

Ийм тохиолдолд тэр хүн яах ёстой нь тодорхой. Уг чуулганыг орхих хэрэгтэй. Энэ бол Бурханы үгэнд бичигдсэн тодорхой тушаал. Тэрээр тэнцвэргүй буулгаас өөрийгөө чөлөөлбөл Бурхан бүх үр дагаврыг хариуцна. Тэр чуулганд үлдэж байгаа залуу хүүхдүүдийг Бурхан Өөрөө хариуцна. Бурхан түүнд шинэ найз нөхдийг ч өгнө. Үнэндээ Бурхан түүний Эцэг нь болж, ойр дотно байна гэдгээ амласан юм. Энэ дотно харилцааг дуулгавартай хүмүүс л мэддэг. Гаж буруугаас салан тусгаарлах үед агуу Бурхантай дотносон нөхөрлөх ивээл ерөөл ирдэг.

## 9 сарын 8

*"Бурханд чи амласан бол биелүүлэхдээ бүү хойрго бай. Учир нь Тэр тэнэгүүдийг таашаадаггүй. Амласнаа биелүүл!"* (Ном 5:4)

Зовлонд унахаараа Бурханд ам өчиг өгдөг хүний тухай бид бүгдээрээ сонсож байсан. Өөрийг нь энэ зовлонгоос аврах л юм бол Танд итгэж, Танд үйлчилж, Таныг хайрлая хэмээн тэр хүн Бурханд амладаг. Гэвч зовлон арилахаар хэлсэн үгээ мартаад урьдын замаараа явдаг.

Христэч хүний хувьд амлалт ямар байр суурь эзлэх ёстой вэ? Амлалтын талаар Библи юу гэж хэлдэг вэ?

Нэгт гэвэл, бид заавал амлалт өгөх шаардлагагүй. Бурханы сайн сайханд талархсандаа сайн дураараа амлалт өгч болох ч, амлалт өг гэж Бурхан тушаагаагүй. Тийм учраас "Хэрэв чи андгайлаагүй бол гэм нүгэлгүй байхсан" гэж Дэд хууль 23:22-т бичигджээ.

Хоёрт гэвэл, ам өчиг өгөх гэж яарах хэрэггүй. Учир нь бид түүнийгээ биелүүлж чадахгүй байж магад. Эсвэл ам гарсандаа эргээд харамсаж болзошгүй. "Бурханы оршихуйд үг хэлэхэд зүрх чинь ч, хэл чинь ч бас бүү яараг. Учир нь Бурхан тэнгэрт, чи газарт байна. Иймд үгээ цөөн байлга" (Ном 5:2) гэж Соломон анхааруулж байна.

Хэрэв амлалт өгсөн бол түүнийгээ заавал биелүүлэх ёстой гэж Библи хэлдэг. "Хэрэв эр хүн сэтгэлээ үүрэгт хүлэхээр ЭЗЭНд ам өчиг өгч, тангараг өргөсөн бол тэр өөрийн үгийг зөрчих ёсгүй. Тэрээр амнаасаа гаргасан бүхний дагуу үйлдэх ёстой." (Тоо 30:2) "Чи ЭЗЭН Бурхандаа андгай өгсөн бол төлөхөө бүү удаашруул. ЭЗЭН

Бурхан чинь үүнийг чамаас заавал шаардах бөгөөд энэ нь чамд нүгэл болно." (Дх 23:21)

Амлачхаад биелүүлэхгүй байснаас анхнаасаа амлаагүй байсан нь дээр. "Амлаад эс биелүүлснээс амлахгүй байх чинь дээр." (Ном 5:5)

Амлалтаа зөрчих ёстой тохиолдол гэж бас бий. Тухайлбал, хүн Христэд итгэхээсээ өмнө, хуурамч шашин юм уу нууц бүлэглэлд тангараг өргөсөн бол тэрхүү тангаргаа зөрчих ёстой. Мөн ам тангаргийг биелүүлэх нь Бурханы үгтэй зөрчилдөж байвал тэр хүн ам тангаргаа зөрчөөд ч болов Библийг дагах хэрэгтэй. Хэрэв ямар нэг нууцыг чандлан хадгална гэж ам өгсөн бол тухайн бүлэглэлээс гарсан ч гэсэн үлдсэн амьдралынхаа турш түүнийгээ чандлан нууцалж болно.

Өнөөдөр хүмүүсийн хамгийн их эвддэг ам тангараг бол гэрлэлтийн тангараг юм. Анх гэрлэхдээ тэд Бурханы өмнө тангараг өргөдөг ч хожим нь түүнийгээ юман чинээ тоохгүй зөрчдөг. Гэсэн ч Бурханы үг хүчин төгөлдөр хэвээр байна: "ЭЗЭН Бурхан чинь үүнийг чамаас заавал шаардах бөгөөд энэ нь чамд нүгэл болно." (Дх 23:21)

## 9 сарын 9

*"Сайн хүн үр ач нартаа өв үлдээдэг."* (Сур 13:22 АБ2004)

Энэ эшлэлийг уншингуутаа үр хүүхдэдээ мөнгө санхүү өвлүүлэн үлдээх ёстой юм байна гэж бүү дүгнээрэй. Бурханы Сүнс, сүнслэг өвийн тухай ярьсан гэж үзэх нь илүү үнэнд нийцнэ. Ядуу боловч бурханлаг эцэг эхийн доор хүмүүжсэн хүн байж болно. Ээж аав нь нас барахдаа сохор зоос ч үлдээгээгүй боловч өдөр бүр Библи уншиж, залбирч, Эзэний сахилга бат, эмээн хүндлэл дор өсгөж хүмүүжүүлсэн бол, тэр хүн эцэг эхдээ үүрд талархах биз ээ. Сүнслэг өв бол хамгийн сайхан нь.

Үнэндээ их хэмжээний мөнгө өвлүүлэн үлдээгээд, хөвгүүд охидынхоо сүнслэг байдлыг бусниулах боломжтой. Гэнэт эд хөрөнгөтэй болох нь хортой. Үүнийг ухаалгаар захиран зарцуулж чаддаг хүн цөөхөн. Их хэмжээний өв хөрөнгө авч үлдээд Эзэний төлөө явсан хүн бараг байдаггүй.

Өөр нэг талаас нь бодож үзье. Нас барсан хүний өв хөрөнгийг хувааж авах гэж гэр бүлүүд атаархал хорсол, маргаан зөрчилд унадаг. Мөнгө төгрөгийн асуудал дээр гэнэтхэн олон хамаатнууд гараад ирдэг. Гэр бүлийн гишүүд олон жил эвтэй найртай амьдарч байснаа хөрөнгө мөнгө, эд хогшлоос болоод дайснууд болцгоодог.

Христэч эцэг эхүүд хөрөнгө мөнгөө сайнмэдээний төлөө ашиглаж болох байтал аврагдаагүй хүүхдүүд, хуурамч шашинтай хамаатнууд, талархаж мэддэггүй үр хүүхдэдээ үлдээдэг олон тохиолдол байдаг.

Үр хүүхдэдээ мөнгө үлдээх нь үнэндээ хувиа хичээсэн зангийн зүсээ хувиргасан хэлбэр байх нь олон. Эцэг эхүүд

тухайн хөрөнгөө чадах чинээгээрээ өөрсдөдөө хадгалж үлдэхийг хүссэндээ тийм үйлдэл гаргадаг. Нэг л өдөр үхэл тэднийг эд хөрөнгөөс нь салгана гэдгийг мэдээд хөрөнгө мөнгөө үр хүүхдэдээ гэрээслэн үлдээх уламжлалыг дагадаг.

Гэвч эд хөрөнгө нь зүй зохистой үрэгдэнэ гэсэн баталгаа байхгүй. Тэнгэрт одсных нь дараа хүүхдүүд нь эцэг эхийнхээ хүслийг биелүүлэхгүй ч байж болно.

Тийм учраас амьд сэрүүн байгаа дээрээ Эзэний ажилд өгөөмрөөр өгөх нь хамгийн зөв шийдэл юм. "Өгөхийгөө амьдадаа л өг. Үхсэний дараа мөнгө чинь хайчихыг та мэдэхгүй шүү дээ" гэж хэлдэг нь учиртай шүү дээ.

"Амьд сэрүүн байхдаа Бурханы ажилд хөрөнгө мөнгөө зарцуулах нь эрүүл ухаан юм. Үр хүүхдэдээ би христитгэлийг өвлүүлж, Христийг хүндэлсэн дурсамж болон Бурханы үгээс эмээж байсан хүүхэд насыг л үлдээе. Хүүхдүүдээ би Бурханд болон нигүүлслийнх нь үгэнд даатгая. Энэ л тэднийг босгон байгуулж, хэзээ ч мөхөшгүй өвийг өгч чадна." Хэрэв бид ийм сэтгэлтэй байвал хамгийн зөв зам юм.

## 9 сарын 10

*"Дайснуудаа хайрла, та нарыг хавчигчдын төлөө залбир."*  
(Мт 5:44)

Нэгэн түүхийг өгүүлбэл энэ эшлэлд хамгийн сайн тайлбар болох байх.

1941 оны 12 сарын 7-нд Сувдан эргийн халдлагыг удирдсан Японы нисгэгчийг ахмад Мицуо Фучида гэдэг. Тэрээр төв штаб руугаа “Тора, Тора, Тора” гэж мэдээ илгээв. Энэ нь даалгавар амжилттай болсныг илтгэнэ. Гэхдээ дэлхийн хоёрдугаар дайн дуусаагүй байлаа. Зөрчил улам ширүүсэж, дайны байдал өөрчлөгдөж, эцэст нь АНУ ялсан юм.

Дайны үеэр япончууд Филиппинд үйлчилж байсан настай хоёр илгээлтийн эзэн эхнэр нөхрийг хороожээ. Тэдний охин Америкт байлаа. Тэрээр эцэг эхийнхээ тухай мэдээ аваад дайнаас олзлогдсон япон хоригдлууд дээр очиж сайнмэдээ тараахаар шийджээ.

Хүмүүс түүнээс “Чи яагаад бидэнд ийм энэрэнгүй зөөлөн хандана вэ?” гэж асуухад "Алагдахаасаа өмнө эцэг эхийн минь залбирдаг байсан залбирлаас болж" хэмээн хариулдаг байлаа. Тэр өөр юу ч хэлдэггүй байв.

Дайн дууссаны дараа Мицуо Фучида машинд хорсон зэвүүцэж, дайны үеэр харгислал хэрцгийлэл үйлдсэн хэргээр АНУ-г олон улсын шүүхийн өмнө авчрахыг хүсжээ. Тэрээр баримт материал цуглуулахын тулд дайны үеийн япон хоригдлуудтай ярилцав. Гэвч дайны үеийн хоригдлууд харгислал хэрцгийллийг биш, эцэг эхээ Филиппинд алдсан сайхан сэтгэлт эмэгтэйн тухай ярьжээ. Тэр эмэгтэй Шинэ гэрээ гэдэг ном тарааж, эцэг эх нь

алагдахынхаа өмнө залбирдаг байсан залбирлын тухай ярьсан байна. Мэдээж хэрэг Фучида ийм үг сонсохыг хүсээгүй. Гэхдээ тэдний яриаг дотроо хадгалсан байлаа.

Олон хоригдол энэ түүхийг ярьсан учраас Фучида Шинэ гэрээ худалдан авчээ. Тэрээр Матайн сайнмэдээ уншиж байхад нэн сонирхолтой санагдаж, Маркийг уншихад бүр ч их татагдаж, Лукийн 23 дугаар бүлэг дээр ирээд сэтгэлд нь гэрэл асав. "Аав аа, юу хийж байгаагаа мэдэхгүй байгаа тэднийг уучлаач". Тэрээр Филиппинд байсан хоёр илгээлтийн эзэн алагдахынхаа өмнө юу гэж залбирч байсныг тэр даруй ухаарчээ.

Фучида америк эмэгтэй, дайны япон хоригдлуудын тухай бодохоо болив. Харин Христийн дайсан болсон өөрийнхөө тухай бодож эхлэв. Цовдлогдсон Аврагчийн залбирлын хариуд Бурхан түүнд уучлал үзүүлэхэд бэлэн байгааг ойлгов. Ингээд тэрээр Бурханаас уучлал гуйж, Христэд итгэн, уучлал ба мөнх амийг олжээ.

АНУ-г олон улсын шүүхэд дуудах төлөвлөгөө ч нуран уналаа. Мицуо Фучида үлдсэн бүх амьдралаа Христийг олон оронд тунхаглахад зориулсан юм.

## 9 сарын 11

*"Өөрийн Бурхан ЭЗЭНийг умартахаас болгоомжил... чамд байгаа бүхэн чинь арвижих үед..." (Дх 8:11,13)*

Бурханы хүмүүс ер нь материаллаг эд хөрөнгөөр арвижаад ирэхээр зөвт байдлаа хадгалж чаддаггүй. Тэд зовлон зүдүүр дор илүү сайн байдаг. Мосе үдэлтийн дуундаа хөгжил дэвшил нь Израилийг сүнсний доройтолд оруулна гэдгийг зөгнөсөн: "Гэтэл Иешурун өөхөлж, тэлчлэв. Чи өөхөлж, бүдүүрч, тэнтийв. Өөрийг чинь бүтээсэн Бурханыг хаяж, өөрийг чинь аварсан Хадыг үл ойшоов." (Дх 32:15).

Энэ зөгнөл Иеремиагийн өдрүүдэд биеллээ олж, Эзэн тэдэнд унтууцан "Тэднийг Би цадтал хооллоход харин тэд завхайрч, янхны гэрт бөөгнөрөв" (Иер 5:7) гэж айлдсан.

Мөн Хосеа: "Бэлчээртэй болмогцоо тэд цаджээ. Цадмагцаа зүрх нь бардам болжээ. Тиймээс тэд Намайг мартсан" (Хос13:6) гэж бичжээ.

Цөллөгийн дараа левичүүд Израилийн нүглийг улайж, Эзэний үйлдсэн сайн сайнхны дагуу хандаагүй гэдгийг өчсөн: "...Тиймээс тэд идэцгээж, таргалцгааж, агуу сайн сайханд тань баясав. Гэвч тэд Танд тэрслэн тэрсэлээр Таны хуулийг ардаа орхисон. Тан уруу эргэж ирүүлэхийн тулд өөрсдийг нь ятгасан Таны эш үзүүлэгчдийг тэд алж, аймшигт доромжлолыг үйлдсэн." (Нех 9:25,26).

Эд хөрөнгөөр арвижаад ирэхээрээ хийж байгаа үйлс, байгаа байдлыг маань Эзэн дэмжиж байна гэж буруугаар ойлгох хандлага бидэнд бий. Бизнесийн маань ашиг орлого нэмэгдээд ирэхээр "Эзэн намайг үнэхээр ерөөж байна" гэж бид хэлдэг. Үнэндээ тэр ашиг орлогыг шалгалт



гэж харвал илүү үнэнд нийцнэ. Тэр бүх эд хөрөнгөөр юу хийхийг маань Эзэн харж байдаг. Өөрсдийнхөө махан биед зориулах нь уу эсвэл итгэмжит нярвын адилаар дэлхийн өнцөг булан бүрд сайнмэдээ тараахад зарцуулах нь уу, ирээдүйнхээ баталгаа болгож хуримтлуулах нь уу эсвэл Христийн төлөө хөрөнгө оруулах нь уу гэдгийг Эзэн харж байдаг.

"Нарлаг өдөр ба шуургатай үе, амжилт ба уналтын аль нь зан чанарыг хамгийн хүндээр шалгадаг вэ гэж асуувал хариултыг нь хүний төрөлх араншин тов тодорхой хэлээд өгнө. Хүн элбэг хангалуун болохоороо л хамгийн хүнд сорилтод ордог." (Ф.Б.Мэйер)

Иосеф үүнтэй санаа нийлэх байсан нь дамжиггүй. "Бурхан, зовлон зүдүүрийн маань газарт намайг үржүүлсэн" (Эх 41:52) гэж тэр хэлсэн. Иосеф эд хөрөнгө, алдар нэртэй амьдралаасаа илүү зовлон дундаас жинхэнэ ашгийг олсон юм. Гэхдээ тэр аль ч нөхцөлд нь итгэмжит байдлаа гээгээгүй.

## 9 сарын 12

*"Түүнийг жингийн цуваан дунд байгаа хэмээн тэд бодсоор аяныхаа нэг өдөр яваад..." (Лк 2:44)*

Есүсийг 12 настай байхад эцэг эх нь Алгасал баярыг тэмдэглэхээр Назараас Иерусалим руу явжээ. Тэд Иерусалимыг зорьсон олон түмэнтэй цуг явсан байж таарна. Мэдээж хэрэг нас чацуу хөвгүүд баярын үеэр найзалж нөхөрлөн нэг дор байцгаасан. Тийм болохоор Иосеф, Мариа хоёр Назар руу буцаж байхдаа Есүсийг бусад хүүхэдтэй хамт, аль нэг тэргэнд яваа гэж бодсон. Гэтэл Есүс хамт байсангүй. Тэрээр Иерусалимд хоцорчээ. Есүсийг байхгүйг мэдэх хүртлээ ээж аав нь нэг өдөр аялсан байна. Тэд Иерусалим руу буцаж гурван өдрийн дараа Есүсийг олсон.

Энэ түүх бидэнд нэгийг өгүүлнэ. Есүс бидэнтэй хамт яваа гэж бодох ч үнэндээ хамт байхгүй байж болно. Аврагч Эзэнтэй минь харилцах харилцаан дундуур нүгэл орж ирсэн ч, өөрсдийгөө бид Түүнтэй нөхөрлөж явна хэмээн буруу бодож болох юм. Бурханыг гэсэн хайр хөрөх үед бид анзаардаггүй. Учир нь энэ нь маш заль мэхтэй. Бид өөрсдийгөө өмнөх шигээ байгаа гэж бодсоор л байдаг.

Гэхдээ бусад хүн бидний үнэн байдлыг хэлж чадна. Анхны хайр минь хөрж, дэлхийн юманд татагдаж, сүнслэг зүйлсийг умартаж байгааг тэд хэлж чадна. Египетийн сонгино, саримс, гогод, жууцайгаар хооллож байгаа минь хөндлөнгийн хүмүүст харагддаг. Өмнө нь зөв бодолтой, бусдыг хайрладаг, сайхан сэтгэлтэй байсан бол одоо буруудаад байгааг минь тэд анзаардаг. Сионы хэлээр биш гудамжны яриагаар яриад байгааг минь олж хардаг. Тэд

анзаарсан ч эс анзаарсан ч, итгэлийн амьдралаас сэтгэл хөндийрөөд ирэхээр зүрхний минь дуу хуур арилдаг. Аз жаргалгүй болж, уйтгар гунигт автан бусад хүнийг ч гэсэн гуниглуулдаг. Бүх юм маань буруугаар эргэсэн мэт санагдана. Олсон мөнгө минь салаагаар урсана. Аврагч Эзэнийг гэрчлэвч хүмүүст өчүүхэн бага нөлөөлнө. Учир нь бид тэднээс ялгарахаа больжээ.

Есүс хамт байхгүй үед амьдралд дохио дуугардаг. Магадгүй хэн нэг тослогдсон номлогчоор дамжуулан Бурхан үгээ хэлнэ. Эсвэл найз минь үнэн байдлыг хэлнэ. Эсвэл өвчин, хайрт хүний минь үхэл, сэтгэлийн утсыг хөндөх гашуун үйл явдал тохиолдоно.

Ийм үе амьдралд ирвэл Иосеф Мариа хоёрын хийснийг хийгээрэй. Тэд Есүсийг хамгийн сүүлд харсан газар руугаа буцаж явсан. Эзэн Есүстэй харилцах харилцаа минь нүгэлд сэвтсэн тэр газар руугаа эргэж оч. Тэндээ нүглээ улайж, гэмээсээ гэдрэг эргэж уучлалыг ол. Ингэж байж, Есүстэй хамт цааш дахин аялж чадна.

## 9 сарын 13

*"Түүнтэй ярьснаас болж нүүрнийх нь арьс гэрэлтсэнийг Мосе мэдсэнгүй" (Гэт 34:29)*

Мосе Синаи уулнаас арван тушаал бүхий чулуун хавтанг бариад бууж ирлээ. Эндээс хоёр зүйлийг онцлон хэлэх ёстой. Нэгт нь, Шекмах гэгддэг алдрын үүлэнд Өөрийгөө илчилсэн Эзэний оршихуйд байхдаа Мосегийн нүүр гэрэлтжээ. Мосе Бурхантай ярьж байхдаа цог жавхлангийнх нь нөлөөг авч нүүр царайнд нь гэрэл тодорсон байв.

Хоёрт гэвэл, нүүр царай нь гэрэлтэж байгааг Мосе мэдээгүй. Эзэнтэй уулзсаны дараа нүүрэнд нь үүссэн онцгой шинж тэмдгийг тэр огт анзаараагүй.

Мосегийн эл явдал бидэнд ч бас тохиолддог. Бид Эзэний оршихуйд цагийг өнгөрөөхөд үр дагавар нь бидний нүүр царайнд тодордог. Учир нь сүнс ба бие махбод хоорондоо нягт холбоотой. Гэхдээ би энд биеийн байдалд илэрдэг чанаруудыг ярихгүй. Учир нь зарим гаж сургаалтнууд ч гэсэн нүүрэндээ маш сайхан мишээл тодруулж чаддаг. Харин би, Эзэнтэй харилцах харилцаа нь бидний зан чанар хийгээд сүнсэнд өөрчлөлт авчирдгийг хэлмээр байна. Паул энэ тухай 2Коринт 3:18 дээр ярьсан: "Харин бид бүгд бүтээлэггүй нүүрээрээ Эзэний алдрын тусгалыг тольдох мэт хараад, Түүний дүрд Эзэний Сүнсээр алдраас алдарт өөрчлөгддөг."

Гэхдээ ийнхүү өөрчлөгдөж буйгаа бид өөрсдөө мэддэггүй. Бусад хүн хардаг. Тэд биднийг Есүстэй хамт байсныг маань мэднэ. Харин энэ өөрчлөлт бидний нүдэнд харагддаггүй.

Нүүрэнд минь гэрэл цацарч байхад бид яахин мэдэж чадахгүй байх билээ гэж та бодож байна уу? Шалтгааныг нь би хэлье. Эзэнтэй ойр байх тусмаа өөрсдийн нүгэл, хувиа хичээсэн зан, арчаагүй сул доройгоо бид улам таньж мэддэг. Эзэний оршихуйн цог жавхлан биднийг илүү их гэмшилд хөтөлж, өөрсдийнхөө муу муухайг олж харахад тусалдаг.

Хэрэв бид өөрсдөөс минь цацарч буй гэрлийг олж харах юм бол эргээд бардамнана. Өнөөх гэрэл маань бардамнах шалтгаан болчихно.

Тэгэхээр Эзэний уулан дээрээс нүүрэндээ гэрэл цацруулж бууж ирснээ мэдэхгүй байх нь бидэнд сайн.

## 9 сарын 14

*"ЭЗЭН амьд! Үүнээс болж чамд ямар ч шийтгэл ногдохгүй."* (1См 28:10)

Саул хаанчлалынхаа эхэн үед бүх мэргэ төлөгч, сүнс дуудагчдыг газар нутгаасаа зайлуулах зарлиг гаргасан. Гэтэл цаг хугацаа явж Саулын хувийн амьдрал хийгээд олны өмнөх байр суурь уналтад орсон. Самуел нас барсны дараа филистчүүд Гилбоад Саулын армийн эсрэг цугласан. Саул Эзэнээс ямар нэг үг авч чадахгүй болохоор нь Ендорын увдист эмээс зөвлөгөө авсан. Тэр эм айн байж, "Та энэ нутгаас бүх сүнс дуудагчдыг зайлуулахыг зарлигдсан шүү дээ" хэмээн сануулахад Саул "ЭЗЭН амьд! Үүнээс болж чамд ямар ч шийтгэл ногдохгүй" (1См 28:10) гэж баталгаа өгөв.

Энэ түүхийн сургамж тодорхой байна. Ихэнх хүн, нөхцөл байдал өөрсдөд нь таарч байгаа үед Эзэнийг дагадаг. Харин таарамжгүй болбол өөрсдийнхөө хүслээр хийх янз бүрийн шалтгийг тэд гаргаж ирдэг.

Би сая "тэд" гээд хэлчихсэн үү? "Бид" гэж хэлэх ёстой байх. Бид бүгдээрээ Эзэнд дуулгаваргүй баймаар үедээ Библийг өөрсдийнхөөрөө тайлбарлаж, мушгин гуйвуулдаг.

Нэг жишээ хэлье. Чуулганд эмэгтэйчүүд ямар үүрэгтэй талаар Библи тодорхой хэлсэн. Гэтэл одоогийн феминист хөдөлгөөнөөс болоод энэ үгсийг тоохоо больжээ.

Үүндээ бид ямар тайлбар өгдөг вэ? "Энэ тушаал тухайн үеийн соёлтой холбоотой байсан. Өнөөдрийн бидэнд хамаагүй" гэж хэлдэг. Хэрэв энэ зарчмыг хүлээн зөвшөөрөх юм бол Библиэс ямар ч санааг гаргаж ирж болно.

Жишээлбэл, Есүс дагалдагчийн талаар зарим нэг хатуу мэдэгдлийг хэлсэн. Энэ мэдэгдлүүд биднээс дэндүү ихийг шаардаад байгаа юм шиг санагдахаар "Есүс ийм утгаар хэлээгүй" хэмээн тайлбарлаж, өөрсдийнхөө дур зоргоор явцгаадаг. Бурханы үгийг дагах сонирхолгүй, өөрсдийнхөөрөө явахыг хүсэхдээ бид өөрсдийгөө хуурдаг.

Бас нэг жишээ хэлбэл, буруутай этгээдийг Библийн дагуу сахилгажуулах ёстой гэж бид хатуу зогсдог. Гэтэл нөгөө буруутан нь бидний найз нөхөд, хамаатан садан болоод ирэнгүүт хатуу байр суурь маань зөөлөрч, эсвэл бүр ор мөргүй алга болно.

Өөр нэг тохиолдол бол Библийн тушаалуудыг "чухал" ба "чухал бус" гэж ангилах явдал. Чухал бишүүдийг нь тоож үзэхгүй өнгөрчихдөг.

Үнэнийг хэлэхэд энэ бүх шалтаг тайлбарууд маань худал хуурмаг бөгөөд эцсийн эцэст өөрсдийг маань л сүйрэлд хүргэнэ. Бидэнд тааламжтай байсан ч тааламжгүй байсан ч үгийг нь дуулгавартай дагаасай гэж Эзэн хүсэж байна. Энэ бол ерөөлийн зам мөн.

## 9 сарын 15

*"Найдвар нь биднийг гонсойлгодоггүй. Учир нь бидэнд өгөгдсөн Ариун Сүнсээр дамжин Бурханы хайр зүрхэнд маань цутгагдсан байдаг."* (Ром 5:5)

Зарим үг христэч утгаар хэрэглэгдэхээрээ жирийн үеийнхээс ондоо утгатай болдог. Тийм үгнүүдийн нэг нь "найдвар" юм.

Энэ ертөнцийн хүмүүсийн хувьд "найдах" гэдэг нь ирээдүй рүү чиглэсэн, одоогоор харагдахгүй байгаа зүйлийг хэлэх боловч түүнд нь биелнэ гэсэн баталгаа байхгүй. Санхүүгийн гүн хямралд орсон хүн, "Бүх юм сайнаар эргэнэ гэж би найдаж байна" гэж хэлж болно. Гэхдээ бүх зүйл сайнаар эргэнэ гэсэн бүрэн баталгаа энэ үгэнд байхгүй. Энэхүү найдаж хэлсэн үг нь жирийн ерөөл төдий. Христэч найдвар нь мөн ялгаагүй ирээдүйн үл үзэгдэх зүйл рүү чиглэдэг. Ром 8:24 дээр "Харагдаж байгаа найдвар нь найдвар биш юм. Хүн харж буй зүйлдээ найдахын хэрэг юу байна?" гэж Паул хэлсэн. Найдвар бүхэн ирээдүй рүү чиглэдэг.

Гэхдээ христэч найдвар Бурханы үгэн дэх амлалтад суурилдаг учраас ялгаатай. Христэч хүний найдвар нь туйлын баталгаатай. "Энэхүү найдвар бидэнд сэтгэлийн зангуу мэт бөгөөд найдвартай хөдөлгөөнгүй" (Евр 6:19). Найдвар гэдэг нь "Бурханы амлалт ба зөгнөж хэлсэн зүйлийн одоо цагийн баталгаанд амьдарч, Бурханы үгээс зуурах итгэл юм." (Вүүдринг) "Найдварыг би баталгаа гэсэн утгаар ашиглаж байгааг минь анзаараарай. Библийн утгаар найдвар гэдэг нь ирээдүйд гарцаагүй болох зүйлд итгэхийг хэлдэг. Энэхүү найдвар нь сэтгэлийг сэргээх



гэсэн хоосон үнэмшил юм уу баталгаагүй хувь тавиланг сохроор дагаж явахыг хэлэхгүй. Найдвар нь христэч амьдралын үндэс суурь. Найдвар бол жинхэнэ бодит байдал." (Жон Уайт)

Итгэгч хүний найдвар Бурханы амлалтад суурилсан учраас хэзээ ч түүнийг ичгүүрт оруулж, урмыг нь хугалахгүй. (Ром 5:5) "Бурханы амлалтгүй найдвар нь хий хоосон бөгөөд ихэнхдээ давилуун бардамнал байдаг. Харин Бурханы амлалтад түшиглэсэн найдвар нь Бурханы зан чанарт суурилдаг бөгөөд урмыг маань хэзээ ч хугалахгүй." (Вүүдринг)

Христэч найдварыг сайн найдвар гэж хэлдэг. Бидний Эзэн Есүс ба Эцэг Бурхан нь биднийг хайрладаг учраас "мөнх тайтгарал ба сайн найдварыг нигүүлслээр өгсөн" (2Тс 2:16).

Христэч найдварыг ерөөлт найдвар гэж нэрлэдэг ба энэ нь тухайлан Христийн ирэлттэй холбогддог: "Бид аугаа Бурхан ба Аврагч Есүс Христийнхээ ерөөлт найдвар хийгээд цог жавхлант илэрхийллийг хүлээдэг" (Тит 2:13).

Христэч найдварыг амьд найдвар гэдэг: "Бурхан Өөрийн агуу өршөөлөөр, үхэгсдээс амилсан Есүс Христийн амиллаар биднийг амьд найдвар өөд..." (1Пт 1:3).

Христэч найдвар нь дуусашгүй урт өдрүүд, зовлон гамшиг, хавчлага, үхлийг хүртэл даван туулах хүчийг өгдөг. Одоогийн зовлон нь ирээдүйн алдрын дэргэд юу ч биш гэдгийг бид мэднэ.

## 9 сарын 16

*"Найдлага байхад хүүгээ гэсгээ. Түүний үхлийг бүү хус."*  
(Сур 19:18)

Бид өнөөдөр юм бүрийг зөвшөөрдөг нийгэмд амьдарч байна. Ялангуяа хүүхэд хүмүүжлийн асуудалд хүмүүс Бурханы үгэнд анхаарахын оронд сэтгэл зүйч социологичдын үгэнд анхаардаг. Хатуу сахилгажуулал дор өссөн олон томчууд хүүхдүүддээ эрх чөлөө, өөрөөрөө байх боломжийг олгохоор шийдэцгээжээ. Үр дүнд нь юу болох вэ?

Тийн өссөн хүүхдүүд хамгаалагдаагүй мэдрэмжийг авдаг. Тэд нийгэмдээ дасан зохицож чаддаггүй. Асуудал зовлон ирэхээр яаж шийдэх ухаанаа ололгүй архи, тамхи, мансууруулах бодисоос амар амгаланг хайдаг. Хүүхдээ хэдхэн жил сахилга баттай өсгөхөд цааш цаашдынх нь амьдрал улам амар болно.

Тэд зах замбараагүй амьдарч байгааг гайхах шалтгаан ерөөсөө байхгүй. Анхнаасаа бодол санаа нь эмх цэгцтэй байж сураагүй учраас гадаад байдал, амьдралын хэвшил, зан чанар нь цадиггүй болдог.

Цаашлаад дорд муу амьдралаар амьдарч байгаадаа сэтгэл нь ер өвдөхгүй. Спорт, хөгжим, урлаг, бизнес гэх мэт амьдралын янз бүрийн талбарт амжилт гаргая гэсэн хүсэл тэмүүлэл ч үгүй болно.

Тийм хүүхдүүд эцэг эхээсээ хөндийрдөг. Эцэг эх нь хүүхдэдээ сахилгажуулал үзүүлэхгүй байснаараа хүүхдийнхээ хайрыг олж авна гэж боддог боловч хүүхдүүд нь эцэг эхээ үзэн яддаг.

Эцэг эхийнхээ эрх мэдлийн эсрэг тэрсэлсэн тэрслэл нь сургууль, ажил, төр засаг гээд амьдралын бусад талбар руу хальдаг. Эцэг эх нь хүүхдийнхээ дураараа занг бага балчир байхад нь дардаг байсан бол амьдралын бусад талбар дээр хүүхдүүд нь хүнд захирагдаж чадах байлаа.

Цаашлаад тэрслүү зан нь Бурханы үгэнд бичигдсэн ёс суртахууны стандартууд руу хальдаг. Ариун шударга амьдрах, зах замбараагүй байдлаа орхих талаар Бурханы тушаалуудыг тэд элэглэн дооглодог. Тэгээд сайн гэсэн болгоныг жигшиж, ёс бус, гажууд, муу гэсэн болгоныг хайрлана.

Эцэст нь хэлэхэд, сахилгажууллаар дамжуулан хүүхдээ хүмүүжүүлж чадаагүй эцэг эхчүүд хүүхдүүдээ авралаас бүр холдуулдаг. Хүн Христэд итгэхийн тулд, Бурханы эрх мэдэлд тэрсэлсэн хүслээ хаях ёстой болдог. Тийм ч учраас Сузанна Уэсли: "Хүүхдийнхээ доторх өөртөө төвлөрсөн хүслийг өөрчлөх тал дээр ажиллаж буй эцэг эх нь хүүхдийнхээ сүнсийг аврах ажил дээр Бурхантай хамтран зүтгэж байна. Харин хүүхдийнхээ хүслийг дураар нь тавигч эцэг эх болбоос диаволын ажлыг хөхүүлэн дэмжиж, хүүхдээ итгэлээс холдуулж, авралын замаас төөрүүлж, хүүхдийнхээ бие, сэтгэл, сүнсийг үүрдийн үүрд алдах ажлыг хийж байна" хэмээн хэлсэн.

## 9 сарын 17

*"Тэрээр том жижиг, баян ядуу, чөлөөт хийгээд боол хүмүүсийн болон бүгдийн баруун гар дээр нь, эсвэл духан дээр нь тэмдэг тавиулснаар тэмдэг, араатны нэр, эсвэл нэрийнх нь тоотой хүнээс өөр нэг ч хүн худалдаж, худалдан авч чадахгүй болох ажээ."* (Илч 13:16,17)

Араатны тэмдэг! Их гамшгийн үед эрх мэдэлтэй хорон муу удирдагч гарч ирээд хүн бүрийн дух болон баруун гар дээр тэмдэг тавихыг тушаана. Уг тэмдгээс татгалзсан хүн араатны уур хилэнг хүртэнэ. Тэмдгийг авсан хүн харин Бурханы уур хилэнг хүртэнэ. Тэмдгээс татгалзсан хүн Христтэй хамт мянган жилийн цог жавхланд хаанчилна. Тэмдгийг авсан хүн ариун тэнгэрэлч ба Хурганы өмнө хүхэрт галт нуурт тарчилна.

Энэ зөгнөл ирээдүйд хамаатай бөгөөд тэр цагт Христийн чуулган тэнгэр дэх гэр рүүгээ авагдчихсан байх учраас бидэнд хамаагүй гэж та бодох байх. Тэгвэл өнөө цагт араатны тэмдэгтэй утга дүйх зүйл байдаг. Бурханд үнэнч үлдэх үү эсвэл Бурханыг эсэргүүцдэг тогтолцоонд бөхийх үү гэдгийн аль нэгийг сонгох үе амьдралд ирдэг шүү.

Жишээ нь, ажилтай болохын тулд Бурханы зарчмын эсрэг болзлыг хүлээн авах уу гэдэг сонголт ирдэг. Ажил хийхгүй бол хоол хүнсээ авч чадахгүй. Хоол хүнсээ авч чадахгүй бол амьд явах боломжгүй. Тэгэхээр бид чинь амьд явах хэрэгтэй биш гэж үү? Энэхүү худал шалтгийг хэлээд ажил олгогчийн шаардлагыг хүлээж авбал араатны тэмдгийг хүлээн авсантай адил юм.

Бидний хоол хүнс, амь насанд аюул занал учрангуут бид уг заналхийллийг зайлуулахын тулд юугаа ч золиослоход бэлэн болдог. Их гамшгийн үед шүтээнд мөргөх хүмүүс яг л ийм шалтаг хэлнэ. Өнөөдөр ч ялгаагүй, Бурханы үнэнийг сонгох уу эсвэл амь насаа аврах уу гэдэг сонголт бидэнд ирж болно.

Бид амьдрах ёстой гэдэг үзэл санаа бол худал хуурмаг. Бидний үүрэг болбоос зөвхөн Бурханыг дагаж, амь насаа үхэлд хүртэл үл хайрлах явдал.

"Үнэнийг худалддаг зоосны маань сүлдэн тал дээр үргэлж анти-Христийн дүрс байдаг юм шүү." (Ф.В.Грант) Тэгэхээр "Би их гамшгийн үед амьдарч байвал араатны тэмдгээс татгалзаж чадах уу?" гэж өөрөөсөө бүү асуу. Харин "Одоо үнэнийг худалдахаас татгалзаж чадах уу?" гэж асуу.

## 9 сарын 18

*"Арван хүн эдгээлгэсэн биш үү? Харин бусад ес нь хаана байна?" (Лк 17:17)*

Эзэн Есүс уяман өвтэй арван хүнийг эдгээсэн боловч нэг нь л буцаж ирж талархлаа өргөсөн. Тэр нь ад үзэгддэг самари хүн байлаа.

Амьдралын нэгэн үнэ цэнтэй туршлага гэвэл талархдаггүй хүмүүстэй учрах юм. Тэгснээрээ Бурханы сэтгэл хэрхэн эмтэрдгийг өчүүхэн ч атугай мэдэрч чадна. Хүнд өгөөмрөөр гараа сунгатал хариуд нь ямар ч талархал байхгүй үед талархаж мэддэггүй энэ ертөнцийн төлөө Хүүгээ өгөхөд Бурханд ямар сэтгэл төрж байсныг ойлгож болох юм. Бусдын төлөө эцэж цуцалгүй үйлчилбэл талархдаггүй хүн төрөлхтний төлөө боолын байр суурийг авсан Нэгэнтэй бид нөхөрлөж чадна.

Үл талархах зан нь нүгэлд унасан хүмүүсийн нэг чанар юм. Ертөнц Бурханыг мэдсэн атлаа Бурхан гэж алдаршуулсан ч үгүй, талархал өргөсөн ч үгүй хэмээн Паул сануулсан (Ром 1:21). Бразилд үйлчилж байсан илгээлтийн эзэн, баярлалаа гэдэг үг үгийн санд нь байдаггүй хоёр овгийг нээжээ. Тэдэнд сайхан сэтгэл үзүүлбэл хариуд нь тэд, "Наадах чинь миний хүссэн зүйл байна" гэнэ. Эсвэл "Энэ чинь надад хэрэг болно" гэж хэлдэг ажээ. Хойд Африкт ажиллаж байсан өөр нэгэн илгээлтийн эзэн, очсон газрынх нь хүмүүс огт талархахгүй байгааг анзаарчээ. Бусдын тусыг авах нь Бурханы өмнө гавьяа байгуулах боломжийг нөгөө хүндээ олгодог гэсэн итгэл үнэмшил тухайн соёлд байдгаас болоод тэд ерөөсөө талархдаггүй байна. Тэдний бодлоор, хийж байгаа сайн

үйлээрээ Бурханы тааллыг илүү их олж байгаа учраас талархах ёстой хүн нь өнөөх илгээлтийн эзэн ажээ.

Үл талархах байдал манай нийгмийн бүх хүрээнд нэвчсэн. "Агаараар ажил зуучлах төв" нэртэй радио хөтөлбөр 2500 гаруй хүнд ажил олж өгсөн байна. Гэвч 2500 хүнээс аравхан нь л талархлын захидал ирүүлсэн гэнэ.

Амьдралынхаа тавин жилийг багшийн ажилд зориулсан хүн байлаа. Наян нас хүрэхдээ тэрээр нэгэн сурагчаасаа талархлын захиа хүлээж авсан байна. Боловсролын салбарт тавин жил ажилласан боловч түүнд ирсэн цорын ганц талархлын захиа энэ байжээ.

Хүмүүсийн баярлаж талархахгүй байгааг мэдрэх нь бидэнд сайн гэж би дээр өгүүлсэн. Яагаад гэвэл Эзэний мэдэрдэг сэтгэлийг бид бага ч атугай мэдэрнэ. Нөгөө талаараа, бид өөрсдөө бусдад талархах ёстойг ойлгоно. Бурханд залбирахдаа бид ихэвчлэн гуйлт хүсэлтийг л хэлдэг боловч талархлыг нэг их хэлдэггүй. Бурханаас өчнөөн олон ивээл ерөөлийг хүртчихээд баярлалаа гэдэг үгэнд хойрго ханддаг. Дээрээс нь, бид бусдын тусламж, зочломтгой зан, өгөөмөр сэтгэл, ач тусын төлөө талархлаа илэрхийлэхдээ муу. Тэр бүх сайхан сэтгэлийг угаасаа авах ёстой юм шиг санадаг.

Талархах мянган шалтгаан байвч үүнийг ухаардаг цөөн хүн байдгийг дээрх арван уяман өвчтөн бидэнд сануулж байна. Бүгдээрээ тэр цөөн хүмүүсийн нэг болцгооё.

## 9 сарын 19

*"Биднийг дорой байхад, сүсэг биширэлгүй хүмүүсийн өмнөөс Христ яг л цагтаа үхсэн билээ."* (Ром 5:6)

Христ сайн хүмүүсийн төлөө үхэхээр эсвэл зөвтнүүдийг дуудахаар ирээгүй. Төлөв төвшин, хүндлүүштэй, шударга хүмүүсийн төлөө Тэр загалмай дээр цовдлогдоогүй. Тэрээр муу хүмүүсийн төлөө үхсэн юм.

Мэдээж Бурханы нүдээр бүх хүн нүгэлтэн. Бид бүгдээрээ нүглийн дотор төрж, хилэнц дотор бүрэлдсэн. Бид бүгдээрээ хонь мэт төөрч, өөр өөрсдийн замаар явсан. Бурханы ариун нүдээр харвал, бүх хүн тэрслүү, бузар, завхарсан. Зөвийг үйлдье гэсэн хамгийн шилдэг зүтгэл маань ч хиртэй даавуутай адил.

Гол асуудал нь өөрийгөө нүгэлтэн гэж хүлээн зөвшөөрөх дуртай хүн тун цөөхөн. Ихэнх хүн өөрийгөө янз бүрийн гэмт хэрэгт холбогдсон хүмүүстэй харьцуулж үзээд "Би гайгүй юм байна. Би диваажинд орж чадна" гэж мунхаглан боддог. Нийгмийн ажилд идэвхтэй байгаагаа, буяны ажилд хандив өргөдгийгөө их юманд санаж, бардамнаж, өөрийгөө дээгүүр зиндааны хүн хэмээн сэтгэдэг эмэгтэй байжээ. Нэгэн удаа христэч хөрш нь түүнд Есүсийн тухай ярьж өглөө. Тэр эмэгтэй, "Надад яагаад аврал хэрэгтэй гэж? Миний сайн үйлс хангалттай шүү дээ! Манайхан удмаараа христэч байсан. Би өөрөө ч сүмд явдаг байлаа" гэж хариу хэлэв. Тэгтэл христэч хөрш нь цаасан дээр "НҮГЭЛТЭН" гэж томоор бичээд "Энэ цаасыг таны цамцан дээр наавал та дургүйцэх үү?" гэж асуулаа. Эмэгтэй, "Мэдээж дургүйцнэ. Хэн ч намайг нүгэлтэн гэдэггүй юм" хэмээн унтууцжээ. Өөрийгөө



шударга сайн хүн гэж итгэсэн түүнд итгэгч хөрш нь ингэж тайлбарлав. "Хэрэв та өөрийгөө нүгэлтэн гэж хүлээн зөвшөөрөхгүй бол Христ таны төлөө үхээгүй гэсэн үг. Төөрсөн хүн гэдгээ хүлээн зөвшөөрөхгүй бол аврагдаж чадахгүй. Өөрийгөө эрүүл гэж үзэж байвал Эмч тан дээр ирэхгүй."

Томоохон зааланд тусгай арга хэмжээ болж байлаа. Энэ арга хэмжээ хараагүй, хөгжлийн бэрхшээлтэй, тахир дутуу хүүхдүүдэд зориулагджээ. Тэнд оролцож буй хүүхдүүд тэргэнцэртэй, таягтай, хүнээр түшүүлсэн байлаа. Арга хэмжээ дундаа орж явтал нэг хүүхэд үүдний шатан дээр уйлж суухыг зохион байгуулагч анзаарав.

- Хүү минь чи юундаа уйлаа вэ?

- Тэд намайг оруулахгүй байна.

- Яагаад чамайг оруулахгүй байгаа юм бол?

- Би цоо эрүүл юм байна.

Сайнмэдээний найран дээр мөн ийм явдал болно. Танд ямар ч асуудал байхгүй бол та тийшээ орж чадахгүй. Орохын тулд нүгэлтэн гэдгээ зөвшөөрөх ёстой. Муу хүн гэдгээ хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Христ зөвхөн нүгэлтнүүдийн төлөө амиа өгсөн юм шүү. "Энэ дэлхий дээр өөрийгөө муу хүн гэдийг хүлээн зөвшөөрч байж гишүүн нь болдог цорын ганц байгууллага бол Христийн чуулган юм." (Роберт Мангер)

## 9 сарын 20

*"Ухаан бодолдоо ч бүү ихэрх. Харин төлөв даруу байхыг эрхэмлэ."* (Ром 12:16)

Хүний төрөлх зан чанар дээд зиндааны хүмүүсийн эгнээнд орохыг хүсдэг. Нэр төртэй, сурвалжит язгууртай, хөрөнгө мөнгөтэй хүмүүстэй нийлэх шунаг хүсэл бүх хүний дотор байдаг. Тэгвэл Ром 12:16 дээр хэлсэн Паулын зөвлөгөө энэхүү хогийн ургамлыг үндсээр нь тасалж байна. Тэрээр "Бүү ихэрх, харин дорд хүмүүстэй нийлэхэд бэлэн бай" гэж хэлж байна (NIVорчуулга). Чуулганд зэрэг зиндаа гэж байдаггүй. Христитгэгчид ангийн ялгааг үл тоон амьдрах ёстой.

Фрэди Элиотын тухай нэгэн түүх үүнийг ойлгомжтой илэрхийдэг. Нэг өглөө Элиот өглөөний цайгаа уучхаад гэр бүлээрээ чимээгүй цагаа хийж суулаа. Гэтэл гадаа нь түчигнэх чимээ сонсогдов. Хог түүдэг хүн ирсэн нь тэр ажээ. Чимээг сонссон Элиот Библиэ ширээн дээр орхиод цонхоо нээж хог түүгчтэй баясгалантайгаар мэндчилээд буцаж ширээндээ суун чимээгүй цагаа үргэлжлүүлжээ. Түүний хувьд хог түүгчтэй мэндлэх нь Библи уншихын адил чухал хэрэг байжээ.

Эзэний өөр нэгэн зарц энэ түүхийг шууд утгаар нь хүлээн авч хэрэгжүүлсэн юм. Жак Верцн зун болгон Нью Йоркийн Шрун нуурын дэргэд насанд хүрэгчдэд зориулж Библийн кемп зохион байгуулдаг байлаа. Нэг удаагийн кемпэд хөгжлийн бэрхшээлтэй иргэн оролцжээ. Уг зочин амныхаа булчинг удирдаж чадахгүй учраас хоолоо залгих нь маш төвөгтэй. Ихэнх хоол нь амнаас нь унаж, эрүүн доороо тоссон сонин дээр асгарна. Түүний идэж уух нь

тийм ч сайхан харагдахгүй учраас энэ хүн бусдаас зайдуу ганцаараа сууж хооллоно.

Жак Верцн ажлынхаа ачааллаас болоод хоолны өрөөнд ихэвчлэн хоцорч орж ирнэ. Түүнийг орж ирэх үед хүмүүс баяр хөөртэйгөөр даллаж бидэнтэй суу гэж ширээндээ урьдаг байв. Гэвч Жак тэр хүмүүстэй ерөөсөө суухгүй. Харин ганцаараа хооллодог өнөөх зочны дэргэд суудаг байлаа. Тэрээр дорд хүмүүстэй нөхөрлөгч байжээ.

"Христитгэгч генерал настай ядуу эмэгтэйтэй ярилцаж байхыг хүмүүс олж харав. Нөхөд нь дөхөж ирээд 'Та зэрэг зиндаагаа бодооч' хэмээлээ. Генерал хариуд нь 'Миний Эзэн зэрэг зиндаагаа бодсон гэж үү?' гэсэн гэдэг." (Чоес Глинингс)

Роберт Бюрнс нэгэн шүлэгтээ "Хэчнээн дорд байлаа ч хүн бүр үнэ цэнтэй. Эрүүл бодолтой хүн, дэгжин гадаад үзэмжээр хүнийг үнэлж цэгнэдэггүй" гэж сануулсан.

Бидний Эзэн Өөрийгөө дорд болгож, бидний хэмжээнд очсоныг бодвол бид ч гэсэн бусдад тийн хандах ёстой билээ.

## 9 сарын 21

*"Урьд минь зөв байдлын титэм надад зэхэгдсэн байна. Зөвт Шүүгч Эзэн намайг тэр өдөр, зөвхөн намайг ч биш, Түүний үзэгдэхийг хүсэгч бүгдийг бас түүгээр шагнах болно."* (2Тм 4:8)

"...Түүний үзэгдэхийг хүсэгч бүгдийг бас..." Олон жилийн турш би энэ үгийг бодохдоо Эзэний ирэлтийг халуунаар хүлээдэг итгэгчдийг хэлж байна гэж ойлгодог байлаа. Тэдний зүрх шүүрэлтийн тухай бодлоор бүлээцдэг учраас зөв байдлын титэм тэднийг хүлээж байгаа.

Гэхдээ энэ үг илүү өргөн утга агуулгатай ажээ. Түүний үзэгдэхийг хүсэгч гэдэг нь Христийн ирэлтэд бэлтгэж амьдардаг буюу Христ өнөөдөр ч ирж магадгүй гэсэн хандлагаар алхдаг хүн юм.

Тэгэхээр "Түүний үзэгдэхийг хүсэх" гэдэг нь ариун шударга, зөвт амьдрахыг хэлнэ. Учир нь "Түүнд ийнхүү найдаж байгаа бүхэн Түүний цэврийн адилаар өөрийгөө цэвэршүүлдэг" (1Ио 3:3) гэж Иохан сануулсан.

Өөрөөр хэлбэл, энэ амьдралын юмсаас сэтгэлээ татаж авна гэсэн үг. Бид газар дээрх юмсыг бус, дээгүүрх юмсыг хайх ёстой билээ (Кол 3:2).

Цаашлаад энэ нь, Бурханы хүмүүст үйлчилж, тэдэнд цагт нь хоол ундыг нь өгөх гэсэн утгатай (Мт 24:45). Өөрийг нь ирэхэд энэ ажлыг итгэмжтэй хийж байгаа зарцыгаа Эзэн тусгайлан шагнахаа амласан.

Товчхондоо гэвэл, "Түүний үзэгдэхийг хүсэх" гэдэг нь Эзэнийг ирэх үед нүүр улайхааргүй зүйлсийг хийж

амьдрах юм. Түүнийг ирэхэд ичгүүртэй санагдах зүйлсийг бид эс хийнэ. Түүний оршихуйд гутамшигтай харагдах зүйлсийг эс хэлнэ.

Христ энэ долоо хоногт ирнэ гэж та мэдвэл үлдсэн өдрүүдээ юу хийж өнгөрөөх вэ? Ажлаасаа гараад ууланд очиж, өдөржин Библи уншиж залбирах уу? Бүтэн цагийн христэч үйлчлэл хийж, өдөржин шөнөжин зааж номлох уу?

Хэрэв та Эзэнтэй үнэхээр хамт алхаж, Түүний хүслийг үйлддэг бол амьдралаа үргэлжлүүлдгээрээ л үргэлжлүүлнэ. Харин өөрийнхөө тааламжаар амьдардаг бол томоохон өөрчлөлтүүдийг хийхгүй бол болохгүй.

Аврагчийн хоёр дахь ирэлтийн талаар сайхан бодолтой байх хангалтгүй. Зөв байдлын титэм нь үнэнээр амьдралаа өөрчилдөг хүмүүст зэхэгдсэн. Эзэний ирэлтийн тухай үнэнийг баримталдаг байх нь хангалтгүй. Үнэн бидний амьдралд нөлөөгөө үзүүлдэг байх хэрэгтэй.

## 9 сарын 22

"Амен" (1Ко 14:16)

Хэлж байгаа зүйлийг зүрх сэтгэлээсээ хүлээн зөвшөөрч буйгаа илэрхийлэхэд "Амен" гэж хэлэх үнэхээрийн тустай. Олон чуулган энэ үгийг цуглаан дээрээ хэрэглэдэг.

Библид энэ үг 68 удаа гарсан. 1Коринт 14:15,16-г үзвэл анхны чуулган "Амен" гэдгийг хэрэглэж байсан нь тодорхой байна. Тэгэхээр "Амен" гэж хэлэх нь Библийн дагуу юм гэдэгт итгэж болно.

"Амен"-ийг заавал хэлж байх хэрэгтэй. Үнэний мөн чанар өөрөө хүлээн зөвшөөрлийг шаардаж байдаг. Үнэнийг сонсцоод хариу илэрхийлэмж байхгүй байх нь үл талархалтай адил харагдана.

Сургаал зааж байхад онцлох хэсгүүд дээр сонсогчид нь "Амен" гэж хэлбэл номлогчид ихээхэн урам өгдөг. Сонсогчид нь ярьж байгааг ойлгож, сүнслэг байдал болон сэтгэл хөдлөлийг нь хуваалцаж байгаагаа үүгээр илэрхийлнэ.

Сонсогч ч мөн "Амен" гэж хэлэх нь тустай. Энэ үгийг хэлснээрээ тухайн номлолд идэвхтэй оролцоно. Сэтгэл хөдлөл гарах ёстой үед, дүмбийсэн, дежирсэн хандлага гаргахаас хамгаална.

Дээрээс нь цуглаанд ирсэн үл итгэгчдэд тустай. Итгэгч нар "Амен"-ийг хэрэглэж байгаа байдлыг харахаараа "Христийнхэн чинь эрч хүчтэй, итгэл үнэмшилдээ дуртай, итгэж байгаадаа үнэхээр итгэдэг хүмүүс юм байна" гэсэн мэдрэмж тэдэнд төрнө. Амен гэдэг үгийг хэрэглэснээр

илүү халуун дулаан байдал үүсдэг. Харин үл хэрэглэснээр чимээгүй дүмбийсэн уур амьсгал бүрэлдэнэ.

Дэлхийн хаа сайгүй нэг л янзаар хэлэгддэг Библийн гурван үгийн нэг нь "Амен". Ихэнх хэл дээр энэ гурван үгийг яг ижил хэлдэг. Та хаана ч очсон "Мараната, Халлелуяа, Амен" гэж хэлээд үзээрэй. Хүмүүс "Эзэн ирж байна, Эзэнийг магъя, Биелэх болтугай" гэж буйг чинь шууд ойлгоно.

Мэдээж "Амен"-ийг зөв цагтаа хэрэглэх хэрэгтэй. Зовж шаналсан, сэтгэлээр унасан, хүнд хэцүүтэй тулгарсан үед баяр бахдалын үгийг хэрэглэх нь зохимжгүй.

Зарим Христийн чуулган "Амен"-ийг хэрэглэхээ больсон нь ичгэвтэр явдал юм. Тэд сэтгэл хөдлөлийг буруутгадаг хэт туйлшралаас болоод ийм болжээ. Сайн юм бүхнийг буруугаар ашиглах, хэтрүүлэн хэрэглэх тохиолдол байдаг. Библийн дагуух энэ хэллэгийг зарим нэг нь зохисгүй хэрэглэсэн байлаа гээд бид болих ёсгүй. Амен?

## 9 сарын 23

*"Сэтгэл зүрх минь тэдний чуулалд [нууцад] бүү оролцог."* (Эх 49:6)

Иаков хөвгүүдээ ерөөхдөө энэ үгийг хэлсэн. Тэрээр Симон, Леви нарын Шехемийн эрчүүдэд үйлдсэн харгислалыг бодохдоо "Сэтгэл зүрх минь тэдний нууцад бүү оролцог" гэж хэлсэн.

Би энэ үгийг зээлдэж аваад илүү өргөн утгаар ашиглах гэсэн юм. Хэзээ ч мэдэхгүй өнгөрсөн нь дээр, нүгэлтэй холбоотой нууцууд гэж байдаг.

Уруу татлага хамгийн сайхан дүр төрхдөө ороод "Нууцуудыг минь мэдэхээс нааш чи хэзээ ч аз жаргалыг олохгүй" гэж худал амладаг. Тэрээр сэтгэлийг гижигдэж, махбодын дур хүслийг өдөөж, сэтгэл хөдлөлийг ихэсгэж, юм үзээгүй үл мэдэгчийг урхиндаа оруулдаг.

Олон хүн, тэр дундаа сайн муу юм бага үзсэн хүмүүс энэхүү урхинд орохдоо амархан. Тэд жинхэнэ таашаалыг мэдээгүй өнгөрчээ гэж боддог. Бусдын эдэлдэг сайхнаас би л ганцаараа хоцорчээ, энэ ертөнцийн амтыг амсахгүй л юм бол сэтгэл минь хэзээ ч ханахгүй юм байна гэж боддог.

Гол асуудал нь, нүгэл хэзээ ч ганцаараа ирдэггүй юм. Нүглийн дагуулууд, үр дагавар, аюул гэж бий. Аливаа нэг нүглийг эхний удаа үйлдэхэд гэмших, харамсах сэтгэл маань сулардаг.

Ингээд уруу татагдахад амархан болж, нүглийг эсэргүүцэх чадвар маань сулардаг. Нүглийг нэг л удаа үйлдвэл дахин үйлдэхэд амархан болно. Удалгүй бид



тухайн нүглийнхээ мэргэжилтэн нь болно. Бүр цаашлаад боол нь болж дадал зуршлын гинжээр хүлүүлдэг.

Уруу татлагад бууж өгөх тэр мөчид нүд маань хэзээ ч мэдэрч байгаагүй буруутгалын мэдрэмжид нээгддэг. Эхэндээ сэтгэл татмаар санагдах тэр нүглийн араас ёс суртахууны нүцгэн байдлаа мэдэрсэн муухай мэдрэмж орж ирнэ. Нүглийг улайж гэмшвэл уучлагддаг нь үнэн. Гэсэн ч нүгэл хилэнцэд хамтарч байсан хүнтэйгээ уулзахаар ичих мэдрэмж өөрийн эрхгүй төрдөг. Ийм мэдрэмж бүх амьдралын турш салахгүй. Мунхаглал үйлдсэн газартаа дахиж очихоор муухай дурсамж минь байнга орж ирдэг. Хамгийн ариун мөчүүдэд маань ч хуучны муухай дурсамжууд өөрөө л тархинд ороод ирнэ.

Эдгээр нүглийг Бурхан уучилдаг нь гайхалтай. Гэсэн ч тэр газрын нууцууд руу орё гэж анхнаасаа бодохгүй байсан нь дээр. Сэтгэлийг чинь гижигдэх тэр нууцуудыг нээн үзэх юм бол хар дарсан зүүд угтана. Таашаал чинь аймшиг болж, дур хүслийн мөч чинь бүх амьдралын харамсал болно.

Сорилт, уруу татлага ирэхэд "Сэтгэл минь тэдний нууцад бүү оролцог" гэж хариу өгөөрэй.

## 9 сарын 24

"...би зөн совингоороо [турилагаараа] мэдсэн." (Эх 30:27)

Эзэн Иаковын төлөө өөрийг нь ерөөж байгааг Лабан туршлагаасаа олж харж байсан. Энэ нь үнэхээрийн сайхан хичээл юм. Туршлага бол агуу багш.

Туршлага нь заримдаа Библийн эшлэлүүдийг ойлгоход бидэнд тусалдаг. Зарим үед тухайн эшлэлийг бодол санаандаа ойлгоод байгаа боловч тодорхой нэг туршлагыг туулсны дараа үнэн голоосоо ойлгох үе ирдэг. Тэрхүү туршлага бидэнд, Библийн аль нэг эшлэлийн талаар цоо шинэ сэтгэгдэл төрүүлнэ.

"Хэрэв би зарим нэг зовлонг амсаагүй бол Дуулал дээрх хэд хэдэн эшлэлийг ерөөсөө ойлгож чадахгүй байх байлаа" гэж Мартин Лютерийн эхнэр хэлж байсан юм.

Даниел Смит эхнэртэйгээ хамт Хятадад илгээлтийн эзнээр үйлчилж байхад хэсэг бүлэг хулгайч шөнө гэрийнх нь нэг талаас нүхлэн орж иржээ. Смит эхнэртэйгээ унтаж байх хооронд тэд хамаг юмыг нь хуу хаман авч явлаа. Илгээлтийн эзэд бат бөх нойрсоогүй бол магадгүй алуулах байсан. Ноён Смит хожим энэ үйл явдлыг дурсан ярихдаа "Хабаккук 3:17,18-ыг би тэр өглөө л жинхэнэ утгаар нь ойлгосон юм. 'Хэдийгээр инжрийн мод цэцэглээгүй, усан үзмийн мод ч үр жимсгүй, чидуны ургац гарахгүй, талбайд хүнс огт ургахгүй байсан ч бас хашаандаа хоньгүй, саравчиндаа үхэргүй болсон ч ЭЗЭНий дотор би баясан хөөрч, авралынхаа Бурхан дотор баярлана'" гэж хэлж билээ. Өөрөөр хэлбэл Хабаккукийн амссан шиг гарз хохирлыг

амсахаас нааш Хабаккук шиг баяр хөөрийг мэдэрч чадахгүй гэсэн үг.

Корри Тэн Бүм бөөнөөр хорих лагерьд хоригдож байхдаа шүүгчийн өмнө зогсжээ. "Шүүгч надад баахан цаас үзүүлэв. Тэр цааснууд нь надад төдийгүй миний найз нөхөд, гэр бүлд үхлийн ял тулгасан тогтоолууд байлаа."

"Чи энэ цааснуудын талаар надад тайлбарлаж чадах уу?" гэж шүүгчийг асуухад "Чадахгүй" гэж би үнэнээ өчив. Гэнэт шүүгч бүх цаасыг барьж аваад зуух руу шидчихлээ. Галын дөл ялын тогтоолтой цааснуудыг шатааж байх тэр үед Бурханы хүч чадал намайг хамгаалж буйг би мэдсэн юм. Түүгээр ч зогсохгүй Колоссай 2:14 дээр "Бидний эсрэг зарлигуудаас бүрдсэн, бидэнд дайсагнаж байсан өрийн дансыг арилгав. Тэр үүнийг загалмайд хадаж, замаасаа зайлуулжээ" гэснийг хэзээ ч ойлгож байгаагүйгээрээ ойлгосон юм."

Амьдралын туршлагаар дамжуулан Библийн талаар цоо шинэ ойлголт ухаарлыг олж авах нь тухайн туршлагыг туйлын үнэ цэнтэй болгодог.

## 9 сарын 25

*"Тиймээс та нарт үнэнийг хэлснээрээ би дайсан чинь болсон хэрэг үү?" (Гал 4:16)*

Бид үнэнийг хэлэх үедээ найз нөхдөө дайсан болгодог. Паул үүнийг Галатын итгэгчдээс мэдэрсэн байна. Элч Паул энэ хүмүүсийг Эзэн рүү авчирч, тэжээн тэтгэсэн. Гэвч удалгүй хуурамч багш нар чуулганд нэвтэрч итгэгчдийг Христээс холдуулан хуулийн боолчлолд оруулж байсныг Паул анхааруулж сэрэмжлүүлсэн. Үүнээс нь болоод тэд итгэл доторх эцэгтээ дайсагнажээ.

Хуучин гэрээнд ч бас ийм явдлууд олон тохиолдсон. Елиа үнэнч шударгаар, итгэмжтэйгээр Ахабт Бурханы үгийг дамжуулдаг байлаа. Гэтэл нэг удаа Ахаб Елиатай уулзахдаа "Энэ чинь Израилийн үйлийг үзэгч чи юу?" (1Хд 18:17) гэж хэлсэн. Елиа бол Израилийн хамгийн сайн найзуудын нэг байтал яагаад түүнийг ингэж хэлэв. Ердөө үнэнийг хэлдэг байснаас нь болж Елиаг үйл үзэгч, гай таригч хэмээн буруутгажээ.

Микаиа бас аймшиггүй зоригт эш үзүүлэгч байв. Иехошафат хаан, "Эзэний зөвлөгөөг авч болох итгэмжит хүн байхгүй юу? гэж асуухад Израилийн хаан, "Имлагийн хүү Микаиа гэж нэг хүн байгаа. Бид түүнээс Эзэний хүслийг асууж болно. Гэхдээ тэр миний талаар сайн юм хэлдэггүй, дандаа мууг эш үзүүлдэг учраас би түүнийг үзэн яддаг" гэж хариулжээ. Израилийн хаан үнэнийг хүсээгүй учраас үнэнийг хэлсэн хүнийг үзэн ядсан байна.

Шинэ гэрээнээс баптисч Иоханыг харж болно. "Та дүүгийнхээ эхнэрийг авах нь хууль бус" (Мк 6:18) гэж тэрээр

Херодод хэлсэн. Энэ үг үнэн байсан боловч үнэнийг зоригтой хэлснээсээ болоод Иохан цаазлуулсан.

Бидний Эзэн үл итгэгч иудейчүүдийн үзэн ядалтыг төрүүлж байсан. Яагаад тэд үзэн ядав? Яагаад гэвэл Эзэн Есүс тэдэнд үнэнийг хэлсэн. "Гэтэл Бурханаас үнэнийг сонсоод, та нарт хэлсэн Хүнийг буюу Намайг одоо та нар алахыг оролдож байна." (Иох 8:40).

"Хэрэв та хүмүүст үзэн ядагдахыг хүсэхгүй бол зүгээр л мөрөөрөө чив чимээгүй явах хэрэгтэй. Ямар ч асуудалд хоёр тал байдаг. Та аль нэг талд нь гараад түүнийхээ төлөө идэвхтэй шийдэмгий дуу хоолой болж эхэлбэл эсрэг талд нь байгаа хүмүүсийн уур хилэнг заавал төрүүлнэ." (Томас Жеферсон)

Үнэн хүнийг өвтгөдөг учраас хүмүүс үнэнд бууж өгөхийн оронд үнэнийг яригч этгээдийг харааж зүхдэг. Эзэний жинхэнэ зарц энэ эрсдэлийг үүрдэг. Тэрээр үнэнийг яриад үхлийг сонгодог. "Анд нөхрийн чинь учруулах шарх итгэмжтэй, харин дайсны чинь үнсэлт заль мэхтэй" (Сур 27:6) гэдгийг тэр мэднэ.

## 9 сарын 26

*"Баалд өвдөг сөгдөөгүй долоон мянган хүнийг Би Өөртөө үлдээсэн."* (Ром 11:4)

Бурхан хэзээ ч Өөрийгөө гэрчгүй үлдээдэггүй. Хамгийн харанхуй өдрүүдэд ч Түүний нэрийн өмнөөс үнэнийг гэрчилсэн дуу хоолой сонсогддог. Хамгийн хүнд цагт ч Өөрийнх нь нэрийг зоригтой тунхаглах хэн нэгнийг Бурхан босгож ирдэг.

Усан галавын үед энэ дэлхий хүчирхийлэл ба ёс бусаар дүүрсэн. Гэвч Ноа Эзэний төлөө зогссон.

Елиагийн өдрүүдэд Израиль бүхэлдээ хуурамч шүтээнд живсэн мэт харагдаж байлаа. Гэвч Баалд өвдөг сөгдөөгүй долоон мянган эрийг Бурхан Өөртөө үлдээжээ.

Дундад зууны харанхуй үед Ян Гус, Мартин Лютер, Жон Нокс нар түүхийн тавцан дээр гарч ирээд хамгийн дээд Нэгэний үнэнийг өмгөөлөн хамгаалсан.

Саяхан гэхэд телеграф зохион бүтээгдэхэд Бурханыг хүлээн зөвшөөрсөн. Анх дамжуулсан мэдээ нь "Бурханы хийсэн ажлыг хараач!" гэдэг үг байлаа.

Аполло-8 хөлөг 1968 оны Христмасаар сар руу ниссэн анхны аяллаасаа буцаж ирэх үед гурван сансрын нисгэгч нь Эхлэл 1:1-10-г уншаад "Аполло-8 хөлгийн мэндчилгээг ингээд дуусгая...Сайхан дэлхий дээр оршин суугаа бүх хүнийг Бурхан ивээг" хэмээн мэндчилгээ дамжуулсан.

Үл итгэгчдийн ширүүн эсэргүүцэл гарсан ч, АНУ-ын шуудангийн алба Аполло-8 хөлгийн маркийг гаргахдаа "Эхэнд Бурхан..." хэмээн Эхлэл 1:1 дүгээр эшлэлээс бичжээ.

АНУ-ын мөнгөн тэмдэгт дээр "Бурханд бид итгэнэ" гэсэн үг бий.

Хуанлийн товчлол А.Д. (МЭ) нь бидний Эзэний (Anno Domini) он жилүүд болохыг бидэнд сануулдаг.

Тэнгэрийн зарим одод эрэгтэй хүүхэд, онгон эмэгтэй, могой, загалмай зэрэг авралын түүхийн гол дүрүүдийн дүрстэй байдаг нь тохиолдол гэж үү? Одод сайнмэдээг тунхагладаг юм биш биз?

Заримдаа бурхангүйчүүд хүртэл Эзэнийг хүлээн зөвшөөрч тунхагладаг. 1979 онд Австрид болсон чуулга уулзалтаар бурхангүй үзэлтэй нэгэн удирдагч "Хэрэв бид алдаа гаргавал Бурхан уучлахгүй шүү" хэмээн мэдэгдэл хийсэн.

Орчлон ертөнц хүртэл Бурханыг зарлан тунхагладаг. Шавь нар нь Эзэн Есүсийг Бурханы нэрээр ирсэн Хаан хэмээн өргөмжлөн магтахад шавь нараа зэмлээч гэж фарисайчууд Христээс шаардсан. Тэр үед Есүс фарисайчуудад хандаж "Тэд дуугаа хураавал энэ чулуунууд хашхирна" гэж хэлсэн (Лк 19:40).

Бурханы нэр хүндлэгдэхгүй, магтагдахгүй өнгөрнө гэж айх хэрэггүй. Хүмүүс Түүнийг үхсэн гэж зарлаж байхад Тэр зарим гэрчүүдийг босгож ирээд дайснуудынхаа үгүйсгэлийг няцааж, найзуудынхаа итгэл зоригийг батжуулдаг.

## 9 сарын 27

*"Харин хулчгар, итгэлгүй, жигшүүрт, алуурчид, завхайрагчид, мэргэчид, шүтээнд мөргөгчид болон бүх худалчуудад ногдох хувь нь хоёр дахь үхэл буюу хүхэр, галаар шатаж буй нуур юм гэв."* (Илч 21:8)

Аймхай хулчгар, итгэлгүй хүмүүсийг муу нүгэлтнүүдтэй адил үзэж, ижилхэн мөнхийн шийтгэл оногдуулна гэж бичсэнийг уншаад олон хүн гайхаж магадгүй.

Дээрээс нь хулчгар гэснийг жагсаалтын хамгийн эхэнд оруулсан нь бүр ч хачирхалтай санагдах байх. Хүн бүрийг үүнд хамаатуулах нь буруу. Зөвхөн найз нөхдийнхөө хэлэх үгнээс айж, бусдаас ирэх хандлагаас эмээсэндээ Эзэн Есүсийг хүлээн авахаас айсан хүмүүсийг энд хэлж байгаа юм. Бурхан ийм аймхай занг шалтаг гэж үзэхгүй. Энэ төрлийн аймхай зан нь яллагдах зохистой нүгэл гэж Тэр харна.

Түүнээс гадна, итгэлгүй хүмүүсийг жагсаалтын хоёрдугаарт оруулсныг нухацтай бодож үзэх хэрэгтэй. "Би итгэж чаддаггүй", "Би итгэмээр л байна" гэж хүмүүсийн хэлэхийг та сонсож байсан байх. Гэхдээ эдгээр нь үнэн сэтгэлийн үг биш. Аврагч Эзэнд итгэх боломжгүй нөхцөл байдал гэж байдаггүй. Асуудал нь хүний ухаанд биш хүсэлд оршдог. Үл итгэгчид нь Эзэн Есүст итгэхийг хүсдэггүй. Өөрийнх нь цаг үед амьдарч байсан үл итгэгч иудейчүүдэд Эзэн Есүс, "Та нар амьтай болохын тулд Над дээр ирэхийг хүсдэггүй" (Иох 5:40) гэж хэлсэн.

Хулчгар, итгэлгүй хүмүүсийн ихэнх нь өөрсдийгөө соёлтой, даруухан, ёс суртахуунтай хүмүүс гэж боддог.



Алуурчид, завхайрагчид, мэргэчид, шүтээнд мөргөгчид, худалчуудаас өөрсдийгөө ялгаатай гэж эндүүрдэг. Гэвч бодит үнэн гэвэл, тэд энэ хүмүүсийн хамт мөнхийн шийтгэлийг хүртэнэ. Яагаад гэвэл тэд аврагдахын тулд Христ дээр ирээгүй юм.

Тэдний шийтгэл нь "хоёр дахь үхэл буюу хүхэр, галаар шатаж буй нуур юм." Энэ бол тэдэнд ноогдох эцсийн ял шийтгэл. Там байхгүй, мөнх шийтгэл гэж үгүй хэмээн хүмүүс хэлж болох ч Библи үүнийг тов тодорхой хэлсэн. Христгүй амьдралын төгсгөлд там байгаа.

Үнэхээрийн харамсалтай нь гэвэл, хулчгар, итгэлгүй хийгээд дээрх эшлэлд жагсаагдсан бүх хүн галт нуурт хаягдана. Галт нуур руу явахгүй ч байх боломжтой. Зөвхөн хулчгар зан, эргэлзээ хийгээд бусад нүглүүдээ гэмшиж, эгэл жирийн итгэлээр Эзэн Есүс рүү эргэвэл тэд уучлалыг олж, цагаадаж, мөнхийн улсад орно.

## 9 сарын 28

*"Мууд бүү дийлд, мууг харин сайнаар дийл. (Ром 12:21)*

Энэ эшлэлийг Бурханы Сүнсээр биш, жирийн нэгэн хүн бичсэн бол "Хэнд ч бүү дийлд. Хариуг нь заавал өг" гэж хэлэх байсан байх. Ертөнц хариуг нь өгөх, өшөө авах тухай л боддог.

Харин Христийн сургууль бидэнд огт өөр хичээл заадаг юм. Бид өөрсдөө мууд эзэмдүүлж болохгүй. Харин мууг ялахын тулд сайныг үйлдэх ёстой.

Ассизи хотын Францискогийн түүхийг сонсвол бидэнд энэ сэдэв дээр эрүүл зөв бодол төрөх байх. Франциско бага байхдаа гэрийнхээ ойролцоо тоглож байлаа. Тэгээд чанга хашхирахаар цуурай гарч байгааг анзаарчээ. Тэрээр анх удаа цуурайг сонссон нь тэр аж. Тиймээс түүнийг туршиж эхлэв. Франциско чангаар "Би чамайг үзэн ядаж байна" гэж хашхирахад өөдөөс нь "Би чамайг үзэн ядаж байна" гэж цуурайтлаа. Дуугаа улам чангаруулаад "Би чамайг үзэн ядаж байна" гэж хашхирахад цуурай өөдөөс нь бүр чангаар "Би чамайг үзэн ядаж байна" гэж дуугарав. Гурав дахь удаагаа хамаг чадлаараа "Би чамайг үзэн ядаж байна" гэж хашхиртал мөн л тийм чанга дуугаар "Би чамайг үзэн ядаж байна" гэх хариу ирлээ. Франциско гэр рүүгээ зугтааж гэртээ ирээд муухай ашилж эхлэв. Ээж нь түүнээс "Хүү минь яагаа вэ" хэмээн асуухад "Тэнд нэг хүүхэд намайг үзэн ядаад байна" гэж хариулав. Ээж нь хэсэг зуур бодолхийлснээ, "Яах ёстойг чинь би хэлж өгье. Чи гадагшаа гараад тэр хүүд хайртай гээд хэлээд үз дээ" гэв.

Хүү гадагш гараад "Би чамд хайртай" гэж хашхирлаа. Өөдөөс нь бас "Би чамд хайртай" хэмээн цуурайтлаа. Илүү

чангаар "Би чамд хайртай" гэж хашхиртал өөдөөс нь бас "Би чамд хайртай" гэх хариу ирлээ. Гурав дахь удаагаа чин сэтгэлээсээ "Би чамд хайртай" гэж орилтол яг адилхан үг түүнд сонстов.

Би энэ бүхнийг бичиж байх үед дэлхий даяар хүмүүс "Би чамайг үзэн ядаж байна" гэж хашхиралдсаар байгаа. Тэгсэн атлаа "Яагаад энэ их асуудал гараад байгаа юм бэ?" гэж гайхширцгаадаг. Нэг үндэстэн нөгөөгөө үзэн ядаж, хөршүүд бие биеийнхээ араас хашхирч, гэр бүлүүд хэрүүл маргаанаар сүйрцгээж байна. Тэд бузар мууд дийлдэж байгаа нь тэр. Учир нь үзэн ядалт үзэн ядалтыг төрүүлдэг. Үзэн ядалтын хариуд хайрыг үзүүлэх аваас бузар мууг сайнаар дийлэх болно. Хайр нь хайрыг төрүүлдгийг тэгэхэд тэд олж харна.

*Гартаа атгасан үрээ*

*Гаргаж ирээд сайтар үз*

*Хайрыг таривал хайрыг хураана*

*Хорслыг таривал хорсол ургана*

## 9 сарын 29

*"Аврал ЭЗЭНээс ирдэг." (Ион 2:9)*

Сайнмэдээ ярьж байна гээд хүн болгон дээр очиж, хэрэгтэй хэрэггүй юм хамж шимж яриад, салж өгдөггүй хүмүүс байдаг. Сонсогч хүмүүс нь залхаж, салахын түүс болсондоо "Би Есүст итгэе ээ" гэж худал хэлдэг. Сайнмэдээ ярих нэрийдлээр хүн хүн дээр очиж, түвэг удаж, залхаадаг явдал нь үнэхээр сайнмэдээний ажил мөн үү?

Шударга хэлбэл энэ нь сайнмэдээний ажил биш. Харин шашны тулгалт юм. Махбодын хүчээр хийсэн ажлууд сайн үр дүн авчрахаасаа илүү хор хохирол учруулна.

"Христэд түлхүүр бий. Христ хаалгыг онгойлгодог. Түгжээтэй хаалган дээр очоод бүдүүлгээр эвдэж орох нь Бурханы хүсэл биш. Хаалга онгойх хүртэл бид Эзэнийг хүлээх ёстой. Бүдүүлэг, тэвчээргүй, бусдыг хүндэлдэггүй зангаар сайнмэдээг тунхаглах нь Христийн үйл хэрэгт тус биш ус болно. Ах дүү, хамаатан садан, найз нөхдөө Христэд итгүүлэх гэж хүсэх нь зөв. Гэхдээ Бурханаас илүү яарч адгаж болохгүй. Тэвчээртэй бай. Шаргуу залбирч, ихээр хайрла. Тэгээд Эзэн Есүсийг гэрчлэх боломжийг хүлээ." Жон Скотын бичсэн энэ үг юутай үнэн бэ!

Диетрих Бонхоферийн зарим номлолтой би санаа нийлдэггүй ч гэсэн түүний хэлсэн дараах үгэнд бодууштай үнэн санаа агуулагдаж байна: "Авралын үгийг зогсоо зайгүй яриад байх нь үр дүнгүй. Хүн бусдыг хүчлэх эрх байхгүй. Хүчээр итгүүлж ч чадахгүй... Сайнмэдээг хүчээр тулгах, хүмүүсийн араас гүйх, өөрийн хүчээр хүмүүсийг аврах гэж оролдох нь аюултай бөгөөд хий дэмий ажил юм... Ийм арга замаар ажилласнаар хүмүүсийн сэтгэл зүрхийг

улам хатууруулж, харанхуйлуулна. Тэгэхээр хүчилдэг арга нь үр дүнгүйн дээр хор хохиролтой гэсэн үг. Хямдхан нигүүлслийн үгээр хурдан үр дүнд хүрэх гэсэн оролдлого маань хүмүүсийг залхааж, унтууцал дургүйцлийг нь төрүүлж, аврах биш алдах ажил болж хувирна."

Хүн дахин төрөх нь Ариун Сүнсний ажил. "Хүний хүслээр ч биш" хэмээн бичигдсэн нь хүний хүчин чармайлт, хичээл зүтгэл, хүсэл байлаа гээд бусдыг аварч чадахгүй гэсэн утгатай. Хэтэрхий их тулгаж хүчлэх аваас "Христэд итгэе" хэмээн амаараа хэлэвч ачир дээрээ зүрх сэтгэл нь Христээс холдож, Христийн загалмайн дайсан болж болзошгүй.

Ариун Сүнс биднийг ашиглаж бусдыг аврах нь амьдралын нэгэн сайхан мөч яах аргагүй мөн. Гэхдээ энэ үр дүнд хүрэх гэж өөрсдийн хүчээр зүтгэвэл эргээд амаа барих хэрэгтэй болно.

## 9 сарын 30

*"Андрей эхлээд өөрийн ах Симоныг олоод...түүнийг Есүс дээр авчрав. "* (Иох 1:41,42)

Итгэгч хүн Есүс Христийг гэрчлэхдээ өдөр тутмын амьдралд учирдаг ойр тойрныхноосоо эхлэх нь хамгийн зөв зам юм. Гэхдээ сайнмэдээг огт танихгүй хүнд ярьж болохгүй гэсэн үг биш. Хэзээ ч уулзаж байгаагүй хөндлөнгийн хүнд Есүсийн авралыг ярихад Бурхан түүнийг нь олонтоо ашигладаг. Гэхдээ өөрийг нь мэддэг, Христ амьдралд нь өөрчлөлт авчирч буйг олж харж чадах ойр тойрныхондоо сайнмэдээ тараах нь хамгийн тохиромжтой арга юм. Андрей энэ аргаар өөрийн ах Симонд Есүсийг гэрчилсэн байна.

Сургууль дээрээ Эзэнийг гэрчлэхээс эмээдэг залуугийн талаар Волтер Хенрихсэний ярьсныг өгүүлье. Хенрихсэн залуугаас ингэж асуув:

-Жое, чи сургуулиасаа хэдэн оюутан таньдаг вэ? Яг чамайг нэрээр чинь мэддэг оюутнуудыг би хэлж байна.

-Би энд ирээд хоёр сар болж байгаа. Хоёр гурван оюутан л танина.

-Жое, ирэх дөрвөн долоо хоногт сургууль дээрээ чи чадах чинээгээрээ олон оюутантай танилц. Тавин оюутан гээд зорилго тавья. Чи тэдэнд сайнмэдээ ярих хэрэггүй. Итгэгч гэдгээ ч хэлэх шаардлагагүй. Чи тэдэнтэй танилц, нөхөрлө, тогло, хамт хоол ид, урлаг спортын арга хэмжээнд хамт оролц. Юу хийх нь чиний хэрэг. Гол нь өнөөдрөөс эхлээд сарын дараа гэхэд тавин оюутныг сайн таньдаг болсон бай. Сарын дараа эргээд ирэхэд минь надад

хүн нэг бүрийг нэрээр нь дэлгэрэнгүй танилцуулж чаддаг болсон байгаарай.

Хенрихсэн уг залуутай сарын дараа уулзахад залуу зургаан хүнийг Христ рүү авчирсан байлаа. Тавин хүнтэй дотносож чадсан эсэхийг тэд ярьсангүй. Тэгэх шаардлага ч байгаагүй. Учир нь, Эзэн татвар хураагчид ба нүгэлтнүүдтэй анд найз болж байхдаа үнэнийг гэрчлэх үүд хаалгыг нээж байсны адил, найз нөхөдтэй болно гэдэг итгэлээ хуваалцах боломж юм байна гэдгийг тэр залуу ойлгосон байлаа.

Өдөр тутмын амьдралдаа ойр дотнынхоо хүмүүст Эзэн Есүсийг гэрчлэн сайнмэдээ тараахдаа хоёр зүйлийг анхаарах ёстой. Нэгт нь, өөрөө үлгэр жишээ амьдрах. Эзэнтэй ойр дотно харилцаатай байх. Сайнмэдээг тунхаглавч өөрөө ариун шударга амьдардаггүй бол ярьсан үгээ үгүйсгэсэнтэй адилхан юм.

Хоёрт гэвэл, энэ аргыг хэрэглэлээ гээд тэр даруй үр дүн гарна гэж бодох хэрэггүй. Есүс авралын үйл явцыг тариа ургахтай зүйрлэсэн. Үр тарьсан өдрөө ургац хурааж авдаггүй. Зарим хүн сайнмэдээг сонсонгуутаа аврагддаг нь үнэн. Гэхдээ тийм хүмүүс маш цөөн. Ихэнх тохиолдолд сайнмэдээг сонссон хүн нүглээ ухаарах цаг хугацаа шаардлагатай бөгөөд эхэндээ Ариун Сүнсний дуу хоолойг эсэргүүцдэг. Энэ үйл явцын дараа л тэд үнэхээр дахин төрдөг.

## 10 сарын 1

*"Амь чинь маргааш ямар байхыг та нар мэдэхгүй. Учир нь та нар хэсэг зуур үзэгдээд дараа нь арилах уур манан шүү дээ."* (Иак 4:14)

Хүний амьдрал ямар ахархан богино гэдгийг бидэнд Ариун Сүнс Библиэр дамжуулж байнга хэлдэг. Эзэний Сүнс янз бүрийн зүйрлэл ашиглаж, өдөр хоногууд маань нүд ирмэхийн зуур өнгөрөн одож байгааг, амьдрал маань хязгаартай гэдгийг ахин дахин сануулдаг.

Жишээлбэл амьдралыг Тэрээр нэхмэлчний зүүтэй (Иов 7:6) адилтгасан. Нэхмэлчний зүү гэдэг нь нүдний хурд гүйцэмгүй хурдаар нааш цааш хөдөлдөг төхөөрөмж юм.

Иов амьдралыг амьсгалтай зүйрлэсэн (Иов 7:7). Амьсгал нэгэн хоромд гараад дахиж хэзээ ч эргэж ирдэггүй. Дуулал ном үүнтэй ижил санааг илэрхийлдэг: "Нэг өнгөрөөд эргэн ирдэггүй салхи болохыг нь Тэрээр санасан билээ." (Дуу 78:39).

Билдад "газар дэлхий дээрх бидний өдрүүд сүүдэр мэт" (Иов 8:9) хэмээн сануулсан. Яг энэ дүрслэл Дуулал 102:11 дээр "Өдрүүд минь уртассан сүүдэр адил" гэж бичигджээ. Сүүдэр бол агшин зуурын үзэгдэл юм.

Иов амьдралыг навчтай харьцуулсан (Иов 13:25). Навч бол эмзэг, нимгэн, амархан хатаж ганддаг, салхинд хорчийдог зүйл. "Бид бүгдээрээ навч мэт хатан хорчийдог" (Иса 64:6) тул биднийг энэрч өрөвдөөч хэмээн Исаиа Эзэнээс гуйсан.

Давид өөрийн өдрүүдийг алганы өргөнтэй адилтгасан (Дуу 39:5). Өөрөөр хэлбэл, амьдралыг 10 см урттай аялал хэмээн үзсэн байна.



Бурханы хүн Мосе амьдралыг унтах нойртой зүйрлэсэн (Дуу 90:5). Өөрөөр хэлбэл, сэрж ч амжаагүй байхад минь цаг хугацаа өнгөрөн оддог.

Мөн Мосе хүмүүсийг болон тэдний амьдралыг өвстэй зүйрлэсэн: "Өглөөд тэд шинээр соёолон буй өвс мэт болой. Өглөө тэр нь цэцэглэж, соёолно. Үдэш нь тэр хагдран хатна" (Дуу 90:5,6). Хэдэн зууны дараа Давид, Мосетэй ижил дүрслэлийг ашиглаад нүд ирмэхийн зуур өнгөрөх амьдралын хугацааг зүйрлэсэн: "Хүний хувьд, өдрүүд нь өвс ногоо адил. Хээрийн цэцэг шиг тэрээр дэлгэрнэ. Салхи үлээгээд өнгөрөхөд тэр үгүй болох бөгөөд Тэр газар ч түүнийг эс танина" (Дуу 103:15,16). Спержоны хэлсэнчлэн "өвс нь таригдаж, ургаж, гандаж, хатаж үгүй болдог." Амьдрал гэдэг ийм л зуурдынх.

Иаков амьдралыг уур манан хэмээн тодорхойлсон (Иак 4:14). Уур манан нь хэсэгхэн зуур үзэгдээд алга болдог. Энэ дүрслэлүүдийг цуглуулж ярьсан маань хоёр зорилготой. Нэгдүгээрт, амьдрал ямар богинохон юм бэ гэдгийг үл итгэгчдэд ойлгуулж, Бурхантай уулзахад бэлтгэхийн ач холбогдлыг сануулах. Хоёрт гэвэл, өөрийн өдрүүдийг тоолохыг итгэгчдэд мэдүүлж, тэдний зүрх сэтгэлийг мэргэн ухаанд хандуулах (Дуу 90:12). Таны зүрх сэтгэлд энэ мэргэн ухаан байх юм бол Христийн төлөө болон мөнх цагийн төлөө амьдралаа зориулна.

## 10 сарын 2

*"Та нар дунд...мэргэ төлгөч, совин тайлагч, ид шидтэн, илбэчин, хараалч, сүнс зуучлагч, хар домч, үхэгсдийг дуудагч бүү байг."* (Дх 18:10,11)

Бурхан Өөрийн ард түмэн Израильд сануулахдаа хар дом, ид шид, сүнслэг зүйлтэй хэзээ ч бүү орооцолд гэж хэлсэн. Өнөөдрийн энэ эшлэлд жагсаан бичсэн зан үйлүүд нь бүгд чөтгөртэй холбоотой бөгөөд үүгээр огтхон ч оролдож болохгүй. Энэ бүхэн Хуучин гэрээний үед төдийгүй өнөөдрийн бидэнд ч хориотой.

Мэргэ төлөгч гэдэг нь хувь тавиланг хэлдэг хүн. Болор бөмбөлөг, зөн билэг, алга уншилт, цайны шаар үзэх зэрэг янз бүрийн аргыг ашиглан ирээдүйн хувь тавиланг хэлэх гэж оролддог хүмүүс.

Совин тайлагч [зурхайч] гэдэг нь од эрхсийн байршлыг ашиглан хүний заяа төөргийг хэлдэг хүмүүс. Сонин сэтгүүл дээр гардаг өдөр тутмын зурхай, орд зэрэг нь энэ ангилалд багтана.

Ид шидтэн гэдэг нь элдвийн шившлэг, илбэ, увдис, тарниар бусдад нөлөө үзүүлдэг хүн.

Илбэчин [witch] гэдэг нь чөтгөрүүдтэй холбогдож ер бусын хүч чадал эзэмшсэн эмэгтэй. Чөтгөртэй ийм холбоо тогтоох нь бузар бөгөөд хор хөнөөлтэй.

Хараалч гэдэг нь бусдад хараал жатга хийж, түүнийгээ чөтгөрийн хүчээр биелүүлдэг хүн. (Ийм хараал итгэгчдэд нөлөө үзүүлэхгүй.)

Сүнс зуучлагч гэдэг нь бузар сүнсний ертөнцтэй холбоо тогтоож чаддаг зууч. Бузар сүнснүүд зуучлагчаас

зөвлөгөө авсан хүний нас барсан хамаатан садны дүрд тоглодог.

Хар домч [wizard] гэдэг нь сүнслэг ертөнцийн тусламжтайгаар ид шид үйлддэг хүн. Заримдаа wizard гэж witch-ийн эр хүйсийг хэлнэ.

Үхэгсдийг дуудагч гэдэг нь нас барсан хүний сүнстэй холбоо тогтоож, ирээдүйг мэдэн, үйл явдлыг өөрчлөх чадалтай гэж өөрийгөө хэлдэг хүн.

Христэд итгэгч нь энэ бүхнээс хол байх хэрэгтэй. Дээр нь нэмээд хэлэхэд орчин үеийн иог, бясалгал, хар шид, цагаан шид, гипноз, сүнслэг эдгэрэл, үхэгсдэд залбирах, тоон мэргэ, усан мэргэ зэргээс зайгаа барих ёстой. Мөн хар тамхи, мансууруулах бодис нь сүнслэг зүйлстэй холбогдох хэрэгсэл гэдгийг мэдэх хэрэгтэй. Далдын нууцлаг зан үйлийн зорилгоор ашиглаж байвал шоо, даалуу, хөзөр, савх, яс, сахиус, зүүлт, унжлага, гэх мэт зүйлээс бид татгалзах шаардлагатай.

## 10 сарын 3

*"Есүс төрөл бүрийн өвчтэй олон хүнийг эдгээсэн бөгөөд олон чөтгөрийг зайлуулсан."* (Мк 1:34)

Чөтгөрт эзэмдүүлэх нь Эзэн Есүсийг газар дэлхий дээр амьдарч байхад байсан боловч одоо байхгүй, эрт дээр үеийн үзэгдэл хэмээн зарим итгэгч боддог. Гэвч энэ буруу бодлоо засах хэрэгтэй. Бараг өдөр бүр мэдээллийн хэрэгслээр буг чөтгөрийн сэдэлтэй гэмээр гэмт хэргийн тухай мэдээлдэг. Чөтгөрт эзэмдүүлсэн хүнд тодорхой хэдэн шинж тэмдэг бий. Энэ шинж тэмдгүүдийг мэдвэл түүнийг сэтгэцийн өвчнөөс ялгахад маань тусална.

Юуны түрүүнд чөтгөр нь эзэмдсэн хүнээ хүчирхийлэл, эвдэн сүйтгэл хийхэд хөтөлдөг. Чөтгөрийн зорилго нь үргэлж алж талах, эвдэн сүйтгэх билээ.

Чөтгөрт эзэмдүүлсэн хүн нь хоёр ба түүнээс дээш зан чанар гаргадаг. Нэг нь өөрийнх, бусад нь чөтгөрийнх. Тэрээр өөр өөр дуу хоолойгоор ярьж, өөрийгөө өөр өөр нэрээр нэрлэдэг.

Чөтгөрт эзэмдүүлсэн хүн хүнээс гарамгүй их бяр тэнхээтэй эсвэл хүнд баймгүй ер бусын мэдлэгтэй болдог.

Чөтгөрт эзэмдүүлсэн хүн заримдаа Эзэн Есүсийн талаар тааламжтай юм ярьж чадах боловч жирийн үед Эзэний нэрийг хэлэхэд, Христийн цус ба загалмайг ярихад, залбирахад, Бурханы үгийг дурдахад доромжлол, уур хилэн, хүчирхийллээр ханддаг.

Түүний зан чанар нь маш этгээд хачин, тогтворгүй, хэвийн бус. Хэн ч түүнийг ойлгож, хянаж удирдаж, эмчилж чадахгүй. Тэрээр амиа хорлохыг хүсдэг байж болно. Эсвэл айдас болон мухар сүсэгт хүлээтэй байдаг.

Чөтгөрт эзэмдүүлэх явдал нь гол төлөв мансууруулах бодис хэрэглэсэнтэй холбоотой. Мансууруулах бодис нь хүний оюун санааг өөр ертөнцтэй холбож, чөтгөрүүдэд үүд хаалгыг нээж өгдөг. Библийн "ид шидтэн", "зөн билигтэн" гэх мэт үгнүүд эх хэл (грек) дээрээ "фармакиа" гэх үг байх бөгөөд энэ нь мансууруулах бодис гэсэн утгатай.

Чөтгөрт эзэмдүүлсэн хүн хэний ч санаанд оромгүй харгислал хүчирхийллийг хийж чаддаг. Заримдаа хохирогчийнхоо биеийг мөчлөх, эд эрхтнийг таслах гэх мэт энгийн хүний ухаанд багтамгүй зүйлийг хийдэг.

Чөтгөрт эзэмдүүлсэн зарим хүний царай зүс авах юмгүй муухай болж, зарим нь оршуулгын газар амьдарч, янз бүрийн яс цуглуулж, айдас хүргэм түүхүүдийг ярих дуртай байдаг.

Нар, сар, ялангуяа шинэ сар чөтгөрийн ертөнцөд маш хүчтэй нөлөөтэй. Тиймээс Библи дээр "Шөнөөр саранд ч, өдрөөр наранд ч чи цохиулахгүй" (Дуу 121:6) гэж итгэгч нарт Бурхан амласан.

Чөтгөрийг залбирал ба Эзэн Есүсийн нэрийн эрх мэдлээр хөөн зайлуулж чадна. Гэхдээ дахиж хэзээ ч эзэмдүүлэхгүйгээр нэг мөсөн чөлөөлөгдөхийн тулд Эзэн Есүс итгэлээ тавьж, дээрээс төрөх хэрэгтэй.

## 10 сарын 4

"Хуурмаг хоосныг харахаас хоёр нүдийг минь" (Дуу 119:37)

Энэ товч залбирлын эхний болон сүүлийн үг нь англи хэл дээр (*Turn away mine eyes from beholding vanity.*) TV гэсэн үсгээр эхэлж байгаа бөгөөд энэ эшлэлийг телевизтэй холбон ярих боломжтой. Телевизийн ихэнх хөтөлбөр хуурмаг хоосон. Тэдгээр нь хаана ч байхгүй ертөнцийг үзүүлж, бодит байдлаас дэндүү хол амьдралыг харуулдаг.

Телевиз нь үнэт цагийг хулгайлдаг. Телевиз үзэгчид эргэж хэзээ ч олодохгүй үнэт цагаа алддаг. Телевизээс болоод Библи уншлага буурч, хүмүүс Бурханы дуу хоолойноос хөндийрч, өөрсдөө ч мэдэхгүйгээр сүнслэг өсөлт нь буурч байдаг.

Телевизийн нөлөө хүүхдэд нэн хортой. Учир нь телевизээр хүчирхийллийг алдаршуулж, бэлгийн харилцааг дур татам харагдуулж, садар самууныг ил тод сурталчилдаг учраас хүүхдүүдийн ёс зүй гажууддаг. Телевизээс болоод хүүхдүүдийн унших бичих хүсэл, цаг зав буурч боловсролын түвшин унадаг. Тэдний эрхэмлэдэг зүйлсийг дэлгэцээр гарч буй хөтөлбөрүүд тодорхойлж, үзэл санаа нь Христийн эсрэг уриа лоозонгоор хэлбэржин тогтдог.

Хошин шог, инээд наргиан нь бохир заваан, хэлэгдэх үгс нь ёс суртахуунгүй.

Зар сурталчилгаа нь ямар ч утга учиргүй, дээрээс нь ёс суртахууныг сүйтгэгч. Биеэ үнэлэгч мэт хувцасласан, биеийнхээ хамаг хэсгийг ил гаргасан, дур хүсэл өдөөсөн эмэгтэй гарахгүй л бол ямар нэгэн юмыг зарж болдоггүй юм байна гэсэн санааг хүүхдүүдэд ойлгуулж байдаг.

Олон гэр бүл зурагтаас болоод харилцаа холбоогүй болж байна. Кино, нэвтрүүлэг, хөтөлбөрийг шимтэн үзээд бие биетэйгээ олигтой ч яриа өрнүүлэхээ байжээ.

Дуу хөгжмийн талаар яривал олигтой үгтэй дуу бараг байхгүй. Ихэнх нь хүсэл тачаалыг дээдэлж, завхайрал ба ижил хүйстний харилцааг магтан алдаршуулж, амьдралын жирийн нэг зүйл мэт ойлгуулж, хэрцгий догшин хүнийг баатар мэт харагдуулдаг.

Зурагтаар эрүүл зөв сургаалтай сайн христэд нэвтрүүлэг гардаг шүү дээ хэмээн зарим нэг нь маргах байх. Үнэндээ тэр нь хортой эмд түрхсэн багахан элсэн чихэр төдий. Бодит байдал гэвэл телевиз нь тэр чигээрээ сүнслэг байдлыг хорлон сүйтгэдэг.

Нэгэн христитгэгч гэртээ зурагт худалдан авч хүргэлтээр авчруулжээ. Тэгтэл хүргэлтийн машины хажуу дээр "Зурагт таны гэрт ертөнцийг авчирна" гэсэн реклам байв. Үүнийг уншаад итгэгч гэмшиж, зурагтыг буцаасан байна.

Зурагтын өмнө хадагддаг хүн Бурханы төлөө түүх бүтээнэ гэж байхгүй. Өнөө үед сүнслэг сэргэлтүүд яагаад ирэхгүй байгаагийн нэг том шалтгаан энэ юм.

## 10 сарын 5

*"Хөлийн чинь ул гишгэх газар бүрийг Би Мосед амласныхаа дагуу та нарт нэгэнт өгсөн билээ."* (Иош 1:3)

Бурхан Канаан нутгийг израильчуудад өгсөн. Энэ нутгийг Бурханы амлалт аль хэдийнээ тэднийх болгочихсон. Гэхдээ тэд алхам хийж уг нутгийг эзэлж авах ёстой байсан. "Хөлийн чинь ул гишгэх газар бүрийг Би та нарт өгнө" гэсний дагуу эзэмшин авах ёстой байсан.

Бурхан бидэнд олон амлалтыг өгсөн. Библи амлалтуудаар дүүрэн. Гэхдээ амлалтын биеллийг үзэхийн тулд итгэх ёстой. Тэгж байж л амлалтыг бодитоор харна. Тухайлбал, авралын тухай амлалтыг авч үзье. Нүглээ гэмшиж, Өөрийг нь Эзэн ба Аврагч болгож хүлээн авсан хүн бүрд мөнх амийг өгнө гэж Эзэн Есүс ахин дахин амласан. Гэхдээ хүн Аврагчид итгэл найдвараа тавихаас нааш энэ амлалт хэрэгжихгүй.

Жоохон цааш явъя. Хүн Эзэн Есүс Христэд үнэн голоосоо итгэлээ гэж бодъё. Гэсэн ч аврагдсан эсэхдээ эргэлзэж магадгүй. Аврагдсан гэдэгтээ өөрийгөө итгүүлэх гэж оролдоод байна гэж бодож магад. Тэгвэл Бурханы үгэнд "Хүүгийн нэрд итгэгч нь мөнх амьтай" гэж бичигдсэн (1Иох 5:13). Энэ амлалтын үнэнийг амьдралдаа амсаж явахын тулд үүнд итгэх шаардлагатай.

Бурхан Өөрт нь найдахыг харах дуртай. Өөрийнх нь үгнээс зуурахыг Тэр таалдаг. Бид Бурханы амлалтуудыг бариад уг амлалтууд биелсэн хэмээн итгэж алхах үед Бурхан хүндлэгддэг.

Нэг өдөр Наполеон цэргүүдийнхээ байр байдалтай танилцаад явж байтал морь нь цочин булгиж, эзэн хааныг



авч шидэхээ шахав. Нэгэн байлдагч яаравчлан хазаараас нь барьж аваад морийг тайвшрууллаа. Наполеон түүнийг жирийн байлдагч болохыг мэдсээр байж "Маш их баярлалаа ахмад аа" гэжээ. Байлдагч үгийг нь шууд утгаар хүлээн аваад "Эрхэм ээ аль хорооных вэ?" гэж асуув.

Байлдагчаас ахмад болсон тэрээр хожим нь найз нөхдөдөө тэр явдлыг дурсан ярихад нөхөд нь "Чи ямар өөртөө итгэлтэй хүн бэ" гэж шоолон инээж байжээ. Эзэн хаан хэлж байгаа л бол газар дээр нь итгэлтэйгээр хүлээж авах нь зөв.

Итгэгч бидний нөхцөл байдал зарим талаараа үүнтэй төстэй. Бид байлдагч хэвээрээ үлдэж болно. Эсвэл ахмад болж болно. Христ Есүсийн доторх өмч баялгийн эзэн болж болно. Эсвэл ядуу чигээрээ үлдэж болно. "Бид Бурханаас хүссэн хэмжээгээрээ авах боломжтой. Христ гарт маань эрдэнэсийн сангийнхаа түлхүүрийг атгуулаад хүссэн хэмжээгээрээ ав гэж хэлсэн. Асар их эд баялагтай өрөө рүү оруулаад хүссэн бүхнээ ав гээд байхад ганц ч зоосгүй гарч ирвэл хэний буруу вэ? Христитгэгчид Бурханы үнэгүй баялгуудыг эзэмшдэггүй нь хэний буруу вэ?" (Макларен)

## 10 сарын 6

*"Хэл яриа нь хэтэрхий амтлаг, хамаг бие нь хайрыг булаам энхрий. Хайрт найз минь ийм дээ, Иерусалимын охид минь дээ." (Сд 5:16)*

Шулаам эмэгтэйн хайртыгаа гэсэн хувиршгүй үнэнч хайр нь сүнсийг минь мөнхөд Хайрлагчийгаа бид хэрхэн хайрлах ёстойг дүрслэн харуулж байна. Дараах зүйлсийг анзаараарай.

Тэрээр хайртынхаа бүх зүйлд дуртай бөгөөд өнгө зүс, толгой, үс, нүд, хацар уруул, гар, бие, хөл, царай, ам гээд гадаад үзэмжийг нь өргөмжлөн магтсан (5:10-16). Мэдээж бид Эзэн Есүсийн гадаад биеийн байдлыг бодно гэсэн үг биш. Харин зан чанарынх нь эрхэмсэг гоо үзэсгэлэнд татагдан дурлана гэсэн үг.

Шулаам эмэгтэй хайртыгаа өдөржин, шөнөжин бодсон. Талбайд ажиллаж байхдаа ч, шөнө унтаж байхдаа ч, шөнийн зүүдэндээ ч түүнийгээ мөрөөдөн хүсэмжилж байлаа. Эзэн Есүсийг гэсэн хайр минь өдөр ч шөнө ч зүрх сэтгэлийг минь дүүргэж байвал бидэнд сайн.

Шулаам эмэгтэйн нүд зөвхөн хайртыгаа л харж байсан. Өөр хүмүүс түүний анхаарлыг татах гэж, сэтгэлийг нь булаах гэж уран сайхан үгсийг хэлэвч тэрээр бүх магтаалыг хайртдаа зориулж байлаа. Үүний адилаар энэ ертөнцийн дуу хоолой бидний анхаарлыг татах гэвэл энэ дууг дуулаарай:

*Ертөнцийн чамин тансаг, яруу сайхан нь  
Ерөөсөө ч миний анхаарлыг татдаггүй  
Би илүү сайхан түүхийг сонссон  
Би жинхэнэ утга учрыг олсон*

*Христ надад мөнхийн гэр бэлдсэн  
Хайрт минь тэнд оршин суудаг  
Тэнд Есүсийг би ширтэн харна  
Тэнд Бурхантай би хамт амьдарна*

Шулаам эмэгтэй хайртынхаа талаар байнга, зогсоо зайгүй ярьдаг байсан. Ам нь зүрхнийхээ бялахлаар ярьж байлаа. Уруул нь бэлэн бичээчийн үзэг байлаа. Бид ч мөн ялгаагүй ямар ч сэдвээс илүү Эзэн Есүсийн тухай хэзээ ч хаана ч ярьдаг байх ёстой. Гэвч харамсалтай нь ийм байдаггүй.

Шулаам эмэгтэй өөрийн дорд байдлаа хүлээн зөвшөөрсөн. Гадаад үзэмжээ зөнд нь орхиж, эгэл дорд байсандаа, хайртдаа хариу өгөөгүйдээ уучлалт гуйсан. Үүнийг өөрсдийн байдал дээрээ авч үзвэл, нүгэлтэй, дуулгаваргүй, тэнэж төөрөх хандлагаа бодох ёстой. Энэ бүхнээ бодох тусам Христ яагаад ийм муу хүмүүсийг хайрлана вэ гэсэн гайхширал төрдөг.

Шулаам эмэгтэй хайрттайгаа хамт байхыг туйлаас хүсдэг байв. Сүйт бүсгүй болох цагаа хамаг сэтгэлээсээ мөрөөднө. Үүний нэгэн адилаар, бид тэнгэрлэг Хүргэний ирэхийг тэсэн ядан хүлээж, Түүнтэй хамт үүрд мөнхөд байхыгаа харуулдан суух ёстой.

Шулаам эмэгтэй хайртынхаа хайранд олзлуулж, хайраар бялхан зүрх нь хүчтэй өвдөж байгааг хүлээн зөвшөөрсөн. Үүн шиг, бид Есүс Христийн хайранд олзлуулж, Түүний хайраар бялхсан зүрх сэтгэлтэй байх болтугай!

## 10 сарын 7

"Ах дүү нар аа, би өөрөө барьж авсан гэж боддоггүй."  
(Флп 3:13)

Элч Паул өөрийгөө болчихлоо хэмээн үзээгүй юм бол бид ч тийн үзэх ёсгүй. Бидэнд бүгдэд маань өөрчлөлт хэрэгтэй. "Хүн өөрийгөө өөрчлөгдөх ёстой бас боломжтой гэж үзэх ёстой. Хүн өөрийгөө өөрчлөгдөшгүй, төгс, ариун, гэж бодож болохгүй. Ингэвээс хүний дотор өсөлт хөгжлийн үйл явц зогсоно." (Лиу Шао Чи)

Асуудал нь гэвэл ихэнх хүн өөрчлөгдөхөөс татгалздаг. Бусдыг өөрчлөх дуртай боловч өөрийгөө өөрчлөх дуртай хүн тун ховор. Хүмүүсийн зан чанар биднийг бухимдуулдаг болохоор энэ хүн л өөрчлөгдөх ёстой хэмээн боддог. Өөрсдийнхөө сул талыг харахгүй, муу зандаа бид сэтгэл хангалуун байж чаддаг. Бид өөрсдийн нүдэн дэх дүнзийг харахгүй мөртлөө бусдын нүдэн дэх үртсийг авах гэж оролддог. Бусдын алдаа зөрчил муухай. Биднийх болохоор сайхан.

Гол асуудал нь бидний хүсэл. Хүсэх л юм бол бид өөрчлөгдөж чадна. Зан чанарт маань дутагдал, сул тал байгааг хүлээн зөвшөөрч, түүнийгээ засахыг хүсэх хэрэгтэй.

Тэгвэл ямар өөрчлөлт хэрэгтэйг яаж мэдэх вэ? Эхний арга нь Бурханы үгийг толио болгох. Библийг уншиж судалж байхдаа яах ёстой, ямар дутагдалтай байгаагаа олж харж чадна. Библи бидний алдаа бурууг шүүмжилбэл үнэнтэйгээ зоригтой нүүр тулж, түүнийхээ төлөө ямар нэгэн юм хийхээр хатуу шийдэх хэрэгтэй.

Христтэй адилгүй зан чанартайгаа мэдэх дараагийн нэг арга бол ах дүү, найз нөхдөө сонсох явдал. Тэдний үг заримдаа зөөлөн, харин заримдаа алх шиг хатуу бууна. Зөөлөн ч бай, хатуу ч бай, хэлж буй үгийг нь бид талархан хүлээн авах ёстой.

Найз нөхдийнхөө хайраар хэлсэн шүүмжлэлийг хүлээн авч сурах нь сайн дадал хэвшил юм. Жишээ нь "Миний зан чанар дотор алдаа, бусдыг зовоосон буруу хандлага байвал чөлөөтэй хэлж байгаарай" хэмээн найзууддаа хэлж болно. Жинхэнэ найз хэлснийг чинь хийнэ.

Чуулгандаа, гэртээ, нийгэмдээ, ер нь хаана ч хүмүүст төвөг удаж, муухай зан ааш гаргах атал хэн ч түүнийг нь хэлэхгүй эсвэл өөрсдөө өөрчлөгдөх хүсэлгүй хүмүүсийг бодохоор нэн гунигтай. Бидэнд ямар алдаа дутагдал, хүмүүсийг зовоосон муу зан чанар байгааг олж харахын тулд цаг зав гаргаж, засахын тулд бодитой арга хэмжээ авч эхэлбэл бид илүү сайн хүн болж чадна.

## 10 сарын 8

"Ах дүү нар аа, бие биенээ бүү гүжирд." (Иак 4:11)

Библийн Жэймс хааны орчуулгад хов жив [gossip] гэж үг байхгүй боловч гүжирдэх, муулах, шивнэх гэх мэт үгэнд энэ санаа агуулагдаж байна. Мэдээж хэрэг хов живийг Библи буруушаадаг.

Хов жив гэдэг нь бусдыг муугаар харагдуулахын тулд тэдний талаарх мэдээллийг задруулна гэсэн үг. Өөрөөр хэлбэл, тухайн мэдээлэл таагүй, онцгүй байдаг. Хов живд ихэвчлэн нууцлал агуулагдана. Хов жив ярьж байгаа хүн өөрийгөө илчлэхийг хүсэхгүй.

Бруклийнд хоёр эмэгтэй ярилцаж байлаа.

-Тиллигийн талаар ярьсныг минь чи Тиллид хэлсэн байна лээ. Тиллигээс би сонслоо. Би чамайг түүнд битгий хэлээрэй гэж хэлсэн шүү дээ.

-Хэлснийг минь чамд битгий хэлээрэй гээд би Тиллид хэлсэн юм даа. Тэр ч өөдгүй эмэгтэй юм аа.

-За яах вэ. Тэр надад хэлснийг чамд хэлэхгүй гэж би Тиллид хэлсэн юм. Чамд ярьсныг минь Тиллид битгий хэлээрэй.

Бусдын талаар сөрөг юм огт ярьдаггүй хүн гэж энэ дэлхий дээр бараг байхгүй. Би цөөхөн ч болов тийм хүмүүстэй уулзаж байлаа. Тэднийг хараад үгээр хэлэхийн аргагүй бишрэл төрсөн. Эхнийх нь бусдын талаар сайн юм дурсаж чадахгүй үедээ зүгээр л амаа хамхисан. Хоёр дахь нь бусад итгэгчдийн дотроос Эзэн Есүсийг сануулсан зүйлс олж харах гэж хичээдэг хэмээсэн. Гурав дахь нь бусдын талаар сөрөг юм хэлэх гэсэнээ өгүүлдэрээ таслаад дундуур нь шууд "Ингэж болохгүй. Энэ нь бусдыг барьж

босгохгүй" гээд хэлээ хазсан. (Түүний ярих гэж байсан үг одоо ч миний сонирхлыг татсаар байдаг.)

Паул Коринтын итгэгчдийн дунд зөрчил байгааг сонсжээ. Энэ асуудлыг сөхөж гаргаж ирэхдээ "Хлоеныхноос надад мэдэгдсэн" (1Кор 1:11) гэж мэдээллийн эх сурвалжийг ярьсан. Хлоеныхон хов жив ярьж яваагүй. Тэд асуудал шийдэгдээсэй гэсэндээ мэдээлэл дамжуулсан.

Элч Паул мөн Хуменай, Александр, Филет (1Тм 1:20; 2Тм 2:17) нарын талаар хатуу үг бичсэн. Яагаад гэвэл тэд Христийн үйл хэрэгт гай тарьж байлаа. Мөн тэрээр Фугел, Хермоген, Дем (2Тм 1:15; 4:10) нарыг Тимотод сэрэмжлүүлсэн. Энэ хүмүүс анжис дээр гараа тавьчхаад эргэж буцжээ. Энэ хүмүүсийн талаар ярьсан нь хов жив биш. Энэ нь тулаанд оролцож байгаа итгэгчдийн зайлшгүй мэдэх ёстой мэдээлэл байсан.

Нэгэн номлогч байж гэнэ. Хүмүүс түүнд хэн нэгний талаар муулахаар ирэх үед тэрээр хар дэвтэр гаргаж ирээд "Ярьсан үгээ наад дэвтэртээ бичээрэй. Тэгээд гарын үсэг зур. Энэ мэдээллийг ярианд дурсагдаж байгаа хүнд бас мэдүүлэх ёстой" гэдэг байлаа. Номлогч олон удаа энэ дэвтрээ гаргаж ирсэн боловч нэг ч удаа мэдээлэл оруулж чадаагүй байна.

## 10 сарын 9

*"...чиний сайн сайхны төлөө өнөөдөр миний чамд тушааж байгаа ЭЗЭНий тушаал, зарлигууд..." (Дх 10:13)*

Өнөөдрийн эшлэлийн эхний дөрвөн үгийг хараарай: "Чиний сайн сайхны төлөө." Эзэний бүх тушаал зарлиг бидний сайн сайхны төлөө байдаг. Ихэнх хүн үүнийг ойлгодоггүй. Тэдний бодлоор Бурхан бол баахан хууль дүрэм тогтоож, амьдралын сайн сайхныг биднээс булаах гэж оролддог хатуу шүүгч. Гэвч тийм биш. Тэрээр бидний сайн сайхан, аз жаргалыг анхаардаг бөгөөд түүний хуулийн эцсийн зорилго ерөөсөө л энэ.

Жишээ болгож арван тушаалыг харъя. Бурхан яагаад өөр бурхадтай байж болохгүй гэсэн юм бэ? Яагаад гэвэл хүн шүтэж мөргөдөг зүйлтэйгээ адилхан болдог бөгөөд хуурамч бурхад нь хүнийг ёс бус руу хөтөлдөг гэдгийг Бурхан мэднэ.

Яагаад хиймэл шүтээн хийж болохгүй гэж Бурхан хэлсэн бэ? Яагаад гэвэл шүтээн шүтлэгийн цаана чөтгөр байдгийг Бурхан мэднэ. "Тахидаг юмсыг тэд Бурханд бус, харин чөтгөрүүдэд тахидаг аж" (1Ко 10:20). Чөтгөрийн зорилго болбоос үргэлж алж устгах.

Бурхан долоон өдрийн нэгийг нь яагаад амралтын өдөр болгосон бэ? Яагаад гэвэл Бурхан хүнийг бүтээсэн учраас нэг өдрийг заавал амарч байх шаардлагатайг нь мэднэ. Долоо хоногийн туршид хүнийг ажиллуулах гэж оролдсон улс үндэстнүүд бүтээмжээ алдаж энэ хууль журмаа цуцалж байлаа.



Бурхан эцэг эхээ дага гэж хүүхдүүдэд яагаад тушаасан бэ? Яагаад гэвэл энэ нь хүүхдүүдийг буруу замаас хамгаалж, цаашлаад цагаасаа эрт үхэхээс аварна.

Бурхан яагаад завхайрлыг хориглосон бэ? Яагаад гэвэл энэ нь орон гэр, элэг бүтэн гэр бүлийг сүйрүүлж, завхайрагч этгээдүүдийн ч гэсэн аз жаргалыг хулгайлдгийг Бурхан мэднэ.

Бурхан яагаад хүний амь хөнөөхийг хориглосон бэ? Яагаад гэвэл энэ нь харамсал, буруутгалыг авчирч, шорон, цаашлаад цаазын ялд хүргэдэг.

Бурхан яагаад шуналыг буруутгасан бэ? Яагаад гэвэл нүгэл бодол санаан дотор эхэлдэг. Уг бодол санааг таслан зогсоохгүй бол хэзээ нэгэн өдөр үйлдэл болно. Усны ундаргыг таслахгүй бол урсгалыг нь таслах боломжгүй.

Бурханы нэрийг дэмий хоосон дурдах, хүний юм хулгайлах, хуурамчаар гэрчлэх гээд бусад нүглүүд ч ялгаагүй биднийг хохироодог. Нүгэл биднийг хэзээ ч сайн сайханд хүргэхгүй. Сүнс, сэтгэл, бие махбодод хохирол учруулдаг. Нүгэл бүхэн муу зуршлыг бий болгож, нүгэлтний амар амгалан, баяр хөөр, сэтгэл ханамжийг хулгайлдаг. Хүн юу тарьснаа хурааж авна. Өөд нь хаясан чулуу өөрийн толгой дээр унана.

Хэдэн жилийн өмнө нэг хүн "Бурханы сайхан хуулиуд" нэртэй ном бичсэн. Үнэхээр ч Бурханы хуулиуд сайхан. Яагаад гэвэл уг хуулиуд бидний сайн сайхны төлөө байдаг.

## 10 сарын 10

*"Аливаа хорсол, уур, хилэн, хаихираан, гүтгэлэг нь бүх муу муухайн хамт та нараас зайлаг."* (Еф 4:31)

Уурлаж уцаарлах шалтгаан амьдралд мундахгүй ээ. Доор дурдах жишээнүүд ихэнх нь танд танил санагдах байх.

Зөөгч хувцсан дээр чинь халуун кофе асгачхаад, дээрээс нь, захиалсан хоолыг чинь удаах. Гэртээ ирээд худалдаж авсан юмаа үзтэл үйлдвэрийн доголдолтой бараа байх. Буцаж очоод бараагаа буцааж мөнгөө авах гэтэл худалдагч нь харьцааны соёлгүй хүн байж таарна. Буруу мэдээлэл авснаас болоод онгоцноосоо хоцрох. Шинэ машин худалдаж автал болгоомжгүй нэгэн жолооч хажуу талыг нь хонхойлгох. Бараа захиалаад гэртээ хүргүүлэхээр тохиролцсон боловч захиалсан бараа чинь ирэхгүй байх. Хэчнээн удаа залгаж асуусан ч одоохон хүргэж өгнө гэхээд таг болох. Супермаркетын кассчин илүү мөнгө биччихээд энэ тухай ярихаар өөдөөс чинь бүдүүлэг авирлах. Хөрш чинь хүүхдүүдийн өчүүхэн жижиг асуудлыг дэвэргэх. Өөр нэг хөрш чинь чанга дуу хөгжим хангинуулан байнга үдэшлэг зохиож тав тухыг чинь алдагдуулах. Хамт ажилдаг хүн чинь христгч болохоор чинь байнга янзыг чинь үзэх. Дэмждэг багт чинь шүүгч шударга бусаар алдаа өгөх. Гэр бүлийнхэн чинь хүссэн нэвтрүүлгийг чинь үзүүлэхгүй зурагтын удирдлага булаацалдах.

Энэ бүх уур унтууцал төрүүлсэн нөхцөл байдлыг бид болиулж чадахгүй. Гол нь итгэгч хүн үүнд ямар хариу үзүүлэх вэ гэдэг нь л чухал. Төрлөх араншин бол шууд

уурлан унтууцаж, буруутай этгээдэд хамаг муу үгээ хэлнэ. Харин христэч хүн уур уцаараараа гэрчлэлээ үгүй хийдэг гэдгийг санах хэрэгтэй. Орилж хашхичиж, нүд нь улаанаараа эргэлдэж, хамаг шүлсээ үсчүүлж, уурлан хилэгнэсний дараа Эзэн Есүсийн өмнөөс үг хэлэх боломжгүй юм. Тэрээр энэ ертөнцийн хүн шиг зан гаргасан учраас Библийн үлгэр жишээ байхаа болино.

Үнэндээ уур унтууцлыг чинь төрүүлээд байгаа хүнд сайнмэдээ хэрэгтэй гэдгийг мэдэх хэрэгтэй. Магадгүй амьдралд нь хэцүү зүйл байгаа учраас муухай авирладаг байх. Хэрэв хайр халамж, зөөлөн дулаан зан харуулбал Эзэн Есүст итгэх ч юм бил үү.

Биеэ барьж чадахгүй уурлаж уцаарлах нь христитгэгчийн гэрчлэлийг үгүй хийж Эзэний нэрд үл хүндлэлийг авчирна. Ууртай итгэгч итгэлээ зөвөөр ойлгуулж чадахгүй.

## 10 сарын 11

*"Явганыг дагаж гүйгээд ядарлаа гэвэл чи, морьтонтой хэрхэн уралдах болж байна? Амгалангийн газар унаж тусаж байвал Иорданы шугуйд чи яах билээ?" (Иер 12:5)*

Өчүүхэн бэрхшээлээс болж шантармаар санагдсан үед энэ эшлэлийг санах хэрэгтэй. Жижигхэн асуудал биднийг бүдрээх юм бол том асуудал ирвэл яах вэ? Амьдралын багахан салхинд цөхөрч унавал хуй салхи ирвэл яах вэ?

Зарим итгэгч хүнд гомдсоноосоо болоод шантрах, шүүмжлүүлснээсээ болоод амьдрах итгэлгүй болох, санааг нь дэмжээгүй гээд урам хугарах тохиолдлуудыг бид олонтоо хардаг.

Жижигхэн шалбархайгаа үхлийн шарх авсан мэт үздэг хүмүүс ч байна. Хэрэв тэд үнэхээр үхлийн өвчин тусвал яах юм бэ? Бизнесмен хүн өдөр өдрийнхөө асуудлыг шийдэж чадахгүй бол том санхүүгийн хямрал болох үед яаж давах юм бэ?

Өөрөөр хэлбэл бидэнд тодорхой хэмжээний хатуужил хэрэгтэй. Гэхдээ хахир хатуу байна гэсэн үг биш. Гэвч амьдралын хэдэн цохилтыг даах сэтгэлийн тэнхээтэй байх нь чухал.

Магадгүй яг одоо танд хэцүү асуудал тулгарсан байж болно. Асуудал гэдэг тухайн үедээ хүнд санагддаг. Яг одоо л больчихмоор, буугаад өгчихмөөр байгаа байх. Гэвч одоогоос жилийн дараа энэ асуудал чинь инээдэмтэй санагдах байх. "Танаар би их цэргийг дайрч, Бурхандаа түшиглээд би хэрмийг давж чаддаг" (Дуу 18:29) гэж хэлэх ёстой цаг чинь яг одоо юм.

Еврей номын зохиогч сорилт, зовлон туулж буй хүмүүст "цус урсгах хүртлээ та нар хараахан эсэргүүцээгүй байгаа" (Евр 12:4) гэж хэлсэн. Өөрөөр хэлбэл, хамгийн үнэтэй зүйл болох амь насаа алдах золиосыг та нар гаргаагүй байна гэж тэр хэлж байгаа юм. Христитгэгч аяга хагарах, муураа алдах, хайр нь бүтэлгүйтэх зэрэгт бүх итгэл найдвараа алдах юм бол үхэлтэй тулахаараа яах юм бэ?

Сэтгэл санаагаар унамагцаа л бүхнийг орхидог хүмүүс бий. Гэвч христитгэгч бид тулаанаас гарч болохгүй. Унасан ч босоод тоосоо гөвөөд тулаан руугаа дахиад ор. Жижиг тулаанд ялсан ялалт дараагийн том тулаанд ялалт байгуулахад маань тусална.

## 10 сарын 12

*"Гал ноцоож, гал сумаараа хүрээлэгчид ээ, харагтун, бүгдээрээ галынхаа гэрэлд, ноцоосон сумнуудынхаа дундуур алхагтун. Мутраас минь авах зүйл чинь энэ билээ. Чи зовлон шаналал дунд хэвтэнэ."* (Иса 50:11)

Аливааг хийх зөв арга эсвэл буруу арга гэж байдаг. Заавар чиглүүлэг авах асуудалд ч ялгаагүй энэ зарчим хэрэгжинэ. Өнөөдрийн эшлэл буруу аргыг нь хэлж байна. Хүн түүдэг гал асаагаад уг галаа ашиглан өөрийнхөө замд гэрэл гаргахыг оролдож буйг энд дүрсэлсэн.

Эзэнтэй зөвлөлдөх, Эзэнд залбирах талаар энд юу ч дурдсангүй. Хүн өөрийнхөө тогтоосон замд бүрэн төгс итгэлтэй байгаа нь харагдана. Өөртөө эрдэж бардаад, өөрийнхөө ойлголтод түшиглэж байна. Хэнлигийн хэлсэн шиг, хүмүүн хувь тавилангийнхаа эзэн, сэтгэлийнхээ жолоодогч болжээ.

Тэгвэл дараа нь юу болсныг үзээрэй. "Мутраас минь авах зүйл чинь энэ билээ. Чи зовлон шаналал дунд хэвтэнэ." Хүн асуудлаа шийдэх гэж өөрийнхөө аргаар явж, өөрийн хүслээрээ үйлдсэн бүхэн эцэст нь ийнхүү харамсалд хүргэдэг. Бурханы замууд л хамгийн зөв гэдгийг тэр гашуун туршлагаар ойлгодог.

Заавар чиглүүлэг авах зөв замыг өмнөх эшлэлд (10-р эшлэл) хэлж өгсөн байна: "Дотор чинь ЭЗЭНээс эмээх, зарцынх нь дуу хоолойг дуулгавартай дагах, харанхуйд явж, гэрэлгүй байх хэн бэ? Тэрээр ЭЗЭНий нэрд итгэж, Бурхандаа найдагтун" (Иса 50:10). Энэ хүний талаар гурван зүйлийг харж болно. Нэгдүгээрт, Эзэний таалдаггүй зүйлийг үйлдэх вий, Эзэнээс хараат бус

амьдрах вий хэмээн Эзэнээс эмээдэг. Хоёрдугаарт, Бурханы зарц болох Эзэн Есүсийн дуу хоолойг дагадаг. Гуравдугаарт, харанхуйд алхаж байгаагаа, гэрэл гэгээгүй гэдгээ хүлээн зөвшөөрдөг. Өөрөөр хэлбэл, хаашаа явахаа мэдэхгүйгээ хүлээн зөвшөөрдөг.

Энэ хүн юу хийх хэрэгтэй вэ? Эзэний нэрд итгэж, Бурхандаа түшиглэх хэрэгтэй. Юу ч мэдэхгүйгээ хүлээн зөвшөөрч, Эзэнд бууж өгч, Бурханы заавар чиглүүлгийг бүрэн дагах хэрэгтэй.

Бидний Бурхан бол хязгааргүй мэргэн ухаан ба хайрын Бурхан мөн. Тэрээр бидэнд юу нь хамгийн сайныг мэддэг бөгөөд бидний сайн сайхны төлөө төлөвлөж үйлддэг.

*Тэр мэддэг, хайрладаг, анхаардаг  
Энэ үнэнийг юу ч бөхөөж чадахгүй  
Өөрт нь сонголт үлдээсэн хүмүүст  
Хамгийн сайныг Тэр хийж өгдөг*

## 10 сарын 13

*"Хүүгээ талх гуйхад чулуу өгдөг хүн та нарын дунд байна уу?" (Мт 7:9)*

Энэ асуултад хэн ч “байхгүй” гэж хариулна. Эцэг хүн үр хүүхдэдээ талхны оронд чулуу өгөхгүй. Тэнгэрлэг Эцэг маань бүр ч илүү. Тэр хэзээ ч бидэнд чулуу өгөхгүй.

Гэтэл заримдаа бид хүмүүст чулуу өгдөг. Асар их сүнслэг хэрэгцээтэй хүмүүс бидэн дээр ирэхэд тэднийг юу зовоогоод байгааг тунгааж үзэхгүй, өнгөцхөн шийд хэлж өгөөд Эзэн Есүсийг хуваалцахгүй явуулчихдаг.

Э. Стэнли Жонс энэ тухай өөрийнхөө түүхээр ярьсан байдаг. (Алдаагаа нуулгүй ярина гэдэг агуу хүний шинж юм.) "Энэтхэгийн конгрессын гишүүд эрх мэдэлд гарахаараа улс орныхоо төлөө ажиллахгүй, ихэнх тохиолдолд өөрсдийн амин хувийн эрх ашигт эрх мэдлээ урвуугаар ашигладаг. Жавахарлал Неру энэ бүхнийг хараад сэтгэл нь ихэд өвдөж байлаа. Тэрээр ерөнхий сайдын албан тушаалаа өгч, дотоод сэтгэлээ эргүүлэн олж авах талаар бодож суув. Тэр үед нь би түүнтэй уулзсан бөгөөд ярианыхаа төгсгөлд олон төрлийн витамин агуулсан амуу тарианы ундаа өглөө. Тэгтэл Жавахарлал Неру талархсанаа илэрхийлээд ‘Миний асуудал биеийнх биш’ гэв. Өөрөөр хэлбэл сүнслэг хэрэгцээ түүнд байсан гэсэн үг. Харин би түүнд Бурханы нигүүлслийг хуваалцахын оронд өвсний ундаа өгсөн. Тэр надаас талх гуйхад би түүнд чулуу өгсөн... Би хариултыг мэдэж байсан ч яаж хэлэхээ мэдэхгүй байлаа. Би тэр том хүнийг гомдоохоос айсан. Сат Тал Ашрамын ханан дээр 'Есүсийн үл тохирох газар хаана ч байхгүй' гэснийг би санах ёстой



байлаа. Гэвч тэгээгүй. Айж байснаа л санаж байна. Айдас минь намайг дийлсэн.”

“Хүн надаас зүрх сэтгэлийг нь эдгээх нигүүлслийг гуйхад би өвсний ундаа л өгсөн. Тэрхүү нигүүлслийг авсан бол тэр хүн “Зүрх минь эдгэрлээ” гэж хэлэх байлаа. Одоо ертөнц чи над дээр ир. Боломжгүй асуудлын ертөнц чи хүрээд ир. Би бэлэн байна.”

Доктор Жонсын туршлага бидэнд бүгдэд нь танил. Сүнслэг хэрэгцээтэй хүн бидэн дээр ирээд Христийг гэрчлэх үүд хаалгыг нээсэн үг хэлэхэд бид боломжийг атгаад авахын оронд ярианы сэдвийг огт өөр тийш хандуулах юм уу сүнслэг гүн шархыг жижигхэн шархны лентээр боогоод өнгөрдөг.

Залбирал: Эзэн, үүд хаалга нээгдэх бүрд боломжийг алдахгүй Таныг гэрчлэхэд минь туслаач. Айдсаа ялж, талх гуйсан хүнд чулуу өгөхгүй, хэрэгтэйг нь өгдөг байхад туслаач.

## 10 сарын 14

*"Тэгээд та нар үнэнийг ойлгож, үнэн та нарыг чөлөөлнө гэв."*(Иох 8:32)

Хүмүүс энэ эшлэлийг эш татаж ашиглахдаа амлалтын болзлыг нь мартаж гээд байдаг. Өмнөх эшлэлд нь "Есүс Өөрт нь итгэсэн иудейчүүдэд 'Хэрэв та нар үгэн дотор минь байвал үнэхээр Миний дагалдагчид байна'" гэж хэлээд араас нь "Тэгээд та нар үнэнийг ойлгож, үнэн та нарыг чөлөөлнө" гэж амласан. Өөрөөр хэлбэл үнэний чөлөөлөх хүч Эзэний үгэн дотор байнга байхаас хамаарна.

Үнэнийг мэдэх нь хангалтгүй. Дагаж хэрэгжүүлэх ёстой. Бид Библийн сургаалын дагуу амьдарвал үй түмэн бузар муугаас чөлөөлөгдөнө.

Сайн мэдээний дуудлагыг дагасан даруйдаа бид буруутгал ял зэмээс чөлөөлөгдөж, Бурханы хөвгүүдийн эрх чөлөө рүү ордог.

Дараа нь нүглээс чөлөөлөгдөж, нүгэл цаашид бидний эзэн байхаа болино.

Бид хуулиас чөлөөлөгддөг. Гэхдээ хуульгүй болсон гэсэн үг биш. Бидний хууль бол Христ. Шийтгэлээс айсандаа биш, Аврагч Эзэнийгээ хайрласандаа бид ариун шударга амьдрах хүсэлтэй болсон.

Бид айдсаас чөлөөлөгдсөн. Учир нь төгс хайр айдсыг зайлуулдаг. Эдүгээ Бурхан бол хатуу Шүүгч бус, бидний тэнгэрлэг Эцэг билээ.

Бид Сатаны боолчлолоос чөлөөлөгдсөн. Тэр одоо биднийг хүссэнээрээ удирдаж чадахгүй.

Бид бэлгийн садар самуунаас чөлөөлөгдсөн. Хүний хүсэл тачаалаар дамжуулан энэ ертөнцөд ялзралыг авчрагч зан чанараа бид гээдэг.

Бид хуурамч сургаалаас чөлөөлөгдсөн. Бурханы үг үнэн бөгөөд Ариун Сүнс Өөрийн хүмүүсийг бүхий л үнэн рүү хөтөлж, үнэнийг худлаас, зөвийг буруугаас ялгаж салгах мэргэн ухааныг өгдөг. Эзэн Есүсийн үгэн дотор байдаг хүмүүс элдвийн мухар сүсэг, бузар сүнсний захиргаадалтаас чөлөөлөгддөг. Чөтгөрийн эрх мэдэл, хүчнээс чөлөөлөгдөнө гэдэг ямар их ерөөл вэ!

Бид үхлийн айдсаас чөлөөлөгддөг. Үхэл биднийг Эзэнтэй чинь учруулдаг учраас түүнээс цаашид айх шалтгаан үгүй. Үхэх нь бидэнд ололт юм.

Бид муу зуршлуудаас чөлөөлөгдсөн. Мөнгөний хайр, итгэл найдваргүй байдал, гуниг гутрал биднийх биш. Тиймээс зүрхэнд минь дараах дууны үг хадаастай байдаг:

*Эзэн Есүс Таны хөл миний байх газар мөн*

*Энд л би үнэнийг сурч, эрх чөлөөг олж авна*

*Хүнийхээрээ явдаг дураараа занг минь таслаач*

*Хүлж байсан гинжийг үүрд надаас авч хаяач*

## 10 сарын 15

*"Иерусалим аа, Иерусалим аа...Тахиа дэгдээхэйнүүдээ далавчин дороо бөөгнүүлдэг шиг Би хүүхдүүдийг чинь цуглуулахыг хэчнээн ч удаа хүслээ дээ. Харин та нар хүсээгүй!" (Мт 23:37)*

Бурхан Өөрийн биеэр залран ирсэн ч энэ агуу боломжийг хүмүүс алджээ. Иерусалим хот хаана ч байхгүй ерөөлийг хүртэж, тоост гудамжнуудад нь Бурханы Хүү алхаж явлаа. Орчлон ертөнцийн Бүтээгч хүмүүсийн дунд явж, юутай ч зүйрлэшгүй үгсээ айлдаж, хэний ч хийж чадахгүй гайхамшгуудаа үйлдсэн. Гэвч тэд Түүнийг тавьсангүй. Түүнийг хүлээн авсангүй.

Хэрэв хүлээн авсан бол байдал илүү дээр байх байлаа. Нөхцөл байдал Дуулал 81:13-16 дээр дүрсэлсэн лугаа адил байх байлаа: "Хүмүүс минь Намайг сонсож, Израиль Миний замаар явсан ч болоосой! Тэгвээс Би дайснуудыг нь хурдан дарж, мутраа өстнүүдийнх нь эсрэг эргүүлэх байсан. ЭЗЭНийг үзэн ядагсад Түүнд сөхрөн бөхийх байсан бөгөөд Тэдний цаг мөнхөд үргэлжлэхсэн. Тэр тэднийг дээд зэргийн буудайгаар хооллохсон. Хад чулуунаас зөгийн бал гаргаж Би та нарыг хангах байсан."

Байдал ямар байх байсныг Исаиа ч бас дүрсэлсэн. "Тушаалуудад минь анхаарлаа хандуулдаг ч болоосой, чи! Тэгвэл амар тайван чинь гол мэт, зөвт байдал чинь далайн давлагаа мэт байхсан. Үр удам чинь элс мэт, хэвлээс чинь гарагчид элсний ширхэг мэт болно. Нэрс нь оршихуйгаас минь хэзээ ч таслагдахгүй, устгагдахгүй" (Иса 48:18-19).

"Үзгээр бичиж, амаар илэрхийлэх хамгийн гунигтай үг бол 'ингэх байсан, тэгэх байсан' гэх юм." (Брэт Харт)

Сайнмэдээний дуудлагаас татгалзсан хүмүүсийг бодоод үз. Назарын Есүс дэргэдүүр нь өнгөрөхөд тэд Түүнийг тоолгүй өнгөрсөн. Яваад одсоных нь дараа тэд хий хоосон утгагүй амьдралаар амьдарч, эцэст нь мөнхийн шийтгэлийг амссан.

Годорхой нэг үйлчлэлийн талбарт дуудсан Христийн дуудлагыг дагаагүй итгэгчдийг бодоод үз. Тэд энэ амьдралдаа ямар их ивээл ерөөл авч, ирээдүйд ямар агуу шагнал хүртэх байснаа төсөөлөх ч үгүй.

Заримдаа боломж ганц л удаа хаалгыг тогшдог. Гэхдээ энэхүү хамгийн сайхан боломж амьдралын минь төлөвлөгөөтэй зөрчилдөж, биднээс золиос гаргахыг шаардаж болно. Үүнийг хараад Бурханы өгсөн хамгийн сайн сайхнаас зугтаж, боломжийг бид алддаг. Хэрэв бид Бурханы хамгийн сайнаас татгалзвал Тэр дараагийн сайныг бидэнд санал болгодог. Ингэх бүрдээ тэрээр "Би та нарт өгмөөр байна. Гэвч та нар авахгүй байна" гэж хэлдэг.

## 10 сарын 16

*"Хүмүүсийн аливаа итгэл сүсэггүйдэл ба зүй бусын эсрэг Бурханы уур хилэн тэнгэрээс илчлэгддэг." (Ром 1:18)*

Бурхан хүн төрөлхтний түүхийн тодорхой нэг үед хүмүүсийн дээр шийтгэл буулгаж, тэдний үйлдсэн нүглүүдэд ямар их дургүйцэж буйгаа харуулсан. Мэдээж Тэр хүнийг нүгэл үйлдэх бүрд нь шийтгээд байдаггүй. Тэгдэг байсан бол дэлхий дээр хүн бараг үлдэхгүй биз. Гэхдээ итгэл сүсэггүйдэл ба зүй бусыг Бурхан заавал шийтгэнэ гэдгээ сануулахын тулд шийтгэл буулган тухайн түүхийг бичиж үлдээсэн байна. Тэр өнөөдөр шийтгэлгүй орхиж болно. Харин маргааш мөнхийн мөнхөд заавал шийтгэнэ.

Бурхан энэ дэлхий рүү хартал хүн төрөлхтөн хүчирхийлэл, гэм нүглээр дүүрсэн байлаа. Тиймээс Тэр усан галав юүлүүлж ертөнцийг устгасан (Эх 6:13). Усан галаваас найман хүн л амьд гарсан билээ.

Хожим нь Содом, Гоморра хотууд ёс бус бэлгийн харилцаа, ижил хүйстний төв болоод байлаа (Эх 19:1-13). Содомын гэм нүгэл нь бардам зан, элбэг дэлбэг хоол, налгар тайван байдал байв (Езк 16:49). Бурхан тэнгэрээс уур хилэнгээ илэрхийлж, гал ба чулуун мөндрөөр хотуудыг устгаж, газрын хөрснөөс арчсан.

"Надаб, Абиху нар ЭЗЭНий өмнө ёс бус галыг өргөхдөө ЭЗЭНий өмнө үхсэн" (Тоо 3:4). Тэд тахилын ширээнээс гал авах ёстой байсан (Лев 16:12). Гэвч Бурханы зааснаас өөр арга замаар Бурханд ойртох гэж оролджээ. Бурхан тэднийг шийтгэснээрээ Өөрийнх нь тогтоосноос өөр арга замаар Өөрт нь ойртох гэж оролдсон хүмүүсийг

ямар хувь тавилан хүлээж байгааг бүх үеийнхэнд сануулга болгосон.

Вавилоны хаан Небухаднезар хүмүүсийн үйл хэргийг удирдан захирдаг хамгийн дээд Нэгэнийг алдаршуулаагүй. Харин бүх Вавилоны алдрыг магтан гайхуулсан. Бурхан түүнийг шийтгэхдээ ухаан санааг нь солиоруулсан. Вавилоны хаан хүмүүсийн дундаас зайлуулагдаж, зэрлэг араатан шиг амьдарсан. Тэрээр үхэр шиг өвс идэж, үс нь бүргэдийн өд мэт сөрвийж, хумс нь шувууны савар мэт ургах хүртэл бие нь тэнгэрийн шүүдэрт норжээ (Дан 4:33).

Ананиа, Сапфир хоёр өмчийнхөө талыг нуусан атлаа, Эзэнд бүхнээ өргөж буй дүр эсгэсэн. (Үйл 5:1-11). Гэвч мөргөл ба үйлчлэлд үнэн сэтгэлээсээ хандахгүй байх нь ямар аюултайг сануулахын тулд Бурхан газар дээр нь хоёулынх нь амийг авсан.

Түүнээс удалгүй Херод хаан Бурханд алдрыг өргөхийн оронд хүмүүсийн хүндлэлийг өөртөө хүлээн авсан. Гэвч тэр өт хорхойд идүүлж үхсэн (Үйл 12:22-23).

Бурхан нам гүм, ямар нэг үйлдэл хийхгүй байгааг харахдаа юу дуртайгаа хийж болно хэмээн нүгэлт хүмүүс эндүүрэх хэрэггүй. Нүгэл хийх бүрд даруй шийтгэл ирэхгүй байлаа гээд хэзээ ч шийтгэл ирэхгүй гэсэн үг биш. Түүхийн тодорхой үед зарим хүнийг шийтгэхдээ гэмшээгүй хүмүүсийг ийм хувь тавилан хүлээж байгаа шүү гэж Бурхан сануулсан юм.

## 10 сарын 17

*"Үнэнийг худалдаж ав үрж үүнийгээ бүү арилж."* (Сур 23:23)

Бурханы үнэнийг олж авахын тулд төлөх ёстой төлөөс гэж бий. Бид ямар ч үнээр хамаагүй Бурханы үнэнийг олж авах ёстой. Хэрэв үнэнийг нэгэнт олж авсан бол юугаар ч битгий арилж.

Энэ эшлэлийг шууд утгаар нь хүлээн авч, Библи болон христэч зохиол бүтээлүүдийг худалдаж аваад, юу ч болсон тэдгээрийг бүү зар хэмээн ойлгож болохгүй. Үнэнийг худалдаж авах гэдэг нь Бурханы зарчмуудыг ойлгож мэдэхийн тулд их золиос гаргахыг хэлж байгаа юм. Гэр бүлийнхэн нь үзэн ядах, ажлаа алдах, шашны холбоо сүлбээгээ таслах, санхүүгийн алдагдал хүлээх, бие махбодын хүчирхийлэлд автах гэх мэт янз бүрийн бэрхшээлийг давах ёстой болно.

Үнэнийг үрж арилжина гэдэг нь буулт хийх, үнэнээс нүүр буруулах гэсэн утгатай. Бид хэзээ ч ингэж болохгүй.

"Гэр чуулган" номдоо Арнот ингэж бичжээ: "Ер нь амьдрал дээр зовлонгүй ирсэн юм зовлонгүй явдаг. Итгэлийн амьдрал ч бай, аливаа бүх асуудалд тэмцэж олсон зүйлээ бид алдахгүйн тулд тэмцдэг. Хялбар аргаар, хөлсөө дуслуулахгүйгээр их хэмжээний эд баялагтай болсон хүн түүнийгээ үрэн таран хийж ядуу зүдүү байдалд насан эцэслэдэг. Хүч хөдөлмөрөө зориулж, зовлогоо зулгаан эд хөрөнгөтэй болсон хүн эд хөрөнгөө үрэн таран хийх нь ховор. Христитгэлийн замаар орохын тулд асар их тэмцлийг туулсан хүн тийм ч амархан итгэлээсээ ухардаггүй. Гал усан дундуур туулаад энэ агуу байр



суурийг олсон бол түүнийгээ зүв зүгээр тавьж явуулахгүй."

Бүх цаг үеийн ариун хүмүүс нарийн хаалгаар орж, давчуу замаар алхахын тулд гэр бүл, алдар нэр, эд хөрөнгөөсөө татгалзсан. Тэд элч Паулын нэгэн адил тэр бүхнийг Эзэн Есүс Христийг мэдэхийн төлөөх гарз хохирол хэмээн тооцсон. Рахабын нэгэн адил хуурамч шүтээнээсээ татгалзаж, Иеховаг цорын ганц үнэн Бурхан гэж хүлээн авахын тулд ард түмнээсээ урвасан. Даниел шиг үнэнийг худалдахаас татгалзахдаа өлсгөлөн арслангийн нүхэнд хаягдах замыг сонгосон.

Эдүгээ бид итгэлийнхээ төлөө амиа ч алдахад бэлэн хүмүүсээр дутагдсан цаг үед амьдарч байна. Хүмүүс үхэхийн оронд итгэл дээрээ буулт хийхийг илүүд үзэж байна. Өнөөдөр эш үзүүлэгчийн дуу хоолой дутагдаж байна. Итгэл гэдэг тоглоомтой адил болжээ. Үнэнийг өмгөөлөн хамгаалагсдыг туйлшрагч, явцуу хэмээдэг. Хүмүүс эв нэгдлийг хадгалахын тулд тулгуур сургаалуудыг золионд гаргаж байна. Тэд үнэнийг зарж арилждаг боловч худалдаж авдаггүй.

Гэхдээ үнэний нууцлагдсан эрдэнэсийг худалдан авахын тулд бүхнээ зарж, нэгэнт авсан бол ямар ч үнээр арилждаггүй хүмүүсийг Бурхан үргэлж үлдээнэ.

## 10 сарын 18

*"Гэрчлэлүүд тань миний бясалгал учир багш нараасаа илүү ухаалаг болов, би. Тушаалуудыг тань сахин биелүүлсэн учраас настангуудаас ч илүү ойлгон ухаарав, би."* (Дуу 119:99,100)

Энэ эшлэлийг анх уншихаар өөртөө эрдсэн хүний үг шиг сонсогддог. Библид ийм бардамналыг бичсэн гэхээр гайхмаар. Христэч хүнд тохиромгүй үгс мэт санагддаг.

Гэхдээ эшлэлийг нарийн лавлан уншвал утга нь тодроод ирнэ. Дуулалын бичээч яаж ухаарал ойлголтыг авснаа бичсэн байна. "Гэрчлэлүүд тань миний бясалгал учир" хэмээн тэр хэлжээ. Өөрөөр хэлбэл, тэрээр Библийг мэддэггүй багш нараасаа илүү ойлгон ухаардаг гэсэн үг. Энэ ертөнцийн мэдлэгийг эзэмшсэн настангуудаас илүү зөв бурууг ялгадаг гэсэн үг. Энэхүү дууллыг бичигч нь өөрийгөө бусад итгэгчтэй бус, ертөнцийн хүмүүстэй харьцуулж ярьжээ.

Мэдээж түүний зөв. Хамгийн дорд итгэгч хүртэл хамгийн боловсролтой үл итгэгчийн харж чадахгүйг хардаг. Доорх хэдэн жишээг бодож үзье. Үүнд:

Төрийн тэргүүн тодорхой алхмуудыг хэрэгжүүлбэл энэ дэлхий дээр энх тайвныг тогтоож чадна гэдэг итгэл найдварыг ард түмэндээ өгөв. Алс нэгэн тосгонд христэч фермер түүний яриаг радиогоор сонсжээ. Энхийн Жонон энэ дэлхий дээр хаанчлалаа байгуулахаас нааш хэзээ ч энх амгалан тогтохгүй гэдгийг тэр итгэгч мэддэг. Христийн хаанчлал ирэхээс нааш хүмүүс илдээ анжисны хошуу болгон давтахгүй, дахиж дайтахад суралцахаа болихгүй. Энэ фермер улс төрчөөс илүү ойлголт ухааралтай байна.

Их сургуульд багшилдаг алдартай эрдэмтэн орчлон ертөнцийн үүсэлд Бурхан ямар ч хамаагүй хэмээн заана. Оюутнуудынх нь дунд саяхан Христэд итгэсэн итгэгч сууж байлаа. Ертөнц Бурханы үгээр хэлбэржээд, харагдах зүйлс нь үл харагдах зүйлсээр бүтээгдсэн гэдгийг энэ оюутан итгэлээр ойлгодог (Евр 11:3). Уг оюутанд эрдэмтэн багшийн олж аваагүй ухаарал ойлголт байна.

Хүний сэтгэлзүйг тайлбарлах гэж оролдовч хүн төрөлхийн нүгэлтэй гэдгийг хүлээн зөвшөөрдөггүй сэтгэл зүйчийг бодож үзье. Бурханы үгийг мэддэг итгэгч нь хүн бүр төрөхдөө ялзарсан мөн чанар, гэм нүглийг өвлөдгийг ойлгодог учраас хүний асуудлыг сэтгэлзүйн ухаанаар шийдэх боломжгүйг мэддэг.

Тэгэхээр дээрх дууллыг бичигч нь бүх багш нараасаа ухаалаг гэж хэлэхдээ бардамнан сайрхсан хэрэг биш ажээ. Итгэлээр алхагсад нь харагдаж буйгаар алхдаг хүмүүсээс илүү сайн хараатай аж. Бурханы гэрчлэлүүдийг бясалгагч нь мэргэн цэцэн хүний хараанаас нуугдсан үнэнүүдийг олж хардаг байна.

## 10 сарын 19

*"Надад хандсан бүх өгөөмөр хишигийнх нь төлөө би ЭЗЭНд юуг буцаах вэ? Би авралын хундагыг өргөж, ЭЗЭНий нэр дээр дуудна."* (Дуу 116:12,13)

Сүнсний авралын асуудалд бид юу ч хийж чадахгүй. Бурханд өгөх, гавьяа байгуулах зүйл бидэнд байхгүй. Аврал нь нигүүлслийн бэлэг учраас Бурханд бид ямар нэг төлбөр төлөх боломжгүй. Бурхан ч бидэнд өргүй.

Мөнх амийг үнэгүй өгсөн Бурханы бэлэгт үзүүлэх хамгийн зөв хариу бол эхлээд авралын хундагыг өргөх. Өөрөөр хэлбэл, авралыг итгэлээр хүлээн авах. Дараа нь Эзэний нэр дээр дуудах. Өөрөөр хэлбэл, үгээр илэрхийлшгүй бэлгийнх нь төлөө Бурханд талархаж, Бурханыг магтах.

Аврагдсаныхаа дараа ч гэсэн, бидэнд хандсан сайн сайхных нь төлөө Эзэнд бид юу ч өгч чадахгүй. "Бүх хорвоо минийх байлаа гээд ч Түүнд өргөхөд дэндүү өчүүхэн." Гэхдээ бидний зүгээс хариуд нь гаргаж болох зохистой хандлага гэж бий. "Энэ гайхамшигт хайр бүх сэтгэл, бүх амьдрал, бүгдийг минь хүсдэг."

Эзэн Есүс бидэнд биеэ өгсөн юм бол бид наанадаж Түүнд биеэ өгч чадна.

Угандагийн Пилкингтон: "Хэрэв Тэр Хаан юм бол бүхнийг минь авах эрхтэй" гэж хэлсэн. Ч. Т. Стадд: "Есүс Христ миний өмнөөс үхсэнийг үнэн голоосоо ухаарах үед Түүний төлөө бүхнээ өргөх нь надад хэцүү санагдахаа больсон" гэж хэлсэн

Йелийн Их Сургуулийн Бордэн: "Эзэн Есүс ээ, бүх амьдралаа би Танд даатгая. Зүрхнийхээ хаан сэнтийд Таныг залъя" хэмээн залбирсан.

Бэтти Скотт Стэм: "Би өөрийгөө, өөрийнхөө амьдралыг, бүхнээ Танд өргөө. Энэ бүхэн үүрд Таных" гэж залбирсан.

Чарльз Хэддон Спержон: "Би Эзэнд бууж өгсөн тэр өдөр бие, сэтгэл, сүнсээ Түүнд өгсөн. Өөрт байгаа бүхнээ, одоо хийгээд өнө мөнхөд надад олдох бүхнийг Түүнд өгсөн. Бүх авьяас чадвар, хүч чадал, мэдлэг ухаанаа, нүдээ, гар хөлөө, сэтгэлийн хөдөлгөөнөө, үзэл бодлоо, надаас гарч болох бүхнийгээ өгсөн" гэж хэлсэн.

*Хэмжээлиггүй тэр хайранд төлөх өр минь  
Хэдэн нулимсаар яахин барагдах билээ!  
Өөрийгөө л Тандаа өргөө, хайрт Эзэн минь  
Өөр би юу хийж чадах билээ!*

(Исаак Уоттс)

Хөл гараа хадуулж, биедээ шарх олж, зовж шаналж, нулимс цусаа урсгасан Христийн зовлонд биднээс гарах цорын ганц зохистой хандлага бол амьдралаа Түүнд тахил болгон өргөх явдал юм.

## 10 сарын 20

*"Давид 'Хэн нэг нь хаалганы хажуу дахь Бетлехемийн худгаас надад ус авчран өгдөг ч болоосой!' гэж ихэд хүсэмжлэв."* (1Шс 11:17)

Бетлехем нь Давидын төрөлх хот. Давид, Бетлехемийн гудамж, талбай, зам, дүүрэг, зах, хүн ард гээд бүгдийг сайн мэднэ. Одоо харин филистчүүд Бетлехемийг эзэлж аваад Давид Адулламын агуйд хорогджээ. Давид, Бетлехемд байдаг худгийн уснаас уух юмсан гэж санаашрахад гурван туслах нь дайсны бэхлэлтийг сэтгэлж ороод Давидад ус авчирч өгөв. Энэ их хайр, үнэнч зангийн илэрхийлэл болсон зоригт үйлдлийг хараад Давидын сэтгэл хөдөлж, усыг нь ууж чадаагүй. Түүний оронд Эзэнд өргөл болгон газар асгасан.

Энэ хэсэгт Давидыг Эзэний бэлгэдэл болгон харж болно. Бетлехем нь Давидын газар байсны адил бүх дэлхий нь Эзэнийх билээ. Давид хаан сэнтийд заларч байх учиртай атал агуйд байна. Үүн шиг бидний Эзэн энэ ертөнцийн хүмүүсээр хаан сэнтийд залуулж суух ёстой байтал гологдож жигшигдсэн. Давид ус уухыг хүсэмжилсний адил Эзэн маань энэ дэлхийгээс хүмүүсийн сүнсийг аврахаар цангаж байна. Бүтээлүүд нь нүглээсээ, махан биеийн хүслээсээ, энэ ертөнцөөс аврагдахыг харж цангаагаа тайлахыг Тэр хүсдэг. Давидын гурван зоригт эр бол их жанжныгаа хүслийг биелүүлэхийн тулд тав тух, аюулгүй байдал, амь насаа дэнчин тавьж дайсны бэхлэлт рүү орсон Христийн цэргүүдийг харуулж байна. Тэд бүх ертөнцөд сайнмэдээг хүргэж, аварсан хүмүүсээ хайр ба үнэнч зангийн тахил болгон Эзэнд авчирдаг. Давидын

сэтгэл хөдлөл нь бүх үндэстэн угсаатнаас Өөрийг нь тойрон цуглаж буй хонин сүргээ харан сэтгэл баясдаг Эзэний сэтгэл хөдлөлийн зураг юм.

Давид ус авчирч өг гэж тушаагаагүй. Юу хүсэж байгаагаа л санаашран хэлсэн. Харин үнэнч туслахууд нь түүний хүслийг тушаал мэт хүлээн авсан.

Тэгвэл Эзэн Есүс үнэт цусаараа худалдаж авсан хүмүүсээсээ юу хүсэж байгааг мэдсэн бол бид юу хийх хэрэгтэй вэ? Бид Бурханд биеэ өргөж, сайнмэдээний төлөө явахгүй гэж үү? “Хэнийг би илгээх бэ? Хэн бидний төлөө явах вэ?” гэж асууж байгааг нь сонсох хангалтгүй гэж үү? Давидын эрчүүд Давидын төлөө амиа хайрлалгүй хийж чадсаныг бид агуу Эзэнийхээ төлөө хийхгүй гэж үү? Таны хүсэл миний даалгавар гэж Түүнд бид хэлэхгүй гэж үү?

## 10 сарын 21

*"Хавчиг хаалгаар ор. Учир нь сүйрэлд хөтөлдөг хаалга нь уужуу, зам нь өргөн юм. Олонх нь түүгээр тийш ордог. Амь өөд хөтөлдөг хаалга нь хавчиг, зам нь нарийн юм. Цөөнх нь түүнийг олдог."* (Мт 7:13,14)

Хүн төрөлхтний шашин шүтлэгийг харвал тоо томшгүй олон урсгал чиглэл, бүлэглэл харагдана. Харин өнөөдрийн эшлэл ердөө хоёр шашин байдгийг хэлж байна. Нэг нь өргөн хаалга, сүйрэлд хүргэдэг дардан зам. Нөгөө нь нарийн хаалга, аминд хүргэдэг бартаат зам. Хэчнээн олон шашин байвч ийм л хоёр ангилалд багтана. Энэ хоёрын гол ялгаа гэвэл, нэг нь авралыг гавьяа зүтгэлээр олно хэмээн хүнд ухуулдаг. Нөгөө нь Бурхан хүний төлөө авралыг бэлдсэн гэж хэлдэг.

Жинхэнэ христитгэл нь итгэлээр мөнх амийг бэлэг болгон хүлээж ав хэмээн дууддаг. Үүгээрээ цор ганц. Бусад шашин авралыг үйлсээр, буянаар, зан чанараар олж явах ёстой гэж сургадаг. Сайнмэдээнд бидний авралд шаардлагатай ажлыг Христ хэрхэн гүйцээснийг тунхагладаг. Бусад шашин хүн өөрийгөө аврахын тулд юу хийх ёстойг номлодог. Нэг нь хийчихсэн гэж хэлдэг бол нөгөө нь хийх ёстой гэж хэлдгээрээ энэ хоёр шашин ялгаатай.

Сайн хүн диваажинд очиж, муу хүн тамд хаягдана гэх түгээмэл үзэл бий. Тэгвэл Библид тунхагласнаар энэ дэлхий дээр нэг ч сайн хүн байхгүй бөгөөд Бурханы нигүүлслээр аврагдсан нүгэлтнүүд л диваажинд очиж чадна. Христийн сайнмэдээ хүний бардамналыг үгүй хийдэг. Хүн нүгэл хилэнц дотроо үхмэл учраас Бурханы



нигүүлслийг олж авахын тулд ямар ч гавьяа байгуулж чадахгүй хэмээн сайнмэдээ тунхагладаг. Бусад шашин бүгдээрээ хүний бардамналыг тэжээдэг. Хүн өөрийгөө аврахын тулд ямар нэг юм хийж чадна эсвэл өөрийгөө аврахын тулд ямар нэгэн хувь нэмэр оруулж чадна гэж бусад шашин номлодог.

Бүх хуурамч шашин нь хүнд зөв мэт харагдавч эцэст нь үхэлд хүргэнэ (Сур 14:12). Эзэн Есүс Христэд итгэж аврагдах нь хүмүүст “дэндүү хялбар зам” шиг санагдах боловч энэ нь аминд хүргэдэг цорын ганц зам юм. Хуурамч шашнуудад Христ хэн ч биш юу ч биш, эсвэл зүгээр л ямар нэг юм. Жинхэнэ христитгэлд Христ бүх зүйл.

Бусад шашинд авралын жинхэнэ баталгаа гэж байхгүй. Яагаад гэвэл хүн хангалттай сайныг эсвэл зөвийг хийснээ баттай мэдэх боломжгүй. Христэд итгэгч хүн аврагдсанаа баттай мэдэх боломжтой. Яагаад гэвэл энэ нь тухайн хүний сайн, муу байхтай ямар ч хамаагүй. Харин Христийн хийж өгсөн ажлаас бүрэн хамааралтай.

Үнэндээ энэ дэлхий дээр хоёр л шашин байна. Нэг нь хууль, нөгөө нь нигүүлсэл. Нэг нь үйлс, нөгөө нь итгэл. Нэг нь үйлдэх, нөгөө нь итгэх. Нэг нь хичээх, нөгөө нь найдах. Эхнийх нь ял ба үхэлд хөтөлнө. Хоёр дахь нь зөвтгөл ба аминд хүргэнэ.

## 10 сарын 22

*"Нуны хүү Иошуа дээр Мосе гар тавин томилсон учраас тэр мэргэн ухааны сүнсээр дүүрэн болжээ. Израилийн хөвгүүд ЭЗЭНээс Мосед тушаасан ёсоор Иошуагийн үгийг даган гүйцэлдүүлжээ." (Дх 34:9)*

Өөрийнх нь үйлчлэл дуусаж буйг мэдсэн Мосе, Иошуаг өөрийн дараагийн хүнээр томилсон. Энэ үйлдлээрээ тэр сүнслэг удирдлагын байр сууринд байдаг хүмүүст сайн жишээг үзүүлэв. Зарим нь үүнийг мэдээжийн ойлгомжтой зүйл шүү дээ хэмээн хэлэх байх. Гэвч бодит байдлыг харвал дараагийн хүнээ бэлдэж, түүнд ажлаа хүлээлгэж өгөхөд хүмүүс тун хойрго ханддаг. Хэн нэгэн хүн биднийг орлоно гэдэг санааг хүлээж авах чадвартай хүн тун ховор.

Зарим чуулганы пасторт ийм асуудал тулгардаг. Тэрээр олон жил итгэмжтэй үйлчилсэн боловч сүргийг хоньчлох өдрүүд дуусаж, өөр хүнд халаагаа өгөх цаг ойртож байлаа. Гэвч залуу хүнийг бэлдэж, өөрийн байр суурийг өгнө гэхээр хүнд байв. Магадгүй залуусыг байр сууринд нь халтай гэж үзсэн байх. Эсвэл туршлагагүй, өөр шиг нь төлөвшөөгүй, тохирохгүй гэж бодсон байх. Нэгэн цагт өөрөө хэчнээн туршлагагүй байснаа, харгалзагчийн үйлчлэлд бэлтгэгдэхдээ ямар замаар яваад өнөөдрийн төлөвшилд хүрснээ мартаж амархан.

Заримдаа илгээлтийн эзэнд ийм асуудал тулгардаг. Илгээлтийн эзэн тухайн нутаг орны хүнийг бэлдэж, удирдагч болгох ёстойгоо мэдэх боловч өөр шиг нь хийж чадна гэдэгт итгэж чаддаггүй. Шинэ хүн олон алдаа гаргана. Номлолыг сайн хийхгүй болохоор чуулганы ирц ч

буурна. Ямартай ч уг илгээлтийн эзэн яаж шинэ удирдагчийг дагуулахаа мэддэггүй. Энэ бүхнийг шийдэх гарц нь тухайн удирдагч өөрийгөө хязгаартайг хүлээн зөвшөөрөх явдал. Тухайн талбарт ажил нь дуусах хүртэл нутгийн хүнийг бэлтгэж, түүнийг удирдагчаар томилох хэрэгтэй. Өөр олон газар ажиллах хэрэгцээ бий. Нэг үйлчлэл дууслаа гээд бүх үйлчлэл дуусна гэсэн үг биш.

Иошуа, Мосегийн халааг авах үед шилжилт тайван замаар хийгдсэн. Удирдлагын байр суурь хоосон үлдээгүй. Бурханы ажил тасалдаагүй. Ийм ч байх ёстой юм.

Залуу хүмүүс өсөж өндийж, удирдлагын байр сууринд гарч ирэхэд Бурханы зарц нар бүгдээрээ баярлах хэрэгтэй. Ахмадууд нь тэдэндээ мэдлэг туршлагаа харамгүй хуваалцаж, үхэл ирэхэд хүчээр ажлаа өгөхийг хүлээлгүй, баяртайгаар халаагаа тавьж өгөхийг аз завшаан гэж үзэх ёстой. “Эзэний ард түмэн бүгдээрээ Бурханы эш үзүүлэгч болоосой” гэж Мосе нэгэн үйл явдал дээр хэлж байсан шиг, тийм хувиа үл хичээсэн хандлага бидэнд байх ёстой.

## 10 сарын 23

*"Тэр (Ариун Сүнс) Өөрөөсөө биш харин алив сонсох юмаа ярина. Ирэх зүйлийг Тэр та нарт мэдүүлнэ. Тэр Минийхийг авч та нарт мэдүүлэх учир Намайг алдаршуулна."* (Иох 16:13,14)

Эзэн Есүс Ариун Сүнсийг Өөрөөсөө ярихгүй гэж хэлэхдээ Ариун Сүнс Өөрийнхөө тухай огт ярихгүй гэсэн санааг агуулаагүй. Өөрийнхөө эрх мэдлээр, Өөрийн дураараа ярихгүй, харин Бурхан Эцэгийн хүслийн дагуу ярина гэсэн утгатай. Тийм учраас “алив сонсох юмаа ярина” гэж бичигджээ. Шинэ Америк Стандарт Библид үүнийг “Тэр Өөрийн санаагаар ярихгүй” гэж орчуулсан байна.

Гэхдээ тэглээ гээд Ариун Сүнс Өөрийнхөө тухай ярьдаг гэсэн үг биш. Түүний гол зорилго нь Христийг алдаршуулах. Есүс “Тэр Минийхийг авч та нарт мэдүүлэх учир Намайг алдаршуулна” гэж хэлснийг анзаараарай.

Нэг ёсондоо алив үйлчлэл Эзэн Есүсийг алдаршуулж байвал тэнд Ариун Сүнсний удирдамж байгаа гэдэгт итгэлтэй байж болно. Эсрэгээрээ, Эзэнийг бус, номлогчийг алдаршуулж байвал Ариун Сүнс гашуудаж байгаа гэдэгт итгэж болно. Ариун Сүнс Есүсийн аугааг болон номлогчийн мундгийг нэгэн зэрэг алдаршуулдаггүй.

“Хамгийн сүнслэг сургаал Христийг бүрэн дүүрнээр, байнга танилцуулж байгаагаар тодорхойлогдоно. Ариун Сүнс тийм номлолд хүч оруулдаг. Есүсийг номлоход Ариун Сүнс хамт байна. Есүсийг номлоход Ариун Сүнс баярлана. Есүсийн эрхэмсэг сайхан чанаруудыг ярих нь Ариун Сүнсэнд тааламжтай. Тэгэхээр Бурханы Сүнсний хүчээр үйлчилж байгаа хүн юу юунаас илүү Христ дээр

төвлөрдөг. Тийм үйлчлэл хүний мэргэн ухаан, цэцэрхэл багтах орон зай үгүй. Ариун Сүнсний цорын ганц зорилго Христийг алдаршуулах билээ.” (Ч. Х. Макинтош)

Иймээс эвангелийн ертөнц номлогчдын эрдмийн зэрэг, теологийн мэдлэг, цол гуншныг өндрөөр үнэлэн танилцуулдаг явдлаа дахин нэг бодож үзэх хэрэгтэй. Хүнийг тэнгэрт тултал магтаад дараа нь Ариун Сүнсний хүчээр номлоно гэдэг бодит байдалд үл нийцнэ.

Христэч ном зохиол Эзэн Есүсийг алдаршуулж байгаа эсэхийг шалгах нэг арга бий. Нэг удаа би Ариун Сүнсний тухай ном уншлаа. Тэнд Ариун Сүнсний гэхээсээ Христийн талаар илүү олон зүйл бичсэнд их гайхсан юм. Гэхдээ Ариун Сүнснийг зөвөөр танилцуулах цорын ганц арга нь энэ гэдгийг би ойлгосон.

“Сүнсээр дүүрэн хүн Сүнсний тухай ном бичихгүй. Харин тэр Сүнсний илчилдэг Нэгэний тухай бичнэ. Бурханы зорилго Христийг алдаршуулах болохоос Ариун Сүнсний дүүргэлт биш” гэж Жим Эллиот нэгэн сэтгүүлд бичжээ.

## 10 сарын 24

*“Мөн амийн номд нэр нь бичигдсэн нь олдоогүй бүхэн галт нуурт хаягдав.” (Илч 20:15)*

Тамын тухай яриа хүмүүний зүрхэнд асар их эсэргүүцлийг төрүүлдэг. Тэд энэхүү эсэргүүцлээ илэрхийлэхдээ ихэвчлэн “Бурхан хайр юм бол мөнхийн тамыг юу гэж бий болгох юм бэ?” хэмээн асуудаг. Паул энэ асуултад хариулсан бол “Бурханы өөдөөс хариу хэлдэг чи хэн бэ? Бүгд худалч байсан ч Бурхан үнэн байг” хэмээн хэлнэ. Үүнийг бидний ойлгох хэлээр орчуулбал: “Бүтээл нь Бүтээгчээ байцаах эрхгүй. Бурхан мөнхийн тамыг бий болгосон бол ямар нэг шалтгаан байж л таараа. Бид Бурханы хайр ба шударга ёсыг байцаах эрхгүй.” Гэхдээ энэ тал дээр Бурханыг зөвтгөх хангалттай мэдээлэл Библид бичигдсэн.

Бурхан тамыг хүнд биш диавол болон түүний тэнгэрэлч нарт зориулан бүтээсэн (Мт 25:41).

Бурхан хэн нэгнийг мөхөөсэй гэж хүсдэггүй. Харин бүгдийг гэмшилд ирээсэй гэж хүсдэг (2Пт 3:9). Хэн нэгэн тамд унавал Эзэний асар их шаналдаг.

Асуудал болоод байгаа нь хүний нүгэл юм. Бурханы ариун чанар, зөвт байдал, шударга ёс нүглийг шийтгэхийг шаарддаг. “Нүглийг үйлдэгч амь үхэх болно” (Езк 18:4) хэмээн Бурхан тунхагласан. Бурханы зүгээс үүнд хийж чадах юм байхгүй. Энэ нь ариун Нэгэний нүглийн эсрэг үзүүлэх хандлага юм.

Бурхан нөхцөл байдлыг энэ чигт нь орхиж болох л байсан. Хүн нүгэл үйлдсэн учраас үхэх нь ч зүй ёсны асуудал юм.

Гэтэл Бурханы хайр орж ирсэн байна. Тэрээр хүнийг мөнхөд мөхүүлэхийг эс хүсэхдээ авралын замыг бэлдэхийн тулд хамгийн гүн ёроол хүртэл явсан. Тэрээр ганц Хүүгээ илгээж нүгэлт хүмүүсийн оронд үхүүлж, нүглийнх нь шийтгэлийг төлсөн. Хүний нүглийг Аврагч Эзэн маань биедээ үүрч загалмайд хадагдсан нь юутай гайхалтай нигүүлсэл вэ!

Эдүгээ Бурхан, нүглээ гэмшиж, Эзэн Есүс Христэд итгэсэн хүн бүрд мөнх амийг үнэгүй бэлэглэж байна. Бурхан хүнийг хүслийнх нь эсрэг хүчээр аврахгүй. Хүн өөрөө амьдралын замаа сонгоно.

Бурханы зүгээс үүнээс илүү юу хийх байсан юм бэ? Тэрээр төсөөлөхөөс ч агууг хийсэн. Хүн Бурханы нигүүлслийн үнэгүй бэлгийг авахаас татгалзвал өөр зам байхгүй. Тэр өөрөө диваажинд орохоос татгалзаж сайн дураараа тамыг сонгож байгаа юм.

Мөнх тамыг бүтээсэн гэж Бурханыг буруутгах нь ямар ч үндэслэлгүй. Ийн буруутгагсад нь энэ дэлхийн хамгийн өөдгүй хүн байсан ч галт тамын тарчлалыг бүү үзээсэй гэсэндээ тэнгэрийн хамгийн дээд Нэгэн дэлхийд ирснийг үл хэрэгсэж байгаа юм.

## 10 сарын 25

*"Ах дүүгээс чинь ч дотно байж чадах анд нөхөр бий шүү."*  
(Сур 18:24 АБ2004)

Есүсийн нөхөрлөл хүмүүсийн сэтгэл зүрхэнд дулаан мэдрэмж төрүүлдэг. Түүнийг энэ дэлхий дээр байхад "татвар хураагчид ба нүгэлтнүүдийн анд" (Мт 11:19) гэж цоллосон. Харин итгэгчид үүнийг хүндэтгэлийн нэр болгон ашигладаг.

Эзэн маань загалмай руу явахынхаа өмнө шавь нараа "анд нөхөд" гэж дуудсан. "Та нар тушаасныг минь үйлдвээс Миний нөхөд мөн. Би та нарыг боолууд гэж дахиж дуудахгүй. Учир нь эзнийхээ юу хийж байгааг боол эс мэдэх юм. Харин Би та нарыг анд нөхөд гэж дуудав. Учир нь Би Эцэгээсээ сонссон бүхнээ та нарт мэдүүлсэн билээ" (Иох 15:14,15).

Бидний дуртай магтан дуунуудад мөн энэ сэдэв түгээмэл. Жишээ болгон хэдэн мөртүүд эш татъя: "Есүс Эзэн Та миний хувьд юутай үнэнч анд билээ!"; "Даруу Есүсийн адил анд нөхөр гэж үгүй"; "Би найзыг оллоо үнэхээр сайн найзыг оллоо".

Есүсийн нөхөрлөл яагаад ийм чухал байдаг вэ? Миний бодлоор ихэнх хүн ганцаардаж байдаг. Тэднийг олон хүн хүрээлэвч найз нөхөд байдаггүй. Олон хүн бусдад үл анзаарагдан амьдардаг. Ялангуяа залуу халуун нас нь дууссан настай хүмүүс ихээхэн ганцаарддаг.

Ганцаардал гэдэг маш хэцүү. Энэ нь хүний бие махбод, оюун санаа, сэтгэлзүйн эрүүл мэндэд хор хөнөөлтэй. Ганцаардсан хүн сэтгэлээ барж, амьдралаас залхдаг. Ганцаардсан хүн нүгэлд буулт хийж мунхаг үйлдэл хийхэд



бэлэн болдог. Ийм хүмүүст Есүсийн нөхөрлөл зүрхийг нь эдгээх эдгэрэл билээ.

Есүсийн нөхөрлөлийг үнэ цэнтэй болгодог дараагийн нэг шалтгаан бол Есүс хэзээ ч анд нөхдөөсөө урвадаггүй явдал юм. Хүмүүн найзууд урмыг минь хугалж, заримдаа амьдралаас минь яваад өгөх нь бий. Харин Есүс хэзээд нэг байрандаа байдаг үнэнч Нөхөр юм.

Дэлхийн найзууд биднээс урваж, биднийг орхиж болно.Заримдаа тэд сайхан. Харин заримдаа биднийг гомдооно. Харин Есүс биднийг хэзээ ч хуурахгүй Найз. Тэр бидэнд үнэхээр хайртай. Есүс бол ах дүүсээс минь ч дотно Найз билээ. Есүс биднийг үргэлж хайрладаг Найз (Сур 17:17).

Эзэн Есүс одоо биеэрээ бидэнтэй хамт байдаггүй гээд Түүнтэй нөхөрлөх боломжгүй гэсэн үг биш. Тэр бидэнд Библиэр дамжуулж ярьдаг. Бид Түүнтэй залбирлаар дамжуулан ярьдаг. Ингэж Тэр, бидэнд хэрэгтэй анд нөхөр гэдгээ бодитоор мэдрүүлдэг. Энэ замаар Тэр залбиралд минь хариулдаг.

Эзэн Есүс ээ, Өөрийгөө Та надад бодитоор мэдрүүлээч. Энэ дэлхийн нүдэнд харагдах материаллаг зүйлээс илүү итгэлийн минь нүдэнд харуулж өгөөч. Энэ дэлхийн хамгийн дотно харилцаанаас илүү надтай дотно байгаач.

## 10 сарын 26

*"Хайртууд аа, сэтгэлийн чинь эсрэг дайтдаг махбодын хүсэл тачаалуудыг цээрлэхийг ирмэл агаад түр суурьшигч та нараас би гуйя."* (1Пт 2:11)

Петр өөрийн уншигчдыг ирмэл харийн хүн ба түр оршин суугч хэмээн сануулсан нь өнөөдрийнх нь хэрэгцээнээс илүү зүйл тэдэнд хэрэггүй гэдгийг хэлэх гэсэн санаа юм. Түр оршин суугч гэдэг нь нэг улсаас нөгөө рүү аялж яваа хүмүүс. Дамжин өнгөрч байгаа улс нь тэдний эх орон биш. Тэд тэнд ирмэл цагаач, харийн хүмүүс. Тэд эх нутгаа зорин аялж байгаа юм.

Түр оршин суугчид майханд амьдардаг. Гийм учраас Абрахам нь Исаак, Иаков нарын хамт майханд амьдарч байсан гэж бичигджээ. Канаан нутгийг Бурхан өгнө хэмээн амласан хэдий ч тухайн үедээ Абрахам Канаанд харь хүн гэдгээ ойлгож байсан. "Абрахам суурь бүхий хотыг хүлээж байсан юм. Түүнийг бүтээгч ба барилгачин нь Бурхан мөн" (Евр 11:10). Гийм учраас тэр түр зуурын сууцыг ашигласан. Түр оршин суугч нь аянчин учраас суурин суурьшдаггүй.

Тэрээр аялж яваа болохоор аль болох цөөн юм авч явдаг. Дэндүү олон материаллаг зүйл цуглуулж аяллаа хүндрүүлдэггүй. Хэрэгтэй хэрэггүй олон юм ачаандаа авч явбал аян замд нь саад болно. Нүүж суухад амрыг нь бодож аль болох цөөн юмтай явна.

Түр оршин суугчийн өөр нэг онцлог гэвэл, тэрээр тухайн газрын хүмүүсээс ялгаатай байна. Нутгийн хүмүүсийн амьдралын хэв маяг, дадал хэвшил, мөргөлийн зан үйл түүнд таарахгүй. Христэч түр оршин суугч бол сэтгэлийнх нь эсрэг дайтдаг махбодын хүсэл тачаалаас

цээрлэ гэсэн Петрийн үгэнд анхаарлаа хандуулах ёстой. Христэч хүн хүрээлэн байгаа нөхцөл байдалдаа уусан адилсаж болохгүй. Христитгэгч ертөнцөд байгаа ч ертөнцийнх биш. Тэрээр энэхүү харийн нутгийг дамжин өнгөрч байгаа болохоор нутгийнхны үнэлэмж, үнэ цэн, ёс заншлыг нь дагахгүй.

Түр оршин суугч бидний дамжин өнгөрч байгаа нутаг дэвсгэр дайсны нутаг юм. Тиймээс дайсантайгаа анд нөхөр болохоос сэрэмжлэх хэрэгтэй. Дайсантайгаа хамсаатан болбол удирдагчдаа үнэнч бус хандсанд тооцогдоно. Удирдагчийнхаа үйл хэргээс урвагч болно.

Христитгэгч түр оршин суугч өстөн дайсныхаа газар нутгийг дайран өнгөрч байгаа. Энэ ертөнц манай Удирдагчид загалмай ба булшаар хариу барьсан. Ийм ертөнцтэй найзална гэдэг Эзэн Есүсээс урвасантай адил. Христийн загалмай энэ ертөнцтэй холбоотой бүх холбоог минь тасалсан. Бид энэ ертөнцийн магтаалд шунах юм уу буруутгалаас нь айж болохгүй.

Түр оршин суугч нь өдөр бүр алхам алхмаар нутагтаа дөхөж байгаагаа мэндэн шантралгүй урагшилдаг. Зорьсон газраа хүрэх л юм бол туулсан бүх бэрхшээл зовлон нь даруй мартагдана гэдгийг тэр мэднэ.

## 10 сарын 27

*"Иудей ч, грек ч гэж байхгүй, боол ч, чөлөөт хүн ч гэж байхгүй, эр ч, эм ч гэж байхгүй. Учир нь та нар бүгд Христ Есүс дотор нэг болой."* (Гал 3:28)

Энэ эшлэлийг уншихдаа ямар утга илэрхийлж байгааг болон ямар утга илэрхийлэхгүй байгааг мэдэх нь хамгийн чухал. Эс бөгөөс буруу үзэл бодолтой болж, Библийг гуйвуулж, амьдралын буруу ойлголттой болно.

Энэ эшлэлийг ойлгох түлхүүр үг нь “Христ Есүсийн дотор”. Энэ үгс бидний байр суурийг илэрхийлдэг. Өөрөөр хэлбэл, Бурханы нүдэнд хэн болсныг минь илтгэнэ. Харин өдөр тутмын амьдралын минь тухай энд яриагүй. Өөрөөр хэлбэл, нийгэмд эзлэх байр суурь, бидний өөрсдийн маань мөн чанарын тухай хэлээгүй.

Тэгэхээр Бурханы өмнө бол иудей ч гэж үгүй, грек ч гэж үгүй. Итгэсэн иудей хүн, итгэсэн харь үндэстэн хоёулаа Христ Есүсийн дотор байгаа учраас Бурханы өмнө тааллыг хүртэн зогсдог. Нэг нь нөгөөгөөсөө илүү биш. Энд бие махбодын ялгаа, зан чанарын зөрүүг байхгүй болгосон гэж хэлээгүй.

Христ Есүсийн дотор боол ч гэж үгүй, чөлөөт ч гэж байхгүй. Юу гэсэн үг вэ гэвэл, Христийн хийсэн ажил, Есүс хэн бэ гэдгээр дамжуулан боол, чөлөөт ялгаагүй Бурханы өмнө ижил байр суурийг олж авсан юм. Харин өдөр тутмын амьдралд нийгмийн ялгаа хэвээрээ байна.

Христ Есүсийн дотор эр ч, эм ч гэж байхгүй. Өөрөөр хэлбэл эмэгтэй хүн Христийн дотор эрэгтэй хүний нэг адил бүрэн төгс болж, үнэгүй зөвтгөгдөж, Бурханд хүлээн

авагдсан. Эмэгтэй хүн эрэгтэй хүний адил Бурханы оршихуйд орох эрх чөлөөг авсан.

Гэхдээ энэ эшлэлийг өдөр тутмын амьдралд нааж тайлбарлаж болохгүй. Хүйсийн ялгаа хэвээрээ байгаа: эр, эм. Хүйсийн үүргийн ялгаа ч хэвээрээ байгаа: аав, ээж. Бурхан эр хүнийг өрхийн тэргүүн болгож, эмэгтэй хүнийг тэрхүү эрх мэдэлд захирагдаж байхаар хүйсийн үүргийг хуваарилсан. Шинэ гэрээнд хүртэл эрэгтэй эмэгтэй хүмүүсийн чуулганд үйлчлэх үйлчлэл ялгаатайг хэлдэг (1Тм 2:8, 2:12; 1Ко 14:34,35). Чуулганд эр ч, эм ч үгүй гэж маргадаг хүмүүс Библийн энэ хэсгийг мушгин гуйвуулж, элч Паулын цаад санааг алдагдуулж, цаашлаад энэ үгсийг Бурханы амьсгалаар бичигдсэн эсэхэд эргэлзээ үүсгэнэ.

Би юу хэлэх гээд байна вэ гэвэл, үндэс угсаа, нийгмийн зэрэг зиндаа, хүйсийн ялгаа Бурханы өмнө л арилсан юм. Харин энэ амьдралд маань арилаагүй. Тэглээ гээд энэ ялгаа нь хэн нэгнийг нь дорд гэсэн утгатай биш. Харь үндэстэн нь иудей хүнээс, боол нь чөлөөт хүнээс, эмэгтэй хүн эрэгтэй хүнээс дорд гэсэн үг биш. Харин ч олон талаараа илүү байж магад. Гол нь, авралын хувьд бүгд Бурханы хувьд адил боловч Бурханы бүтээлийн дэс дараа, эрэмбэ хэвээрээ. Үүнийг хооронд нь хольж хутгалгүй байгаагаар нь хүлээн авч, тэдгээрт талархацгаая.

## 10 сарын 28

*"Харамгүйгээр тараах хүн арвижих. Хэт гамнах хэрнээ ядуу тарчиг болох."* (Сур 11:24)

Ариун Сүнс бидэнд нэгэн нууцыг дэлгэж байна. Энэ нь бидний боддогийн яг эсрэг ажээ. Нууц юу вэ гэвэл, та өгөх тусмаа илүүг олно. Харамлах тусмаа ихийг алдана. Өгөөмөр зан үржүүлдэг. Хармын сэтгэл хорогдуулдаг. "Өгсөн зүйл минь эргээд надад ирсэн. Зарцуулсан зүйл минь надад үлдсэн. Хадгалсан зүйлээ би алдсан."

Гэхдээ итгэмжит нярав санхүүгийн хувьд баян чинээлэг болно гэсэн үг биш. Мөнгө таривал эргээд мөнгө хураана гэсэн үг ч биш. Доллар тариад хүний сүнсийг хурааж авах. Сайхан сэтгэл тариад найз нөхдийг хурааж авах. Энэрлийг тариад хайрыг хурааж авах.

Өгөөмөр хүн бусдын мэдэж чадахгүй тийм шагналыг хурааж авдаг. Нэг хүн цахим шуудангаа нээж үзтэл явуулсан мөнгө нь хэрэгтэй цагт, хэрэгтэй хэмжээгээр, чухал шаардлагатай үед ирсэн гэдгийг мэдэх хэчнээн сайхан. Шинэхэн итгэгчид зориулан авч өгсөн ном нь Бурханаар ашиглагдаад уг залуугийн амьдралыг өөрчилснийг харах ямар их жаргал вэ! Эзэн Есүсийн нэрээр сайхан сэтгэл гаргатал тэр нь хүний авралын хөшүүрэг болсныг мэдвэл үгээр хэлэхийн аргагүй баяр хөөр төрнө. Энэ баяр хөөрөө тэр юугаар ч солихыг хүсэхгүй.

Үнэний нөгөө тал гэвэл, эд хөрөнгө цуглуулах нь ядууралд хөтөлнө. Банканд байгаа мөнгө бидний сэтгэлийг үнэндээ дүүргэдэггүй. Энэ нь амьдралын баталгааны хуурамч мэдрэмжээр биднийг төөрөгдүүлэх боловч

үнэндээ жинхэнэ баяр хөөрийг өгдөггүй. Мөнгийг Христийн алдрын төлөө болон хүмүүсийн сайн сайханд зарцуулагдаж байхыг харах нь мөнгөөр олж авч болох ямар ч зүйлээс илүү. Хэрэгцээнээсээ илүүг цуглуулдаг хүн банкны дансандаа их мөнгөтэй байж болох ч амьдралын дансандаа өчүүхэн баяр хөөртэй, тэнгэрийн дансанд багахан шагналтай байдаг.

Өнөөдрийн эшлэл бидэнд тэнгэрийн зарчмыг ойлгуулаад зогсохгүй тэнгэрийн уриалгыг хүргэж байна. Энэ үгээр дамжуулан Эзэн ингэж хэлж байна: “Өөрт байгаа хэдэн зүсэм талх, загаснуудаа надад өг. Өдрийн хоолондоо хэрэглэх гэж байсныг чинь би мэдэж байна. Гэхдээ чи тэднийг надад өгвөл чи өөрөө цадтал хооллоод зогсохгүй өөр олон мянган хүн хооллоно. Хооллож байхад чинь хүмүүс чамайг тойроод хараад суувал чамд эвгүй биш үү? Харин өдрийн хоолыг чинь ашиглаад Би түмэн олныг хоолловол чиний сэтгэл ч дүүрнэ шүү дээ!”

*Харамлаж хурааснаа бид алддаг.*

*Харин бүгдийг ивээж өгсөн*

*Христ Эзэн танд зээлүүлбэл*

*Хэмжээ хязгааргүй эрдэнэтэй болдог*

(Чарльз Вөрдворт)

## 10 сарын 29

*"Дэлхийн эд хөрөнгөтэй нь ах дүүгийнхээ гачигдлыг хараад түүнд туслах сэтгэл үл гаргавал, түүний дотор Бурханы хайр хэрхэн байх билээ?" (1Ио 3:17)*

Хорт хавдрыг эмчлэх эмчилгээг мэдсэн атлаа дэлхий даяар байгаа хорт хавдрын өвчтөнүүдэд түгээхгүй бол хүнлэг бус хэрэг болно.

Элч Иохан сүнслэг асуудалд үүнтэй ижил зүйлийг ярьжээ. Өөрийгөө итгэгч гэх атлаа өчнөөн эд хөрөнгөтэй, тансаглал, тав тух, амар амгаланд амьдардаг хүн байлаа гэж бодъё. Түүний эргэн тойронд нь бие махбодын болон сүнслэг хэрэгцээтэй хүмүүс дүүрэн байдаг. Дэлхий даяар сайнмэдээг сонсоогүй сая сая хүн амьдарч байна. Тэд балар харанхуйн дунд, мухар сүсэг, итгэл найдваргүйн дунд амьдардаг. Өлсгөлөн, ган гачиг, дайн, байгалийн гамшгаас болж зовлонд унасан үй олон хүн байна. Баян эр энэ бүх хэрэгцээг харж л байгаа. Тэгсэн атлаа хүний энэлэл шаналал, өвдөлт зовлонд гараа сунгахгүй байна гэдэг юу гэсэн үг вэ? Хүсэх л юм бол туслах боломжтой атал мөнгөө хав дараад сууна гэдэг юу гэсэн үг вэ?

Иохан энд тэсрэх бөмбөг хаяж байна. "Түүний дотор Бурханы хайр хэрхэн байх билээ?" хэмээн Иохан асууж байна. Энэ асуулт нь түүний дотор Бурханы хайр байхгүй гэдгийг л хэлээд байгаа юм. Түүний дотор Бурханы хайр байхгүй юм бол тэр хүн жинхэнэ итгэгч мөн эсэх нь ч эргэлзээтэй.

Үнэхээр ноцтой асуудал! Өнөөгийн чуулган мөнгөтэй баян хүнийг өргөмжилж, түүнийг чуулганы удирдагч



болгож, ирсэн зочдод түүгээр сайрхдаг. Баян итгэгчийг харах нь бидэнд сайхан санагддаг болжээ. Тэгвэл Иохан асууж байна: Тэр жинхэнэ христитгэгч юм бол хэрэгцээнээсээ илүү гарсан мөнгөө яагаад бусдын төлөө зарцуулахгүй байгаа юм бэ?

Миний харж байгаагаар энэ эшлэл бидэнд хоёр сонголтыг үлдээж байна. Нэг нь, Иоханы үгийг огоорч, мөс чанараас минь цуурайтах дуу хоолойг нам хааж, энэ тухай номлосон хүнийг буруутгах. Хоёр дахь сонголт нь гэвэл, энэ үгийг даруугаар хүлээн авч, өөрийн эд хөрөнгийг ах дүүсийнхээ хэрэгцээнд зарцуулж, Бурханы болон хүмүүсийн өмнө цэвэр мөс чанартай явах. Итгэгч хүн даруу төлөв амьдарч хэрэгцээнээсээ гарсан бүхнийг Эзэний төлөө зарцуулах хэрэгтэй. Ингэснээр Бурханы өмнө санаа амар амьдарч, хэрэгцээ бүхий ах дүүстээ тусалж чадна.

## 10 сарын 30

*"Миний хүүхдүүд үнэний дотор буйг сонсохоос эрхэм баяр баясгалан гэж надад үгүй билээ."* (3Ио 4)

Хүний сүнсийг аврахын баяр хөөрийг элч Иохан мэдээж мэддэг байсан. Нүгэлтнийг Эзэн Есүс рүү хөтлөх нь үнэхээр их баяр жаргалыг авчирдаг. Гэхдээ Иоханы хувьд түүнээс ч илүү, үнэндээ хамгийн агуу баяр хөөр бол итгэл доторх хүүхдүүд нь Эзэний төлөө тууштай явахыг харах байжээ.

“Христэд үйлчилсэн он жилүүдийнхээ эхэн үед би хүнийг Христэд итгүүлэх нь итгэгч хүний хамгийн том баяр хөөр гэж хэлдэг байлаа. Харин цаг хугацаа өнгөрөхөд миний бодол өөрчлөгдсөн юм. Христэд итгэлээ хэмээн нэгэн цагт хэлж байвч удалгүй замаасаа эргэж, Христийн замаар тууштай алхахгүй байгаа хүмүүсийг харахаар туйлын их сэтгэл өвддөг. Харин итгүүлсэн хүмүүс минь нигүүлсэл дотор өсөж, үнэний дотор алхаж, олон жил өнгөрсөн ч тууштай явж байгааг харахаар итгэгч хүний хамгийн том баяр хөөр бол энэ юм байна гэж бодох болсон” хэмээн доктор М. Р. Дихаан бичжээ.

Лерой Эимсээс амьдралын чинь хамгийн том баяр хөөр юу вэ гэж асуухад “Христ дээр авчирсан хүн чинь итгэлээр өсөж, төлөвшиж, үр жимс гаргаж, дараа нь бусдыг Христ рүү дагуулж, тэдэндээ тусалж дэмжиж байгааг харах л хамгийн том баяр хөөр” гэж хэлсэн байдаг.

Энэ нь яагаад хамгийн том баяр хөөр гэдгийг гайхах зүйлгүй. Жирийн амьдралд ч ийм л байдаг. Шинээр хүүхэд төрөхөд хүн бүхэн баярладаг. Гэхдээ “Хүү минь том болоод ямар хүн болох бол?” гэсэн санаа зовоом асуулт

төрдөг. Хүүхэд нь өсөж том болоод зөв шударга, амжилттай хүн болохыг харахаар эцэг эхүүд хэчнээн их баярладаг бол. Тийм ч учраас Сургаалт үгс 23:15,16 дээр “Зүрх чинь мэргэн байвал, хүү минь зүрх минь ч бас баясна. Уруул чинь чигч шударгыг ярихад дотор минь хүртэл баярлана” гэж бичигджээ.

Бид сайнмэдээ тараах, дагалдагч бэлтгэх өнгөц арга замууддаа сэтгэл ханаж болохгүй гэдгийг эндээс ойлгох ёстой. Сүнслэг үр хүүхдийг хүсэж байвал бид өөрсдөө үнэн дотор алхаж, тэдний төлөө амь амьдралаа зориулж, залбирах, заавар чиглүүлэг өгөх, урамшуулах, залруулах ажилд үнэт цагаа зориулах ёстой.

## 10 сарын 31

*"Мэргэн хүү эцгийн баяр баясгалан, мулгуу хүү эхийн зовлон."* (Сур 10:1)

Хүүхэд нь мэргэн болох уу мулгуу болох уу гэдгийг юу шийдэх вэ? Иохан болох уу Иудас болох уу гэдэгт ямар хүчин зүйл нөлөөлдөг вэ?

Мэдээж хэрэг эцэг эхийн өгөх хүмүүжил нэг чухал хүчин зүйл юм. Хүүхдээ зөвөөр хүмүүжүүлбэ гэвэл, юуны түрүүнд хүүхдүүдээ Бурханы үгэнд суурилуулах ёстой. Библи ариун шударга зан төлөвшилтэй болоход асар их нөлөөлдөг бөгөөд үүнийг дутуу үнэлж болохгүй.

Мөн гэр орноо залбирлын уур амьсгалтай байлгах хэрэгтэй. Ээж нь хүүгийнхээ төлөө өвдгөө цоортол залбирч байсны ачаар хүү нь ёс суртахууны болоод сургаалын буруу замаас хамгаалагдаж, сайнмэдээний нэр төртэй номлогч болж чадсан жишээ бий.

Мөн хүүхдийг дуулгавартай байдалд сургаж, эрх мэдэлд захирагддаг болгохын тулд хатуу сахилгажуулал хэрэгтэй. Өнөөдөр сахилгажуулалыг буруу хэмээн шүүмжилдэг хүмүүс олон болсон. Гэвч саваа ашигладаг байсан үеэс илүү, дураар нь тавьдаг болсон явдал хүмүүсийн амьдралыг сүйрэл рүү нь хөтөлж байна (Сур 13:24; 23:13,14).

Хүүхдээ сурган хүмүүжүүлэхийн тулд мөн хайртайгаа ойлгуулж, аюулгүй байдлыг мэдрүүлж байх хэрэгтэй. Сахилгажуулах нь хайрын үйлдэл болохоос уур уцаараар хийдэг зүйл биш.

Эцэг эхчүүд ярьдаг зүйлээ амьдралдаа үлгэрлэн харуулж байх хэрэгтэй. Итгэл үнэмшилдээ хоёр нүүр

гаргадгаас болоод христэч эцэг эхтэй олон хүүхэд бүдэрдэг.

Хүүхдийн хүслийг ч гэсэн харгалзан үзэх ёстой. Хүүхэд гэрээсээ явах цаг болоход шийдвэрийг өөрт нь үлдээх ёстой. Ижил нөхцөлд нэг гэрт өссөн хүүхдүүд өөр өөр замаар явах нь бий.

Амьдралын хоёр үнэнийг хүлээн зөвшөөр. Нэгт, хүмүүс өөрсдөө энэ ертөнцийг таньж мэдэж, өөрсдийнхөө төлөө шийдвэр гаргах ёстой. Хоёрт, ихэнх хүн мэргэн зөвлөгөөгөөр биш, ичгүүр гутамшгаар ухаарлыг олж авдаг.

Хүүхдүүдийг хүчээр итгүүлэх гэж оролдох хэрэггүй. Хүүхдүүд сайн дураараа Эзэн рүү ирвэл түүнийг нь урамшуул. Харин хүчээр итгэсэн гэж хэлүүлэх гэж оролдвол хожим энэ хуурамч итгэлээсээ ухарч, Христ рүү эргэхэд зүрх нь улам хатуурна.

Христэч эцэг эх хүүхдээ Эзэний эмээн хүндлэл, сахилга бат дотор өсгөхийн тулд хамаг сайнаараа хичээсэн боловч хүүхэд нь мунхаг мугуйд амьдардаг болбол яах ёстой вэ? Нэг зүйлийг мартаж болохгүй. Эцсийн бүлэг бичигдээгүй байна. Эзэний хувьд дэндүү хэцүү зүйл гэж байхгүй. Олон хүн тасралтгүй залбирч, байнгын харилцаа холбоотой байснаараа тэнэж төөрсөн хүүхдүүдээ эргэн ирэхийг харцгаасан. Гэхдээ бас олон тохиолдолд эцэг эхийнх нь залбирлын хариулт Эзэн рүү явсных нь дараа ирж байсан удаа ч бий.

## 11 сарын 1

*"Өглөө тарь, үдэш ч гараа бүү буулга. Учир нь өглөө орой тариалсны аль нь үр дүнтэй болохыг эсвэл хоёулаа сайн эсэхийг чи мэдэхгүй шүү дээ."* (Ном 11:6)

Бурхан бидний үйлчлэлийг хэзээ, яаж ашиглахыг баттай мэдэхгүйгээс хойш эцэж цуцалгүй явж, боломж болгоныг ашиглацгаая. Эзэн ихэвчлэн бодож байснаас минь өөрөөр, санаанд ороогүй арга замаар ажилладаг.

Христэч усан цэрэг, тэнгисийн хүчний агаарын бааз дээр хамтрагчдаа Эзэн Есүсийг гэрчлэн ярьж байлаа. Хамтрагч нь түүний яриаг ойшоон үзсэнгүй. Гэтэл цаахна талд нь тэр хоёрын яриаг сонсож байсан гурав дахь усан цэрэг сайнмэдээг хүлээн авч, нүглээ ухаарч, үнэн сэтгэлээсээ Есүст итгэжээ.

Нэгэн номлогч шинэ зааландаа хөгжим техникийн дуугаралтыг шалгаж микрофон дээр Иохан 1:29-ийг эш татаж: “Харагтун! Ертөнцийн нүглийг үүрэгч Бурханы Хурга” хэмээн хэлжээ. Номлогчийг харахад зааланд хэн ч байсангүй. Номлогч баптисч Иоханы үгийг дахин давтаж, “Харагтун! Ертөнцийн нүглийг үүрэгч Бурханы Хурга” хэмээн микрофон дээр ярилаа. Заал ямар ч хүнгүй харагдсан ч нэгдүгээр тагтан дээр хүн ажиллаж байж. Тэр хүн Библийн үгийг сонсоод Бурханы Хурга руу эргэж, уучлал ба шинэ амийг авчээ.

Нэгэн америк Библийн номлогч Пансын галт тэрэгний буудал дээр америк жуулчинд Есүсийн тухай яриу. Тэр хоёр хоёулаа нэг хотынх, тэгээд зогсохгүй нэг дүүргийнх ажээ. Жуулчин бага зэрэг унтууцан “Та намайг Пансын галт тэрэгний өртөөн дээр аварчихна гэж бодоод байна уу

даа?” гэсэнд Библийн багш, “Үгүй ээ. Би чамайг аварч чадахгүй. Гэхдээ амьдралд тохиолдлын зүйл гэж байдаггүй юм. Бид хоёр энд тааралдсан нь тохиолдол биш. Миний бодлоор Бурхан чамайг аврахыг хүсэж байна. Сонссон нь чамд дээр байх аа” гэж хэлэв. Жуулчин дараагийн өдөр нь Вена рүү замын унаанд суув. Унаанд христитгэгч таарч замын турш Есүсийн тухай ярьжээ. Америкт ирснийх нь дараа өнөөх итгэгч түүнийг Колорадогийн христэч фермер айлд урив. Фермерийнд байх сүүлийн өдрөө залуу, бассейны дэргэд ганцаараа зогсож байтал өөр нэг зочин дэргэд нь ирж намдуунаар Эзэний тухай ярьж өгч, түүнийг Аврагч Эзэн дээр авчирч асар их баярлажээ. Хэдэн жилийн дараа америк Библийн багшид итгэмжит залуу итгэгчийг танилцуулав. Нэр нь танил сонсогдлоо. Пансын галт тэрэгний буудал дээр Есүсийн тухай ярьж өгсөн өнөөх жуулчин мөн болохыг тэр таньжээ.

Дүгнэн хэлэхэд, бид өглөө ч, орой ч, цагаа олсон ч, олоогүй ч Христийн төлөө хичээнгүй үйлчлэх хэрэгтэй. Ямар үг хүнийг авралд хүргэж, ямар үйлчлэл нүдээ олохыг бид мэдэхгүй шүү дээ.

## 11 сарын 2

*“Тиймээс хайрт ах дүү нар минь, та нарын зүдэл зүтгэл Эзэн дотор хоосон биш гэдгийг мэдэж, тууштай байж, гуйвж дайвалгүй, Эзэний үйл хэргээр үргэлж бялхаж бай.”*  
(1Ко 15:58)

Эзэний төлөө үйлчилж байхдаа урам хугарч, үйлчлэлээ орхих явдал байдаг. Бидний ихэнх нь ийм сорилттой учирсан байх. Тиймээс өнөөдөр би өөрийг минь ихээр зоригжуулж, үйлчлэлээ болихоос хамгаалсан дөрвөн эшлэлийг та бүхэнтэй хуваалцъя.

Эхнийх нь Исаиа 49:4: “Харин Би ‘Дэмий хөдөлмөрлөж, хүчээ юунд ч биш, хоосон зарцуулжээ, би. Гэвч үнэхээр шударга ёс минь ЭЗЭНТэй хамт, шагнал минь Миний Бурхантай хамт юм’ гэсэн.” Эзэний төлөө үйлчилсэн он жилүүд минь хий дэмий өнгөрсөн мэт санагдах цөөн боловч тийм мөчүүд байдаг. Хамаг хичээл зүтгэл минь талаар болсон мэт, хөдөлмөр минь хайран өнгөрсөн юм шиг санагддаг. Гэвч тийм биш шүү. Бурханы шударга ёс биднийг заавал шагнаана гэдгийг өнөөдрийн эшлэл батлан хэлж байна. Эзэний төлөө хийсэн бүхэн нэг нь ч хоосон өнгөрөхгүй.

Хоёр дахь эшлэл нь Исаиа 55:10,11: "Бороо, цас тэнгэрээс бууж ирээд, газраас цухуйн ургуулж тариачинд үрийг, идэгчдэд талхыг өгөгч газрыг усалтлаа буцдаггүйтэй адил амнаас минь гарсан Миний үг Над уруу хоосон буцаж ирэхгүй, Харин юу хүссэнийг минь хэрэгжүүлж, юунд илгээснийг минь гүйцэлдүүлнэ." Бурханы амьд үгийг түгээн дэлгэрүүлэх ажил заавал амжилт олно. Үр дүн нь баталгаатай. Бурханы үгийг юу ч



эсэргүүцэж чадахгүй. Энэ ертөнцийн ямар ч цэрэг арми цас бороог газар унахыг болиулж чадахгүй шиг, үй түмэн чөтгөрүүд, олон мянган хүн нийлээд ч Бурханы үгийг зогсоож, хүний амьдралд хувьсгал хийхийг нь болиулж чадахгүй. Бид ялагч талд нь зогсож байна.

Гуравт Маттай 10:40 дүгээр эшлэл биднийг ихээр урамшуулна: " Та нарыг хүлээн авах нь Намайг хүлээн авсан хэрэг юм. Намайг хүлээн авах нь Намайг Илгээгчийг хүлээн авсан хэрэг юм." Есүс Христийг гэрчилснээсээ болоод ад үзэгдэж, хөөгдөж, шоолуулж, доромжлууулж, зодуулж байсан уу? Гэрийнхээ үүдээр ч оруулахгүй нүүрэн дээр чинь хаалгаа тас хаадаг хүнтэй таарч байсан уу? Үүнд нэг их эмзэглэх хэрэггүй. Таныг хүлээн авахгүй бол Аврагчийг хүлээн аваагүй гэсэн үг. Танд яаж хандаж байна Эзэнд тийн хандсантай адил. Бурханы Хүүтэй ийм нягт холбоотой тооцогдох ямар гайхалтай вэ!

Дөрөв дэх эшлэл нь Коринт 15:58 (дээр эш татсан). Паул амиллын үнэнийг өгүүлж байна. Хэрэв бүх юм энэ амьдралаар дуусдаг бол бидний хөдөлмөр үнэхээр хоосон байх байлаа. Гэвч үхлийн цаана мөнхийн алдар хүлээж байна. Тэр үед Эзэний нэр дээр хийсэн бүхэн шагналаа авна. Хайрын үйлчлэл бүхэн үр жимсээ өгнө.

Христэч үйлчлэл бол хамгийн яруу алдартай дуудлага юм. Үүнээс болих үндэслэлтэй шалтгаан гэж байдаггүй. Биднийг эргэж буцахаас хамгаалах хангалттай урамшуулал Бурханы үгэнд байна.

## 11 сарын 3

*"Хэдий тийм ч Бурханы бат суурь нь хөдөлшгүй ба 'Эзэн өөрийнхнийгөө мэддэг', 'Эзэний нэрийг дуудагч бүр зүй бусаас зайл' гэсэн тамгатай."* (2Тм 2:19)

Элч нарын өдрүүдэд хүртэл шашны ертөнцөд толгой эргэм зүйл олон байлаа. Тухайлбал хоёр хүн итгэгчдийн амилал байхгүй болсон хэмээн сонин сургаал номлодог байв. Бидний хувьд ийм үзэл санаа үнэхээрийн этгээд гажууд. Гэвч тухайн үедээ энэ нь олон хүний итгэлийг хөмрүүлэх хэмжээнд ноцтой асуудал байжээ. Ийм хүмүүстэй учрахаар “Энэ хүмүүс жинхэнэ христитгэгчид мөн үү?” гэсэн асуулт урган гардаг.

Өнөөдөр ч гэсэн энэ асуулттай бид тулгардаг. Нэр нөлөөтэй санваартан Мариагийн онгон төрөлтийг няцаана. Библийн сургуулийн профессор Библид алдаа мадаг байдаг гэж номлоно. Итгэлээр дамжуулан нигүүлслээр аврагдсанаа тунхагладаг оюутан Амралтын өдрийг сахих нь авралд нэн чухал гэж бат итгэнэ. Христэд итгэсэн хэмээн хэлдэг бизнесмен шүтээнүүдэд мөргөдөг, ариун ёслолуудаар дамжуулан аврагдана гэж заадаг, удирдагчаа төгс гэгээнтэн гэж тунхагладаг сүмд явсан хэвээр. Энэ хүмүүс жинхэнэ итгэгч мөн үү?

Үнэнийг хэлэхэд, тэдний христитгэл жинхэнэ эсвэл хуурамч болохыг баттай мэдэх ямар ч аргагүй. Үнэн ба худал, хар ба цагааны хооронд саарал хэсэг байдаг. Бид энэ хэсэг дээр итгэлтэй байж чадахгүй. Зөвхөн Бурхан л мэднэ.

Бүрхэг тодорхойгүйн ертөнцөд ганц баттай юм бол Бурханы хөдөлшгүй суурь. Түүний барьж байгуулсан юм л хөдөлшгүй бат бэх. Түүний суурин дээр тамга байх

бөгөөд уг тамган дээр хоёр бичиг бий. Нэг нь Бурханы талыг, нөгөө нь хүний талыг харуулна. Эхнийх нь тунхаглал. Хоёр дахь нь тушаал.

Бурханы тал дээр “Эзэн Өөрийнхнийг мэддэг” гэсэн тунхаглал бичээтэй. Эзэн хэн нь үнэхээр Өөрийнх нь вэ гэдгийг мэднэ. Гаднах үйлдэл нь зүй зохисгүй байсан ч Тэр мэднэ. Нөгөө талд, Тэр бүх хоёр нүүр, дүр исгэлтийг мэднэ. Гаднаа үнэмшилтэй ч худал хуурмаг бүхнийг танина. Бид хэн нь хонь, хэн нь ямаа болохыг ялгаж чадахгүй боловч Бурхан ялгаж салгадаг.

Хүний тал дээр “Эзэний нэрийг дуудагч бүхэн зүй бусаас зайл” гэсэн үг бичээтэй. Хүн итгэлийнхээ үнэнийг ингэж л харуулна. Нүглээ үргэлжлүүлсээр байгаа хүн “Би христитгэгч” гэж хэлж чадахгүй болно.

Улаан буудайг хогийн ургамлаас ялгаж салгах хэцүү бол бид үүнийг л харна. Эзэн хэн нь Өөрийнх нь болохыг мэднэ. Харин хүмүүн бид нүглээсээ гэдрэг эргэж байгаагаараа Эзэнийх гэдгээ харуулна.

## 11 сарын 4

*"Бурханы хүүхдүүд ба диаволын хүүхдүүд үүгээр илчлэгдэнэ. Зөвийг үйлддэггүй нь ч, ах дүүгээ хайрладаггүй нь ч Бурханых биш."* (1Ио 3:10)

Олон жилийн өмнө бараг бүх айл зочны өрөөндөө томоо гэгчийн гэр бүлийн зургийн альбомтой байлаа. Альбом нь янз бүрийн чимэг хээ хуартай, үзэмж сайхан хавтастай, хавтас нь ирмэгээрээ хүрээтэй. Альбомоо шургуулдаг хавтсанд нямбай гэгч нь хадгалцгаана. Элдэв янзын цэцгээр чимэглэгдсэн, янз бүрийн материалаар хийгдсэн хуудаснуудтай. Хуудас бүр зургаа тогтоох зүсэлтгэй эсвэл зураг хийх гялгар уутан хэсэгтэй. Ирсэн зочид зургийн цомгийг үзээд “Жош өвөөтэйгөө яг адилхан юм”, “Сарад ч гэрийнхнийх нь төс байна шүү” гэх мэтчилэн хэлцгээнэ.

Иоханы нэгдүгээр захидал хуучин цагийн гэр бүлийн альбомыг надад сануулдаг. Яагаад гэхээр энэ захидал хоорондоо адилхан Бурханы гэр бүлийн гишүүдийн зургийг зуржээ. Гэхдээ гадаад дүр төрхөөрөө адилхан биш, харин сүнслэг байдал, зан чанараараа адилхан байхыг ярьж байна.

Христитгэгчид сүнслэг байдлаараа доод тал нь найман ижил зүйлстэй байдаг. Нэгт, тэд бүгдээрээ Есүсийн талаар ижил зүйл хэлдэг. Есүс бол Христ буюу Мессиа, Тослогдсон Нэгэн гэдгийг бүгд хүлээн зөвшөөрдөг (1Ио 4:2; 5:1). Тэдний хувьд Есүс ба Христ бол нэг Хүн юм.

Бүх христитгэгч Бурханыг хайрладаг. (5:2) Тэдний хайр сул дорой, хүний нүдэнд харагдахааргүй байж болох

ч Бурхантай уулзаад “Би Танд хайртай гэдгийг Та мэднэ” гэж хэлж чадахгүй итгэгч нэг ч байхгүй.

Бүх христитгэгч ах дүүгээ хайрладаг (2:10; 3:10,14; 4:7,12). Үхлээс аминд шилжсэн бүх хүний шинж тэмдэг энэ юм. Тэд Бурханыг хайрладаг болохоор Бурханаас төрсөн хүмүүсийг хайрладаг.

Бурханыг хайрладаг хүмүүс Бурханы тушаалуудыг сахидаг (3:24). Тэд шийтгэлээс айсандаа бус, бүхнээ өгсөн Бурханыг хайрласандаа дуулгавартай дагадаг.

Христитгэгчид нүгэлтэй зууралддаггүй (3:6,9; 5:18). Тэд нүгэлд унадаг нь үнэн. Гэхдээ нүгэл тэдний амьдралд захирах хүчгүй болсон. Тэд гэм нүгэлгүй биш. Харин гэм нүгэл хийхгүйг хичээдэг.

Бурханы гэр бүлийн гишүүд зөвт байдлыг хэрэгжүүлдэг (2:29; 3:7). Тэд байнга нүгэл үйлдэхгүй хэмээн зүгээр л идэвхгүй суудаг хүмүүс биш, харин зөвт байдлын үйлсээр бусдад хүрэх гэж идэвхтэй явдаг хүмүүс юм.

Бурханы гэр бүлийн гишүүдийн долоо дахь чанар бол, тэд ертөнцийг хайрладаггүй (2:15). Ертөнц гэдэг нь Бурханыг эсэргүүцэхээр хүмүүсийн байгуулсан тогтолцоо бөгөөд ертөнцтэй найзлагч нь Бурханы дайсан гэдгийг тэд ойлгодог.

Бурханы гэр бүлийн гишүүдийн найм дахь төстэй чанар бол, тэд энэ ертөнцийг итгэлээр ялдаг (5:4). Тэд өнгөрөн одож буй зүйлсийн цаадхыг, мөнх зүйлсийг олж хардаг бөгөөд үл үзэгдэх юмсын төлөө амьдардаг.

## 11 сарын 5

*“Итгэл, сайн мөс чанараа сахь. (1Тм 1:19)*

Мөс чанар бол зөвийг дэмжиж, бурууг эсэргүүцэх зорилгоор Бурханаас хүнд өгсөн хяналтын механизм юм. Адам Ева хоёр нүгэл үйлдэх үед мөс чанар нь буруутгаж, нүцгэн гэдгээ мэдсэн.

Нүгэл орж ирснээр хүний бүх мөн чанар буруудсан бөгөөд мөс чанар ч ялгаагүй. Тиймээс мөс чанарт бүрэн найдах аргагүй. “Мөс чанар чинь чамайг замчлаг” гэх хуучны үг туйлын үнэн биш юм. Гэхдээ хамгийн хатуурсан сэтгэлд хүртэл мөс чанар улаан ногоон гэрлээ анивчуулан дохио өгдөг.

Хүн Христэд итгэх үед Христийн цусаар мөс чанар нь үхмэл үйлсүүдээс цэвэрлэгддэг (Евр 9:14). Өөрөөр хэлбэл хүн Бурханы өмнө тааллыг олохын тулд өөрийн үйлсэд түшиглэхээ больсон гэсэн үг. Тэрээр хилэнцэт мөс чанараас цэвэрлэгдэхийн тулд зүрхэндээ цацуулсан (Евр 10:22). Яагаад гэвэл, Христийн ажлаар нүглийн асуудал нэг мөр шийдэгдсэнийг тэр мэддэг болсон. Нүглийн ял буруутгалын асуудалд мөс чанар нь түүнийг яллахаа больсон.

Тиймээс итгэгч хүн Бурхан ба хүний өмнө мөс чанараа сэвтээхгүй байхыг хүсдэг (Үйл 24:16). Итгэгч хүн сайн мөс чанартай байхыг хүсдэг (1Тм 1:5,19; Евр 13:18; 1Пт 3:16). Итгэгч хүн цэвэр мөс чанартай байхыг хүсдэг (1Тм 3:9).

Итгэгч хүний мөс чанар нь Бурханы үгээр дамжуулан Бурханы Сүнсээр сургагдах хэрэгтэй. Ингэснээр христэч хүн хэрхэн биеэ авч явах тал дээрх бүрхэг асуудлуудад илүү мэргэн ухаантай болж чадна.

Зөв ч биш, буруу ч биш зүйлс дээр хэтэрхий эмзэг ханддаг итгэгчдийн мөс чанар сул дорой байдаг. Хэрэв тэд мөс чанарынхаа буруутгаж буй зүйлийг үйлдвэл нүгэл үйлдсэн хэрэг (Ром 14:23) бөгөөд мөс чанараа сэвтээдэг (1Ко 8:7).

Мөс чанар нь уян хатан туузтай адил. Татаж сунгах тусам уян хатан чанараа алддаг. Мөс чанар дөжрөх боломжтой. Хүн буруу үйлдлээ хаацайлж, элдвийн арга саамаар зөвтгөөд байх юм бол мөс чанар нь хүссэн бүгдийг нь зөвтгөдөг болно.

Үл итгэгчид мөс чанараа халуун төмрөөр хуйхлуулсан мэт ширэн нүүртэй, дүр эсгэгч болж чаддаг (1Тм 4:2).

Мөс чанарынхаа дуу хоолойг байнга эсэргүүцэх аваас эцэст нь юуг ч хүлээн зөвшөөрөхөд бэлэн, нүгэл үйлдсэн ч сэтгэл нь өвддөггүй нэгэн болно (Еф 4:19).

Хүн мөс чанартаа хэрхэн хандсанаа Бурханы өмнө тайлагнана. Бурханы өгсөн зан чанар хэзээ ч хорон мууд дөжирч чадахгүй.

## 11 сарын 6

*"Ингээд ЭЗЭНээр солигдогсод буцаж, баяртайгаар дуулан Сион уруу ирнэ. Тэргүүн дээр нь мөнхийн баяр хөөр. Тэд цэнгэл, хөөртэй байх бөгөөд гашуудах, санаа алдах нь зугтан одно." (Иса 51:11)*

Хам сэдвийг нь харвал, Бурханы сонгосон хүмүүс Вавилоны далан жилийн цөллөгөөс буцаж ирэхийг Исаиа зөгнөн хэлсэн байна.

Мөн Мессиа, дэлхийн өнцөг булан бүрээс израильчуудыг дахин цуглуулж, эх нутагт нь буцаан авчирч, ирээдүйд сэргээх тухай хэлсэн байж болно. Энэ ч бас агуу их баяр хөөрийн үе юм.

Гэхдээ энэ эшлэлийг бид бүр өргөн утгаар, Христийн чуулганы шүүрэлтэй холбон ярьж болно. Эзэний уухай, тэргүүн тэнгэрэлчийн дуун, Бурханы бүрээгээр бүх цаг үеийн аврагдсан хүмүүс булшнаасаа босох болно. Тэр үед амьд байх итгэгчид хоромхон зуурт өөрчлөгдөж, амилсан итгэгчидтэй хамт дээш өргөгдөн, Эзэнтэй агаар мандалд уулзана. Дараа нь Эцэгийн гэр рүү явцгаана.

Тэдний замыг бүхэлд нь тэнгэрэлч нар хамгаалах нь дамжиггүй. Тэдний манлайд үхэл ба булшийг ялсан жавхланта Ялагч, Аврагч Эзэн Өөрөө явна. Дараа нь дэлхийн бүх үндэстэн ястан, овог аймаг, хэлтэн, угсаатнаас аврагдсан үй түмэн хүний чуулал болно. Түм түмээрээ, мянга мянгаараа тэд хөгжмийн төгс хоршлоор “Нядлуулсан Хурга, хүч, баялаг, мэргэн ухаан, сүр хүч, хүндэтгэл, алдар ба магтаалыг авбал зохистой” хэмээн дуулна.



Тэр түмэн олон бүгдээрээ Бурханы гайхамшигт нигүүлслийг хүртэгч юм. Тэд нүгэл ба ичгүүрээс ангижирч, Есүс Христийн дотор шинэ бүтээл болжээ. Зарим нь итгэлийнхээ төлөө хатуу зовлонг туулсан. Зарим нь Аврагчийнхаа төлөө амиа өгсөн. Гэхдээ одоо бүх шарх сорви нь эдгэрчээ. Ариун хүмүүс үхэшгүй, цог жавхлант биетэй болжээ.

Абрахам, Мосе, Давид, Соломон нар тэнд байна. Петр, Иохан, Иаков, Паул нар ч тэнд байна. Мартин Лютер, Жон Уэсли, Жон Нокс, Жон Калвин нар бас тэнд байна. Гэхдээ тэд Бурханы нуусан хүмүүс бус, дэлхий дээрх алдар нэргүй хүмүүс ч бус, харин тэнгэрт алдар нэрээ дуурьсгагсад болжээ.

Ингээд ариун хүмүүс Хааны ордон руу явна. Уй гашуу, зовнил мөнхөд арилж, үүрдийн баяр баясгалан бий болно. Итгэл үл үзэгдэх зүйлсийг харах бус, бодитоор харж, найдварын удаан хүлээсэн хүлээлт биеллээ олно. Хайртай хүмүүс бие биетэйгээ халуун тэврэлтээр уулзацгаана. Хаа сайгүй баяр баясгалан. Нүглийн гүн намгаас аварч, ийм гайхамшигт цог жавхланд оруулсан нигүүлслийг хүн бүр биширнэ.

## 11 сарын 7

*“Гэртээ, өөрийнхөндөө оч. Эзэн чамд хэчнээн ихийг үйлдэж, чамд хэрхэн өршөөлөө үзүүлснийг тэдэнд мэдэгд.”*  
(Мк 5:19)

Дөнгөж аврагдсаныхаа дараа Аврагч Эзэний талаар гэр бүл, хамаатан садандаа хэлбэл тэд бүгдээрээ итгэнэ хэмээн бид их л хялбархан санадаг. Үнэхээр гайхалтай үйл явдал болно гэж төсөөлдөг. Гэтэл ихэнх тохиолдолд тэд маань гомдож, хардаж сэрдэж, үзэн яддаг. Өөрсдөөс нь урвасан мэт аашилдаг. Ийм нөхцөл байдалд орохоороо бидний гаргадаг хандлага эргээд хайртай хүмүүсээ Христ дээр ирэхэд саад болдог. Заримдаа бид тэдэн рүү уурлаж, тэднээс зайгаа барьж, харилцаагаа тасалдаг. Эсвэл христэч бус амьдралын хэв маягийг нь шүүмжилж, христэч хэм хэмжээний дагуу амьдрах Ариун Сүнсний хүч тэдэнд байхгүйг умартдаг. Иймэрхүү зан хадлага маань өөрсдийгөө тэднээс илүү хэмээн үзэж байгаа юм шиг сэтгэгдэл төрүүлдэг. “Би чамаас ариун” гэж хэлээд байгаа мэт хайртай хүмүүс маань хүлээж авдаг. Үүнээс бид болгоомжлох хэрэгтэй.

Бидний гаргадаг өөр нэг алдаа бол сайнмэдээнд хүчээр итгүүлэх гэж оролдох. Хайраасаа болоод, бас сүнснүүдийг аврах халуун сэтгэлийнхээ улмаас хэтэрхий яарч адгаад сайнмэдээнд бүдрүүлэл болдог.

Юм бүхэн уялдаа холбоотой. Нэг үйлдэл дараагийн үр дагаврыг авчирдаг. Христэд итгэмэгцээ бид эцэг эхийнхээ үгэнд хайраар захирагдахдаа хойргошдог. Христитгэл маань биднийг том толгойтой болгосон мэт тэдэнд санагдана. Дээрээс нь гэр орондоо үзэгдэхээ больж,

чуулганы үйлчлэлд их цагийг зарцуулж, итгэгч найзуудтайгаа олон цагаар өнждөг. Үүнээс болоод гэрийнхэн маань сүм чуулган, христэч хүмүүс гэхээр дургүй нь хүрч эхэлнэ. Есүс “Легион” буюу “Түмэн” хэмээх үй олон чөтгөрт эзэмдүүлсэн хүнийг эдгээснийхээ дараа түүнд “Гэртээ харьж, Эзэн чамд ямар агуу зүйл хийснийг гэрийнхэн болон найз нөхдөдөө хэл” гэсэн. Хийх ёстой эхний зүйл минь энэ. Хэрхэн итгэсэн тухайгаа энгийнээр, даруугаар, хайраар гэрчлэн ярих.

Дараа нь өөрчлөгдсөн амьдралаараа гэрчлэх хэрэгтэй. “Хүмүүс та нарын сайн үйлсийг хараад, тэнгэр дэх Эцэгийг чинь алдаршуулахын тулд та нарын гэрэл тэдний өмнө тийнхүү гэрэлтэг” (Мт 5:16).

Эцэг эхээ хүндэлж, хайрлаж, өмнө байгаагүйгээрээ захирагд. Библи тэй үл зөрчилдөх зөвлөгөө зааврыг нь хүлээж ав. Өмнөхөөсөө ч илүү гэр орондоо тус дэм бол. Гэрээ цэвэрлэж, аяга тавгаа угааж, хогоо асга. Хэнээр ч хэлүүлэхгүйгээр хий.

Санал шүүмжлэлийг уурлаж уцаарлахгүйгээр тэвчээртэйгээр хүлээн ав. Ийм даруу болсныг маань тэд хараад гайхна. Талархлын захиа бичих, утсаар ярих, бэлэг өгөх гэх мэт өчүүхэн ч гэсэн хайр халамжийн хандлага нь эсэргүүцлийг арилгахад тусална. Эцэг эхээсээ харилцаа холбоогоо таслахын оронд тэдэнд цаг зав гаргаж, харилцаагаа барьж босгох гэж оролд. Ингэснээр тэд илүү нээлттэй болж, сүм чуулганд урихад уриалгахан болно. Тэд урилгыг минь хүлээн авч, магадгүй Эзэн Есүс Христэд өөрсдийгөө өгнө.

## 11 сарын 8

*"Хүн бүр дуудагдсан дуудлагадаа байг."* (1Ко 7:20)

Христэч болонгуутаа өмнөх амьдралтайгаа холбоотой бүхнээ, бүх холбоогоо таслах ёстой гэж бодох хүн гарч магад. Элч Паул энэ бодлыг залруулахын тулд итгэсэн тэр мөчид өгөгдсөн дуудлагадаа үлдэх ёстой гэсэн ерөнхий зарчмыг бичиж үлдээсэн байна. Бүгдээрээ энэ зарчмыг авч үзээд энэ нь ямар утгатай бас ямар утга илэрхийлэхгүй болохыг ярилцъя.

Энэ эшлэлийн хам сэдэв нь гэрлэлттэй холбоотой. Гэр бүлийн хоёрын нэг нь аврагдаад нөгөө нь Христийг хүлээж аваагүй байна. Энэ тохиолдолд итгэгч хүн яах ёстой вэ? Үл итгэгч эхнэрээсээ салах ёстой юу? Үгүй. Эхнэр нь эсвэл нөхөр нь гэрчлэлээр нь дамжуулан Христэд итгэнэ хэмээн найдаж, гэр бүлийн харилцаагаа хэвээр хадгалж үлдэх ёстой гэж Паул хэлж байна.

Ерөнхий утгаараа бол, хүн Христэд итгэлээ гээд Библид хориглоогүй өмнөх харилцаа холбоо, амьдралын нөхцөл байдлаасаа салж ангижирч болохгүй гэсэн үг. Тухайлбал, иудей хүн Христэд итгэлээ гээд иудей хүний биеийн тэмдгээ арилгах гэж мэс засал хийлгэх хэрэггүй. Иудей бус хүн хозлол гэх мэтээр биедээ өөрчлөлт оруулж бусдаас ялгаатай болох гэсний хэрэггүй. Бие махбодын тэмдэг өөрчлөлт тийм ч чухал биш. Бурхан биднээс тушаалуудад нь дуулгавартай байхыг л хүсдэг.

Шинээр төрөх үедээ боол байсан хүн эзэнтэйгээ тэрсэлдэж, өөртөө гай зовлон шийтгэл авчрах шаардлагагүй юм. Тэрээр нэгэн зэрэг сайн боол бас сайн христэч байх боломжтой. Нийгмийн байр суур, зэрэг

зиндаа Бурханд чухал биш. Гэхдээ хуулийн үндэслэлээр эрх чөлөөгөө олж авах боломж олдвол тэр боломжоо ашиглах хэрэгтэй.

Паулын зарчмыг олон асуудал дээр ярьж болно. Гэхдээ энэ зарчмыг мөрдөх ёсгүй тохиолдлууд гэж байна. Тухайлбал, Бурханы үзэл санаатай үл нийцэх ажил мэргэжлээ үргэлжлүүлж болно гэсэн үг биш. Баарны үйлчлэгч, мөрийтэй тоглоомын газрын эзэн, шөнийн цэнгээний газрын ажилтан ажлаа үргэлжлүүлж болохгүйг сүнслэг мөс чанар нь хэлээд өгнө.

Паулын зарчмыг дагаж мөрдөх ёсгүй өөр нэг тохиолдол бол шашин шүтлэг. Христэд шинээр итгэсэн хүн христитгэлийн тулгуур сургаалуудыг үгүйсгэдэг алив тогтолцооноос гарах ёстой. Аврагч Эзэнийг гутаадаг чуулганаас явах хэрэгтэй. Христийн нэрийг үгүйсгэдэг аливаа бүлэглэлийн гишүүнчлэлээс татгалзах ёстой. Бурханы Хүүд үнэнч байхын тулд энэ мэт бүхий л шашнаас өөрийгөө салган тусгаарлах учиртай.

Дүгнэж хэлбэл, нүгэлтэй холбоотой болон Эзэнийг үл хүндэтгэсэн бүхий л холбоо сүлбээгээ шинэ итгэгч таслах ёстой. Харин Бурханы үгээр хориглоогүй бол өнгөрсөн амьдралынхаа харилцаа холбоог хэвээр үргэлжлүүлнэ.

## 11 сарын 9

*"Ах дүүс минь, хэрэв хүн 'Надад итгэл бий' гэсэн атлаа үйлсгүй бол ямар ашигтай юм бэ? Итгэл нь түүнийг аварч чадна гэж үү?" (Иак 2:14)*

Өнөөдрийн эшлэлд гарч байгаа хүнд итгэл байгаа гэж Иаков хэлээгүй. Харин тэр хүн өөрөө өөрийгөө итгэлтэй гэж хэлжээ. Гэвч түүнд авралд хүргэх итгэл үнэхээр байгаа бол үйлс ч байдаг байна. Харамсалтай нь түүний итгэл үгнээс цаашгүй байсан бөгөөд ийм итгэл хэнийг ч авардаггүй юм. Үйлсгүй үг үхмэл.

Хүн үйлсээр аврагдахгүй. Итгэл ба үйлсээр ч аврагдахгүй. Харин сайн үйлс гаргадаг итгэлээр аврагдана.

Тэгвэл 24-р эшлэлд Иаков хүн үйлсээр зөвтгөгдөнө гэж хэлсэн нь ямар учиртай вэ? Итгэлээр аврагдана гэсэн Паулын номлолтой энэ үг зөрчилдөж байгаа бус уу? Үгүй. Паул, Иаков хоёр хоёулаа үнэн хэлсэн. Тэдний үг зөрчилддөггүй. Шинэ гэрээ зөвтгөлийг зургаан өөр талаас харуулсан. Үүнд:

Бид Бурханаар зөвтгөгддөг (Ром 8:33) – Биднийг зөвд тооцдог нь Бурхан юм.

Бид нигүүлслээр зөвтгөгддөг (Ром 3:24) – Бурхан зөвтгөлийг зохисгүй хүмүүн бидэнд үнэгүйгээр бэлэг болгон өгсөн.

Бид итгэлээр зөвтгөгддөг (Ром 5:1) – Бурханы энэ бэлгийг бид Эзэн Есүс Христэд итгэсэн итгэлээр хүлээн авна.

Бид цусаар зөвтгөгддөг (Ром. 5:9) – Христийн үнэт цус биднийг зөвтгөгдөхөд төлсөн үнэ юм.

Бид хүч чадлаар зөвтгөгддөг (Ром 4:25) – Бидний Эзэн Есүс Христийг үхлээс амилуулсан хүч чадал нь бидний зөвтгөлийг боломжтой болгосон.

Бид үйлсээр зөвтгөгддөг (Иак 2:24) – Сайн үйлс нь үнэхээр зөвтгөгдсөн хүмүүсийн гадаад баталгаа юм.

Христэд итгэлээ гэж хэлэх нь хангалтгүй. Үнэхээр Бурханаас төрсөн бол тэр хүний дотроос сайн үйл гардаг бөгөөд үүнийг бид харуулах хэрэгтэй.

Итгэл харагддаггүй. Энэхүү үл харагдах үйл явц Бурхан бид хоёрын дунд болдог. Хүмүүс итгэлийг маань харж чадахгүй. Гэхдээ тэд авралд хүргэдэг итгэлийн үр жимс болох сайн үйлсийг харж чадна. Тэд үйлсийг минь харахаас нааш итгэлд минь эргэлзэх нь зүй ёсны асуудал.

Абрахамын сайн үйлс нь хүүгээ Бурханд өргөл болгоход бэлэн сэтгэл нь байлаа (Иак 2:21). Рахабын сайн үйлс нь зарлага элч нарыг хүлээн авч, тэдний амийг хамгаалсан явдал байв (Иак 2:25). Тэд Иеховад итгэх итгэлээ харуулсан учраас үйлс нь сайн гэгдэж байгаа юм. Тийм үгүй байсан бол тэдний үйлс ердөө л нэг аллага, урвалт бүхий муу үйлс болно.

Сүнсгүй бие үхмэл. Сүнс нь биеэсээ гарч явахыг бид үхэл гэдэг. Үүн шиг, үйлсгүй итгэл үхмэл юм. Ийм итгэлд ямар ч амь, хүч чадал, үйл ажиллагаа байдаггүй.

Бие махбод хөдөлж, ажиллаж байгааг харвал дотор нь үл харагдах сүнс оршин байгааг бид мэднэ. Үүн шиг, авралд хүргэх, үл үзэгдэх итгэл хүний дотор байгаагийн тэмдэг нь сайн үйлс юм.

## 11 сарын 10

"Сүнс дор шат." (Ром 12:11)

Физикийн хуулиар юм бүхэн буурч доройтож, эрч хүчээ алдаж, элэгдэн мууддаг. Энд би шинжлэх ухааны үгээр тодорхойлолт хэлэх гэсэнгүй. Ерөнхий санааг нь хэлж байна.

Тухайлбал, нар тодорхой температураар шатаж байдаг бөгөөд энэ нь маш урт хугацаанд үргэлжлэх боломжтой боловч хэзээ нэгэн цагт эрчим хүчээ алдана гэдгийг хэлцгээдэг.

Хүний бие хөгширч, үхэж, эцэст нь тоос шороо болцгоодог. Савлуурыг гараараа хөдөлгөн савлуулахад аажим аажмаар эрчээ алдсаар эцэст нь зогсоно. Цагны баадууг чангалахад хэсэг яваад дахин чангалах хэрэгтэй болно. Халуун ус өрөөний температураар хөрнө. Металлууд зэвэрч өнгөө алддаг. Өнгө гунддаг. Хязгааргүй оршдог зүйл нэг ч үгүй бөгөөд мөнхийн хөдөлгүүр гэж байхгүй. Өөрчлөлт элэгдэл нь бүгдэд нөлөөлдөг.

Дэлхий ч гэсэн хөгширч байна. Библи тэнгэр газрын талаар хэлэхдээ, "Тэд мөхөх боловч Та (Бурханы Хүү) үлдэнэ. Тэд бүгд хувцас адил элэгдэнэ. Та тэднийг бүтээлэг мэт ороож тэд хувцас адил бас өөрчлөгдөнө. Харин Та хэвээрээ, Таны он жилүүд эс төгсөнө" (Евр 1:11,12) гэж бичигджээ.

Харамсалтай нь энэ зарчим сүнслэг зүйлсэд ч хэрэгждэг мэт харагдах юм. Хувь хүмүүс, чуулганууд, хөдөлгөөнүүд цагийн эрхээр сүнслэг галаа алддаг.

Христэч амьдралаа гал цогтой эхэлсэн хүн хүртэл нэг мэдэхэд хичээл зүтгэлээ гээж, эрч хүчгүй болж, алсын



хараагаа умартана. Бид сульдаж, ядарч, цөхөрч, хөрж, хөгширдөг.

Чуулганууд ч ялгаагүй. Олон чуулган Ариун Сүнсний агуу хөдөлгөөнөөр эхэлдэг. Гал нь олон жил илчтэй асдаг. Гэвч гал дөл нь буурч, анхны хайраа орхино (Илч 2:4). Бал сар дуусаж, сайнмэдээний халуун сэтгэл нэгэн хэвийн мөргөл болно. Сургаалын цэвэр ариун байдлыг эвтэй байх гэсэн ямар ч хэрэггүй зүйлээр золино. Эцэст нь хоосон барилга л үлдэж, тухайн чуулганы яруу алдар үгүй болсныг чимээгүйхэн гэрчилнэ.

Хөдөлгөөнүүд, байгууллагууд ч гэсэн гал дөлөө алддаг. Эхэндээ тэд сайнмэдээний ажилд халуун байсан боловч аажимдаа сайнмэдээгээ гээж, нийгмийн ажилд төвлөрнө. Эхэндээ тэд Ариун Сүнсний урам зориг, эрч хүчээр эхэлсэн боловч хүйтэн хөндий ёс дүрэм рүү шилжинэ. Бид сүнслэг хөрөлтөөс сэрэмжлэх хэрэгтэй. Норман Грабын хэлсэн шиг бидэн дээр байнгын сэргэлт байх ёстой. Бид үргэлж “Сүнс дор шатах” хэрэгтэй.

## 11 сарын 11

*"Сонсохоосоо өмнө хариу хэлэх нь мулгуу агаад ичгүүртэй."* (Сур 18:13)

Амьд Библи (Living Bible) орчуулгад энэ эшлэлийг “Баримтуудыг мэдэхээсээ өмнө шийдвэр гаргах нь хэчнээн ичгүүртэй, ямар мунхаг хэрэг вэ!” гэж хөрвүүлсэн байдаг. Эндээс бидний сурах ёстой чухал сургамж бий. Бид бүх баримтыг сонсохоос нааш эрүүл зөв шийдвэр, дүгнэлт гаргаж чадахгүй. Харамсалтай нь олон итгэгч асуудлыг аль аль талаас нь сонсох хүлээцтэй зан гаргадаггүй. Тэд нэг талын мэдээллийг сонсоод дүгнэлт гаргах ба ихэнхдээ дүгнэлт нь буруу байдаг.

1979 онд Гэрри Брүүкс (зохиомол нэр) нэгэн эвангелийн чуулганы үйлчлэгчдийн багт байлаа. Тэрээр маш алдартай. Хүний сэтгэлийг татах халуун дулаан зан чанартай. Түүнийг өрөөнд ороод ирмэгц гэрэл гийх шиг л болно. Чуулганых нь гишүүдээс ямар л хэрэгцээтэй хүн байна түүнд тусалж үйлчилдгээрээ тэр бусдаас ялгарна. Тэрээр чуулганы ахмад настнуудад байнга санаа тавина. Эхнэр, хоёр хүүхэд нь ч чуулганд идэвхтэй үйлчилдэг. Брүүксийнхэн үлгэр жишээ гэр бүл шиг харагдана.

Гэтэл чуулганы ахлагчид Гэррийг сахилгажуулж, үйлчлэлээс нь буулгаж, Эзэний зоог барих мөргөлд оролцохгүй байхыг гуйсан нь яг л бөмбөг тэслэх мэт үйл явдал болжээ. Гэрригийн найз нөхөд цуглаж, чуулганы бусад гишүүдийг талдаа оруулж, ахлагчдын шийдвэрийг эсэргүүцлээ. Ахлагч нар мэдэж байгаа бүхнээ хүмүүст зарлахыг хүсээгүй учраас бусдын нүдээр ахлагчдын буруу мэт санагдана. Гэвч ахлагчид өөрсдийнхөө зөвийг батлах

гэж олон юм ярилгүй Гэрригийн өнцгийг сонсохыг хүсжээ. Учир нь аливаа юманд хоёр тал байдгийг тэд мэддэг байжээ. Сонсохгүй өнгөрвөл буруу гэдгийг ч мэдэж байв.

Чуулганы ахлагчид юу мэдэж байв? Гэрри нарийн бичигтэйгээ учир уруулж, гэр бүлээ сүйтгэж байгааг мэдэж байсан. Гэрри чуулганы санхүүд итгэмжгүй хандаж хувьдаа завшиж байгааг мэдэж байсан. Гэрри ёс зүйгүй бизнесийн үйл ажиллагаа явуулж бизнесийн ертөнцөд Есүс Христийг буруугаар гэрчилж байгааг ч мэдэж байсан. Бурууг нь батлах баримтуудыг тавьж алдаагаа засах боломжийг олгосон ч Гэрри худал хэлж, зөрүүдэлсээр байгааг ч мэдэж байсан.

Гэрри ахлагчдын сахилгажуулалтыг хүлээн авч даруудахын оронд найз нөхдөө цуглуулан өөрийгөө өмөөрүүлж, чуулганыг хагаралдахад хүргэсэн. Сүүлд нь Гэрриг дагагсдын зарим нь ахлагчидтай биечлэн уулзаж, Гэрригийн зарим бурууг мэдэж авсан ч нүүрэн дээр нь буруутгаж чадахгүй Гэрриг өмөөрсөн хэвээр үлдсэн.

Эндээс гурван зүйлийг ойлгож болно. Нэгдүгээрт, бүх баримтыг мэдэхээс нааш ямар нэг дүгнэлт шийдвэр бүү гарга. Хоёрт, бүх баримтыг мэдэж чадахгүй бол дүгнэлт хийх гэж оролдох хэрэггүй. Гуравт, найз нөхдийн харилцаа холбоогоо бурууг өмгөөлөхөд бүү ашигла.

## 11 сарын 12

*"Хөри нь ирж, шалгахаас нааш хэрэг явдлаа түрүүлж хэлсэн хүний л зөв байдаг." (Сур 18:17)*

Хэрэг явдлаа түрүүлж хэлсэн хүний л зөв байдаг. Учир нь хүн бүр өөрийгөө аль болох сайнаар ойлгуулахыг хичээдэг. Энэ нь бидний төрөлх чанар юм. Жишээлбэл, бид өөрсдийнхөө сайн талууд дээр ач холбогдол өгч, муу талуудаа далдалдаг. Алдаа буруу нь илэрхий хүмүүстэй өөрсдийгөө харьцуулдаг. Бусад руу буруугаа чихдэг. Илэрхий буруу үйлдлээ хаацайлахдаа сэдлийг нь зөв байсан гэж тайлбарладаг. Баримтуудыг мушгин гуйвуулдаг. Мөн өөрийнхөө талаар таатай зураг харуулахын тулд сэтгэл хөдөлгөсөн сайхан үгсийг ашигладаг.

Адам Еваг буруутгаж, “Өнөөх эмэгтэй, надтай хамт байлгахаар Таны надад өгсөн тэр л надад нөгөө модны жимснээс өгсөн. Тэгээд л би идсэн” (Эх 3:12) гэж хэлсэн. Ева болохоор диаволыг буруутгаж, “Тэр могой, тэр л намайг мэхэлснээс болоод би идсэн” (Эх 3:13) гэсэн.

Саул амалекчуудын хонь үхрийг хэлтрүүлсэн дуулгаваргүй зангаа өмгөөлөхдөө сүсэгтэй хүний дүр эсгэж, "Ард олон Бурхан ЭЗЭНд нядалж тахихын тулд олзноос авчирсан билээ" (1См 15:21) гэж хэлсэн. Мэдээж хэрэг Саул өөрийнхөө бурууг тохох хүмүүсийг аль хэдийнээ олжээ. Буруутан нь Саул биш, ард олон аж.

Давид зэвсэг авахын тулд Ахимелехт худал хэлж, “Хааны тушаал яаралтай байв” (1См 21:8) гэсэн. Үнэндээ Давид хааны тушаалаар яваагүй. Саул хаанаас зугтаж явсан.

Худаг дээр байсан эмэгтэй үнэн байдлаа нууж “Би нөхөргүй” (Иох 4:17) хэмээн хэлсэн. Үнэндээ тэр таван нөхөртэй байсан бөгөөд цуг амьдардаг эр нь хууль ёсны нөхөр нь биш байжээ.

Энэ мэт олон жишээг хэлж болно. Адамаас өвлөж авсан нүгэлт мөн чанараасаа болоод бид хэрэг явдлын тухай ярихдаа хуудуугүй үнэн байж чаддаггүй. Аль болох өөрсдийгөө сайн талаас нь харуулах гэж л хичээдэг. Өөрсдийнхөө амьдрал дахь нүглийг хүлээн зөвшөөрч чаддаг атлаа бусдынхыг хатуу ялалдаг.

"Хөрш нь ирж, шалгахаас нааш хэрэг явдлаа түрүүлж хэлсэн хүний л зөв байдаг." (Сур 18:17) Өөрөөр хэлбэл, хөрш маань бидний үнэн байдлыг биднээс илүү үнэн зөв ярина. Өөрсдийгөө гэгээлэг харуулж, зөвтгөх гэсэн зальтай оролдлогуудыг маань тэр илчилнэ. Хөрш маань болсон явдлыг гуйвуулгагүйгээр ярина.

Бурхан бол бидний Хөрш билээ. Тэрээр харанхуйд нууцлагдсан зүйлсийг гэрэлд гаргаж, зүрхний бодол сэдлүүдийг илчилдэг. Бурхан бол гэрэл. Түүний дотор ямар ч харанхуй байхгүй. Бурхантай толь шиг тунгалаг нөхөрлөө гэвэл, бид өөрсдөө худал хуурмаггүй шударга байж, биднийг хохироох байсан ч гэсэн үргэлж үнэнийг ярих ёстой.

## 11 сарын 13

*"Та нар гуйдаггүй учраас та нарт байдаггүй."* (Иак 4:2)

Энэ мэт эшлэл нэгэн сонирхолтой асуултыг төрүүлдэг. Гуйдаггүй учраас бидэнд байдаггүй юм бол залбирдаггүйгээсээ болоод бид амьдралдаа ямар их юмыг алдсан бол?

Иаков 5:16-аас бас ийм асуулт төрнө. "Зөвтийн залбирал үр нөлөөтэй бөгөөд ихийг гүйцэлдүүлж чадна." Хэрэв зөвт хүн залбирахгүй бол түүний хийж болох асар олон зүйл хийгдэхгүй өнгөрөх биш үү?

Гол асуудал нь, бид хангалттай залбирдаггүй, залбирлаа ч дэндүү багыг гуйдаг явдал. Ч. Т. Стаддын хэлсэн шиг, бид боломжгүйг шүүрэгчид бус, боломжтойгоос зуурагсад юм. Зоригтойгоор залбирах ёстой атал бидний залбирал зориггүй байдаг.

Агуу зүйлсийн төлөө залбирснаараа бид Бурханыг алдаршуулдаг. Жон Ньютон үүнийг ийн хэлжээ:

*Асар том хүсэлтээ бариад*

*Аугаа Хаан дээр та ирлээ*

*Хэмжээгүй нигүүлсэл, агуу хүч Түүнийх*

*Хэтэрхий том гуйлт гэж Түүнд үгүй*

Үүнийг хийснээрээ бид Бурханыг алдаршуулаад зогсохгүй өөрсдийгөө сүнслэг байдлын хувьд баяжуулдаг. Бурхан бидэнд тэнгэрийн эрдэнэсийн санг нээж өгөхийг хүсэж байна. Гэхдээ өнөөдрийн эшлэлийг харвал залбирсны хариуд үүнийг хийх ажээ.

Энэ эшлэл бидний хааяа сонсдог асуултад хариулт өгсөн байна. Ямар асуулт вэ гэвэл: Залбирал нь Бурханыг хөдөлгөж, хийхгүй байх байсан зүйлийг нь хийлгэдэг юм

уу эсвэл угаасаа хийх байсан зүйлтэй нь биднийг нэгдүүлдэг юм уу? Хариулт тодорхой байна: Залбираагүй бол Бурхан хийхгүй байх байсан зүйлээ залбирлын хариуд хийдэг.

Үүнийг бодохоор хоёр бодол төрнө. Нэгт нь, залбирлын хариулт болгож бид ямар агуу зүйлсийг биелүүлж болох вэ гэдэг бодол. Еврей 11:33, 34 дээр хэлсэн шиг “хаанчлалуудыг эзэлж, зөвийг үйлдэн, амлалтуудад хүрч, арслангуудын амыг хааж, галын хүчийг унтраан, илдний ирээс зайлж, буурайгаас хүчирхэг болгогдож, дайн тулалдаанд зоригжин, харийн дайчдыг буулган авах” агуу үр дүнд залбирлаар дамжуулан хүрэх боломжтой.

Хоёрт гэвэл, залбирсан л бол Христийн төлөө ямар агуу зүйлсийг хийж болох байсан юм бэ гэх бодол. Бурханы үгэнд дэндүү агуу, үнэ цэнтэй өчнөөн амлалт байдаг ч түүнээс нь зуураагүй өнгөрсөн үеүдээ бодож болно. Хүчирхэг байх боломжтой байтал сул дорой байжээ. Бурханы нэрээр хэдэн мянга, бүр хэдэн сая хүний амьдралд хүрч чадах байтал цөөхөн хүнд л хүрч чаджээ. Тив дэлхийг гуйх боломжтой байтал хэдхэн га газар гуйжээ. Бид сүнслэг байдалдаа баян байж болох атал ядуу болжээ. Гуйдаггүй учраас бидэнд байдаггүй.

## 11 сарын 14

*"Харин та нарын дунд хэн чинь агуу болохыг хүснэ, тэр нь та нарын зарц болог. Мөн та нарын дунд хэн чинь тэргүүнд байхыг хүснэ, тэр нь та нарын боол болог."* (Мт 20:26,27)

Шинэ гэрээнд хоёр төрлийн агуу байдлыг ярьсан. Эдгээрийг ялгаж салгаж ойлгох нь нэн тустай. Эхний агуу байдал нь хүний байр суурьтай холбоотой. Хоёр дахь агуу байдал нь хүний зан чанартай холбоотой.

Эзэн Есүс баптисч Иоханы тухай ярихдаа “Эш үзүүлэгчдийн дунд түүнээс агуу нь үгүй” гэж хэлсэн (Лк 7:28). Аврагч Эзэн маань тэгэхэд Иоханы байр суурийн агууг ярьсан. Мессиагийн замыг бэлтгэх хувь заяа өөр ямар ч эш үзүүлэгчид олдоогүй юм. Иохан Хуучин гэрээний эш үзүүлэгчдээс илүү сайн зан чанартай гэсэн үг биш. Харин ертөнцийн нүглийг үүрэгч Бурханы Хурганы замыг бэлтгэх онцгой үүрэг хүлээнсээрээ хамгийн агуу нь болсон.

Иохан 14:28 дээр Эзэн Есүс шавь нартаа “Эцэг Надаас илүү аугаа юм” гэж хэлсэн. Бурхан Эцэг зан чанарын хувьд Есүсээс агуу гэсэн үг үү? Үгүй. Яагаад гэвэл Гурвалын бүх Бодгаль адил. Есүсийн үг ямар утгатай вэ гэвэл, Эцэг тэнгэрийн цог жавхлантай сэнтийд заларч байхад Есүс Өөрөө газар дэлхий дээр хүмүүст гологдож, жигшигдэж байгааг хэлсэн. Тиймээс Есүс Эцэг рүүгээ буцна гэдгийг мэдээд шавь нар нь баярлах ёстой байсан. Яагаад гэвэл, тэнгэр рүү дээш одсоноороо Эзэн Есүс Эцэг Бурхантайгаа нэгэн адил цог жавхланд орох юм.



Бүх итгэгч Есүстэй нэг болсон учраас Түүний адил байр суурьтай. Тэд Бурханы хөвгүүд, Бурханы өв залгамжлагчид, Есүс Христийн хамтран өвлөгчид.

Шинэ гэрээнд мөн зан чанарын агуу байдлыг ярьсан. Жишээ нь, Матай 20:26,27 дээр Есүс, "Харин та нарын дунд хэн чинь агуу болохыг хүснэ, тэр нь та нарын зарц болог. Мөн та нарын дунд хэн чинь тэргүүнд байхыг хүснэ, тэр нь та нарын боол болог" гэж хэлсэн. Энэ бол бусдад үйлчилдэг амьдралаар харуулах зан чанарын агуу байдал юм.

Ихэнх хүн агуу байдлыг зөвхөн байр суурьтай холбож ойлгодог. Эзэн Есүс энэ тухай ярьсан: "Харийнхны хаад ард олноо ноёрхдог бөгөөд эрх баригчид 'Буянтнууд' хэмээгддэг" (Лк 22:25). Харин зан чанарын агуу байдлыг ярихаар хүмүүс огт ойшоож үздэггүй. Ийм агуу хүмүүсийн дунд завхайрагчид, архичид, луйварчид ч байх боломжтой.

Зан чанарын агуу байдал үгүй бол байр суурийн агуу байдал үнэ цэнэгүй гэдгийг итгэгч хүн ойлгох ёстой. Хүний дотор юу байгаа нь хамгийн чухал. Сүнсний үр жимс нь өндөр дээд албан тушаалаас илүү. Оддын дунд байснаас ариун хүмүүсийн дунд тоологдсон нь дээр.

## 11 сарын 15

*“...харин хийдэг ганц юм маань ардхаа мартаж, урдах өөдөө тэмүүлж...” (Флп 3:13)*

Энэ үгсийг уншихаар Паул өнгөрсөн нүглүүдээ ярьж байна гэсэн бодол ер нь төрдөг. Нүглүүд нь уучлагдаж, Бурхан нүглүүдийг нь нурууныхаа ард хаяж, дахиж хэзээ ч дурсахгүй гэдгийг Паул мэдэж байсан. Тиймээс Паул ч гэсэн нүглүүдээ мартаж, “Христ Есүс дотор Бурханы дээш чиглэсэн дуудлагын шагналын төлөө бариа өөд урагшлахаар” шийджээ.

Мэдээж дээрх эшлэлийг энэ утгаар авч үзэж болно. Гэхдээ Паул энд өөрийнхөө нүглүүдийг яриагүй. Харин бардамнан сайрхдаг байсан зүйлсээ бодсон. Тухайлбал угсаа гарал, өмнөх шашин, хичээл зүтгэл, хуулийн дагуух зөвт байдал. Харин одоо энэ бүхэн нь түүнд юу ч биш болжээ. Паул тэдгээрийг мартахаар шийдсэн байна.

Энэ эшлэлийг уншихаар Хятадын тууштай сайнмэдээ түгээгч, АНУ-д суралцаж байсан Жон Сунг санаанд ордог. Лесли Лиал түүний талаар ингэж бичсэн байна: “Түүний аялал шувтарч хөлөг онгоц эрэг дээр дөхөж ирлээ. Жон Сунг ачаа тээшээ аваад өрөөнөөсөө гарав. Тэрээр эмчийн дипломоо үлдээгээд бусад бүх гэрчилгээ, диплом, медаль, шагнал урамшууллаа хаялаа. Эмчийн дипломоо авч үлдсэн нь аавыгаа сэтгэл дүүрэн байлгах гэснийх аж. Дипломыг жаазанд хийж гэрт нь өлгөв. 1938 онд В. Б. Коль гэрт нь уг дипломыг харж зогслоо. Үүнийг анзаарсан Сунг түүнд ‘Иймэрхүү зүйл надад хэрэггүй. Миний хувьд юу ч биш’ гэж хэлсэн байна.”

“Христийн ажилд агуу болохын тулд асар их зүйлээс татгалзах ёстой.’ Доктор Деннигийн энэ үг Сунгийн бодолд хадаатай байсан биз. Жон Сунг энэ ертөнцийн үнэлж үздэг зүйлсээс татгалзсан учраас л асар их нөлөөтэйгөөр Христийн төлөө үйлчилж чадсан болов уу.”

*Бурхан минь болох Христийн загалмайнаас бусдаар  
Бардамнаж сайрхахыг надад бүү зөвшөөр Эзэн  
Сэтгэлийг минь татах хоосон бүхнийг би  
Түүний цусанд тахил болгон өргөе Эзэн*

Хүмүүний хүндлэл алдар гэдэг хий хоосон зүйлс. Хэсэгхэн зуур үнэлэгдээд эцэст нь хэдэн арван жил тоос шороонд дарагдана. Загалмай бол бидний алдар. Бидний төлөө амиа өгч үхлээс амилсан Эзэн Есүс Христэд таалагдах гэж амьдрах нь бидний зорилго байх ёстой. “Сайн байна” гэж Түүнээс сонсож, Бурханд сайшаагдах нь хамгийн чухал. Энэ шагналыг авахын тулд бүхнээ огоороход бэлэн байя.

## 11 сарын 16

*“...юу ч мэдэхгүй, туйлбаргүйчүүд Бичвэрийн бусад зүйлсийг гуйвуулдаг шигээ тэдгээрийг ч мушгин гуйвуулж өөрсдийгөө сүйрүүлдэг.” (2 Пт 3:16)*

Доктор П. Ж. Ван Гордер, “Энд бүх төрлийн мушгих, эргүүлэх ажлыг хийнэ” гэсэн хаягтай мужааны цехийн тухай ярьдаг байсан. Юмыг мушгих ажлыг зөвхөн мужаанууд сайн хийдэг юм биш. Итгэгч гэгдэх олон хүн Библийг өөртөө тааруулж мушгихдаа сайн. “Бичвэрийн бусад зүйлсийг гуйвуулдаг шигээ тэдгээрийг ч мушгин гуйвуулж өөрсдийгөө сүйрүүлдэг” хүмүүс бий.

Нүгэлт, дуулгаваргүй байдлаа зөвтгөн тайлбарлахдаа бид бүгд мэргэжилтнүүд. Библийг ашиглаж, өөрсдийн буруу хандлагыг зөвтгөн харуулахдаа бид тун сайн. Сонсоход үнэмшилтэй боловч үнэн биш шалтаг шалтгаануудыг бид хялбархан олдог. Зарим нэг жишээг дурдъя.

Нэгэн христэч бизнесмен итгэгч хүний эсрэг шүүхэд зарга мэдүүлэх нь буруу гэдгийг мэдсээр байж зарга мэдүүлсэн (1Ко 6:1-8). Энэ бурууг нь хэлэхээр “Тийм ээ. Гэхдээ энэ хүн үнэхээр буруу юм хийсэн. Эзэн түүнийг энэ чигээр нь явуулахыг хүсэхгүй байна” гэж өөрийгөө хаацайлсан.

Жени итгэгч биш гэдгийг нь мэдсээр байж Жонтой гэрлэхээр шийджээ. Христэч найз нь Женитэй уулзаж, “Энэ харилцаа чинь буруу. 2Коринт 6:14-т үүнийг хориглосон шүү” гэж сануулахад Жени “Тэр үнэн. Гэхдээ Жонтой гэрлэвэл түүнийг Христ дээр авчирч чадна гэж Эзэн надад хэлсэн” гэв.

Глейн, Рут нар өөрсдийгөө христитгэгч гэдэг. Гэвч тэд албан ёсоор гэрлэлтээ батлуулахгүйгээр хамт амьдарч эхлэв. Глейний найз үүнд нухацтай хандаж, “Энэ чинь садар самуун. Садар самуун хүмүүс Бурханы хаанчлалыг өвлөхгүй гэж Библид хэлдэг шүү” (1Ко 6:9,10) гэхэд, Глейн, “Наадах чинь чиний л бодол. Бид бие биедээ үнэхээр хайртай. Бурханы нүдэнд бид гэрлэсэн хосууд” гэж тайлбар хэлэв. “Хэрэв хоол хүнс, хувцас хунар байвал эдгээрээр сэтгэл хангалуун байж” (1Тм 6:8) энгийн амьдар гэсэн Паулын сануулгыг үл хэрэгсэн, тансаглалд амьдардаг христэч гэр бүл байлаа. Амьдралын энэхүү хэв маягаа зөвтгөхдөө тэд, “Бурханы хүмүүс сайн сайхныг хүртэх эрхтэй” гэж хэлнэ.

Эд хөрөнгө олж авахын тулд бүхнээ зориулдаг шуналтай бизнесмен байв. “Мөнгө өөрөө буруу зүйл биш. Мөнгөний хайр л бүх бузар муугийн үндэс” гэдэг амьдралын философитой. Мөнгийг хайрлаж байгаагаа тэр ерөөсөө олж харахгүй.

Хүн Библийн зөвшөөрөөгүй үндэслэлээр нүгэл хилэнцээ зөвтгөн тайлбарлах гэж оролддог. Нэгэнт Бурханы үгийг дагахгүй гэж шийдсэн бол яаж ийж байгаад шалтаг олдог.

## 11 сарын 17

*“Та нар сохрыг тахил болгон өргөж байгаа нь муу биш гэж үү? Та нар доголлон ба өвчтэйг өргөж байгаа нь муу биш гэж үү? Үүнийг захирагчдаа аваачиж өг. Тэр та нарт таатай хандах уу? Эсвэл тэр та нарыг элэгсгээр хүлээн авах уу? гэж түг түмдийн ЭЗЭН айлдаж байна.”*  
(Мал 1:8)

Бурхан тахилд ямар малыг хүсэж байсан нь тодорхой. Ямар ч толбогүй, өө сэвгүй малыг хүсэж байсан. Өөрийн ард түмнийг сүргийнхээ хамгийн шилмэлийг авчраасай гэж хүсэж байсан. Бурхан хамгийн сайныг нь хүсдэг.

Израильчууд юу хийж байсан бэ? Тэд сохор, доголлон, өвчтэй малыг өргөсөн. Шилмэл мал нь амьдаараа зах дээр өндөр үнэ хүрнэ. Эсвэл үржилд оруулбал сайн төл гаргана. Тиймээс Израилийн ард түмэн согогтой малыг өргөсөн. Энэ нь цаагуураа “Эзэнд юу ч өргөсөн хамаагүй” гэсэн утгыг агуулж байлаа.

Израильчуудын үйлдлийг хараад буруутгахаасаа өмнө өөрсдийгөө бодож үзье. Хорьдугаар зууны христитгэгч бид хамгийн сайныгаа Бурханд авчралгүй, Бурханыг үл хүндэтгэдэг юм биш биз?

Бид эд хөрөнгө хураах гэж, алдар нэртэй болох гэж, амьдралын сайхныг амтлах гэж, хотын захад тансаг байшинтай болох гэж хамаг амьдралаа зориулаад, гал халуун нас минь дууссан үлдсэн амьдралаа Бурханд өгдөг. Шилдэг чадвараа бизнес, ажил мэргэжилдээ зориулаад илүү гарсан цагаа Эзэнд ашигладаг.

Үр хүүхдээ энэ ертөнцийн төлөө хүмүүжүүлж, “Их мөнгө хураа. Сайн хүнтэй гэрлэ. Сайхан гэр оронтой бол”

хэмээн захидаг. Эзэний төлөө үйлчлэх нь хүсүүштэй амьдрал гэдэг үлгэр жишээг үр хүүхдэдээ харуулдаггүй. Илгээлтийн талбарт бусдын хүүхэд болдог, бидний хүүхэд болдоггүй.

Мөнгө төгрөгөө үнэтэй машин, тансаг завь, дээд зэрэглэлийн чийрэгжүүлэх төхөөрөмжид зориулаад илүү гарсан хэдэн зоосоо л Эзэний ажилд өргөдөг. Үнэтэй тансаг хувцас өмсдөг хэр нь Авралын Армид шавхруугаа хандивладаг.

Энэ үйлдлээрээ “Эзэнд юу ч өгсөн хамаагүй” гэж хэлж байгаа юм. Тэгсэн мөртөө өөрсдөдөө хамгийн сайныг хүсдэг. “Наад юмсаа ерөнхийлөгчдөө өгөөд үз. Тэр та нарыг таалах уу?” хэмээн Эзэн биднээс асууж байна. Ерөнхийлөгч өөрийг нь доромжиллоо хэмээн үзнэ. Эзэн ч ялгаагүй. Эзэнд бид ерөнхийлөгчид ханддаг шигээ яагаад ханддаггүй юм бэ?

Бурхан хамгийн сайныг нь хүсдэг. Бурхан хамгийн сайныг авах ёстой. Эзэнд шилдгээ өргөхөд чин сэтгэлээсээ анхаарцгаая.

## 11 сарын 18

*"Тиймээс могой мэт ухаалаг, тагтаа мэт гэмгүй бай.*

(Мт 10:16)

Мэргэн ухаантай байхын нэг чухал элемент бол хүний эвийг олох явдал юм. Христитгэгч нь хүнтэй эвтэйхэн харилцаж сурах хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, сайн харилцааг эвдэж бусниулахгүйн тулд хэлэх үг, хийх үйлдэлдээ мэдрэмжтэй хандана гэсэн үг. Хүний арга эвийг олдог хүн бусдын амьдралыг өөр дээрээ тусган авч үзээд ийм нөхцөл байдалд ямар үг, ямар үйлдэл тохиромжтой вэ гэдгийг боддог. Бусдын өнцгөөс харж, нигүүлсэнгүй үгээр ярьж, наадах цаадхыг ялгаж салгаж, дипломат хүн шиг харилцана гэсэн үг.

Харамсалтай нь итгэгчдийн дотор, хүнтэй зохистой зөв харилцаж чаддаггүй олон хүн байна. Хэдэн жишээ хэлье. Нэгэн жижиг хотод христэч үсчин байлаа. Нэг өдөр сэтгэл нь тавгүйтсэн үйлчлүүлэгч сахлаа хусуулахаар орж ирэв. Үсчин түүнийг санал дээр суулгаад хүзүүгээр нь цагаан бүтээлэг ороож, сандлыг налуулав. Таазан дээр нь “Мөнх амьдралаа та хаана өнгөрөөх вэ?” гэсэн бичиг байлаа. Үсчин сахлын хутгаа хурцлангаа сайн мэдээ ярих гэж оролдов. Тэгээд үйлчлүүлэгчээсээ “Та Бурхантай уулзахад бэлэн үү?” гэж асуув. Үйлчлүүлэгч цухалдаж, алчуурыг нь авч шидээд хөөсөө арилган гарч одлоо. Түүнээс хойш уг үсчний газраар дахиж орж ирсэнгүй.

Халуун итгэлтэй нэг оюутан шөнө дөлөөр сайнмэдээ тараахаар гарав. Харанхуй гудамжаар уруудаж явтал өмнө нь нэг эмэгтэй алхаж байхыг харлаа. Гүйцэж очихоор алхаагаа хурдасгатал эмэгтэй зугтаав. Залуу ч араас нь



гүйлээ. Эмэгтэйг хурдлахаар залуу ч хурдлав. Ингээд эмэгтэй гэрийнхээ үүдэн дээр ирээд хаалгаа онгойлгохоор түлхүүрээ гарган салгалж байтал залуу хажууд нь гүйцээд ирлээ. Эмэгтэй айсандаа хамаг чадлаараа орилов. Залуу инээмсэглээд сайнмэдээний тараах материалаа өгчхөөд яваад өгчээ. Нэг хүнд Христийн сайнмэдээг хүргэж чадлаа хэмээн баярлан өөр нэг хүний эрэлд гарсан нь тэр аж.

Өвчтэй хүнийг эргэж очиход мэргэн ухаан хэрэгтэй. “Таны бие муу харагдаж байна” эсвэл “Миний нэг танил тан шиг өвчин туссан юм. Тэр нас барчихсан” гэж хэлбэл байдлыг улам дордуулна. Ийм үгээр хүнийг тайтгаруулж болохгүй.

Хайртай хүнээ алдсан хүмүүс дээр очихдоо ч мэргэн ухаантай байх ёстой. Халдлагад өртөж амиа алдсан улс төрчийн бэлэвсэн эхнэрт “Техаст ийм явдал болох нь зайлшгүй зүйл байсан” гэж хэлсэн Техасын иргэн шиг байж болохгүй.

Бурхан минь оновчтой үгийг хэрэглэдэг, юу ярихаа мэддэг, ариун хүмүүсийг та ерөөгөөрэй. Мөн бодлогогүй ярьдаг хүмүүст хэрхэн мэргэн дипломатч шиг байхыг зааж өгөөрэй.

## 11 сарын 19

“Би чиний зовлон зүдүүр, хоосролыг...мэднэ.” (Илч 2:9)

Эзэн Есүс Ази дахь чуулгануудад илгээсэн захидалдаа долоон удаа “Би мэднэ” гэж хэлсэн. Энэ үг ерөнхийдөө тааламжтай утга агуулсан байна. “Би чиний ажил үйлсийг... зүдэл зүтгэлийг... тэвчээрийг... зовлон зүдүүрийг... үйлчлэлийг... итгэлийг мэднэ.” “Би мэднэ” гэх үг Бурханы хүмүүст асар их тайтгарал, урам зориг өгдөг.

Лехман Страус, Эзэн Есүсийн “Би мэднэ” гэх үгэнд дараах тайлбарыг бичсэн: “Эзэн Есүс *гиноскэ* гэж үгийг ашиглаагүй. *Гиноскэ* нь суралцаж мэдлэгт хүрсэн гэх утга илэрхийлнэ. Эзэн Есүс *оида* гэдэг үгийг ашигласан. *Оида* гэдэг нь ажиглалтаар бус туршлагаар, бүрэн төгс мэдэхийг хэлдэг. Зовлон амсагч ариун хүмүүсийг энэ ертөнц мэдэхгүй. Энэ ертөнц тэднийг үзэн яддаг. Харин Эзэн Есүс тэднийг мэддэг бөгөөд хайрладаг. Христ Өөрийнхнийхөө ядуурал, хавчлагыг мэднэ. Ертөнц тэднийг хэрхэн үзэж байгааг ч мэднэ. Ядарсан, зовсон, зүдэрсэн олон ариун хүн “Би мэднэ” гэх хоёрхон үгээр хүчирхэгжиж, урам зоригийг авдаг. Аврагч Эзэний минь хэлсэн энэ хоёр үг зовлон зүдүүрийг маань нураадаг. Энэ ертөнцийн зовлонг “бидэнд илчлэгдэх тэрхүү алдрын дэргэд юу ч биш” (Ром 8:18) болгодог.

Энэ үгсийг сонсохоор Эзэн биднийг ойлгодог гэсэн мэдрэмж төрнө. Бидний агуу Тэргүүн Тахилч Өөрөө зовлон амссан учраас бидний юу туулж байгааг мэддэг. Тэр зовлон амсаж, соригдож, гуниг харууслыг үзсэн билээ.

Энэ үгс зовлонг маань хуваалцаж байгааг мэдрүүлдэг. Эзэн Есүс биеийн тэргүүн учраас бусад эрхтнийхээ амсаж

буй зовлон хавчлагыг хуваалцдаг. Зүрх зүсэм зовлон бүрийг минь Эзэн Есүс хамт мэдэрдэг. Бидний юун дундуур явж байгааг Тэр тархиараа л мэддэг юм биш. Бас зүрхээрээ мэдэрдэг.

Энэ үгс тусламжийг амладаг. Тэрээр бидний Хамгаалагч учраас ачааг минь хамт үүрэлцэж, нулимсыг минь арчдаг. Тэр бидний шархыг боож өгч, дайнуудыг минь үлдэн хөөдөг.

Энэ үгс ирээдүйн шагналыг баталгаажуулдаг. Эзэн Есүстэй нэг болсноос болж юу хийж, юу амсаж буйг Тэр мэддэг. Хайр, дуулгавартай байдал, тэвчээр гаргасан үйлдэл бүхнийг минь Тэр нарийн тэмдэглэж авдаг. Хэзээ нэг өдөр Тэр бүгдийнх нь хариуг барьж, асар ихээр шагнаана.

Хэрэв та зовлонгийн хөндийгөөр яваа бол Аврагч Эзэн танд “Би мэднэ” гэж хэлж байна. Та ганцаараа биш. Тэр тантай хамт хөндийг туулж, аюул эндлээс хамгаалан явж, зорьсон газарт чинь заавал хүргэнэ.

## 11 сарын 20

*“Хэн нэг нь та нарыг Христийн дагуу биш, харин хорвоогийн язгуур юмс, хүний уламжлалын дагуух гүн ухаан [чадварлаг оюун ухаан] болон хоосон мэхлэлээр [ухаантай сонсогдох хоосон үгсээр] олзлох вий хэмээн сэрэмжлэгтүн.” (Кол 2:8)*

Филипсийн “чадварлаг оюун ухаан” (intellectualism) гэж орчуулсан үг нь эх грек дээрээ философи. Философи нь үгчилбэл “мэргэн ухааныг хайрлах” гэсэн утгатай. Өргөн утгаараа, амьдралын утга учир, үнэнийг хайх ухаан.

Ихэнх философич гүн утга агуулгатай, ойлгоход хэцүү үгсээр санаагаа илэрхийлдэг. Тэдний яриаг жирийн хүмүүс ойлгоход амаргүй. Тэд ойлгоход хэцүү үгсээр хүний бодролыг илэрхийлж, тийм зүйлсийг ойлгож ухаарахад оюун санаагаа чилээдэг хүмүүсийг татдаг.

Гэвч хүмүүн философичид бүрэн дүүрэн хариултыг өгч чаддаггүй. Филипс тэднийг “Чадварлаг оюун ухаан болон ухаантай сонсогдох хоосон үгсээр яригсад” хэмээжээ. Тэд аливаа зүйлсийн мөн чанарыг хүний өнцгөөс тайлбарлаад Христийг орхигдуулдаг. Алдартай гүн ухаантан Берtrand Рассел амьдралынхаа сүүл үед “Философи гэдэг утгагүй хоосон гэдгээ надад баталсан” гэж хэлж байжээ.

Мэргэн христитгэгч чадварлаг оюуны ухаантай сонсогдох хоосон үгсийг тоодоггүй. Тэрээр хүний мэргэн ухааны шүтээнд мөргөдөггүй. Харин мэргэн ухаан ба мэдлэгийн бүх эрдэнэс Христийн дотор байдгийг ойлгодог. Тэрээр хүмүүний бүх мэргэн ухааныг Бурханы үгээр шалгаж, Библитэй зөрчилдсөн бүхнээс татгалздаг.

Гүн ухаантнууд буюу философичид христитгэл рүү дайрч давшлахад тэр гайхаж цочирддоггүй. Философичдоос өөр зүйл гарч чадахгүй гэдгийг тунгаан дүгнэх ухаарал түүнд бий.

Гүн ухаантнууд элдвийн уран цэцэн үгсээрээ түүнийг татаж чадахгүй. Тэрээр өөрийгөө гүн ухаантнуудаас дор гэж үздэггүй. Тэдний цэцэрхлийг ч аялдан дагадаггүй. Харин хэлэх гэсэн санаагаа энгийн үгээр ойлгуулж чаддаггүйг нь хараад шогширдог. Тэгээд саймэдээ нь тэнэг хүн ч ойлгож болохуйц энгийнээр илэрхийлэгдсэнд баярлан талархдаг.

Мөн орчин үеийн гүн ухаан нь могойн өгөөш гэдгийг мэднэ. Сатан Еваг мэхлэхдээ энэ аргаа хэрэглэж “Та нар Бурхан шиг болно” (Эх 3:5) хэмээн хууран мэхэлсэн билээ. Энэ нь хүн өөрийн ухааныг Бурханыхаас дээр гэж өргөмжлөх гэсэн оролдлого юм. Ухаантай христитгэгч диаволын худал хуурмагаас татгалздаг. Тэрээр хүний цэцэрхлийг таягдан хаядаг. Бурханы мэдлэгийн эсрэг өөрийгөө өргөмжилсөн бүхнийг огоордог (2Ко 10:5).

## 11 сарын 21

*“Энэ нь Есүсийн нэрд тэнгэр, газар дээр, газрын доорх бүгд өвдөг сөгдөж, Бурхан Эцэгийн алдрын төлөө Есүс Христ бол Эзэн гэж хэл бүхэн хүлээн зөвшөөрөхийн учир ажээ.” (Флп 2:10,11)*

Ямар агуу үйл явдал вэ! Орчлон дэлхий дээрх бүх өвдөг Есүсийн ариун нэрд сөгдөнө. Хэл бүхэн Түүнийг Эзэн гэж хүлээн зөвшөөрнө. Бурхан тунхагласан учраас энэ үйл явдал заавал биелнэ.

Энд бүх хүн төрөлхтөн аврагдана гэж хэлээгүй. Дэлхийн бүх хүн эцсийн эцэст Христийг өөрсдийн хайрт Эзэн хэмээн хүлээн зөвшөөрнө гэж Паул хэлэхийг зориогүй. Харин энэ амьдрал дээр Есүс Христийг хүлээн зөвшөөрөхөөс татгалзсан хүмүүс ирээдүйд хүчээр хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүйд хүрнэ гэдгийг хэлж байна. Бүх хүн эцсийн эцэст Есүс Христийн үнэнийг хүлээн зөвшөөрнө. Бүх хүн төрөлхтөн Түүнд бууж өгнө.

Вэстминстерийн сүмд хатан хаанд титэм өмсгөх ёслолын хамгийн сэтгэл хөдөлгөм мөч нь титмийг хатан хааны тэргүүнд залахын яг өмнө нь болдог гэж Жон Скотт “Есүс бол Эзэн” номдоо бичсэн байдаг. “Кантербуригийн тэргүүн бишоп улсын, хүндэт иргэн бээр сүмийн дөрвөн зүг рүү тус бүр нэг удаа чангаар ‘Хатагтай ноёд оо, би та бүхэнд энэ улсын жинхэнэ хатан хааныг танилцуулж байна. Та бүхэн түүнийг хатан хаанаа болгох уу?’ гэж асуудаг. Вэстминстерийн сүмд ‘зөвшөөрч байна’ гэсэн үг дөрвөн удаа сонсогдохоос нааш хатан хааны тэргүүнд титмийг өмсгөдөггүй.”

Ноён Скотт цааш нь ингэж асуусан: "Хатагтай ноёд оо, өнөөдөр би та бүхэнд таны жинхэнэ Эзэн Хаан, Есүс Христийг танилцуулж байна. Та түүнийг Эзэнээ болгох уу?"

Энэ асуулт зуун зууны турш хүн бүрээс асуугдсан. Зарим нь "Есүс Христ бол миний Эзэн" гэж хүлээн зөвшөөрсөн байхад, зарим нь "Би Есүс гэдэг хүнд захирагдахгүй" хэмээн хэлсэн. Гэхдээ хэзээ нэгэн цагт нугардаггүй өвдөг нугарч, Есүс Христийг Эзэн хэмээн аргагүйн эрхэнд хүлээн зөвшөөрнө. Харамсалтай нь дэндүү оройтсон байх болно. Бурханы нигүүлслийн өдөр дуусаж, нүгэлтнүүд Аврагч Эзэнийг хүлээн авах боломж хаагдсан байна. Тэр Эзэн тэднийг аврах гэж биш, харин шүүх гэж агуу их цагаан сэнтийдээ заларсан байх болно.

Есүс өнөөдөр таны Эзэн биш бол одоо Түүнийг хүлээн зөвшөөрэй. Түүнд зүрх сэтгэлээ нээж өгөөрэй.

## 11 сарын 22

*"Хэрэв би хүмүүсийн болон тэнгэрэлч нарын хэлээр ярилаа ч надад хайр үгүй бол..." (1Ко 13:1)*

Сопран хоолойтой залуухан бүсгүй дуурийн тайзан дээр анх удаагаа дуулаад буухад нэгэн шүүмжлэгч "Түүнд хайр байсан бол жинхэнэ гайхамшигтай үзүүлбэр болох байлаа" гэж бичжээ. Дуучинд хайр байхгүй байгааг шүүмжлэгч олж харсан байна. Түүний дуулалт мэргэжлийн хувьд өө сэвгүй байсан ч халуун дулаан байдал дутаж байлаа.

Бидэнд ч ийм юм тохиолддог. Бид бүхнийг дүрмийн дагуу хийж, шударга хандаж, өгөөмөр загнаж, даруу дөлгөөн байж, эрч хүчтэй, найдвартай амьдрал хайр байхгүй үед энэ бүх сайн чанарууд яагаад ч бүрэн гүйцэд болдоггүй.

Олон хүн яаж хайрлах, яаж хайрлуулахаа ойлгох гэж их зүйлийг туулдаг. Саяхан би нэгэн алдартны тухай уншиж байтал тэрээр "Хайртай хүмүүстээ сэтгэлээ илэрхийлэхээс бусдыг юу ч байсан хийж чадна" хэмээн хэлсэн байна.

Жон Уайт "Залбирлын хүмүүс" номдоо өөрийнхөө талаар дурсан бичсэн. Үүнд: "Олон жилийн турш би хайрлуулахаас айдаг байлаа. Би бусдыг хайрлахад ер тэвдэж байсангүй. Гэвч хэн нэг хүн надад хэтэрхий их хайр халамж үзүүлэхээр сэтгэл зүрх минь хөндүүрлэдэг байсан. Хайранд яаж хандахыг гэр бүлээсээ би сураагүй ажээ. Манайхан хайр харуулах эсвэл хайрыг хүлээн авах талаар тийм ч сайн хүмүүс биш. Гэхдээ бие биеэ хайрладаггүй байсан гэсэн үг



биш. Ердөө л маш Британи араншинтай хүмүүс байж. Арван есөн насандаа гэрээ орхиж дайнд явах болоход аав минь санаанд оромгүй зүйл хийсэн юм. Тэрээр мөрөн дээр минь гараа тавиад намайг үнссэн. Би балмагдаж орхисон. Юу хэлэхээ, яахаа ч ойлгоогүй. Миний хувьд үнэхээр ичмээр санагдсан бол аавд минь гуниг төрж билээ.”

“Нэг өдөр үзэгдэл дотор Христ өмнө минь зогсож байхыг би харлаа. Хадаасны нүхтэй гараа над руу сунгаад зогсож байв. Эхэндээ би Христийн хайрыг хүлээж авах гэхээр дэндүү дорой санагдлаа. Тэгээд залбирч “Эзэн, би Таны гараас баримаар л байна. Даанч чадахгүй нь” гэж хэллээ.

“Нам гүм байдал нөмрөн авлаа. Тэгтэл өөрийгөө тойруулан барьсан хана хэрэм минь нурж унав. Ингэж л би Христийн хайрыг хүлээн авахыг сурсан юм. Тэр хайр намайг дүүргэсэн.”

Хэрэв бид өөрсдийгөө тойруулан хана хэрэм босгож, бусдын хайрыг хүлээж авахгүй эсвэл өөрсдөөсөө хайр гаргаж чадахгүй байгаа бол тэр хана хэрмийг нураахыг Эзэнд зөвшөөрч, биднийг хүйтэн хөндий итгэгч болгодог айдсаасаа чөлөөлүүлэх хэрэгтэй.

## 11 сарын 23

*"...Бачит хүмүүсийн зам бэрх." (Сур 13:15)*

Бачит хүмүүсийн зам бэрх гэдэгт баталгаа хэрэгтэй бол өдөр тутмын ямар ч хамаагүй сониныг аваад үз. Тэндээс үй түмэн баталгааг та олж харна. Би өөрөө үүнийг туршилт болгож хийж үзсэн бөгөөд тэндээс олсноо энд сийрүүлэе.

Нацист дайны гэмт хэрэгтэн мөрдөн байцаалтаас зугтаж Өмнөд Америкт 35 жил нуугдан амьдарч байгаад баригдсаныхаа дараа амиа хорложээ. Шүүхээр орж, цаазын ял сонсохоос айсан түүнд цаашид амьдрах аргагүй санагджээ.

74 настай эрийг зэвсэглэсэн гурван этгээд хулгайлж, хүүгээс нь 90,000 доллар шаардсан байна. Хүү нь зартай хар тамхины наймаачин бөгөөд одоо цагдаа болон хар тамхитай тэмцэх албаныхнаас зугтаж байгаа.

АНУ-ын төлөөлөгчдийн танхимын гишүүн, хүнд улс төрийн таатай нөхцөл амласныхаа хариуд авлигал авсан хэрэг нь илчлэгдэж, танхимын суудлаасаа огцорчээ. Тэр хүн дахиж конгресст орох эрхээ бүрэн алдсан байна.

Афганы босогчид Оросын дайчидтай тулаанаа үргэлжлүүлж байна. Афганистаны засгийн газар улсынхаа цорын ганц Христийн чуулганы барилгыг бульдозероор нураасныг сонин дурдалгүй өнгөрчээ. Оросуудын халдлага Бурханы шийтгэл байх боломжтой юу?

Цагдаагийн ахмад машинаа хулгайд алдсан хэмээн хуурамч мэдүүлэг өгчээ. Тэрээр даатгалын мөнгө авах гэж үүнийг хийсэн байна. Тэрээр нэр төртэй офицерт тооцогддог байсан бөгөөд удахгүй тушаал ахих гэж байж.

Харин одоо цагдаагийн албанаас чөлөөлөгдөж, мөрдөн байцаагдаж байгаа.

Заримдаа бид Дуулал бичээчийн нэгэн адил хорон муу хүмүүст атаархдаг. Энэ дэлхий тэдний баян бүрд мэт харагддаг. Бүх зүйл нь амжилттай байгаа юм шиг санагддаг. Гэвч тэд буруутгал, ичгүүр, айдсыг хураан авч буйг бид мартжээ. Ихэвчлэн тэд заналхийлэл, сүрдүүлгийн хохирогч болдог. Тэд өөрсдийнхөө болон гэр бүлийнхнийхээ амь насанд санаа зовдог. Тэд өөрсдийгөө хамгаалахын тулд үнэтэй хамгаалалтын систем худалдан авах шаардлагатай болдог. Мөн баривчлагдах, торгууль төлөх, шоронд орох эрсдэл дунд амьдардаг. Сайн сайхныг мөрөөдөж байсан боловч амьдрал нь хар дарсан зүүд болон хувирах нь олон.

Үүнийг сайн ухаарсан нэг хүн номлогч Сэм Жонст “Библид ‘Бачит хүмүүсийн зам хэцүү’ гэсэн нэг үг бий. Энэ үг үнэн болохыг би мэднэ’ гэж хатуухан хэлжээ.” Нүглийн үр дагавар эргэж заавал ирдэг бөгөөд хэзээ ч таатай сайхан байдаггүй. Тэр хүн үүнийг амьдралаараа үзэж ухаарсан байна.

## 11 сарын 24

*"Петр хараал тавин тангараглаж..."* (Мт 26:74)

Чуулганы нэг ахлагч цэцэрлэг дундуур ганцаараа алхаж явахдаа өнгөрсөн долоо хоногт болсон үйл явдлыг бодож байв. Эвгүй байдалд орсон мөч бодолд нь зурсхийн орж ирэхэд өөрийн эрхгүй амнаасаа хараалын үг урсгачхав. Тэгтэл чуулганых нь итгэгч цэцэрлэгт хажууханд нь алхаж явжээ. Түүнийг ахлагч анзаараагүй аж. Ахлагчийнх нь амнаас муухай бүдүүлэг үг гарсныг сонсоод итгэгч чихэндээ ч итгэсэнгүй.

Бурханы үнэнч сэтгэлтэй хүүхдүүдийн дотор хараалын үг урсгах гэх мэт тэднийг зовоож байдаг далд муу зуршил байх нь бий. Энэ нь тэдний зовлон болдог. Хэдийгээр Бурханы алдрыг гэрчлэхэд саад болж, өөрийнхөө амьдралыг ч гутааж байгааг мэдсээр байх боловч үүнийгээ яаж ч хичээгээд өөрчилж чаддаггүй. Олон зуун итгэгч энэ зүйлээсээ болоод зовж шаналсаар байдаг.

Ганцаараа үед нь (эсвэл ганцаараа байна гэж бодож байхад нь), эсвэл сэтгэлийн хүнд дарамттай үед нь нөгөө муу үгс амнаас нь уначихдаг. Заримдаа уураа барьж тэвчихээ болихоороо, заримдаа сэтгэл гутрахаараа хараал урсгаж өөрийгөө илэрхийлнэ. Чуулганы ахлагчийн хувьд эвгүй байдалд орсон ичгүүрээсээ болоод өөрийн мэдэлгүй хараал хэлчихжээ.

Энэ муу зуршлын бүр нэг муухай юм нь гэвэл, нэг өдөр олны өмнө ил болчих вий гэдэг айдас. Унтаж байхдаа ч юм уу эмнэлэгт мэдээ алдуулагч хийлгэсэн байхдаа өөрийн мэдэлгүй үүнийгээ ил болгочих вий гэдэг айдас.

Аврагч Эзэнийг яллаж байсан тэр орой Петрийн хуучин муу зуршил эргээд иржээ. Түүнийг Галилын Есүсийн хамсаатан хэмээн буруутгахад тэрээр хараал тавин Эзэнийг үгүйсгэсэн (Мт 26:74). Бүх юм тайван амгалан байхад Петр хэзээ ч ийм үг хэлэхгүй байлаа. Харин хэцүү үе ирэхэд үл итгэгч байсан үеийнх нь муухай зуршил өөрийн мэдэлгүй гараад ирэв.

Бид хамаг сайнаараа хичээж, чин сэтгэлээсээ шийдвэр гаргасан ч гэсэн бодож ч амжаагүй байхад маань муухай үгс амнаас маань урсчихдаг.

Амьдралд минь байдаг энэ Голиатыг хэзээ ч ялж чадахгүй юм гэж үү? Үгүй ээ. Бусад бүх сорилтын адил, үүнийг ч гэсэн ялж болно гэдэг амлалт бидэнд өгөгдсөн (1Ко 10:13). Нэгдүгээрт бид унах бүртээ нүглээ хүлээн зөвшөөрч, түүнээс татгалзах хэрэгтэй. Тэгээд, аманд минь манаач тавьж өгөөч гэж Бурханаас хичээнгүйлэн гуй. Амьдралын таагүй нөхцөл байдалд тайван тогтуун, чимээгүй байж чадах хүчийг Бурханаас гуй. Заримдаа өөр итгэгчид буруугаа хэлэх нь муу дадал хэвшлийг тастаж хаяхад тусалдаг. Эцэст нь хэлэхэд, бидний үгийг хэн ч сонсоогүй байсан ч, тэнгэр дэх Эцэг сонсож буйг санах хэрэгтэй. Энэ нь Бурханд ямар олиггүй харагддагийг санаж явбал өөрийгөө татаж явахад маш том тус болдог.

## 11 сарын 25

“Талархагтун.” (Кол 3:15)

Талархдаг зүрх ямар ч амьдралыг гэрэл гэгээтэй болгодог. Оройн хоолны үеэр хүүхдүүдийн нэг нь "Ээж ээ, ёстой сайхан хоол байлаа" гэж хэлэв. Энэхүү үг угаас аз жаргалтай гэр бүлд бүр ч халуун дулаан уур амьсгалыг авчрав.

Ихэнхдээ бид талархлаа илэрхийлэхдээ хойрго ханддаг. Эзэн Есүс арван уяман өвчтөнийг эдгээсэн боловч зөвхөн нэг нь талархал илэрхийлэхээр буцаж ирсэн бөгөөд тэр нь самари хүн байлаа (Лк 17:17). Эндээс хоёр зүйлийг ойлгож болно. Нэгт, нүгэлд унасан хүмүүс бидний дунд талархал гэдэг ховор үзэгдэл. Хоёрт, талархал байлаа ч, ихэнхдээ огт бодоогүй хүмүүсээс ирдэг.

Бусдад сайхан сэтгэлээр хандах үед “Баярлалаа” ч гэдэг үгийг сонсохгүй байхаар бидний сэтгэл гонсойдог шүү дээ. Тэгвэл бидэнд үзүүлсэн ач тусын хариуд талархлаа илэрхийлэхгүй байх нь бусдад ямар санагдахыг бодож үзэх хэрэгтэй.

Библийг харвал Бурханд талархаж бай гэж олон удаа ятгаж, олон жишээгээр хэлжээ. Бурханд талархах олон шалтгаан бидэнд бий. Бүгдийг нь энд дурдах боломжгүй юм. Бидний бүх амьдрал Түүнд талархах дуулал байх ёстой.

*Түм буман бэлгүүдийн хариуд*

*Түүнд өдөр бүр талархаж амьдаръя*

*Баяртайгаар бэлгүүдийг нь амтлахад*

*Баярлаж талархах сэтгэл хэрэгтэй*

Бид бие биедээ талархлаа илэрхийлэх хэвшлийг хөгжүүлэх хэрэгтэй. Халуунаар гар барих, утсаар холбогдох, захидал бичих – ийм жижигхэн зүйлс ч гэсэн ямар их урам зориг өгдөг гэж санана! Настай эмч өвчтөнүүдийнхээ нэгнээс төлбөрийн хамт талархлын захидал хүлээн авав. Тэрээр энэхүү захидлыг шагнал урамшууллынхаа дунд хадгалжээ. Энэ нь түүний авсан анхны талархал байлаа.

Бэлэг авах, зочлуулах, үнэгүй хүргүүлэх, багаж хэрэгслээ түр хэрэглүүлэх, ажилд минь туслах, сайхан сэтгэл хүлээн авах, үйлчилгээ үзүүлэх – бидэнд үзүүлсэн ач тус бүхэнд бид талархлаа даруй илэрхийлж байх хэрэгтэй.

Харамсалтай нь бид эдгээр зүйлийг авах албатай юм шиг санадаг. Эсвэл бид суугаад захиа бичиж ер сураагүй ажээ. Хэрэв тийм бол талархах дадлыг хөгжүүлцгээе. Өөрсдийгөө талархалд сургацгаая. Талархах боломжийг алдалгүй ашиглаж, талархлаа илэрхийлж байцгаая.

## 11 сарын 26

*"Алсын хараа байхгүй аваас ард түмэн журамгүй. Харин хуулийг сахигч нь жаргалтай."* (Сур 29:18)

Өнөөдрийн эшлэлийн эхний хэсэг: “Алсын хараа байхгүй аваас ард түмэн журамгүй.” Хүмүүс хийж буй зүйлдээ тодорхой зорилго чиглэлтэй байх ёстой гэдэг утгаар энэ үгийг ихэвчлэн тайлбарладаг. Өөрөөр хэлбэл, ямар үр дүнд хүрэхээ зураглан харж чаддаг, түүндээ хүрэх алхам, хөтөлбөрүүдийг тодорхойлсон байна гэсэн үг.

Гэвч алсын хараа гэдэг үг нь энд “Бурханаас ирдэг илчлэл” гэсэн утгатай. Тэгэхээр Бурханы үгийг эс мэддэг, үл хүндэлдэг газар хүмүүс зах замбараагүй болдог гэсэн санаа харагдаж байна.

Эшлэлийн хоёр дахь хэсэгт эсрэг утгыг дүрсэлжээ: “Харин хуулийг сахигч нь жаргалтай.” Нэг үгээр хэлбэл, Бурханы бичмэл үгэнд илчлэгдсэн Бурханы хүслийг дагах нь ивээгдэж ерөөгдөх зам юм.

Эшлэлийн эхний хэсгийг тунгаан ярилцацгаая. Бурханы мэдлэгийг огоорсон газар хүмүүсийн явдал үйлийг хязгаарлах хэм хэмжээ байхгүй болно. Жишээлбэл, Бурханаас эргэсэн үндэстэн байна гэж бодъё. Тэд бүхнийг эволюцын үйл явцаар тайлбарладаг. Тэгэхээр хүн гэгч нь цэвэр байгалийн шалгарлын үр дүн бөгөөд тэнгэрлэг Нэгэний бүтээл биш болно. Энэ үнэн бол ёс суртахууны хэм хэмжээг тогтоох ямар ч суурь үндэслэл олдохгүй. Бидний гаргаж байгаа үйлдэл бүхэн байгалийн үйл явцын үр дүн болох юм. Ланн, Линн нар “Шинэ ёс суртахуун” номдоо энэ санааг тодотгож, “Хэрэв ямар ч амьдрал оршдоггүй гараг дээр анхны амьд эс цэвэр байгалийн үйл



явцаар бий болж, хүмүүний оюун санаа галт уулын адил байгаль хийгээд материйн хүчээр үүссэн юм бол Өмнөд Африкийн улс төрчдийг арьс өнгөний үзэл гаргасан гэж буруутгах нь галт уулыг халуун хайлмаг гаргасан гэж буруутгахтай яг адилхан утга учиргүй зүйл болно” гэж бичжээ.

Бурханы үгийг орхигдуулбал зөв буруугийн хэм хэмжүүр үгүй болно. Ёс зүйн хэм хэмжээ нь тухайн хүмүүсийн үзэмжээр тогтоогдоно. Хүмүүс өөрөө өөрсдийнхөө үйлдлийн шүүгч болно. “Сайхан санагдаж байвал хий” гэдэг үзэл санаа дэлгэрнэ. Хүн бүр хийж байвал зөв гэдэг үзэлтэй болцгооно.

Тэгэхээр хүмүүс эмх журамгүй болно. Тэд садар самуун, завхайрал, ижил хүйстний харилцаа, гэмт хэрэг, хүчирхийлэлд өөрсдийгөө гаргуунд нь тавина. Авлига, хээл хахууль төр засаг, бизнесийн салбарт тархаж, худал хуурмаг жирийн үзэгдэл болж, нийгэм бүхэлдээ ялзралд автана.

“Харин хуулийг сахигч нь жаргалтай.” Бүх дэлхий эмх журамгүй болсон ч итгэгч хүн Бурханы үгэнд итгэж, Бурханы үгийг дуулгавартай дагаснаараа аз жаргалыг олж чадна. Явах ёстой цорын ганц зам энэ мөн.

## 11 сарын 27

*“Би удахгүй ирнэ.”* (Илч 22:20)

Христ хэзээ ч ирж магадгүй гэсэн итгэл найдварыг олон хүн гээнэ. Энэ бол үеийн төгсгөлийн нэг шинж. Гэхдээ энэ үнэнээс хүмүүс зуурсан ч, эс зуурсан ч үнэн хөдөлшгүй.

Эзэн Есүс хэдийд ч ирж магадгүй. Сүйт залуу Өөрийн сүйт бүсгүйг авахаар эргэн ирэх цаг өдрийг бид мэдэхгүй. Тэр одоо ч ирж болно. Түүний уухай, тэргүүн тэнгэрэлчийн дуу, Бурханы бүрээ сонсогдохын өмнө биелэх ёстой зөгнөл гэж байхгүй. Чуулган энэ дэлхий дээр байхдаа зовлон амсдаг нь үнэн боловч их гамшиг, зовлонгийн үеийг үзэхгүй. Чуулган их зовлонгийн үеийг туулах байсан бол Эзэн дор хаяж долоон жилийн дараа ирнэ гэсэн таамаглал төрнө. Яагаад гэвэл их зовлонгийн үе долоон жил үргэлжлэх юм. Мэдээж бид их зовлонгийн үед амьдраагүй.

Библид Аврагч Эзэн хэзээ мөдгүй, хэдийд ч ирж магад гэж номлосон олон эшлэл байна. Заримыг нь эш татъя:

“Урьд бидний итгэсэн үеэс аврал одоо бидэнд улам ойрхон байна” (Ром 13:11).

"Шөнө өнгөрч, өдөр ойртов" (Ром 13:12).

"Эзэн ойрхон байна" (Флп 4:5).

"Учир нь айсуй Нэгэн тун удалгүй ирнэ. Эс саатна" (Евр 10:37).

“Эзэний ирэх ойртсон тул зүрхээ чангал" (Иак 5:8).

"Харагтун, шүүгч үүдэн дээр зогсож байна" (Иак 5:9).

"Бүх юмсын төгсгөл ойр ирчхээд байна" (1Пт 4:7).

Энэ эшлэлүүд “Эзэн хэзээ ч хамаагүй ирэх юм байна” гэсэн сэтгэгдлийг бидэнд төрүүлэх зорилготой. Эзэний

ирэлтийг бид харуулдан хүлээх ёстой юм. Эзэнийг ирэх үед бид үйлчлэлийг нь хийгээд зав чөлөөгүй байж, хариуцуулсан зүйлсийг нь итгэмжит нярвын адил зарцуулж байх ёстой.

Р. А. Торри нэгэнтээ ингэж хэлжээ: “Ариун шударга, хувиа хичээгээгүй, сүсэгтэй, ертөнцөөс тусгаарлагдмал, үйлчлэлд идэвхтэй амьдрах Библийн дагуух үндэслэл маань, Эзэн Есүсийг хэзээ ч байсан ирж магад гэх найдвар юм. Олон номлогч, үхэл хэзээ ирэх нь тодорхойгүй учраас ариун амьдарч, хичээл зүтгэлтэй ажилла хэмээн хүмүүсийг ятгадаг нь Библийн үндэслэл биш. Библи үргэлж ‘Христ ирж байна. Түүнийг ирэхэд бэлэн бай’ гэж ятгадаг.”

Бидний үүрэг тодорхой. Бэлхүүс минь бүслээстэй, дэнлүү минь асаатай байх ёстой. Бид Эзэнээ хүлээж буй хүмүүс шиг байх ёстой (Лук 12:35,36-г үз). Эзэн Есүсийг хэзээ мөдгүй ирнэ гэж номлодоггүй хүмүүсийн үгэнд үл хууртацгаая. Түүний оронд, Эзэнийгээ өнөөдөр ч байсан ирж магад хэмээн итгэж, Эзэн өнөөдөр ч ирж магад хэмээн гал халуунаар номлож, энэ сургаалыг амьдралдаа тод гэрэлтүүлцгээе.

## 11 сарын 28

*"Бурханы нигүүлслээр би одоогийн би болсон."* (1Кo 15:10)

Хүн бусдыг дуурайх гэж оролдохоороо өөрөө өөрийнхөө амьдралыг зовлон болгодог. Хүн бүхэн Бурханы онцгой бүтээл. "Бурхан биднийг бүтээхдээ ашигласан хэвээ дахиж ашиглалгүй хаячихсан" гэдэг үг ч байдаг шүү дээ. Бурхан биднийг өөр хүн байлгахыг хүсдэггүй.

"Таныг өөр хэнтэй ч адилтгах аргагүй. Яагаад гэвэл энэ дэлхий дээр тан шиг хүн байхгүй. Та цорын ганц. Та хувь хүн. Та онцгой. Та өөр хүмүүстэй адил болж чадахгүй. Өөр хүнтэй адил болохоор ч бүтээгдээгүй. Бусад хүн ч тантай адил байх албагүй." (Максвел Молц)

Бурхан нэг стандарт хүнийг бүтээгээд бүгдийг нь тэр хүний хэвээр хувилаагүй. Бурхан хүн бүрийг тусгайлан бүтээсэн бөгөөд цасны ширхэг бүр адилгүй байдаг шиг хүн бүр адилгүй.

Хүн бүр Бурханы мэргэн ухаан ба хайрын бүтээгдэхүүн. Тэр биднийг бүтээж байхдаа юу хийж байгаагаа мэдэж байсан. Бурхан бидэнд хамгийн сайныг өгсөн нь одоогийн бидний дүр төрх, зан чанар, авьяас чадвар юм. Хязгааргүй мэдлэг, хязгааргүй хайрыг эзэмшдэг Бурханаас өөр нэгэн байсан ч ингэж л хийх байсан.

Тэгэхээр бусдыг дуурайх гэж, өөр хүн байх гэж хүсэх нь Бурханыг доромжилсонтой адил. Энэ нь Бурханыг алдаа гаргасан гэснээс ялгаагүй бөгөөд намайг бусдаас дутуу бүтээсэн гэж хэлэхтэй адил.

Өөр хүн шиг болох гэж шунах нь биелшгүй мөрөөдөл. Бурхан биднийг яг одоогийн байдлаар нэгэнт бүтээчихсэн учраас өөр болгох боломжгүй болсон. Мэдээж бид бусдын сайхан чанаруудыг дуурайж болно. Гэхдээ энд би Бурханы бүтээл гэдэг талаас нь ярьж байна.

Бидний амьдралд өгсөн Бурханы хүсэл төлөвлөгөөнд сэтгэл дундуур байвал өөрсдийгөө бусдаас доогуур мэт мэдэрч, үр дүнтэй амьдарч чадахгүй болно. Бусдаас доогуур гэдэг асуудал энд байхгүй. Бид бусдаас дорд дутуу биш. Зүгээр л бусдаас өөр.

Өөр хэн нэгэн болох гэж оролдох нь эцэстээ амьдралаа сүйрүүлнэ. Зүрхний оронд хуруу ажиллавал яах бол? Бурхан ингэж төлөвлөөгүй учраас хэзээ ч бүтэхгүй.

Хамгийн зөв хандлага болбоос Паулын нэг адил “Бурханы нигүүлслээр би одоогийн би болсон” гэж хэлэх (1Ко 15:10). Бурханы өгсөнд баярлан талархаж, хэн байгаагаараа, Бурханаас юуг авснаараа Бурханы алдрын төлөө хамаг чадлаараа үйлчилцгээе. Бидний чадахгүй зүйлс байдаг нь үнэн. Гэхдээ бусдын чаддаггүй, бидний чаддаг зүйлс байдаг юм шүү.

## 11 сарын 29

*"Би юуг ч Өөрөөсөө үйлдэж чадахгүй." (Иох 5:30)*

Иохан 5-р бүлэгт Эзэн Есүс хоёр удаа “Би юуг ч Өөрөөсөө үйлдэж чадахгүй” гэж хэлсэн. Эхнийх нь 19-р эшлэлд гарна: “Үнэнээр үнэнээр Би та нарт хэлье...Хүү юуг ч Өөрөөсөө хийдэггүй.” Хоёр дахь нь 30-р эшлэлд гарна: “Би юуг ч Өөрөөсөө үйлдэж чадахгүй.”

Энэ хоёр эшлэлийг эхлээд уншихаар урам хугарч магадгүй. Есүс бидний нэгэн адил хязгаарлагдмал байсан гэж үү? Тэр Бурхан юм бол бүхнийг чадагч байх ёстой биш үү? “Би Өөрөөсөө юуг ч хийж чадахгүй” гэж Тэр яагаад хэлсэн юм бэ? Үнэндээ сайнмэдээний дайснууд энэ эшлэлийг ашиглаад Есүсийг жирийн л нэг хүн байсан гэж нотлохыг оролддог.

Гэхдээ илүү нарийн үзээрэй. Эзэн Есүс биеийнхээ хүч чадлын тухай яриагүй. Харин Эцэгийнхээ хүсэлд хамаг сэтгэлээ зориулсан учраас Өөрийн дураар юуг ч хийж чадахгүй гэж хэлсэн байна. Тэрээр Өөрийн хүслээр юуг ч хийж чаддаггүй төгс ёс суртахуунтай Нэгэн байжээ. Тэрээр Бурханы хүслээс ангид юуг ч эс хүснэ.

Та бид хоёр бол “Юуг ч өөрөөсөө хийж чадахгүй” гэж хэлэх боломжгүй хүмүүс. Учир нь бид ихэвчлэн Эзэнээс хамааралгүй өөрсдийн дураар үйлддэг. Бид Эзэнтэй зөвлөлдөхгүйгээр шийдвэр гаргаж, нүгэл үйлдэж буйгаа мэдсээр байж сорилтод орж, өөрийн хүслийг Бурханыхаас дээгүүрт тавьдаг. Эзэн Есүс хэзээ ч ийм юм хийж чадахгүй байлаа.

Тэгэхээр дээрх эшлэл Есүс Христийг сул дорой, хязгаарлагдмал гэж харуулаагүй. Харин эсрэгээрээ төгс

төгөлдөр болохыг нь харуулжээ. Эшлэлийг бүхлээр нь уншвал энэ санаа бүр тодорхой харагдана. 19-р эшлэлд “Эцэгээс хийж харуулсныг нь л Хүү хийхээс, Хүү юуг ч Өөрөөсөө хийдэггүй. Учир нь Эцэг юу хийнэ, Хүү нь бас эдгээрийг түүнчлэн хийдэг” гэж Есүс хэлжээ. Өөрөөр хэлбэл, Хүү Эцэгээс хамааралгүйгээр бие дааж ямар ч үйлдэл хийдэггүй гэсэн үг. Эцэгийн хийдгийг л хийнэ. Энэ үгээрээ Есүс Өөрийгөө Бурхантай адилтгажээ.

Дараа нь 30-р эшлэлд “Би юуг ч Өөрөөсөө үйлдэж чадахгүй. Би сонссоноороо шүүх бөгөөд шүүлт минь шударга. Учир нь Би Өөрийнхөө хүслийг бус харин Намайг Илгээгчийн хүслийг хайдаг” гэж Есүс хэлсэн. Өөрөөр хэлбэл, Эзэн Есүс Эцэгээсээ хүлээн авсан зааврын дагуу шийдвэр гаргадаг бөгөөд Бурханы хүсэлд бүрэн захирагддаг учраас шийдвэрийг нь Бурхан зөв болохыг баталдаг гэсэн үг.

Ж. С. Бакстер, Иохан 5-р бүлгийг судлаад Христ Өөрийгөө Бурхантай энэ тэнцүү хэмжээнд тавьсан долоон мэдэгдэл байгааг тогтоожээ. Ижил үйлстэй (19-р эшлэл), ижил мэдлэгтэй (20-р эшлэл), үхэгсдийг амилуулах адил эрх мэдэлтэй (21,28,29-р эшлэл), шүүх адил эрхтэй (22,27-р эшлэл), ижил хүндлэлийг хүртдэг (23-р эшлэл), хүнийг дахин төрүүлэх ижил эрхтэй (24,25-р эшлэл), ижил амьтай (26-р эшлэл). Бидний Аврагч хязгаарлагдмал, сул дорой энгийн нэгэн бүтээл биш, махан биеэр үзэгдсэн бүхнийг чадагч Бурхан мөн.

## 11 сарын 30

*"Нэг нэгнийхээ ачаанаас үүрэлц. Тийнхүү Христийн хуулийг хэрэгжүүлэгтүн... Учир нь хүн бүр ачаагаа үүрнэ."*  
(Гал 6:2,5)

Энэ хоёр эшлэлийг өнгөцхөн уншвал хоорондоо зөрчилтэй мэдэгдэл мэт санагдана. Эхнийх нь, нэг нэгнийхээ ачаанаас үүрэлц гэсэн бол, хоёр дахь нь, өөрийнхөө ачааг үүр гэж хэлжээ.

Хоёрдугаар эшлэлд “ачаа” гэж орчуулагдсан үг нь сүнс, сэтгэл, оюун санаа, бие махбодын хувьд дарамт учруулах аливаа ачааллыг хэлж байна. Хам сэдвийг нь харвал гэм нүгэлд унаж, буруутгал зэмлэлийн хүнд ачаа үүрсэн хүнтэй холбогдож байна (1-р эшлэл). Ийм ах дүүдээ хайрын гараа сунгаж, түүнийг Бурхан руу эргүүлж, Бурханы хүмүүсийн нөхөрлөлд оруулж ирэхэд тусалснаар ачаанаас нь бид үүрэлцэнэ. Гэхдээ ачаа гэдэг нь зөвхөн үүгээр хязгаарлагдахгүй. Амьдралд ирдэг зовлон, бэрхшээл, шаналал, өвдөлт бүхэн ачаа юм. Нэг нэгнээ урамшуулж, тайтгаруулж, бие биедээ материаллаг зүйлсээ хуваалцаж, барьж босгох зөвлөгөө өгснөөр бусдынхаа ачаанаас бид үүрэлцдэг. Өөрсдөөс минь их золиос гарах байсан ч бусдынхаа асуудалд санаа тавина гэсэн үг. Үүнийг хийснээрээ “Бие биеэ хайрла” гэсэн Христийн хуулийг биелүүлнэ. Бид хэрэгтэй цагтаа тусламж авч, хэрэгцээтэй нэгэндээ тусламж үзүүлснээрээ хайрыг бодитоор харуулж чадна.

Тавдугаар эшлэлд гарч буй “ачаа” нь эх хэл дээрээ 2-р эшлэлийнхээс өөр үг байна. Энэ нь үүрч явдаг ямар нэг зүйлийг хэлнэ. Хүнд эсвэл хөнгөн байхыг яриагүй. Хүн



бүр Христийн шүүх суудлын өмнө үүрэг хариуцлагынхаа ачааг үүрнэ гэж Паул хэлж байгаа юм. Тэгэхээр энэ ачааг бусдынхтай харьцуулах шаардлагагүй. Бид өөрсдийнхөө үйлсийн дагуу шүүгдэж, өөрсдийнхөө үйлсийн дагуу шагналаа авна.

Энэ хоёр эшлэл юугаараа холбогдож байна вэ? Нүгэлд унасан ах дүүгээ сэргээх үйлчлэл хийж буй хүн магадгүй өөрийгөө илүү сүнслэг, илүү ариун хэмээн санаж магадгүй. Унасан ах дүүгийнхээ ачааг үүрэлцэж байхдаа өөрийгөө арай дээгүүр түвшний хүн хэмээн эндүүрч болзошгүй юм. Өөрийгөө нүгэлд унасан ах дүүтэйгээ харьцуулах эрсдэлтэй. Паул түүнд сануулж байна: “Тэр Эзэний өмнө зогсдог. Тэр хийсэн үйл, гаргасан зан чанарынхаа төлөө Эзэнд өөрөө тайлагнана. Бусдын өмнөөс тайлагнахгүй. Тэр өөрийнхөө ачааг өөрөө үүрэг.”

Тиймээс энэ хоёр эшлэл бие биеэ үгүйсгэдэггүй. Харин ч хоорондоо төгс уялдаж байна.

## 12 сарын 1

*"Чамайг амьдруулахаар Бурхан ЭЗЭНээс чинь чамд өгч буй аль нэгэн хотод...чи үүнийг сураглаж, эрж, сайтар асуугаад, тийм жигшүүрт юм та нар дунд гарсан нь үнэн байвал..." (Дх 13:12,14)*

Израилийн аль нэг хот Бурханыг орхиж, хуурамч шүтээн рүү эргэсэн тухай цуурхал тарвал шийтгэлийн арга хэмжээ авахаасаа өмнө эхлээд сайтар нягтлан шалгах ёстой гэж Бурханы хуульд заажээ.

Бид ч гэсэн элдвийн цуу яриа, хов живд хөнгөн хандаж болохгүй. "Энэ үг баримттай юу? Би судалж үзсэн үү? Би шалгасан уу? Нэг бүрчлэн асуусан уу? Энэ үг үнэн үү? Хөдөлшгүй юу?" гэж бид өөрөөсөө асуух хэрэгтэй.

Итгэл үнэмшлийн хүрээлэлд заримдаа сонсогддог янз бүрийн мэдээ цуурхалд ийм сэрэмжтэй няхуур хандвал тустай. Хэдэн жишээ хэлье.

Хэдэн жилийн өмнө, Иерусалимд сүм барих чулуунуудыг Нью Йоркийн боомтод хадгалж байгаа бөгөөд зохистой цаг нь ирэхээр Израиль руу тээвэрлэхээр бэлдсэн байгаа гэсэн мэдээ тархсан. Тэдгээрийг Индиана мужийн шохойн чулуу гэсэн мэдээ гарч байлаа. Христитгэгчид энэ мэдээг баяр хөөртэйгөөр тараасан. Харамсалтай нь мэдээ худал болох нь удахгүй батлагдаж олны урмыг хугалсан.

Бас хэдэн жилийн өмнө, эрдэмтэд хүн төрөлхтний түүхийн хуанлитай холбоотой өгөгдөл мэдээллийг компьютерт оруулахад үр дүнд нь Йошуагийн түүхэнд гардаг нар жаргаагүй өдрийн түүх батлагдсан гэх мэдээ тарсан. Библийг батлах хүсэлдээ автсан итгэгчид энэ тухай

сонин сэтгүүлд бичиж, амаараа ч олон хүнд тараажээ. Гэвч энэ түүх мөн л худал болох нь батлагдсан.

Саяхан хэсэг хүмүүс математикийн тооцоолол хийгээд олны танил нэг хүнийг анти-христ болохыг баталлаа гэгцээсэн. Тухайн хүний нэрийн үсгүүд тоон утга илэрхийлнэ гэж тэд үзсэн байна. Тэгээд үржих, хуваах, нэмэх, хасах үйлдэл хийгээд 666 гэсэн тоо гаргажээ. Мэдээж энэ ямар ч утгагүй мэдэгдэл. Иймэрхүү математикийн тооцооллоор хэний ч нэрээс 666 гэсэн тоо гаргаж ирж болно.

Миний уншсан нэг тараах материалд Чарльз Дарвин амьдралынхаа сүүлийн мөчид эволюцын онолоос татгалзаж Библид итгэдэг боллоо гэсэн байсан. Энэ үнэн ч байж магад. Үнэн байгаасай гэж би хүсэж байна. Хэзээ нэг өдөр үнэн гэдгийг нь нотлох баримт олж юу магад. Гэхдээ одоогийн байдлаар түүхийн ямар ч материалаас энэ мэдэгдлийг батлах баримт би олоогүй. Тиймээс ч энэ мэдэгдлийг хүмүүст ярьж явахыг хүсээгүй.

Өнөөдрийн эшлэлд гарч байгаа шиг, аливаа мэдээлэлд нухацтай хандаж, "Энэ үг баримттай юу? Би судалж үзсэн үү? Би шалгасан уу? Нэг бүрчлэн асуусан уу? Энэ үг үнэн үү? Хөдөлшгүй юу?" гэж шалгаж нягталдаг байсан бол олон удаа ичгэвтэр байдалд орохоос өөрсдийгөө аварч, христитгэлийг утгагүй хоосон яриа болгож харуулах олон тохиолдлоос хамгаалах байв.

## 12 сарын 2

*"Дуулал, магтуу ба сүнслэг дуунуудаар өөр хоорондоо ярилцаж, Эзэнд хандаж зүрхэндээ дуулж, ая дуу зохио."*  
(Еф 5:19)

Энэ эшлэлд дууг Ариун Сүнсний дүүргэлттэй холбож, Ариун Сүнс дүүрэх үед хүнээс дуу дуулал гардаг гэж бичжээ. Түүхэнд тохиолдсон агуу сэргэлтүүдээс үргэлж дуу төрөн гарсан байдаг нь ч ийм учиртай. Уэлсийн сэргэлт үүний тодорхой нэг жишээ юм.

Христигэгчид шиг олон дуутай, дуулал, магтуу, сүнслэг дууны баялаг өв сантай ард түмэн дэлхийн хаана ч байхгүй. Магтан дуу нь үгээр илэрхийлж чадахгүй мэдрэмжийг маань илэрхийлдэг агуу хэл юм. Зарим магтан дуу нь туршлагаас минь давсан бодлуудыг илэрхийлдэг. "Бүхнээ би Есүст өргөө" гэх мэт үнэнч сэтгэлийн тухай сайн магтан дуунууд байна. Энэ магтан дуунуудаар бид зүрхнийхээ бялхалтыг илэрхийлэн дуулж чаддаг.

Сүнслэг дуунуудад хэмнэл, хөгжим, хоршил тийм чухал биш. Гол нь зүрхнээс гарч байгаа үг, Ариун Сүнсний хүчээр Бурханд очих нь чухал. Мэрри Бовлери энэ тухай дуундаа өгүүлжээ:

*Хэчнээн сайхан аялгуу дуу байлаа ч  
Христ Эзэнд чухал биш гэдгийг би мэднэ  
Зөвхөн Ариун Сүнсний заасныг л  
Зүрхнээсээ дуулах нь Танд эшиглэнтэй*

Бурханы Сүнс дууг Библийн номлол шиг ашиглаж чаддаг. Граттан Генисийн ээж гол руу үсэрч амиа хорлох гэж явахдаа газар хагалж буй тариачин эрийн дуулахыг сонсоод амиа хорлохоо больжээ. Хожим нь доктор Генис:

"Эгэл жирийн ажлаа хийж байхдаа Эзэний магтаалуудыг дуулж байсан тэрхүү даруу христитгэгч тариачинд би өртэй учраас бүхнээ Бурханд зориулна" гэж хэлсэн байна.

Христэч хөгжмийн үйлчлэл хийдэг хүмүүс хоёр туйлшралаас болгоомжлох хэрэгтэй. Нэг нь, өөрийгөө өргөмжлөх явдал. Ямар ч үйлчлэлд өөрийгөө өргөмжлөх хандлага орж ирэх аюул бий. Эзэний алдрыг дуулж, Бурханы хүмүүст ивээл ерөөл болохын оронд, авьяас чадвараараа хүмүүсийг гайхшируулах хүсэл үргэлж төрж байдаг.

Хоёр дахь нь, бусдыг босгон байгуулах биш, хөгжөөн цэнгээх аюул. Хөгжим дуугаар дамжуулан сонсогчдод Бурханы үгийг дамжуулах бус, хөгжмийн уран чадварт тулгуурласан магтан дуу болох аюул. Хүмүүсийн сэтгэл зүрхийг дуугаар хөөргөх боловч бидний хайрладаг Эзэнд ямар ч үнэ цэнэгүй, утга учиргүй, ач холбогдолгүй дуунууд төрөн гарах боломжтой.

Улс үндэстнүүдийн соёл бүхэн хөгжмийг өөр өөрөөр мэдэрдэг. Гэхдээ ямар ч соёл байсан, магтан дуу нь эрүүл сургаалтай, хүндэтгүүштэй, хүмүүсийг Сүнсээр босгон байгуулдаг байх ёстой.

## 12 сарын 3

*"Биднийг хавчиж байсан хүн, тэр үед устгах гэсэн итгэлээ эдүгээ өөрөө тунхаглаж байна."* (Гал 1:23)

Тарсын Саул Христэд итгэжээ. Тэрээр христитгэлийг хавчигсдын манлайд явж байснаа, тэрхүү итгэлээ халуун сэтгэлээр номлож, хамгаалдаг болсон гэж Иудейн чуулганууд сонсоцгоов. Үнэхээр сэтгэл хөдөлгөм өөрчлөлт болжээ.

Паулын адил үгүйсгэж байсан итгэлээ өмгөөлөн хамгаалдаг болсон гайхалтай өөрчлөлтүүд өнөө цагт ч болдог.

Лорд Литтелтон, Гилберт Уэст нар Библийг өмгөөлдөг хүмүүсийн итгэлийг нураахаар хатуу шийдэцгээв. Литтелтон, Саулын Христэд итгэсэн түүхийг няцаах зорилго тавив. Уэст болохоор Христийн амиллыг үлгэр домог гэж батлахыг зорьсон. "Тэр хоёр хоёулаа Библийн тэмдэглэлүүдийг сайн мэддэггүй ч няцаахаар шийджээ. Тэгээд баримт материал цуглуулахаар судалгаа хийж эхлэв. Судалгааныхаа ажлын үеэр үе үе хоорондоо уулзалдана. Нэг удаагийн уулзалтад дээр Литтелтон, 'Энэ итгэл үнэмшилд ямар нэг юм байх шиг байна. Сүүлийн үед надад тэгж санагдах боллоо' гэж хэлэв. Уэст хариуд нь, 'Надад ч гэсэн тэгж санагдах болсон' гэлээ. Эцэст нь энэ хоёр хүн уулзаад ярилцтал хоёулаа үгүйсгэж байсныхаа эсрэг утга санаатай ном бичсэн байлаа. Тэд хуулийн мэргэжилтний хувиар бүх баримт материалтай танилцаж үзэхэд Библийн тэмдэглэл алдаа мадаггүй үнэн зөв болохыг өөрийн эрхгүй хүлээн зөвшөөрцгөөжээ" (Фредрик П. Вүүд). Лорд Литтелтоны ном "Паулын Христэд итгэсэн үнэн баримт"

нэртэй. Гилберт Уэстийн ном "Есүс Христийн амилал" нэртэй. Үл итгэгч Роберт Г. Ингерсол, агностик үзэлтэй Лью Уаллсыг Есүс Христийн тухай тэмдэглэл худал болохыг нотолсон ном бичээч хэмээн санал тавьсан байна. Уаллс методист эхнэрээ зовоон байж олон жил судалгаа хийв. Тэгээд номоо бичиж эхэлжээ. Номынхоо дөрөвдүгээр бүлгийг дуусахын алдад Христийн тухай тэмдэглэлүүд үнэн гэдгийг ухаарч эхлэв. Тэрээр өвдөг сөгдөн гэмшиж, Есүс Христийг Эзэн ба Аврагч хэмээн итгэжээ. Тэрээр Христ бол Бурханы Хүү мөн гэх утгатай "Бен Хур" номоо бичиж хэвлэн гаргасан юм.

Фрэнк Морисон, Есүс Христийн талаар зохиол бичихийг хүссэн байна. Гэвч тэр гайхамшигт итгэдэггүй болохоор загалмайд цовдлогдсон өдөр хүртэлх долоон өдрийг номдоо оруулахаар төлөвлөв. Тэгээд судалгаа хийж эхлэв. Гэвч үйл явдлыг цааш дахиад бага зэрэг сунгах хэрэгтэй болж, Есүс Христийн амиллын талаар номдоо оруулахаар шийдэв. Ном бичих явцдаа Есүс Христ үнэхээр амилсныг баттай мэдээд Есүс Христийг Аврагч Эзэнээ болгон хүлээн авчээ. Тэгээд "Хэн чулууг хөдөлгөсөн бэ?" нэртэй ном гаргасан. Номын эхний бүлэг нь "Бичмээргүй байсан ч бичигдсэн ном" гэсэн гарчигтай.

Библийн үг амьд бөгөөд эрх мэдэлтэй. Хоёр талдаа иртэй илдээс ч хурц. Библи өөрөө өөрийгөө баталдаг. Библийг дайрч давшилж, гутаан доромжилдог хүмүүс магадгүй нэг өдөр Библид итгэж, Библийн өмгөөлөгч болохыг үгүйсгэх аргагүй.

## 12 сарын 4

*"Би түүнийг мэргэн ухаан, ойлголт, мэдлэг, бүх талын ур чадварт Бурханы Сүнсээр дүүргэсэн."* (Гэт 31:3)

Өнөөдрийн эшлэлд майхан сүмийг барих авьяас чадварыг Ариун Сүнснээс авсан Безалелийн тухай гарч байна. Тэрээр алт, мөнгө, хүрлээр урлах, чулуу зүсэх, янзлах, модны ажил хийх бэлэг авьяастай байлаа. Бурханы Сүнс түүнд энэ төрлийн ажлыг хийх мэргэн ухааныг өгчээ.

"Ариун Сүнсний үйлчлэлүүд дотроос яг энэ талбарыг бид орхигдуулж боддог. Үйлдвэр, албан газар, гэр орныхоо өдөр тутмын ажилд бид Ариун Сүнсний тусламжаар ажиллах боломжтой. Үйлдвэрийнхээ ажлын байрыг индэр мэт ашигладаг нэг залууг би мэднэ. Марта гэдэг бүсгүй гал тогоогоо итгэгчдийн нөхөрлөлд зориулдаг. Өөр нэг хүн оффисын ширээгээ Эзэний ажлыг хийхэд ашиглаж, ажлын байран дээрээ Бурханыг гэрчилж, заваараа ном бичдэг. Энэ мэт олон жишээг дурдаж болно." (Э. Трамп)

Израилийн Назар хотод гол төлөв арабчуудад үйлчилдэг христэч эмнэлэг байдаг. Эмнэлгийн подвалд сүм цуглааны үйл ажиллагаа болно. Гэхдээ номлогч нь сургаал заахдаа индрийн ард зогсдоггүй. Харин ирмэг дээрээ модон тискитэй мужааны ширээний ард зогсоно. Энэхүү ширээ номлогчийн индэр юм. Үүгээр, Эзэн Назар хотод мужаан байсныг хүмүүст сануулдаг.

Хүний биеийг эмчлэхээс гадна сэтгэлийг нь эмчилж, сүнснийг нь аврахыг хүсдэг нэгэн эмч байлаа. Тэрээр эмнэлэгт нь ирсэн өвчтөнүүдийг оношилж эмчлэхээс гадна өвчтөнүүдтэйгээ ярилцаж, сүнсний асуудал байгаа эсэхийг



нягтална. Тэгээд орой нь өвчтөнийхөө гэрээр зочилно. Өвчтөн эхэндээ эмч ирсэнд гайхдаг. Эмч эелдгээр "Би эмчийн хувиар бус найзын хувиар танайд зочилж байна. Чамтай ярилцах гэсэн юм. Орж болох уу?" гэж асууна. Мэдээж нөгөө хүн цааргалалгүй эмчийг гэртээ оруулна. Эмч түүнд сүнслэг асуудлынх нь тухай ярина. Тэгээд Эзэн Есүс уг асуудлыг хэрхэн шийдсэнийг тайлбарлана. Тэр эмчийн олон өвчтөн Эзэнд амьдралаа өгч, Эзэний үйлчлэгч болжээ. Биеийнх нь төдийгүй сүнснийх нь хэрэгцээнд анхаарал тавьсан эрхэм эмчийн үйлчлэлд олон хүн үүрд талархах буй заа.

Өнөөдөр энэ ертөнц дээр Эзэн янз янзын индэртэй. Олон хүн Трампын хэлсэн шиг жирийн ажлыг Хааны ажил болгохыг сурч байна.

## 12 сарын 5

*"Урсгал мэт дайсан ирвэл ЭЗЭНий салхи [Сүнс] түүнийг хөөж явуулна."* (Иса 59:19)

Сатан Эзэний хүмүүсийн эсрэг хамаг хүчээрээ дайрч давшлахад амьдралд туйлын хүнд цаг ирэх нь бий. Дээшээ тэнгэр хол, доошоо газар хатуу гэдэг шиг, найдварын гэрэл өчүүхэн төдий ч үл үзэгдэнэ. Гэвч хүнд хэцүү цагт Өөрийн хүмүүст хүчийг өгнө гэж Бурхан амлажээ. Зовлонгийн өдрүүдэд Эзэний Сүнс диаволын эсрэг бат зогсоход бидэнд тусалдаг.

Израилийн ард түмэн Египетийн хатуу хаанд боолчлогдож байлаа. Тэд ажлын даамлуудын ташуур дор зүдэрч байв. Гэхдээ Бурхан тэдний шаналлыг хайхралгүй орхиогүй. Бурхан фараонтой нүүр тулах Мосег босгож ард түмнээ чөлөөлсөн.

Шүүгчдийн өдрүүдэд харийн түрэмгийлэгчид халдан ирж, Израилийн овгуудыг захирдаг байлаа. Гэвч хамгийн харанхуй үед ч гэсэн Эзэн чөлөөлөгчдийг босгож, дайснуудыг нь үлдэн хөөж, амар амгаланг тогтоосон.

Сеннахериб ассирийн армийг удирдаж, Иерусалимыг бүслэхэд Иудагийн ард түмэн цөллөгт явах нь ойлгомжтой санагдаж байлаа. Хүний ухаанаар харвал халдан түрэмгийлэгчдийг зогсоох ямар ч арга байгаагүй. Гэтэл нэг шөнийн дотор Эзэний тэнгэрэлч ассирийн хуаран дундуур явж 185,000 хүнийг хөнөөсөн.

Естер, Персийн хатан байх үед дайсан үерийн ус мэт хүрч ирж, хаанчлал даяарх бүх иудейчүүдийг алах ёстой гэсэн хатуу зарлиг гаргуулсан. Меде-Персийн хааны зарлиг Бурханыг маданд оруулсан уу? Үгүй. Бурхан үйл

явдлыг өөрчилж, өөр нэгэн зарлиг гаргуулж, иудейчүүдэд өөрсдийгөө хамгаалах боломжийг олгосон. Мэдээж хэрэг иудейчүүдийн талд ялалт ирсэн.

Савонарола, Флоренцийн ядуурал, хүчирхийлэл, шударга бус явдлыг хараад Ариун Сүнсний мутарт ашиглагдах зэмсэг болж, өөрчлөлт шинэчлэлийг авчирсан.

Мартин Лютер католик сүмийн гэм нүглийн эсрэг хашхирч, Бурханы уучлалыг мөнгөөр худалдахыг нь буруушаах үед дундад зууны харанхуй үед гэрэл тусах шиг болсон.

Хатан хаан Мэри Англи болон Шотландад жинхэнэ христитгэлийг бусниулж байлаа. Гэвч Бурхан тэрхүү туйлын хэрэгцээтэй цагт Жон Нокс хэмээх эрийг босгосон. "Жон Нокс Бурханы өмнө шороон дээр нүүрээ наагаад залбирч, 'Сонгосон хүнийхээ өшөөг Та аваач. Шотландыг надад өгөөч. Эс бөгөөс би үхье' хэмээн гуйсан. Эзэн түүнд Шотландыг өгөөд хатан хааныг сэнтийнээс нь зайлуулсан."

Өнөөдөр та амьдралынхаа хамгийн хүнд үеийг туулж байж магад. Хэзээ ч битгий ай. Эзэний Сүнс яг хэрэгтэй цагт нь хүч чадлыг танд илгээж, таныг хөтлөн дагуулаад илүү өргөн уудам газарт авчирна. Зөвхөн Түүнд найд.

## 12 сарын 6

*"Ефраимыг ярихад сүрдэж байв. Тэр өөрийгөө Израильд өргөмжилсөн ч Баалаар ялд унаж үхсэн."* (Хос 13:1)

Зөв шударга хүний үгэнд маш их хүч чадал, эрх мэдэл оршдог. Түүний үг хүмүүсийн амьдралд нөлөө үзүүлдэг. Яриа нь хүмүүст жинтэй тусдаг. Хүмүүс түүнийг хүндлүүштэй, дагууштай хүн байна гэж хардаг.

Харин тэр хүн нүгэлд унавал бүх нөлөөгөө алдана. Хэлэх үгнийх нь эрх мэдэл үгүй болно. Хүмүүс түүнээс зөвлөгөө тусламж хүсэж ирэхээ болино. Тэрээр зөвлөгөө өгөх гэж оролдвол хүмүүс доогтой нүдээр хараад "Эмч ээ, өөрийгөө эдгээ" гэж хэлнэ. Эсвэл "Эхлээд өөрийнхөө нүдэн дэх дүнзийг ав. Дараа нь миний нүдэн дэх үртсийг авах гэж оролд" гэнэ. Тэр хүн юм хэлэх эрхгүй болсон нь тэр.

Тэгэхээр эцсийн мөч хүртэл зөв шударга амьдрах нь туйлын чухал билээ. Гараагаа сайн эхлэх хангалтгүй. Бариандаа орохын өмнөхөн бүдэрвэл урьдын алдар суу чинь тоос шороонд замхарна.

"Ефраимыг ярихад сүрдэж байв." Виллиям үүнийг дараах байдлаар тайлбарласан: "Ефраим Иошуагийн өдрүүдийнх шиг Бурхантай хамт алхаж байхад хэлсэн үг нь эрх мэдэлтэй байлаа. Хүмүүс түүнийг ярихад сүрдэж байсан. Түүнд нэр төр, эрх мэдэл байсан. Гэтэл Ефраим шүтээн шүтлэг рүү эргэж, сүнслэг байдлын хувд үхжээ...Христитгэгч хүн зүрхээ Христэд захируулж, шүтээн шүтлэгээс ангид алхваас эрх мэдэл, нэр төртэй амьдарна."

Гидеон бол үүний нэг тод жишээ. Эзэн энэхүү хүчирхэг эртэй хамт байсан. Тэрээр гурван зуухан хүнтэй армиар Мидианы 135,000 цэрэгтэй хүчит армийг устгасан. Израильчууд түүнийг хаан болгохыг хүсэхэд тэрээр ухаалгаар татгалзсан. Яагаад гэвэл, Израилийн жинхэнэ хаан нь Исхова гэдгийг тэр ухаарч байлаа.

Ийм агуу ялалтыг байгуулаад маш том сорилтыг амжилттай давсан атлаа өчүүхэн зүйл дээр тэр бүдэрсэн. Гидеон ишмаелчуудаас тоносон алтан ээмэгнүүдийг цэргүүдээсээ гуйжээ. Уг ээмэгнүүдээр Гидеон ефод хийсэн нь Израилийн ард түмэнд шүтээн болж, Гидеон болон түүний гэр бүлд урхи болжээ.

Нүгэлд унасан ч нүглээ улайж гэмшвээс Бурхан уучилна гэдгийг бид мэднэ. Бурхан царцаанд идэгдсэн он жилүүдийг минь сэргээж чадна гэдгийг мэднэ. Өөрөөр хэлбэл, үрэн таран хийгдсэн цаг хугацааг минь Тэр нөхөж чадна. Гэвч анхнаасаа унахгүй байх нь унаад сэргэлтийг авахаас хамаагүй дээр гэдгийг хэлэх нь илүүц биз. Анхнаасаа гэрчлэлээ бүтэн хадгалах нь хэдэн хэсэг болсных нь дараа цавуугаар нааж бүтэн болгох гэж оролдсоноос дээр. "Эндрью, хоёулаа эцсийг нь үзтэл итгэмжтэй явахын төлөө залбирья" гэж Эндрью Сонарын аав хэлдэг байлаа. Бүгдээрээ ч гэсэн баяр хөөртэйгөөр замаа дуусгахын төлөө залбирцгаая.

## 12 сарын 7

*"Хамгийн агуу нь хайр мөн."* (1Ко 13:13)

Үзэн ядалт, хувиа хичээсэн зан, зөрчил тэмцэл ноёлсон энэ ертөнцийг дийлэх цорын ганц хүч бол хайр мөн. Сайн сайхан чанарын алиных нь ч хийж чадахгүйг хайр хийж чаддаг. Тиймээс хайр бол бүх сайхан чанарын ноён оргил. Хайр хүчирхийлэлд сайхан сэтгэлээр хариу барьдаг. Өөрийг нь зовоогчдод энэрэл үзүүлдэг. Эрхийнхээ төлөө бүгд тэмцэж байхад хайр ганцаараа хувиа үл хичээдэг. Хайр дахиж өгөх юмгүй болтлоо бүгдийгээ өгдөг.

Энэтхэг эр заан унаад гудамжаар явж байлаа. Явж байхдаа заанаа хурдлуулах гэж байнга ташуурдана. Гэтэл төмөр ташуур гараас нь мултарч, чулуун зам дээр тас няс дугарган уналаа. Заан эргэж хараад хошуугаараа ташуурыг авч эзэндээ өгөв. Хайр үүнтэй адил.

Нар, салхи хоёр хэн нь хүний гадуур хувцсыг тайлуулж чадахаа үзье хэмээн хоорондоо тэмцээн зохиосон тухай Аесопын үлгэрт гардаг. Салхи хамаг хүчээрээ үлээж гарлаа. Үлээх тусам хүн гадуур хувцасныхаа товчийг товчилж, бүсийг улам чангалав. Харин нар халуун дулаан илчээрээ төөнөхөд хүн хувцсаа тайллаа. Хүнийг дулаан илч өөрчилсөн байна. Хайр үүнтэй адил.

Сер Уолтер Скот уурлан хилэгнэхдээ нохойныхоо хөлийг хугалах гэж хөл рүү нь хамаг хүчээрээ чулуу авч шидэв. Скотын уур нь гараагүй зогсож байтал нохой түүн рүү дөхөж ирээд чулуу шидсэн гарыг нь долоожээ. Хайр үүнтэй адил.

Стэнтон, Линкольныг үзэж чаддаггүй хорсдог байлаа. Линкольныг "алиалагч", "жинхэнэ горилла бич" хэмээн

хочилно. "Спрингфилдэд горилла байсаар атал горилла үзэх гэж Африк явах чинь тэнэг хэрэг шүү дээ" гэж хошигноно. Линкольн түүнд нөгөө хацраа тавьж өгсөн юм. Хожим Линкольн Стэнтоныг дайны хэрэг явдал хариуцсан сайдаар томилж, энэ ажилд хамгийн тохирох чадварлаг хүн хэмээн итгэл үзүүлжээ. Линкольн буудуулан нас барахад Стэнтон цогцосных нь хажууд зогсоод "Энэ ертөнцийн хамгийн агуу удирдагч нас барлаа" хэмээн нулимс унаган хэлж байжээ. Линкольн хацрыг нь алгасан хүнд нөгөө хацраа тавьж өгч, дайснаа буулгаж авчээ. Хайр үүнтэй адил.

"Нөгөө хацраа тавьж өгснөөрөө та дайснаа зэвсэггүй болгодог. Дайсан чинь таны хацрыг алгадахад нөгөө хацраа тавьж өгснөөрөө та зүрхийг нь алгадаг. Зүрхэнд нь байсан дайсагнал тийнхүү үгүй болно. Тэгээд та дайсангүй болно. Өс хорслоо таягдан хаявал өстөн дайснаасаа ангижирна. Хариуг нь өгч эргүүлэн цохих хангалттай хүчтэй ч, жинхэнэ хүчийг үзүүлж эргүүлж цохиогүй Есүс гэдэг хүний хөлд энэ ертөнц сөгддөг." (Э.Стэнли Жонс)

Заримдаа, хатуу үг хэлэхгүй, хариуг нь өгөхгүй, эрхээ хамгаалах гэж тэмцэхгүй байвал илүү том үр дүнд хүрч чадна. Энэ аргууд өөрийн гэсэн хүч нөлөөтэй. Гэхдээ жинлүүр дээр тавиад үзвэл хайрын хүч илүү жин дарна. Дайсагналыг гүнзгийрүүлэхийн оронд хайр үзүүлбэл өстөн дайсан ч үнэнч найз болж магад.

## 12 сарын 8

*"Муу үйлийн эсрэг цааз жаяг тэр дороо гүйцэлддэггүй учраас тэдний дунд буй хүмүүний хөвгүүдийн зүрх нь муу муухайг үйлдэхдээ бэлэн байдаг аж."* (Ном 8:11)

Энэ үгсийг бичиж байхад минь манай улсын гэмт хэргийн түвшин өссөн байдалд ард олон хаа сайгүй дургүйцлээ илэрхийлж байна. Хүмүүс хууль журмыг шаардаж байна. Хууль шүүх гэмт хэрэгтнүүдэд ээлтэй, хохирогчдод халгаатай хандаж буйг хүмүүсийн эгдүүцэл харуулна. Гэмт хэргийг шүүн таслах ажиллагаа дуусахгүй ар араасаа хөврөх бөгөөд өмгөөлөгчид хуулийн цоорхойг ашиглаж, буруутны талд ялалтыг авчирсаар...

Дайран дээр нь давс хийх гэгчээр, гэгээнтний дүрд тоглогч, либерал социологич, сэтгэл зүйч мэтийн мэргэжилтнүүд энэхүү эмх замбараагүй байдлыг улам гааруулдаг. Тэд цаазын ялыг буруутгаж, хүмүүнлэг бус хэмээцгээнэ. Тэдний бодлоор шийтгэлээс айх айдас гэмт хэргийг бууруулахгүй. Хүмүүсийг шийтгэх биш, эергээр засан хүмүүжүүлэх хэрэгтэй гэж тэд зөвлөдөг.

Гэвч тэдний үзэл бодол буруу. Шийтгэлээс зугтах боломж олон байх тусам гэмт хэргийн тоо улам нэмэгдэнэ. Шийтгэл хөнгөн байвал гэмт хэрэгтнүүд улам зоригжино. Шүүн таслах ажиллагаа сунжруу болох тусам гэмт хэрэгтэнд ашигтай болно. Тэгэхээр цаазын ял бол гэмт хэргийг бууруулах том хүчин зүйл мөн.

Нэгэн алдартай мэдээний сэтгүүл гэмт хэргийн түвшин өссөн явдалд дүн шинжилгээ хийж дараах дүгнэлтэд хүрсэн: "Гэмт хэрэг өсөж буй нь нэг талаар Америкийн эрүүгийн хуулийн тогтолцоонд хатуу шийдмэг шийтгэл



дутаж байгаатай холбоотой. Шийтгэх нь зөв бол шийтгэлийг нэн даруй, заавал өгөх ёстой гэдгийг албаны бүх хүн хэлж байна. Дэндүү сунжирсан үйл явцаас болоод АНУ-ын тогтолцоо зохих ёсоор ажиллахгүй байна."

"Хайраас болж биеэ зөв авч явдаг нэг хүн тутамд шийтгэлээс айсандаа биеэ зөв авч явдаг арван мянган хүн ноогдоно гэж криминалистикийн нэгэн мэргэжилтэн мэдэгдсэн. Нэг алуурчныг цаазлахад 17 аллагыг таслан зогсоодог болохыг статистик харуулж байна гэж Чикагогийн их сургуулийн профессор Исаак Эхрлик хэлсэн." Хүнийг өөрчилж, хайраар засна гэдэг арга хэзээ ч бүтэхгүй. Хүнийг хэн ч өөрчилж чадахгүй. Зөвхөн Бурханы Сүнсээр дахин төрсөн нүгэлтэн л гэгээрч чадна. Харамсалтай нь үүнийг хүлээн зөвшөөрөх эрх мэдэлтэн дэндүү цөөхөн.

Тиймээс өнөөдрийн эшлэлийг нухацтай авч үзэх нь хамгийн зөв арга юм. "Муу үйлийн эсрэг цааз жаяг тэр дороо гүйцэлддэггүй учраас тэдний дунд буй хүмүүний хөвгүүдийн зүрх нь муу муухайг үйлдэхдээ бэлэн байдаг аж." Зохих шийтгэлийг тэр даруй өгч байхгүй бол гэмт хэргийн тоо хэзээ ч буурахгүй. Шийдэл Библид байна. Гагцхүү хүмүүс хүлээж авдаггүй.

## 12 сарын 9

*"Харин Эзэн Есүс Христээр маань бидэнд ялалт өгдөг Бурханд талархал нь байх болтугай."* (1Ко 15:57)

Есүс Христ Голготын загалмайгаар олж авсан ялалтын цар хүрээг хүмүүн бид ухаарч ойлгож чадахгүй. Тэр ертөнцийг ялсан (Иох 16:33). Тэр энэ ертөнцийн захирагч Сатаныг ялсан (Иох 16:11). Тэр захирагчид болоод эрх баригчдыг ялсан (Ко 2:15). Тэрээр үхлийг ялсан (1Ко 15:54,55,57).

Түүний ялалт биднийх. Давид Голиатыг ялсан нь бүх Израильд чөлөөлөлт авчирсан шиг Христийн аугаа ялалт Христэд харьяалагддаг бүх хүнд хамаарна. Тиймээс бид Хоратиус Бонарын дууг дуулж чаддаг:

*Ялалт биднийх*

*Хүчит Нэгэний хүч чадал бидэнд ирсэн*

*Тэр тулалдаад ялалтыг бидэнд авчирсан*

*Ялалт биднийх*

"Биднийг хайрладаг Түүгээр дамжин [бид] давуулан дийлдэг. Учир нь үхэл ч, амь ч, тэнгэрэлч нар ч, эрх баригчид ч, өнөөгийн юмс ч, ирэх юмс ч, хүч ч, өндөр ч, гүн ч, өөр ямар ч бүтээл бидний Эзэн Христ Есүсийн доторх Бурханы хайраас биднийг салгаж чадахгүй" (Ром 8:37-39).

Чухал тэмцээний дараа хөл бөмбөгийн тамирчдыг орон нутагт нь авчирсан галт тэрэг өртөөн дээр ирэхэд нэг хүү тэнд зогсож байлаа. Хүү галт тэрэгнээс буусан эхний хүн дээр гүйн очиж "Хэн ялсан бэ?" хэмээн амьсгаа даран асуув. Тэгээд галт тэрэгний буудлаар баяр хөөртэйгөөр гүйж, "Бид ялжээ", "Бид ялжээ" хэмээн хашхирлаа. Энэ хүү

ялалт авчрахад юу хийсэн бэ? Хөл бөмбөгийн талбай дээр тамирчдын хамт өрсөлдсөн үү? Мэдээж үгүй. Гэвч тухайн хотод харьяалагддаг учраас өөрийгөө тухайн хотын хөл бөмбөгийн багт хамааруулж ялалтыг нь өөрийнх мэт тунхаглаж байлаа.

Английн төмөр гүнтэн гэгддэг Велингтон, Уотерлүгийн тулаанд Наполеоныг ялгууснаар ялсан. Энэ ялагдалд цуг байсан францын нэгэн эр иргэншлээ сольж Британийн иргэн болоод Велингтоны ялалтыг манай ялалт хэмээн хэлэх эрхтэй болжээ.

Төрөхдөө бид бүгдээрээ Сатаны хаанчлалд харьяалагддаг. Тиймээс ялагдагч талд нь байсан. Харин Христийг Эзэн ба Аврагчаа болгон сонгохдоо ялагдагч талаас ялагч тал руу шилжсэн юм.

## 12 сарын 10

*“Прискила, Акул нар... түүнд Бурханы замыг нарийн тайлбарлаж өгөв.” (Үйл 18:26)*

Авралын замыг бусдад тайлбарлахдаа товч бөгөөд тодорхой байх нь маш чухал. Эс бөгөөс сонсогч хүнийхээ толгойг эргүүлнэ. Тэд угаасаа хангалттай их төөрөлдсөн байгаа. Учир нь Сатан "үл итгэгчдийн бодол санааг сохолсон" (2Ко 4:4).

Үл итгэгчдийн толгойг эргүүлэх яриаг нэг жишээгээр тайлбарлая. Сайнмэдээг анх удаагаа сонсож байгаа нэгэн залууд Есүс Христийн тухай ярьж эхэлж байна гэж бодъё. Яриагаа дөнгөж эхэлтэл сонсогч маань яриа тасалж, "Би шашинд итгэдэггүй. Шашнаар явах гэж үзсэн ч ерөөсөө бүтээгүй" гэж хэлж магад. Тэгэнгүүт бид "Би ч бас шашинд итгэдэггүй. Танд шашны тухай ярих гээгүй байна" гэж хариулах байх.

Шууд энд зогс! Энэ үг чинь ямар толгой эргэмээр мэдэгдэл болохыг та төсөөлж байна уу? Бид шашны гэж ойлгогдохоор зүйлсийг ярьж байж "Би шашинд итгэдэггүй" гэж хэлж сууна шүү дээ. Ганц энэ өгүүлбэр чинь л түүнийг будилуулна.

Мэдээж таны ямар утгаар хэлснийг би ойлгож байна. Тэр хүнийг та ямар нэгэн сүм, шашны бүлэглэлд оруулах гээгүй. Харин Эзэн Есүстэй амьд харилцаатай болгох гэж байгаа. Та түүний үзэл бодлыг өөрчлөх гээгүй. Харин Есүс гэдэг хүнтэй уулзуулах гэж байгаа. Та түүний амьдралыг өөрчлөх гээгүй. Харин Ариун Сүнсээр дахин төрүүлэхийг хүсэж байгаа. Та түүний хувцсыг солих гээгүй. Харин дотоод хүнийг нь солихыг оролдож байгаа.

Гэхдээ таны сонсогч шашин гэдгийг бодохдоо Бурханд мөргөх, үйлчлэхтэй холбоотой аливаа бүхнийг бодно. Шашин гэдэг үг ихэнх хүний толгойд хүн Бурхантай харилцахын тулд тодорхой нэг итгэл үнэмшлийг баримтлах, ямар нэг амьдралын хэв маягтай байх гэж ойлгодог. Тэгэхээр "Би шашинд итгэдэггүй" гэж хэлэхээр биднийг атейст гэж шууд ойлгоно. Ямар утгаар хэлж буйгаа тайлбарлаж амжаагүй байхад чинь итгэл сүсэггүй хүн гээд таныг аль хэдийнээ дүгнэчихсэн байна.

Үнэндээ "Би шашинд итгэдэггүй" гэдэг үг чинь үнэнд нийцэхгүй. Бид христитгэлийн тулгуур сургаалуудад итгэдэг. Христитгэгчид амьдралаараа итгэлээ харуулах ёстойд итгэдэг. "Цэвэр бөгөөд бузартаагүй сүсэглэл бол өнчин хүмүүс, бэлэвсэн эхнэрүүдийг зүдрэхэд нь эргэж тойрон, өөрийгөө ертөнцөөс бохирдуулалгүй хамгаалах" (Иак 1:27) явдал гэдэгт итгэдэг.

Шашин хүнийг аварна гэдэгт бид итгэдэггүй. Зөвхөн амьд Христ хүнийг аварч чадна. Өнөөгийн ихэнх хүний христитгэл гэж ойлгодог гажуудсан христитгэлд бид итгэдэггүй. Сайн үйлс, гавьяа зүтгэлээр диваажинд очиж чадна гэсэн номлол сургаалд бид итгэдэггүй. Гэхдээ үүнийг ойлгуулахын тулд "Би шашинд итгэдэггүй" гэх мэт толгой эргэм үгсийг ашиглах хэрэггүй. Хүмүүсийн сүнс үхлийн ирмэг дээр байхад үгийн тоглоомоор наадахаа больцгооё.

## 12 сарын 11

*“Тиймээс та нар миний энэ үгсийг зүрх, сэтгэлдээ тогтоож, түүнийг тэмдэг болгон бугуйндаа уяж, хоёр нүднийхээ хоорондох сахиус мэт байлга.” (Дх 11:18)*

Дараагийн гурван эшлэл нь байхгүй бол өнөөдрийн эшлэл бүрэн гүйцэт болохгүй. Тиймээс энд эш татан оруулъя: "Та нар түүнийг хөвгүүддээ зааж, гэртээ сууж байхдаа ч, замд явж байхдаа ч, хэвтэхдээ ч, босохдоо ч түүний тухай ярьж бай. Та нар үүнийг гэрийнхээ хатавчин дээр, хаалган дээр ч бич. Тэгвэл эцэг өвгөдөд чинь өгөхөөр ЭЗЭНий тангарагласан газар дээр та нарын болон хөвгүүдийн чинь өдөр хоног газрын дээрх тэнгэрийн хоногууд мэт маш олон болно."

Бурханы хүмүүсийн амьдралд Бурханы үг хаана байх ёстой вэ гэдгийг энэ эшлэлд хэлж өгч байна. Энэ болзлууд хангадвал итгэгч бидний өдөр хоног газрын дээрх тэнгэрийн хоногууд мэт маш олон болох нь ээ.

Юуны түүрүүнд, "энэ үгсийг зүрх сэтгэлдээ тогтоо" гэж өнөөдрийн эшлэлд хэлсэнчлэн бид Библийн үгийг цээжлэх хэрэгтэй. Библийн үгийг зүрхэндээ ихийг хадгалах тусам бид амьдралаа улам баялаг болгож, бусдад илүү ивээл болно.

Дараа нь, Библийн үгийг гартаа уяж, духан дээрээ байрлуулах хэрэгтэй. Гэхдээ зарим хүний боддог шиг сахиус, тэмдэг зүүнэ гэсэн үг биш. Харин үйлдэл (гар) болон хүслээ (нүд) Эзэн Есүст захируулна гэсэн үг.

Бурханы үг гэр оронд минь ярианы гол сэдэв байх ёстой. Айл болгон Библийг өдөр бүр уншиж, хамтдаа

залбирдаг байх хэрэгтэй. Ийм гэр оронд Библи ямар агуу нөлөө үзүүлж чадахыг хэн ч таашгүй.

Бурханы үгийг бид замд алхаж явахдаа ч, хэвтэхдээ ч, босохдоо ч ярьж байх ёстой. Өөрөөр хэлбэл, Библийн үгс амьдралын маань салшгүй хэсэг болж, юу ч хийж байсан ярианы маань гол сэдэв байна гэсэн үг. Нэг ёсондоо, Библийн уур амьсгалаар амьдрах хэрэгтэй гэсэн үг.

Бид Библийн эшлэлүүдийг гэрийнхээ хатавчин дээр, хаалган дээрээ бичих хэрэгтэй юу? Энэ үнэхээр сайхан санаа шүү. Олон христитгэгч айл гэрийнхээ үүдэн дээр "Би болон манай гэрийнхэн бид ЭЗЭНд үйлчилнэ" гээд Иошуа 24:15-ыг бичсэн байдаг. Гэрт нь орохоор ханан дээрээ Библийн эшлэлүүд өлгөсөн айл бүр ч олон бий.

Ариун Бичвэрийг амьдралдаа зохих байр сууринд нь тавивал хэрэгтэй хэрэггүй ярианд цагаа гарздахаас өөрсдийгөө авраад зогсохгүй жинхэнэ утга учиртай зүйл буюу мөнхийн утга учиртай зүйлд цаг заваа зориулж чадна. Цаашлаад гэр орон минь христэч уур амьсгалтай болно.

## 12 сарын 12

"Бурхан Эзэнээ бүү сорь." (Мт 4:7)

Эзэнийг сорих гэж юу гэсэн үг вэ? Бид ийм алдаа гаргадаг уу?

Израилийн хөвгүүд цөлд ус байхгүй гэж гомдоллохдоо Эзэнийг сорьсон (Гэт 17:7). "ЭЗЭН бидний дунд байна уу, үгүй юү?" гэж асуухдаа тэд Бурханы оршихуйд эргэлзээд зогсохгүй Бурхан анхааран халамжилдаг эсэхэд эргэлзсэн.

Сатан, Эзэн Есүсийг сүмийн оройгоос үсэр гэж хэлэхдээ Эзэнийг сорьсон (Лк 4:9-12). Есүс Сатаны үгээр үсэрсэн бол Бурхан Эцэгийг сорьсон хэрэг болох байлаа. Яагаад гэвэл, сүмийн оройгоос үсэрч олныг алмайруулснаараа Эцэгийн хүслийг зөрчих байв.

Фарисайчууд Цезарьт татвар төлөх нь хуульд нийцэх үү гэж Есүсээс асуухдаа Эзэнийг сорьсон (Мт 22:15-18). Эзэн Есүс ямар ч хариу өгсөн, нэг бол ромчуудын, эс бол Ромыг эсэргүүцэгч иудейчүүдийн дургүйг хүргэх байлаа.

Сапфир хөрөнгийнхөө талыг авч үлдсэн байж, бүгдийгээ Эзэнд өргөсөн мэт дүр эсгэхдээ Эзэний Сүнснийг сорьсон (Үйл 5:9).

Иудей хүмүүсийн үүрч чадаагүй буулгыг буюу хуулийг харь үндэстэн итгэгчдийн дээр тохох нь Бурханыг сорьсон явдал болно гэж Иерусалимд болсон хурал дээр Петр мэдэгдсэн (Үйл 15:10).

Бурханыг сорих гэдэг нь "Бурханы шүүлт ирэх хүртэл хэр хол явж болохыг үзэх оролдлого. Бурхан үгээ биелүүлэх нь үү үгүй юу гэж шалгах. Шүүлтийнхээ хязгаарт хүртэл нь янзыг нь үзэх." (Дх 6:16 болон Мт 4:7-г харьцуул.) (Түссэень) Гомдоллож, гонгиногч хүн



Бурханыг сорьж байна. Яагаад гэвэл Бурханы оршихуй, хүч чадал, сайн сайханд эргэлзэж байгаа нь тэр. Бурхан бидний нөхцөл байдлыг ойлгохгүй байна, анхаарал тавихгүй байна, биднийг чөлөөлж чадахгүй гэж хэлсэнтэй адил юм.

Шаардлагагүй байхад аюул руу өөрсдөө явж орчхоод авралыг Бурханаас хүлээх нь Бурханыг сорих мөн. Могойн хор уугаад нас барсан мунхаг итгэгчийн тухай та сонссон байж магад. Марк 16:18 дээр “Могой барьж, үхүүлэх хор уусан ч үхэхгүй” гэж хэлсэн үгийг барьж тэр ийм үйлдэл хийжээ. Гэвч Бурханы хүслийг биелүүлж байхад ийм аюултай учирвал энэ амлалтыг барих ёстой болохоос ямар ч утга учиргүйгээр өөрөө өөрийгөө хөнөөлд оруулчхаад энэ амлалтыг нэхэж болохгүй.

Бурханд худал хэлэх нь Бурханыг сорих сорилт билээ. Үнэн мөн нь огт өөр атал өөрсдийгөө Бурханд зориулдаг мэт, итгэл сүсэгт дүр эсгэх нь үүний тод жишээ. Фарисайчууд Христийг хоёр нүүрт хуурамч зангаараа сорьсон шиг бид ч тийн сорих аюултай.

Бурханы хүслийн дагуу тогтоож өгсөн байр суурь, нөхцөл байдлаас явж, өөрсдийнхөө хүслээр дураараа загнах үедээ бид Бурханыг сорьдог.

Бүтээл нь Бүтээгчээ сорих, нүгэлтэн Аврагчийг доромжлох шиг хэрдхийлгэм зүйл үгүй.

## 12 сарын 13

*"Харин ЭЗЭНээс эмээдэг хүмүүс бие биентэйгээ ярихад ЭЗЭН анхаарал тавин сонсдог. ЭЗЭНээс эмээдэг болон Түүний нэрийг болгоодог хүмүүсийн төлөө дурсгалын ном Түүний өмнө бичигдсэн билээ."* (Мал 3:16)

Бид хэт завгүй болоход сэтгэл минь хоосрох боломжтой. Амьдралын үй түмэн асуудлуудад анхаарлаа хандуулж, ажилдаа дэндүү их улайрснаар Бурханд зарцуулах цаг завгүй болно. Өөртөө цаг гаргаж, бясалгаж, Эзэнтэй харилцаа үүсгэдэггүй номлогчийн сургаалууд удахгүй хүч чадал, эрх мэдлээ алддаг. "Эзээн, биднийг завгүй амьдралын хоосролоос чөлөөлж өгөөч" хэмээн залбирах хэрэгтэй. Олон итгэгч ганцаараа байхаас айдаг. Тэд бусадтай хамт байж, ярьж хөөрч, ажиллаж, аялахыг хүсдэг. Харамсалтай нь чимээгүй цаг хийдэггүй. Орчин үеийн амьдралын хэв маяг нь биднийг их ажилтай, олон зүйл хийдэг хүмүүс байхыг шахдаг. Асар олон хийх зүйл байдаг учраас хурдаа хасахад хэцүү болдог. Юунд хүрэх нь мэдэгдэхгүй яваад л, яваад л байна. Эцэст нь гүн сүнслэг үндэс ургуулж чадаагүй үлдэнэ. Хорин жил өнгөрсөн ч нэг хэвэндээ байсаар л...

Харин Эзэнтэй хоёулхнаа байх цаг гаргахын тулд яарч адгасан амьдралын хэв маягаас холдож, заримдаа хүмүүсийн урилгаас татгалзаж, хоёрдугаар зэргийн ач холбогдолтой ажлуудыг хойш тавьдаг хүмүүс бий. Тэд залбирал ба бясалгалд цаг заваа зориулдаг. Эзэнтэй хувьчлан уулзахын тулд энэ ертөнцийн дуу чимээнээс холдох нууц өрөөтэй.

Тэд Эзэнтэй хамт алхдаг хүмүүс. "ЭЗЭНий андлал Өөрөөс нь эмээгчидтэй хамт байдаг. Тэр тэдэнд гэрээгээ мэдүүлнэ" (Дуу 25:14). Завгүй амьдралын дотроос хэзээ ч олж мэдэхгүй нууцуудыг Бурхан тэдэнд илчилдэг. Бурхан тэднийг замчилж, сүнслэг ертөнцөд болж байгаа үйл явдлыг илчилж, ирээдүйн талаар ойлгуулдаг. Бурханы өмнө суудаг хүмүүс түмний түжигнээн дунд амьдрагсдын олж хараагүй харааг Бурханаас авдаг. Аврагчийн энгэрийг налж суусан шавь нь Есүс Христийн Илчлэлийг үзсэн билээ.

Заримдаа би Сэцилийн үгийг боддог: "Та нар Бурхантай цаг өнгөрөөхгүй бол сэтгэл чинь үхнэ гэж би хаа очсон газраа ярьдаг. Бурхантай алхахгүй бол Сатан та нартай алхана. Нигүүлсэл дотор өсөхгүй бол нигүүлслээс төөрнө. Яаж хийх вэ гэвэл, Бурханд хангалттай цагийг гарга. Зарим итгэгч Бурханд ерөөсөө цаг гаргахгүй яаж яваад байдгийг би огт ойлгодоггүй. Бурханд цаг гаргахгүй бол энэ ертөнц биднийг өөртөө шингээн уусгана. Нэг мэдэхэд эргүүлэгт нь автаж, махбодын бузар мууд живнэ. Тиймээс 'Би юу хийж байна вэ? Би хаана явна вэ?' гэж өөрөөсөө байнга асуух шаардлагатай."

## 12 сарын 14

*"Би түүнийг алдрынхаа төлөө бүтээж, хэлбэржүүлж, хийсэн."* (Иса 43:7)

Хүн амьдралаа үрэн таран хийхээс илүү гунигтай юм үгүй. Хүн Бурханы дүр төрхөөр бүтээгдсэн болохоор яруу алдарт хувь тавилан түүнд бий. Амьдралынх нь зорилго нь цэнгээний газар биш. Хүн Бурханыг төлөөлөн харуулахаар бүтээгдсэн болохоор нүглийн боол байх учиргүй. Хүний амьдралын гол зорилго юу вэ? Бурханыг алдаршуулж, Бурхантай хамт үүрд аз жаргалтай амьдрах. Энэ зорилгоо гээвэл бид бүхнээ алдсантай адил.

Хүн шалбаагт сэлдэг амёбаас ялгаагүй он жилүүдээ өнгөрөөж буйг хараад Ж. Х. Жовет уйлж байлаа. Хүн нэг компанийн ажилтан байхаас өөр зорилгогүй байхыг хараад сэтгэл нь өвдөж байлаа. Тиймээс "Хүн болж төрөөд худалдагч болж үхэх" гэдэг алдартай үгийг хэлсэн.

Ф. В. Х. Мэйерс хүний амьдралыг ажиглаад дараах шүлгийг бичжээ:

*Ялгуусан их хувь тавилантай атлаа  
Ямар ч гойд зүйлгүй амьдрах хүмүүн  
Хаадын зиндаанд төрсөн атлаа  
Харц боолын ёсоор амьдрах хүмүүн  
Хөөсрөн замхрах хоосон зүйлсэд  
Хөөрч баярлан сэтгэл ханах хүмүүн*

Вочман Ни залуу байхдаа туйлын авьяас чадвартай хүн шуналтай эзний дор ажиллаж байгааг хараад ихэд гайхсан гэдэг. "Хуучин хотын гоёмсог гудамжны нэгэн дэлгүүрт нэр нь үл мэдэгдэх уран бүтээлч бүхэл бүтэн зургаан жилийг лангууны ард үджээ. Хийдэг ажил нь модон дээр

цэцэг урлаж өнгө будгаар гоёх. Бороотойд ч, нартайд ч, амралтын өдрөөр ч, амралтаар ч, юу ч болж байсан ажлаа хийнэ. Үүнийхээ төлөө өдөрт наймхан цент авна. Дээр нь идэх хоол, толгой хорогдох өрөөгөө хангуулна. Ийм их авьяас чадварыг олж авчхаад ингэж л дуусах байсан гэж үү? Ингэж явсаар эцэст нь олсон ч юмгүй, гуйлгачны эгнээнд л шилжинэ.”

Хүн ямар агуу дуудлагатайгаа ер тоохгүй амьдардаг нь нэн гунигтай. Ач холбогдолгүй зүйлээс зуурсаар байгаад амьдралаа барцгаана. Нисэж явах учиртай байтал мөлхөцгөөнө. Хааны адил амьдрах ёстой атал хог новш ухаж, хамаг цагаа үрнэ. Амьдрахын төлөө явахаас биш ерөөсөө амьдардаггүй.

Өнөөдөр олон хүн байгаль дэлхий, хүрээлэн буй орчны бохирдол сүйтгэлд сэтгэл зовдог. Гэвч хүмүүний амьдрал үрэн таран болж байхад юу ч боддоггүй. Устаж үгүй болж буй шувуу, загас, ан амьтдыг аврах хөдөлгөөн аян олон өрнөдөг. Гэтэл хүмүүс амьдралаа хий хоосонд өнгөрүүлж байгааг хараад ерөөс сэтгэл нь зовдоггүй. Нэг хүний амь бүх ертөнцөөс үнэтэй. Тийм амийг үрэн таран хийх нь үгээр хэлэхийн аргагүй харамсал. Нэгэн настай эмэгтэй, “Би дал хүрлээ. Энэ амьдралдаа юу ч хийж чадсангүй” гэж хэлж байсан. Үүнээс илүү харамсмаар зүйл гэж байх уу?

## 12 сарын 15

*"Нулимс дуслуулан үр суулгагчид уухайн дуутай ургац хураах болно. Үртэй уутаа үүрэн уйлан цааш нааш явах тэрээр багцалсан тариагаа үүрэн баяр хөөрийн дуутай гэртээ ирнэ."* (Дуу 126:5,6)

Дуулал 126 дээр Израилийн хөвгүүд Вавилоны цөллөгөөс нутагтаа ирсэн тухайгаа дурсан бичжээ. Энэ үйл явдал яг л зүүдний ертөнцөд ирсэн мэт байлаа. Тэд баяр баясгалан, инээд хөөр, дуу хуураар дүүрсэн юм. Хуурамч шүтээнтэй хөрш улсууд нь хүртэл, Эзэн ард түмнийхээ төлөө юу хийсэн тухай агуу зүйлсийг ярьцгааж байлаа.

Одоо тэд эх нутагтаа иржээ. Тариа ногоогоо тарих ёстой боллоо. Гэвч энэ нь тэдэнд асуудал болов. Буцаж ирэхдээ маш бага хэмжээний үр тариа авчирсан учраас түүнийгээ хоол хүнсэнд хэрэглэх үү эсвэл газарт тариад ирээдүйд арвин ургац авах уу гэдэг асуудал тулгарсан. Авчирсан тариагаа үр болгож тарина гэвэл ургац гартал тарчиг зүдүү амьдрах болно. Гэхдээ тэд тариа тарихаар шийджээ.

Тариачин талбай руугаа явж, үрээ газарт суулгаж, хагалсан талбай дээгүүрээ цацахдаа нулимс дуслуулж байв. Учир нь ургацын цаг болтол гэр бүлээ яаж тэжээх вэ гэдэг хүнд бодол түүнийг шаналгасан юм.

Гэхдээ талбай нь тариан түрүүгээр шаргалтах үед түүний нулимс баяр хөөрөөр солигдсон. Ургацаа хурааж, амбаар савандаа нөөцлөхдөө хөөрөн баясаж байсан. Гаргасан тэр их золиос нь одоо үр шимээ өгчээ.

Энэ үйл явдлыг бид өөрсдийнхөө амьдралтай холбон харж болно. Эзэн бидэнд маш бага хэмжээний эд

хөрөнгийг, материаллаг юмсыг даатган үлдээж нярав болгосон. Энэ бүхнийг бид амьдралын таашаалд зарцуулж, хүссэн болгоноо худалдан авахад үрж болно. Эсвэл золиос гарган Эзэний ажилд хөрөнгө оруулж, харийн нутагт ажиллах илгээлтийн эзэн, христэч ном зохиол, сайнмэдээний хөтөлбөр, чуулганд зарцуулж болно. Үүний тулд бид хамгийн даруу төлөв амьдралын хэв маягийг сонгож, хэрэгцээнээсээ илүү гарсан бүхнийг Эзэний ажилд өгнө. Хүний зайлшгүй хэрэгцээгээ хангаад үлдсэн бүхнээ сайнмэдээний үйлсэд өргөж, мөхөж буй сүнснүүдийг аврах ажилд зориулна.

Гэхдээ ийм золиос ургацын цаг ирэхэд заавал шагналаа авна. Бидний зориулсан зориулалтаас болж олон хүн мөнхийн улсад орсныг бид харна. Одоо гаргах золиос маань магадгүй нэг хүнийг ч гэсэн мөнхийн зовлонгоос аварч, Бурханы Хургыг үүрд мөнх магтан хүндлэгч болгох боломжтой.

## 12 сарын 16

*"Сэтгэл минь ээ, ЭЗЭНийг магтаж, ач тусыг нь ч буу март. Тэрээр...бүх өвчнийг чинь илааршуулдаг."* (Дуу 103:2,3)

Бурханы нэг нэрийг Иехова Рафа гэнэ. "ЭЗЭН Би та нарыг эдгээгч" (Гэт 15:26) гэсэн утгатай. Биднийг эдгээгч нь Бурхан. Тэр биднийг бүх төрлийн өвчнөөс эдгээдэг бөгөөд хожим бүх өвчнийг үүрд зайлуулна.

Бидний бие дотор өөрөө өөрийгөө эдгээх чадварыг Бурхан өгсөн. Энэ бол Бурханы эдгээх нэг арга. Тийм ч учраас эмч нар "Ихэнх зүйл өглөөд дээрддэг" гэж хэлдэг. Заримдаа Бурхан эм тариа, хагалгаагаар эдгээдэг. "Эмч хүн шархийг боодог. Бурхан түүнийг эдгээдэг" гэж Францын алдарт эмч Дубоис хэлжээ. Заримдаа Бурхан гайхамшгаар эдгээдэг. Энэ тухай сайнмэдээний номуудад бичсэн. Мөн гайхамшгаар эдгэсэн олон хүн бий.

Гэхдээ Бурханы туйлын зорилго нь хүнийг эдгээх биш. Тийм байсан бол бид хэзээ ч хөгширч үхэхгүй. Гэтэл Эзэнийг ирэх хүртэл бүх хүн эрт орой хэзээ нэгэн цагт үхнэ. Бурхан Паулын биеийн зовлонг зайлуулаагүй. Харин түүнийг даах нигүүлслийг өгсөн (2Ко 12:7-10).

Ерөнхийдөө өвчин гэдэг зүйл нүглийн үр дагавар юм. Өөрөөр хэлбэл, нүгэл байгаагүй бол өвчин байхгүй байх байсан. Заримдаа өвчин нь тухайн хүний нүглийн шууд үр дагавар байдаг. Жишээ нь, архи элэгний өвчнийг, тамхи хорт хавдрыг, садар самуун бэлгийн замын өвчнийг, санаа зоволт ходоодны шархыг үүсгэдэг. Гэхдээ өвчин болгон тухайн хүний нүглээс болдоггүй. Иов энэ дэлхийн хамгийн шударга хүн (Иов 1:8; 2:3) байтал Сатан түүнд хүнд өвчин



тусгасан (Иов 2:7). Сатан нэг эмэгтэйг бөгтөр болгосон (Лк 13: 11-17). Мөн Паулын биед өргөс оруулсан (2Ко 12:7). Иохан 9:2,3 дээрх сохор хүн нүглээсээ болж төрөлхийн сохор төрөөгүй. Епафродит нүглээсээ болж биш Эзэнд эцэж цуцалгүй үйлчилснээсээ болж хүнд өвчин туссан (Флп 2:30). Гаи сэтгэл нь сайн сайхан байсан ч биеийн байдал сайнгүй байлаа (3Ио 2).

Эцэст нь хэлэхэд, өвчин эдгэхгүй байлаа гээд заавал итгэл багатай гэсэн үг биш. Бурхан эдгээнэ гэж тусгайлан амласан бол тэр үгнээс л бид итгэлээр зуурах ёстой. Тийм амлалт үгүй бол амьдardгаараа амьдарч, Эзэнийгээ хайрлан, хүслийг нь биелүүлэхийн төлөө залбирах хэрэгтэй.

## 12 сарын 17

*"Түлээгүйд гал унтарна. Хов зөөгчгүйд эвдрэлцэл намжина."* (Сур 26:20)

Хоёр хүн хэрэлдэж байна. Нэг нь ууртайгаар хашхирахад нөгөө нь эргүүлээд доромжилно. Нэг нь хамаг муу үгээ хэлэхэд өөдөөс нь яг ижил хариу барина. Дуугаа хураачихвал сул дорой харагдах гээд, ялагдчих юм шиг бодогдоод хэн нь ч хэрүүлийг намжаахыг оролдсонгүй. Гал улам дүрэлзэж, хорсол зэвүүцэл улам бадарна.

Тэгвэл зургийг өөрчлөөд үзье. Нэг хүн хэрүүл өдөж муухай үг хэлэв. Гэвч нөгөө талаас гал өрдөх юу ч хэлсэнгүй. Хэрүүл эхлүүлэгч нь уурлаж, гутааж, доромжилж байсан ч нөгөө хүн нь ижил хариу барьсангүй. Эцэст нь ууртай хүн цагаа гарздаж буйгаа ойлгоод хараал зүхлээ уншин цааш явж одлоо. Нэг нь хэрүүлд гал нэмээгүй учраас гал аажмаар унтарсан юм.

Цуглааны дараа хэдэн хүмүүс доктор Айронсайд дээр ирээд хэлсэн үгийг нь өөнтөглөн маргах гэж оролдов. Тэд тулгуур сургаалуудыг ярилцахгүй байж, хэрэгтэй хэрэггүй юм хамж шимж яриад байлаа. Доктор Айронсайд тэднийг тэвчээртэйгээр сонсоод нэг завсар гарахаар нь "Ах дүүс минь, мөнхийн улсад очихоор бидний хэн нь буруутай нь тогтоогдоно. Магадгүй тэр нь би байх биз" гэж хэлжээ. Энэ хариулт тэднийг хэлэх үггүй болгож доктор Айронсайд өөр хүмүүстэй ярилцах боломжтой болсон байна.

Бид шүүмжлэлийг хэрхэн хүлээж авдаг вэ? Өөрсдийгөө өмөөрч, хэрүүл маргаан гаргаж, нөгөө хүнийхээ талаар бодсон хамаг шүүмжлэлт бодлуудаа урсгадаг уу? Эсвэл дөлгөөхнөөр "Найз минь, чи миний

талаар багыг мэддэг нь ямар сайн хэрэг вэ! Ихийг мэдвэл бүр ч их шүүмжлэх байсан" гэж хариулдаг уу? Иймэрхүү хариулт олон галыг унтраах байсан даа.

Бидний ихэнх нь хорвоогийн хамгийн муухай үгтэй захиаг авч байсан биз ээ. Ийм үед хүний төрөлх араншин бол үзэг цаасаа барьж аваад муу муухай үгээр хариу бичнэ. Хариуд нь ч бүр ч хорон муу үгтэй захиа хүлээн авна. Тиймээс "Найз минь, чи тэмцмээр байгаа бол диаволтой тэмцээрэй" гэж бичвэл хамаагүй дээр байхсан.

Өөрийгөө өмгөөлж, хүнтэй хэрэлдэж, муу муухай үгсээр маргалдаж суухад амьдрал дэндүү богинохон. Иймэрхүү зүйлс гол анхаарлыг минь алдагдуулж, сүнслэг харааг минь булингартуулж, Эзэнийг гэрчлэх гэрчлэлийг унагаадаг. Хүмүүс бамбар барьж ирээд санаатайгаар гал асааж болно. Бид тэднийг удирдаж чадахгүй. Харин гал дээр тос нэмэхгүй байж чадна. Гал дээр нь тос нэмэхгүй байваас аажимдаа гал унтарна.

## 12 сарын 18

*"Мууг сайн, сайныг муу гэж нэрлэгчид, харанхуйг гэрэл, гэрлийг харанхуйгаар солигчид, гашиууныг амттай, амттайг гашиуунаар орлуулагчид хөөрхий ээ!" (Иса 5:20)*

Ёс суртахууны хэм хэмжээг урвуулж, нүглийг сайхан хэмээж, ариун байдлыг хүсэшгүй зүйл гэж ухуулагсдыг Бурхан золгүй хүмүүс хэмээн тунхаглаж байна. Хэрбэрт Вандэр Лугт орчин үеийн хүн ёс суртахууны хэм хэмжээг яаж гуйвуулж байгааг гурван жишээгээр тайлбарласан: "Нэг дэх нь, порнографын муу муухайг хөнгөнөөр тайлбарлаж, цэвэр ариун ёс суртахууныг баримталдаг итгэгчдэд халагласан өнгө аястай нийтлэлийг саяхан би уншлаа. Хоёр дахь нь, гэр бүл болоогүй байж жирэмсэн болсон багш эмэгтэйг ажлаа өгөхийг шаардсан хэсэг бүлэг эцэг эхийн тухай сонины мэдээ. Сурвалжлагч, багшийг үзэсгэлэнт эмэгтэй гэж дүрслээд эцэг эхчүүдийг увайгүй амьтад болгож бичжээ. Гурав дахь нь, телевизийн ярилцлагын цагаар оролцсон зочин, хүнд рок, архидалтыг өмөөрч, тоглолтын үеэр хар тамхи хэрэглэх явдлыг зөвтгөж байв. Гэтэл энэ тоглолтын үеэр хэд хэдэн залуу амиа алдсан юм. Тэрээр ийм төрлийн цугларалтыг шүүмжилдэг хүмүүс манай нийгмийн асуудлыг бий болгож байна гэж буруутгасан."

Нийгэмд ёс суртахууны зөв хэм хэмжээг уландаа гишгэж байгаа нь хоёр шалтгаантай гэж би боддог. Нэг дэх нь, хүмүүс Библид бичигдсэн хэм хэмжээг илт умартаж байна. Тэд ёс суртахууныг өөр өөрийн дураар тайлбарладаг. Хоёрт гэвэл, хүмүүс нүгэлд дэндүү их автаж

байгаа учраас нүглийг байж болох асуудал хэмээн дүгнэж өөрсдийгөө өмөөрдөг.

Нүглийг зөвтгөж чадахгүй болохоороо нүглийг буруутгагч хүмүүс рүү тэд дайрцгаадаг. Өөрийн бурууг олж харахын оронд бурууг нь хэлж байгаа хүмүүсийг үзэн яддаг. Дээр дурдсан жишээнээс ярихад, бэлгийн цэвэр ариун байдлыг чухалчилдаг хүмүүсийг дорд үзсэн. Үр хүүхдэд нь буруу үлгэр дуурайл үзүүлэх багшийг зэмлэсэн эцэг эхчүүдийг өөдгүй амьтан хэмээн харлуулсан. Архи, хар тамхийг буруутгаж, залуусын аминд хүрсэн рок концертод дургүйцсэн хүмүүсийг нийгэмд гарч буй асуудлуудын буруутан болгосон.

Ёс суртахууны хэм хэмжээг уландаа гишгэж, мууг сайн хэмээгчдийн хажуугаар мууг шулуухан муу гэж хэлдэггүй булингартуулдаг хүмүүс байна. Эдний дунд христэч удирдагчид олон тоогоор байгаа нь тун харамсалтай. Тэд Библийн талд зогсож, нүглийг нэрээр нь дуудахын оронд асуудлыг бөөрөнхийлж, тийм ч муу биш шүү дээ гэсэн санааг цухалзуулдаг. Архидалтыг өвчин гэнэ. Гэрлэлтээс гадуурх бэлгийн харилцааг нийтээр зөвшөөрч байвал асуудал биш гэцгээнэ. Гажуудлыг амьдралын нэг төрлийн хэв маяг гэж үзнэ. Үр хөндөлт, задгай хувцаслалт, биеэ үнэлэлтийг хүний эрх учраас шүүмжилж болохгүй гэцгээнэ.

Иймэрхүү хүний толгой эргүүлсэн, бөөрөнхийлсөн үзэл санаа нь ёс суртахууныг улам дордуулдаг. Энэхүү үзэл санаа нь диаволын худал хуурмаг бөгөөд хүнийг гэм нүгэлд нь живүүлнэ.

## 12 сарын 19

*"Тэнгэр газар өнгөрөн одовч Миний үгс үгүй болохгүй."*  
(Лк 21:33)

Бурханы үг мөнхийнх төдийгүй заавал биелнэ. "Тэнгэр газар өнгөрөн одож, бүгд биелэгдтэл хуулиас ганц ч үсэг [иод], ганц ч зураас алга болохгүй" гэж Матай 5:18 дээр Есүс хэлсэн. Иод гэдэг нь еврей цагаан толгойн нэг үсэг бөгөөд таслалтай төстэй. Зураас гэдэг нь еврей үсгийн нэг дүрс бөгөөд том Е үсгийн доод зураастай адил. Энэ зураасыг Е үсгээс авчихвал F үсэг болно. Өөрөөр хэлбэл Бурханы үгийн хамгийн жижиг хэсэг ч гэсэн заавал биелнэ гэж Есүс хэлж байгаа юм.

МЭ 331-363 онд амьдарч асан Ромын эзэн хаан Юлиан Библийг худал болохыг нотолно гэж христитгэлийг үгүйсгэхээр шийджээ. Тэрээр Лук 21:24-г тусгайлан сонгож аваад худал болохыг нь батлах гэж оролдов: "Илдний ирээр тэд унагаагдаж, бүх үндэстнүүд уруу цөлөгдөнө. **Харийнхны цаг гүйцэх хүртэл Иерусалим харийнхны хөл доор талхлагдах болно.**" Тэрээр Иерусалимын сүмийг дахин барих ажлыг дэмжиж, иудейчүүдийг зоригжуулж эхлэв. "Иудейчүүд шаргуу ажиллаж, баярлаж хөөрсөндөө мөнгөн хүрээр газар ухаж, нил ягаан өнгийн даавуугаар шороо зөөж байлаа. Гэтэл газар хөдлөлт болж, газар доороос галт бөмбөлгүүд гарснаас болоод ажил зогсжээ. Тэд барилгын ажлыг үргэлжлүүлэх боломжгүй болсон" гэж Гиббоны "Ромын эзэнт гүрний мөхөл" зохиолд бичсэн байна.

Христийг ирэхээс 600 орчим жилийн өмнө бичигдсэн Езекиелийн зөгнөлд "Жонон" ирэх хүртэл Иерусалимын

зүүн хаалга нээгдэхгүй гэж зөгнөсөн. Уг хаалгыг хожим нь алтан хаалга гэж нэрлэсэн бөгөөд МЭ 1543 онд султан Сулейман хаажээ. Кайсер Вилгелм Иерусалимыг эзлэн авахаар төлөвлөхдөө уг хаалгаар орно гэж бодсон боловч түүний хүсэл талаар болсон. Хаалга ч хаалттай хэвээр үлдсэн.

Вольтер, “Зуун жилийн дотор Библи ямар ч хэрэгцээгүй ном болно” гэж бардамнасан. Зуун жил өнгөрөхөд Волтер өөрөө нас барж, гэр нь Женевийн Библийн нийгэмлэгийн төв оффис болжээ. Ингерсолл мөн ийн бардамнаж, “15 жилийн дотор Библи моргт очно” гэж хэлсэн. Гэвч Библи биш Ингерсолл өөрөө моргт очсон. Библийг шүүмжлэгч нар өнгөрөн одовч Библи үлдэж хоцордог.

Библи бол Бурханы мөнх үг бөгөөд хэзээ ч өнгөрөн одохгүй. “Ийм илэрхий юмыг олж хардаггүй хүнээс илүү сохор хүн гэж үгүй.” (Жонатан Свифт)

## 12 сарын 20

"Би байгаадаа сэтгэл хангалуун байж сурсан юм." (Флп 4:11)

Амьдралын нөхцөл байдал ямар байхаас илүү нөхцөл байдалд яаж хандах вэ гэдэг нь чухал. Нөхцөл байдлыг өөрчлөх гэж оролдохоос илүү өөрийгөө өөрчлөх нь амархан.

Хэцүү зүйл тохиолдоход хүмүүс янз бүрийн хандлага гаргадаг. Эхнийх нь шүд зуун тэсэх хандлага. Тийм хүмүүс ямар ч сэтгэлийн хөдөлгөөн гаргахгүй, тэвчиж, ямар нэг үйлдэл хийхгүй асуудлыг давах гэж оролддог. Яаж ч болохгүй юмыг яалтай билээ гэсэн үзэл бодолтой.

Зарим хүн асуудалд сүр дуулиан бадруулж хандана. Уйлж, хашхирч, биеийн хэлэмжээрээ зовлонгоо илэрхийлнэ. Зарим хүн ялагдал хүлээсэн байдлаар хариу үзүүлнэ. Тэд цөхөрч бууж өгдөг. Туйлдаа хүрэхээр амиа хорлож ч магад.

Христэч хүний зөв хандлага нь хүлцэнгүй байх. "Тохиолдлын санамсаргүй хэрэг гэж үгүй. Амьдралд минь ирэх бүх зүйлийг Бурхан удирдаж байгаа. Бурхан алдаа гаргадаггүй. Өөрийгөө алдаршуулж, бусдыг ерөөж, надад сайныг хийхийн тулд Бурхан үүнийг зөвшөөрсөн. Бурханы төлөвлөгөөг бүтнээр нь харж чадахгүй байгаа ч Түүнд би найдна. Түүний хүсэлд би бөхийнө. Өөрийгөө надаар алдаршуулж, заахыг хүссэнээ надад заагаач гэж би залбирна" гэж итгэгч хүн бодох ёстой.

Итгэгч хүний өөр нэг хандлага гэвэл нөхцөл байдлыг ялгуусан ялалт болгох. Ийм хандлагатай итгэгч хүн цөөхөн. Би ч өөрийгөө тэдний нэг гэж хэлж чадахгүй.



Мэдээж тэдний нэг болохыг хүсдэг. Тэд замд тээглэсэн чулууг ялалтад хүргэх гишгүүр болгодог. Тэд гашууныг чихэрлэг, үнс нурмыг гоо үзэсгэлэн болгож хувиргадаг. Тэд нөхцөл байдалд захируулдаггүй. Харин нөхцөл байдлыг өөрсдөдөө үйлчлүүлдэг. Тэднийг “давуулан дийлэгч” гэнэ. Хэдэн жишээ хэлье.

Амьдрал нь цөхрөл, уй гунигаар дүүрсэн мэт харагдах нэгэн христитгэгч эмэгтэй байлаа. Гэвч түүний намтарт “Тэрээр Бурханыг эсэргүүцсэн эсэргүүцлээс гайхамшигтай цэцгийн баглаа хийсэн билээ” гэж бичигдэн үлджээ.

Дорнын нэгэн улсад уурлан хилэгнэсэн этгээдүүд итгэгчид рүү чулуу шидэлжээ. Тэр итгэгчид буцаж ирээд өөрсөд рүү нь шидсэн чулуунуудаар сүмийн барилга барьсан байна.

Нэг хүн байшин худалдаж автал цэцэрлэгийнх нь төвд томоо гэгчийн бул чулуу байлаа. Тэрээр чулуун цэцэрлэг байгуулахаар шийджээ.

Э. Стэнли Жонсийн хэлсэн шиг “Үгүйсгэлүүдийг ашиглаад өөр боломжийн үүд хаалга гаргацгаая.” Нэгэн ухаант хүний хэлсэн шиг “Амьдрал танд исгэлэн нимбэг өгвөл нимбэгийн ундаа хийгээрэй.”

Нүдний өвчин туссан хүн эмчид үзүүлтэл, нүдээ авхуулж болор нүд хийх шаардлагатай гэдэг хариу сонсов. Өнөөх хүн эмчдээ, “Гялалздаг нүд хийгээд өгөөрэй” хэмээн хэлжээ. Нөхцөл байдалд захирагдахгүй амьдрах гэж энэ юм.

## 12 сарын 21

*“Христ чуулганыг хайрлаад түүний төлөө Өөрийгөө өгсөн.” (Еф 5:25)*

Чуулган Христийн бодол сэтгэлд туйлын онцгой байр суурь эзэлдэг. Тиймээс бид ч гэсэн чуулганыг чухалчлан үзэх ёстой.

Шинэ гэрээнээс чуулган ямар чухлыг олж харж болно. Мөн элч нарын үйлчлэл ч чуулганыг чухалд тавьж байсан. Тухайлбал Паул сайнмэдээг тунхаглаж, чуулганы тухай (Бурханы дотор үеэс үед нууцлагдаж байсан нууцыг) ярих нь миний үйлчлэл юм гэж хэлсэн (Еф 3:8,9). Элч нар чуулганыг маш онцгойд үзэж байсан атал өнөөдөр тэднийх шиг хандлага харагдахаа больжээ. Элч нар хаа ч очсон чуулган тарьж байсан бол өнөөдрийн хүмүүс очсон газраа христэч байгууллага үүсгэх нь түгээмэл болсон.

Чуулганы тухай сургаал нь Библийн илчлэлийн ноён оргил юм (Кол 1:25,26). Энэ нь илчлэгдэх ёстой хамгийн сүүлчийн гол сургаал.

Чуулганаас тэнгэрэлч нар хүртэл суралцдаг (Еф 3:10). Тэд Бурханы олон талт мэргэн ухааны тухай чуулганаас сурч авдаг.

Бурхан энэ дэлхий дээр итгэлийг түгээж, хамгаалуулахаар чуулганыг сонгосон (1Тм 3:15). Чуулганыг үнэний тулгуур ба багана гэж нэрлэдэг. Сайнмэдээг дэлгэрүүлэх, итгэгчдийг барьж босгох ажилд идэвхийлэн оролцож байгаа христэч байгууллагуудад талархах нь зөв. Гэхдээ энэ байгууллагууд чуулганыг орлоно гэвэл буруу. Үхэгсдийн орны хаалга чуулганыг

дийлэхгүй гэж Бурхан амласан (Мт 16:18). Энэ амлалтыг христэч байгууллагуудад өгөөгүй.

Паул чуулганыг бүхнийг Дүүргэгчийн дүүрэл гэж хэлсэн (Еф 1:20-23). Мөн чуулган нь Христийн бие бөгөөд итгэгчид тэр биеийн эрхтнүүд. Тэргүүн болох Христ эрхтнүүдгүйгээр нэг бүтэн бие болж чадахгүй.

Чуулган нь Христийн бие төдийгүй (1Ко 12:12,13), Христийн сүйт бүсгүй (Еф 5:25-27,31,32). Энэ эрин үед Христ Өөрийн бие болох чуулганаар дамжуулан Өөрийгөө дэлхийд илэрхийлдэг. Чуулган Түүний сүйт бүсгүй учраас онцгой хайрыг нь хүртэгч юм. Ирээдүйн хаанчлал, яруу алдарт үе ирэхэд чуулган Христтэй хамт хаанчилж, цог жавхланг нь хуваалцана.

Энэ бүхнээс дүгнээд үзэхээр, итгэгчдийн хамгийн сул дорой цуглаан ч гэсэн Христийн хувьд ертөнцийн хамгийн агуу эзэнт гүрнээс үнэ цэнтэй. Христ чуулганыг туйлаас онцгойлон эрхэмлэж үздэг. Тэгэхээр чуулганы ахлагч гэдэг нь ямар ч ерөнхийлөгч, эзэн хаанаас эрхэм чухал юм. Шинэ гэрээнд сайн удирдагч байх талаар заавар цөөхөн өгөгдсөн боловч ахлагчийн талаар ихийг өгүүлжээ.

Хэрэв бид чуулганыг Эзэний нүдээр харж эхэлбэл амьдрал, үйлчлэлд маань хувьсгал гарна.

## 12 сарын 22

*"Учир нь бид үнэний мэдлэгийг хүлээн авсныхаа дараа зоргоороо нүгэл үйлдсээр байвал нүглийн төлөөх тахил цаашид үлдэхгүй. Харин шүүлт хийгээд эсэргүүцэгчдийг шатаах галын хилэнг айн чичирч хүлээх л үлдэнэ."* (Евр 10:26,27)

Үнэн сэтгэлээсээ Христэд итгэдэг хүмүүсийн толгойг гашилгадаг хэд хэдэн эшлэл Шинэ гэрээнд байдгийн нэг нь энэ. "Би нүгэл хийх сорилтод орсон. Буруу гэдгийг нь мэдэж байсан. Хийх ёсгүйгээ ч мэдэж байсан. Би санаатайгаар дуулгаваргүй хандсан. Сайн дураараа нүгэл хийсэн. Энэ эшлэлийг харвал би авралаа алджээ" гэж тэд боддог.

Энэ эшлэлийг хам сэдвээс нь салгаж, хэлэх гэсэн санаанаас нь огт өөр утга гаргаж ирдэгт гол асуудал байгаа юм. Хам сэдэв нь хуурамч итгэгч гэгчид итгэлийг орхих тухай (апостаси-итгэлээс салах) өгүүлсэн. Нэгэн үе өөрийгөө христитгэгч гэж нэрлэж байснаа хэсэг хугацааны дараа христитгэлээс нүүр буруулж, Христийг эсэргүүцэгч болж хувирахыг апостаси буюу итгэлээс салах явдал гэнэ. Еврей номыг бичигч түүнийг 29-р эшлэлд тодорхойлсон: "Бурханы Хүүг уландаа гишгэж, өөрийг нь ариусгасан гэрээний цусыг бузар хэмээн тооцож, нигүүлслийн Сүнснийг доромжлогч." Христийн эсрэг хорсолтойгоор эргэж байгаагаараа хэзээ ч дахин төрөөгүй гэдгээ тэр харуулдаг.

Хүн сайнмэдээг сонсож, христитгэлд элэгтэй болжээ. Өвөг дээдсийнхээ хуурамч шашныг орхиж, жинхэнээр дахин төрөөгүй атлаа христэч нэрийг зүүжээ. Гэтэл хэцүү

бэрхшээл, хавчлага ирэх үед христитгэгч хэмээн нэрлэгдэх нь зөв эсэхэд эргэлзэж эхлэв. Ингээд хуурамч шашин руугаа буцав. Гэхдээ энэ нь тийм ч амар хэрэг биш. Удирдагч хүн итгэлээсээ ухрах болбол нэг жижиг ёслол хийх ёстой болдог байлаа. Тэд гахайн цус аваад газар асгана. Тэгээд “Энэ бол Христийн цус. Хэрэв чи эцэг эхийнхээ шашин руу эргэхээр шийдсэн бол үүний дээгүүр алх” гэнэ. Тэр ч үүнийг хийнэ. Энэ үйлдлээрээ тэрээр Бурханы Хүүг уландаа гишгэж, цусыг нь бузар хэмээн тооцож байгаа юм. Энэ бол итгэлийг орхигч хүн бөгөөд санаатайгаар ийм нүгэл үйлдэж байгаа юм.

Жинхэнэ итгэгч ийм нүгэл хэзээ ч хийж чадахгүй. Жинхэнэ итгэгч мэдсээр байж нүгэлд унах нь бий. Сайн дураараа буруу үйлдэл хийж магад. Мэдээж түүний нүглийг зөвтгөх ямар ч арга байхгүй. Бурханы нүдэнд ч ноцтой харагдана. Гэхдээ нүглээ улайж, түүнээсээ гэдрэг эргэснээр тэр уучлалыг хүртэх боломжтой. Харин итгэлээ орхигч хүнд ийм боломж байхгүй. Түүний нүгэлд цаашид ямар ч тахил үлдэхгүй. “Дараа нь завхайрагсад дахин шинээр гэмших боломжгүй” (Евр 6:6).

## 12 сарын 23

*“Түүний дотор байгч хэн ч нүгэл үйлддэггүй. Нүгэл үйлддэг хэн ч Түүнийг үзээгүй, мэдээгүй.” (1Ио 3:6)*

Жинхэнэ христитгэгчийг зовоодог нэг эшлэлийг өчигдөр үзсэн. Тэгвэл өнөөдөр, нүгэлтэйгээ ойлгож мэддэг жинхэнэ итгэгчдийг зовоодог гурван эшлэлийг Иоханы 1-р захианаас ярилцъя. Эхнийх нь өнөөдрийн эшлэл. Хоёр дахь нь 1Иохан 3:9: “Бурханаас төрөгч бүр нүгэл эс үйлддэг. Учир нь Бурханы үр түүн дотор оршдог. Тэрээр Бурханаас төрсөн тул нүгэл үйлдэж эс чадна.” Гурав дахь нь 1Иохан 5:18: “Бурханаар төрсөн хэн боловч нүгэл үйлддэггүйг бид мэднэ. Тэднийг харин Бурханаар төрсөн Тэрээр хамгаалдаг бөгөөд ёрын муу нэгэн тэдэнд хүрэхгүй.” Энэ гурван эшлэлийг уншихаар бид үнэхээр жинхэнэ итгэгч мөн эсэхдээ өөрийн эрхгүй эргэлзээ төрдөг.

Гэтэл Иоханы нэгдүгээр захидлын өөр нэг газарт итгэгч хүн нүгэл үйлддэгийг хүлээн зөвшөөрсөн. Жишээлбэл 1:8-10, 2:1.

Дээрх гурван эшлэлийг буруу ойлгоход хүргэж буй гол шалтгаан нь орчуулгын асуудал. Шинэ гэрээний эх грек хэл дээр нэг удаагийн нүгэл болон давтан давтан үйлддэг нүглийг ялгах ялгаа байдаггүй. Итгэгч хүн нүгэл үйлдэх үе бий. Гэхдээ байнга үйлддэггүй. Нүгэл түүний амьдралын хэв маяг биш. Нүгэл түүний амьдралын эзэн байхаа больсон.

Библийн Олон Улсын Шинэ Орчуулга (New International Version) энэ гурван эшлэлийн үйл үгийг үргэлжлэх төлөв дээр орчуулжээ: “Түүний дотор байгч хэн ч нүгэл үйлдсээр байдаггүй. Нүгэл үйлдсээр байдаг хэн ч

Түүнийг үзээгүй, мэдээгүй” (1Ио 3:6). “Бурханаас төрөгч бүр нүгэл эс үйлдсээр байдаггүй. Учир нь Бурханы үр түүн дотор оршдог. Тэрээр Бурханаас төрсөн тул нүгэл үйлдсээр байж эс чадна” (1Ио 3:9). “Бурханаар төрсөн хэн боловч нүгэл үйлдсээр байдаггүйг бид мэднэ. Тэднийг харин Бурханаар төрсөн Тэрээр хамгаалдаг бөгөөд ёрын муу нэгэн тэдэнд хүрэхгүй” (1Ио 5:18).

Христигтэгч өөрийгөө нүгэл үйлддэггүй гэж хэлбэл нүглийн талаар сайн ойлгоогүй гэсэн үг. Бурханы төгс хэм хэмжээнд эс хүрэгч бүхэн нүгэл гэдгийг тэр ухаараагүй нь илэрхий байна. Үнэндээ бид бодол санаа, үг хэл, үйлдлээрээ өдөр бүр нүгэл үйлдэж байдаг.

Иохан энд хүний амьдралын дадал хэвшил болсон нүглийг ярьж байна. Нэг удаагийн эсвэл тохиолдлын нүглийг яриагүй. Жинхэнэ итгэгч хүний амьдралын мөн чанарт нүгэл нь харь зүйл. Итгэгч хүний амьдралын тодорхойлолт нь зөвт байдал.

Тэгэхээр эдгээр эшлэлийг үзээд авралдаа эргэлзэх хэрэггүй. Мэдээж Бурхан биднийг нүгэл үйлдэхгүй байгаасай гэж хүсдэг. Харамсалтай нь бид нүгэл үйлддэг. Гэхдээ нүгэл бидний амьдралд захирах хүчгүй болсон. Бид аврагдахаас өмнөх үеийнх шигээ байнга нүгэлтэй хутгалдаж амьдрахаа больсон. Бид нүгэл үйлдвэл гэмшиж, нүглээ улайж, түүнээс гэдрэг эргэснээр уучлалыг олно.

## 12 сарын 24

*"Баячуудын хөрөнгө нь хүчирхэг хот. Өөрийнх нь төсөөлөлд өндөр хана мэт буюу." (Сур 18:11)*

Асар их эд баялагтай боловч түүгээрээ юу хийхээ мэддэггүй мунхаг баяны тухай Лукийн сайнмэдээнд өгүүлдэг. Тиймээс тэр хуучин агуулахаа нурааж илүү томыг барихаар шийджээ. Энэ их эд баялаг нь сэтгэл ханамж өгнө гэж тэр боджээ. Даан ч барилга баригдаж дуусмагц үхнэ гэдгээ мэдээгүй байлаа. Эд хөрөнгө нь түүнийг үхэл ба булшнаас аварч чадахгүй.

Мунхаг баян болбоос шуналт хүний дүрслэл билээ. Тэр их эд хөрөнгө өөрт нь ямар ч хэрэггүй атал илүү ихийг олж авах гэсэн шунал хүсэл түүнд байлаа. Эд хөрөнгө цуглуулах их амжилт нь материаллаг зүйлсээр бүх хэрэгцээгээ хангаж чадна гэсэн утгагүй дүгнэлтэд хүргэжээ. Гэтэл Бурханы нүдээр түүний хандлага мунхаглал төдий харагдав. Баян эр ердөө л нэг тэнэг хүн аж.

Үнэт цаасны бизнесээр баяжих хүсэлтэй нэгэн хүн байлаа. Бирд гарч ирээд нэг хүслээ хэл гэв. Өнөөх хүн жилийн дараа гарах сонины дугаарыг уншихыг хүсжээ. Дараа жил хамгийн их өсөх хувьцааг мэдэж аваад наана нь худалдан авч мөнгөө хэд дахин өсгөх нь түүний гол санаа байв. Бирд түүнд сониныг өгтөл өнөөх хүн чинээлэг нэгэн болсон тухай мэдээ нийтлэгджээ. Гэвч гашуудлын буланд өөрийг нь нас барсанд эмгэнэл илэрхийлсэн байв.

Дуулалыг бичигч эд баялгаа үүрдийн юм шиг санадаг хүмүүсийн хэчнээн мунхаг болохыг хэлжээ. "Газар нутгаа тэд өөрсдийнхөө нэрээр нэрлэвч булш нь тэдний үүрдийн



орон гэр, үеийн үед суух газар нь байна” (Дуу 49:11). Тэд үхэхдээ эд хөрөнгөө бусдад үлдээгээд одно. “Хүндэтгэл дотроо хүн хоноглож үл чадах агаад тэрээр мөхөс адгуустай л адил” (Дуу 49:12).

Мөнгө хүнийг энэ дэлхийн хаана ч очуулж чадах боловч мөнхийн улсад очуулж чадахгүй. Мөнгө хүний материаллаг хэрэгцээг хангаж чадах ч аз жаргалыг өгч чадахгүй.

Баян хүн амьдралынхаа турш эд мөнгөний хойноос хөөцөлдөвч булшин дээрээ долларын тэмдэг тавьдаггүй. Амьдралынх нь гол утга учир болсон зүйлийн бэлгэ тэмдгийг булшны чулуун дээр нь сийлдэг байсан бол яах аргагүй мөнгөн тэмдэгтийг тавина. Гэтэл баячууд үхэхдээ загалмай гэх мэт шашны тэмдэг тавьдаг. Хоёр нүүрийнх нь эцсийн үйлдэл энэ ажээ. Зөвт хүн үүнийг хараад “Харагтун, Бурханыг хүчит цайзаа болгоогүй, харин баялгийнхаа элбэгт итгэж, хорлол дотроо батажсан хүн” гэх болно (Дуу 52:7). Бурхан ч түүний талаар “Тэр хүн өөрийнхөө төлөө эд баялгийг хураадаг ч Бурханд үл бялхдаг болой” (Лк 12:21) гэж эмгэнэл бичнэ.

## 12 сарын 25

*"Итгэл сүсгийн нууц агуу нь эргэлзээгүй. Махбодоор илчлэгдсэн Тэр, Сүнс дотор зөвтгөгдсөн. Тэнгэрэлч нарт үзэгдсэн Тэр, харийнханд ч тунхаглагдсан. Ертөнцөд итгэгдсэн Тэр, сүр алдраар дээш авагдсан."* (1Тм 3:16)

Энэхүү нууц нь дэндүү нууцлаг болохоор биш, харин дуу алдан алмайрч, гайхаж биширмээр болохоор агуу юм. Бурхан махбодоор илчлэгдсэн гэдэг гайхамшигт үнэн нь энэхүү нууц болой.

Тухайлбал Мөнх Нэгэн нь цаг хугацаат ертөнцөд төрсөн тухай энэ нууц өгүүлдэг. Цаг хугацаагүй Нэгэн нь хуанли, цаг тоолол бүхий ертөнцөд амьдарчээ.

Хаа сайгүй нэгэн зэрэг Оршигч нь Бетлехем, Назар, Капернаум, Иерусалим зэрэг нэг газарт Өөрийгөө хязгаарлажээ.

Тэнгэр ба газрыг Дүүргэгч аугаа Бурхан хүний бие дотор багтжээ. Түүнийг харсан хэн ч "Түүн дотор Бурханы төгс дүүрэн нь бүхлээрээ биетээр оршдог" гэж хэлж чадна.

Бүтээгч дэлхий нэртэй жижигхэн гараг дээр айлчилсан гэдгийг энэ нууц бидэнд сануулдаг. Бүх орчлон ертөнцтэй харьцуулахад энэ дэлхий сансрын тоос төдийхөн юм. Гэтэл Тэр энэ газарт иржээ. Тэнгэрийн орд харшаасаа малын саравчинд төржээ.

Бүхнийг чадагч Нэгэн сул дорой нярай хүүхэд болжээ. Мариагийн тэвэрт байсан Нэгэн Мариаг тэвэрч байсан гэж хэлэхэд буруудахгүй биз. Учир нь Тэр бол орчлон ертөнцийн Бүтээгч төдийгүй Ивээн тэтгэгч, Тогтоон баригч билээ.

Тэрээр бүх мэргэн ухаан, мэдлэгийн эх сурвалж, бүхнийг мэдэгч Нэгэн атал хүүхэд байхдаа мэргэн ухаан ба мэдлэг дотор өссөн гэж Түүний тухай бичигдсэн байна. Бүхний Эзэн өөрийнхөө эзэмшилд ирэхэд хэн ч угтан аваагүй гэдгийг бодохоор хэчнээн харамсалтай. Дэн буудалд Түүнийг оруулах өрөө байсангүй. Ертөнц Түүнийг таньсангүй. Өөрийнхөн нь Түүнийг хүлээн авсангүй.

Орчлонгийн Эзэн энэ ертөнцөд зарц болон иржээ. Алдрын Эзэн цог жавхлангаа махан биед далдалжээ. Амийн Эзэн энэ ертөнцөд үхэхээр иржээ. Ариун Нэгэн нүгэлт орчлонд мэндлэв. Хязгааргүй өндөрт Оршигч нь туйлын дорд болов. Эцгийн баяр баясал, тэнгэрэлч нарийн мөргөл хүндэтгэлийг хүртэгч нь өлсөж, цангаж, ядрахдаа Иаковын худаг дээр амсхийж, Галил нуурт завин дээр унтаж, мутраараа бүтээсэн ертөнцдөө орон гэргүй харь хүн шиг тэнүүчилсэн. Тэрээр тансаг газраас ядуу газарт ирж, толгой хорогдох ч орон гэргүй явсан. Тэрээр мужаан хийж, шаргуу ажилласан. Хэзээ ч зөөлөн гудсан дээр унтаагүй. Хананаасаа халуун хүйтэн ус гоождог биднийх шиг тав тухыг огт үзээгүй.

*Тэрээр бидний төлөө амьдарсан*

*Түүнийг бүгдээрээ бишрэн хүндэтгэе*

## 12 сарын 26

*"Содомын хаан Абрамд 'Хүмүүсийг надад өг, эд хөрөнгийг нь чи өөртөө ав' гэв."* (Эх 14:21)

Халдан түрэмгийлэгч цэрэг арми Содомд ирж Лотыг гэр бүлийнх нь хамт олзлоод их хэмжээний хөрөнгө мөнгө дээрэмдэн тоножээ. Абрам энэ тухай сонсмогцоо зарц нараа зэвсэглээд тэдний араас нэхэн хөөж, Дамаскийн ойролцоо очоод олзлогсдыг эд хөрөнгөтэй нь аврав. Абрамыг буцаж ирэхэд Содомын хаан гарч ирээд "Хүмүүсийг надад өг, эд хөрөнгийг нь чи өөртөө ав" гэж хэлэв. Абрам "Би чамгаас ширхэг үдээс ч авахгүй. Эс бөгөөс би Абрамыг баяжуулсан гэж чи хэлж магад" хэмээн Содомын хаанд хариулсан.

Содомын хаан нь нэг талаараа Сатаныг төлөөлж байна. Тэрээр итгэгчдийн харааг материаллаг зүйлсэд хандуулж, хүмүүсийг огооруулахыг оролддог. Абрам энэ сорилтыг эсэргүүцсэн. Гэвч ихэнх хүн эсэргүүцэж чаддаггүй. Тэд хөрөнгө мөнгө цуглуулахад хамаг анхаарлаа хандуулаад Бурхангүй, Христгүй, найдваргүйгээр мөнхөд тамд тарчлах гэж буй хөршүүдээ, найзуудаа умартдаг.

Эд зүйл биш хүмүүс чухал. Ээж нь хувцас нэхээд сууж байтал залуу христитгэгч зочны өрөөндөө орж ирээд "Ээж ээ, Бурхан надад эд зүйлсээс илүү хүмүүсийг хайрлах хайр өгсөнд би баяртай байна" гэж хэлэв. Ээж нь ч бас баяртай байсан нь мэдээж.

Үнэт шаазан ваар минь хагарахад бид уйлдаг мөртөө, сая сая хүн мөхөж байгаад уйлдаггүй. Бейсболын тэмцээний оноог сайн санадаг атлаа хүмүүсийн нэрийг амархан мартдаг. Машин маань мөргөлдөхөд миний

машин хэр их гэмтэв гэж хардаг болохоос нөгөө машинд гэмтсэн хүнийг боддоггүй. Хийж байгаа ажилд маань хүн саад болж, ярилцахыг хүсэхэд бид амархан унтууцдаг. Гэтэл тэр хүний асуудал ажлаас маань ч чухал байж болно шүү дээ.

Бид хүнээс илүү алт мөнгийг сонирхдог. А. Т. Пиерсон: “50,000 хөлөг онгоц барьж, бүгдийг нь илгээлтийн эзнээр дүүргэж, ханатал нь Библи ачиж, дэлхийн хязгааруудад сүм чуулган барьж, хүн бүрд сайнмэдээг хүргэх ажлыг санхүүжүүлэх алт, мөнгө, хэрэгтэй хэрэггүй чимэглэлүүд христитгэгч айлуудад хий дэмий хэвтэж байна” гэж хэлжээ. Бурханы өөр нэгэн эш үзүүлэгч Ж. А. Стюарт: “Бид эд хөрөнгөө ямар ч шаардлагагүй тансаглалд зориулдаг. Дэлхийн нөгөө талд сая сая хүн нүгэл дотроо мөхөж байхад бид элбэг дэлбэг хоол ундаар ширээгээ дүүргэдэг. Бид ууган хүүгийн эрх бүхий сүнслэг өвөө аяга шөлөөр зарж байна” гэж бичсэн.

Христитгэгч бид эд хөрөнгө цуглуулах гэсэн мунхаг хүсэл сонирхлоо хэзээ хаяж, хүмүүсийн сүнслэг хэрэгцээнд анхаарах юм бол доо гэж хааяа би боддог юм. Нэг хүний сүнс дэлхийн бүх баялгаас үнэтэй. Эд юмс чухал биш. Хүмүүс чухал.

## 12 сарын 27

*“Энэ бол та нарын төлөөх Миний бие мөн.” (1Ко 11:24)*

Эмми Кармайкл Библи дотроос эмтэрч, хагарч, хуваагдсан дөрвөн зүйлийг олж тэдний үр дүнд юу бий болсон бэ гэдгийг жагсааж бичжээ.

Хагарсан ваар (Шүү 7:18,19) – Гэрэл гэгээ туссан.

Хагарсан гөлтгөнөн сав (Мк 14:3) – Эзэнийг үнэт тосоор тосолсон.

Хуваасан талх (Мт 14:19) – Өлссөн олныг хооллосон.

Гэмтэж шархадсан бие (1Ко 11:24) – Ертөнц аврагдсан.

Эдүгээ энэ жагсаалтад би тав дахийг нь нэмье: Хүслээ хаях – Хүний амьдралд амар амгалан, дүүргэлт ирнэ.

Аврагдахын тулд загалмай дээр ирсэн хүмүүсээс олонх нь хүслээ хаяхын тулд тэнд ердөө очдоггүй. Тэд дөлгөөн зөөлөн зантай байж болно. Огт уурлан уцаарладаггүй сүнслэг дүртэй ч байж болно. Гэвч амьдралд нь өгөх Бурханы хамгийн сайныг авахад өөрсдийнх нь хахир хүсэл хазаар болоод байж болох л юм. Дурлалдаа шатаж гэрлэхээр төлөвлөж буй залуу хосуудаас энэ зүйл харагддаг. Эцэг эх болон төлөвшсөн найзууд нь мэргэн зөвлөгөө өгч, бүтэхгүй гэдгийг нь олж хараад хэлсээр байвч зөрүүд хоёр зөвлөгөөг нь ер авч үзэхгүй. Бурханы өмнө орхиогүй тэр хүсэл нь тэднийг хуримын ордонд хүргэх боловч тун удалгүй шүүхийн өмнө гэр бүл салалтын хэргээр аваачдаг.

Заримдаа ийм хаяагүй хүслийг туршлагагүй байж тодорхой нэг бизнес рүү орохоор зориг шулуудсан итгэгчээс олж хардаг. Мэдлэг туршлагатай хамтрагчид нь хийх хэрэггүй гэдгийг зөвлөсөөр атал зөрүүдэлж хүнээс

мөнгө зээлээд бизнес эхлүүлнэ. Гэтэл удалгүй бизнес нь дампуурч авлагатай хүмүүс нь өрөө нэхнэ.

Дур зоргоороо хүслийн хор уршгийг христэч үйлчлэлээс олонтоо олж харна. Тийм хүсэл хүнийг гэр бүлтэй нь хамт илгээлтийн талбар руу явуулах боловч илгээсэн чуулгандаа асар их зардал тариад жил ч хүрэхгүй буцаад ирцгээнэ. Хаях ёстой хүсэл нь Бурханы биш хүний санаагаар эхэлсэн ажлыг гэнэн итгэгчдээр санхүүжүүлнэ. Гэвч тэр ажил хэсэг хугацааны дараа нуран унана. Дур зоргоороо хүсэл хүмүүсийн дунд хэрүүл маргаан үүсгэнэ. Яагаад гэвэл зарим нь бусадтайгаа хамтрахаас татгалзаж өөрийн зоргоор явахыг хүснэ.

Бид бүгдээрээ загалмайн өмнө ирж, дураараа зан, тэрслүү зөрүүдлэл, өөрсдийгөө тэргүүнд тавьдаг араншингаа хаяж, тэр бүхнээ загалмайн өмнө орхих хэрэгтэй. Хахир хатуу хүслээ тахилын ширээн дээр тавих ёстой. Тэгээд Эмми Кармайлтай нэгэн сэтгэлээр дараах дууг дуулаарай:

*Эзээн Та миний төлөө эмтэрч шархаджээ*

*Би таны хайрын төлөө хүслээ орхиё*

## 12 сарын 28

*"Бусдын хэрүүлд хөндлөнгөөс оролцох нь хажуугаар өнгөрөгч нохойг чихнээс нь зулгаахтай адил."* (Сур 26:17)

Энэ эшлэлд дурдагдсан нохой нөхөрсөг, дөлгөөн зантай нохой биш. Харин ааш муутай, зэрлэг араншинтай, харсан үзсэн болгон руугаа архирч, хажуугаар нь өнгөрсөн бүхнийг боргож хуцна. Тийм нохойны чихнээс зулгаах нь битгий хэл дэргэдүүр нь өнгөрөхөөс ч айна.

Өөрт нь хамааралгүй хэрүүл тэмцэлд оролцдог хүнийг үүгээр дүрсэлжээ. Тийм хэрүүл тэмцэлд оролцох үед тэмцэлдэгч хоёр эргээд нөгөө хүн рүү дайрна.

Тэмцэлдэгч этгээдүүд дундуур нь орсон хүнийг ялахад нь саад боллоо гэж үзээд юунд маргаж байснаа мартан нөгөө хүн рүү нийлж дайрдаг.

Нэг ирланд хүн зодолдож байсан хоёр эр дээр очоод "Энэ зодоон хувийн асуудал уу эсвэл өөр хүн оролцож болох асуудал уу?" гэж асууж гэнэ. Бид ер нь ийм хандлагатай байх хэрэгтэй. Гэхдээ хүн бүрд өөрт хамаагүй хэрүүл маргааны дундуур орох сонирхол байдаг.

Эхнэр нөхөр хоёрын хэрүүлд дуудлага хүлээн авсан цагдаа асуудалд маш болгоомжтой ханддаг. Цагдаа хүн болгоомжтой хандаж байхад жирийн иргэд бид хэр их болгоомжтой хандах ёстой нь ойлгомжтой.

Өнөөдрийн эшлэлд дурдагдсан дүр зураг чуулганд олонтоо харагддаг. Ихэнхдээ хоёр хүний дунд асуудал үүснэ. Тэгтэл өөр хүмүүс тэр хоёрын аль нэгний талд орж талцана. Жирийн нэг оч байснаа удалгүй түймэр болно. Өөрсдөд нь ямар ч хамааралгүй асуудалд оролцогч хүмүүс мэргэн зөвлөгөөгөө өгөх гэж улайрна. Байдал хурцдаж,



найз нөхдийн харилцаа эвдэрч, зүрх сэтгэлүүд шархална. Тулаан эрчээ авч эхлэхэд хүмүүс ходоодны шарх гэх мэт олон төрлийн өвчин туссан тухай сураг сонсогдож эхэлнэ. Хоёрхон хүний асуудал чуулганы олон хүнийг ийнхүү асуудалд унагана.

Өөрт хамааралгүй хүмүүсийн хэрүүл маргаан дундуур бүү ор гэсэн анхааруулга, Матай 5:9 дээр “Амар тайвныг тогтоогсод ерөөлтэй еэ! Тэд Бурханы хөвгүүд гэж нэрлэгдэх болно” гэж хэлсэн Эзэн Есүсийн үгтэй зөрчилдөж байгаа мэт харагдаж байж болох юм. Гэхдээ ямар ч зөрчилдөөн байхгүй. Маргалдагч талууд маргаанаа таслуулах хүсэлтэй байгаа үед амар тайвныг тогтоогч асуудалд оролцож болно. Эс бөгөөс бусдын хэрүүлд оролцогч нь өөрийгөө зугтах аргагүй хүнд асуудалд унагана.

## 12 сарын 29

*“Давид аа, бид таных, Иессийн хүү, бид таны талд. Амар амгалан, амар тайван танд оршиг! Танд туслагч нэгэнд амар тайван нь оршиг! Үнэхээр таны Бурхан таныг дэмждэг билээ.” (1Шс 12:18)*

Давидад үнэнч сэтгэлээ илэрхийлсэн энэ эрхэм үгийг итгэгч бүхэн Эзэн Есүс Христийг гэсэн үнэнч сэтгэлийнхээ илэрхийлэл болгон хэлэх хэрэгтэй. Хаадын хаанд хагас сэтгэл, хоёрдмол санаагаар үнэнч байх боломжгүй. Түүнд бүх зүрхээ өргөх хэрэгтэй.

Наполеоны дайны тулаанд хүндээр шархадсан франц цэргийн түүх миний сэтгэлийг ихэд хөдөлгөдөг. Түүний амийг аврахын тулд хагалгаа хийх шаардлагатай гэж эмч нар үзжээ. Хагалгаанд орохын өмнөх өдөр цэрэг эрийн цээжинд үзлэг хийж байлаа. Өвчтөн, “Эмч ээ, илүү лав үзээрэй. Та тэндээс эзэн хааныг олно” гэж хэлсэн байдаг. Өөрөөр хэлбэл, цэрэг эрийн зүрх сэтгэлийн сэнтийд эзэн хаан нь заларч байгаа гэсэн утгатай юм.

Элизабет залуухан байхдаа хатан хаанаар өргөмжлөгдсөн. Тэгэхэд түүний эмээ, хатан хаан Мери үнэнч байдлаа илэрхийлэн захиа бичихдээ “Таны хайрт эмэг эх, үнэнч албат” хэмээн гарын үсэг зурсан байдаг. Үүгээрээ, хатан хааны титмийг өмссөн хүнд үнэнч зүтгэнэ гэдгээ тодорхой хэлжээ.

Тэгвэл бид ямар байх ёстой вэ? Дээрх жишээнүүдийг хэрхэн хэрэгжүүлэх вэ? Энэ тал дээр Мэттью Хэнри өөрийнхөө саналыг хэлсэн: “Амасаигийн үгнээс бид Эзэн Есүс Христийг хайрласан хайр, Түүнд үнэнч байдлаа хэрхэн илэрхийлэх зааврыг авах хэрэгтэй. Бид юу ч

үлдээхгүйгээр бүхлээрээ Эзэн Есүсийнх байх ёстой. Бид Түүний талд зогсох учиртай. Бүх зүрхээрээ Эзэн Есүсийн үйл хэрэгт сайн сайхныг хүсэж, Түүний сайнмэдээ хийгээд хаанчлалын төлөө явах ёстой. Учир нь Түүний Бурхан Түүнд тусалж, хожим бүх засаг захиргаа, эрх мэдлийг хөлд дор нь оруулна.”

Спержон ч ялгаагүй бидний амьдрал ямар байх ёстойг хэлсэн: “Есүс ээ бид Таных. Эзэмшдэг бүхэн минь Таных. Бүхнээ бид Таны хаан зорилгын төлөө зориулна. Бурханы Хүү, бид Таны талд. Хэрэв бид Христийнх юм бол мэдээж Христийн талынх байж таарна. Шашны, улс төрийн, ёс суртахуун бүхий л асуудалд бид Таны талд. Таны дээр амар амгалан байх болтугай. Зүрх сэтгэл минь Танд амар амгаланг хүснэ. Таны туслагчид амар амгалан байх болтугай. Сайн хүн бүхэнд бид хамаг сайныг хүснэ. Бид амар амгаланг хүсэн залбирна. Учир нь Таны Бурхан Танд тусалдаг. Байгаль дэлхийг эзэгнэн захирагч аугаа Бурханы бүх хүч чадал, эрх мэдэл, нигүүлслийн Эзэнд туслахаар ажиллаж байна. Үхлээс амилсан Христ ээ, тэнгэр өөд ширтэн Таныг бид бишрэн хүндэтгэдэг. Дээш одсон Христ ээ, бид Таны хөлд сөгддөг. Давидын хүү, Гослогдсон Жонон, Аврагч аа, бид Таных. Удахгүй ирэх Христ ээ, бид Таны ирэхийг харуулдан хүлээдэг. Өөрийнхөн дээрээ хурдан ирээрэй. Амен. Амен.”

## 12 сарын 30

*“Дараа нь Давид ‘Саулын гэрээс амьд үлдсэн хүн байхгүй юу? Би Ионатаны төлөө тэр хүнд энэрэл хайр үзүүлэх юмсан’ гэв.” (2См 9:1)*

Мефибошет нь Давидын амийг авах гэж удаа дараа оролдсон Саул хааны ач хүү байлаа. Тиймээс тэрслэгч гэр бүлийн хүн гэж тооцогдоно. Давид хаан ширээнд суухдаа Мефибошетиийг арчин хаяж болох байсан. Түүнээс гадна, Мефибошетиийг хүүхэд байхад асрагч нь алдаж унагаад тахир дутуу болгожээ. Тэрбээр "бэлчээргүй" гэсэн утгатай Ло-Девбар хэмээх газар, хүний гэрт ядуу тарчиг амьдарч байв. Ло-Девбар нь Иорданы зүүн талд байдаг бөгөөд Бурханы оршихуй бүхий Иерусалимаас алс хол. Мефибошетод Давидын тааллыг хүртэх юу ч үгүй.

Гэсэн ч Давид түүнийг эрж хайж, элч нарыг илгээн хааны ордонд авчирч, айх зүйл байхгүй хэмээн тайтгаруулж, түүнд Саулын эзэмшил нутгийг өгч, үйлчлэх зарц нарыг томилж, хүндэтгэл үзүүлж, хааны хөвгүүдийн адил хааны ширээнээс байнга хооллох эрхийг өгөв.

Давид ийм үнэ цэнэгүй хүнд яагаад өршөөл, нигүүлсэл, энэрэл хайр үзүүлсэн бэ? Хариулт нь “Ионатаны төлөө.” Давид, Мефибошетиийн эцэг Ионатантай гэрээ байгуулж, гэр бүлд нь үргэлж хайр энэрэл үзүүлнэ гэж амласан. Энэ бол болзолгүй нигүүлслийн гэрээ (1См 20:14-17).

Мефибошет үүнийг ойлгож байсан учраас хааны өмнө ирэх үедээ бөхийн мөргөөд “үхсэн нохойноос ялгаагүй би ийм их хайр нигүүлслийг хүртэх зохисгүй” гэж хэлсэн.

Энэ зураглалаас бид өөрсдийгөө олж харах хэрэгтэй. Бид тэрслүү нүгэлт удам угсаанаас, үхлийн ял дор төрсөн.

Бид нүглийн улмаас тахир дутуу хүнээс ялгаагүй байсан. Мөн "бэлчээргүй" нутагт сүнслэг өлсгөлөн дотор амьдарч байлаа. Бид ядуу тарчиг төдийгүй, Бурханаас алс хол, Христгүй, найдвар үгүй амьдардаг байсан. Бурханы хайр нигүүлслийг татах зүйл бидэнд юу ч байгаагүй.

Гэсэн ч Бурхан биднийг эрж хайж, олж, үхлийн айдсаас чөлөөлж, тэнгэр дэх бүх сүнслэг ерөөлөөр ерөөж, найрын ширээндээ урьж, хайрынхаа тугийг бидний дээр өргөв.

Тэр яагаад үүнийг хийсэн бэ? Хариулт нь “Есүсийн төлөө.” Ертөнцийн суурь тавигдахаас ч өмнө биднийг Христ дотор сонгосон Түүний нигүүлслийн гэрээнээс болсон аж.

Түүний өмнө өвдөг сөгдөхдөө, “Боол би чинь хэн болоод над шиг үхсэн нохойг та тооно вэ?” гэсэн даруу сэтгэл гаргах нь бидний зохист хандлага мөн.

## 12 сарын 31

*“Харагтун, Би үүдэн дээр зогсоод тогшиж байна. Хэрэв хэн нэгэн нь дууг минь сонсоод үүдээ нээвэл, Би дотогш түүн уруу орж, түүнтэй хамт, тэр Надтай хамт хооллоно.” (Илч 3:20)*

Бид нэг жилийг ардаа үдэж, шинэ онтой золгох гэж байна. Гэсэн ч тэвчээртэй Аврагч маань хүмүүний хаалгыг тогшин зогссоор. Хаалга нээж өгөх хүн гарч ирэхийг хүлээн тэнд удаан зогсжээ. Өөр хүн бол аль эрт бууж өгөөд яваад өгөх байлаа. Харин Эзэн Есүс тийм биш. Тэрээр хэнийг ч мөхүүлэхийг үл хүсэн тэвчээртэй хүлээдэг. Нэг л өдөр хаалга онгойж, Өөрийг нь дотогш оруулна хэмээн найдан хүлээнэ.

Эзэн Есүс хаалга тогшиход хэн ч хариу өгөхгүй байгаа нь гайхмаар. Хэрэв хөрш минь байсан бол хаалгыг нэн даруй нээнэ. Хэрэв наймаачин байсан бол хэн нэгэн нь ядаж хаалгаа онгойлгоод "Бид юм авахгүй" гэж хэлнэ. Хэрэв ерөнхийлөгч юм уу засаг дарга байсан бол түүнийг угтан авах гэж гэрийн гишүүд уралдан хаалга тайлах биз. Гэтэл ертөнцийн Бүтээгч, Тогтоон баригч, Аврагч хаалга тогшиж байхад ямар ч чимээ анир алга.

Эзэн Есүс дээрэмдэж тонох гэж бус, өгөх гэж ирдгийг мэдсээр байж хаалга тайлахаас татгалзах нь бүр ч хачирхалтай. Тэрээр элбэг дэлбэг бялхсан амьдрал өгөх гэж ирдэг.

Христитгэгч радиогийн номлогч нэлээн орой болсон хойно утасны дуудлага хүлээн авав. Нэг сонсогч нь түрхэн зуур ороод гарахыг хүсжээ. Номлогч түүнийг ирүүлэхгүйн тулд бүхий л шалтаг шалтгааныг тоочсон ч яах ч аргагүй

хүлээж авав. Сонсогч радиогийн үйл ажиллагааг дэмжихийн тулд их хэмжээний мөнгө өгөх гэж иржээ. Сонсогчийг явсны дараа номлогч, "Түүнийг оруулсан нь сайн хэрэг боллоо" гэж хэлэв.

Жое Блинко зочны өрөөнд өрнөх яриагаар үйл явдлыг дүрсэлдэг. Гэнэт урд хаалгыг хүн тогших нь тэр. Гэрийнхний нэг нь "Хаалган дээр хүн ирчхэж" гэж хэлнэ.

Өөр нэг нь хаалга руу очоод хаалга нээж өглөө. Зочны өрөөнөөс "Хэн ирээв?" гэж асууна. Хаалганаас хариу хэлнэ. Гэрийн эзэн "Зочныг оруул, оруул" гэж хашхирна.

Товчхондоо бол сайнмэдээ энэ юм. Сонсооч! Хаалган дээр хүн байна. Энэ хэн бэ? Амь ба алдрын Эзэнээс өөр хэн байх билээ? Тэрээр бидний оронд үхэж, гурав дахь өдрөө үхлээс амилсан. Одоо Тэр цог жавхланд заларч байгаа бөгөөд удахгүй Өөрийн хүмүүсийг гэр рүүгээ авч явж, Өөртэйгөө хамт байлгахаар ирнэ. Түүнийг гэртээ оруулаарай.

